

Хуучин Гэрээ

О Ю У Т Н Ы



СУДЛАХ ГАРЫН АВЛАГА

**Сүмийн Боловсролын Системээс
бэлтгэв**

**Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмээс
хэвлэв
Солт Лейк Хот, Юта**

Хуучин Гэрээний тухай та нарын мэдвэл зохих зарим зүйл . . . 1	
Христийн тухай гэрчлэл 1	
Хуучин Гэрээний түүх 1	
Хуучин Гэрээг урьдчилан тоймлох нь—	
Агуулгын товъёог 1	
Хуучин Гэрээг судалснаас та нарын олох ашиг тус 1	
Энэ гарын авлагыг та нар хэрхэн ашиглах вэ 2	
Оршил 2	
Судруудыг ойлгох нь 2	
Судруудыг судлах нь 2	
Гэрээр судлах семинарын хөтөлбөр 2	
Семинарын өдөр тутмын хөтөлбөр 2	
Судруудыг судлах нь 2	
Хуучин Гэрээг унших хуваарь 4	
ХҮГ-ний судруудын хэвлэлүүд	
дэх судлах тусламжууд 3	
Харьцуулах ишлэлүүд 3	
Судруудын Удирдамж дахь	
ишлэлүүд 3	
Үг, өгүүлбэрүүдээр авах тусламж 3	
Библийн Иосеф Смитийн Орчуулга 3	
Газарзүйн нэрийн лавлах ба газрын зургууд 3	
Бүлгийн болон хэсгийн оршил тайлбарууд,	
газарзүйн товч дүгнэлт 3	
Судлах ур чадвар 3	
Уншихын өмнө 3	
Унших үед 5	
Уншсаны дараа 6	
Эхлэлийн, Мосегийн болон Абрахамын Номнууд 9	
Абрахам 3	Мөнх бус байдлын өмнөх амьдрал
	ба Тэнгэр дэх Зөвлөгөөн 9
Моце 1	“Энэ бол миний ажил мөн
	миний алдар суу бөлгөө” 10
Эхлэл 1; Моце 2	Бүтээлт 11
Эхлэл 2; Моце 3	Еваг бүтээсэн нь 12
Эхлэл 3; Моце 4	Уналт 13
Эхлэл 4; Моце 5	Золиослол ба Адамын гэр бүл 15
Эхлэл 5; Моце 6	Сайн мэдээний анхдагч
	зарчмуудыг Енох заав 16
Эхлэл 5; Моце 7	Сион Тэнгэрт аваачигдсан нь 18
Эхлэл 6; Моце 8	Ноагийн номлол 19
Эхлэл 7	Үер 20
Эхлэл 8	Бороо зогсов 21
Эхлэл 9	Шинэ эхлэл 21
Эхлэл 10	Ноагийн үр удам 22
Эхлэл 11	Бабелын Цамхаг 22
Абрахам 1	Абрахам санваар хүссэн нь 23
Абрахам 2	Абрахам гэрээнүүдийг
	Бурханаас хүлээн авсан нь 23
Эхлэл 12–13	Сөргөлдөөн бүү байг 24
Эхлэл 14	Абрахам Мелкизедектэй
	уулзсан нь 25
Эхлэл 15	Гэрээ батлагдсан нь 25
Эхлэл 16	Абрахам Хагартай гэрлэсэн нь 26
Эхлэл 17	Абрахамын Гэрээ 26
Эхлэл 18	“ЭЗЭНд дэндүү хэцүү юм
	байдаг гэж үү?” 27
Эхлэл 19	Содом ба Гоморра 28

Эхлэл 20–21	Амлалт биелэгдэв 28
Эхлэл 22	Исаакийг тахилд өргөх
	гэсэн нь 29
Эхлэл 23	Сара нас барсан нь 30
Эхлэл 24	Исаакт эхнэр олсон нь 30
Эхлэл 25	Гэрээний үнэ цэнэ гэж юу вэ? 31
Эхлэл 26–27	Иаков гэрээний адислалуудыг
	хүлээн авсан нь 31
Эхлэл 28	Иаковын ариун туршлага 32
Эхлэл 29	Иаковын хүүхдүүд, Хэсэг 1 33
Эхлэл 30	Иаковын хүүхдүүд, Хэсэг 2 33
Эхлэл 31	Иаков Падан-арамыг орхин
	явсан нь 34
Эхлэл 32	Иаков төрсөн нутаг уруугаа
	явсан нь 34
Эхлэл 33	Иаков Есавтай уулзсан нь 34
Эхлэл 34	Иаковын хөвгүүдийн
	хонзогногч үйлдлүүд 35
Эхлэл 35	Иаков Бетелд эргэж ирсэн нь 35
Эхлэл 36–37	Иосеф ба олон өнгөт дээл 35
Эхлэл 38–39	Иосефын зөв шударга зан 36
Эхлэл 40	Иосеф шоронд 37
Эхлэл 41	Иосеф ба Фараон 37
Эхлэл 42	Иосефын ах нар Египет
	уруу явсан нь 38
Эхлэл 43	Иосефын ах нар Египетэд
	эргэж ирсэн нь 39
Эхлэл 44	Иосеф ах нараа сорьсон нь 39
Эхлэл 45	Иосеф ах нартаа өөрийгөө
	илчилсэн нь 39
Эхлэл 46	Эцэг хүү хоёр дахин учран
	золгов! 40
Эхлэл 47–48	Иаков Иосефын хөвгүүдийг
	үрчлэн авав 40
Эхлэл 49	Израилын хөвгүүдийн патриархын
	адислалууд 41
Эхлэл 50	Иаков Иосеф хоёр нас барав 41
Египетээс Гарсаны Ном 42	
Египетээс Гарсан нь 1	Зоригт эх баригчид 43
Египетээс Гарсан нь 2	Мосегийн эхэн үеийн амьдрал 43
Египетээс Гарсан нь 3	Шатаж байгаа бут 44
Египетээс Гарсан нь 4	Моце Египетэд эргэж ирсэн нь 44
Египетээс Гарсан нь 5	Хатуу сэтгэлт Фараон 45
Египетээс Гарсан нь 6	Би бол Их Эзэн 45
Египетээс Гарсан нь	Тахал 45
7–10	
Египетээс Гарсан нь	Дээгүүр Өнгөрөх Баяр 46
11–12	
Египетээс Гарсан нь 13	Уганууд 47
Египетээс Гарсан нь 14	Улаан Тэнгисийг гаталсан нь 48
Египетээс Гарсан нь 15	Дургүйцэл, Хэсэг 1 49
Египетээс Гарсан нь 16	Дургүйцэл, Хэсэг 2 49
Египетээс Гарсан нь 17	Дургүйцэл, Хэсэг 3 50
Египетээс Гарсан нь 18	Моце ядрахаас хамгаалсан нь 50
Египетээс Гарсан нь 19	Синайн Уулан дээр 51
Египетээс Гарсан нь 20	Арван Зарлиг 51
Египетээс Гарсан нь	Нүдийг нүдээр, шүдийг
21–23	шүдээр 52
Египетээс Гарсан нь 24	Далан ахлагч Бурханыг харав 52

Египетээс Гарсан нь 25–27, 30	Асар	53
Египетээс Гарсан нь 22–29	Санваартнууд Ариун сүмд	54
Египетээс Гарсан нь 31	Эрчүүд асарт ажиллахаар дуудагдав	54
Египетээс Гарсан нь 32	Алтан тугал	55
Египетээс Гарсан нь 33	Мосе Их Эзэнийг дахин харав	55
Египетээс Гарсан нь 34	Бага хууль	56
Египетээс Гарсан нь 35–40	Асар баригдаж, онцгойлон адислагдав	56
Левитийн Ном		56
Левит 1	Шатаалт тахил	57
Левит 2–7	Бусад өргөлүүд	58
Левит 8–9	Аарон болон түүний хөвгүүдийг ариулан адисалсан нь	58
Левит 10	Санваар атгагчид ариун байх ёстой	58
Левит 11	Израилчуудад зориулсан “Мэргэн Ухааны Үг”	59
Левит 12	Цэвэр ба бузар	59
Левит 13–14	Уяман өвчин	59
Левит 15–16	Цагаатгалын өдөр	60
Левит 17–18	Хиймэл шүтээний зуршлуудаас зайлхий	61
Левит 19–20	“Ариун байгтун, учир нь би ариун билээ”	61
Левит 21–22	Санваарын ариун чанар	61
Левит 23–25	Ариун өдрүүд ба үйл явдлууд	62
Левит 26–27	Адислалууд эсвэл зүхлүүд	62
Тооллогын Ном		63
Тооллого 1–4	Хүн амын тооллого	63
Тооллого 5–8	Мосегийн хууль дээрх нэмэлтүүд	64
Тооллого 9	Цөл дэх анхны Дээгүүр Өнгөрөх Баяр	64
Тооллого 10	Синайг орхин явсан нь	65
Тооллого 11	Дур хүсэлдээ хөтлөгдсөн израилчууд	65
Тооллого 12	Бошиглогчийг дэмжих буюу эсэргүүцэх нь	66
Тооллого 13–14	Амлагдсан нутгийг тандан судалсан нь	66
Тооллого 15	Уучлалыг олж авах нь	67
Тооллого 16	Бошиглогчийг эсэргүүцсэн нь	67
Тооллого 17–19	Эмгэнэлт явдлын үр дагаврууд	67
Тооллого 20	Цөхрөлийн гучин есөн жил	68
Тооллого 21	Гуулин могой	68
Тооллого 22–24	Балаамын түүх	69
Тооллого 25–26	Израилыг зүхсэн нь	69
Тооллого 27	Израилд шинэ удирдагчийг сонгосон нь	70
Тооллого 28–30	Хуучин зарлигууд хэвээр хэрэглэгдсэн нь	70
Тооллого 31	Балаам үхэв	70
Тооллого 32	Реубен Гад хоёрын нутаг	70
Тооллого 33–36	Амлагдсан нутгийн талаарх зааврууд	71
Дэд Хуулийн Ном		71
Дэд Хууль 1–3	Түүхийн тойм	71

Дэд Хууль 4	“Чи өөртөө анхаарал тавь”	72
Дэд Хууль 5	Арван Зарлиг	72
Дэд Хууль 6	Агуу зарлиг	72
Дэд Хууль 7	Гэрээнд гэрлэ	73
Дэд Хууль 8	Санатгун!	73
Дэд Хууль 9–10	Их Эзэн туслах болно	74
Дэд Хууль 11	Адислалуудыг эсвэл зүхлүүдийг та нар сонгодог	74
Дэд Хууль 12–13	Хилэнцэт зуршлуудаас зайлхий	74
Дэд Хууль 14–17	Бурханы хүмүүсийн зуршлууд	74
Дэд Хууль 18	Үнэн ба хуурамч бошиглогчид	75
Дэд Хууль 19–25	Сонгогдсон хүмүүст зориулсан тусгай хуулиуд	75
Дэд Хууль 26	Бурханд төлөх бидний өр	75
Дэд Хууль 27–28	Адислалууд ба зүхлүүд	75
Дэд Хууль 29–30	Их Эзэнд эргэж очих нь	76
Дэд Хууль 31–32	Мосегийн дуун	77
Дэд Хууль 33	Овог бүрийн адислалууд	77
Дэд Хууль 34	Мосегийн салах ёс гүйцэтгэсэн нь	78
Иошуагийн Ном		78
Иошуа 1	“Тууштай бөгөөд зоригтой бай”	79
Иошуа 2	Иерихо дахь туршуулууд	79
Иошуа 3–4	Иордан голыг гаталсан нь	79
Иошуа 5	Онцгой зочин	80
Иошуа 6	Хана нурж унасан нь	80
Иошуа 7	Аи хотыг эзэлсэн нь	81
Иошуа 8	Аи хотыг эзэлсэн нь	81
Иошуа 9	Гибенчуудад залилуулсан нь	81
Иошуа 10	Нар сар мандсан хэвээр	82
Иошуа 11–21	Канааныг эзлэх нь үргэлжлэв	82
Иошуа 22	Иорданы зүүнтээ суурьшсан нь	82
Иошуа 23–24	“Энэ өдөр та нар сонго”	83
Шүүгчдийн Ном		83
Шүүгчид 1	Хэн бидний төлөө тэмцэх вэ?	84
Шүүгчид 2–3	Ехүд Израилыг чөлөөлсөн нь	85
Шүүгчид 4–5	Эмэгтэй бошиглогч Дебора	85
Шүүгчид 6–8	Гидеон	85
Шүүгчид 9–10	Мөчлөгийн үе үргэлжлэв	86
Шүүгчид 11–12	Иефтагийн түүх	86
Шүүгчид 13	Самсоны төрөлт	86
Шүүгчид 14–15	Нэг алдааны дараа өөр нэг алдаа	86
Шүүгчид 16	Самсон Делила хоёр	87
Шүүгчид 17–21	Дуулгаваргүйнхээ төлөө Израил зовсон нь	87
Рутын Ном		88
Рут 1	“Таны явах газар уруу би явна”	88
Рут 2	Рут Боазтай учрав	88
Рут 3–4	Рут Боаз хоёр гэрлэсэн нь	88
Самуелын Нэгдүгээр Ном		89
1 Самуел 1	“Энэ хөвгүүний төлөө би залбирсан юм”	90
1 Самуел 2	Елигийн хөвгүүд	90
1 Самуел 3	Самуел Их Эзэнийг сонсон нь	91
1 Самуел 4–6	Гэрээний авдар	91
1 Самуел 7	Наманчлал ялалт авчирдаг	92
1 Самуел 8	“Хааныг бидэнд томилж өгөөч”	92

1 Самуел 9–10	Хааныг Саул тослон адисалсан нь	93	Хаадын Дээд 19	Елиа Ариун Сүнсний тухай илүү ихийг мэдсэн нь	108
1 Самуел 11	Саул Израилыг тулалдаанд удирдсан нь	93	Хаадын Дээд 20–21	Ахабын дуулгаваргүй зан үргэлжлэв	109
1 Самуел 12	Их Эзэн Хаан хэвээр байлаа	94	Хаадын Дээд 22	Бошиглогч Микаиа	110
1 Самуел 13	Саул мунхгаар үйлдсэн нь	94	Хаадын Дэд Ном	110	
1 Самуел 14	Мунхаг тангараг	94	Хаадын Дэд 1	Хаан хиймэл шүтээнүүдээс тусламж эрэлхийлэв	110
1 Самуел 15	Дуулгавартай байхын ач холбогдол	94	Хаадын Дэд 2	Елиа Тэнгэрт аваачигдсан нь	110
1 Самуел 16	Их Эзэн шинэ хааныг сонгосон нь	95	Хаадын Дэд 3–4	Гайхамшгууд	111
1 Самуел 17	Давид Голиат хоёр	95	Хаадын Дэд 5	Нааманыг эдгээсэн нь	112
1 Самуел 18–23	Саул Давидын амийг эрэлхийлсэн нь	96	Хаадын Дэд 6–7	Бошиглогчид итгэ	112
1 Самуел 24	Их Эзэний тослогдогсдыг хүндэтгэх нь	96	Хаадын Дэд 8	Их ёс бусын дундах зөв шударга ёс байдал	113
1 Самуел 25–26	Дайснуудаа хайрла	96	Хаадын Дэд 9–10	Ахабын үр удам устгагдсан нь	113
1 Самуел 27	Давид Филистчүүдийн дунд	97	Хаадын Дэд 11–14	Бүр илүү их ёс бус хаад, Хэсэг 1	113
1 Самуел 28	Саулын сүнсний харанхуй	97	Хаадын Дэд 15–16	Бүр илүү их ёс бус хаад, Хэсэг 2	113
1 Самуел 29–31	Давидын амжилт ба Саулын үхэл	97	Хаадын Дэд 17	Умард Хаант Улс (Арван овог) боолчлолд аваачигдав	114
Самуелын Хоёрдугаар Ном	98		Хаадын Дэд 18–19	Зөв шударга хаан Хезекиа	115
2 Самуел 1–3	Саулын үхлийн дараа	98	Хаадын Дэд 20	Хезекиагийн тухай өөр зүйлүүд	115
2 Самуел 4–5	Давид хаан болов	98	Хаадын Дэд 21	Ёс бус хаан Манассе	115
2 Самуел 6	Гэрээний авдар Иерусалимд ирэв	99	Хаадын Дэд 22–23	Бурханы Үгийн хүч	116
2 Самуел 7	Давид Ариун сүм барихыг хүссэн нь	99	Хаадын Дэд 24–25	Иуда Вавилоноор боолчлолд аваачигдав	116
2 Самуел 8–10	Давидын улс төрийн болон хувийн амжилт	99	Шастирын Дээд ба Дэд Номнууд	117	
2 Самуел 11–12	Давидын эмгэнэлт алдаанууд	100	Шастирын Дээд 22:5–19	Ариун сүм барихаар бэлтгэсэн нь	117
2 Самуел 13–14	Давидын хүүхдүүдийн нүгэл	101	Шастирын Дээд 29:29	“Давид Хааны үйлүүд”	117
2 Самуел 15–18	Абсалом хаан болохыг эрэлхийлсэн нь	101	Шастирын Дэд 3:1	Соломон Ариун сүм барьж эхлэв	117
2 Самуел 19–20	Давидын гай зовлонгууд үргэлжилсэн нь	102	Шастирын Дэд 7:1–12	Их Эзэний алдар суу	118
2 Самуел 21–23	Давидын тухай өөр зүйлүүд	102	Шастирын Дэд 11:13–17	Левичүүд эргэж ирсэн нь	118
2 Самуел 24	Давидын өөр алдаануудын тухай	102	Шастирын Дэд 15	Аса бошиглогчийн зөвлөгөөг дагав	118
Хаадын Дээд Ном	102		Шастирын Дэд 20	Асагийн хүү Иехошафат	118
Хаадын Дээд 1–2	Давидын үхэл	103	Шастирын Дэд 26:14–21	Уззия уяман өвчтэй болсон нь	119
Хаадын Дээд 3	Би чамд юу өгөх вэ?	103	Шастирын Дэд 29:1–11	“Одоо бүү хайхрамжгүй бай”	119
Хаадын Дээд 4	Соломон хаант улсыг зохион байгуулсан нь	104	Шастирын Дэд 36:11–16	Иерусалим дахь ёс бус явдал	119
Хаадын Дээд 5–7	Соломон Ариун сүм барив	104	Езрагийн Ном	119	
Хаадын Дээд 8	Ариун сүм онцгойлон адислагдсан нь	104	Езра 1	Кореш бошиглолыг гүйцэлдүүлэв	120
Хаадын Дээд 9	Их Эзэн Соломон дээр хүрч ирсэн нь	105	Езра 2	Хэн эргэж ирсэн бэ?	121
Хаадын Дээд 10	Хатан хаан Шеба айлчилж ирэв	105	Езра 3–6	Ариун сүмийн барилга	121
Хаадын Дээд 11	Соломон Их Эзэнээс эргэсэн нь	106	Езра 7	Езра—хуулийн багш	121
Хаадын Дээд 12	Хуваагдсан хаант улс	106	Езра 8	Иерусалим уруу явсан нь	122
Хаадын Дээд 13–14	Гай зовлонг хоёр дахин ихэсгэсэн нь	107	Езра 9–10	Израил бус эхнэрүүдтэй гэрлэсэн нь	122
Хаадын Дээд 15–16	Шинэ хаад, хуучин асуудлууд	107	Нехемиагийн Ном	122	
Хаадын Дээд 17	Бошиглогч Елиа	107	Нехемиа 1	Нехемиагийн залбирал	123
Хаадын Дээд 18	Елиа Баалын 450 санваартны эсрэг	108	Нехемиа 2	Нехемиа Иерусалим уруу явсан нь	123
			Нехемиа 3–4	Барилгачид эсэргүүцэлтэй тулгарав	124
			Нехемиа 5	Нехемиа: Агуу удирдагч	124
			Нехемиа 6	Нехемиа хэрмийг дуусгав	124
			Нехемиа 7	Эргэж ирэгсдийн нэрс	124

Нехемиа 8	Езра судруудыг хүмүүст уншиж өгсөн нь	124
Нехемиа 9–10	Үгийн хүч	125
Нехемиа 11–12	Хэрмийг онцгойлон адисалсан нь	125
Нехемиа 13	Нехемиа наманчлалыг номлохоо үргэлжлүүлэв	125
Естерийн Ном		126
Иовын Ном		127
Иов 1	. . . бусад, бүх зүйлээ Иов алдав	127
Иов 2	Иовт дахиад олон хүнд сорилт тулгарав	128
Иов 3	Би ер нь яах гэж төрсөн юм бол?	128
Иов 4–31	Иовын найз нар зөвлөгөө өгөв	128
Иов 32–37	Дөрөв дэх найз	128
Иов 38–39	Их Эзэн хэлсэн нь	129
Иов 40–42	Иов сорилтыг даван гарав	129
Дуулалын Ном		130
Дуулал 22	Есүс Христийн тухай дуулал	131
Дуулал 23	“ЭЗЭН бол миний Хоньчин”	131
Дуулал 24	ЭЗЭНий ирэлтийн баяр хөөр	132
Дуулалаас сонгон авсан шүлгүүд		132
Сургаалт Үгс		133
Сургаалт Үгс	Тойм	133
Номлогчийн Үгс буюу Номлогч		134
Номлогчийн Үгс 1–2	“Бүгд хоосон”	134
Номлогчийн Үгс 3	Та чадах л юм бол амьдралыг хамгийн сайхан болго	135
Номлогчийн Үгс 4–5	Та нарыг юу аз жаргалтай болгодог вэ?	135
Номлогчийн Үгс 6	Бүгд хоосон хэвээр	135
Номлогчийн Үгс 7–11	Амьдралд сэтгэл ханамжийг олох нь	136
Номлогчийн Үгс 12	Дүгнэлт	136
Соломоны Дуун		136
Исаиагийн Ном		136
Исаиа 1	Исаиа Израилыг наманчлалд дуудав	137
Исаиа 2	ЭЗЭНий ууланд ирэгтүн	138
Исаиа 3	Бардамнагчдын тухай бошиглолууд	139
Исаиа 4	Даруу хүмүүст ирдэг адислалууд	139
Исаиа 5	Израилын нүглүүд	139
Исаиа 6	Исаиа ЭЗЭНийг харсан нь	140
Исаиа 7–8	ЭЗЭНд итгэ	140
Исаиа 9	Мессиагийн ирэлтийн тухай бошиглол	140
Исаиа 10	Устгагчид устгагдах болно	141
Исаиа 11	Ирээдүйн үйл явдлууд	141
Исаиа 12	ЭЗЭНийг магтан дуул	141
Исаиа 13–14	Вавилон ба Люсифер	142

Исаиа 15–23	ЭЗЭНд үйлчилдэггүй үндэстнүүдийн тухай бошиглолууд	142
Исаиа 24	Ёс бус дэлхий устгагдана	143
Исаиа 25	Исаиа ЭЗЭНийг магтан дуулав	144
Исаиа 26	Исаиагийн магтаалын дуун	144
Исаиа 27	ЭЗЭН ба түүний усан үзмийн талбай	144
Исаиа 28	Бардам зант хүмүүст өгсөн зөвлөгөө	144
Исаиа 29	Гайхамшигт ажил ба гайхалтай зүйл	144
Исаиа 30–32	ЭЗЭНд итгэ	145
Исаиа 33–34	Есүс Христийн Хоёр дахь Ирэлт	146
Исаиа 35	Найдварын захиас	146
Исаиа 36–39	Хаан Хезекиагийн түүх	146
Исаиа 40	ЭЗЭНий хүч ба аугаа их чанар	146
Исаиа 41–47	Израилын Гэтэлгэгч	147
Исаиа 48	Эргэж ирэх урилга	148
Исаиа 49	Тараагдсан Израилд өгсөн захиас	148
Исаиа 50	ЭЗЭНд эргэж ир	149
Исаиа 51–52	Сэргэгтүн! Тэгээд Түүнд ир	149
Исаиа 53	Есүс Христийн зовлон угтан хэлэгдсэн нь	150
Исаиа 54	Нинжин сэтгэлт эр нөхөр	150
Исаиа 55	ЭЗЭНий урилга	151
Исаиа 56	ЭЗЭН бүх үндэстнүүдийг аварна	151
Исаиа 57	ЭЗЭНд эдгээх хүч бий	151
Исаиа 58	Мацаг ба Хүндэтгэлийн өдөр	151
Исаиа 59	Нүгэл ба түүний үр дагаврууд	152
Исаиа 60	Гэрэл тань цацраг	152
Исаиа 61	ЭЗЭН болон түүний үйлчлэгчдийн үүрэг зорилго	152
Исаиа 62	Израилын угсааны гэтэлгэл	153
Исаиа 63	Есүс Христийн Хоёр дахь Ирэлт	153
Исаиа 64	Зөв шударга хүмүүсийн залбирал	153
Исаиа 65	Мянган Жил	153
Исаиа 66	Сионы найдвар	154
Иеремиагийн Ном		154
Иеремиа 1	Иеремиагийн дуудлага	155
Иеремиа 2–3	Иудагийн нүгэл ба Иеремиагийн захиас	155
Иеремиа 4–6	“Бид наманчлах хэрэггүй”	156
Иеремиа 7	Иеремиагийн Ариун сүмийн номлол	156
Иеремиа 8	Иудагийн эсрэг бүр олон шүүлт	157
Иеремиа 9–10	Иеремиа уйлж Иудагийн төлөө залбирав	157
Иеремиа 11–15	Бурханы шүүлтүүд	157
Иеремиа 16	Хожмын өдрүүд дэх найдвар	157
Иеремиа 17	Иудагийн нүглүүд	158
Иеремиа 18–19	Ваар сав ба Иуда	158
Иеремиа 20	Иеремиагийн гай зовлон	158
Иеремиа 21–22	Хоёр хааны тухай бошиглолууд	159
Иеремиа 23	Хуурамч бошиглогчид	159

Иеремиа 24	Сайн ба муу жимс	160	Даниел 3	Эрэлхэг зоригт гурван залуу эр	177
Иеремиа 25–26	Бошиглогчдыг эсэргүүцэх нь боолчлолд хөтөлдөг	160	Даниел 4–5	Бардам зант хоёр хаан	177
Иеремиа 27–28	Вавилоны буулга	160	Даниел 6	Даниел арслангийн үүрэнд	177
Иеремиа 29	Боолчлогдогсод бичсэн Иеремиагийн захидал	160	Даниел 7–12	Даниелын бошиглолын зүүднүүд ба үзэгдлүүд	178
Иеремиа 30	ЭЗЭН туслахаар амласан нь	161	Хосеагийн Ном	178	
Иеремиа 31	Израилын цугларалт	161	Хосеа 1–3	Гэрлэлтийн гэрээ	179
Иеремиа 32	Иеремиа газар худалдаж авсан нь	162	Хосеа 4–5	Израил Иуда хоёрын нүгэл	180
Иеремиа 33	Иерусалим дахь амар амгалан	162	Хосеа 6	Бурхан чин сэтгэлийн наманчлалыг хүсдэг	180
Иеремиа 34	Зедекиа болон иудейчүүдийг зэмлэсэн нь	163	Хосеа 7–10	Израил юу тарина, түүнийгээ хурааж авна	180
Иеремиа 35	Рехабууд	163	Хосеа 11	Бурханы хайрын нотолгоо	180
Иеремиа 36	Бичээч Барух	163	Хосеа 12–14	ЭЗЭНд эргэж ирэх дуудлага	181
Иеремиа 37–44	Вавилон Иудаг эзэлсэн нь	163	Иоелын Ном	181	
Иеремиа 45	Зөв шударга хүмүүст ч бас хүнд сорилтууд тулгардаг	164	Иоел 1	Голионы дайралтаас суралц	181
Иеремиа 46–51	Үндэстнүүдийн устгал	164	Иоел 2	Тэр Өдрийг хэн тэсэн гарч чадах вэ?	181
Иеремиа 52	Иеремиагийн сүүлчийн бичээсүүд	164	Иоел 3	Агуу тулалдаан	182
Иеремиагийн гашуудал	165		Амосын Ном	182	
Гашуудал 1	Нүглийн үр дагаврууд	165	Амос 1–2	Израил болон эргэн тойрны үндэстнүүдэд ирэх буруутгал	182
Гашуудал 2–4	Иуда яагаад шийтгэгдсэн бэ	166	Амос 3	Бошиглогчдын үүрэг	183
Гашуудал 5	Иеремиагийн гуйлт	166	Амос 4	“Би та нарт туслахыг хичээсэн”	183
Езекиелийн Ном	166		Амос 5	ЭЗЭНийг эрэлхийлж, амьдар	184
Езекиел 1	Бурханы алдар суугийн тухай Езекиелийн үзэгдэл	167	Амос 6	Тайван байгчид гаслантайяа	184
Езекиел 2–3	Езекиелийн үйлчлэх дуудлага	167	Амос 7–9	Амосын таван үзэгдэл	184
Езекиел 4–5	Иерусалимын устгалын тухай бошиглолууд	168	Обадиагийн Ном	185	
Езекиел 6–7	Нүгэл ба устгал	168	Обадиа	Нас барагсдыг гэтэлгэх нь	185
Езекиел 8–11	Иерусалим яагаад эзлэгдсэн бэ	168	Ионагийн Ном	185	
Езекиел 12–17	Яагаад боолчлолд оров?	169	Иона 1–2	Та нар ЭЗЭНээс зугтааж чадах уу?	185
Езекиел 18	Нүглийн төлөөх хариуцлага	169	Иона 3–4	Иона Ниневед	186
Езекиел 19–20	Үл сонсох удирдагчид	170	Микагийн Ном	187	
Езекиел 21–24	Ёс бус явдал устгал уруу хөтөлдөг	170	Мика 1–2	Израил, Иуда хоёул унана	187
Езекиел 25–32	Бусад үндэстнүүдийн шийтгэл	171	Мика 3	Ёс бус удирдагчид шүүмжлэгдсэн нь	187
Езекиел 33	Цамхаг дээрх харуулууд	171	Мика 4	ЭЗЭН Сионд хаанчлах болно	187
Езекиел 34	Израилын хоньчид	172	Мика 5	Мессиагийн Ирэлт	188
Езекиел 35	Едомын устгал	172	Мика 6–7	Израилын нүгэл ба ЭЗЭНий нигүүлсэл	188
Езекиел 36	Найдварын захиас	172	Нахумын Ном	188	
Езекиел 37	Сэргээлтийн тухай хоёр үзэгдэл	172	Хабаккукийн Ном	188	
Езекиел 38–39	Гог, Магогийн тулалдаан	173	Хабаккук 1–2	Асуултууд ба хариултууд	189
Езекиел 40–42	Ариун сүмийн тухай Езекиелийн үзэгдэл	173	Хабаккук 3	Хабаккукийн залбирал	189
Езекиел 43–44	Бурханы алдар суу Ариун сүмийг дүүргэв	174	Зефаниагийн Ном	189	
Езекиел 45–46	Ариун сүмийн тухай өөр зүйлүүд	174	Зефаниа 1–2	Шүүлтийн өдөр	189
Езекиел 47	Ариун сүмийн эдгээгч ус	174	Зефаниа 3	Урам хайрласан үгс	190
Езекиел 48	Израил цугларч, ЭЗЭН тэдэнтэй хамт байна	174	Хаггайн Ном	190	
Даниелын Ном	175		Хаггаи 1	Ариун сүмийг дуусга	190
Даниел 1	Итгэлтэй залуу израилчууд	175	Хаггаи 2	Барилгыг үргэлжлүүл!	191
Даниел 2	Небухаднезарын зүүд	176			

Зехариагийн Ном	191
Зехариа 1–6	Зехариагийн найман үзэгдэл . . . 192
Зехариа 7–8	Тухайн үеийн болон ирээдүйн Иерусалим 192
Зехариа 9	Ирж буй хаан 192
Зехариа 10	Хожмын үеийн амлалтууд 192
Зехариа 11–13	Иудейчүүд ба тэдний Аврагч . . . 193
Зехариа 14	Есүс Христийн Хоёр дахь Ирэлт 193

Малахийн Ном	193
Малахи 1	Чин сэтгэлийн бус шүтлэг 194
Малахи 2	Санваартнууд наманчлалд дуудагдав 194
Малахи 3–4	ЭЗЭНий ирэлт 194

Христийн тухай гэрчлэл

Бүх судрын нэгэн адил Хуучин Гэрээ бол Бурхан амьдардаг тухай, Есүс Христ бол бүх хүмүүсийн Аврагч болох тухай, түүнчлэн бид тэднийг шүтэн биширч, энэ амьдралд амар амгаланг, үхлийн дараа мөнх амьдралыг олохын тулд тэднийг заадаг зүйлүүдээр амьдрах ёстой тухайн гэрчлэл юм.

“Есүс Христ бол Хуучин Гэрээний Бурхан бөгөөд Абрахам, Мосе хоёртой ярьсан Тэрбээр байсан юм. Исаиа Иеремиа нарт сүнслэгээр нөлөөлсөн нь Тэрбээр байсан юм; ирээдүйн үйл явдлуудын тухай эдгээр сонгогдсон хүмүүсээр дамжуулан угтан хэлсэн нь Тэрбээр байсан юм” хэмээн Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл хэлжээ (in Conference Report, 1977 оны 4-р сар, 113; *Ensign*, 1977 оны 5-р сар, 76).

Есүс Амилалтынхаа дараа Иерусалимаас Еммау уруу явж байсан хоёр хүн дээр хүрч ирсэн юм. Хүмүүсийг Сүнсээр дүүргэж, тэдний зүрх сэтгэлийг гэрчлэлээр шатахад хүргэсэн өөрийнх нь тухай Хуучин Гэрээний бошиглалуудыг Тэрээр иш татжээ (Лук 24:13–32-ыг үз). Та нар Хуучин Гэрээг судлах үеэрээ, Есүс Христийн тухай илүү ихийг та нарт мэдүүлж, бас түүний Сайн мэдээг амьдралдаа хэрхэн хэрэглэж болохыг та нарт заадаг үнэнүүдийг эрж хай. Та нар судалгааныхаа нэг хэсэг болгон ойлгосон зүйлээ, мөн даалгавруудаа тэмдэглэх тэмдэглэлийн дэвтэр хөтлөх хэрэгтэй. Христийн тухай заадаг буюу гэрчилдэг өөрсдийнхөө сурсан зүйлийг тэмдэглэх зайг та нар тэмдэглэлийнхээ дэвтэрт гаргаж болох юм. Та нар бас Хуучин Гэрээнд түүнийг эрж хайх үед зүрх сэтгэл чинь Есүс Христийн тухай гэрчлэлээр дүүрэхийг мэдэрч болно.

Хуучин Гэрээний түүх

Анхны эрэгтэй хүн Адам, эмэгтэй хүн Ева хоёрын бүтээлтээр Хуучин Гэрээ эхэлдэг билээ. Тэгээд энэ нь аугаа их үер, Ноа болон түүний гэр бүл, түүнчлэн хөвөгч авдар доторх амьтдаас бусад бүх хүмүүс, амьтдыг устгасан үеийг хүртлэх Адам, Ева хоёрын үр удмын түүхийг товчхон өгүүлдэг. Хуучин Гэрээ нь Ноагийн түүхийг өгүүлсний дараа, Бурхантай гэрээнүүдэд (ариун амлалтуудад) орж, өөрийн үр удмын талаар Бурханаас онцгой амлалтууд хүлээн авсан Абрахамын амьдрал уруу хөтөлдөг үйл явдлуудыг товчхон цэдэглэсэн байдаг. Бурханаас Абрахамд өгсөн амлалтуудыг “Абрахамын гэрээ” гэж нэрлэдэг. Абрахамын гэрээг Абрахамын хүү Исаак, Их Эзэн Израил хэмээн нэрийг нь өөрчилсөн Абрахамын ач хүү Иаков нар үргэлжлүүлсэн юм. Дараа нь Хуучин Гэрээ өөрийн гэрээт хүмүүс, “Израилын угсаа” буюу “Израилын хүүхдүүд” хэмээн нэрлэгддэг Иаковын үр удамтай харилцсан Бурханы үйл хэргүүдийг цэдэглэсэн байдаг.

Хуучин Гэрээг урьдчилан тоймлох нь— Агуулгын товъёг

Библийнхээ эхний хуудсан дахь “Хуучин ба Шинэ Гэрээний бүх номны нэрс ба дэс дарааллыг” хар. Хуучин Гэрээг хамтад

нь авч үзэх юм бол, номнууд нь дандаа он дарааллаар байрлагдаагүй болно. Та нар Хуучин Гэрээн дэх өөр өөр бичээсүүдийг санахын тулд агуулгын товъёгийг тэмдэглэх нь аятайхан санаа байж болно. Жишээ нь: Доорх дөрвөн нэрийг агуулгын товъёгт дурдагдсан номнуудын хажууд тавь.

1. *Хууль*. Эхлэлээс Дэд Хууль хүртэлх номнуудыг “хууль” хэмээн олонтаа нэрлэдэг. Мосе тэдгээрийг бичсэн учраас эдгээр номнуудыг заримдаа “Мосегийн таван ном” хэмээн нэрлэдэг. Эхлэл нь дэлхийн болон Адам Ева хоёрын бүтээлтээр эхэлдэг бол Дэд Хууль нь Мосегийн амьдралын төгсгөлд дуусдаг. Эдгээр таван ном Бурханы хүнтэй хийсэн гэрээнүүдийн тухай, түүнчлэн уг гэрээний нэг хэсэг болгон хүн тэдгээрээр амьдрах ёстой зарлигуудын тухай өгүүлдэг.
2. *Түүх*. Иошуагаас Естер хүртлэх номнууд Мосегоос хойших зургаан зуун жилийн турш дахь Израилын хүүхдүүдийн түүхийг үргэлжлүүлэн өгүүлдэг. Эдгээр номнуудыг нийтэд нь “түүх” хэмээн нэрлэдэг. Эдгээр номнууд ерөнхийдөө он дарааллаар байрлагдсан хэдий ч, Шастирын Дээд, Шастирын Дэд нь чухамдаа Хаадын Дээд болон Хаадын Дэдэд гардаг нэгэн адил түүхийг өөр бичигчийн бичсэн хувилбар юм.
3. *Яруу найраг*. Иовоос Номлогчийн Үгс хүртлэх номнууд нь яруу найргийн хэлбэрээр бичигдсэн сургамжууд хийгээд илчлэлтүүдээр дүүрэн юм; тийнхүү, энэ хэсгийг “яруу найраг” гэдэг. Соломоны Дуун бол бас яруу найргийн хэсэгт агуулагддаг хэдий ч, Бошиглогч Иосеф Смитийнхээр энэ бол сүнсээр нөлөөлөгдсөн бичээс юм. Дуулалын Ном нь тухайн үеийн ариун хөгжмүүдэд зориулан бичсэн үгсийг агуулдаг.
4. *Бошиглогчид*. Исаиагаас Малахи хүртэлх номнууд нь Израилын хүүхдүүд хаадтай байсан үед өөр өөр бошиглогчдын заадаг байсан зүйлүүдийг агуулдаг. Эдгээр нь түүхийн он дарааллаар биш юм. Эдгээр номнууд ийм дэс дараалалтай байгаагийн шалтгааныг бид мэддэггүй.


Хуучин Гэрээг судалснаас та нарын олох ашиг тус

Хуучин Гэрээний түүхүүд бол түүхэн дэх хамгийн их нэрд гарсан түүхүүд юм. Хэрэв бид тэдгээрийг мэддэггүй байсан бол, Шинэ Гэрээ, Мормоны Ном, Сургаал ба Гэрээнээс их зүйл утга учиргүй байх сан. Бид зөвхөн түүхүүдийг мэддэг байгаад зогсохгүй түүнээс илүү их зүйл хийх ёстой. Бид эдгээр түүхүүдээс үнэн сургаалыг мэдэж тэрхүү сургаалыг амьдралдаа хэрэглэх ёстой.

Та нар Хуучин Гэрээг хичээнгүйлэн судлах юм бол, Сүнс та нарын зүрх сэтгэлд гүнзгий нэвтэрч, Христтэй илүү адилхан болоход тань та нарт туслах тийм цаг үе ирэх болно. Хуучин Гэрээ нь мянга мянган жилийн туршид Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөг итгэлээр дагахад нь хүмүүст тусалсаар ирсэн билээ.

Энэ гарын авлагыг хэрхэн ашиглах вэ

Энэ гарын авлагын нэр өгүүлж байгаачлан, энэ нь судруудыг судлахад та нарт удирдамж байх болно. Энэхүү гарын авлага дараах арга замуудаар туслалцаа үзүүлэх болно.



байхгүй учраас та нар эдгээр үйл ажиллагаануудыг тэмдэглэлийн дэвтэрт буюу өөрийнхөө цаасан дээр бичиж болно.

Судруудыг судлахад та нарт дараах алхмууд туслах болно:

- Залбирлаар эхэл.
- Өөрсдийн судлах бүлгийн оршлыг уншиж, “Уншихын өмнө” бусад судлах ур чадварыг анхааралтай авч үз (х.5-ыг үз).
- Даалгаварт өгсөн бүлгүүдийг унш. Туслалцаа авахын тулд уншихдаа уг гарын авлагын “Судруудыг ойлгох нь” хэсгийг үз. “Унших үед” судлах ур чадварыг ашигла (х.5-ыг үз). Тэмдэглэлийн дэвтэр буюу тэмдэглэл хийх цаас гаргаж, асуултыг бич. Өөрийнхөө хувьд чухал бодол санаанууд буюу сэтгэгдлүүдийг бас бич.
- Өөрсдийн судалж байгаа бүлэгт байгаа “Судруудыг судлах нь” хэсэг дэх үйл ажиллагаануудыг хий. Зарим үед та нар ямар үйл ажиллагаануудыг хийхээ сонгох шаардлагатай. Хэрэв та нар Хуучин Гэрээний тухай илүү ихийг мэдэхийг хүсвэл, бүх үйл ажиллагааг хийж дуусга.

Гэрээр судлах семинарын хөтөлбөр

Хэрэв та гэрээр судлах хөтөлбөрөөр хичээллэж байгаа бол, дараах унших хуваарь нь семинарын долоо хоног бүр та юуг унших ёстойг танд харуулна. Семинар бол шашны боловсролын өдөр тутмын хөтөлбөр гэдгийг, судруудаа залбирч унших нь та нарын өдөр тутмын зуршил байх ёстойг, тэр ч байтугай та нар семинарт өдөр бүр оролцдоггүй байлаа ч гэсэн, семинарын даалгавар дээрээ хичээлийн өдөр бүр ажиллах ёстойг сана. Хэрэв та нар семинарын хичээлийн жилд гучин зургаан долоо хоногоос илүү юм уу дутуу оролцдог бол, нэг долоо хоногт аль бүлгүүдийг унших болон аль даалгавруудыг хийж дуусгах ёстойг чинь багш чинь та нарт хэлж өгөх болно. Судруудыг уншиж, энэ гарын авлагыг ашиглах нь семинарын хичээлд оролцоогүй хичээлийн өдөр бүр та нараас гучаас дөчин минут шаардана.

Судруудын тухай өөрийн бодол санаа хийгээд тухайн долоо хоногт өөрийн хариулсан асуултуудыг агуулсан тэмдэглэлийн дэвтрийнхээ хуудсуудыг та нар долоо хоног бүр багшдаа өгөх ёстой. Багш чинь эдгээр хуудсуудыг уншиж, тэдгээрт хариулж, тэмдэглэлийн дэвтрийг чинь буцааж өгөх ёстой. Та нар хоёр тэмдэглэлийн дэвтэртэй байж, тэдгээрийг долоо хоногоор ээлжлэн хэрэглэж болно. Та нар бас салгадаг хуудастай дэвтэр ашиглаж, тухайн долоо хоногийг тэмдэглэсэн хуудсууд дээрээ бичиж болно. Багш чинь хуудсуудыг буцааж өгөхөд тэдгээрийг тэмдэглэлийн дэвтэртээ эргүүлж хий.

Семинарын өдөр тутмын хөтөлбөр

Хэрэв та нар семинарын өдөр тутмын хөтөлбөрөөр хичээллэж байгаа бол, багшийнхаа зааварласны дагуу энэ судлах удирдамжийг ашиглах болно.

Судруудыг судлах нь

Энэ гарын авлага бол судруудыг унших, судлах, ойлгоход чинь та нарт туслах удирдамж юм. Та нарын судлах цагийн ихэнх нь судруудыг уншиж, тэдгээрийн талаар эргэцүүлэн бодоход зарцуулагдах болно, иймээс энэ хэсэг нь энэхүү судалгаанаас илүү их зүйлийг олж мэдэхэд та нарт туслах болно.

А Оршил

Доор хэвлэгдсэн тайлбар бүр нь уншихыг нь та нарт даалгасан судруудын бүлгүүдийн оршлууд, түүнчлэн уншихыг нь та нарт даалгаагүй бүлгүүдийн тайлбарууд юм. “Оршил” хэсэг нь дараах төрлийн мэдээллийг агуулдаг:

- Түүхэн хэсэг
- Судрын хэсэг нь үүний өмнөх буюу дараах бүлгүүдэд хэрхэн холбогдох тухай тайлбар
- Уншихаас өмнө мөн унших явцад тухайн судрын захиас дээр анхаарлыг чинь төвлөрүүлэх асуултууд.

Б Судруудыг ойлгох нь

“Судруудыг ойлгох нь” хэсэг нь судруудад агуулагдаж буй санаанууд хийгээд үзэл баримтлалуудыг ойлгоход та нарт туслах тайлбарын хамт хэцүү үгс болон нийлмэл үг, өгүүлбэрүүдийг ойлгоход тусална. Энэ тайлбар нь Ерөнхий Эрх Мэдэлтнүүдийн мэдэгдлүүдийг олонтаа агуулсан байгаа.

В Судруудыг судлах нь

“Судруудыг судлах нь” хэсэг нь судрууд дахь Сайн мэдээний зарчмуудыг илрүүлэн олж, тэдгээрийн тухай бодож, хэрэглэхэд та нарт туслах асуултууд хийгээд үйл ажиллагаануудыг агуулдаг. Энэ гарын авлагад бичих зай

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн, Ахлагч Ховард В.Хантер судар судлах талаар доорх үнэт зөвлөгөөг Сүмийн гишүүдэд өгсөн билээ. Та нар эдгээр санаануудыг хуудсан дээр бичиж, судар судлах үедээ үүнийг харж болохоор газарт байрлуулж болно.

- Судруудыг ойлгохын тулд анхааралтай унш.
- Өдөр бүр судал.
- Судар судлахдаа өдөр бүр тогтмол цаг гарга.
- Анхаарлаа төвлөрүүлж болохын тулд анхаарал сарниулах буюу ямар нэг саад учруулахааргүй нам гүм орчинд судал.
- Тодорхой тооны бүлэг буюу хуудсуудыг уншихаас илүүгээр тодорхой хугацаагаар судал. Жаран минут нэн тохиромжтой, гучин минутад их зүйл уншиж амждаг бол, арвантаван минут ч байж болно.
- Судлах төлөвлөгөөтэй бай. (Conference Report, 1979 оны 10-р сар, 91–93; *Ensign*, 1979 оны 11-р сар, 64–65-ыг үз.)

Та нар энэ зөвлөгөөг дагах юм бол, судрууд судлахад ашиг тустай өөр хоёр зүйлийг олж мэдэх болно: энэ нь ХҮГ-ний судруудын хэвлэл дэх судлах тусламжууд болон судлах сайн ур чадварыг ашиглах явдал болно.

Хожмын Үеийн Гэгээнтний судруудын хэвлэлүүд дэх судлах тусламжууд

Харьцуулах ишлэлүүд

Харьцуулах ишлэл бол өөрсдийн тань судалж байгаа сэдвээр та нарт нэмэлт мэдээлэл болон ойлголт өгөх судрын ишлэл юм.

Судруудын Удирдамж дахь ишлэлүүд

Судруудын Удирдамж нь Сүмийн бүх дөрвөн жишиг бүтээл дэх судрын ишлэл бүхий олон үгс болон сэдвийн цагаан толгойн дарааллаарх жагсаалтыг агуулдаг. Энэ нь Библийн олон нэр, сэдвүүдийн тодорхойлолтууд болон тайлбаруудаар хангадаг.

Үг, өгүүлбэрүүдээр авах тусламж

Үгс болон өгүүлбэрүүд нь дараах товчлолуудаар тэмдэглэгдсэн байгаа:

- “ЕВ” гэсэн товчлол нь еврей хэлээрх (Хуучин Гэрээний анхны хэл) үгийг зааж байгаа болно.
- “ГР” гэсэн товчлол нь грек үгсийг (Шинэ Гэрээний анхны хэл) зааж байгаа болно.
- “ӨХ” гэсэн товчлол нь “хэлц” (өвөрмөц) үг хэллэгийг (судрууд бичигдэх үед өвөрмөц байдлаар хэрэглэгдэж байсан боловч өнөө үед нийтээр хэрэглэгдэхгүй болсон) зааж байгаа болно.

Библийн Иосеф Смитийн Орчуулга

Библийг судалж, Библийн илүү бүрэн, зөв орчуулга хийхийн тулд илчлэлт эрэлхийлэхийг Их Эзэн, Бошиглогч Иосеф Смитэд зарлиглажээ (С ба Г 37:1; 73:3–4-үз). Иймээс, Бошиглогч Иосеф Смит Библийн буруу орчуулагдсан газруудад олон чухал өөрчлөлт оруулсан билээ (Итгэлийн Тунхаг 1:8-ыг үз). Эдгээр өөрчлөлтүүдийг бид “Иосеф Смитийн Орчуулга” гэж нэрлэдэг. Уг орчуулгыг “ИСО” гэж товчилдог. Иосеф Смитийн Орчуулга ‘Библийн Иосеф

Смитийн Орчуулгаас авсан түүврүүд’ нэртэй хавсралтад *Судруудын Удирдамжууд* байдаг.

Газарзүйн нэрийн лавлах ба газрын зургууд

Библийн ХҮГ-ний хэвлэлийн хавсралтад байдаг газарзүйн нэрийн лавлах болон газрын зургууд нь судруудад дурдагддаг газруудыг олоход ашиг тустай юм.

Бүлгийн болон хэсгийн оршил тайлбарууд, шүлгийн товч дүгнэлт

Бүлгийн болон хэсгийн оршил тайлбарууд, түүнчлэн шүлгийн товч дүгнэлтүүд нь уншиж байгаа зүйлээ ойлгоход чинь та нарт туслах чухал суурь мэдээллийг тайлбарладаг буюу ийм мэдээллийг өгдөг. Жишээ нь, Сургаал ба Гэрээний хэсэг 89-ийн оршил тайлбарыг уншсанаар та нар ямар чухал мэдээлэл олж авдаг вэ?

ХҮГ-ийн судруудын хэвлэлүүдэд байдаг судлах тусламжуудтай байх нь—бүгдээрээ нэг дор байдаг ишлэлүүдийн цуглуулга бүхий жижигхэн номтой байхтай адил юм!

Судлах ур чадвар

Бид судрууд дээр “найрлавал” зохино хэмээн Нифай хэлсэн байдаг (2 Нифай 32:3), түүнчлэн “[тэдгээрийг] хичээнгүйлэн судлахыг” Есүс нифайчуудад зарлиглажээ (3 Нифай 23:1). Энэ төрлийн судалгаа нь судруудыг зүгээр л түргэн гүйлгэн уншихаас илүү зүйлийг багтаадаг. Судруудыг судлах үед илүү ихийг мэдэхэд дараах санаанууд хийгээд ур чадварууд та нарт туслах болно. Эдгээр нь: уншихын өмнө, унших үед, уншсаны дараа гэсэн гурван өөр төрөлд хуваагддаг.

Уншихын өмнө

Залбирал

Судрууд сүнслэг нөлөөллөөр бичигдсэн юм. Иймээс, бид Сүнсний нөхөрлөлтэй байгаа үед судрууд дээд зэргээр ойлгогддог. Хуучин Гэрээнээс бид “Эзэний хуулийг сурахад зүрхээ зориулсан” санваартан Езрагийн тухай мэддэг (Езра 7:10). Бид судруудыг унших бүрдээ залбирснаар тэдгээрийг уншихад зүрх сэтгэлээ бэлтгэдэг.

Суурь мэдээллийг олж ав

Судруудын түүхэн үндэс суурийг ойлгох нь унших үедээ илүү сайн ойлголтууд олж авахад чинь та нарт туслах болно. Судруудын Удирдамж нь ном бүрийн түүхэн үндэс суурь хийгээд агуулга, гол сэдвүүдийн товч тоймыг өгдөг. Сургаал ба Гэрээн дэх хэсгийн оршил тайлбарууд нь илчлэлтүүдийн түүхэн үндэс суурийг товч тайлбарладаг. Энэ гарын авлага бас судрууд дахь олон бүлгийн зарим үндэс суурийг тайлбарладаг. Хэрэв та нарт цаг байвал, өөрсдийн судалж байгаа судрын талаар суурь мэдээлэл байдаг Сүмийн зөвшөөрөн баталсан ном, гарын авлагуудыг бас үзэж болно.

Асуултууд асуу

Та нар уншихаасаа өмнө “Эдгээр шүлгүүдийг хэн бичсэн юм бол?” “Хэнд зориулсан юм бол?” “Энэ сургамж яагаад судруудад орсон юм бол?” “Өнөөдөр би судар уншихдаа юуг мэдэхийг хүсэж байгаа билээ?” “Эдгээр судруудаас юуг мэдэж авахыг Их Эзэн надаас хүсэх бол?” гэх зэрэг асуултуудыг өөрсдөөсөө асуух нь ашиг тустай. Та нар судруудыг уншихдаа, өөрсдийнхөө асуултуудын хариуг эрж хай. Та нар бас

Хуучин Гэрээг унших хуваарь

Би арван минут буюу түүнээс илүү хугацаагаар унших өдрүүд

Н	Д	М	Лх	П	Б	Бя	Долоо хоног 1
Н	Д	М	Лх	П	Б	Бя	Долоо хоног 2
Н	Д	М	Лх	П	Б	Бя	Долоо хоног 3
Н	Д	М	Лх	П	Б	Бя	Долоо хоног 4
Н	Д	М	Лх	П	Б	Бя	Долоо хоног 5
Н	Д	М	Лх	П	Б	Бя	Долоо хоног 6
Н	Д	М	Лх	П	Б	Бя	Долоо хоног 7
Н	Д	М	Лх	П	Б	Бя	Долоо хоног 8
Н	Д	М	Лх	П	Б	Бя	Долоо хоног 9
Н	Д	М	Лх	П	Б	Бя	Долоо хоног 10
Н	Д	М	Лх	П	Б	Бя	Долоо хоног 11
Н	Д	М	Лх	П	Б	Бя	Долоо хоног 12
Н	Д	М	Лх	П	Б	Бя	Долоо хоног 13
Н	Д	М	Лх	П	Б	Бя	Долоо хоног 14
Н	Д	М	Лх	П	Б	Бя	Долоо хоног 15
Н	Д	М	Лх	П	Б	Бя	Долоо хоног 16
Н	Д	М	Лх	П	Б	Бя	Долоо хоног 17
Н	Д	М	Лх	П	Б	Бя	Долоо хоног 18
Н	Д	М	Лх	П	Б	Бя	Долоо хоног 19
Н	Д	М	Лх	П	Б	Бя	Долоо хоног 20
Н	Д	М	Лх	П	Б	Бя	Долоо хоног 21
Н	Д	М	Лх	П	Б	Бя	Долоо хоног 22
Н	Д	М	Лх	П	Б	Бя	Долоо хоног 23
Н	Д	М	Лх	П	Б	Бя	Долоо хоног 24
Н	Д	М	Лх	П	Б	Бя	Долоо хоног 25
Н	Д	М	Лх	П	Б	Бя	Долоо хоног 26
Н	Д	М	Лх	П	Б	Бя	Долоо хоног 27
Н	Д	М	Лх	П	Б	Бя	Долоо хоног 28
Н	Д	М	Лх	П	Б	Бя	Долоо хоног 29
Н	Д	М	Лх	П	Б	Бя	Долоо хоног 30
Н	Д	М	Лх	П	Б	Бя	Долоо хоног 31
Н	Д	М	Лх	П	Б	Бя	Долоо хоног 32
Н	Д	М	Лх	П	Б	Бя	Долоо хоног 33
Н	Д	М	Лх	П	Б	Бя	Долоо хоног 34
Н	Д	М	Лх	П	Б	Бя	Долоо хоног 35
Н	Д	М	Лх	П	Б	Бя	Долоо хоног 36

Энэ долоо хоногт уншихаар надад даалгасан бүлгүүд

“Судруудыг судлах нь”
Абрахам 3:22–28 Мосе 1 2 3 4
Мосе 5 6 7
Мосе 8 Эхлэл 6:14–22 7 8 9:1–17 11:1–9
Абрахам 1 2 Эхлэл 13 14:13–24 15 16 17
Эхлэл 18 21:1–21 22 23 (үйл ажиллагаа)
Эхлэл 24 25:19–34 27 28 29 30:1–24 32 33
Эхлэл 35 37 39 40 41
Эхлэл 42 43 44 45 46 49 50 ИСО, Эхлэл 50:24–38
Египетээс Гарсан нь 1 2 3 4 5 6 7 8 9 10
Египетээс Гарсан нь 12 13 14 15:22–27 16 17
Египетээс Гарсан нь 18 19 20–24
Египетээс Гарсан нь 25–27, 30 28 29 32 33 34-т зориулсан үйл ажиллагаанууд
Левит 1 10 11 14 16 19 26
Тооллого 6 9 11 12 13 14 16 21:4–9 22 23 24 27:12–23
Дэд Хууль 4 6 7:1–6 8 10:10–22 26 28 30 32
Иошуа 1 2 3 4 5:10–15 6 7 10 23 24
Шүүгчид 6 7 8 13 14 15 16 Рут 1 2 3 4
1 Самуел 1 2 3 7 8 9 10
1 Самуел 13 15 16 17 24 26
2 Самуел 7 9 11 12 13 14
Хаадын Дээд 3 8 9:1–9 11 12 17 18 19
Хаадын Дэд 2 4 5 6 17 18 19 22 23
Шастирын Дээд ба Шастирын Дэд 15 20 Езра 9 10 Нехемиа 1 6 8-аас сонгож авсан хэсгүүд
Естер 1 2 3 4 5 6 7 8 9 10 Иов 1 2 3 38 42
Дуулал 22 23 24 Дуулал болон Номлогчийн Үгс Номлогчийн Үгс 1 2 4 5 12-оос сонгож авсан шүлгүүд
Исаиа 1 2 4 5 11 14
Исаиа 24 29 30:15–21 33:14–17 40 42:1–7 47:5–10
Исаиа 48 49 50 53 55 58 61:1–3 63:1–9 65:17–25
Иеремиа 1 7 9:23–24 16 17:5–8, 19–27 23 29:11–14
Иеремиа 30 31 33:15–18 52 Гашуудал 1 5 Езекиел 2 3
Езекиел 11:16–20 18 20:33–44 33 34 37
Даниел 1 2 3 6
Хосеа 1 2 3 13:9–14 Иоел 2 Амос 3 4 5:4–6, 14–15 8:11–12 Обадиа 1:21
Иона 1 2 3 4:1–11 Мика 3 5:2 6:7–8 Хабаккук 3:17–18 Зефаниа 3 Хаггаи 1
Зехариа 9:9 10 11:12–13 12:10 13:6 14 Малахи 3 4

судруудын ХҮГ-ний хэвлэл дэх судлах тусламжуудыг ашиглах буюу хариултуудыг Сүмийн гарын авлагууд, хэвлэлүүдээс хайж болно.

Бүлгийн оршил тайлбаруудыг унш

Бүлгийн оршил тайлбарууд нь тухайн бүлэг дэх гол санаануудын энгийн хураангуйлал юм. Бүлгийг эхлэхээсээ өмнө бүлгийн оршил тайлбарыг унших нь зөвхөн судлах сайн зуршил төдийгүй, бас унших үедээ асуулт асуух, хариултуудыг эрж хайхад өөрийгөө бэлтгэхэд чинь танд туслах болно.

Унших үед

Зогсохоос бүү ай

Ихэнх шижир алт газрын гадаргуу дээр байдаггүй. Тэдгээрийг та газраас ухаж олж авах ёстой. Хэрэв та судар судлахдаа яарахгүй байх буюу зогсолт хийж, бас доорх үйл ажиллагаануудыг хийх юм бол, таны судар судлах ажил илүү үнэ цэнэтэй байх болно.

Ойлгохгүй байгаа үгнүүдийн утгыг хар

Толь бичиг ашигла. Зарим үед утгыг нь аль хэдийн мэднэ гэж таны боддог үг танд нэмэлт ойлголт өгч болно. Энэ гарын авлагын “Судруудыг ойлгох нь” хэсгүүд олон хэцүү үг, өгүүлбэрүүдийг ойлгоход чинь та нарт туслах болно.

Зарим үед Их Эзэн өөрийн бошиглогчдыг өөрсдийнхөө бичээсүүдэд тайлбар хийхэд нь сүнсээр нөлөөлдөг нь хэцүү үг, өгүүлбэрүүдийн утгыг мэдэхэд бидэнд тусалдгийг анхаар. Жишээ нь, Мозая 3:19-ийг уншиж, хүүхэдтэй адилхан болно гэдэг нь юу гэсэн утгатайг өөрөөсөө асуу.

ХҮГ-ний судруудын хэвлэлүүд дэх Судлах тусламжуудыг ашигла

Хуудас 3 дээрх “ХҮГ-ний судруудын хэвлэлүүд дэх Судлах тусламжууд” хэсгийг үз.

Судартай адилтгах нь

Аль нэг шүлэгт өөрийнхөө нэрийг ашиглах нь судруудын заадаг зүйлүүдийг илүү хувь хүний шинжтэй болгоход тусалдаг. Жишээ нь, Мосе 1:39 дэх “хүмүүн” гэдэг үгийн оронд та өөрийнхөө нэрийг тавибал ямар ялгаатай болох вэ?

Төсөөлөн бодох нь

Болж байгаа зүйлүүдийг оюун санаандаа зураглан дүрсэл. Жишээ нь, та нар Эхлэл 37-г унших үед хэрэв чи уг гэр бүл дэх эрэгтэй дүү нарын нэг нь байсан бол, түүнчлэн ах нар чинь бүгдээрээ чамайг үзэн ядаж байсан бол, эсвэл чамд атаархаж байсан бол чамд ямар байх байсныг төсөөлөн бод.

Зарим үед, судрууд биднээс дүрслэн бодохыг шаарддаг. Алма 5:15–18-ыг уншаад, Алмагийн санал болгож байгааг хийхийн тулд зогсолт хий. Эдгээр шүлгүүдийг дүрслэн бодох үед танд ямар сэтгэгдэл төрсөн тухай бичихэд хэсэг цаг гарга.

Холбоос үгсийг хай

Мөн, гэвч, учраас, тиймээс, гэсэн хэдий ч гэсэн үгс юм. Эдгээр үгсийг уншихдаа, хоёр буюу түүнээс дээш санаануудыг ойлгоход эдгээр үгс та нарт хэрхэн тусалдгийг ажигла. Заримдаа эдгээр нь хоёр буюу илүү олон зүйл адил төсөөтэй буюу ялгаатайг харуулдаг.

Жишээ нь, хэрэв та Мозая 26:2–3 дахь *учир* гэдэг үг юуг харуулж байгаа талаар бодох юм бол, судар судлах талаарх нэгэн чухал үнэнийг та мэдэж чадна.

2 Тэд үхэгсдийн амилуулалтын талаар яригдсан байсан зүйлд итгэсэнгүй, бас тэд Христийн ирэлтийн талаар ч итгэсэн нь үгүй болой.

3 Мөн эдүгээ итгэлгүйнхөө учир тэд Бурханы үгийг ойлгож чадсангүй; мөн тэдний эрх сэтгэл нь хатуурсан байв.

Учир гэдэг үг хүмүүсийн итгэлгүй байдал хийгээд судрууд болон бошиглогчдын үгсийг ойлгох тэдний чадварын учир шалтгаан, үр нөлөөний хамаарлыг харуулж байна.

Одоо Сургаал ба Гэрээ 45:30–32-ыг уншиж, *гэвч* гэдэг үг хожмын өдрүүд дэх ёс бусчууд болон зөв шударга хүмүүсийн эсрэг тэсрэг нөхцөлүүдийг хэрхэн харуулсныг ажигла.

30 Мөн тэр үед харийнханы цаг гүйцээгдэх болно.

31 Мөн давшгүй их “цээрлүүлэлтийг үзэх хүртлээ, үхэхгүй хүмүүс тэр үед амьдарсаар байх болно; учир нь эзгүйрүүлэгч өвчин уг нутгийг бүрхэх болно.

32 Гэвч миний шавь нар ариун газруудад “амьдарсаар байх болно, мөн шилжин нүүлгэгдэх нь үгүй болно; харин ёс бусчуудын дундах хүмүүс дуу хоолойгоо өргөж тэгээд Бурханыг “эрхэн мөн үзэх болно.

Гэвч гэдэг үгийг онцгойлон авч үзэх нь Хоёр дахь Ирэлтийн өмнөх зарим устгалуудаас зөв шударга хүмүүс хамгаалагдан үлдэх болно гэсэн баттай итгэлийг бидэнд төрүүлж чадна.

Загваруудыг хай

2 Нифай 31:2-т, Христийн сургаалын тухай хэдэн үг бичихийг тэрээр хүсэж байна хэмээн Нифай хэлсэн байдаг. Дараа нь шүлэг 21-д тэрээр Христийн сургаалыг тэрээр саяхан тайлбарласан хэмээх өөрийн гэрчлэлийг хэлжээ. 2 Нифай 21-д байгаа Христийн Сургаалын талаар мэдэхийн тулд бид Нифайн үгсийг эргэн судлах ёстой юм.

Загвар олохын өөр нэг жишээ бол *хэрэв, тэгвэл* гэдэг үгсийг бошиглогч хэрэглэсэн байдлыг харах замаар шалтгаан, үр дагаврыг тэрээр хэрхэн тайлбарласныг хайж олох явдал мөн. Левит 26-д, Мосе Израилын хүүхдүүдэд ирж болох адислалууд эсвэл зүхлүүдийг бошиглосон байдаг. Шүлэг 3–4, 18, 23–24, 27–28, тэрчлэн 40–42-ыг харж, хэрэв Израилын хүүхдүүд Их Эзэний зарлигуудыг дуулгавартай дагах буюу дагахгүй бол тэдэнд юу тохиохыг заахдаа *хэрэв-тэгвэл* загварыг ашигласан байдаг.

Аль нэг үг буюу санааг давтах нь эрж хайвал зохих өөр нэг загвар юм. Жишээ нь, Эхлэл 39-д Их Эзэн Иосефтой хамт байсныг бичигч хичнээн удаа дурдсаныг ажигла.

Судрууд дахь жагсаалтуудыг хай

Их Эзэн болон түүний бошиглогчид юу заадгийг илүү тодорхой харахад жагсаалтууд та нарт тусална. Арван Зарлиг бол жагсаалт юм (Египетээс Гарсан нь 20-ийг үз). Матай 5 дахь Ерөөлүүд харахад жагсаалт гэдэг нь амархан мэдэгддэг. Бусад жагсаалтуудыг олох нь багахан хүч чармайлт шаардана. Жишээ нь: Эцэг эхчүүд хүүхдүүдээ юу заах шаардлагатай талаар Сургаал ба Гэрээ 68:25–31-д Их Эзэний хэлсэн зүйлээс жагсаалт хий.

Асуултууд асуу

Дээрх “Уншихын өмнө” хэсэгт та нарт зааварласантай адил асуултууд асуухаа үргэлжлүүл. Та нар уншихдаа, уншихын өмнө асуусан асуултуудаа өөрчлөх буюу эсвэл огт өөр асуултууд тавьж болно. Асуултууддаа хариулт олохоор эрэлхийлэх

нь судар судалснаар агуу ойлголт олж авах хамгийн чухал арга замуудын нэг юм. Асуух хамгийн чухал асуултуудын нэг бол, “Ямар шалтгааны улмаас Их Эзэн зохиогчид сүнслэгээр нөлөөлж үүнийг энд оруулсан бэ?” гэсэн асуулт юм. Зарим үед бичигчид “мөн ийнхүү бид үздэг” гэхчлэн хэлж, тодорхой түлхүүр ойлголт өгсөн байдгийг эрж ол.

Судруудад өгсөн асуултуудад хариул

Их Эзэн олон удаа асуулт асууж, тэгээд түүндээ хариулсан байдаг. Тэрээр Нифайчуудад хандан, “Та нар ямархуу маягийн хүмүүс байвал зохих билээ?” гэж асуугаад дараа нь Тэрээр хариулахдаа, “Бүр миний адил” гэжээ (3 Нифай 27:27).

Бусад тохиолдлуудад асуултууд асуусан хэдий ч, хариултуудыг өгөөгүй байдаг учир нь ерөнхийдөө хариулт нь тодорхой гэж зохиогч бодсон хэрэг. Заримдаа бичигчид хариулдаггүй боловч, асуусан асуултад нилээд бодож байж хариулах шаардлагатай буюу эсвэл тэр даруйд хариулах боломжгүй байж болно. Жишээ нь, Марк 4:35–41-ийг уншиж, эдгээр шүлгүүд дэх дөрвөн асуултад, та өөрөө тэнд байсан гэж бодон хариул.

Хэв шинж болон бэлэгдлийн утгуудыг эрж хай

Бошиглогчид өөрсдийн захиасуудыг илүү их хүчтэйгээр дамжуулахын тулд бэлэгдлүүд хийгээд төсөөллийг олонтаа ашигладаг. Жишээ нь: Сургаалт зүйрлэлүүд бол захиасын тухай энгийн арга замаар, түүнчлэн илүү гүнзгий утгыг илэрхийлэх арга хэлбэр юм. Сургаалт зүйрлэл дэх түүх нь заагдаж байгаа сургамжийг ой тойнд илүү үлдэгтэй, утгыг нэн тодорхой болгодог.

Дараах зөвлөмжүүд судрууд дахь бэлэгдлүүдийг ойлгоход та нарт тусалж чадна:

1. Судрууд дахь тайллыг эрж хай. Жишээ нь, 1 Нифай 8-д Лихай үзэгдэл хардаг. Хожим нь Нифай эцгийнхээ харсан үзэгдлийг эцгийнхээ үзэгдэл дэх бэлэгдлүүдийн тайллын хамт хардаг (1 Нифай 11–14-ийг үз). Зарим үед та нар өөрсдийн зүүвэр тайлбарууд дахь харьцуулах ишлэлийг ашигласнаар тайллыг олж болно.
2. Бэлэгдлийн онцгой шинж чанарын тухай, гэрчлэн бэлэгдэл та нарт юуг зааж болох тухай бод. Алма Лиахонаг хүүдээ тайлбарлахад энэ ур чадварыг ашигласан байдаг (Алма 37:38–47-үз).
3. Бэлэгдэл нь Аврагчийн тухай ямар нэг зүйлийг та нарт зааж байгаа эсэхийг хар. “Бүх зүйл [түүний] тухай гэрчилдгийг” (Моисе 6:63) Их Эзэн Адамд хэлжээ. Жишээ нь, Абрахам хүү Исаакаа тахилд өргөх гэсэн тухай түүхэнд өөр бусад хэсэг Есүс Христийн золиослолын тухай хэрхэн гэрчилдэг вэ?

Бич

Жагсаалтууд, өөрийнхөө олж мэдсэн өвөрмөц ойлголтууд, эсвэл өөрийнхөө уншсан ямар нэг зүйлийн талаарх бодол санаа зэргийг тэмдэглэж авахын тулд та хэсэг цаас буюу тэмдэглэлийн дэвтрээ ойр байлга. Та дараагийн удаа уншихдаа бодол санаа буюу ойлголтуудыг эргэн санахын тулд та бас эдгээр санаануудыг судруудынхаа зах дээр бичиж болно.

Олон хүмүүс чухал үгс, өгүүлбэрүүдийг судрууд дээрээ тэмдэглэх дуртай байдаг. Үүнийг хийх зөв буюу буруу арга гэж байдаггүй. Зарим хүмүүс тухайн шүлгийг өвөрмөц онцгой утгатай болгож байгаа чухал үгс болон өгүүлбэрүүдийг будах

буюу доогуур нь зурдаг. Судруудыг тэмдэглэх өөр нэг арга бол харьцуулах ишлэлийг өөр сударт зах дээр нь бичих явдал мөн. Үүнийг хэд хэдэн шүлэгт хийснээр нэг адил сэдвээрх судруудын гинжин хэлхээг бий болгож, улмаар та уг гинжин хэлхээн дэх судруудын аль нэгийг олж болно. Судруудад тэмдэглэгээ хийх нь чухал шүлгүүдийг илүү хурдан олоход танд олонтаа тусалж чадна.

Уншсаны дараа

Тунгаан бод

Тунгаан бодох гэдэг нь ямар нэг юмны тухай гүнзгийгээр бодож, үүнийг оюун ухаандаа цэгнэн, асуултууд тавьж, мэддэг зүйлээ, түүнчлэн сурч мэдсэн зүйлээ үнэлэн дүгнэх явдал мөн. Зарим үед судрууд үүнийг “бясалгах” гэж нэрлэдэг (Иошуа 1:8-ыг үз). Чухал илчлэлтүүд тунгаан бодолтын үр дүн болж, ялангуяа судруудыг тунгаан бодсоноор ирсэн сайн жишээ судруудад нилээд хэд байдаг (С ба Г 76:15–20; 138:1–11-ийг үз).

Судруудыг өөртэйгөө адилтга

Судруудыг өөртэйгөө адилтгах гэдэг нь тэдгээрийг өөрийнхөө амьдралтай зүйрлүүлж үзэх явдал мөн. Судруудыг өөртэйгөө адилтгахын тулд та “Миний саяын уншсан судруудад Сайн мэдээний ямар зарчмууд заагдаж байна вэ?” “Эдгээр зарчмууд миний амьдралд хэрхэн холбогдох вэ?” гэх зэрэг асуултуудыг асуух хэрэгтэй. Судруудыг өөртэйгөө адилтгахын нэг чухал хэсэг бол, “Та нарыг бүх үнэн уруу удирдана” (Иохан 16:13) хэмээн Их Эзэн амласан Сүнсний өдөөлтүүдийг сонсох явдал мөн.

Жишээ нь, Нифай өөрсдийнх нь нөхцөл байдалд тохируулан Исаиагийн заасан зарим зарчмуудыг ярих замаар судруудыг өөртэйгөө болон гэр бүлтэйгээ адилтгасан байдаг. Ах нар нь Израилын хүүхдүүдийн нэгэн адил Бурханаас нүүр буруулсан байхад—Бурхан тэднээс нүүр буруулаагүйг Нифай ах нартаа заажээ. Хэрэв тэд наманчлах юм бол Их Эзэн нигүүлсэнгүй байж, тэднийг өршөөх болно гэдгийг тэрээр бас тэдэнд заажээ (1 Нифай 19:24; 21:14–16-г үз). Исаиагийн үгсийг өөртэйгөө болон ах нартайгаа адилтгаснаар Гэтэлгэгчийн хувьд Есүс Христэд итгэх тэдний итгэл өсөх болно гэж Нифай хэлжээ (1 Нифай 19:23-ыг үз).

Дахин унш

Бид судрын хэсгийг анх удаа уншаад түүн доторх бүх зүйлийг мэдэж чадахгүй нь тодорхой. Чухамдаа, судруудыг үнэн зөвөөр ойлгохын тулд насан туршдаа судлах хэрэгтэй. Бид хоёр юм уу гурав дахин уншсаны дараа загваруудыг харж, илүү сайн төсөөлж, судруудыг илүү гүнзгий ойлгож эхлэх нь олонтаа тохиолддог. Та дахин унших үед шинэ сургамжуудыг эрж хайх буюу өөр асуултууд асуухыг хүсэж болно. Аль нэг түүх буюу эсвэл зүгээр л нэг юм уу хоёр шүлгийг өөрийнхөө үгээр дахин бичихийг хичээх нь уншсан зүйлээ ойлгосон эсэхийг мэдэхэд, түүнчлэн судруудыг илүү сайн ойлгоход танд туслах болно.

Бич

Зарим хүмүүс өөрсдийнхөө уншсан зүйлийн гол санаа, уншаад өөрсдөд нь төрсөн бодлын тухай, эсвэл өөрсдийнх нь уншсан зүйл амьдралд нь хэрхэн хэрэглэгдэж болно гэж боддог тухайгаа бичихийн тулд тэмдэглэл хөтөлдөг. Хэрэв та нар энэ гарын авлагыг гэрээр судлах семинарт ашиглаж байгаа бол, та нар үнэлгээ авахын тулд тэмдэглэлийн дэвтрээ

хөтлөх шаардлагатай. Энэ тэмдэглэлийн дэвтэр нь судрын тэмдэглэлтэй адилхан байх болно.

Уншсан зүйлийнхээ тухай бусдад ярих нь бас сайн. Юуны тухай ярих, мөн сурч мэдсэн зүйлийнхээ тухай ярилцахаа санахын тулд зарим зүйлийг бичиж тэмдэглэх нь уншсан зүйлээ ойлгож, түүнээс илүү их зүйлийг санахад чинь та нарт туслах болно.

Хэрэглэ

Судруудаас та нарын олж авах мэдлэгийн үнэ цэнэ нь та нар сурч мэдсэн зүйлээрээ амьдрах үед ирдэг. Их Эзэнд ихэд ойр байх хийгээд түүний өгдөг амар амгалангийн мэдрэмж бол Сайн мэдээгээр амьдардаг хүмүүст ирдэг адислалуудын зөвхөн нэг хэсэг нь юм. Түүнээс гадна, сурч мэдсэн зүйлээрээ амьдардаг хүмүүст илүү их зүйл өгөгдөх болно. Харин сурч мэдсэн зүйлээрээ амьдардаггүй хүмүүс өөрсдөд нь байгаа мэдлэгийг ч алдах болно хэмээн Их Эзэн хэлжээ (Алма 12:9–11-ийг үз).

“Христийн үгс дээр найрла; учир нь болгоогтун, Христийн үгс та нарын хийвэл зохих бүх зүйлийг та нарт хэлэх болно” (2 Нифай 32:3).



Эхлэлийн, Мосегийн болон Абрахамын Номнууд

Эхлэлийн Ном

Эхлэлийн Ном бол Мосегийн бичсэн таван номны эхнийх нь юм. Энэ ном түүхийн хоёр мянга таван зуун жил буюу Шинэ Гэрээг оролцуулан Библийн бүх үлдсэн хэсгээс илүү урт хугацааг хамардаг! Адам Ева хоёрын Уналт, Абелыг алсан Каин, Ноа ба Үер, Бабелын Цамхгийг барьсан, хүү Исаакаа тахилд –өргөх гэсэн Абрахам, Египетэд худалдагдсан Иосеф зэрэг Библийн хамгийн алдартай түүхүүдээс олон нь Эхлэлд байдаг билээ. Энэ номны тухай илүү ихийг мэдэхийн тулд Судруудын Удирдамж дахь “Эхлэл”-ийг үз.

Мосегийн Ном

1830 оны дөрөвдүгээр сарын 6-нд Сүм зохион байгуулагдсанаас хойш хэдхэн сарын дараа, Библийн “орчуулга” хийхийг Их Эзэн Бошиглогч Иосеф Смитэд зарлиглажээ. Библиэс “олон тодорхой болоод эрхэм үнэт зүйлүүд” (1 Нифай 13:23–28-г үз) алга болсныг Бошиглогч Мормоны Номноос мэдсэн ажээ. Бичвэрийг хуулбарласан хүмүүсийн хайхрамжгүйгээс, эсвэл хүмүүс мэдэхийг нь тэд хүсээгүйн улмаас ёс бус хүмүүс Библиэс авч хаясан үнэнүүдийг түүний Библийн орчуулга сэргээжээ. Библийн энэхүү бүрэн орчуулга Бошиглогч Иосеф Смитийг амьд сэрүүн байхад нийтлэгдээгүй юм. Гэвч өнөөдөр бид түүний хийсэн өөрчлөлтүүдийг уншиж болно, тэдгээрээс хамгийн чухлууд нь Судруудын Удирдамжид байдаг.



Эхлэл 1–6-гийн Иосеф Смитийн Орчуулганд их олон өөрчлөлт хийгдсэн нь Агуу Үнэт Сувдад тусдаа хэвлэгдсэн бөгөөд –Мосегийн Ном хэмээн нэрлэгддэг. Мосегийн ном найман бүлэгтэй. Мосе 1 бол бид ердийнхөөр Библийн эхлэл гэж үзмээр өмнөх үг лугаа адил бөгөөд Эхлэлд байдаггүй мэдээллийг агуулдаг.

Мосегийн Ном бол Эхлэл 1–6 дахь заадаг зүйлүүдийн илүү бүрэн, үнэн зөв хувилбар учраас судлах энэхүү удирдамж нь Мосегийн Номноос уншиж, ойлгон, суралцахад та нарт туслах болно.

Абрахамын Ном

Абрахам дахь илчлэлтүүд Библийн эхэн үеийн хэсгүүдэд хамаардаг учраас тэдгээрийг Эхлэлийн эхний хэсэг болгон Мосегийн номтой хамт судалдаг. 1835 онд Бошиглогч Иосеф Смит Египетэд хуучны судлаачдын олсон эртний Египетийн зарим бичээсүүдийг хүлээн авчээ. Эдгээр бичээсүүд Бошиглогч Иосеф Смитийн орчуулсан, Абрахамын бичээсүүд хийгээд заадаг зүйлүүдээс заримыг нь өөртөө багтаадаг. Эдгээр нь бас Агуу Үнэт Сувдад байдаг бөгөөд Абрахамын ном хэмээн нэрлэгддэг. Эхний хоёр бүлэгт Абрахамын амьдралын тухай тусгайлан өгүүлдэг бөгөөд энэ судлах удирдамжид Эхлэл 11–12-той хамт байдаг. Абрахамын номны сүүлчийн гурван бүлэг нь мөнх бус байдлын өмнөх амьдрал хийгээд дэлхийн бүтээлтийн тухай Абрахамын хүлээн авсан илчлэлтүүдийг агуулдаг. Та нар Абрахам 3-т байдаг мөнх бус

байдлын өмнөх амьдралын тухай шастирыг уншсанаар Хуучин Гэрээний судалгаагаа эхлэх болно.

Дараах схем нь Мосегийн болон Абрахамын номнуудын сүнслэгээр нөлөөлөгдсөн нэмэлтүүд Эхлэлийн Номонд эрхэн холбогдохыг харахад чинь та нарт туслах учиртай.



Абрахам 3

Мөнх бус байдлын өмнөх амьдрал ба Тэнгэр дэх Зөвлөгөөн

Египет уруу явахыг Их Эзэн Абрахамд зарлигласны дараа Тэрээр гарагууд, нар, сар, түүнчлэн оддын тухай үнэнүүдийг түүнд заажээ. Энэ бүгд нь тэр үеийн Египетийн шашинд чухал бэлэгдлүүд байв. Абрахам эдгээр үнэнүүдийг египетчүүдийн аль хэдийн мэддэг байсан зүйл дээр тулгуурлан Сайн мэдээг тэдэнд заахад ашиглажээ (Агуу Үнэт Сувдын 41-р хуудсан дахь Хуулбар 3-ын тайлбарыг ажигла). Тэнгэрийн эрхэсүүд хийгээд тэдгээрийн хөдөлгөөний тухай ярилцах замаар түүний шүтэн биширдэг Бурхан бол бүтээлтэн дэх бусад бүх зүйлүүдээс илүү агуу юм, учир нь тэр бол Бүтээгч гэдгийг Абрахам египетчүүдэд заасан ажээ.

Судруудыг ойлгох нь



Абрахам 3:22–28

Зохион байгуулагдсан оюун билгүүд (ш. 22)—Тэнгэрлэг Эцэгийн сүнсэн хүүхдүүд

Нотлох (ш. 25)—Сорих

Анхны байдал (ш. 26, 28)—
Мөнх бус байдлын өмнөх амьдрал

Хоёр дахь байдал (ш. 26)—
Дэлхийн амьдрал

Хүний хүү (ш. 27)—Есүс Христ



Мөнх бус байдлын өмнөх дэлхий

Мөнх бус байдлын өмнөх амьдралд сонгогдсон удирдагчид



Мөнх бус байдлын төрөлт



Дэлхий

Сонгогдсон удирдагчид хоёр дахь байдалд соригддог

Абрахам 3:22–23—Төрөхөөсөө өмнө сонгогджээ

“Дэлхийн оршин суугчдад тохинуулах дуудлага бүхий хүн бүр энэ дэлхий бий болохоос өмнө Тэнгэрийн Их Зөвлөгөөний үеэр тэрхүү зорилгод урьдчилан томилогдсон юм” хэмээн –Бошиглогч Иосеф Смит хэлжээ (*Teachings of the Prophet Joseph Smith*, түүвэрлэсэн, Жозеф Фиелдинг Смит [1976], 365). Өөрөөр хэлбэл, зөвхөн Абрахам тодорхой ажил үүргийн төлөө төрөхөөсөө өмнө сонгогдсон биш, мөн та нар ч гэсэн нэгэн адил төрөхөөсөө өмнө сонгогдсон юм (С ба Г 138:53–56-г үз).

Абрахам 3:27–28—Мөнх бус байдлын өмнөх Тэнгэр дэх Зөвлөгөөн

Тэнгэр дэх мөнх бус байдлын өмнөх зөвлөгөөний нэг хэсэг болон тохиосон зүйлийн тухай илүү бүрэн дүүрэн ойлголтой болохын тулд Илчлэлт 12:7–11; Сургаал ба Гэрээ 76:25–28; Мосе 4:1–4-ийг бас унш.

Судруудыг судлах нь



Абрахам 3:22–28-ыг судлах үедээ үйл ажиллагаа А-г, дараа нь бусад гурван үйл ажиллагаанаас (Б–Г) хоёрыг нь хий.

А Төгс Эзэмших Судар—Абрахам 3:22–23

1. Мөнх бус байдлын өмнөх амьдралын тухай Абрахам юу олж мэдсэнийг бич.
2. Ерөнхийлөгч Жозеф Ф.Смитийн, сүнсний дэлхийн тухай үзэгдлийн хэсэг болох Сургаал ба Гэрээ 138:53–56-г унш. Сургаал ба Гэрээн дэх илчлэлт Абрахам 3:22–23 дахь илчлэлт дээр ямар мэдээлэл нэмсэн байна вэ? Та нар энэ хоёр судрын харьцуулах ишлэлийг өөрсдийн зүүвэр тайлбарууд дахь ишлэлүүдийг ялган тэмдэглэж эсвэл нөгөө судрын зах дээр ишлэлийг бичих замаар хийхийг хүсэж болно.
3. Абрахам 3, Сургаал ба Гэрээ 138-д уншсан зүйл дээрээ нэмэлт болгон, “Судруудыг ойлгох нь” хэсэг дэх Бошиглогч

Иосеф Смитийн мэдэгдлийг анхааралтай авч үзэн, мөнх бус байдлын өмнөх амьдралын тухай эдгээр сургаалууд та нарт хэрхэн нөлөөлдгийг, түүнчлэн эдгээр зүйлүүдийг мэдэх нь та нарт ямар сэтгэгдэл төрүүлдгийг дүрсэл.

Б Чухал үгсийг эрж ол

1. Бурхан дэлхий дээр хэнийг удирдагчид болгохоор сонгодог, мөн хэзээ тэд сонгогдсон тухай өгүүлдэг үгсийг Абрахам 3:22–23-оос ол. Эдгээр үгсийг тэмдэглэлийн дэвтэртээ бич. Тэрчлэн та нар эдгээр үгсийг судрууддаа дугуйлан тэмдэглэж бас болно.
2. Абрахам 3:24-т Есүс Христийг хамгийн оновчтойгоор дүрсэлсэн өгүүлбэрийг ол. Үүнийг тэмдэглэлийнхээ дэвтэрт бичиж, энэ өгүүлбэр яагаад түүнийг их сайн дүрсэлснийг ярь.

В Асуулт бич

Абрахам 3:24–26-гаас хариулж болно гэж өөрийнхөө бодсон, хүмүүс асууж болох нэг чухал асуултыг бич.

Г Сургаалыг хэрэглэ

Шүлэг 22–28-д заасан үнэнүүдээс нэгийг сонгож, энэ нь таныг зөв шударгаар амьдрахад хэрхэн урамшуулан дэмжих учиртайг, хэрхэн урамшуулан дэмжсэнийг, түүнчлэн хэрхэн урамшуулан дэмждэг тухай бич.

Мосе 1

“Энэ бол миний ажил мөн миний алдар суу бөлгөө”

Энэ нь хэдийгээр Иосеф Смитийн Орчуулгын нэгдүгээр бүлэг ч гэсэн, *Эхлэл дэх Мосегийн 1-тэй огт адилгүй юм. Мосе 1 дэх заадаг зүйлүүд нь Эхлэл номын эхлэлд хамаардаг, учир нь эдгээр нь Эхлэлийн номонд өөрийнхөө бичсэн үнэнүүдийг Мосе хэрхэн олж мэдсэнийг өгүүлдэг билээ. Түүнээс гадна, Мосе 1 нь өөрийн хүүхдүүдэд зориулсан Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөний талаар чухал мэдээллээр хангадаг. Мосе 1-д Мосед өгсөн илчлэлт нь шатаж буй бутан дахь илчлэлтээс хойш (Мосе 1:18-ыг үз), гэвч Мосег Египетэд эргэж ирэхээс (Мосе 1:26-г үз) өмнө тохиосныг ажигла. Иймээс, энэ илчлэлт Хуучин Гэрээнд байдаг бол Египетээс Гарсан нь 3 буюу 4-т хаа нэгтээ байх учиртай.*

Бид амьдралдаа зарим үед, “Би хэн юм бэ?” “Би хаанаас ирсэн юм бол?” “Би яагаад энд байгаа юм бол?” “Энэ гараг дээр амьдрал яаж, бас яагаад бүтээгдсэн юм бол?” гэсэн асуултуудыг асууж болох юм. Эдгээртэй адил асуултуудыг Мосе асууж, тэгээд Бурхан хариултуудыг нь илчилсэн ажээ. Та нар унших үедээ эдгээр асуултуудын тухай бодож, бүлэг 1 болон түүнчлэн Мосегийн номны үлдсэн хэсгийг оролцуулан, энэ илчлэлтэд Их Эзэн Мосед өгсөн хариултуудыг эрж ол.

Судруудыг ойлгох нь

Моце 1

Тэсч чадах (ш. 2)—Амьд үлдэх

Болгоох, болгоов (ш. 5, 8, 25, 27)—Харах, үзэх

Хатаж (ш. 11)—Бүх хүч чадлаа алдсан

Бүгдээр татан авагдсан (ш. 15)—Бүрмөсөн алга болсон

Зайл (ш. 16, 18, 21–22)—Өөр нэгэн газар луу холдох

Бурханыг дуудахаа зогсох (ш. 18)—Залбирахаа болих

Асууж мэдэх (ш. 18)—Асуух

Чанга дуугаар хашгирч (ш. 19)—Хэрцгийгээр ярьж

Шүдээ хавирах (ш. 22)—Уур хилэн хийгээд зовиуртайгаар шүдээ зуух

Хараа билчээн (ш. 27)—Харж

Ялган таних, ялган таньсан (ш. 27–28)—Хэвийн мэдрэмжээс илүү зүйлээр дамжуулан илүү тодорхой ойлголт, мэдлэг хүлээн авах

Үхэшгүй байдал (ш. 39)—Амилагдсан хүмүүн бие болж үүрд амьдрах

Мөнх амьдрал (ш. 39)—Бурханы амьдардаг маягаарх өргөмжлөл; Бурхантай хамт байж, түүнтэй адилхан болох

Моце 1:11—Моце өөрчлөгдсөн байв

“Ариун Сүнсний хүчээр олон бошиглогчид хувиран өөрчлөгдөж, Бурханы дэргэд зогсож, үүрд мөнхийн үзэгдлүүдийг харсан юм” (Брус Р.МкКонки, *Mormon Doctrine*, 2 дахь хэвлэл. [1966], 803). Хүмүүс хувиран өөрчлөгдсөн тухай шастирууд 3 Нифай 28:13–17, Сургаал ба Гэрээ 76:11–12, 19–20-д байдаг.

Моце 1:23—Яагаад эдгээр зүйлүүд Библид байдаггүй вэ

Моце 1:23 Моце Сатаныг дийлсэн тухай шастир бидний одоогийн Библид яагаад байдаггүйг тайлбарласан байдаг. Библи дэх Эхлэл 1–6-д Сатан, чөтгөр гэсэн үгс байдаггүйг ажиглах нь сонин юм. Эдгээр бүлгүүдийн (Моце 1–8) Иосеф Смитийн Орчуулгад Сатан, чөтгөр гэдэг үгс хорь гаруй удаа гардаг. –Хүмүүсийг мэхлэхийг оролддог Сатаны арга замуудын нэг нь тэрээр байдаггүй гэдэгт тэднийг итгүүлдэг явдал мөн (2 Нифай 28:22-ыг үз).

Судруудыг судлах нь

Моце 1-ийг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А–Г) наад зах нь хоёрыг хий.

А Бурхан гэж хэн бэ? Хүн гэж хэн бэ?

1. Моце 1:1–11-ийг уншиж, Бурханы тухай Моце юу мэдсэнийг жагсаа.
2. Мөн эдгээр шүлгүүдээс Моце өөрийгөө Бурхантай ямар хамааралтай болох талаар юу мэдэж авсныг жагсаа. Та нар судрууддаа энэ хоёр жагсаалтыг ямар нэг байдлаар онцгойлон тэмдэглэхийг хүсэж болно.
3. Мэдэж авсан зүйлийнхээ талаар Мосед ямар сэтгэгдэл төрсөн гэж бодож байгаагаа, мөн яагаад гэдгийг тайлбарла.

Б Энэ нь яагаад чухал вэ?

1. Моце өөрийнхөө тухай мөн Бурханы тухай мэдсэн зүйлээ (Моце 1:1–11-ийг үз) Сатаныг дийлэхэд хэрхэн ашигласан бэ? (Моце 1:12–22-ыг үз).

2. Та нар амьдралдаа тохиолдсон уруу таталтыг даван туулахын тулд Моце 1:12–22 дахь Мосегийн үлгэр жишээг хэрхэн ашиглаж болох вэ?

В Төгс Эзэмших Судар—Моце 1:39

Моце 1:39 нь бүхий л учир шалтгаан нь Бурханы ажлууд хийгээд бүтээлүүдийн ард байдгийг бидэнд өгүүлдэг. *Үхэшгүй байдал* хийгээд *мөнх амьдралын* тодорхойлолт “Судруудыг ойлгох нь” хэсэгт байгааг ажигла.

1. Энэ шүлгийг тэмдэглэлийн дэвтэртээ дахин бичиж, “хүмүүний” гэдгийн оронд өөрийн нэрийг бич.
2. Бурханы зорилгуудыг мэдэх нь яагаад чухал вэ?
3. Үхэшгүй байдал хийгээд мөнх амьдралыг тохиолгон авчрахын тулд Бурхан ямар “ажил” хийсэн бэ?
4. Өөрсдөд тань Бурханы өгсөн зүйлсийг та нар хэрхэн ашиглаж байгаа вэ, яаж ашиглах гэж байна вэ?

Г Сонины сурвалжлагч бол

Энэ бүлэг дэх Мосегийн туршлагын дараа түүнтэй ярилцлага хийхээр асуулт тавьж буй сурвалжлагч гэж өөрийгөө бод. Түүнээс асууж болох таван асуулт бич.

Эхлэл 1; Моце 2

Бүтээлт

Судруудад Бүтээлтийн тухай гурван шастир байдаг нь: Эхлэл 1–2; Моце 2–3 (энэ бол Иосеф Смитийн Орчуулгын Эхлэл 1–2); Абрахам 4–5 юм. Энэ судлах удирдамж Эхлэлийн Иосеф Смитийн Орчуулгыг судлах тусламжаар хангадаг. Харин Абрахамын хувьд нэмэлт ойлголт өгдөг.

Зарим хүмүүс дэлхий тохиолдлоор бүтээгдсэн бөгөөд хүн төрөлхтөн олон сая жилийн туршид хоорондоо нэгдэн нийлэх элементүүд тохиолдлоор нэгдэх замаар бий болсон гэдэгт итгэдэг. Үүнд хариулж нэг зохиолч хэлэхдээ:

“Та нэгэн буланд олон тоосго овоолж орхиод, тэдгээр нь бие биетэйгээ нэгдэн байшин бий болохыг харах боломжийг надад олгоно уу? Түүнчлэн та атга дүүрэн нүриш, цагираг, эрэг шургийг миний ширээн дээр ассаад, эдгээр нь өөрсдөө нэгдэн цугларч, цаг болохыг харах боломжийг надад олгоно уу? Тэгвэл эдгээр мянга мянган дэлхий өөрсдөө бүтээгдэж, тэнцвэрээ олон, төлөвлөгч ямар ч оюун ухаангүйгээр өөрсдөө хэд хэдэн тойрог замд хөдөлгөөнд ордог гэдэгт итгэх нь миний хувьд амар хялбар байх болно.

“Түүнээс гадна хэрэв ертөнцөд оюун ухаан байдаггүй бол, тэгвэл ертөнц өөрөөсөө илүү агуу ямар нэг зүйлийг бүтээдэг байх нь учир нь энэ нь таныг бас намайг бүтээсэн байх нь” гэжээ (Брус Бартон, Е.Ернест Брамвелл, *эмхтгэсэн. Old Testament Lessons [1934 seminary course]*, 4).

Та нар унших үедээ, Мосе 2-т (Эхлэл 1) Мосе хүмүүний болон газар, тэнгэрийн дээрх бүх зүйлийн бүтээлтийн талаар юу гэж хэлэхийг хичээсэн талаар тунгаан бод.

Судруудыг ойлгох нь



Мосе 2

Миний төрсөн ганц (ш. 1, 26)—Есүс Христ

Хэлбэргүй (ш. 2)—
Одоогийн байгаа байдлаар зохион байгуулагдаагүй

Гүн (ш. 2)—Ус

Мандал (ш. 6–8, 14–15, 17, 20)—Сансар, огторгуй

Үрийг гаргагч (ш. 11–12, 29)—Төрүүлэгч, үр гаргагч

Жигүүртэн (ш. 21–22, 28, 30)—Шувууд

Үр жимстэй байгтун мөн өсөн үржтүгэй (ш. 22, 28)—
Хүүхдүүдтэй бол

Эзэгнэх (ш. 28)—Эрх мэдэлтэй буюу эзэгнэлтэй байх

Мосе 2:1 (Эхлэл 1:1)—Есүс Христ бол Бүтээгч мөн

Мосе 2:1; Абрахам 3:22–25; 4:1 нь Эцэгийн удирдлаган дор Есүс Христ дэлхийг бүтээснийг бидэнд өгүүлдэг. Өөр олон судар Судруудын Удирдамжид “Есүс Христ, Бүтээгч” гарчгийн дор энэ үнэнийг заадгийг та нар олж үзэж болно.

Судруудыг судлах нь



А Хуваарь гарга

Нэг дэх өдөр	Дөрөв дэх өдөр
Хоёр дахь өдөр	Тав дахь өдөр
Гурав дахь өдөр	Зургаа дахь өдөр

Тэмдэглэлийн дэвтрийнхээ нэг хуудсыг зургаа хувааж, нүд бүрийг харуулсны дагуу хаягла.

Нүд бүрд, тухайн өдөр Бурханы бүтээсэн зүйлүүдийн тухай бичиж эсвэл зургийг нь зур.

Б Энэ юу вэ? Мөн энэ юу биш вэ?

Мосе 2 дэлхий хэрхэн бүтээгдсэн талаар төдийлөн их зүйл өгүүлдэггүйг ажигла. Бидэнд ямар зүйлийг ойлгуулахын тулд үүнийг бичсэн бэ? (Мосе 1:31–33, 39-ийг үз).

В Төгс Эзэмших Судар—Эхлэл 1:26–27 (Мосе 2:26–27)

1. Эхлэл 1:26–27-г Мосе 2:26–27-той харьцуул. Эхлэл 1:26 дахь бид гэдэг үгийг ойлгоход Мосе 2:26 та нарт хэрхэн тусалдаг вэ?
2. Эхлэл 1; Мосе 2-г дүрсэлсэн бусад бүх бүтээлүүдээс хүн юугаараа ялгаатай вэ?

Эхлэл 2; Мосе 3

Еваг бүтээсэн нь



Эхлэл 2 (мөн Мосе 3) нь Бүтээлтийн түүхийг дуусгадаг. Энэ номноос бид Адамд өгсөн Бурханы зарлигуудын талаар, бусад бүх бүтээлүүдийн талаарх Адамын харилцааны тухай, түүнчлэн анхны эмэгтэй Еваг бүтээсэн тухай илүү ихийг бид мэддэг.

Судруудыг ойлгох нь



Мосе 3

Үеийнхэн (ш. 4)—Эхлэлүүд

Сүнслэг хэлбэрээр, сүнслэг (ш. 5, 7, 9)—Мөнхийн, үхлийн эрхшээлд байддаггүй

Жам ёсоороо (ш. 5, 9)—
Мөнх бус, эцэстээ хүрэх

Боловсруулах (ш. 5)—Газар хагалах

Махбод (ш. 5, 7)—Мөнх бус байдлын амьдрал

Хүрээ (ш. 9)—Нөхцөл

Нэгдэн нийлэх (ш. 24)—
Нэн ойр дотно, хамт байх

Мосе 3:4–9—Сүнсэн Бүтээл

Мосе 3:5-д дүрсэлсэн цаг үед, бүх зүйл “сүнс хэлбэртэй” байсан гэсэн нь тэд үхдэггүй гэсэн утгатай юм. Ахлагч Жозеф Фиелдинг Смит хэлэхдээ: “Адамын бие газрын тоосноос бүтээгдсэн юм. Гэвч тэр үед энэ нь сүнсэн дэлхий байжээ . . .

“ . . . Сүнсэн бие гэж юу вэ? Энэ бол цусаар биш, харин сүнсээр амьдруулагдсан бие юм . . .

“... Хориглогдсон жимс нь цус бий болгож, түүний мөн чанарыг өөрчлөн үхэшгүй байдлын оронд мөнх бус (үхэлт) байдлыг авчрах хүчтэй байжээ” гэжээ (*Doctrines of Salvation*, эмхтгэсэн, Брус Р.МкКонки, 3 боть. [1954–56], 1:76–77).

Өөрөөр хэлбэл, Бүтээлтийн тухай бидэнд байгаа шастирт, Адам Ева хоёр махбодон биетэй, гэвч тэд “сүнсэн” махбодон биетэй байсан тухай уншдаг. Тэр хоёр унахад, өөрчлөлт гарч (Моисе 4-т дүрсэлсэн шиг), тэгээд бүх зүйл “жам ёсны” болж, Адам Ева хоёр үхлийн эрхшээлд орсон гэсэн утгатай юм. Тийнхүү Адам Ева хоёр “жам ёсны” махбодон биетэй болжээ (2 Нифай 2:22-ыг үз). Та нар судрууддаа *сүнсний, жам ёсны* гэсэн үгсийг онцгойлон тэмдэглэж, эдгээр үгсийн тодорхойлолтыг судруудынхаа зах дээр бичихийг хүсэж болно.

Дараах схем Эхлэл 2; Моисе 3-т дүрсэлсэн Адамын оршихуйн өөр өөр үе шатыг тоймлон харуулдаг.



Моисе 3:15–17—Сайн ба муугийн мэдлэгийн модны жимс

Их Эзэн Еденийн Цэцэрлэгт Адам Ева хоёрт сонгох эрх чөлөөг олгосон юм. Сонгох эрх буюу сонголтууд хийж, эдгээр сонголтуудын төлөө хариуцлага хүлээх чадвар нь Бурхантай адилхан болохын тулд өсч хөгжиж болохын төлөө сонгох эрхээ хэрэгжүүлж, сайн ба муугийн мэдлэгийн модны жимснээс хүртэх хэрэгтэй болсон юм. Тэр модны жимснээс хүртэх нь Адам Ева хоёрт зөвхөн өсч хөгжихөд нь тусалсан төдийгүй, бас энэ нь Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүдийн үлдсэнийг нь дэлхийд ирж, өөрсдийн сонгох эрхийг хэрэгжүүлэх боломжтой болгосон юм (2 Нифай 2:22–27-г үз).

Уналт нь мөнхийн өсөлт дэвшилтэд зайлшгүй шаардлагатай юм бол, Бурхан эхлэлийг тавихын тулд Адам Ева хоёрыг яагаад унасан байдалд тавиагүй юм бол хэмээн зарим хүмүүс гайхдаг. Гэвч, хэрэв Тэнгэрлэг Эцэг хүмүүний мөнх бус байдлыг бий болгоход хүргэсэн юм бол, дараа нь тэрээр мөнх бус байдлын амьдралын улмаас хүмүүнд ирж болох бүх өвчин, нүгэл, уй гашууны төлөө бүрэн хариуцлага хүлээх учиртай. Жимсийг идэж, унахаар сонголт хийх эрх чөлөө Адамд байх ёстой байлаа. Сонгох эрхийн улмаас хүмүүн өөрийнхөө хувь заяаны төлөө хариуцлага хүлээх болдог. Мэдээжийн хэрэг, Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөө нь өөрийн хүүхдүүдийг энэхүү унасан байдлаас нь тэрээр гэтэлгэж болох арга хэрэгслийг ч бас багтаадаг. Гэвч тэд сонгох эрхээ дахин хэрэгжүүлж, уг төлөвлөгөөг хүлээн авах ёстой. Адам Ева хоёрт Бурхан сонгох эрхийн бэлгийг өгсөн учраас, мөн Адам Ева хоёр өөрсдийн сонгох эрхийг хэрэгжүүлсэн учраас бид Сайн мэдээний зарчмуудад тулгуурласан зөв шийдвэрүүд гаргаж, Бурхантай ихэд адилхан болж чадна.

Моисе 3:20–24 (Эхлэл 2:20–24)—Эмэгтэй хүнийг бүтээсэн нь

Еоөнхийлөгч Гордон Б.Хинкли Сүмийн эмэгтэйчүүдэд хандаж үг хэлэхдээ:

“Та нар бол [Тэнгэрлэг Эцэгийн] төлөвлөгөөний туйлын чухал хэсэг юм.

“Та наргүйгээр уг төлөвлөгөө үүргээ биелүүлж чадахгүй байсан. Та наргүйгээр уг хөтөлбөр бүхэлдээ хэрэгжихгүй байсан. . . . Бүтээлтийн үйл явц тохиоход, Бүтээгч Иехова, Эцэгийнхээ заавраар эхлээд харанхуйгаас гэрлийг салгаж, дараа нь газрыг уснаас тусгаарласан билээ. Дараа нь ургамлын амьдралын бүтээлт, үүний дараа амьтдын амьдралын бүтээлт залгасан юм. Дараа нь эрэгтэй хүний бүтээлт ирж, ингээд бурханлиг тэрхүү үйл ажиллагааны дээд оргил болсон эмэгтэй хүний бүтээлт ирсэн юм” гэжээ (in Conference Report, 1996 оны 10-р сар, 90; *Ensign*, 1996 оны 11-р сар, 67).

Судруудыг судлах нь

А Чухал үгсийг сонго

Хүндэтгэлийн өдрийн ач холбогдлыг хамгийн сайнаар ойлгож, өндрөөр үнэлэхэд бидэнд тусалдаг ямар дөрвөн үг Моисе 3:2–3-д байдаг гэж та нар бодлогоо сонгож, эдгээр үгс бидний ойлголтыг хэрхэн нэмэгдүүлдгийг тайлбарла.

Б Үүнийг өөрийнхөө үгээр ярь

1. Моисе 3:15–17-д Адам ямар зарлиг хүлээн авсан бэ?
2. Энэ зарлигийг зөрчсөний үр дагавар юу байж болно гэж Бурхан хэлсэн бэ?

Эхлэл 3; Моисе 4

Уналт

Хэрэв та хүнсний ногооны үр буюу гоё сайхан цэцэгний үрийг хэсэгхэн газарт тариад огт арчилж тордохгүй орхивол юу болох вэ? Хүнсний ногоонууд зэрлэг ургамлуудыг зулгааж, зайлуулдаг гэж үү? Хэрэв арчилж тордохгүй бол зэрлэг ургамлууд илүү сайхан буюу ашигтай зүйлүүдийг яагаад зайлуулдаг вэ?

Яагаад өдий олон хүмүүс зөвийн оронд бурууг сонгох нь тэдэнд амар хялбар байдаг вэ? Дэлхий дээр яагаад өдий их ёс бус явдал байдаг вэ? Гэм зэмгүй мэт хүмүүст яагаад өдий төдий хүнд сорилтууд тулгардаг вэ?

Уналт гэж бидний нэрлэдэг зүйлд эдгээр асуултуудын хариултуудыг эрэх учиртай. Адам Ева хоёр сайн ба муугийн мэдлэгийн модны жимснээс хүртэж, тэгээд Еденийн Цэцэрлэгээс болон Бурханы оршихуйгаас хөөгдөх үед Уналт тохиосон билээ. Адам Ева хоёрын хүүхдүүд болох бид нүгэл, хүнд сорилт, бэрхшээлүүд хийгээд үхлээр

дүүрэн дэлхийд, Бурханы оршихуйгаас гадна амьдрахыг өөртөө багтаадаг тэдний шийдвэрийн үр дагавруудыг өвлөн авсан юм. Гэвч, хэрэв Адам унаагүй бол бид хэзээ ч төрөхгүй, бас Тэнгэрлэг Эцэг өөрийн хүүхдүүдэд санал болгодог бүрэн дүүрэн баяр хөөрийг хүлээн авахын тулд хэзээ ч өсч хөгжиж чадахгүй байсан. Адам Ева хоёрын Уналтын илүү бүрэн түүх Библид бидний олж үздэгээс илүүгээр Мосе 4-т байгаа нь бидний адислал юм. Уналтын сургаалыг бусад ямар ч номноос илүү бүрэн дүүрэн тайлбарладаг Мормоны Ном бидэнд байгаа нь бүр илүү адислал юм.

Судруудыг ойлгох нь



Мосе 4

Гэтэлгэх (ш. 1)—Нүгэл, үхлээс аврах

Чиний болгоож буй (ш. 9)—Чиний харж буй

Эмэгтэй та хоёрын хооронд өс хонзон тавих (ш. 21)—Эмэгтэй хүн та хоёрыг бие биенээ үзэн ядаж, бие биенийхээ эсрэг дайсагнадаг болгох

Няцлах (ш. 21)—Бэртээх, гэмтээх

Нүүрнийхээ хөлсөөр (ш. 25)—Шаргуу ажиллаж

Херубим (ш. 31)—Нэгэн тэнгэрлэг биет

Мосе 4:4—Сатан мэхэлж, харалган болгож, боолчлолд оруулж чаддаг уу?

Мосе 4:4-д Сатан та нарын дээр хүчтэй болж чадах цорын ганц замыг дүрсэлдэг. Та нар судруудынхаа зах дээр дараах тайлбарыг бичихийг хүсэж болно: “Зөвхөн бид түүнд боломж олгохгүй л бол чөтгөр бидний дээр хүчтэй байж чадахгүй. Бурханаас ирдэг аль нэг зүйлийг бид эсэргүүцсэн үед л чөтгөр хүчтэй байдаг” (Иосеф Смит, *Teachings of the Prophet Joseph Smith*, эмхтгэсэн Жозеф Фиелдинг Смит [1938], 181).

Мосе 4:12—Сонголт

Мосе 5-ны эхний таван шүлэгт цэдэглэгдсэн үйл явдлуудыг хүртэл Адам Ева хоёр өөрсдийн сонголтын нөлөөг бүрэн ойлгоогүйг мэдэх нь чухал юм. Өөрөөр хэлбэл, Адамын сонголт нь энэ бол хийх ёстой зөв зүйл гэсэн түүний итгэл дээр тулгуурласан байжээ. Тэрбээр мөнх бус байдлын буюу эсвэл Бурханы оршихуйгаас гадна байж огт үзээгүй байлаа, иймээс түүний сонголтын үр дагавар юу байж болохыг тодорхой мэдэхгүй байжээ.

Сайн ба муугийн мэдлэгийн мод



Хүртвэл

Цэцэрлэгийг орхиж, үхлийн эрхшээлд орно, гэвч Бурхан шиг болох боломж бий.

Хүртэхгүй бол

Террестриел нөхцөлд үр удамгүй үлдэж, хэзээ ч үхэхгүй.

Мосе 4—Уналт

Уналтын улмаас Адам Ева хоёр биеийн хувьд мөн сүнсний хувьд аль алинаар нь үхэх байсан гэдгийг бид ойлгохгүй бол, Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөн дэх Уналтын ач холбогдлыг бид бүрэн ойлгож чадахгүй (Мосе 3:17-г үз). Сүнсний үхэл гэдэг бол Бурханы оршихуйгаас таслагдана гэсэн утгатай (Мосе 5:4-ийг үз). Биеийн үхэл гэдэг бол, сүнс, бие хоёр сална гэсэн үг. Хэдийгээр Адам Ева хоёр жимсийг идсэн тэр даруйд биеийн хувьд үхээгүй боловч, эцэстээ тэднийг үхэхэд хүргэх өөрчлөлт Адам Ева хоёрт гарсан ажээ. Эцэстээ тэд яг Бурханы хэлснээр биеийн хувьд үхэх байв. Биеийн буюу сүнсний үхлийг даван туулах хүч Адам Ева хоёрт байсангүй. Эдгээр үнэнүүдийг мэдэх нь тэдэнд, мөн тэдний хүүхдүүд болох бидний хувьд Аврагч болоод Цагаатгал яагаад хэрэгтэйг ойлгоход бидэнд тусална. Уналтын дараа Адам Ева хоёрт Цагаатгалын тухай заажээ. Эдгээр сургамжуудын заримыг нь бид Мосе 5-д уншдаг.

Судруудыг судлах нь



А Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөө

Тэнгэрлэг Эцэг	Сатан
<input type="checkbox"/>	
<input type="checkbox"/>	
<input type="checkbox"/>	

1. Тэмдэглэлийнхээ дэвтэрт хоёр багана гарга. Нэг дэх багананд “Тэнгэрлэг Эцэг” хоёр дахь багананд “Сатан” гэж бич.

Багана тус бүрд Тэнгэрлэг Эцэг буюу Сатаныг дүрсэлсэн үгс болон өгүүлбэрүүдийг Мосе 4:1–4-өөс бич. Тэнгэрлэг Эцэг өөрийн авралын төлөвлөгөөг эдгээр дөрвөн шүлэгт дүрслэгдсэн үйл явдлууд

дыг тохиохоос өмнө мөнх бус байдлын өмнөх дэлхийд өөрийн сүнсэн хүүхдүүдэд танилцуулсныг мэдэх нь энэ дасгалыг хийх үед та нарт тусалж болох юм. Бид түүний оршихуйгаас гадна байхыг, түүнчлэн бидний гэтэлгэлийн төлөө нэгэн Аврагч өгөгдөх болно гэдгийг Тэнгэрлэг Эцэг тайлбарлажээ.

- Есүс Сатан хоёр ямар ялгаатайг дүрсэлсэн нэг догол мөр бич. Жишээ нь, тэдний хүслүүдэд ямар ялгаа байдаг вэ?



Б Тэмдэглэл бич

Та өөрийгөө Мосе 4-ийн үйл явдлууд дахь Ева гэж төсөөлөн бод. Та өөрийгөө Ева гэж бодон тэмдэглэл бич. Жимсийг идэх эсэх талаар бодож байхад чинь ямар сэтгэгдэл төрөх байсан тухай мөн юу чамайг жимсийг идэхэд хүргэх байсан гэдгийг бич. Тэгээд жимсийг идсэний дараа, түүнчлэн сонголтын чинь үр дагавруудын тухай Их Эзэний хэлсэн зүйлийн талаар танд ямар бодол төрж болох тухай бич.

ЭСВЭЛ

Та өөрийгөө Мосе 4-ийн үйл явдлууд дахь Адам гэж төсөөлөн бод. Ева жимсийг идсэн гэдгийг мэдсэний дараа өөртөө төрж болох бодлуудыг бич (Мосе 2:27–28; 3:23–24-ийг үз). Үр дагавруудыг нь мэдсээр байж, та яагаад жимсийг идэхээр шийдсэнээ тайлбарла (Мосе 3:16–17; 4:9-ийг үз), мөн өөрийн чинь сонголтуудын талаар Их Эзэний хэлсэн зүйлийн талаар танд ямар бодол төрөх вэ? Бичихэд чинь дараах ишлэл танд тусалж болох юм: “Адам . . . мэхлэгдээгүй юм; харин Евагийн хүссэнчлэн, тэрээр өөрийг нь Бий Боллогчийн зорилгуудыг гүйцэлдүүлж болохын тулд үүнийг хийхийг зориудаар шийдсэн юм” (Жеймс И.Талмейж, *Faith of Articles* [1960], 69–70).

В Сонгож хийх үйл ажиллагаа

- Еденийн Цэцэрлэгээс хөөгдөх үед Адам Ева хоёрт юу тохиолдсоныг товчхон дүрсэл. Алма 12:21–37; 42:2–28-ыг уншиж, сайн ба муугийн мэдлэгийн модны жимснээс идсэнийх нь дараахан Их Эзэн Адам Ева хоёрыг амьдралын модны жимснээс идэхээс хамгаалсан шалтгааныг ол.
- Энэ амьдралд ямар зүйлүүдийг хийх нь чухал болох тухай Их Эзэний нэрлэсэн шалтгаанууд бидэнд юуг өгүүлдэг вэ?

Эхлэл 4; Мосе 5

Золиослол ба Адамын гэр бүл

Еденийн Цэцэрлэгээс болон Их Эзэний оршихуйгаас хөөгдсөн нь Адам Ева хоёрын хувьд аймшигтай байсан нь гарцаагүй. Мөнх бус байдлыг тэд хэзээ ч биеэр үзээгүй байлаа. Тэд Бурханы оршихуйд яаж дахин очиж чадах вэ?

Адам Ева хоёрын нэгэн адил, бид Бурханы оршихуйгаас таслагдсан юм. Ингэхлээр энэ асуудал бидэнд ч бас хамаатай.

Адам Ева хоёр Еденийн Цэцэрлэгээс болон Их Эзэний оршихуйгаас хөөгдсөн тухай түүхийг тэд Их Эзэний оршихуйд дахин амьдрах найдваргүй болсон мэтээр Эхлэл өгүүлдэг.

Аз болоход, дэлхийн бүтээлтээс өмнө нэгэн төлөвлөгөө бэлтгэгдсэн байсан бөгөөд Уналтын улмаас дэлхийд бий болсон нүгэл хийгээд үхлээс өөрөө болон үр удам нь гэтэлгэгдэж бас чөлөөлөгдөж чадна гэдгийг Адам мэдэж авсан тухай Эхлэлд байдаггүй сүнсэлгээр нөлөөлөгдсөн нэмэлтүүд Мосегийн номонд агуулагддаг.

Мосе 5 нь гэтэлгэл хийгээд Цагаатгалын тухай үнэнүүдээс гадна Сатан болон түүний дагалдагчид Христээр дамжин ирэх гэтэлгэлийн захиасыг зөрчихөд нь Адамын гэр бүлд мөнх бус байдлын өмнөх амьдралаас эхлэн нөлөөлөхөөр хичээж байсан тухай шастирыг агуулдаг. Та нар унших үедээ, Их Эзэний зөвлөгөөг сонсохоос татгалзаж, үүний оронд Сатаны зөвлөгөөг дагасан хүмүүст юу тохиолдсоныг ажигла.

Судруудыг ойлгох нь



Мосе 5

Дуныхаа хөлсийг дуслуулан байж (ш. 1)—Хүнд хөдөлмөрөөрөө

Хоёр хоёроороо хуваагдах (ш. 3)—Эцэг эхчүүдээсээ тусгаарлаж, гэрлэх (ингэснээрээ хоёр хоёроороо хос болох)

Ууган төлүүд (ш. 5, 20)—Анхны төрсөн хурга, тугал, ишиг гэхчлэн

Гэтэлгэгдэж (ш. 9)—Нүгэл, үхлээс аврагдаж

Гэтэлгэл (ш. 11)—Нүгэл, үхлийн үр дагавруудаас чөлөөлөгдөх

Мөнх бус байдлын (ш. 13)—Биеийн хэрэгцээ, зугаа цэнгэл, хүсэл тачаалд санаа тавьдаг

Тачаангуй (ш. 13)—Тачаал хүслийн цэнгэл буюу өөрөөр хэлбэл, хүрч, харж, сонсож болох зүйлүүдэд санаа тавин эрхэмлэдэг

Яллагдах (ш. 15)—Өсөлт дэвшилт нь зогсох

Түүний төрх байдал алдаг-
дав, төрх байдал алдагдах
(ш. 21–22)—Тэрээр хөмсөг
зангидан, муухай харав

Хүч чадлаараа чамд өгөх
(ш. 37)—Чамд хангалттай
хүнс өгөх

Зугтагч, хэрэн тэнүүчлэгч
(ш. 37, 39)—Оргон босогч,
тэнүүлчин (тэрээр гэр бү-
лээсээ таслагдана гэсэн ут-
гатай)

Өс хонзон (ш. 40)—
Шийтгэл

Тохинуулсангүй (ш. 52)—
Адисалсангүй

Ноёрхох (ш. 55)—Ихэд
нөлөөтэй болох

Цагийн голч (ш. 57)—
Хамгийн чухал цаг үе (Энэ
нийлмэл үг нь Есүс Христ
ирж, өөрийн цагаатгагч
үүрэг зорилгыг гүйцэтгэх
үеийг хэлж байна).

Судруудыг судлах нь



Мосе 5-ыг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А–Д) наад тал нь гурвыг хий.

А Эдгээр өгүүлбэрүүдийг дуусга (Мосе 5:4–11-ийг үз.)


1. Адам тахилууд өргөдөг байв, учир нь . . .
2. Тэнгэр элчээс Адам . . . мэджээ.
3. Адам Ева хоёр . . . ухамсарлан ойлгов.

Б Харьцуулалт хий

Мосе 5:7–8-д тэнгэр элч Адамд түүний тахилууд юуг төсөөлснийг тайлбарлажээ, мөн Мосе 5:9-д, Аврагчийн үүрэг бол төгс гэтэлгэгч золиослол хийх явдал гэдгийг Ариун Сүнс тайлбарлажээ. Тэмдэглэлийнхээ дэвтэрт дараах асуултуудад хариул: (1) Өнөө үед бид Адамын адил шатаалт тахилууд өргөл болгодоггүй ч гэсэн, мөн үүнтэй нэг ижил зорилготой ямар ёслолуудад бид оролцдог вэ? (2) Хийж буй бүх зүйлээ “Хүүгийн нэрээр” үйлдсэнээр (ш. 8), Төрсөн Ганцын золиослол, гэтэлгэлд эдгээр ёслолууд ямар учир холбогдолтой байдаг вэ?



Адамын үе



Манай үе

В Мормоны Номноос нэмэлт ойлголтуудыг олж ав

Мосе 5:9–11 нь Уналтын улмаас Адам Ева хоёр болон тэдний үр удмын хүлээж авсан адислалуудаас заримынх тухай өгүүлдэг. 2 Нифай 2:19–27-г уншиж, Адам Ева хоёр яагаад Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөний зайлшгүй чухал хэсэг байсан тухай, мөн Уналт бидний хувьд хэрхэн адислал болсон тухай энэ хоёр ишлэлээс мэдэж авсан зүйлээ хураангуйлан бич.

Г Каины асуултуудад хариул

Өнөө үед ч гэсэн хүмүүс асуусаар байдаг хоёр чухал асуултыг Каин асуусан байдаг (Мосе 5:16, 34-ийг үз). Түүний асуултуудын зөв хариултуудыг тайлбарласан захидал бич.

Д Сатаны уруу таталтууд

Мосе 5:12–13-ыг уншиж, Адам Ева хоёрын болон Сатаны хийсэн үйлдлүүдийн талаар тунгаан бод.

1. Өнөө үед Сатаны ийм нөлөөг та нар ямар хэлбэрээр хардаг вэ?
2. Өөрийн уруу таталтуудад Сатан юуг “зарладаггүй” вэ? (Мосе 5:41, 52–54; түүнчлэн Алма 30:60-ыг үз).

Эхлэл 5; Мосе 6

Сайн мэдээний анхдагч зарчмуудыг Енох заав

Адам Ева хоёр хуульд дуулгаваргүй байсны улмаас унасан юм, ингээд тэд Бурханы оршихуйгаас “таслагдсан” билээ (Мосе 5:4). Дуулгаваргүй байдал хүмүүсийг Бурханаас хэрхэн холдуулдгийг бид Мосе 5-д Каин, Ламех болон бусад хүмүүсийн жишээнээс уншдаг. Адам Ева хоёр Еденийн Цэцэрлэгийг орхисны дараа, сургаалуудыг ойлгож, тэдгээрийн дагуу амьдрах хийгээд гэрээнүүдийг хийж, тэдгээрийг сахихыг тэдэнд заасан ажээ. Бурханы оршихуйд эргэн очиж, тэнд амьдрахын тулд авралын ямар ёслолууд тэдэнд шаардлагатайг тэд бас мэджээ. Эдгээр сургамжуудын олон нь Мосе 6-д байдаг. Бошиглогч Енох өөрийнх нь хүмүүс гэтэлгэгдэж, тэд Бурханы оршихуйд буцаан аваачигдаж болохын тулд нүглүүд хийгээд ёс бус явдлуудаасаа наманчлахад нь тэдэнд сүнслэгээр нөлөөлөхийг хичээн, эдгээр үнэнүүдийг тэдэнд заадаг байв.



Судруудыг ойлгох нь



Моисе 6

Удмын бичиг (ш. 8, 22)—
Гэр бүлийн түүх

Бурханы хөлийн гишгүүр
(ш. 9)—Дэлхий (ш. 44-ийг үз)

Эзэгнэл (ш. 15)—Хүч

Дүрэлзэж байна (ш. 27)—
Өсөн нэмэгдэж эхлэв

Тогтоол (ш. 30)—Албан ёс-
ны мэдэгдэл

Цоо хатгах (ш. 32)—Хор
хүргэх, алах

Зөвтгөх (ш. 34)—Тохиолгон
авчрах

Анхны гэм (ш. 54)—Адам
Ева хоёрын зөрчил

Нүгэлд төрөх (ш. 55)—
Нүгэлт дэлхийд, унасан дэл-
хийд амьдардаг бөгөөд
өөрсдөө нүгэл үйлддэг эцэг
эхчүүдэд төрөх

Нүгэл боловсрох (ш. 55)—
Нүгэл өсөн нэмэгдэхийн
төлөөх хүсэл

Зөвтгөгддөг (ш. 60)—
Нүглийн гэм болон шийтгэ-
лээс чөлөөлөгдөх,
өршөөгдөх, уучлагдах

Судруудыг судлах нь



Моисе 6-г судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А–Д) наад тал нь гурвыг хий.

А Агуулгын товъёг хий

Моисе 6:5–25-д дүрслэгдсэн номны хувьд агуулгын товъёг нь ямархуу харагдах болно гэж та бодож байгаага бич.



Б Гэр бүлийнхээ тухай бич, эсвэл гэр бүлдээ бич.

- Моисе 6:45–46-д өгүүлснээр, Енох болон түүний хүмүүс өөрсдийн өвөг дээдсийг (эцгүүдийг) юуны учир мэддэг болсон бэ?
- Хөтөлсөн цэдгийнхээ улмаас өөрийнхөө “мэддэг” болсон өвөг дээдсийнхээ нэгнийх нь тухай бич. Өөрийг чинь илүү сайн болоход сүнслэгээр нөлөөлдөг тэдний тухай ямар нэг зүйлийг оруул.

ЭСВЭЛ

Өөрийнхөө тухай үр удам чинь мэдээсэй хэмээн хүсдэг нэг зүйлийн тухай бич. Ерөнхийлөгч Кимбаллын дараах үгсийг анхаар:

“Тэмдэглэлийн дэвтрээ ав. . . Өнөөдөр эхэлж, өөрт чинь ирдэг, өөрөөс чинь гардаг зүйлүүдийн тухай,

өөрсдийнхөө гүнзгий бодол санаануудын тухай, өөрийнхөө амжилт ололтууд хийгээд бүтэлгүйтлүүдийн тухай, өөрийнхөө хэлхээ холбоо хийгээд ялгуусан зүйлүүдийн тухай, өөрийн сэтгэгдлүүд хийгээд гэрчлэлүүдийн тухай тэмдэглэлийн дэвтрээ бич” (Спенсер В.Кимбалл, “The Angels May Quote from It,” *New Era*, 1975 оны 10-р сар, 5).

В Тэдгээр нь юуг дүрсэлдэг вэ?

- Енохын үеийн хүмүүсийн нүглүүдийг дүрсэлсэн: “зүрх сэтгэл нь хатуурч,” “чих нь сонсоход дүйрэнгэ байна,” “нүд нь холыг харж чадахгүй байна,” “тэд намайг үгүйсгэсэн,” “харанхуйд тэд өөрсдийнхөө зөвлөгөөг эрэлхийлсэн,” “аллагыг төлөвлөсөн,” “зарлигуудыг [Адамд өгсөн] сахьсангүй,” “хуурамчаар тангарагласан байна” гэсэн өгүүлбэрүүдийг Моисе 6:27–29-өөс ол. Та нар эдгээр өгүүлбэрүүдийг судрууддаа доогуур нь зурах буюу онцгойлон тэмдэглэж болно.
- “Зүрх сэтгэл нь хатуурсан,” “чих нь сонсоход дүйрэнгэ,” “нүд нь холыг харж чадахгүй” гэдгээр юуг дүрсэлсэн гэж та нар боддог вэ, “харанхуйд зөвлөгөө эрэлхийлэх” гэсэн нь юу гэсэн утгатайг дүрсэл.
- Дээрх дүрслэл бүрийн эсрэг, зөв шударга хүмүүсийг дүрсэлдэг тодорхойлолтыг хэл. Өөрөөр хэлбэл, Сайн мэдээгээр дамжуулан зүрх сэтгэл _____ болно, нүднүүд _____ болно гэхчлэн.

Г Их Эзэнээс ирдэг дуудлага

- Моисе 6:31-д өгүүлснээр, Их Эзэнээс өөрт нь ирсэн дуудлагын талаар Еноход ямар санагдсан гэж боддоого тайлбарла.
- Моисе 6:32–36-д Их Эзэн өөрт нь үйлдсэн хийгээд хэлсэн зүйлсийн талаар Еноход ямар сэтгэгдэл төрсөн гэж бодож байгаагаа тайлбарла.
- Моисе 7:13–19-ийг уншиж, Еноход өгсөн Их Эзэний амлалтууд хэрхэн биелэгдсэн тухай бич.

Д Бид өөрсдийн өвийг Тэнгэрлэг Эцэгээс хэрхэн хүлээж авдаг вэ?

Уналтын улмаас	Уналтаас хэрхэн чөлөөлөгдөх вэ
•	
•	
•	

Бурханы хүүхдүүдийн хувьд бид түүнд байдаг бүхнийг өвлөх эрхтэй. Гэвч бид нүгэл үйлдэж, цэвэр ариун биш болох юм бол цэвэр ариун биш зүйлүүд Бурханы хаант улсыг өвлөж чадахгүй. Хэрхэн цэвэр ариун болж, улмаар мөнх амьдралыг өвлөхөд тохирч болохыг Их Эзэн Адамд заажээ. Мөн эдгээр зүйлүүдийг Енох өөрийн хүмүүст заадаг байв. Моисе 6:48–68-ыг уншиж, дараа

нь үзүүлсний адил схем хий. Эхний баганад Уналтын улмаас тохиосон зүйлүүдийг жагсаан бич. Хоёр дахь баганад Уналтын үр дүнд бий болсон зүйлсээс хэрхэн чөлөөлөгдөж болохыг жагсаан бич.

Эхлэл 5; Моисе 7

Сион Тэнгэрт аваачигдсан нь

Бурхан дэлхий дээрх өөрийнхөө хүүхдүүдийн ёс бус явдлыг хараад юу гэж бодох буюу түүнд ямар бодол төрөх бол гэж та хэзээ нэгэн цагт бодож үзсэн үү? Бурхан өөрийн хүүхдүүдийг хэрхэн хардгийг, тэдний ёс бус явдлын талаар түүнд ямар бодол төрдгийг, түүнчлэн ёс бус явдал эцсийн эцэст устгагдах болно гэдгийг ойлгоход Моисе 7 бидэнд тусалдаг.

Судруудыг ойлгох нь



Моисе 7

Хилэнгийн галт зэвүүцэл, миний хилэнгийн галт зэвүүцэл (ш. 1, 34)—Хүнд шийтгэл

Өөрсдийгөө хуваах (ш. 7)—Тархан суурьших

Өргөө (vш. 21, 64)—Амьдардаг газар, гэр орон

Хөшгүүд өдий хүртэл сунгагдсан байгаа (ш. 30)—Бүтээлүүд одоо ч гэсэн үргэлжилсээр байгаа

Цээж (ш. 30, 31, 63, 69)—Дотоод эрхтэнүүд, ямар нэг зүйлд нэн ойр дотно байхын бэлэгдэл

Таны хаан сэнтийн мөн чанар (ш. 31)—Таны орши-хуйд амьдардаг зүйл

Миний мэлмий тэдгээрийг цоо ширтэж чадна (ш. 36)—Миний нүд тэдгээрийг

голд нь ортол нэвт харж чадна.

Миний сонгосон тэр, миний Сонгосон (ш. 39)—Есүс Христ

Түүний дотор өрөвч сэтгэлээр дүүрэн (ш. 41)—Түүнд харууслын нэн хүчтэй бодрол төрөв

Цаг уурын (ш. 42)—Биеийн

Цагийн голч (ш. 26)—Хамгийн чухал цаг үе (Энэ холбоо үг нь Есүс Христ ирж, өөрийн цагаатгагч үүрэг зорилгыг гүйцэтгэх үеийг хэлж байгаа болно.)

Бүсээ бүсэлж (ш. 62)—Бэлтгэж

Моисе 7:16–20—Сионыг байгуулж, төлөвшүүлэх нь Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл манай өнөө үед Сионыг төлөвшүүлэх тухай хэлэхдээ:

“Хэрэв бид Сионыг дахин авчрах ёстой боллоо гэхэд, бидний хийх ёстой гурван гол тулгуур зүйлийг санал болгохыг надад зөвшөөрнө үү . . .

“Нэгдүгээрт, бодгалийг урхидаж, зүрх сэтгэлийг агшаан, оюун ухааныг харанхуйлдаг амиа хоохойлсон хувь хүний хандлагыг үгүй болгох ёстой. . .

“Хоёрдугаарт, бид төгс байдлаар хамтран, бие биентэйгээ эв нийцтэй ажиллах ёстой. Бидний шийдвэрүүдэд нэгдмэл санаа, бидний үйл ажиллагаануудад эв нэгдэл байх ёстой . . .

“Хэрэв Их Эзэний Сүнс бидний ажил хөдөлмөрийг өргөжүүлэн тэлж байвал, нэгдмэл санаа, хамтын ажиллагааны сүнс бидний хийдэг бүх зүйлд давамгайллагч сүнс байх ёстой . . . (Teachings of the Prophet Joseph Smith, x. 1983.) . . .

“Гуравдугаарт, Их Эзэний шаарддаг юуг боловч бид өгөх буюу золиослох ёстой. Бид ‘харууссан зүрх, гэмшсэн сэтгэлийг’ өргөл болгосноор эхэлдэг. Бид ажил хөдөлмөрийн талбартаа болон дуудлагууддаа өөрсдийн хүч чармайлтыг дээд зэргээр дайчлан ажилласнаар үүнийг дагадаг. Бид өөрсдийн үүрэгт суралцаж, үүнийг бүрэн биелүүлдэг. Эцэст нь бид өөрсдийн үе үеийн удирдагчдаар уриалан дуудуулж, Сүнсний шивнээгээр өдөөгдсөнөөр, өөрсдийн цаг зав, авьяас чадвар, хөрөнгө мөнгийг өргөлд өргөдөг билээ” гэжээ (in Conference Report, 1978 оны 4-р сар, 122–24; or Ensign, 1978 оны 5-р сар, 81).

Золиослол	Хүч чармайлт	Өргөл
Хамтын ажиллагаа		Эв нэгдэл
Аминч үзэл		

Судруудыг судлах нь



Моисе 7-г судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А–Г) наад тал нь хоёрыг хий.

А Төгс Эзэмших судар—Моисе 7:18

Моисе 7:4–27-г уншиж, Енохын хүмүүсийн нэг хэсэг байх нь юутай адилхан байж болохыг төсөөл. Өөр газар амьдардаг бөгөөд Сион шиг сайхан газрыг хэрхэн бий болгохыг мэдэхийг хүсдэг, санаандаа төсөөлсөн нэг найздаа захидал бич. Моисе 7 дахь мэдээллийг, ялангуяа шүлэг 18-ыг ашиглан, Сионыг төвхнүүлж, тэнд амьдрахад юу шаардлагатайг найздаа бич. Найзаа урамшуулан дэмжиж, “аминч үзлийг үгүй болгохын тулд” эсвэл Ерөнхийлөгч Кимбаллын зөвлөмж болгосон зүйлүүдийн нэгийг хэрэгжүүлэхэд өөрийн чинь насны хүн юу хийж болох тухай зөвлөгөөг түүнд өг. Найз чинь эхлээд гэр бүлдээ, дараа нь Сүмд буюу хамт олны дотор юу хийж болоход тусгайлан анхаар.

Б Их Эзэнийг юу уйлахад хүргэдэг вэ?

1. Моисе 7:29–31-д Их Эзэн яагаад уйлсныг Енох асуусан байдаг. Шүлэг 31–40-ийг уншиж, Енохын асуултын хариуг бич.
2. Моисе 7:41-д өгүүлснээр, Енох өөрийнх нь асуултад өгсөн Их Эзэний хариултыг ойлгоод тэрээр юу хийсэн бэ?
3. Их Эзэн Енох хоёр өнөө үеийн дэлхийг хараад юуны тул тэд уйлах байсан гэж та нар боддог вэ?

В Енохын асуултуудад хариул

Моисе 7:42–67-г уншиж Их Эзэнээс Енохын асуусан асуултуудыг ол. Асуулт бүрийг тэмдэглэлийн дэвтэртээ бичиж, дараа нь Их Эзэний хариултын хураангуйг оруул.

Г Дүрслэлийг тайлбарла

Моисе 7:62-д, эцсийн өдрүүд дэх Сайн мэдээний Сэргээлтийн тухай Еноход хэлсэн байдаг. Хоёр дахь Ирэлтэд бэлтгэхийн тулд бүх дэлхийгээс “сонгогдогсдыг” цуглуулахад туслахад тохиох хоёр чухал зүйлийн талаар бас түүнд хэлжээ: “Зөв шударга ёсыг би тэнгэрээс доош илгээх болно; мөн үнэнийг би дэлхийгээс илгээх болно” Сэргээлтийн хэсэг болж тохиосон үйл явдлуудын талаар мэдэх зүйлээ авч үзэн, Их Эзэн юуны тухай хэлсэн гэж бодлогоо тайлбарла.



Эхлэл 6; Моисе 8

Ноагийн номлол

Их Эзэн дэлхийг ёс бус явдлаас цэвэршүүлэх тусдаа хоёр цаг хугацааны тухай судруудад өгүүлдэг. Эхнийх нь Ноагийн үед байлаа (Эхлэл 6-г үз), хоёр дахь нь Хоёр дахь Ирэлтийн үед байх болно. Агуу Үнэт Сүвд дахь Иосеф Смит—Матай 1:41–43-т, энэ хоёр цаг хугацаа бие бие-тэйгээ адилхан байх шалтгаануудын тухай өгүүлдэг. Энэ хоёр цаг хугацааны хамгийн том ялгаа нь Ноагийн үед дэлхий усаар цэвэршигдсэн бол, Хоёр дахь Ирэлтэд энэ нь галаар цэвэршигдэх болно. Энэ хоёр үйл явдал нь бид Ариун Сүнсний бэлгийг жинхэнэ ёсоор хүлээн авах үед тохиодог бодгалийн цэвэршилт—усан баптисм, түүнчлэн галын баптисмаар бид хэрхэн цэвэршигддэгийн хэв шинж юм.

Эхлэл 6–9 нь Ноагийн болон Үерийн түүхийг өгүүлдэг. Та нар унших үедээ Их Эзэн ёс бусчуудыг устгасан шалтгаануудыг олж, тэднийг устгах нь яагаад өөрийн бүх хүүхдүүдийн авралын төлөө түүний хийж чадах хамгийн сайн боломжит зүйл байсныг тайлбарла. Ноагийн үеийг манай өнөө үе—дэлхий галаар цэвэршигдэхийн өмнөх үетэй хэрхэн харьцуулж болохыг бас авч үз.

Моисе 8 бол Эхлэл 5:23–32; 6:1–13-ын Иосеф Смитийн Орчуулга юм, иймээс та нар Эхлэл 6:14–22-ыг уншихын өмнө Моисе 8-ыг уншиж болно. Моисе 8 бол Агуу Үнэт Сүвд дахь Мосегийн сүүлчийн бүлэг болохыг ажигла. Хуучин Гэрээний үлдсэн хэсгийн хувьд, унивал зохих мэдээлэл нь Судруудын Удирдамж дахь “Библийн Иосеф Смитийн Орчуулгуудаас авсан түүвэрүүдэд” байдаг.

Судруудыг ойлгох нь



Моисе 8

Түүний хэвлийн үр (ш. 2)—
Түүний үр удам

Бурханы хөвгүүд (ш. 13,
21)—Их Эзэнтэй гэрээ хий-
сэн хүмүүс

Хүмүүний хөвгүүд (ш. 14)—
Их Эзэнтэй гэрээ хийдэггүй
буюу түүнийг дагадаггүй

Өөрсдийгөө худалдлаа
(ш. 15)—Гэрээнээс гадуур
гэрлэлт

Хөөрч (ш. 22)—Өөрийгөө до-
вийлгөн, даруу бус авирлах

Түүний сэтгэлийг эмзэг-
лүүлэв (ш. 25)—Түүнийг
ихэд харамсахад хүргэв

Ач ивээлийг олов (ш. 27)—
Адислалууд болоод хүчийг
хүлээн авав, сайшаагдав

Маханбод (ш. 29)—Хүмүүс

Эхлэл 6

Тохой (ш. 15–16)—Насанд
хүрсэн хүний тохойноос
дунд хурууны үзүүр хүртэлх

зай (ойролцоогоор дөчин
таван сантиметр буюу арван
найман инч)

Моисе 8; Эхлэл 6—Их Эзэн дэлхийг яагаад Үерт автуулсан бэ

Ноагийн гэр бүлээс бусад дэлхий дээрх бүх хүмүүсийг Их Эзэн яагаад устгахаар шийдсэнийг тайлбарлахад Ерөнхийлөгч Жон Тейлор тусалжээ. Хүүхдүүд нь сонголтгүйгээр ёс бус болж өсөх хүртлээ дэлхий тийм их ёс бус болсон байлаа хэмээн Ерөнхийлөгч Тейлор хэлжээ. Тэр үед зөв шударга ёсыг сонгох боломжгүй байж, гэм зэмгүй сүнснүүдийг тэнгэрээс дэлхий уруу илгээх нь зогссон байв. Иймээс, Их Эзэн бүх ёс бусчуудыг устгаж, Ноагийн гэр бүлээс зөв шударга, эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийг дахин өсгөн бойжуулахаар шийдсэн ажээ. “Тэдний дэлхийн оршин тогтнолыг үгүй болгосноор тэд өөрсдийн нүглүүдийг үр удамдаа өвлүүлэхээс [өв болгон өгөхөөс], түүнчлэн тэднийг бууран доройтохоос тэрээр урьдчилан сэрэмжилсэн юм. Тэрчлэн бас тэднийг цаашид ёс бус үйлүүд үйлдэхээс урьдчилан сэрэмжилсэн юм” (in *Journal of Discourses*, 19:158–59). Хэрэв Бурхан дэлхийг үерт автуулаагүй бол, түүний агуу төлөвлөгөө гүйцэлдэж чадахгүй байв. Их Эзэн яагаад ийнхүү үйлдсэн талаар 2 Нифай 26:24-д Нифайн хэлсэн зүйлийг унш.

Судруудыг судлах нь




Эхлэл 6; Моисе 8-ыг судлахдаа дараах дөрвөн үйл ажиллагаанаас (А–Г) гурвыг нь хий.

А Их Эзэнээс бидэнд ирдэг дуудлагыг хэрэгжүүлэх заавар

1. Бид ариусч, өөрсдийн бодгалиудад авралыг авчрах нэг арга зам бол бусдад авралыг авчрахын тулд өөрсдийн

бүх хүч чадал, оюун ухаан, чадлаар ажиллах явдал мөн хэмээн Их Эзэн Сургаал ба Гэрээний 4:2–4-г хэлжээ. Ноа бол энэхүү үйл явцын онцгой жишээ мөн. Доорхтой адил схемийг тэмдэглэлийн дэвтэртээ хийж, Мосе 8:14–27-гоос өөрсдийн олох мэдээллээр үүнийг бөглө. Та нар энэ үйл ажиллагааг хийхдээ, Их Эзэнээс ирсэн дуудлагадаа Ноа хэрхэн хичээл зүтгэл гаргаж байсныг ажигла. Бас тэрээр хүч чадал хийгээд хүчээр хэрхэн адислагдсанд, мөн Их Эзэн түүнд болон түүний хүч чармайлтуудад баяртай байсныг яаж мэдсэнд анхаарлаа хандуул.

Их Эзэн юу хийсэн бэ Ноа юу хийсэн бэ Хүмүүс юу хийсэн бэ



- Хайрцгийг Мосе 8:27-гоор бөглөсний дараа, хичээнгүй хөдөлмөрийнхөө үр дүн болгон Ноагийн хүлээж авсан зүйлийг илүү бүрэн ойлгохын тулд “ач ивээл” гэдэг үгийг Судруудын Удирдамжаасаа хар. Өөрсдийнхөө схемийн доор ач ивээлийн тухай товч тодорхойлолт бич.

Б Ялгаа нь юу вэ?

- Мосе 8:13–14, 21-ийг, түүнчлэн дээрх “Судруудыг ойлгох нь” хэсэг дэх “Бурханы хөвгүүд,” “хүмүүний хөвгүүдийн” тодорхойлолтуудыг унш. Бурханы хөвгүүд охид, хүмүүний хөвгүүд охидын хоорондох ялгааг тайлбарла. Эдгээр дөрвөн бүлэгт ямар ямар хүмүүс багтаж болохыг тайлбартаа оруул.
- Мосе 8:15–22-т өгүүлснээр, хүмүүний охидтой гэрлэсэн Бурханы хөвгүүд, эсвэл Бурханы охидтой гэрлэсэн хүмүүний хөвгүүдийн тухай Их Эзэний хэлсэн зүйлийг мөн энэ нь яагаад тийм чухал гэж бодож буйгаа тайлбарлана уу?

В Ойлгоогүй хүнд тайлбарла


“Хайрлагч Бурхан хэрхэн дэлхийг үерт автуулж чадсан юм бол?” гэсэн асуултад хариулахын тулд дээрх “Судруудыг ойлгох нь” хэсэг дэх мэдээллийг Мосе 8-д өөрсдийн уншсан зүйлийн хамт ашигла.

Г Үүнийг хэмжиж үз



Эхлэл 6:14–22-ыг уншиж, хөвөгч авдар хэр зэрэг том байсныг хэмжиж үзээд, дараа нь хөвөгч авдрыг өөрсдийн мэдэх ямар нэг юмтай харьцуул. Хөвөгч авдрын хэмжээг тэмдэглэлийн дэвтэртээ

тайлбарла. (Санамж: Тооцоо хийхэд туслалцаа авахын тулд Судруудын Удирдамж дахь “тохой” гэдэг үгийг хар.)



Эхлэл 6 нь Үерийн өмнөх Ноагийн тухай өгүүлдэг. Эхлэл 7 нь Үерийн өмнөх сүүлчийн бэлтгэлүүдийг хийж байгаа Ноагийн тухай, түүнчлэн Үерийн үед юу болсон тухай өгүүлдэг.

Судруудыг ойлгох нь

Эхлэл 7

Цэвэр, бузар (ш. 2, 8)—Идэх буюу Бурханд тахил өргөж болдог эсвэл болдоггүй гэж үздэг мал

Үр удмыг нь амьд үлдээх (ш. 3)—Нөхөн үржих боломжийг тэдэнд олгох

Газрын гүний (ш. 11)—Далайн

Маханбод (ш. 15–16, 21)—Мал амьтад (ш. 15–16), хүмүүс (ш. 21)

Нэмэгдэх, бялхан халих (ш. 18–19, 24)—Үерлэх

Судруудыг судлах нь

А Юу болсныг мэд

- 1 Петр 3:18–20; Сургаал ба Гэрээ 138:6–11, 28–35-ыг унш. Үерт устгагдсан хүмүүсийн төлөө Есүс Христ юу хийснийг дүрсэл.
- 1 Петр болон Сургаал ба Гэрээ 138-д дүрслэгдсэн зүйлүүдийг тэрээр хийснийг мэдэхэд энэ нь Аврагчийн тухай та нарт юу заадаг вэ?

Эхлэл 8

Бороо зогсов

Судруудыг судлах нь


А Түүхийг хэрэглэ

Эхлэл 6–8-д уншсан зүйлээ ашиглан, Ноа болон түүний гэр бүл Үерээс аврагдсан арга замуудыг жагсаан бич. Дараа нь тэдний үйлдлүүдийг Хоёр дахь Ирэлтийн бэлтгэлд сүнсний хувьд тэсэн гарахын тулд өнөө үед бидний хийх ёстой зүйлүүдтэй харьцуулан бич.



Ноагийн үе

=



Өнөөдөр

Эхлэл 9

Шинэ эхлэл

Эхлэл 9 нь хөвөгч авдраас гарч, өөрийн хүүхдүүдийн төлөөх Бурханы зорилгуудыг хэрэгжүүлэхэд тусалсан Ноа болон түүний гэр бүлийн түүхийг өгүүлдэг. Тэд бол дэлхий дээрх цорын ганц гэр бүл байсан учраас тэд Адам Ева хоёртой адил нөхцөлд орсон гэр бүл байлаа. Гэвч Ноагийн гэр бүл Адам болон Үерийн хоорондох цаг зуурын хийгээд сүнснэг байдлын түүхийг мэддэг байснаараа давуу талтай байлаа. Их Эзэн яагаад дэлхийг үерт автуулсан тухай өөрсдийн мэддэг зүйлсийн улмаас, хэрэв та нар Ноагийн гэр бүлийн нэг гишүүн байсан бол амьдралдаа ямар зүйлийг илүү анхаарал болгоомжтой хийх байсан бэ? Та нар хүүхдүүддээ юуг заах вэ?

Ёс бус явдлаас цэвэршигдсэн дэлхийд шинээр амьдралаа эхлэх, Ноа болон түүний гэр бүлийн боломж нь баптисм хүртэх үедээ бидний хүлээн авдаг боломж—бид дахин

шинээр эхэлж, Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөг дагахад илүү хичээнгүй байх боломжтой болдгийн бэлэгдэл юм. Солонго нь Ноагийн гэр бүлийг хайрлах Бурханы хайр хийгээд нигүүлслийн сануулагч болсны нэгэн адил ариун ёслол нь, Цагаатгалаар дамжуулан мөнх амьдралыг олох арга замыг Их Эзэн бидэнд хэрхэн хангаж өгсний байнгын сануулагч болж чадна.

Судруудыг ойлгох нь

Эхлэл 9:1–17

Гарт орох (ш. 2)—Өгөгдөх : Хүний цусыг урсгах (ш. 6)—Өөр хүнийг алах

Эхлэл 9—Иосеф Смитийн Орчуулгын тусламж

Та нар Эхлэл 9-ийг уншихдаа, энэ бүлэгт зориулсан Иосеф Смитийн Орчуулгын ишлэл бүрийг уншсанаар нэмэлт ойлголт авах болно.

Эхлэл 9:18–29—Ноагийн тухай будлиантай түүх

Ноа согтуу байсан тухай энэ түүхийн талаар бүх нарийн тодорхой зүйл бидэнд байдаггүй. Хэдийгээр согтуу байсных нь төлөө Их Эзэн Ноаг судрын бусад хэсгүүдэд зэмлэдэг байсан ч, яг энэ хэргийнх нь төлөө түүнийг зэмлэсэн эсэхийг бид мэдэхгүй. Хуучин Гэрээний үед усан үзмийн шүүсийг (дарс гэж нэрлэдэг байсан) нөөцлөн хадгалдаг байсан нь цаг хугацаа өнгөрөхөд аяндаа исч, согтууруулах чанартай болсон байж мэднэ. Гэвч усан үзмийн исгэсэн шүүс нь “хүчтэй ундаа” хэмээн Библийн нэрлэдэг зүйлээс огт өөр юм. Хүчтэй ундааг төрөл бүрийн жимс, үр тариагаар, зориуд согтууруулах чанартайгаар хийдэг байжээ. “Дарс” уусны дараа Ноа согтуу байсан нь зориудын согтуурал биш бололтой.

Эхлэл 9:22-т “Канааны эцэг Хам эцгийнхээ нүцгэн байгааг хараад” гэсэн тухайд, түүнчлэн шүлэг 25-д Ноа яагаад Канааныг хийсэн зүйлийнх нь төлөө хараасныг ч бид бас мэддэггүй. Энд дурдсан өмсгөл нь шашин шүтлэгийн онцгой учир холбогдолтой бөгөөд Ноагийн санваарыг төлөөлж байсан учир энэ нь түүнээс авагдсан байжээ гэдэгт зарим хүмүүс итгэдэг. Хэрэв Канаан буюу Хам өмсгөлийг авсан бол, хараал нь “Санваарт хамаарахынхаа хувьд . . .” (ш. 26) Хамын үр удмынханд хамаатайг Абрахам 1:26–27-д бид уншдаг.

Бошиглогч Иосеф Смит нэмж хэлэхдээ: “Ноа дарс уусан боловч энэ нь гэм хоргүй байсныг шоолсон учир хараал Хамд хамаатай гэж би хэлнэ. Ноа зөв шударга хүн байсан боловч, тэрээр дарс ууж, согтсон байж; үүнээс болж Их Эзэн түүнийг орхисонгүй. Учир нь тэрээр түүний санваарын бүх хүчийг хэвээр үлдээжээ. Тэгээд түүнийг Канаан буруутгахад, тэрээр өөрийн атгадаг байсан санваараар түүнийг хараахад, Их Эзэн түүний үгийг хүндэтгэж, тэрээр согтуу байсан нь түүний атгаж байсан санваарт огт нөлөөлсөнгүй. Тийнхүү хараал нь өнөө үеийг хүртэл Канааны үр удам дээр үлдсэн юм” гэжээ (History of the Church, 4:445–46).

Бид санваарын адислалуудыг шударга бусаар олж авах буюу ашиглахыг эрэлхийлсэн үед бид зүхэгдэх болно, түүнчлэн бид боломжууд, адислалууд хийгээд хүчийг алдах болно. Жишээ нь: Өөрсдийнхөө зохистой байдлын талаар худал хэлэх замаар санваарыг буюу санваарын адислалуудыг олж авсан хүмүүс ёслолуудын адислалуудыг хүлээн авахгүй. Харин ч адислалуудаа алдах болно. Бид Их Эзэнийг мэхэлж чадахгүй шүү дээ.

А Таны “Солонго” юу вэ?



1. Их Эзэн хийсэн гэрээнийхээ тэмдэг буюу сануулагчийг Ноад өгсөн билээ. Уг тэмдэг нь Их Эзэн түүнд хичнээн нигүүлсэнгүй байсныг санахад нь Ноад тусалсан юм. Их Эзэн танд хичнээн нигүүлсэнгүй байдгийг өөрт чинь сануулдаг ямар нэг зүйлийн тухай бич.

2. Ноагийн хувьд солонго ямар учир холбогдолтой байсны адил ариун ёслол бидний хувьд юу байж болох вэ?



Эхлэл 11:10–32—Абрахамын удам

Эхлэл 10

Ноагийн үр удам


Эхлэл 10 нь хэд хэдэн үеийнхний турш дахь Ноагийн хөвгүүдийн үр удмыг нэрлэсэн байдаг. Үүнд: Иафет (ш. 2–6-г үз), Хам (ш. 6–20-ийг үз), Шем (ш. 21–31-ийг үз). Энэ бүлгийн дараа, Библи нь ихэвчлэн Шемийн удмын зарим хүмүүсийн түүхийг өгүүлдэг. Семит гэдэг нэр томъёо бол ихэвчлэн иудейчүүдэд хамаарах бөгөөд “Шемийн үр удам” гэсэн утгатай ажээ.

Эхлэл 11

Бабелын Цамхаг

Та өөртэйгөө нэг хэлээр ярьдаггүй хэн нэгэнтэй харилцах гэж оролдсон тохиолдол бий юу? Хэрэв нэг сургуулийн бүх оюутнууд өөр өөр хэлээр ярьдаг байгаад хоорондоо харилцаж чадахгүй бол хичнээн их ажил хийх шаардлагатай болох вэ? Эхлэл 11 нь хэрхэн, бас юуны улмаас дэлхий дээр бидэнд өөр хэлнүүд байдаг тухай өгүүлдэг.

Судруудыг ойлгох нь



Эхлэл 11:1–9-ийг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А–В) хоёрыг хий.

А Уншаад харьцуул

1. Эхлэл 11:1–4-ийг уншиж, Шинарын хүмүүс тэнгэрт хүрэх гэж оролдон юу хийснийг тайлбарла.
2. Үйлс 4:12; 2 Нифай 9:41–43; Мозая 3:17; 5:10–15-ыг уншиж, тэнгэрт очих боломжийг бидэнд олгодог “нэрийг” (Эхлэл 11:4) бид яаж авдаг тухай бич.

Б Мормоны Номтой холбо

Өөрсдөдөө нэр олж авах хийгээд тэнгэрт хүрэх цамхаг барих хүмүүсийн оролдлогод Их Эзэн хэрхэн хариулсныг мэдэхийн тулд Эхлэл 11:5–9-ийг унш. Дараа нь Ифер 1:33–43-ыг уншиж, Эхлэлд өгүүлэгдсэн цаг үед хүмүүсийн нэг бүлэгт юу тохиолдсоныг тэмдэглэлийнхээ дэвтэрт товчлон бич.

В Та нар юу гэж бодож байна?

Эхлэл 11:1–9 дэх Их Эзэний үйлдлүүд хүмүүст хэрхэн адислал болсон гэж бодож байгаагаа тайлбарла.

Эхлэлийн оршилд дурдсанчлан (“Эхлэлийн, Мосегийн болон Абрахамын номнууд” х. 9), Иосеф Смит Огайогийн Кертландад амьдарч байхдаа олж авсан үйсэн дээрх зарим бичээсийг орчуулснаар бошиглогч Абрахамын бичээсүүд хийгээд заадаг зүйлүүдийн талаар илүү ихийг хүлээн авсан ажээ. Абрахамын номыг Иосеф Смитийн Библийн Орчуулгын хэсэг гэж үздэггүй, харин Абрахам 1–2 нь Эхлэл 12-т дүрслэгдсэн үйл явдлуудын тухай ойлголтоо нэмэгдүүлэхэд бидэнд тусалдаг.

Абрахам 1

Абрахам санваар хүссэн нь

Хэрэв хүмүүс зөв шударга ёсыг хөхиүлэн дэмждэггүй гэр оронд амьдардаг, эсвэл зөв шударга байсных нь төлөө тэднийг эцэг эх нь хавчдаг байвал тэд зөв шударга байж чадах уу? Хэрэв тийм байвал, ёс бус нөлөөг даван туулахын тулд тэдгээр хүмүүс яах ёстой вэ? “Бурханы анд нөхөр” (Иаков 2:23) хэмээн нэрлэгддэг асан агуу их бошиглогч Абрахам яг ийм нөхцөлд өссөн юм. Тэрбээр залуу насанд нь түүнд нөлөөлсөн муу зүйлсийг ялан дийлсэн бөгөөд зөв шударгын загвар байсан учраас үнэн сайн мэдээг хүлээн авдаг хүн бүр түүний хүүхдүүд хэмээн нэрлэгдэж, Есүс Христ түүний үр удмаас төрөх болно гэдгийг Бурхан түүнд амласан юм. Та нар Абрахамын тухай Абрахамын болон Эхлэлийн дараагийн хэдэн бүлгийг уншихдаа, түүнд учирсан сорилтуудыг даван туулж, түүхэн дэх хамгийн агуу бошиглогч болохын тулд тэрээр юу хийснийг ол.

Судруудыг ойлгох нь

Абрахам 1

Эцгүүдийн адислалууд (ш. 2)—Санваарын ёслолууд хийгээд гэрээнүүд

Өвлөгч (ш. 2)—Өөр хүнээс адислалууд буюу өвийг залгамжлан хүлээж авах эрхтэй хүн, учир нь тэрээр өв залгамжлуулагчийн хүүхэд, ойрын садан төрөл буюу хувь хүн байдаг

Томилолт (ш. 4)—Дуудлага, томилолт

Үнэн Бурханыг мэддэггүй хүмүүс (ш. 5, 7)—Үнэн бө-

гөөд амьд Бурханыг шүтдэггүй хүмүүс

Өргөн золиослох, өргөл өргөх (ш. 7–8, 11, 15)—Тахил өргөх, өргөл өргөх

Харгис бурангуй санаагаа над дээр тавив (ш. 12)—Намайг албадан аваачив

Тэдгээрийн ерөнхий дүрслэл (ш. 14)—Тэдгээрийн харагдах байдал

Хадгалагдан үлдсэн (ш. 22, 24)—Үргэлжилсэн

Эцгийн эрхэт ёсны (ш. 25–26)—Эцэгээс хүүд ирэх

Хиймэл шүтээн (ш. 27)—Хуурамч бурхдыг шүтэн бишрэх

Он дараалал (ш. 28)—Түүх

Судруудыг судлах нь

Абрахам 1-ийг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А–В) хоёрыг хий.

А Та нар ямар адислалууд хүсдэг вэ?

1. “Цаг үе өнгөрөх тусам бидний шаргуугаар хүсдэг зүйл нь эцсийн эцэст бид ямар байх вэ гэдэг тэр зүйл, түүнчлэн үүрд мөнхөд бидний хүлээн авах тэр зүйл мөн” хэмээн Ахлагч Нийл А.Маквелл хэлжээ (in Conference Report, 1996 оны 10-р сар; Ensign, 1996 оны 11-р сар, 21). Абрахам 1:2–4-ийг уншиж, Абрахамын “эрэлхийлж байсан,” мөн “хүсэж байсан” адислалуудыг жагсаан бич. Тэрчлэн та нар тэдгээрийг судрууддаа онцлон тэмдэглэж болно.
2. Мөн өөрийнхөө хүсдэг буюу эрэлхийлдэг ямар нэг зүйлийг энэ жагсаалтаас сонгож, яагаад гэдгийг тайлбарла. Абрахам өөрийн эрэлхийлж байсан зүйлийг олж авсныг бид шүлэг 2-ын төгсгөлөөс мэддэгийг та нар ажиглах хэрэгтэй. Түүний амьдрал бол бидний хувьд түүний эрэлхийлж байсан адислалуудыг олж авах үлгэр жишээ болдог.

Б Зөв шударга хүмүүс яагаад хавчигддаг вэ?

1. Гурван онгон охин, Абрахам хавчигдаж байсан шалтгаануудыг тогтоон, эдгээр шалтгаануудыг зарим үед зөв шударга хүмүүс хавчигддаг гэж өөрсдийн боддог арга хэлбэрүүдтэй харьцуул.
2. Бүр та нар хавчигдаж байлаа ч гэсэн зөв шударгаар амьдрах нь зохистой гэж яагаад боддогоо тайлбарла.

В Шүлгүүдийг өөрийнхөө үгээр бич

Их Эзэн Абрахамд юу амласныг, түүнчлэн Абрахамын хүлээж авсан үүрэг хариуцлагуудыг олж тогтоогоод, Абрахам 1:18–19-ийг өөрийн үгээр бич.

Абрахам 2

Абрахам гэрээнүүдийг Бурханаас хүлээн авсан нь

Их Эзэнээс тодорхой адислалууд хүлээн авах Абрахамын хүслийн тухай, түүнчлэн тэрээр эдгээр адислалуудаас заримыг нь хэрхэн хүлээн авч эхэлсэн тухай та нар Абрахам 1-д уншидаг (ялангуяа шүлэг 18–19-ийг үз). Абрахам 2-т Их Эзэн Абрахамд нэмэлт адислалууд амлажээ. Та нар унших үедээ, Абрахам ийм адислалуудыг

Бурханаас хүлээн авахын тулд өөрийн итгэлтэй, зохистой байдлыг харуулахын төлөө түүний хийсэн зүйлүүдийг эрж ол.

Судруудыг ойлгох нь



Абрахам 2

Гааруулсан (ш. 1)—Улам муудсан, дордсон

Миний нэрийг гэрчлэх (ш. 6)—Миний төлөөлөгч байх (номлогч лугаа адил), миний тухай гэрчлэх

Хэмжээнээс дээгүүр (ш. 9)—Хэмжиж болохоос илүү ихээр

Чин сэтгэлээсээ (ш. 12)—Их хүч чармайлтаар

Бидний олж авсан бодгалиуд (ш. 15)—Сайн мэдээнд хөрвөсөн хүмүүс

Абрахам 2—Абрахамын түүх хаана болсон бэ?

Судруудын Удирдамж, газрын зураг 1-ийг үз.

Абрахам 2:8–11—Абрахамын Гэрээ

Та нар Абрахамын Гэрээний тухай илүү их зүйлийг Судруудын Удирдамж дахь “Абрахам, түүний гэрээнээс” уншиж болно. Та нар Абрахамын гэрээний тухай Эхлэл 17-д илүү их зүйлийг судлах болно.

Абрахам 2:22–25—Тэр бол миний дүү

Абрахам яагаад Сараиг өөрийн дүү гэж нэрлэсэнд зарим хүмүүс гайхдаг. Анхны бөгөөд хамгийн чухал шалтгаан нь Бурхан түүнд ингэж хэл хэмээн хэлсэн юм. Түүнчлэн еврей хэлэнд ач, ач хүү, үеэл, зээ охин, эсвэл зээ хүү гэсэн тусдаа үг байдаггүйг мэдэх нь зүйтэй юм. Хүү, охин, ах, эгч гэсэн ерөнхий нэр томьёонуудыг гэр бүлийн харилцаанд хэрэглэдэг байжээ. Сараи бол Абрахамын ах Хараны охин байсан учраас тэрээр бас түүний дүү байсан хэрэг.

Египетчүүд хүний эхнэртэй садар самууныг үйлдэх ёсгүй гэж боддог байсан хэдий ч, тэд хүний эхнэртэй “хууль ёсоор” гэрлэхийн тулд нөхрийг нь алах нь энүүхэнд байсан нь хачирхалтай санагдаж болох юм. Хэрэв Абрахам тэр үед үхсэн бол, түүнтэй хийсэн Их Эзэний гэрээ хэрэгжиж чадахгүйд хүрэх байсныг мэдэх нь чухал юм. Тийнхүү, энэ тохиолдолд тэрээр амь насаа аварч, гэрээг гүйцэлдүүлэхийн тулд юу гэж хэлхийг нь Их Эзэн түүнд хэлсэн ажээ.

Судруудыг судлах нь



А Нотолгоо хай

1. Абрахам 2:1–17-г уншиж, Абрахам Бурханд итгэдэг байсны нотолгоог ол. Эдгээр нотолгоонуудыг тэмдэглэлийн дэвтэртээ жагсаан бич.
2. Та Бурханыг дагаж, түүнд итгэдгийг харуулсан юуг өөр хүн таны амьдралд олж чадна гэж боддог тухайгаа бич. Абрахам Бурханд итгэдэг өөрийн итгэлийг харуулсан арга замуудтай адил төстэй, өөрийн амьдралын жишээнүүдийг тэмдэглэх буюу Абрахамын итгэлийн жишээтэй адил байлгахыг хүсдэг өөрийн амьдрал дахь зүйлүүдийг ашигла.

Б Үг бүрийг ашигла

Абрахам 2:8–11-д Их Эзэн Абрахамд амласан зүйлүүдийг товчлон дүгнэсэн нэг буюу хоёр өгүүлбэр бичихэд дараах үгсийг бүгдийг нь ашигла: адислах, үр удам, тохинуулах, санваар, Сайн мэдээ, эцэг, гэр бүлүүд, аврал.

Эхлэл 12–13

Сөргөлдөөн бүү байг

Эхлэл 12 нь Абрахам 1–2-т гардаг үйл явдлуудын заримынх нь тухай өгүүлдэг. Эхлэл 12 нь Абрахам тахилын ширээ босгож, Их Эзэнийг шүтэн биширсэн газрын байршил (Эхлэл 12:8-ыг үз), мөн түүнчлэн Абрахам Египетэд ирж, Сараг өөрийнхөө дүү хэмээн Фараонд хэлсэн үед юу болсон тухай түүхийн нарийн тодорхой зүйлүүдийг нэмж оруулсан байдаг (Эхлэл 12:14–20-ийг үз).

Эхлэлийн номонд бүлэг 17-г хүртэл Абрахамыг, “Абрам,” Сараг “Сараи” хэмээн нэрлэсэн байдгийг та нар ажиглах болно. Та нар Эхлэл 17-г унших үед, тэдний нэрс яагаад өөрчлөгдсөн тухай илүү ихийг олж мэдэх болно.

Бурханд итгэдэг байсных нь төлөө аав нь түүнийг хавчдаг байсан гэр бүлд Абрахам өссөн ажээ. Лотын эцэг (Харан) бүр Лотын өвөг эцгээс ч (Тера) өмнө нас баржээ. Абрахам Лот хоёрт аль алинд нь сорилтууд тулгарсан юм. Ураас, дараа нь Египет уруу, эцэст нь Канааны амлагдсан нутаг уруу нүүх зэрэгт тэд үргэлж хамт байжээ. Гэсэн хэдий ч, тэдний амьдрал нилээд өөрөөр эргэсэн аж. Абрахам Лот хоёр адил нөхцөлд өссөн хэрнээ амьдрал нь яагаад тийм их ялгаатай байсанд та нар гайхаж байж болох юм. Та нар Эхлэлийн дараагийн зургаасаас найман бүлгийг унших үед, Абрахам Лот хоёрын хийсэн сонголтуудыг, түүнчлэн эдгээр шийдвэрүүд цаг хугацаа өнгөрөх тусам тэдэнд хэрхэн нөлөөлснийг эрж ол.

Судруудыг ойлгох нь



Эхлэл 13

Хараагаа өргөн (ш. 10)—
Орчноо харав

Судруудыг судлах нь



А Найздаа тусал

Эцэг эхийнхээ аль нэгтэй нь буюу гэр бүлийн өөр нэг гишүүнтэй санал нэгдэхгүй байгаа асуудлаа шийдвэрлэхэд нь найздаа туслахын тулд Эхлэл 13:5–13 дахь Абрахам Лот хоёрын түүхийг та нар хэрхэн ашиглаж болох тухай бич.

А Шинэ Гэрээнээс тусламж ав

Еврей 11:8, 10, 13–16-г уншиж, энэ бүлэгт өөрийнхөө асуудлыг шийдэхэд нь Абрахамд юу нөлөөлсөн талаар ярь.

Эхлэл 14

Абрахам Мелкизедектэй уулзсан нь

Лот “майхнаа Содомын ойролцоо босгосныг” бид Эхлэл 13:12-оос уншидаг. Эхлэл 14:12-оос бид тэрээр “Содомд сууж байсныг” мэддэг. Үүний улмаас тэрээр тэр үед уг нутгийн өөр өөр хаадын хооронд болж болсон тулааны үеэр олзлогджээ. Лотыг олзлогдох хүртэл уг дайн Абрахамд хор хохирол учруулаагүй бололтой. Эхлэл 14:1–12 олон хаяд өөрсдийгөө халгаалах, бас тулалдаанд ялахын тулд цэргийн холбоод хэрхэн байгуулж байсныг тайлбарладаг. Энэ үед, хэрэв нэг хаан нөгөөдөө ямар нэг тус хүргэсэн бол нөгөөдөх нь ямар нэг зүйлээр хариу заавал барьдаг байжээ. Та нар Эхлэл 14:13–24-ийг уншихдаа, Лотод туслахын тулд Абрахам юу хийснийг, түүнчлэн дэлхийн Материаллаг байдлын хувьд хүч их хүнээс алдар хүнд, хүч, мөнгө эсвэл зусардалт хүлээн авах тухайд Абрахам ямар бодолтой байсныг ажигла. Энэ хариултаа тэрээр тэнгэрлэг хүч хийгээд эрх мэдэлтэй хүнийг хэрхэн хүлээн авч, хүндэтгэдэг байсантай харьцуул.

Судруудыг ойлгох нь



Эхлэл 14:13–24

Нэхэн хөөжээ (ш. 14–15)—
Мөрдөн хөөжээ
Эд юмс (ш. 16, 21)—
Булаагдсан зүйлүүд

Улавчны уяа (ш. 23)—
Гутлын үдээс

Судруудыг судлах нь



Эхлэл 14:13–24-ийг судлахдаа А үйл ажиллагааг хий, дараа нь Б, В үйл ажиллагааны аль нэгийг хий.

А Мелкизедек гэж хэн байсан бэ?

Судруудын Удирдамж дахь “Библийн Иосеф Смитийн Орчуулгаас авсан түүвэрүүдийн” Эхлэл 14:25–40; Алма 13:14–19; Сургаал ба Гэрээ 84:14; 107:1–4; 138:41-ийг унш. Мелкизедек гэж хэн байсныг, мөн Абрахам яагаад түүнд аравны нэг төлж, адислалуудыг хүлээн авдаг байсан гэж боддоогоо дүрслэн бич.

Б Өөрийнхөө дүгнэлтийг хий

Содомын хот эд баялаг хийгээд дэлхийн олон зугаа цэнгэлээр, мөн маш их ёс бусаараа нэрд гарсан байжээ.

Содомын хаанд хандсан Абрахамын үйлдлүүд түүний үнэ цэнэ хийгээд Бурханд шийдвэр төгс байх талаар бидэнд юу заадаг вэ? Та нар энэ асуулгад хариулахдаа, Абрахам Содомын хаанаас юу авч болох байсныг авч үз. Бас Моронай 10:30-д байдаг зарчмыг авч үз.

В Зур

Эхлэл 14:17–24 дэх Абрахамын түүхийг төлөөлсөн буюу үүнийг бэлэгдсэн ямар нэг зүйлийг зур.

Эхлэл 15

Гэрээ батлагдав

Абрахамын амьдралын эхэн үед түүний үр удмын талаар олон зүйлийг, түүний дотор тэд “газрын шороо” (Эхлэл 13:16) лугаа адил олон болно гэсэн амлалтыг Их Эзэн түүнд өгчээ. Эхлэл 15 дахь үйл явдлууд тохиох хүртэл Абрахам Сара хоёр хүүхэдгүй байжээ. Энэ бүлэгт, түүний амлалтууд гүйцэлдэх болно гэдгийг мэдэхэд нь Их Эзэн Абрахамд тусалсан байдаг.



Судруудыг ойлгох нь



Эхлэл 15

Өв залгамжлагч (ш. 2)—
Бусад зарц нарыг хариуцсан зарц

Гэрт минь өссөн хүн (ш. 3)—Миний зарц нарын нэгэнд өссөн хүн

Миний өв залгамжлагч (ш. 3)—Намайг нас барахад өмч хөрөнгийг минь хүлээн авах хүн

Гунжин үнээ (ш. 9)—Залуу үнээ

Тэднийг хоёр таллан хувааж (ш. 10)—Тэднийг дундуур нь таллан хувааж

Сэг (ш. 11)—Хүүр

Зарцлагдаж, дарлагдах (ш. 13)—Зовох

Өвөг дээдэс уруугаа очих (ш. 15)—Үхэх

Эхлэл 15:6—Иосеф Смитийн Орчуулгаас авах тусламж

Судруудын Удирдамж дахь “Библийн Иосеф Смитийн Орчуулгаас авсан түүврүүдийн” Эхлэл 15:9–12 нь Эхлэл 15-д ашигтай нэмэлтүүдийг өгдөг.

Эхлэл 15:9–17—Эдгээр шүлгүүдэд Абрахам юу хийсэн бэ?

Эхлэл 15 дахь эдгээр шүлгүүд гэрээ хийх “таллан хуваах” эртний Ойрхи Дорнодын заншлыг дүрсэлдэг. Хувь хүн гэрээ хийж, малыг (эсвэл малнуудыг) таллан хуваасны дараа, хуваасан хоёр хэсгийн хооронд алхан, “Хэрэв би гэрээгээ сахихгүй бол, би энэ мал шиг болог” гэж хэлдэг байжээ. Энэ тохиолдолд шатаасан хурга нь Их Эзэний оршихуйг төлөөлж, Их Эзэн гэрээгээ биелүүлэх болно гэсэн баттай итгэлийг Абрахамд төрүүлдэг байж.

Судруудыг судлах нь

А Бэлэгдлийг тайлбарла

Эхлэл 15:1-д Их Эзэний Абрамын төлөө байгаагаа дүрсэлсэн үгсийг онцгойлон тэмдэглэ. Түүнтэй гэрээ хийж, гэрээгээ сахсан хүмүүсийн төлөө тэдгээр зүйлүүдийг Их Эзэн хэрхэн хийдэг тухай бич.

Б Доорх өгүүлбэрүүдийг төгсгө

1. Абрахам . . . санаа тавьж байв (ш. 3, 7–8-ыг үз)
2. Их Эзэн Абрахамд баттай итгэл төрүүлжээ. . . (ш. 1, 17)

Эхлэл 16

Абрахам Хейгартай гэрлэсэн нь

Эхлэл 15-д бид Абрахамын эргэлзээ хийгээд санаа тавилтуудын тухай уншдаг. Эхлэл 16-д бид Сарагийн бодол ямар байсан байж болох тухай бага сага зүйлийг мэддэг. Их Эзэн Хейгарыг Абрахамд эхнэр болгон өгөхийг Сарад зарлиглаж, бас Хейгарыг эхнэрээ болгон авахыг Абрахамд зарлигласан ажээ (С ба Г 132:34–35-ыг үз). Энэ нь хэдийгээр хэцүү байж болох ч гэсэн, Сара үүнийг Абрахамын төлөө хийсэн нь тэрээр Их Эзэнийг дуулгавартай дагаж, түүний гэрээнүүдийг гүйцэлдүүлэх хичнээн их хүсэлтэй байсныг харуулсан юм. Та нар энэ бүлгийг уншихдаа, энэ богинохон түүхийн туршид Хейгарт ямар санагдаж байсан байж болохыг бод.

Судруудыг ойлгох нь

Эхлэл 16

Намайг төрөхийг зөвшөөрсөнгүй (ш. 2)—Намайг хүүхэдтэй болгохгүй байв

Эзэгтэй (ш. 4, 8)—Зарцтай эмэгтэй

Таны гарт (ш. 5)—Танд

Судруудыг судлах нь

А Бурханы хайрыг танин мэдэх нь

Хейгар хүнд сорилтын дунд, сорилтуудыг тэсэн гарахад бид бүгдэд тусалж чадах зүйлүүдийг мэдэж авчээ. Эхлэл 16-д Хейгарыг хайрлах Бурханы хайрыг, түүнчлэн Хейгар түүний хайрыг хэрхэн хүлээн авсныг харуулсан, өөрт чинь хамгийн их сэтгэгдэл төрүүлсэн зүйлийн тухай бич.

Эхлэл 17

Абрахамын Гэрээ

Эхлэл 17-д Бурхан Абрахамыг дахин нэгэнтээ адисалж, тэр болон түүний үр удмынхан хүлээж авах адислалуудын талаар цаашидын амлалтуудыг түүнд өгчээ. Тэрээр бидэнд өгдгийн нэгэн адил, Их Эзэн Абрахамд амлалтууд болоод адислалуудыг алхам алхмаар, тухай бүр арай ихийг өгч байжээ. Абрахамд өгсөн бүх амлалтууд, адислалууд хийгээд гэрээнүүдийг хамтад нь нийлүүлэн “Абрахамын гэрээ” гэж нэрлэдэг. Ахлагч Рассел М.Нелсон Абрахамын гэрээний амлалтуудыг нэгтгэн дүгнэж, хэлэхдээ:

“Уг гэрээ . . . үлэмж ач холбогдолтой юм. Энэ нь нилээд хэдэн амлалтыг агуулдаг байв:

“Абрахамын үр удам үй олон болно, мөнхийн өсөлт дэвшлийн, түүнчлэн санваарыг авч явах эрх олгогдсон юм.”

“Тэрээр олон үндэстний эцэг болно.”

“Абрахамын үр удамаар дамжин Христ болон хаад ирэх болно.”

“Тодорхой нутгууд өвлөгдөх болно.”

“Түүний үр садаар дэлхийн бүх үндэстнүүд адислагдах болно.”

“Тэрхүү гэрээ нь үүрдийн бөгөөд—бүр мянган үеийг дамжих болно” гэжээ (in Conference Report, 1995 оны 4-р сар, 42; Ensign, 1995 оны 5-р сар, 33).

Адислалууд Абрахам дээр хэрхэн нэмэгдсэнийг Ахлагч Брус Р.МакКонки тайлбарлахдаа:

“Абрахам эхлээд Сайн мэдээг баптисмаар (энэ бол авралын гэрээ юм) хүлээн авчээ. Дараа нь тэрээр өөр дээрээ

дээд санваар хүлээн авч, улмаар тэрээр селестиел гэрлэлтэд (энэ нь өргөмжлөлийн гэрээ юм) орж, үүгээр түүнд мөнхийн өсөлт дэвжилт байх болно гэсэн баттай итгэлийг олсон юм; эцэст нь эдгээр бүх адислалууд түүний мөнх бус бүх үр удамд санал болгогдох болно гэсэн амлалтыг тэрээр хүлээн авчээ. (Абрахам. 2:6–11; С ба Г 132:29–50.) . . .

“ . . . Хувийн өргөмжлөлд хамаарах үүний хэсгүүд болон мөнхийн өсөлт дэвжилт нь селестиел гэрлэлтийн жаягт орсон Израилын угсааны гишүүн бүрийн хувьд шинэчлэгддэг ” гэжээ (Mormon Doctrine, 13).

Гэрээгээр дамжин Сүмийн бүх гишүүд Абрахамын үр удам учраас бид Абрахамтай Их Эзэний хийсэн гэрээнүүдэд анхааралтай хандаж, тэдгээр нь бидэнд хэрхэн холбогдохыг ойлгодог байх ёстой.

Судруудыг ойлгох нь



Эхлэл 17

Чамаас үндэстнүүдийг бий болгож, чамаас хаад гарах болно (ш. 6)—Чиний үр удмынхны зарим нь улс үндэстнүүд хийгээд хаад байх болно.

Төрөх (ш. 17)—Хүүхэдтэй болох

Салан одов (ш. 22)—Орхин явав.

Эхлэл 17:9–14—Хөвч хөндөх ёслол

Абрахамтай хийсэн Бурханы гэрээний тэмдэг нь хөвч хөндөх ёслол байжээ. Хөвч хөндөх ёслол нь Бурханы өмнөх ариун байдлыг бэлэгддэг байсан бөгөөд бас Их Эзэн Абрахамд, түүний үр удмын талаар өгсөн амлалтуудын бэлэгдлийн сануулагч байв. Хөвч хөндөх ёслолын талаар та нар Судруудын Удирдамжаас илүү их зүйлийг уншиж болно. Хөвч хөндөх ёслол өнөөдөр шаардлагагүй.

Судруудыг судлах нь



А Гэрээний бүрдүүлбэрүүдийг тогтоо

Гэрээ бол тодорхой зүйлүүдийг хийхээр амладаг хоёр талын хоорондох тохиролцоо юм. Сайн мэдээний гэрээнд, Бурхан ямагт нөхцөлүүдийг, эсвээс юу хийх ёстойг, түүнчлэн гэрээний хэсэг болгон юуг хүлээн авах ёстойг тогтоодог бөгөөд эдгээр нөхцөлүүдийг дуулгавартай дагахыг хүн зөвшөөрдөг.

1. Энэ гэрээг хүлээн аваад юу хийхийг Их Эзэн Абрахамаас хүссэн бэ? (ш. 1, 10-ыг үз).
2. Их Эзэн Абрахамд юу амласан бэ? (ш. 2–8, 15–19-ийг үз). Эдгээр шүлгүүдийн бүх ишлэлүүдийг та нар Судруудын Удирдамжаас уншиж, тэдгээрийг жагсаалтын нэг хэсэг болгон оруул.
3. Эхлэл 12:1–3; 13:14–16; 15:1–7; Абрахам 1:18–19; 2:9–11-ийг унш. Та нар дээр эхэлсэн жагсаалтдаа өгөгдсөн амлалтуудыг нэм.

В Бүрдүүлбэрүүдийг зохион байгуул

Абрахамын Гэрээ	
Газар нутаг	Үр удам
Санваар ба Сайн мэдээ	Аврал

Абрахамын гэрээнд: газар нутаг, үр удам, санваар ба Сайн мэдээ, аврал гэсэн үндсэн дөрвөн төрлийн адислал байдаг. Өөрсдийн хийсэн жагсаалтыг дээрх А үйл ажиллагаанд оруулж, тэдгээрийг төрлөөр нь зохион байгуул. Адислал нь нэгээс дээш төрөлд холбогдоно гэж та бодвол үүнийг, холбогдож болох бүх төрлүүдийн дор жагсаа.

В Нэрний учир?

Абрахамын болон Сарагийн нэр гэрээний хэсэг болон өөрчлөгдсөнийг анхаар (Эхлэл 17:4–8; 15–16-г үз). ХҮГ-ний англи хэл дээрх судруудын зүүвэр тайлбарт Сара нь “гүнж” гэсэн утгатайг нотолсон байдаг.

1. Сарагийн хүлээн авсан шиг тийм нэр хүлээж авбал танд ямар санагдах вэ? Яагаад?
2. Сарагийн нэр нь ямар талаараа Бурханы амлалтуудын тухай нэмэлт гэрчлэл байсан бэ? Хэний хувьд тэр гүнж байсан бэ, түүнчлэн тэрээр хэн болж чадах тухай энэ нь бидэнд юу заадаг вэ?
3. Сүмийн гишүүд бол Абрахам Сара хоёрын хүүхдүүд учраас, Бурхан энэхүү агуу хосод өгсөн нэрнүүдээс бид өөрсдийнхөө тухай юу мэдэж болох вэ?
4. Өнөөдөр бид түүний хүмүүс болохоор Их Эзэнтэй хийсэн гэрээнүүдийн хэсэг болгон ямар замаар нэр хүлээн авдаг вэ? (2 Нифай 31:13, 17–20; Мозая 18:8–10; Моронай 4:1–3-ыг үз).
5. Бид баптисм хүртэж, ариун ёслолоос хүртэх үед бидний хүлээн авдаг шинэ нэр юу вэ? Бид тэр нэрийг өөрсөд дээрээ авахын ач холбогдлыг юу гэж та нар боддог вэ?

Эхлэл 18

“Их Эзэнд дэндүү хэцүү юм байдаг гэж үү?”



Эхлэл 17-д Сара хүү төрүүлэх болно хэмээн Их Эзэн Абрахамд амласан байдаг. Тэрхүү амлалтад Абрахам хэрхэн хариу үйлдэл үзүүлснийг бид унидаг. Сара мөн энэ амлалтын тухай мэдээд тэрээр хэрхэн хариу үйлдэл үзүүлснийг бид Эхлэл 18-аас мэддэг.

Судруудыг ойлгох нь



Эхлэл 18

Эзэн (ш. 12)—Нөхөр

Зөв ба шударга ёсыг үйлд
(ш. 19)—Зөв шударгаар
амьдарч, бусдад тусал

Хашгираан (ш. 20)—Нүгэл,
ёс бус явдлын талаар хэ-
лэгдсэн зүйл

Тэдний хийсэн бүхэн нь
надад сонсогдсон хашги-
раан шиг эсэхийг мэдэх

(ш. 21)—Тэд хийсэн бүх зүй-
лээ хүмүүсийн хэлсэн шиг
хийсэн эсэхийг мэдэх

Ийм зүйл хийх нь танаас
хол байг (ш. 25)—Энэ бол
юмсыг таны хийдэг ердийн
арга зам биш

Тоос шороо (ш. 27)—
Бурхантай харьцуулахад юу
ч биш

Эхлэл 18:1–22—Абрахам дээр хэн ирсэн бэ?

Эхлэл 18:1 нь Их Эзэн Абрахам дээр хүрч ирснийг харуулдаг. Энэ бол түүнтэй ирж уулзсан гурван хүний нэг нь Их Эзэн байсан гэсэн үг биш. Энэ гурван хүн бол санваар атгагч ариун хүмүүс, мөн Их Эзэний албан ёсны төлөөлөгчид байсныг Иосеф Смитийн Орчуулга харуулдаг.

Эхлэл 18:20—Содом ба Гоморрагийн нүглүүд

Бид Эхлэл 19-ийг унших үед эдгээр хотуудын гол нүглүүдийн нэг нь ёс суртахуунгүй явдал байсныг бид мэдэх болно. Езекиел 16:48–50 нь Содом, Гоморрагийн хүмүүс бардам зантай, өөрсдийн дундах ядуус хийгээд гачигдалтай хүмүүсийг анхаарч халамжлах хүсэлгүй, түүнчлэн залхуу байсныг мэдэхэд бидэнд тусалдаг.

Эхлэл 18:23–33—Зөв шударга хүмүүсийн улмаас ёс бусчууд хадгалагдан үлдэж болно

Ёс бусчууд хадгалагдан үлдэх энэ зарчмын тухай илүү ихийг мэдэхийн тулд Алма 10:20–23-ыг унш.

Судруудыг судлах нь



А Их Эзэний асуултанд хариул

1. Эхлэл 18:14 дэх асуулт хариулагдаагүйг ажигла. Лук 1:37 гоос хариултыг хайж олоод, дараа нь уг хариултыг тайлбарла.
2. “Их Эзэнд хэтэрхий хэцүү зүйл гэж байдаггүйг” харуулсан, танд эсвэл таны таньдаг хэн нэгэнд тохиолдсон туршлагын тухай бич (ш. 14).

Б Хамгийн сайн үгсийг сонго

Эхлэл 18:16–33-ыг уншсаны дараа, Абрахамын зан төлөв, мөн Бурханы зан төлвийн талаар та нар юу мэдсэнэ авч үз. Абрахамыг хамгийн сайн дүрсэлсэн гэж өөрийнхөө боддог хоёр үг, тэрчлэн Бурханы мөн чанарыг хамгийн сайн дүрсэлсэн гэж өөрийнхөө боддог хоёр үгийг энэ хэсгээс сонго.

Эхлэл 19

Содом ба Гоморра

Лот “Содомд сууж байсныг” Эхлэл 14:12 нотолдог.

Эхлэл 18 нь Бурханы элчүүд Содом, Гоморра хоёр уруу явах замдаа Абрахамтай хамт байсныг нотолдог, тэгээд Содом, Гоморра хоёрыг устгах Бурханы төлөвлөгөөний тухай Абрахам мэдсэн ажээ. Эхлэл 19 нь Содом Гоморра хоёрыг устгахаас өмнө эдгээр хотуудыг орхиж явахад нь Лот болон түүний гэр бүлд туслахаар элчүүд ирсэн үед юу болсон тухай түүхийг өгүүлдэг.

Хэдийгээр Лот Содом Гоморра хоёр устгагдахаас өмнө зугтааж амжсан ч гэсэн, түүний гэр бүлийн гишүүдийн зарим нь Содом Гоморрагийн ёс бус арга замуудад дассан байжээ. Тэд орхиж явах зөвлөгөөг дагаагүй учраас устгагдсан аж.

Эхлэл 20–21

Амлалт биелэгдэв

Эхлэл 20-д Эхлэл 20-д Бурхан Абрахамд өөрийнхөө амийг аврахын тулд Сараг өөрийнхөө дүү гэж хэл хэмээн дахин зөвлөсөн байдаг. Үүний үр дүнд Абрахам бол бошиглогч байсныг ойлгоход нь Абимелех болон түүний гэр бүлд Их Эзэн тусалж чадсан аж. Абимелехийн гэр бүлийн гишүүд адислагдсан байлаа. Учир нь Абрахам бол Бурханы хүн мөн бошиглогч байсанд тэрээр итгэсэн ажээ.

Зарим үед бид Их Эзэний амлалтууд гүйцэлдэхийн төлөө эрэлхийлэх үед бидний тэвчээр, итгэл соригддог билээ. Эхлэл 21 Сара хүү төрүүлэх болно хэмээн Абрахам Сара хоёрт өгсөн Бурханы амлалт хэрхэн биелэгдсэн тухай түүхийг агуулдаг. Эхлэл 21 дэх үйл явдлууд Абрахамыг зуун настай, Сараг ерэн настай байхад тохиосон аж. Тэдэнд хүү төрсөн нь гайхамшиг хийгээд Бурханы адислал байсан гэдэгт эргэлзээ байж болно гэж үү?

Судруудыг ойлгох нь



Эхлэл 21

Айлчилж (ш. 1)—Адисалж
Өв залгамжлах (ш. 10)—Гэр
бүлийн хэсэг байж, эцгээсээ
өмч хөрөнгө хүлээн авах

Харвасан сумны тусгалын
газар (ш. 16)—Хүн нум су-
маар харваж чадах зай
Харваач (ш. 20)—Нум сум-
тай анчин

Судруудыг судлах нь



А Захидал бич

Өөрийгөө нэг бол Абрахамын, нэг бол Сарагийн нөхцөл байдалд байна гэж төсөөлөн бодоод, Исаакийн төрөлтийн тухай өгүүлсэн захидлыг нэг найздаа бич. Уг түүхийн

нарийн тодорхой зүйлүүдийг, Сара хэзээ ч хүүхэдтэй болж чадахгүй гэж бодож байсан тэр үед оруулж, түүхийн хэсэг бүрд танд ямар санагдах байсныг дүрсэл.

ЭХЛЭЛ 22

Исаакийг тахилд өргөх гэсэн нь

Хэрэв Их Эзэн ямар нэг зүйлээсээ татгалзахыг танаас хүсвэл, таны хувьд салахад хамгийн хэцүү ямар зүйл байж болох вэ? Та энэ зүйлээсээ салж чадах уу? Яагаад? Бурхан хүнд өгч болох хамгийн хүнд сорилтуудын нэгийг нь түүхийг Эхлэл 22 өгүүлдэг. Бүлэг 22-ыг уншихын өмнө, Сургаал ба Гэрээ 101:4–5-д Их Эзэн сүмийн гишүүдэд юу гэж хэлснийг унши. Та Эхлэл 22-ыг унших үедээ, өөрийгөө Абрахамын юм уу, эсвэл Исаакийн оронд тавьж, тухайн нөхцөлд чамд ямар сэтгэгдэл төрж болох байсан талаар бод.

Судруудыг ойлгох нь

Эхлэл 22

Эмээдгийг (ш. 12) —
Хүндэтгэдгийг, хайрлагд-
гийг, хүндэлдгийг

Үүд хаалгыг эзлэх (ш. 17) —
Тэдний дээгүүр хүчтэй
болж

Эхлэл 22—Их Эзэн яагаад Исаакийг тахилд өргөхийг хүссэн бэ?

“Яагаад Их Эзэн ийм зүйлүүдийг Абрахамаас хүссэн бэ? Учир нь гэвэл, түүний ирээдүй ямар байхыг, тэрчлэн тэрээр тоо томшгүй олон хүний эцэг болно гэдгийг мэдэж байсан болохоор түүнийг сорихоор шийдсэн хэрэг. Бурхан үүнийг Өөрийнхөө төлөө хийгээгүй юм. Учир нь Өөрийнх нь урьдаас өгсөн мэдлэгээр Абрахам юу хийхийг Тэрбээр мэдэж байжээ; гэвч зорилго нь бол Абрахамд сургамж өгөх, түүнчлэн тэрээр өөр ямар ч аргаар олж авч чадахгүй мэдлэгийг олж авах боломжийг түүнд олгох явдал байжээ. Бурхан яагаад бид бүгдийг сорьдгийн учир энэ юм. Энэ бол Түүний өөрийнх нь мэдлэгийн төлөө биш юм. Учир нь Тэрбээр бүх зүйлийг урьдаас мэддэг билээ. Тэрбээр та нарын бүх амьдралыг, мөн та нарын хийх бүх зүйлийг мэддэг. Гэвч Тэрээр биднийг бидний сайн сайхны төлөө, бид өөрсдийгөө мэддэг байхын төлөө биднийг сорьдог. . . . Тэрээр Абрахамд алдар суу, өргөмжлөл, хүндэтгэлийг өгөх зорилгоор энэхүү хүнд сорилтыг туулахыг түүнээс шаардсан ажээ; Тэрбээр түүнийг хаан, санваартан болгож, Өөрт нь байдаг алдар суу, хүч хийгээд эзэгнэлийг Өөртэйгөө хуваалцахыг зорьсон ажээ” (Жорж К.Каннон, in Conference Report, 1899 оны 4-р сар, 66).


Ахлагч Нийл А.Максвелл эдгээр үнэнүүдийг бидний амьдралд холбогдуулан хэлэхдээ, бидний амьдрал нэгэн зэрэг “итгэлээр дүүрэн бас сэтгэлийн дарамтаас чөлөөтэй байж чаддаггүй. . . .

“Иймээс, та бид амьдралынхаа туршид бартаагүй замаар гулсах лугаа адил дэвэлзэн, өө Их Эзэн надад уй гашуу, уйтгар гуниг, өвчин зовлон, эсэргүүцэл урвалтыг биш, харин туршлага

өгсөн шүү дээ. Бас намайг орхихгүй нь мэдээж, гэхчлэн бодож, үнэхээр үүнийг хүсэн хүлээж хэрхэн чадах билээ. Их Эзэн минь ээ! Таныг ямар болгосон тэр бүх туршлагаудыг надаас холдуулаач! Тэгээд ирж Тангтай хамт оршиж, Таны баяр хөөрийг бүрнээр хуваалцахыг надад зөвшөөрөөч!” гэжээ (in Conference Report, 1991 оны 4-р сар, 117; *Ensign*, 1991 оны 5-р сар, 88).

Золиослол бол бид хамгийн агуу итгэл олж авах арга замуудын нэг хэмээн Бошиглогч Иосеф Смит хэлжээ. Жишээ нь: Хэрэв Абрахамын биеэр туулсан туршлага та нарт тохиолдсон бол Бурханд итгэх та нарын итгэл хэрхэн өсөх байсан гэж та нар боддог вэ? Хэрэв тэрээр Бурханы зарлигласан золиослолоос татгалзсан бол түүний итгэл өсөхгүй байсан билээ. “Бүх зүйлд золиослолыг шаарддаггүй шашин амьдрал, авралын төлөө шаардлагатай итгэлийг төрүүлэх хангалттай хүчтэй байдаггүй” (*Lectures on Faith* [1985], 69).


Есүсийн үеийн Иерусалим



Эхлэл 22:14—Иехова-жире хаана байсан бэ? Мөн энэ нэр ямар утгатай вэ?

Абрахам тахилын ширээ босгосон газраа “Иехова-жире” хэмээн нэрлэсэн нь Их Эзэн мөн энэ уулан дээр хожим нь үзэгдэх болно гэсэн бошиглол ажээ. Мориа Уул (Эхлэл 22:2-ыг үз) хэмээн нийтээр нэрлэдэг толгод дээр Соломоны Ариун Сүм байсан бөгөөд мөн Аврагч энд цовдлогджээ.

Судруудыг судлах нь



Эхлэл 22-ыг судлахдаа дараах таван үйл ажиллагаанаас (А–Д) хоёрыг нь хий

А Христийн хэв шинж

1. Иаков 4:3–5-ыг уншиж, Абрахам, Исаак хоёрын тухай түүхээс юу мэдсэнээ тайлбарла.

Абрахам Исаак хоёр	Бурханы Хүүгийн золиослол

2. Абрахам Исаак хоёрын түүхээс Есүс Христийн Цагаатгалын тухай ямар нэг зүйлийг бидэнд заадаг нарийн тодорхой зүйлүүдийг чадахынхаа хэрээр олныг жагсаан бич. Та нар схем дэх мэдээллийг дээр харуулсны нэгэн адилаар зохион байгуулахыг хүсэж болно.

Б Жишээнүүдийг олж, тэмдэглэ

1. Абрахамын дуулгавартай зан, итгэлтэй байдал хийгээд Бурханд бүхнээ зориулсан чанарыг харуулсан, Эхлэл 22:1–14-г өөрсдийн олж чадах бүх нотолгооны жагсаалт хий.
2. Өөртөө гүнзгий сэтгэгдэл төрүүлсэн нэг зүйлийг жагсаалтаасаа сонгон, үүнийг өөрийнхөө амьдралд хэрхэн хэрэглэж болох тухай бич.

В Золиослолын тухай тунгаан бодож, бич

1. Яагаад Абрахам хүүгээ тахилд өргөхөд бэлэн байсан гэж та нар бодож байна вэ?
2. Их Эзэн та нараас юуг золиослол болгон өргөхийг хүсдэг вэ? (3 Нифай 9:19–20-ийг үз).
3. Хүн яагаад Бурханд золиослол өргөхөд бэлэн байх ёстой вэ?

Та нар эдгээр асуултуудад хариулахдаа, Боцшиглогч Иосеф Смитийн дараах заасан зүйлийг авч үз: “Хүний хувьд өөрийн гэсэн бүхнийг, зан ааш хийгээд нэр хүндээ, нэр төр хийгээд магтаал сайншаал, хүмүүсийн дундах сайн нэрээ, орон гэрээ, газраа, ах эгч дүүсээ, эхнэр хүүхдүүдээ, тэр ч байтугай хувийнхаа амьдралыг хойш тавих нь . . . ганцхан итгэлээс илүү ихийг шаарддаг, энэ нь тэрээр Бурханы тааллыг гүйцэлдүүлж байгаа хэрэг. Харин үүнийг ухаарагч жинхэнэ мэдлэг, эдгээр зүдгүүрүүд төгсөхөд тэрээр мөнхийн амралтанд орж, Бурханы алдар сууг хүртэгч болно” (Lectures on Faith, 68; Еврей 11:17–19 дэх Паулын заасан зүйлийг бас үз).

Г Амлалтуудыг харьцуул

Эхлэл 12:2–3; 13:14–16; 15:5; 17:2, 4, 7-д Абрахамд Бурханы өгсөн амлалтуудыг унш. Эхлэл 22:15–18-д Бурхан Абрахамд амласан зүйлтэй тэдгээрийг харьцуул. Аль талаараа тэдгээр нь адилхан буюу ялгаатай байна вэ?

Д Сорилтын болон бэрхшээлийн туршлагауд бидний итгэлийг хэрхэн бэхжүүлдэг тухай тунгаан бодож, бич

Абрахам Исаак хоёрынх шиг ийм хүнд сорилтууд Христэд итгэх бидний итгэлийг хэрхэн бэхжүүлдэг вэ? Дээрх “Судруудыг ойлгох нь” хэсэг дэх ойлголтуудын зарим нь хариулахад чинь та нарт тусалж болно.

Эхлэл 23

Сара нас барав

Сара нас барсан тухай бид Эхлэл 23-т унидаг. Сара бол Бурханы Абрахамд амласан нутагт оршуулагдсан Абрахамын гэр бүлийн анхны хүн юм.

Судруудыг судлах нь

А Абрахамыг танилцуул

Та өөрийгөө хурал хөтлөгч, харин Абрахам бол гол үг хэлэгч гэж төсөөлөн бод. Түүнийг хэрхэн танилцуулах тухайгаа бич: Түүнчлэн юу түүний амьдралын хамгийн чухал, хамгийн гүнзгий сэтгэгдэл төрүүлэх зүйлүүд байж болно гэж боддогоо оруул.

Эхлэл 24

Исаакийн эхнэр

Гэрлэх хүнийг сонгоход юуг хамгийн чухал чанарууд гэж та нар боддог вэ? Амьдралын ханиа сонгоход та хэнд итгэл хүлээлгэн найдах вэ?

Ерөнхийлөгч Спенсер В. Кимбалл хэлэхдээ: “Та маргааш юу хийх гэж байгаа, таны үйл ажиллагаа, таны бодол санаа, таны мөнхийн хувь тавиланд нөлөөлөгч хамгийн агуу, цорын ганц хүчин зүйл бол . . . нэгэн насны ханиа болохыг та хэн нэгнээс хүсэх үед таны гаргадаг тэрхүү шийдвэр юм. Энэ бол таны амьдралдаа хийх хамгийн чухал шийдвэр! Энэ бол та хаана сургуульд явдаг буюу ямар хичээлүүд үзэх, эсвэл таны эзэмших мэргэжил юу болох, эсвэл та амь зуулгаа яаж залгуулах тухай асуудал биш. Эдгээр нь чухал ч гэсэн үүрд мөнхийн ханиа болохыг хэн нэгнээс хүсэх үед гаргадаг тэрхүү чухал шийдвэртэй харьцуулахад хоёрдугаар зэргийн, юу ч биш юм” гэжээ (The Teachings of Spencer W. Kimball, Эдвард Л.Кимбалл, хянан тохиолдуулсан, [1982], 301).

Амьдралынхаа ханийг сонгох нь хүн бүрийн хувьд, ялангуяа мөнхийн гэр бүлийн амлалтыг агуулдаг Абрахамын гэрээний адислалуудыг хүсдэг хүмүүсийн хувьд чухал ач холбогдолтой юм. Хэрэв нөхөр эхнэр хоёулаа ариун сүмд бүрнээрээ хүлээн авагддаг Абрахамын гэрээг хүлээн авч, үүнийг сахих юм бол, тэд мөнхийн гэр бүлийн адислалтай байж чадна. Та нар унших үедээ, Исаакийг гэрээнд гэрлэх боломжтой болгосон тэрхүү хүч чармайлтуудыг, тэрчлэн уг үйл явцад Их Эзэн хэрхэн тусалсныг ажигла. Та гэрээнд

гэрлэхийн тулд ямар хүч чармайлт гаргахыг хүсэж байгаа болон Их Эзэн танд хэрхэн тусалж болохыг авч үз.

Судруудыг ойлгох нь



Эхлэл 24

Үнэн зөвөө орхисонгүй (ш. 27)—Өгсөн (ямар нэг юм) хүн
Ажил хэрэг (ш. 33)—Үүрэг даалгавар
Заяагддаг (ш. 50)—Ирдэг
Удаа (ш. 56)—Саатуул, зогсоо
Түүнээс асууя (ш. 57)—Түүнээс асууж хариулснаар нь болъё

Бясалгал хийх (ш. 63)—Юмсын талаар залбирч бодох
Нөмрөг (ш. 65)—Гивлүүр, нүүр халхлах даавуу, энэ нийгэмд гэрлээгүй эмэгтэй нүүрээ бүтээдэг заншилтай байжээ

Судруудыг судлах нь



А Та ямар хүнтэй гэрлэхийг хүсдэг вэ?

1. Эхлэл 24-өөс Ребекагийн талаар олж мэдсэн зүйлээ, түүнчлэн юу түүнийг Исаакийн хувьд сайн эхнэр болгосон гэж бодлогоо жагсаан бич.
2. Эхнэр буюу нөхөр маань яг ийм байгаасай гэж өөрийн хамгийн ихээр хүсдэг, өөрийн жагсаал дахь нэг зүйлийн тухай бичиж, яагаад гэдгийг тайлбарла.

Эхлэл 25

Гэрээний үнэ цэнэ гэж юу вэ?

Сараг нас барсны дараа, Абрахам өөр эхнэр авч, өөр олон хүүхэдтэй болсон тухай Эхлэл 25 өгүүлдэг. Энэ бүлэг түүний үхэл хийгээд оршуулгын тухай өгүүлдэг. Ишмаелын үр удмын тухай товч жагсаалт өгөгдөж, дараа нь уг бүлэг Исаак Ребека хоёрын ихэр хөвгүүд болох Есав Иаков хоёрын төрөлтийн тухай түүх дээр анхаарал төвлөрүүлдэг. Есав Иаков хоёрын түүх нь: Абрахамын гэрээг өөрийн өв болгон төрөх тухайд би ямар бодолтой байдаг вэ? Би энэ гэрээг хэр зэрэг их үнэлдэг билээ? хэмээн бидний хүн нэг бүр өөрсдөөсөө асуух учиртай чухал асуултуудыг дэвшүүлэн тавьдаг.

Судруудыг ойлгох нь



Эхлэл 25:19–34

Надад юунд ийм зүйл тохиолдов (ш. 22)—Яагаад ийм болов, яагаад энэ нь тохиолдов

Чиний биенээс салсан (ш. 23)—Төрсөн
Арьс (ш. 25)—Хувцас

Эхлэл 25:30–34—Есав ууган хүү байх эрхээ худалдсан нь

Тэр үеийн заншил ёсоор ууган хүү, “ууган хүүгийн эрхийг” хүлээн авдаг байсан бөгөөд энэ нь, эцгээ нас барсны дараа гэр бүлээ тэргүүлэх, эцгийнхээ өмч хөрөнгө, газраас давхар хувь хүртэх эрхийг давхар эдэлдэг байжээ. Ууган хүүгийн эрхтэй хүү нь гэр бүлийн үлдсэн хэсгийг, түүний дотор эцгийнхээ бэлэвсэн эхнэрийг анхаарч, халамжлах ёстой байв. Хоёр хүүгийнхээ талаар Ребекагийн хүлээн авсан илчлэлт энэ уламжлалыг тэдний гэр бүл дагах шаардлагагүйг ойлгоход түүнийг бэлтгэсэн бололтой. Гэрээний өв залгамжлах эрхийг хүлээн авах нь төрөлтийн дарааллаар биш, харин зөв шударга байдлын улмаас ирдэг. Эхлэл 25:29–34 дэх түүх нь яагаад дүү нь ууган хүү байх эрхийг хүлээн авах учиртайг Ребекад хэлснийг ойлгоход бидэнд тусалдаг. Ахаасаа “давуу талыг олж авсных нь” төлөө Иаковыг зарим хүмүүс шүүмжилдэг; гэвч бид уг түүхийг бүхэлд нь мэддэггүй шүү дээ. Абрахамын гэрээний шугам дахь ууган хүү байх эрх болон үүний адислалуудад Есав хичнээн бага үнэ цэнэ өгснийг, түүнчлэн Иаков эдгээр адислалуудыг хүсэж байсныг уг түүх харуулдаг.

Судруудыг судлах нь



А Өнөө үед энэ нь хэрхэн тохиолддог вэ?

Ирээдүйд өөрт нь агуу үнэ цэнэтэй байж болох зүйлийг (ууган хүүгийн эрх) Есав тэр даруйд олж авч болох, өчүүхэн үнэ цэнэтэй зүйлээр худалдаж, хоол идэх дур хүслээ (өлссөнөө) хангажээ. Өнөөдөр хүмүүс мөнхийн боломжуудаа дур хүслээ хангадаг ямар нэг зүйлээр, эсвэл дэлхийн ямар нэг зүйлээр худалддаг хэлбэрүүдийн тухай бич.

Эхлэл 26–27

Иаков гэрээний адислалуудыг хүлээн авсан нь

Их Эзэн Исаакийг хэрхэн өсгөн дэвжүүлж, өөртэйгөө хийсэн Абрахамын гэрээг хэрхэн шинэчилснийг бид Эхлэл 26-д уншидаг (ш. 3–5, 23–25-ыг үз). Бүлэг 26 нь эцэг Абрахамд нь тохиолдсон зүйлүүдтэй адил төстэй туршиллагууд Исаакт тохиолдсон тухай бас өгүүлдэг (ш. 6–11, 19–22, 26–31-ийг үз). Уг бүлгийн төгсгөлийн шүлгүүд Есав хэрхэн гэрээнээс гадуур гэрлэхээр шийдсэн хийгээд энэ шийдвэр Исаак Ребека хоёрыг хэрхэн гуниглуулсан тухай өгүүлдэг.

Зарим хүмүүс тухайн адислалуудад холбогдох зарлигуудыг дуулгавартай дагахгүйгээр уг адислалуудыг хүлээн авч болно гэж боддог. Тэд буруу ташаа боддог (С ба Г 130:20–21-ийг үз). Есав ууган хүү байхаар гэрээнд төрсний үүрэг хариуцлагууд хийгээд адислалуудын тухай бодохоос илүүгээр хэрхэн хувийнхаа дур хүслийг тэр даруй хангахад санаа тавьсныг бид Эхлэл 25:29–34-т уншидаг. Эхлэл 26:34–35-д Есав гэрээнээс гадуур эхнэр сонгохдоо гэрээг хэрхэн өчүүхэн багаар үнэлдгээ дахин харуулжээ. Есавын тухай энэ хоёр зүйлийг

мэдэх нь Эхлэл 27-д болсон үйл явдлыг ойлгоход тустай юм. Исаакийн өгөхийг хүсэж байсан адислалуудад Есав тэнцэхгүй байсныг бид ухамсарлан ойлгох хэрэгтэй.

Эхлэл 27-д Иаковт амлагдсан адислалууд болзолтой байсныг зөвхөн тэрээр гэрээнд итгэлтэйгээр амьдрах юм бол тэдгээр нь Иаковт амлагдсаныг та нар бас ажиглах хэрэгтэй. Уг адислалууд аяндаа ирээгүй юм. Та нар Эхлэл 28–35-ыг үргэлжлүүлэн уншихдаа, амлагдсан адислалууд биелэгдэхийг харахын тулд Иаков юу хийснийг ол.

Судруудыг ойлгох нь



Эхлэл 27

Саадаг (ш. 3)—Сумны сав
Хангасан (ш. 37)—Адисалсан

Чи түүний буулгыг хүзүүн дээрээсээ авч хаяна (ш. 40)—Түүний зарц байхаа болино

Эхлэл 27—Хулгайлагдсан адислал уу?

Есавыг адисалсан гэж Исаак бодож байсан хэдий ч, тэрээр Иаковыг адисалснаа мэдээд түүний адислалыг буцаан авч, түүнийг зүхээгүй ажээ (Эхлэл 27:33-ыг үз). Зөв хүнийг адислахад нь Их Эзэн түүнд сүнслэгээр нөлөөлж байсныг Исаак мэдсэн бололтой. Иаков Исаак нарын түүх нь Их Эзэн өөрийн үйлчлэгчдийн сул талууд буюу нөхцөл байдлын бүрэн бус мэдлэгийг нь үл харгалзан өөрийнх нь тааллыг хэрэгжүүлэхэд тэдэнд сүнслэгээр нөлөөлдөг байсныг ойлгоход бидэнд тусалдаг.

Эхлэл 27-д Иаковт адислалууд амлагдсан хэдий ч, тэдгээр адислалууд түүний амьдралд ирэх боломж олгогч зарлигуудыг тэрээр дуулгавартай дагах хүртэл уг адислалууд биелэгдээгүй аж.

Судруудыг судлах нь



А Есавт зөвлөгөө өг

Өөрийгөө Есавын найз, мөн Эхлэл 27 дахь үйл явдлуудын дараа түүнтэй ярилцах боломж өөрт чинь гарчээ гэж төсөөлөн бод. Эхлэл 25–27-гоос олж мэдсэн зүйлээ ашиглан, Иаков яагаад гэрээний адислалуудыг хүлээн авсныг ойлгоход нь Есавт тусалж, Есав юу хийх ёстойг түүнд хэл.

Эхлэл 28

Иаковын ариун туршлага

Эхлэл 27-д Иаков үр удамтай болж, өөрийн ах Есавыг захирах болно гэсэн адислалаар Исаак Иаковыг адисалжээ. Гэвч Иаковын олж авсан хамгийн агуу адислалууд нь түүний өвөг эцэг Абрахам, түүний эцэг Исаак нарт өгөгдсөн гэрээний адислалууд байжээ. Эхлэл 28-д Их Эзэн гэрээний

тухай түүнчлэн үүний адислалуудын тухай илүү их зүйлийг Иаковт заасан байдаг.

Судруудыг ойлгох нь




Эхлэл 28

Захьж хэлсэн нь (ш. 1, 6)—
Зарлигласан нь
Хамгаалан (ш. 15)—Харж хандан, адисалж

Сүрдмээр (ш. 17)—Ариун Багана (ш. 18, 22)—Тахилын ширээ

Эхлэл 28:10–28—Иаков Бетелд

Иаковын зүүдэн дэх шат ямархуу харагдаж байсныг бид яг тодорхой мэддэггүй. Ямар ч байсан уг шат нь Бурханы хангаж өгч, түүний үйлчлэгчдийн (тэнгэр элч) хяналт дор тэнгэр өөд “өгсөн алхах” арга хэрэгслийг бэлэгддэг.



Шатны гишгүүрүүд нь өөрсдийгөө түүнд илүү ойрхон аваачихын тулд Бурхантай бидний хийсэн гэрээнүүдийг төлөөлдөг гэж Ахлагч Марион Г.Ромни заажээ. Тэрээр хэлэхдээ, “Иаковын хувьд Бетел юу байсан лугаа адил ариун сүмүүд бидний хувьд яг тийм юм” гэжээ. (“Temples —The Doors to Heaven,” *Ensign*, 1971 оны 3-р сар, 16). Ариун сүмүүд бол бид өөрсдийгөө дэлхийн зүйлүүдээс дээгүүрт өргөн, Бурхан хийгээд тэнгэрт ойртон очиж, түүний оршихуйд үүрд мөнхөд хэрхэн орохыг мэдэхийн тулд очдог “Их Эзэний уулнууд” юм. Ариун сүмд бидний хүлээн авдаг ёслолууд бидний өргөмжлөлд зайлшгүй чухал юм. Тийнхүү, ариун сүм бол Бурхан хийгээд мөнх амьдралд хүрэх “үүд хаалга” юм.

Судруудыг судлах нь



Эхлэл 28-ыг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А–Б) нэгийг хий.

А Адислалуудыг ол

Исаак Иаковт амлалт өгөв (ш. 3–4-ийг үз)	Их Эзэн Иаковт амлалт өгөв (ш. 13–15-ыг үз)	Иаков Их Эзэнд амлалт өгөв (ш. 20–22-ыг үз)

Эхлэл 28-д Исаак Иаковт тодорхой адислалууд амладаг, Их Эзэн Иаковт тодорхой адислалууд амладаг, түүнчлэн Иаков өөрөө тодорхой зүйлүүд хийх болно хэмээн Их Эзэнд амласан байдаг. Энэ бүлэг дэх амлалтуудыг олж, тэдгээрийг дээр харуулсантай адил схемд тавь.

Б Тэнгэрт хүрэх өөрийнхөө шатыг зур

1. Тэмдэглэлийн дэвтэртээ шат (дээр харуулсан загвараар) зур. Мөнх амьдралтай болохын тулд өөрийн хүлээж авах ёстой ёслолууд, Бурхантай хийх ёстой гэрээнүүдийг шатны гишгүүрүүд болгон нэрлэ.
2. Та ямар нэг зүйл орхисон эсэхийг шалгуулахын тулд зургаа эцэг эхдээ буюу Сүмийн удирдагчдад үзүүл.
3. Эдгээр гэрээнүүдийг хүлээн авахын тулд та нар яг одоо юу хийж байгаа тухайгаа, эсвэл та нар өөрсдийн аль хэдийн орсон гэрээнүүдийн ёслолуудад зохистой байхын тулд юу хийж байгаа тухайгаа бич.

Эхлэл 29

Иаковын хүүхдүүд, Хэсэг 1


Их Эзэн Иаковыг хэрхэн Израил болгож өөрчилсөн тухай та нар Эхлэл 32-т унших болно. Иаковын (Израил) арванхоёр хүү болон тэдний үр удмыг төлөөлдөг “Израилын арванхоёр овгийн” тухай бид Сүмд олонтаа ярьдаг. Эхлэл 29–30 нь Иаковын гэрлэлтүүд болон түүний арванхоёр хүүгийн арваннэгийг нь төрөлтийн тухай түүхийг өгүүлдэг.

Судруудыг ойлгох нь

Эхлэл 29

Өдөр яагаа ч үгүй байна (ш. 7)—Нар тэнгэрт дээр байна (Үд дунд байна)
Суужээ (ш. 14)—Амьдарчээ
Түүн дээр оръё (ш. 21)—Түүний нөхөр болъё (үгчилбэл,

түүний майханд орж, хамт амьдаръя)
Умайг нээв (ш. 31)—Хүүхэдтэй болгохоор түүнийг адислав
Үргүй (ш. 31)—Хүүсэр, хүүхэд төрүүлээгүй



Судруудыг судлах нь

Эхлэл 29-ийг судлахдаа А, Б үйл ажиллагааны аль нэгийг хий.

А Өөрийгөө тэдний оронд тавь

Өөрийгөө Иаков, Леа буюу Рахел гэж төсөөлөн бод. Өөр гажарт амьдардаг дотны найз буюу гэр бүлийн нэг гишүүнд бичихдээ, та өөрөө тэр хүн байсан гэж бодон Эхлэл 29 дэх түүхийг дүрсэл.

Б Сайн гэрлэлтийн үнэ цэнэ юу вэ?



1. Эрт үед, эрэгтэй хүн охинтой нь гэрлэх эрх олж авахын тулд аавд нь төлбөр төлдөг байжээ. Иаковт хангалттай зүйл байгаагүй учир Леа, Рахел хоёртой гэрлэх эрхийг олохын төлөө тэр юу хийсэн бэ?
2. Та эхнэр буюу нөхөртэй болохын тулд Иаковын хийсэн юуг, яагаад хийх буюу хийхгүйгээ тайлбарла.

3. Өнөөдөр сайн, мөнхийн гэрлэлтийн “үнэ цэнийг” та юу гэж боддог тухайгаа бич.

Эхлэл 30

Иаковын хүүхдүүд, Хэсэг 2

Судруудыг ойлгох нь

Эхлэл 30

Хөлсийг нь (ш. 18)—Шагналыг нь
Сайхан бэлэг өгчээ (ш. 20)—Адисалжээ

Умайг нь нээж өгчээ (ш. 22)—Түүнийг хүүхэдтэй болгохоор адисалжээ

Эхлэл 30:25–43—Иаков цэцэглэн хөгжсөн нь

Иаков эцгийнхээ нутагт эргэж очихыг эрэлхийлж байсан тухай бид Эхлэл 30-д уншдаг. Тэрээр өөрийнхөө хөдөлмөрөөр олж авсан зүйлүүдийг өөртөө авч болох эсэхийг Лабанаас асуужээ. Иаков өөрт нь Лабаны өгөхийг хүсэж байснаас хавигүй илүү их зүйлтэй болоход нь Их Эзэн түүнийг гайхамшигтай арга замаар цэцэглүүлэн хөгжүүлжээ.

Судруудыг судлах нь

А Иаковын хүүхдүүд

Иаковын хөвгүүдийн схемийг доорхтой адилаар хий. Уг схемийг бөглөхийн тулд та нар бас Эхлэл 29:31–35-ыг харах хэрэгтэй байж болно. Иаковын отгон хүү Бениамин Иаковын амьдралын хожуу үеийг хүртэл төрөөгүй байжээ; Бениамины төрөлтийн тухай түүх Эхлэл 35-д байдаг. Та нар өөрсдийн схемд зай үлдээж, дараа нь түүнийг бичиж болно. Судруудын дагуу төрсөн дарааллаар нь хөвгүүдийг байрлуул. Бас та нар шүлгүүдэд хамгийн түрүүнд гарч ирсэн хөвгүүн тус бүрийн нэрийг онцлон тэмдэглэх буюу доогуур нь зурахыг хүсэж болно. Хэрэв та нар судрууддаа

энэ маягаар тэмдэглэвэл, дараагийн удаа уншихдаа нэр тус бүрийг хурдан харж чадна.

Хүүхдийн нэр	Эх нь	Нэрний утга	Ийм нэр өгсний шалтгаан
Реубен	Леа	Хараач, хүү	Леа Иаковт хүү төрүүлж өгч чадсандаа, бүр өөрөө үүнд ор олсондоо баяртай байжээ.
Симеон			
Леву			

Эхлэл 31

Иаков Падан-арамыг орхисон нь

Эхлэл 31-д гэрээгээр амлагдсан, төрсөн нутагтаа эргэж очихыг Их Эзэн Иаковт зарлигласан байдаг. Иаковыг төрсөн нутаг уруугаа буцахад Лабан, түүний хөвгүүд, зару нар бухимдан уцаарлаж байжээ. Лабанд харьяалагддаг өмч хөрөнгийг Иаков авч явна гэж тэд бодон, Бурхан Иаковыг дэвжүүлсэнд атаархаж байв. Иаков охидыг нь авч явсанд Лабан бас ууртай байв. Гэтэл Иаков тэдэнтэй хамт амьдарсан хорин жилийн турш Лабан Иаков болон өөрийнхөө охидод шударга бус хандаж байсныг бид бас уншидаг. Хэрэг дээрээ, тэрээр өмч хөрөнгө өвлөх өөрийнхөө охидын зүй ёсны эрхийг нь ч үгүйсгэсэн аж. Рахел эцгийнхээ нутгийг орхихдоо, өөрийн өвийг шаардсан оролдлого болгож, өөрийн өмч хөрөнгийн хууль ёсны тодорхойлолт агуулсан бяцхан дүрсүүдийг эцгийнхээ гэрээс авч явчээ. Иаков болон түүний гэр бүлийн араас Лабан хөөн ирж, тэгээд тэд Лабан Иаковтой хэрхэн харьцаж байсныг, мөн яагаад тэрээр төрсөн нутаг уруугаа буцахаар шийдсэнийг ярилцсан ажээ. Эцэст нь, Лабан Иаков хоёр бие биендээ хор хөнөөл учруулахгүй, Иаков Лабаны охид болон зээ нарт найрсгаар хандаж байх болно гэсэн амлалт өгчээ.

Эхлэл 32

Иаков төрөлх нутаг уруугаа явсан нь

Иаков эхнэр олохоор явах үед Иаков Есав хоёрын хоорондын харилцаа ямар байсан бэ? (Эхлэл 27:41–45-ыг үз). Хэрэв чи Иаков байсан бол, төрсөн нутаг уруугаа явах нь чамд ямар санагдах байсан бэ? Энэ нөхцөлд чи юу хийх байсан бэ?

Эхлэл 32–33-т Иаков эргэж ирсэн тухай мөн Есавтай уулзахад бэлтгэхийн тулд тэрээр юу хийсэн тухай өгүүлдэг. Та нар уншихдаа, муудсан харилцааг хэрхэн залруулах тухай энэ түүхээс юу сурч болохыг авч үз.

Судруудыг ойлгох нь

Эхлэл 32

Түнх (ш. 25, 32)—Дунд чөмөгний толгой сүүжний нүхэнд суудаг хонхор



Амь нас мэнд үлдсэн (ш. 30)—Аврагдсан

Судруудыг судлах нь



А Өнөө үеийн Бошиглогчдын үгсийг хэрэглэ

Ерөнхийлөгч Спенсер В.Кимбаллын дараах мэдэгдлийг авч үзэн, энэ нь Эхлэл 32:1–23-т Иаковын хийсэн зүйлүүдийн заримтай нь хэрхэн холбогдож болох тухай бич.

“Хэрэв бид ялгаануудыг шийдвэрлэх санаачлагыг гартаа аван, амар амгалангийн төлөө зарга үүсгэдэг байвал, хэрэв бид бүх зүрх сэтгэлээрээ уучилж, мартаж чаддаг байвал, хэрэв бид бусдыг чулуугаар шидэхийн өмнө өөрсдийн бодгалийг нүгэл, буруутгал, гоморхол хийгээд гэмээс цэвэршүүлж чаддаг байвал, хэрэв бид өөрсдийнхөө нүглүүдийн төлөө уучлал гуйхын өмнө бүх бодитой хийгээд хий хардсан гомдлуудыг уучилдаг байвал, хэрэв бид өртөнгүүдээ шахаж шаардахын өмнө өөрсдийн том, жижиг өрүүдийг төлдөг байвал, хэрэв бид бусдын нүдэн дэх үртсийг томруулж харахаасаа өмнө өөрсдийнхөө нүдэн дэх дүнзийг авч хаяж чаддаг байвал, энэ дэлхий мөн ч сайхан байх сан!” (in Conference Report, 1949 оны 10-р сар, 133).

Б Энэ юу гэсэн утгатай вэ?

1. Мормоны Номноос Инос 1:1–5-ыг уншиж, Их Эзэний өмнө “өөртэйгөө тэмцэлдэх” гэсэн нь юу гэсэн утгатай гэж боддогоо бич.
2. Яагаад Иаков Их Эзэний өмнө өөртэйгөө тэмцэлдсэн гэж та нар боддог вэ? (Та нар шүлэг 9–12-оос туслалцаа олж болно.)

Эхлэл 33

Иаков Есавтай уулзсан нь

А Есавын үзэл бодол



Өөрийгөө Есав гэж бодон Эхлэл 32–33-т байдаг түүхийг бич. Хорин жилийн өмнөх Иаковын тухай бодлоо, түүнчлэн уг түүхийн үе дэх түүний тухай бодлоо оруул. Түүхийг аль болохоор үнэн зөв байлгахын тулд Эхлэл 33 дахь мэдээллийг ашигла.

ЭХЛЭЛ 34

Иаковын хөвгүүдийн хонзогногч үйлдлүүд

Шехем хэмээх газарт Иаков хэсэг хугацаанд суурьшсан тухай Эхлэл 33-ын сүүлчийн хэсэг өгүүлдэг. Эхлэл 34 нь Шехем хэмээх эр Иаковын охин Динаг өөртэйгөө хурьцал үйлдэхэд хүчлэн албадсан тухай өгүүлдэг. Энэ нь Динагийн ах нарыг уурлуулжээ. Тэдний хоёр нь, Симеон, Леви хоёр Шехем болон энэ хотын бусад эрчүүдийг үхэлд хүргэсэн төлөвлөгөөг хэрэгжүүлжээ. Тэдний хонзогногч үйлдлүүдийн талаар Иаков ихэд бухимдаж байв.

ЭХЛЭЛ 35

Иаков Бетелд эргэж ирсэн нь

Эхлэл 28-д Бетел гэдэг нэртэй газарт Иаковт нэн чухал сүнслэг туршилага тохиолдсон байдаг. Тэр үед, Их Эзэн Иаковтой хамт байна хэмээн амласан бөгөөд ингэснээр тэр төрсөн нутагтаа эргэн ирж, Их Эзэнийг дахин шүтэн бишрэх боломжтой болох байв. Арванхоёр хүүхэдтэй болсныхоо дараа бас тэгээд хорь гаруй жилийн хойно тэрээр тэрхүү ариун нутагт эргэж ирэхэд, тэнд өөр нэгэн сүнслэг туршилага тохиожээ. Та нар унишхдаа, Иаковын тухай мэдсэн бүх зүйлийнхээ тухай, түүнийг сүүлчийн удаа Бетелд ирснээс хойш тохиолдсон бүх зүйлийн тухай, түүнчлэн Иаковын туршигууд энэ үед Бетелд Бурхан түүнд амласан зүйлүүдэд хэрхэн, ямар байдлаар нөлөөлж болох тухай бод.

Эхлэл 35

Багана (ш. 14, 20)—Тахилын ширээ : Унтав (ш. 22)—Хурьцал үйлдэв

А Их Эзэний Өргөөнд очиход бэлтгэ

Еврей хэлэнд, Бет-ел гэдэг нь “Бурханы Өргөө” гэсэн утгатай ажээ. Иаковын хувьд Бетел нь өнөөдөр бидний хувьд ариун сүмүүд ямар байдагтай адил байлаа. Үүнийг мэдсэнээр, Эхлэл 35:1–5 ариун сүмд явах талаар бидэнд юу зааж болох вэ?

Б Их Эзэн Иаковт хэлсэн зүйлийг Тэрээр бусад хүмүүст хэлсэн зүйлтэй харьцуул

Эхлэл 12:1–3; 15:17–21; 17:1–8; 22:15–18-д Их Эзэн Абрахамд хэлсэн зүйлүүдийг унш. Эдгээр үгсийг Эхлэл 35:9–12-д Их Эзэн Иаковт хэлсэн зүйлтэй хэрхэн харьцуулж болох вэ?

ЭХЛЭЛ 36–37

Иосеф ба олон өнгөт дээл

Эхлэл 36-д Есавынхны үр удмынхаас олных нь нэрүүдийг жагсаасан байдаг (Есавыг бас шүлэг 1, 43-т “Едом” гэсэн байдаг). Есавын үр удам Библийн түүхийн туршид Иаковын (Израил) хөршүүд байсан бөгөөд “едомчууд” гэж нэрлэгддэг байлаа.

Ууган хүүгийн эрхтэй хүү нь эцгээ нас барсны дараа гэр бүлийнхээ тэргүүн болдог байлаа. Тэр бас гэр бүлийн бусад гишүүдэд анхаарал халамж тавих үүргийг хүлээдэг байв. Тэрээр өөрийн үүрэг хариуцлагуудыг биелүүлэхийн тулд түүнд өв хөрөнгө болгон хоёр дахин их газар, өмч хөрөнгө өгдөг байжээ. Бурхан Абрахамтай хийсэн гэрээний улмаас, ууган хүүгийн эрхтэй хүү нь бас сүнслэг үүрэг хариуцлагуудыг хүлээдэг байв. (Дэлгэрэнгүй мэдээллийг Судруудын Удирдамж, “Өв залгамжлах эрх”-ээс үз)

Ихэвчлэн ууган хүү нь ууган хүүгийн эрхийг хүлээн авдаг байлаа. Гэвч Реубен энэ хүндэтгэлд өөрийгөө зохисгүй болгосон аж (Эхлэл 35:22; Шастирын Дээд 5:1-ийг үз). Иаковын хоёр дахь эхнэр Рахелын ууган хүү Иосефт ууган хүүгийн эрхийг өгсөн байна. Иосефт Иаковын өгсөн “олон өнгөтэй дээл” (Эхлэл 37:3-ыг үз) нь ууган хүүгийн эрхийг Иосеф хүлээн авсан баримтыг төлөөлдөг гэж бодогддог (Виллям Вилсон, Old Testament Word Studies [1978], s.v. “colour,” 82).

Иосеф хэдийгээр Рахелаас төрсөн ууган хүү боловч, тэрээр арваннэг дэх хүү гэдгийг сана. Тэр хэдийгээр

зохистой байсан ч гэсэн, тэрээр ууган хүүгийн эрхийг хүлээн авсан тухайд арван ах нь ямар бодолтой байсныг бид төсөөлж чадна. Та нар Эхлэл 37-гийн хэсэг тус бүрийг уншихдаа, хэрэв чи тэр үед Иосеф байсан бол чамд ямар санагдах байсан тухай бод.




Судруудыг ойлгох нь



Эхлэл 37

Бүдүүн таараар ууц нуруугаа ороож (ш. 34)—Бүдүүн ширхэгтэй шуудай шиг

даавуугаар хувцаслаж (уй гашуугаа харуулах заншил)



Судруудыг судлах нь



Эхлэл 37-г судлахдаа доорх үйл ажиллагаануудаас (А–В) хоёрыг хий.

А Намтарт нэр сонго

Хэрэв чи Иосефын намтрыг Эхлэл 37-гийн төгсгөл хүртэл бичиж байгаа бол, үүнийг юу гэж нэрлэх вэ? Яагаад гэдгийг тайлбарла.

Б Иосефт учирсан хүнд сорилтууд

1. Эхлэл 37-д Иосефт учирсан сорилтуудыг жагсаан бич.
2. Иосеф өөртөө учирсан сорилтуудын талаар юу гэж боддог байсан гэж та нар бодож байна вэ?
3. Иосефт учирсан сорилтууд өнөө үед залуу хүмүүст тохиолддог сорилтуудтай хэр зэрэг адилхан бэ?

В Мормоны номноос ойлголт ав

1. Иаков яагаад “тайвширхаас татгалзсан” (ш. 35) гэж бодож байгаагаа тайлбарла.



2. Хөвгүүдийнхээ авчирч өгсөн Иосефын дээлийн тасархайг Иаков хадгалжээ. Хожим нь тэрээр, Иосеф амьд байгааг мэдээд Иосефын үр удмын талаар бошиглоосон ажээ. Алма 46:24–25 дахь энэ бошиглолыг уншиж, үүнийг өөрийнхөө үгээр тайлбарла. Энэ бошиглол зөвхөн Мормоны Номын хүмүүст холбогддог төдийгүй, хэрэв та нар Ефраимын буюу Манассегийн (Иосефын хөвгүүд) овгуудынх бол, бас та нар т ч хамаатай.

Эхлэл 38–39

Иосефын зөв шударга зан

Эхлэл 38 нь Иаковын (Израил) дөрөв дэх хүү Иуда болон түүний ёс бус үлгэр жишээний тухай түүхийг өгүүлдэг. Тэр гэрээнээс гадуур гэрлэж, бас үүргийнхээ дагуу гэр бүлдээ анхаарал халамж тавиагүйг бид уншидаг. Тэрээр тэр үед түүнийг таниагүй ч гэсэн, бэртэйгээ ариун явдлын хуулийг зөрчсөнийг бид бас уншидаг.

Үүний эсрэгээр, Эхлэл 39 нь Иосеф хэрхэн сайныг үйлдэхийг эрэлхийлж байсныг бидэнд өгүүлдэг. Хэдийгээр Иосеф итгэлтэй залуу эр байсан ч гэсэн, тэрээр маш хүнд сорилтуудыг биеэр амссан юм. Тэрээр гэр бүлтэйгээ дахин хэзээ ч уулзахгүй байж ч мэдэх байв. Иймэрхүү нөхцөл байдалд чамд ямар санагдах байсан бэ? Итгэл бишрэл нэг хүмүүсээсээ хол байхдаа та өөрийн шашны итгэл бишрэл, ёс заншилыг яах байсан бэ?

Нэгэн үйл явдлын үеэр Бошиглогч Иосеф Смит Ахлагч Жорж А.Смитэд хэлэхдээ: Хэзээ ч бүү санаагаар уна. . . [Хэрэв] би Нова Скотиягийн хамгийн гүехэн нүхэнд живж, Хадат Уулс дээрээс минь нурлаа гэхэд, би үл шантран, итгэлээ хөгжүүлэн, эр зоригоо өндөрт өргөж, тэгээд би орой дээр нь гарч ирнэ” гэжээ. (in John Henry Evans, Иосеф Смит: An American Prophet [1933], 9). Эхлэл 39-ийг уншихдаа та нар Иосеф хэрхэн Бошиглогч Иосефын мэдэгдлийн үлгэр жишээ байсныг эрж ол.

Судруудыг ойлгох нь



Эхлэл 39

Фараон (ш. 1)—Египетийн хаан

Гарт даатгах (ш. 3–4, 6, 8, 22)—Хяналтад өгөх

Даамал (ш. 4–5)—Хариуцагч, удирдагч, захирагч

Эзнийгээ (ш. 16)—Потифарыг

Хянадаггүй байлаа (ш. 23)—Санаа нь зовдоггүй байлаа

Эхлэл 39:7–20—Иосеф ба Потифарын эхнэр

Иосефын үйлдлүүдийг Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон дараах байдлаар тайлбарлажээ:

“Иосеф Египетэд байхдаа—Бурхан, ажил, эсвэл Потифарын эхнэрийн алийг нэгдүгээрт тавьсан бэ? Потифарын эхнэр түүнд сэтгэгнэх гэж оролдоход тэрээр, “Би яаж ийм муухай хэрэг үйлдэж, Бурхандаа нүгэл үйлдэх билээ?” (Эхлэл 39:9) гэж хариулсан байдаг.

“Иосеф Бурханыг нэгдүгээрт тавьсан учраас тэрээр шоронд орсон юм. Хэрэв бидэнд үүнтэй төстэй сонголт учрах юм бол, бид өөрсдийн үнэн итгэлийг хаана тавих бол? Бид аюулгүй байдал, амар амгалан, дур хүсэл, эд баялаг, хүмүүнийг хүндлэн дээдлэхээс дээр Бурханыг тавьж чадах болов уу?

“Иосеф сонголт хийхээр албадагдсан үед, эзнийхээ эхнэрийг баярлуулахаас илүүгээр Бурханыг баярлуулахад санаа тавьсан билээ. Бид сонголт хийх шаардлагатай болоход бид даргаа, багшийгаа, хөршийгөө, эсвэл болзсон хүнээ баярлуулахаас илүүгээр Бурханыг баярлуулахад санаа тавих ёстой биз дээ?” (in Conference Report, 1988 оны 4-р сар, 4; *Ensign*, 1988 оны 5-р сар, 4–5).

Судруудыг судлах нь



А Давтагдсан санааг ол

1. Шүлэг 2–3, 21, 23-ыг уншиж, дөрвөн шүлэгт бүгдэд нь буй нэг өгүүлбэрийг ол. (Та нар уг өгүүлбэрийг судруудаа доогуур нь зуран тэмдэглэхийг хүсэж болно.) Үүний үнэнийг мэдэх нь Иосефын хувьд яагаад чухал байсан гэж та нар боддог вэ?
2. Шүлэг 2–3 дахь өгүүлбэр нь шүлэг 21, 23-д мөн адил үнэн байхын төлөө Иосеф Эхлэл 39-д юу хийсэн бэ?

Б Төгс Эзэмших Судар—Эхлэл 39:9

1. Ёс суртахуунгүй байхад урьсан Потифарын эхнэрийн урилгыг эсэргүүцэхийн тулд Иосеф ямар шалтгаан заасан бэ?
2. Иосефын заасан шалтгаан болон үйлдлүүдээс юу нь та нарт хамгийн гүнзгий сэтгэгдэл төрүүлсэн вэ? Та нар өөрсдийнхөө амьдрал дахь уруу таталтыг эсэргүүцэхийн тулд мөн энэхүү санаануудыг хэрхэн ашиглаж болох вэ?

Эхлэл 40

Иосеф шоронд

Та нар Эхлэл 40–41-ийг уншихдаа, “Их Эзэн Иосефтой хамт байсан” (Эхлэл 39:21) илүү олон арга замыг эрж ол. Хэрэв Иосеф Потифарын эхнэрийн уруу таталтанд бууж өгсөн бол, Иосефын амжилтуудын аль нь ч байхгүй байсныг авч үз. Та нар уншихдаа, муу байх нөхцөл байдлыг Их Эзэн хэрхэн сайн нөхцөл байдал болгон хувиргадгийг ажигла.

Судруудыг ойлгох нь



Эхлэл 40

Сөнч (ш. 1–2)—Үйлчлэгч

Тэр хоёрын зүүдний совин нь өөр өөр байлаа (ш. 5)—Хоёр хүний зүүд бүр нь өөр өөр утга учиртай байлаа

Тайлагч, тайлал, тайлсан (ш. 8, 12, 16, 18, 22)—Ямар

нэг юмны утгыг тайлбарладаг хүн, эсвэл ямар нэг юмны утгыг тайлбарлах
Таны толгойг өндийлгөж (ш. 13)—Таныг шоронгоос гаргаж, ивээлдээ авах

Судруудыг судлах нь



А Зүүднүүд ба тэдгээрийн тайллууд

Доорхтой адил схем хийж, сөнч, талхчин хоёрын зүүдүүдийг болон Иосефын хийсэн тайллуудыг уг схемд бич.

	Зүүдний агуулга	Тайлал
Сөнч		
Талхчин		

Б Өөрийнхөө бодлыг хэл

Иосефын амьдралын тухай хамгийн их мэддэг зүйл дээрээ тулгуурлан, яагаад тэрээр энэ бүлэг дэх зүүдүүдийг тайлж чадсан гэж бодлогоо тайлбарла.

Эхлэл 41

Иосеф ба Фараон

Хэрэв та улсынхаа удирдагчийн өмнө очиж, түүнд зөвлөгөө өгөхөөр дуудагдвал танд ямар санагдах вэ? Та юуны тухай бодож, юу хэлэх вэ? Хэрэв та зөвхөн Ерөнхийлөгч, хаан, хатан хаан буюу эсвэл ерөнхий сайдын дараах улс орныхоо хоёр дахь удирдагч болбол яах вэ? Та нар Эхлэл 41-ийг уншихдаа, эдгээр нөхцөл байдлуудад Иосеф юу хийснийг авч үзэн, түүний үйлдлүүдийг өөрийнхөө хийх зүйлтэй харьцуул.

Судруудыг судлах нь

Эхлэл 41-ийг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А–В) хоёрыг хий.

А Дүрсэл эсвэл зур

Фараоны хоёр зүүдийг дүрслэх буюу зургийг нь зурж, Иосефын тайллаар эдгээр нь юу гэсэн утгатайг тайлбарла.

Б Дараах өгүүлбэрүүдийг өөрийнхөө үгээр төгсгө

1. Фараон зүүдээ Иосефт ярьсны дараа Иосеф . . .
2. . . . Иосеф санал болгов.
3. Фараон Иосефыг . . . болгов.
4. Иосеф . . . хоёр хүүтэй болов.

В Тэрээр юуны тухай бодож байсан гэж та нар боддог вэ?

1. Бүлэг 41-ийн төгсгөлд Иосеф амьдралынхаа талаар ямар бодол санаатай байсан гэдэгт итгэдгээ та нар дүрслэхдээ, тэрээр гэр бүлтэйгээ хамт Канаанд байсан цагаас хойш Их Эзэн түүнийг адисалсан арга замуудыг авч үз.
2. Өөртөө учирсан хүнд сорилтуудын талаар Иосеф бусад хүмүүст ямар зөвлөгөө өгч болно гэж та нар боддог вэ?
3. Хэрэв Иосеф Потифарын эхнэрт бууж өгсөн бол юмс хэрхэн өөрөөр эргэх байсан бэ?



Эхлэл 42

Иосефын ах нар Египет уруу явсан нь

Нэг хүн өөрөөс чинь урван тэрсэлж, улмаар таныг бараг бүх өмч хөрөнгөө алдахад хүргэсэн санхүүгийн том асуудалд унагажээ гэж бод. Хожим нь та сэхэж, нилээд баян чинээлэг болжээ. Та баян чинээлэг болсныхаа дараа өмнө нь өөрт чинь хохирол учруулсан нөгөөх хүн одоо маш ядуу болж, бараг л өлбөрч үхэхийн даваан дээр байгааг мэджээ. Танд ямар санагдах вэ? Та яах вэ? Яагаад?

Эхлэл 42–45 дахь Иосефын түүх нь энд дүрсэлсэн нөхцөл байдалтай маш адилхан юм. Түүний түүх нь бидэнд хохирол учруулсан хүмүүст бид хэрхэн хандах тухай бодож үзэхэд биднийг хүргэх учиртай. Бид энэ түүхийг уншихдаа, бас хор хохирол учруулсан хүмүүсийн үзэл бодлын үүднээс уг түүхийг харж болно. Өөрчлөгдөх боломж тэдэнд хэрхэн олдсон байна вэ, мөн үүнтэй төстэй нөхцөл байдлуудыг Их Эзэн бидэнд хэрхэн өгдөг вэ? Та нар бүлэг 42–45-ыг уншихдаа эдгээр санаануудыг хайж ол.

Судруудыг ойлгох нь

Эхлэл 42

Нөгөөх нэг нь алга болсон (ш. 13, 32)—Нэг нь нас барсан

Эндээс (ш. 15)—Гэр уруугаа буцаж

Зовлон (ш. 21)—Шийтгэл

Түүний цусны үнэ өртгийг төлөх болж байна (ш. 22)—Бид түүнийг ясныхаа төлөө хариуцлага хүлээх болно

Учирсан бүхнийг (ш. 29, 38)—Тохиолдсонг

Судруудыг судлах нь

А Иосефын ах нарт юу тохиолдсон бэ?

“Гэмшил, гүн харуусал тэгээд наминчлалын урьдчилсан нөхцөл ирдэг. . . .

“ . . . Зовох нь наманчлалын нэн чухал хэсэг юм.

Нүглүүдийнхээ төлөө ихэд зовох хүртлээ хүн наманчилж эхэлдэггүй ” (Спенсер В.Кимбалл , *The Teachings of Spencer W. Kimball*, 87–88).

Дээрх мэдэгдлийг авч үзэн, Иосефын ах нар түүнд хийсэн зүйлийнхээ төлөө наманчлалын үйл явцыг хэрхэн эхэлсэн тухай Эхлэл 42-д харуулсан зүйлүүдийг олж, бич. Та нар Эхлэл 43–44-ийг уншихдаа эдгээрийг эрж олохоо үргэлжлүүл.

Эхлэл 43

Иосефын ах нар Египетэд эргэж ирсэн нь

Эхлэл 42-ын төгсгөлд, Симеон тэнд саатсан хэвээр байсан хэдий ч, Бениаминьг Иаков (Израил) Египет уруу явуулахгүй байхаар шийдсэн байлаа. Та нар Эхлэл 43-ыг уншихдаа Иаковын бодлыг юу өөрчилснийг эрж ол. Иосеф дүүтэйгээ уулзахад юу болсон гэж та нар бодож байна?

Судруудыг ойлгох нь

Эхлэл 43

Гэрийн даамал (ш. 19)—
Хариуцлага хүлээсэн
үйлчлэгч

Сэтгэлээ барин (ш. 31)—
Сэтгэлийнхээ хөдөлгөөнийг
хянаж

Судруудыг судлах нь

А Бошиглолын биелэлтийг ол

Эхлэл 37:5–10-т байдаг Иосефын зүүдүүдийг дахин унш. Эхлэл 42–43-д эдгээр зүүдүүд биелэгдсэн өвөрмөц арга замуудын тухай бичихдээ, эдгээр зүүдүүдийг гүйцэлдүүлсэн гэдэгт өөрийнхөө итгэдэг шүлгүүдийг оруул.

Эхлэл 44

Иосеф ах нараа сорьсон нь

Иосеф болон түүний ах нарын түүхийн эхэнд, ах нар нь дүү нартаа тохиолдсон зүйлүүдийн тухайд түүнчлэн эцгийнхээ санаа бодлуудын талаар төдийлөн их зовдоггүй байсан бололтой. Та нар уншихдаа, эдгээр бодол санаанууд хэрхэн өөрчлөгдсөнийг ажигла.

Судруудыг судлах нь

А Энэ түүх хэрхэн бэлэгдэл байдаг вэ?

“Иосеф эцгийнхээ гэр орны цаг зуурын аврагч байхаар урьдчилан томилогдсон, харин Иосефын үр удам хожмын

өдрүүдэд Израилын бүх угсааны сүнсний болоод цаг зуурын аврагчид байхаар урьдчилан томилогдсон юм” хэмээн Ерөнхийлөгч Бригам Янг сургажээ (in *Journal of Discourses*, 7:290). Бошиглогч Иосеф Смит Иаковын хүү Иосефын шууд удам байсан юм; Сүмийн гишүүдийн ихэнх нь Иосефын хоёр хүү Ефраим, Манассе хоёрын аль нэгнийх нь удам угсаа байдаг. Эрт дээр үед гэр бүлийнхээ төлөө цаг зуураар Иосефын хийж байсан зүйлийг түүний өнөөгийн үр удам (Сүм) Израилын угсааны төлөө хэрхэн сүнслэгээр хийж байна вэ?

Б Иуда хэрхэн Христийн хэв шинж байдаг вэ?

Эхлэл 44:18–34 дэх Иудагийн үйлдлүүд нь түүний үр удам Есүс Христийн ирээдүйн үйлдлүүдтэй хэрхэн адилхан байсныг дүрсэл.



Эхлэл 45

Иосеф ах нартаа өөрийгөө илчилсэн нь

Эхлэл 45-д, Иосеф эцэстээ өөрийгөө ах нартаа илчилдэг. Та нар уншихынхаа өмнө, түүний ах нар, египетчүүд, тэрчлэн Иосефын аав Иаков (Израил) хэрхэн хариу үйлдэл үзүүлэхийг урьдчилан хэл. Хэрэг дээрээ юу болсныг уншиж, үз.

Судруудыг судлах нь

Эхлэл 45-ыг судлахдаа А буюу Б үйл ажиллагааны аль нэгийг хий.

А Тэмдэглэл бич

Иосеф өөрийгөө ах нартаа илчилсэн тэр өдрийн төгсгөлөөрх түүний тухай тэмдэглэлийг санаандаа төсөөлөн бич. Египетэд худалдагдсанаасаа хойших хорин жилийн амьдралынхаа тухай, түүний дотор өөртөө учирсан хүнд сорилтуудын тухай тэрээр юуг ойлгож ухаарсан гэж боддогоо оруул.



Судруудыг судлах нь

А Иосеф: Христийн хэв шинж

Христийг гэрчилдэг байсан эртний зарим бошиглогчдын нэг өвөрмөц арга бол тэд өөрсдийнхөө амьдардаг байдлаар, өөрсдөд нь тохиолдсон зүйлүүдээр гэрчилдэг байжээ. Бошиглогчдын амьдралыг анхааралтай ажигласнаар, тухайн үйл явдал Аврагчид тохиолдсон бол Аврагч юу хийх буюу юу хэлэхийг бид загвар, хэв шинж болгон авч үзэж болно. Египет дэх Иосефын амьдралд эдгээр хэв шинжүүдээс олон нь байлаа.

Иосефын түүхийг нэгтгэн дүгнэ (Эхлэл 37–46-г үз). Нэг бол Есүс Христэд тохиолдсонтой адилхан, эсвэл Аврагчийн тухай ямар нэг зүйлийг бидэнд заадаг, Иосефын амьдралын тухай аль болох олон тодорхой зүйлийг чадахаараа жагсаан бич. Том жагсаалт бий болгохын тулд та нар энэ үйл ажиллагааг бусадтай ярилцахыг хүсэж болно. Зарим оюутнууд Христийн хэв шинж болох арвантаваас хорин өөр зүйлийг судруудаас Иосефын талаар олсон байдаг.

Б Тэд юу хэлсэн гэж та нар бодож байна?

Эхлэл 45:25–27-д Иосефын ах нар тэднийг Египетэд байх үеэр тэдэнд юу тохиолдсон тухай түүхийг Иаковт ярьсан байдаг. Гэвч уг түүхийн зарим хэсэгт, тухайлбал Иаков түүнийг үхсэн гэж бодож байсан үед Иосефт *хэрэг дээрээ* юу тохиолдсоныг нэмэх хэрэгтэй байсан нь мэдээж юм. Өөрийгөө Иуда гэж бодоод энэ тохиолдолд чи Иаковт юу хэлэх байснаа бич. Бичих зүйлдээ дараах мэдээллийг оруул. Улиран одсон он жилүүдэд өөрийн чинь бодол санаа хэрхэн өөрчлөгдсөн (жишээ нь, Эхлэл 37:23–34-ийг Эхлэл 43:3–10; 44:14–34-тэй харьцуул), ямар үйл явдлууд бодол санааг чинь өөрчилсөн, өнгөрсөн үеийн үйл явдлуудын тухай юу гэж боддог. Мөн Египет уруу явах үед тохиолдсон зүйлийн талаар, ялангуяа Иосеф өөрийгөө илчилсэн эцсийн үеийн тухай юу гэж бодогоо оруул.

Эхлэл 46

Эцэг хүү хоёр дахин учран золгов!

Хүүгээ үхсэн гэж Иаков боддог байжээ. Иосеф амьд гэдгийг мэдсэнээс хойш хорин жилийн дараа хайртай хүүтэйгээ дахин уулзах аз завшаан түүнд тохиожээ. Тэрхүү учран золголт ямархуу байсныг бид зөвхөн төсөөлж чадна (энэ тухай Эхлэл 46:28–30-аас унш). Энэ бүлэгт бас Египет уруу явж, тэнд амьдарч байсан Иаковын (Израилын) бүх үр удмынхны нэрсийн жагсаалт бас байдаг (ш. 8–27-г үз).

Судруудыг ойлгох нь

Эхлэл 46

Шөнө нь үзэгдэж (ш. 2)— : Замчлуулахаар (ш. 28)—
Зүүдэлж : Зам заалгахаар

Эхлэл 47–48

Иаков Иосефын хөвгүүдийг үрчилж авсан нь

Өлсгөлөнгийн сүүлчийн таван жилд тохиосон зүйлүүдийг Эхлэл 47 өгүүлдэг. Өлсгөлөн нэн хүчтэй байсан учир хүмүүс хувийн өмч хөрөнгө, газраа хүнснээс худалдаж байв. Энэхүү худалдааны улмаас Фараон аажмаар улс орныхоо бараг л юм бүхнийг эзэмшигч болсон ажээ.

Эхлэл 47-гийн төгсгөл үеэр, Иаков таалал төгсөх ойртоод байлаа. Түүнд ердөө ганцхан хүсэлт байсан нь: Бурхан түүнд, түүний өвөг дээдэст, түүнчлэн түүний үр удамд амласан газар нутагт түүнийг нутаглуулах явдал байлаа.

Иаков нас барахынхаа өмнө ууган хүүгийн эрхийн үүрэг хариуцлагуудыг томилох хэрэгтэй байв. Ерөнхийдөө, ууган хүүгийн адислал, үүрэг хариуцлагуудыг ууган хүү хүлээн авдаг байв. Гэтэл Исаак, хэрэг дээрээ, Абрахамын ууган хүү биш байв. Иаков бол Исаакийн ууган хүү биш байв. Иосеф бол Иаковын бараг л отгон хүү байв. Гэвч энэ гурван эр бүгдээрээ ууган хүүгийн эрх хүлээн авсан юм. Эхлэл 48-д, ах Манассегийнхаа оронд Ефраим ууган хүүгийн эрхийг хүлээн авсан юм. Ефраим яагаад сонгогдсон талаарх шастир бидэнд байдаггүй. Бурхан өөрийн хуулиуд хийгээд зарлигуудын дагуу сонгогдийг бид мэднэ (С ба Г 130:20–21-ийг үз). Хэдийгээр Ефраим ууган хүүгийн эрхийг хүлээн авсан ч гэсэн, Иосефын бүх үр удамд амлагдсан зүйлүүдийн улмаас Манассегийн адислалууд ч бас агуу юм. (Эхлэл 49:22–26; Дэд Хууль 33:13–17-г үз). Түүнээс гадна, энэ хоёр хөвгүүнийг хоёуланг нь Иаков “үрчилсэн юм” (Эхлэл 48:5-ыг үз). Ууган хүүгийн эрхийн улмаас Иосеф, эцэг Иаковаасаа хоёр дахин их өв хүлээн авах эрхтэй байв. Ефраим Израилын гэр бүлийг тэргүүлэх буюу

удирдах үүрэг хүлээсэн аж. Ефраим, Манассе хоёр тус бүрдээ хоёр дахин их өв хүлээн авч “Израилын овгуудын” хоёр нь болсон билээ.



ЭХЛЭЛ 49

Израилын хөвгүүдийн патриархын адислалууд

Бошиглогч хийгээд патриарх Иаков (Израил) нас барахынхаа өмнө өөрийн арванхоёр хөвгүүнд өгсөн адислалуудыг Эхлэл 49 агуулдаг. Үр удамд нь Есүс Христ багтдаг Иудад өгсөн адислалуудыг, тэрчлэн үр удам нь Мормоны Номын хүмүүс, Сэргээлтээс хойших Сүмийн гишүүдийн олонх нь болох Иосефт өгсөн адислалуудыг тусгайлан ажигла.

Энэ бүлгийг илүү сайн ойлгохын тулд, энэ нь еврей эх хэл дээр яруу найргийн хэлбэрээр бичигдсэнийг мэдэх нь ашигтай юм. Судруудад, ялангуяа Хуучин Гэрээнд олон-таа хэрэглэгддэг яруу найргийн хэлбэрийг “зэрэгцүүлэл” гэдэг. Энэ хэлбэрт, зохиогч буюу өгүүлэгч нь ямар нэг зүйлийг хэлээд, дараа нь үүнийг өөр үгс хэрэглэн давтдаг. Шүлэг 11-ийн төгсгөл дэх хоёр өгүүлбэрийг ажигла:

- “Тэрээр хувцсаа дарсанд угаав.”
- “[Тэрээр] хувцсаа усан үзмийн шүүсэнд угаав.”

Судруудыг ойлгох нь

Эхлэл 49

Охь (ш. 3)—Хамгийн дээд
Цог жавхлан (ш. 3)—
Хүндэтгэл
Бургилж (ш. 4)—Болчимгүй
Гүг (ш. 9)—Зулзага
(арслангийн)
Босгохоор (ш. 9)—Сэрээхээр
Хааны таяг (ш. 10)—Захирах
эрх буюу эрх мэдэл

Дудран (ш. 11)—Илжигний
даага буюу залуу илжиг
Хүнд хүчир дарамт (ш.
15)—Албадлагын хөдөлмөр
Захиран хэлсэн (ш. 29)—
Зарлигласан
Эцсийнхээ амьсгааг аваад
(ш. 33)—Үхэж

Иуда Иосеф хоёрт өгсөн Иаковын адислалууд

Иуда

Иосеф



Судруудыг судлах нь

Эхлэл 49-ийг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А–В) хоёрыг хий.

А Адислалуудыг ол

Судруудад Израилын арванхоёр хөвгүүний нэрийн доогуур зур. Ингэснээр та нар хөвгүүн тус бүрийн адислал хаана байгааг хурдан олж чадна. Иуда Иосеф хоёрт адислагдсан тусгай зүйлүүдийн тухай бич; хоёр адислал бусдаасаа илүү дээгүүр байх вий.

Б Патриархын адислалууд

Эхлэл 49-д өгөгдсөн адислалууд нь патриархын адислалуудтай адилхан юм. Таны патриархын адислал өөрийн чинь хувьд ямар утга учиртайг тайлбарла.

ЭСВЭЛ

Бид яагаад патриархын адислал хүлээж авдаг болон энэ адислалыг хүлээж авах шаардлагууд юу болохыг тайлбарла.

В Энэ бошиглол хэрхэн биелэгдсэн бэ?

Эхлэл 49-ийн 22 ямар утгатайг тайлбарла. Өөртөө туслацга авахын тулд Мормоны Номын хүмүүс ямар овгийнх болохыг өгүүлдэг 1 Нифай 5:14–16; Иаков 2:25-ыг унш. Эхлэл 49:26 дахь “мөнхийн уулс” нь Америк юм гэж Ахлагч Лий Гранд Ричардс хэлснийг бас сана (Conference Report, 1967 оны 4-р сар, 20).

ЭХЛЭЛ 50

Иаков Иосеф хоёр нас барав

Библи бол Израилын угсааны цэдэг юм. Эхлэл гэдэг нь “эхлэлүүд” гэсэн утгатай. Эхлэл бол эхлэлүүдийн ном бөгөөд бид эндээс дэлхийн эхлэлийн тухай, мөн Израилын угсааны эхлэлийн тухай уншдаг. Эхлэл 50 бол Эхлэлийн

сүүлчийн бүлэг бөгөөд Израилын (Иаковын) нас баралтын тухай өгүүлдэг; энэ талаараа Эхлэл 50 бол “эхлэлийн төгсгөл” юм.

Эхлэл 50-ийн томоохон хэсэг нь Библид байдаггүй. Гэвч энд ороогүй хэсэг нь Бошиглогч Иосеф Смитэд илчлэгдсэн бөгөөд Судруудын Удирдамж, “Библийн Иосеф Смитийн Орчуулгаас авсан түүврүүд,” Эхлэл 50:24-38-д байдаг. Энэ шастир нь Мосе болон түүний ажлыг дурддаг учраас Египетээс Гарсаныг илүү сайн ойлгоход биднийг бэлтгэдэг.

Судруудыг ойлгох нь



Эхлэл 50

Биенд гүгэл хийлгэх (ш. 2-3, 26)—Оршуулахад бэлтгэх
Үтрэм (ш. 10)—Улаан буудайг сүрэлнээс нь салган цэвэрлэдэг газар

Эргүүлж хийх (ш. 15)—
Эргүүлж төлөх

Судруудын Удирдамж, “Библийн Иосеф Смитийн Орчуулгаас авсан түүврүүд,” Эхлэл 50:24-38

Миний (чиний) хэвлийн үр жимс (ш. 24, 26-27, 30-31)—
Миний (чиний) үр удам
Үзмэрч (ш. 26-27, 29-30, 33)—Бошиглогч
Шившиглэх, шившиглэсэн (ш. 31, 33)—Тагдан хаях буюу устгах

Зөрчилдөөнүүдийг намжааж (ш. 31)—Хэрүүл тэмцлээ зогсоох
Хамгаалан үлдээх (ш. 34)—
Устгалаас хамгаалах
Нотлов (ш. 37)—Тодорхой болгов

Судруудыг судлах нь



Эхлэл 50, түүний дотор Судруудын Удирдамж, “Библийн Иосеф Смитийн Орчуулгаас авсан түүврүүдийг” судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А-Г) хоёрыг хий.

А Тэд яагаад санаа нь зовсон бэ?

1. Эхлэл 50:14-21-д Иосефын ах нарын хийсэн зүйлийг тэд яагаад хийсэн гэж та нар боддог вэ?
2. Христийнхтэй адил ямар үлгэр жишээг Иосеф харуулсан бэ?

Б Иосефын бошиглолын бүрдүүлбэрүүдийг ол

Израилын гэр бүлд тохиолдох болно хэмээн Иосефын бошиглосон зүйлүүдийг Судруудын Удирдамж, “Библийн Иосеф Смитийн Орчуулгаас авсан түүврүүд,” Эхлэл 50:24-38-аас жагсаан бич.

В Өгүүлбэрүүдийг ол

1. Судруудын Удирдамж, “Библийн Иосеф Смитийн Орчуулгаас авсан түүврүүд,” Эхлэл 50:31 нь Библи болон Мормоны Номны тухай өгүүлдэг. Ямар нэр томъёо нь Библийнх, ямар нэр томъёо нь Мормоны Номных вэ?
2. Мормоны Ном яах болно хэмээн Иосеф хэлсэн бэ?

Г Энэ үзмэрч хэн бэ?

Эхлэл 50:30-33-д дурдагдсан үзмэрч хэн болохыг тогтоож, энэ үзмэрч юу хийх болно гэж Иосеф бошиглосныг тайлбарла.

Египетээс Гарсан нь Ном



Египетээс Гарсан нь Ном бол Мосегийн таван номны хоёр дахь нь юм. Египетээс Гарсанд бид Мосегийн төрөлтийн тухай, түүний бошиглогчийн дуудлагын тухай, түүнчлэн тэрээр Израилын хүүхдүү-

дийг Египетээс хэрхэн удирдан гаргасан тухай уншдаг. Египетээс Гарсан нь гэдэг нь “гаргах” буюу “явах” гэсэн утгатай.

Египетээс Гарсаныг яагаад унших хэрэгтэй вэ?

Өнөө үед Египетээс Гарсан нь ном Хожмын Үеийн Гэгээнтнүүдэд олон учир шалтгааны улмаас ач холбогдолтой юм. Египетээс Гарсаны эхний хагас нь бошиглогч Мосе ирраилчуудыг хэрхэн гайхамшигтайгаар боолчлолоос удирдан гаргасан тухай сүнслэгээр нөлөөлөгдсөн тухай өгүүлдэг.

Дээгүүр Өнгөрсний баяр, Улаан Тэнгисийг хуваасан тухай, түүнчлэн Арван Зарлигийг өгсөн гэхчлэн шашны түүхэн дэх онцгой үйл явдлуудын тухай бид бас мэддэг. Хүмүүст зааж, тэднийг удирдах бошиглогчдыг өгсөн төлөвшүүлж, тэдэнд өөрийн хуулийг өгснөөр, уг хуулийг сахих гэрээнд ороход тэднийг урьснаар, түүнчлэн тэд гэрээнүүдийг хүлээн авч түүнийг бүр илүү бүрэн дүүрнээр шүтэн биширч чадах ариун сүмүүдийг тэдэнд өгснөөр Их Эзэн өөрийн хүмүүсийг удирдах болно гэсэн итгэлийг бид Египетээс Гарсанд заадаг зүйлүүдээс олж чадна. Үнэнч, итгэлтэй хүмүүс түүний орши-хуйд орж чадна гэдгийг Их Эзэн амладаг.

Египетээс Гарсаныг судлахад бэлтгэх нь

Эхлэлийн төгсгөл, Египетээс Гарсаны эхлэлийн хооронд Библид бичигдээгүй нэгэн үе байдаг. Тэр үеийн туршид, Израилын хүүхдүүд тоогоор өсч, Иосефын үед хаанчилж байсан Фараон тэдэнд зааж өгсөн нутагт цэцэглэн хөгжиж байлаа. Хэдэн жилийн дараа Иосефын гэр бүлийг хүндэтгэдэггүй фараонуудын шинэ үе засгийн эрхэнд гарч, израилчуудыг боолчилж эхэлжээ.

Египетээс Гарсаны эхний хагас нь Мосегийн болон Израилын хүүхдүүдийг боолчлолоос чөлөөлөхөд түүний гүйцэтгэсэн үүргийн тухай түүхийг өгүүлдэг (бүлэг 1–18-ыг үз). Египетээс Гарсаны үлдсэн хэсэг нь шүтлэг бишрэлийн болон шашны хуулиуд Израилын хүүхдүүдийн дунд хэрхэн дахин үндэслэгдсэн тухай өгүүлдэг. Эдгээр хуулиуд болон гэрээнүүд нь Абрахамын үр удмын хувьд Бурхан тэдэнд амласан нутагт израилчуудыг ороход бэлтгэхийн тулд өгөгдсөн ажээ (бүлэг 19–40-ийг үз).

Харамсалтай нь израилчууд өөрсөдтэйгөө харилцсан Бурханы үйл хэргүүдийн тухайд олонтаа гомдоллож, энэ нь тэднийг эсэргүүцэл, дуулгаваргүй байдал уруу хөтөлж байлаа. Тэдний гомдол, эсэргүүцэл Их Эзэн тэдэнд өгөхийг хүссэн бүх адислалуудыг хүлээн авахаас тэднийг саатуулан барьж байв. Та нар уншихдаа, Их Эзэн израилчуудад—тэр ч байтугай тэд өөрийнх нь талаар гомдоллон дургүйцсэн үед ч гэсэн, хичнээн нигүүлсэнгүй байсанд та нар гайхах вий. (Египетээс Гарсан нь Номны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг *Судруудын Удирдамж* дахь “Египетээс Гарсан нь номноос” үз).

Египетээс Гарсан нь 1

Зоригт эх баригчид

Ямар нэг зүйл буруу гэдгийг та нар мэдэж байвч, эрх мэдэл бүхий чухал хүмүүс ямар ч байсан үүнийг хий гэж та нарт хэлсэн тохиолдолд та нар яах вэ? Египетээс Гарсан нь 1 нь ийм нөхцөл байдалтай учирсан хэсэг эмэгтэйчүүдийн жишээг харуулдаг.

Судруудыг ойлгох нь



Египетээс Гарсан нь 1

Тэдэнд нарийн ухаанаар хандах (ш. 10)—Өөрсдөдөө ашигтай байдлаар тэднийг залах

Ажлын дарга нар (ш. 11)—Хүнд хүчир ажил хуваарилдаг хүмүүс

Эх баригч (ш. 15–21)—Төрсөн хүүхдийг эх барьж авдаг эмэгтэйчүүд

Бурханаас эмээх (ш. 17, 21)—Бусад зүйлүүдээс илүүгээр Бурханыг дээдлэн хүндэлж, санаа тавих

Судруудыг судлах нь



Египетээс Гарсан нь 1-ийг судлахдаа А, Б, В үйл ажиллагаануудаас зөвхөн аль нэгийг нь хий.

А Өгүүлбэрүүдийг төгсгө

1. Фараон Израилын хүүхдүүдийн амьдралыг улам бүр хэцүү бэрх болгов, учир нь . . .
2. . . . Фараон эх баригчдад зарлиглажээ.
3. Эх баригчид Фараоны зарлигийг дуулгавартай дагасангүй, учир нь . . .

Б Зарчмыг ол

Сургаал ба Гэрээ 3:7–8-ыг унш. Энэ нь эх баригчдын хийсэн зүйлтэй хэрхэн холбогдох вэ? Та нар “Египетээс Гарсан нь 1:15–22-ыг” шүлэг 7–8-ын хажуу талд нь бичиж болно.

В Зарчмыг хэрэглэ

1. Найз нарынхаа боддог зүйлээс, эсвэл Бурханаас эмээхийн аль нь илүү хялбар гэж боддог тухайгаа бичиж, яагаад гэдгийг тайлбарла.
2. Өөрийн чинь насны хүмүүс Бурханаас илүүгээр хүнээс эмээдэг гэж өөрийн боддог нэг хэлбэрийг нэрлэ. Ийм асуудал бүхий хүн юу хийх ёстойгоо ойлгоход нь туслахын тулд тэмдэглэлийн дэвтэртээ түүнд захидал бич. Сургаал ба Гэрээ 3:7–8-аас мэдсэн зүйлээ, түүнчлэн Египетээс Гарсан нь 1 дэх түүхийг бичих зүйлдээ ашигла.

Египетээс Гарсан нь 2

Мосегийн эхэн үеийн амьдрал



Бурханыг төлөөлөхийн өмнө “хүн Бурханаас дуудагдах ёстойг” (Итгэлийн Тунхаг 1:5) Сүмийн гишүүд бид мэддэг. Еврейчүүдийг Египетээс чөлөөлөхөд туслах ёстой хүн байх болно гэдгээ Мосе лавтай мэдэж байсныг Үйлс 7-д үздэглэсэн байдаг. Та нар Египетээс Гарсан нь 2-ыг уншихдаа Их Эзэн өөрийнхөө хүмүүсийн төлөө агуу ажил хийхэд нь Мосег бэлтгэсэн

арга замуудыг, тэрчлэн Мосе өөрийн туршлагаадаас юу мэдэж авсан болохыг эрж ол. Мосегийн туршлагаудын талаар бодох нь ‘өөрсдийнхөө амьдралд та нар Их Эзэнд үйлчилж болох зарим арга замуудын тухай бодоход чинь та нарт тусалж болно. Эдгээр үүрэг хариуцлагуудад та өөрийгөө хэрхэн бэлтгэж байна вэ? Эдгээр үүрэг хариуцлагуудын ихэнхийг бий болгохын тулд та юу хийж чадах вэ?

Судруудыг ойлгох нь



Египетээс Гарсан нь 2

Шивэгчингүүд (ш. 5)—Үйлчлэгчид

Харж анхаарав (ш. 25)—Тэдний нөхцөл байдлыг мэдэж байв

Судруудыг судлах нь

А Шинэ Гэрээнээс туслалцаа ав

Үйлс 7:22–29; Еврей 11:24–27-г унш. Тэгээд дараах үйл ажиллагаануудыг хий

1. Мосегийн өсч хүмүүжсэн нөхцөл, ялангуяа Израилын хүүхдүүдийг чөлөөлөхөд түүнийг хэрхэн бэлтгэснийг тайлбарла.
2. Мосе египет хүнийг алаад юу хийх гэж оролдсоныг тайлбарла (Египетээс Гарсан нь 2:11–12-ыг үз).

Б Мосегийн бэлтгэл

Мидианд байхад нь Мосед юу тохиолдсоныг илүү бүрэн дүүрэн ойлгохын тулд Египетээс Гарсан нь 2:15–22-ыг унш. Египетээс Гарсан нь 3:1-д Реуелын нэрийг унш (Египетээс Гарсан нь 2:18-ыг үз). Дараа нь Реуел Мосед юу санал болгосныг мэдэхийн тулд Сургаал ба Гэрээ 84:6-г унш. Израилын хүүхдүүдтэй ажиллахад түүнийг бэлтгэхэд чухал байсан гэж өөрийн боддог, Мидианд Мосед тохиолдсон гурван туршлагыг тэмдэглэлийн дэвтэртээ жагсаа.

Египетээс Гарсан нь 3

Шатаж буй бут

Та өөрийгөө энэ ажилд тэнцэхгүй гэж бодож байсны улмаас амжилттай дуусгаж чадахгүй гэж бодсон ажил үүрэг танд өгөгдөж байсан уу? Хэрэв танд энэ туршилага тохиолдсон бол, яагаад та уг ажлыг хийх гэж хичээсэн бэ? Хэрэв танд ийм туршилага тохиолдоогүй бол, уг ажлыг хийхийн тулд юу хийхийг хичээх байсан бэ? Египетээс Гарсан нь 3–4 нь Израилын хүүхдүүдийг Египетээс чөлөөлөхийн тулд Их Эзэн Мосег хэзээ дуудсан тухай өгүүлдэг. Мосе өөрийн хүмүүсийг чөлөөлөхийн тулд өөрийгөө хангалттай сайн байгаагүй гэж тэрээр бодож байсныг бид унидаг, мөн дараа нь, түүнд итгэл төрүүлж, туслахын тулд Их Эзэн юу хийснийг бид унидаг. Та нарт мөн түүнчлэн Мосед Их Эзэний хийсэн амлалтын тухай Ифер 12:27 та нарт юу заадаг вэ?

Судруудыг ойлгох нь

Египетээс Гарсан нь 3

Би мутраа сунгах болно (ш. 20)—Би өөрийн хүчийг ашиглах болно

Египетээс Гарсан нь 3:11–16—“Би бол Би Байдаг”
“Би бол Би Байдаг” гэдэг нь “Иеховагийн” нэг хувилбар, Есүс Христийн нэрнүүдийн нэг юм. Энэ нэр нь Бурхан мөнх бөгөөд тэр үеийн бусад бурхад шиг хүнээр бүтээгдээгүй гэсэн утгатайг Мосе болон израилчууд ойлгодог байжээ. Энэ нэр

бол Их Эзэн өөрийгөө бүх хүч бүхий үнэн бөгөөд амьд Бурхан гэдгийг харуулдаг арга зам юм. Энэ нэрэнд израилчууд гүн хүндэтгэлтэй ханддаг бөгөөд үүнийг хэлэх нь доромжлол хэмээн тунхаглажээ.

Хуучин Гэрээний еврей хэл дээрх эх бичвэрт энэ нэр гарч байгаа үед Иеховаг “ЭЗЭН” гэж хамгийн олонтаа орчуулсан байдаг. Есүс өөрийгөө “Би Байдаг” хэмээн Мосед болон бусад бошиглогчдод гэрчилсэн учир Шинэ Гэрээнд хэсэг иудейчүүд түүнийг алахыг хичээж байсан билээ (Иохан 8:58-ыг үз). Шинэ Гэрээний энэ ишлэл Есүс Христ бол Иехова, Хуучин Гэрээний Бурхан гэдгийг баталдаг.

Судруудыг судлах нь

А Бурханы тухай илүү ихийг мэд

Египетээс Гарсан нь 3 нь Бурхан өөрийгөө Мосед илчилж, түүнийг бошиглогч болгохоор дуудсан тухай өгүүлдэг. Бүлэг 3-ыг судалснаар бид Мосе юу хийхээр дуудагдсаныг мэдэх төдийгүй, бас Бурханы өөрийнх нь тухай ямар нэг зүйлийг бас мэддэг болно.

1. Египетээс Гарсан нь 3-т түүний хэлсэн, хийсэн зүйлүүдээс Бурханы тухай та нар юу мэдсэнээ дүрсэл.
2. Энэ бүлгээс Бурханы тухай та нарын мэдсэн үнэнүүд нүглийн боолчлолд байгаа хүнд (Израил Египетэд боолчлолд байсан шиг) эсвэл хэцүү ажил үүрэг биелүүлэх шаардлагатай байгаа хүнд (Мосе шиг) хэрхэн тусалж болох вэ?

Египетээс Гарсан нь 4

Мосе Египетэд эргэж ирсэн нь

Египетээс Гарсан нь 3-ын оршлыг үз.

Судруудыг ойлгох нь

Египетээс Гарсан нь 4

Уяман өвчтэй (ш. 6)— : Уран үгтэй (ш. 10)—
Уяман буюу арьсны өвчтэй : Ярихдаа сайн

Судруудыг судлах нь

А Хэрэв тэд надад итгэхгүй бол яах вэ?

• Мосегийн айдас, эргэлзээ ба санаа тавилтууд	• Их Эзэн санаа тавилтыг хэрхэн шийдвэрлэсэн нь
---	---

Дээрх харуулсантай адил схем хий. Өөрийнхөө ажил үүргийн талаарх Мосегийн санаа тавилт болон түүний санаа тавилтыг шийдвэрлэхэд туслахын тулд Их Эзэн юу хийсэн тухай мэдэж авсан зүйлүүдээрээ схем хий.

Египетээс Гарсан нь 5

Хатуу сэтгэлт Фараон

Бид зөв зүйлийг хийсэн тэр даруйд шагнагддаггүй. Эсвэл бидний хүссэн байдлаар тэр даруйд амжилт олохгүй байж болно. Бид зөв гэдгийг нь мэддэг зүйлийг хийхэд шагналууд нь тэр даруйд ирдэггүй. Эсвэл юмс илүү сайн болохын оронд улам муу болох шиг санагдах нь итгэлийн чухал сорилт юм (Ифер 12:6-ыг үз).

Египетээс Гарсаны төгсгөлд бид Мосе Египетэд эргэж ирэн, тэмдгүүд хийгээд гайхамшгуудыг өөрийн хүмүүст үзүүлсэн тухай уншидаг. Тэд түүнд итгэж, түүнийг дагаж, мөн чөлөөлөгчийнх нь хувьд түүнд санаа тавих болжээ. Та нар Египетээс Гарсан нь 5-ыг уншихдаа хүмүүсийн харьцаа хандлага хэрхэн, бас яагаад өөрчлөгдсөнийг ажигла. Үүнтэй адил нөхцөл байдалд та нар юу хийх байсан тухайгаа бас бод.

Судруудыг ойлгох нь



Египетээс Гарсан нь 5

Надад баярын ёслол үйлд (ш. 1)—Намайг шүтэн бишир

Тарианы ёзоор (ш. 12)—
Улаан буудай арвай мэтийг хадсаны дараа үлддэг богинохон иш

Судруудыг судлах нь



А үйл ажиллагааг, дараа нь Б буюу В үйл ажиллагааны аль нэгийг хий.

А Бүлгийг хураангуйл

Доорх жишээгээр Египетээс Гарсан нь 5-ыг хураангуйл. Өгүүлбэр бүрийг өөрийнхөө үгээр төгсгө.

Мосе Аарон хоёр . . . гэх зэргийг Фараоноос хүсэв.

Фараон . . . гэж хариулав.

Израилчууд . . . Фараонд хэлэв.

Фараон . . . гэж хэлэв.

Израилчууд Мосе Аарон нарт . . . гэж хэлэв

Б Тэмдэглэл зохион бич

Мосе Аарон хоёрын хийсэн зүйл танд тохиолдсон бол Египетээс Гарсан нь 5-ын төгсгөлд та юу бичих байснаа тэмдэглэ.

В Чухал санааг тайлбарла

Бид зөв зүйл хийсэн үед Их Эзэн нөхцөл байдлыг бидний төлөө хөнгөвчлөхийн оронд заримдаа үүнийг яагаад бидний хувьд улам хатуу чанга болгодгийг израилчуудад хэлж өгч бич. Та хариултандаа аль ч судрыг ашиглах буюу

эсвэл өөртөө олдсон Ерөнхий эрх мэдэлтнүүдийн мэдэгдлүүдийг ашиглаж болно.

Египетээс Гарсан нь 6

Би бол Их Эзэн

Египетээс Гарсан нь 5-ын төгсгөлд Мосе болон израилын хүүхдүүдийн хэн хэнийх нь урам хугарсан байлаа; Бурханыг дуулгавартай дагасан нь зөвхөн илүү хүнд сорилтууд уруу хөтөлж байх шиг санагдаж байжээ. Египетээс Гарсан нь 6 нь тэднийг чөлөөлж, дэмжих болно гэсэн Их Эзэний амлалтуудыг агуулдаг.

Судруудыг ойлгох нь



Египетээс Гарсан нь 6

Сунгасан мутар (ш. 6)—Энэ нийлмэл үг бол хүчний бэлэгдэл юм

Гомдсон сэтгэл (ш. 9)—
Урам хугаралт

Судруудыг судлах нь



А Урам хайрласан захиасуудыг ол

Египетээс Гарсан нь 6-д Их Эзэн израилчуудад хэлсэн, урам хайрласан хоёр зүйлийг та нар юу гэж бодож байгаагаа сонго. Энэ хоёр зүйл Израилын хүүхдүүдэд урам хайрлаж байсныг, тэрчлэн өнөөдөр сорилт бэрхшээлүүдтэй тулгарч байгаа хүмүүст яагаад урам хайрлаж чадахыг тайлбарла.

Египетээс Гарсан нь 7–10

Тахал

Египетээс Гарсан нь 5-д Израилын хүүхдүүдийг зүгээр гаргаж явуулах боломжийг Фараонд Их Эзэн олгосон боловч, Фараон татгалздаг. Египетээс Гарсан нь 7 нь Мосе Аарон хоёр Фараонтой зөрчилдсөн цуврал сөргөлдөөнөөр эхэлдэг. Мосе Аарон хоёр израилчуудыг явуулахыг Фараоноос хүсэж, хэрэв тэрээр ингэхгүй бол өвчин тахал дэгдээх буюу Египетэд асуудал бэрхшээлүүд бий болгох замаар, Бурхан өөрийн хүчийг харуулах болно хэмээн мэдэгджээ. Үүний дүнд, Бурханы илгээсэн тэмдгүүдийг “Египетийн тахлууд” гэдэг. Египетээс Гарсан нь 7–10 нь есөн өөр өвчин тахлыг цэдэглэсэн байдаг. Арав дахь тахлыг Египетээс Гарсан нь 11–13-д өгүүлэх болно.

Их Эзэн Египетийг өдий олон удаа тахлаар цохьсон баримт нь тэрээр хичнээн нигүүлсэнгүй болохыг харуулдаг. Фараон болон египетчүүдийг тэр даруйд устгахын оронд тэрээр өөрийг нь болон хүчийг нь мэдэх олон боломжийг тэдэнд олгосон юм. Их Эзэний зорилго бол түүний бүх хүүхдүүд түүнд эргэж очих явдал мөн. Их Эзэн өөрийн хүчийг сүрдэн цочирдмоор есөн удаа харуулсны дараа, мөн Фараон зүрх сэтгэлээ бүрмөсөн хатууруулсны дараа л Их Эзэн сая сүйрүүлэгч арав дахь тахлыг бэлтгэсэн билээ.

Энэ түүхийг бүхэлд нь ойлгоход, “Судруудыг ойлгох нь” хэсэг дэх энэ бүлгийн зарим үгс болон нийлмэл үгс та нарт тусалж, “Судруудыг судлах нь” хэсэг нь бүх дөрвөн бүлгийг нэг болгон нэгтгэх болно.

Судруудыг ойлгох нь



Египетээс Гарсан нь 7

Цэргүүд (ш. 4)—Хэсэг буюу бүлэг хүмүүс

Өөрийн мутраа сунгаж (ш. 5)—Өөрийн хүчийг үзүүлж

Илбэчид (ш. 11)—Муу ёрын сүнсний тусламжтайгаар

илбэ, ид шид үйлдэхийг оролддог хүмүүс

Илбэ (ш. 11, 22)—Ид шид үзүүлэх зуршил

Египетээс Гарсан нь 7—Фараоны илбэчид “гайхамшгуудыг” хэрхэн үйлдэж чадсан бэ?

Тэр үед Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ерөнхийлөгч байсан Ерөнхийлөгч Жозеф Фиелдинг Смит хэлэхдээ, “Бүх эрин зуунуудын туршид, мөн бараг бүх улс орнуудад, хүмүүс ид шидийн агуу нууцлаг хүчийг, бүр өвчтөнүүдийг эдгээх болон гайхамшгуудыг үйлдэхэд ашигласаар ирсэн билээ. Мэргэ төлөгчид, илбэчид, зурхайчид хаадын орднуудад байдаг байлаа. Тэд төлөг буулгадаг, хаадын асуудлууд, зүүд мэтийг шийдвэрлэдэг тодорхой хүчнүүдтэй байлаа. . . .

“ . . . Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийг харалган болгож, тэдэнд гашуунаар нөлөөлдөг хүч Сатанд байдаг хэмээн Аврагч мэдэгдсэн юм [Матай 7:22–23; Лук 13:16-г үз]. . . . Сатанд агуу мэдлэг байдаг бөгөөд үүгээрээ эрх мэдлийг ашигладаг бөгөөд илүү агуу хүч хөндлөнгөөс оролцохгүй бол ямар нэг хэмжээгээр байгалийн үзэгдлүүдийг хянадгийг санах ёстой” хэмээжээ (Answers to Gospel Questions, 5 боть, [1957], 1:176, 178).

Египетээс гарсан нь 8

Бүх хил хязгаар (ш. 2)—Бүх

Дүүрсэн (ш. 3)—Их тоотой нутгийг

Судруудыг судлах нь



А Бурхан яагаад өвчин тахлууд илгээсэн бэ?

Египетээс Гарсан нь 7:1–7; 9:16-г уншиж, яагаад тэрээр тэмдгүүд болон гайхамшгуудыг үзүүлсэн талаар Их Эзэн юу гэж хэлснийг ярь.

Б Өвчин тахлуудыг ол

Дараахтай адил схем хийж, есөн тахал тус бүрийн талаар олсон мэдээллээр схемийг бөглө.

Ишлэл	Тахал	Тахлын өмнө Мосе Аарон хоёр юу хийсэн бэ	Тахал египетчүүдэд нөлөөлсөн нь	Тахал израилчуудад нөлөөлсөн нь	Фараон болон түүний үйлчлэгчид тахалд хариу үйлдэл үзүүлсэн нь
Египетээс Гарсан нь 7:14–25					
Египетээс Гарсан нь 8:1–15					
Египетээс Гарсан нь 8:16–19					
Египетээс Гарсан нь 8:20–32					
Египетээс Гарсан нь 9:1–7					
Египетээс Гарсан нь 9:8–12					
Египетээс Гарсан нь 9:13–35					
Египетээс Гарсан нь 10:1–20					
Египетээс Гарсан нь 10:21–29					

Египетээс Гарсан нь 11–12

Дээгүүр Өнгөрөх Баяр

Египетээс Гарсан нь 11 бол Египетээс Гарсан нь 10-ын төгсгөлд болсон Мосе Фараон хоёрын нүүр тулан учирсан уулзалтын үргэлжлэл юм. Мосе бүр Фараоны дэргэд байхдаа сүүлчийн, арав дахь тахлын тухай илчлэлт хүлээн авчээ. Арав дахь тахлаар бүх зузанууд нь үхэх болно гэдгийг тэрээр Фараонд мэдэгдсэн аж. Фараон урьдынх шигээ Мосед хариу үйлдэл үзүүлж—тэрээр зүрх сэтгэлээ хатууруулан, Мосегийн сэрэмжлүүлгийг эс хайхарчээ. Тэгэхэд нь Мосе явж, Фараоны “нүүрийг дахин харсангүй” (Египетээс Гарсан нь 10:29; мөн ш. 28-ыг үз).



Египетээс Гарсан нь 11–12-т дүрслэгдсэн сүүлчийн арав дахь тахал египетчүүдийн хувьд том эмгэнэлт явдал болжээ. Сүүлчийн тахал нь Бурхан өөрийн хүмүүсийг чөлөөлөхөд хүчээ үзүүлсэн, Израилын түүхэн дэх хамгийн чухал үйл явдлуудын нэг болсон юм. Есүс Христэд итгэдэг бүх хүмүүсийн хувьд, энэ үйл явдал—Дээгүүр Өнгөрөх Баяр хэмээн мэдэгддэг—энэ нь

Хуучин Гэрээн дэх Христийн хамгийн хүчтэй бэлэгдлүүдийн нэг бөгөөд түүний Цагаатгалын тухай бидний гэрчлэлийг бэхжүүлж чадна. Та нар уншихдаа, израилчуудыг

Египетийн боолчлолоос Бурхан хэрхэн гайхамшигтайгаар чөлөөлсөн нь Христийн Цагаатгалтай хэрхэн харьцуулагдаж болохыг эрж олон, Есүс Христ биднийг нүглийн сүнсний боолчлолоос хэрхэн чөлөөлдөг тухай бод.

Судруудыг ойлгох нь



Египетээс Гарсан нь 12

Өө сэв (ш. 5)—Согог буюу дутагдал

Хиссоп (ш. 22)—Нэг төрлийн өвс

Тотго (ш. 22-23)—Хаалганы дээд хэсэг

Тэмдэглэ (ш. 24)—Хий, мөрд, баримтал

Бүх цэргүүд (ш. 41)—Хүмүүс

Харь хүн (ш. 43)—Израил биш хүн

Египетээс Гарсан нь 11:2—Израилчууд явах үедээ юмсыг гуйж (“зээлж”) авахыг Их Эзэн яагаад хүссэн бэ?

Энд зээлж авах гэдэг үг бидний ердийн хэрэглэдэг утгаар хэрэглэгдээгүй ажээ. Зээлэх гэдэг еврей үг нь гуйх буюу хүсэх гэсэн утгатай юм байна. Өөрөөр хэлбэл, израилчууд олон жилийн туршид египетчүүдэд үйлчилснийхээ хөлсийг авахыг хүссэн ажээ. Саяхны тахлуудын улмаас, египетчүүд хангалттай өглөгч, өгөөмөр сэтгэлтэй болсон байв (Египетээс Гарсан нь 12:35–36-г үз). Та нар Египетээс Гарсаныг цааш нь уншихаар, Их Эзэн эдгээр эд баялгуудаар нь тэднээр юу хийлгэснийг олж мэдэх болно.

Египетээс Гарсан нь 12:1–20—Малаар тахил өргөх нь Христийн цовдлуулалттай ижил юм

Ерөнхийлөгч Жозеф Фиелдинг Смит хэлэхдээ: “Израилчууд Египетийг орхин гарах үед, Их Эзэн тэдэнд Дээгүүр Өнгөрөх Баярыг өгсөн юм. Тэд ямар ч согоггүй хурга авах ёстой байв. Тэд хурганы ясыг хугалахгүй байх ёстой байв. Тэд хургыг нядалж, чанаад, үүнийг гашуун ургамал, исгээгүй талхтай хамт идэх ёстой байлаа. Энэ баярыг тэд тэр цагаас хойш Христийг иртэл жил бүр тэмдэглэх ёстой байв. Энэ нь бас Есүс Христийн золиослолын адилтгал байлаа. Хэрэв та энэ талаар тунгаан бодохын тулд түр завсарлах юм бол, тэрээр бидний Гэтэлгэгч байх болно хэмээх амлалтуудын биелэлт болон бидний Их Эзэн цовдлогдсон тэр үед дээгүүр өнгөрөх баяр болж байсныг олж мэдэх болно.

“Эдгээр бүх зүйлүүд түүний ирэлт, мөн түүний тохинуулал дээр төвлөрдөг. Ер нь, бүр Адамын үеэс золиослолыг хийж эхэлсэн. Есүс Христийн золиослолын бэлэгдэл, Түүний ирэлтийг сануулагч болдог байсан тул тахилд өргөх мал нь ямар ч согоггүй байх ёстой байжээ. Золиослол гэж юу байсан тухай бид Эхлэлийн номноос багаахан зүйл мэддэг. Учир нь золиослолд хамаарах тодорхой зүйлүүд авагдсан юм” гэжээ (*Doctrines of Salvation*, эмхтгэсэн Брус Р.МкКонки, 3 боть. [1954–56], 1:22).

Судруудыг судлах нь



А Дээгүүр Өнгөрөх Баяраас Христийн тухай мэд

Дээгүүр Өнгөрөх Баяр бол Есүс Христийн Цагаатгалын хэв шинж буюу бэлэгдэл юм. Доор харуулсантай адил схем хий. Египетээс Гарсан нь 12:1–20, 43–49-ийг ашиглан, Дээгүүр Өнгөрөх Баярын бүрдүүлбэрүүд Христ, түүний

Цагаатгал, түүнчлэн нүглийн боолчлол хийгээд дэлхийн шинж байдлаас наманчлах наманчлалаар дамжсан бидний чөлөөлөлтөнд холбогдохдоо юуг төлөөлдөг гэж боддог тухайгаа бич. Дараах судрын ишлэлүүд бэлэгдлүүдийн утгыг эрж олоход та нарт тусалж болно: Иеремиа 51:6; Иохан 19:30–36; 1 Петр 1:18–20; Мозая 27:24–26; Алма 5:21, 27, 57; 34:8–10; Сургаал ба Гэрээ 19:16–19, 31.

Наанадаж дараах бүрдүүлбэрүүдийг олохыг хичээ. Шинэ хуанли, хурга(согоггүй), хатавчин дээрх цус, гашуун ургамалтай хамт иддэг исгээгүй талх. Энэ судлах удирдамжийн өмнөх “Хэв шинжүүд болон бэлэгдлүүдийн утгыг эрж ол” (х. б) жижиг хэсэг нь сүнслэг бэлэгдлүүдийн утгыг тайлах буюу олоход та нарт туслах болно. Эхний хоёр бүрдүүлбэр нь та нарт жишээ болно.

Шүлэг	Дээгүүр Өнгөрөх Баярын бүрдүүлбэрүүд	Сүнслэг утга буюу тайлал
2	Хуанли өөрчлөгджээ; Дээгүүр Өнгөрөх Баярыг жилийн эхний сард тэмдэглэдэг байв	Бид өөрсдийн наманчлал болон Есүс Христийн Цагаатгалаар дамжуулан, “шинэ эхлэлийг” бий болгож чадна.
3	Хурга	Хэрэв бид наманчлах юм бол, Бурханы Хурга буюу Есүс Христийн цус биднийг цэвэр шүүлдэг.

Б Өнөө үеийн тухайд

Есүс Христ Өөрийн Амилалтын дараа Мосегийн хуулийн дагуух золиослолууд ба өргөлүүдийн тухай зааврууд өгчээ.

- Матай 26:17–30-ийг уншиж, эрт дээр үед Дээгүүр Өнгөрөх Баярын гүйцэтгэдэг байсан сүнслэг зүйлүүдийг санахад бидэнд тусалдаг ямар ёслолд өнөөдөр оролцохыг Их Эзэн биднээс хүсдэг тухай ярь.

- 1 Коринт 5:7–8-ыг уншиж, яагаад бид Дээгүүр Өнгөрөх Баярыг тэмдэглэхээ больсон тухай ярь.



Египетээс Гарсан нь 13

Ууганууд

Та өөрийгөө өөр нутагт үхэхээр яллагджээ гэж бод. Таныг цаазаар аваачихын оронд хэн нэг нь их үнээр зохицуулалт хийж, таны эрх чөлөөг худалдан авчээ. Тэр хүний талаар танд ямар бодол төрөх вэ? Таны амьдралын үлдсэн хугацаанд тэр хүнтэй харилцах таны харилцаа ямар байх вэ? Энэхүү үйл явдал Израил дахь ууган төрсөн эрчүүдийн нөхцөл байдалтай адилхан юм. Хэрэв тэд хаалганыхаа тотгон дээр хурганы цус түрхээгүй бол арав дахь тахлын нэг хэсэг болох байсан юм. Тэр цус чухамдаа тэднийг үхлээс гэтэлгэж бидэнд, аварсан юм. Тэд өөрсдийгөө аврах чадваргүй байсан учраас, үнэндээ тэр цагаас хойш, “зээлдэж авсан хугацаагаар” амьдарч ирсэн эдгээр уугануудад Их Эзэний хэлсэн зүйлийг Египетээс Гарсан нь 13 цэдэглэдэг.

Судруудыг ойлгох нь



Египетээс Гарсан нь 13

Ариусга (ш. 2)—Их Эзэнд онцгойлон адисалж, ариун болго

Хэвлий бүрийн анхны төрөгсөд (ш. 2)—Ууганууд

Товлосон цагт нь (ш. 10)—Их Эзэний хэлсэн цагт

Хэвлий бүрийн ууган үр (ш. 12, 15)—Ууганууд

Золих (ш. 13, 15)—Орноос нь төлөөс төлөх. Өөрөөр хэлбэл, Их Эзэнд харьяалагддаг

нь хүлээн зөвшөөрөгдсөн өөр ямар нэг зүйлийн оронд хургыг золих буюу золигт гаргах гэсэн утгатай

Хоёр нүдний хоорондох сахиус (ш. 16)—Духан дээрээ зүүдэг чимэглэл буюу тууз

Наманчлах (ш. 17)—Бодол санаагаа өөрчлөх

Хатуу тангараглуулаад (ш. 19)—Гэрээ буюу амлалт хийж

Судруудыг судлах нь



А Ууганууд

1. Та өөрийгөө Мосегийн үе дэх Израилын нэг аав гэж төсөөлөн бод. Та ууган хүүдээ тэрээр хэн болох хийгээд яагаад түүний төлөө онцгой зүйлүүд хийгддэг. Мөн түүнээс юуг хүсэн хүлээгддэг тухай түүнд юу ярихаа бич. Та ярих зүйлээ бодоходоо Египетээс Гарсан нь 13:1-3, 8-16-г тусгайлан анхаар.
2. 1 Коринт 6:20; 1 Петр 1:18-19; 2 Нифай 2:8; 9:7-9; Сургаал ба Гэрээ 18:10-12-ыг уншиж, та нар Израилын ууган төрснүүдтэй хэрхэн адил болох тухай бич. Бас Их Эзэний хийсэн зүйлийг үргэлж дурсан санахын тулд, тэрчлэн түүний Цагаатгалаар дамжин бий болсон гэтэлгэлийн төлөө талархлаа харуулахын тулд та нар юу хийж болох тухай бич.

Египетээс Гарсан нь 14

Улаан Тэнгисийг гаталсан нь



Амьдралд сорилтуудтай тулгарснаар бидэнд ирдэг адислалуудын нэг нь, тусламжийн төлөө Их Эзэнд хандахад сорилтууд биднийг олонтаа өдөөдөг явдал мөн (Исфер 12:27-г үз). Бид Их Эзэний хүч, тусламжийг хүлээн авсан үед ирээдүйд түүнд итгэх бидний итгэл өсөн нэмэгддэг. Бид гагцхүү чадах бүхнээ эхлээд хийх

замаар итгэлээ хөгжүүлсний дараа л ихэнх тохиолдолд бурханлиг тусламж ирдгийг бид санах ёстой (Исфер 12:6-г үз). Тусламж нь ихэвчлэн, Их Эзэний мутрыг харахад бидэнд тусалдаг тийм арга хэлбэрээр ирдэг.

Египетээс Гарсан нь 13:17-18-д Израилын хүүхдүүдийг амлагдсан нутгийн зүг аль чиглэлээр удирдахыг Их Эзэн Мосед хэлсэн байдаг. Тэрээр Израилчуудыг хамгийн шулуун шууд замаар удирдахгүй гэдгээ хэлсэн юм. Учир нь өөрсдийг нь уг нутагт оруулахгүй байхыг хичээх филистчүүдтэй тулгарах хангалттай итгэл хараахан тэдэнд байгаагүй хэмээн тэрээр хэлжээ. Бидний шийдвэрлэж чадахаас илүү хэцүү сорилтуудыг Их Эзэн бидэнд өгөхгүй гэдгийг мэдсэнээр бид тайтгарлыг олж болно (1 Нифай 3:7-г үз). Гэвч бид өөрсдийн итгэл хийгээд итгэлтэй байдлаа төлөвшүүлэхийн тулд бидний даван туулж чадна гэсэн сорилтуудыг биеэр туулах боломжийг Тэрбээр бидэнд олгох болно. Египетээс Гарсан нь 14 ийм нэг сорилтын тухай өгүүлдэг. Тэдний итгэл соригдсоны дараа, боломжгүй мэт санагдаж байсан нөхцөл байдлыг даван туулахад нь тэдэнд тусалсан Бурханы хүчийг дахин нэгэнтээ харуулсан гайхамшигийг Израилчууд биеэрээ харсан билээ.

Судруудыг ойлгох нь



Египетээс Гарсан нь 14

Би Фараоноор дамжиж алдарших болно (ш. 4, 17-18)—Фараон болон Египетийн цэргийн тухайд түүний хийсэн зүйлийн улмаас хүмүүс өөрийг нь Бурхан хэмээн үзэж илүү ихээр хүндлэх болно гэдгийг Их Эзэн хэлж байна.

Нэг нь (ш. 20)—Египетчүүд

Нөгөөдөө (ш. 20)—Израилчуудад

Үүрийн гэгээнээр (ш. 24)—Өглөөний 2:00 цагаас нар мандах хүртэл

Судруудыг судлах нь



Египетээс Гарсан нь 14-ийг судлахдаа А буюу Б үйл ажиллагааг хий.

А Зөвлөгөө өг

Саяхан Сүмд хөрвөгдсөн хэн нэгэнд буюу эсвэл хуучин найз нартайгаа харилцах харилцаанд болон арга замуудын хувьд хэцүү үеийг туулж, тэдэн уруу эргэж магадгүй байгаа, идэвхтэй болсон хэн нэгэнд зөвлөгөө өгсөн захидал бичихийн тулд бүлэг 14-өөс өвөрмөц санаанууд, нийлмэл үгсийг ашигла.

Б Тохируул

Мосегийн үе	Өнөөдөр
Египетийг орхин явсан нь	баптисм
Цөлийг гатлан аялсан нь	Дэлхийн арга замуудыг орхих нь
Улаан Тэнгисийг гаталсан нь	Ариун Сүнсний бэлэг хүлээн авах нь
Израилчуудыг дээрээс харж, удирдан хамгаалж байсан үүлэн багана ба гал	Сүнслэг байдлыг хөхиүлэн дэмждэг зүйлүүдийг олж, хэцүү дэлхийд амьдрах нь

Эхний багана дахь зүйлүүдийг хоёр дахь багана дахь зүйлүүдтэй тохируулж, тэдгээр нь хоорондоо хэрхэн холбогдохыг тайлбарла. Хэрэв та нарт тусламж хэрэгтэй бол, 1 Коринт 10:1–4-ийг Египетээс Гарсан нь 14-ийн эхлэлийн хажуу дахь зах дээр бичиж болно.

Египетээс Гарсан нь 15

Дургүйцэл, Хэсэг 1

Баяр талархлаа та нар хэрхэн илэрхийлдэг вэ? Өөрсдийнхөө бодол санааг Их Эзэнд харуулахын тулд та нар юу хийдэг вэ? Египетээс Гарсан нь 15 нь израилчууд Улаан Тэнгисийг гайхамшигтай байдлаар гатлан гарсны дараа Их Эзэнд зориулан нэг дууг хэрхэн бичиж, дуулсан тухай өгүүлдэг. Тэдний чөлөөлөлтийн дараа удалгүй Израилын хүүхдүүдэд өөр нэг сорилт тулгарсан ажээ. Тэдэнд тулгарсан дараагийн энэ сорилтыг олохын тулд Египетээс Гарсан нь 15:22–27-г унши.

Судруудыг ойлгох нь

Египетээс Гарсан нь 15:22–27

Гомдоллон (ш. 24)—

Тогтоол (ш. 25–26)—Зарлиг

Дургүйцэж

Судруудыг судлах нь

А Таны дуртай дуулал юу вэ?

Израилчууд баяр, талархалтай байсан үедээ Их Эзэнд зориулан дуулдаг байжээ. Ямар дуулал таныг Бурханд илүү ойртуулдаг вэ? Яагаад гэдгийг тайлбарла. Тайлбартаа уг дууллын үгнээс ашигла.

Б Энэ тохиолдолд та юу хийх вэ?

1. Египетээс Гарсан нь 15:22–27-г уншиж, ус байхгүйг мэдсэн үед хүмүүс яасныг, мөн Мосе юу хийснийг харьцуул.
2. Энэ сорилтод Мосе болон хүмүүсийн хариулсан өөр өөр арга замуудаас та нар юу сурч болох вэ?

В Сонгож хийх үйл ажиллагаа

Египетээс Гарсан нь 15:22–27; Алма 36:17–21-ийг уншиж, Марад учирсан бие махбодын туршлага ямар сүнслэг утгатай байж болохыг тайлбарла.

Египетээс Гарсан нь 16

Дургүйцэл, Хэсэг 2

Египетээс Гарсан нь 15 нь Израилын хүүхдүүд өөрсдөд нь асуудал бий болсон үед Мосе болон Их Эзэний талаар тэд хэрхэн “дургүйцэх” буюу гомдоллож байсныг үздэг. Улаан Тэнгисийн тэрхүү агуу гайхамшигийн дараа тэд хэрхэн тийм хурдан гомдоллож эхэлснийг ойлгох нь бидэнд хэцүү байдаг. Гэвч, боолчлол хэдийгээр израилчуудын эрх чөлөөг хязгаарлаж байсан ч гэсэн, боолчлол нь шоронд байгаа хүнийхтэй адил төстэй байдлаар израилчуудыг амьдралын хэрэгцээт зүйлсээр бас хангадаг байсныг бид санах ёстой. Израилын хүүхдүүд сонголтууд хийх эрх чөлөөгөөр хязгаарлагдмал байсан учраас, тэд сүнслэг байдлын хувьд өсч хөгжөөгүй байжээ. Их Эзэн бидний өсөлт хөгжилтийг сонирхдог учраас, бид сонголт хийхийг тэрээр хүсдэг. Тэр ч байтугай шаарддаг билээ. Бидэнд түүний тусламж хэрэгтэй болсон үед биднийг төлөвшүүлж, хүчирхэгжүүлдэг хүнд хэцүү зүйлүүдийг хийхийг биднээс шаарддаг тийм арга хэлбэрээр тэр биднийг тусламжаар хангадаг. Их Эзэнд дургүйцэх нь бидний хувьд хамгийн сайн зүйл юу болохыг тэрээр мэддэгт итгэх бидний итгэл дутмаг байгааг харуулдаг.

Египетээс Гарсан нь 16–17 нь Израилын хүүхдүүдийн их дургүйцэлийг агуулдаг. Та нар эдгээр бүлгүүдийг уншихдаа, Израилын хүүхдүүдийг хүчирхэгжүүлж, өөрт нь итгэх илүү агуу учир шалтгааныг тэдэнд өгөхийн тулд Их Эзэн тэдэнд юу заасныг эрж ол.

Судруудыг ойлгох нь

Египетээс Гарсан нь 16

Омер (ш. 16, 18, 22, 32, 36)—
Таван пайнт (хоёр литр)
орчим

Зааварласан (ш. 24)—
Зарлигласан

Судруудыг судлах нь

А Маннагийн зорилго юу байсан бэ?

1. Египетээс Гарсан нь 16:4-т өгүүлснээр, маннагийн зорилгуудын нэг юу байсан бэ?
2. Бүлэг 16-гаас уншсан зүйл дээрээ тулгуурлан, шүлэг 4-т өгүүлсэн зорилгыг манна хэрхэн хэрэгжүүлж чадсан гэж та нар боддог вэ?

Б Манна бол Христийн хэв шинж байв

Иохан 6:31-35, 48-51-ийг уншиж, манна хэрхэн Есүс Христтэй адилхан, бид хэрхэн Израилын хүүхдүүдтэй адилхан болох тухай бич. Еврей хэлээр *Бет.лехем* (Есүсийн төрсөн хот) гэдэг нь “талхны өргөө” гэсэн утгатайг мэдэх нь та нарт сонин байж болох юм.

В Та нар үнэн хэрэгтээ хэнд гомдоллодог вэ?

Та нар удирдагчдаа дургүйцсэнээр, үнэн хэрэгтээ хэнд дургүйцдэг вэ? (Египетээс Гарсан нь 16:8; С ба Г 84:36-г үз).

Египетээс Гарсан нь 17

Дургүйцэл, Хэсэг 3

Та нар Египетээс Гарсан нь 17-г уншихдаа дараах зүйлийг авч үз: Цангаж, ус уухыг хүсэх нь нүгэл биш. Ийм болохоор Их Эзэн Яагаад Израилын хүүхдүүдэд дургүй байсан бэ?

Судруудыг судлах нь

Египетээс Гарсан нь 17-г судлахдаа А буюу Б үйл ажиллагааг хий.

А Та нар юу гэж хэлэх байсан бэ?

Египетээс Гарсан нь 17-д цэдэглэгдсэн үйл явдлуудын дараа та израилчуудад хандаж таван минут үг хэлэх боллоо гэж бодвол, та тэдэнд хандаж юу хэлэх вэ, яагаад?

Б Өнөөдөр энэ нь хэрхэн тохиолддог вэ?

Египетээс Гарсан нь 17:4-т хүмүүс Бошиглогч Мосегоор хийлгэхийг хүсэж байсан зүйлийг шүлэг 10-13-т Мосегийн төлөө Аарон Хур хоёрын хийсэн зүйлтэй харьцуул.

Египетээс Гарсан нь 18

Мосег ядарч туйлдахаас хамгаалсан нь

Хүмүүс таныг шүүмжлэхэд та хэрхэн хариу үйлдэл үзүүлдэг вэ? Хэрэв таны зөв байвал яах вэ? Та тэдний санал бодлыг хүлээн авч, өөрчлөгдөх үү. Эсвэл зүгээр л бардам зангаа хамгаалахын тулд маргах уу? Мосе бол хүмүүсийн дээр тавигдсан агуу бошиглогч байлаа. Гэвч хэн нэг нь Мосег хэрхэн ажиллах ёстойг шүүмжилж, тэрээр

хэрхэн өөрчлөгдөж болохыг санал болгоход Египетээс Гарсан нь 18-д юу болсныг ажигла. Энэ тохиолдолд, Мосег шүүмжилсэн хүн хувьдаа юу ч олж аваагүй. Тэрээр зөвхөн хайрладаг хүндээ туслах сонирхолтой байлаа.

Судруудыг судлах нь

Мосе үүнийг бүгдийг нь хийхийг хичээж байв.



Израилын хүүхдүүдийг удирдах зохион байгуулалтыг Их Эзэн Мосед заажээ.



А Мосег “ядарч туйлдахаас” хамгаалсан нь

Нөхцөл байдал	
<input type="radio"/> Яагаад асуудал бий болов	
<input type="radio"/> Төлөвлөж буй шийдэл	
<input type="radio"/> Үг шийдлийг хэ рэгжүүлэхийн ач тус	
<input type="radio"/> Мосе юу хийсэн бэ	

Дээр үзүүлсэнтэй адил схем хийж, Египетээс Гарсан нь 18:13-26-д уншсан зүйлээсээ мэдээллийг бөглө.

Б Мосегийн үлгэр жишээнээс бид юу суралцах вэ?

Иетрогийн шүүмжлэлд Мосе хэрхэн хариулсан талаар бид юу суралцдаг вэ?

Египетээс Гарсан нь 19

Синайн Уулан дээр



Израилчуудыг Египетийн боолчлолоос чөлөөлөхийн тулд түүнийг Их Эзэн дуудахад Мосе Синайн Уулан дээр очжээ (Египетээс Гарсан нь 3-ыг үз). Тэрээр Израилын хүүхдүүдийг Египетээс удирдан гаргасны дараа, тэд “Бурханд энэ уулан дээр үйлчлэх болно гэдгийг Их Эзэн Мосед амласан нь Синайн Уулыг хэлсэн ажээ” (Египетээс Гарсан нь 3:12). Улаан Тэнгист болсон гайхамшигийн

дараа, Мосе нэгэн дуу бичиж, түүндээ тэд “таны өвийн уул” (Египетээс Гарсан нь 15:17) болох түүний “Ариун газарт” байж болохын тулд Их Эзэн израилчуудыг Египетээс удирдан гаргасан юм хэмээн тэрээр хэлжээ.

Тэр үеэс хойш Мосе бошиглогч хэмээн нэрлэгдсэн юм, Их Эзэнээр ариун болгогдсон газар—Синайн Уул уруу Израилын хүүхдүүдийг удирдсан нь Бурханы төлөвлөгөөний хэсэг байсан аж. Сургаал ба Гэрээнд өгүүлснээр, Мосе санваарын ёслолуудаар дамжуулан өөрийн хүмүүсийг Их Эзэний оршихуйд авчрахыг эрэлхийлж байжээ (С ба Г 84:19–24-ийг үз). Тэрээр дээрээс ирдэг хүчийг хүлээн авахын тулд тэднийг ариун сүм уруу аваачихыг хүсдэг байжээ хэмээн өнөөдөр бид хэлж болно. Мосе болон Израилын хүүхдүүдийн хувьд Синайн Уул нь Их Эзэн өөрийн хүмүүст өөрийгөө мэдүүлдэг газар—ариун сүм байсан юм. Та нар Египетээс Гарсан нь 19-ийг уншихдаа үүнийг сана.

Судруудыг ойлгох нь



Египетээс Гарсан нь 19—Египетээс Гарсан нь Бурханы оршихуйд эргэж очих бидний аяллын бэлэгдэл мөн

Дараах схем нь Израилын хүүхдүүд бүлгээрээ хийх аяллын тоймыг, түүнчлэн тэдний аялал Бурханы оршихуйд эргэж очихыг эрэлхийлэн бидний хийж байгаа аяллын хэв шинж хэрхэн болдгийг харуулжээ.

Дэлхий	Баптисм	Ариун Сүнс	Дэлхийгээр дамжин Бурхан уруу хийх аялал	Ариун сүм	Селестиел хаант улс
--------	---------	------------	--	-----------	---------------------

Египетийн нутаг



Улаан Тэнгис



Үүл ба галан багана

Цөл



Синайн Уул

Амлалтын нутаг

Хүмүүсийг зохистой болох хүртэл Бурханы оршихуйгаас хол байлгахын тулд тавигдсан хязгаарлалтууд

Судруудыг судлах нь

А Мосе Синайн Уулан дээр гарч, мөн бууж ирсэн нь

Египетээс Гарсан нь 19-д Синайн Уулан дээр Мосе гурван удаа гарч, мөн тэндээс буусан тухай шастирыг агуулдаг. Мосе Их Эзэнтэй ярихын тулд Синайн Уулан дээр гарч, дараа нь Их Эзэний үгсийг хүмүүст хүргэхийн тулд уулнаас буудаг байжээ. Мөн үүний хамт, бас тэд уг уулан дээр гарч, Их Эзэнтэй харилцахын тулд хүмүүсийг хангалттай зохистой байхад бэлтгэхийг Мосе хичээж байв. Синайн дээр гарч, буусан Мосегийн аяллуудыг тоймлосноор энэ бүлгийг зохион байгуулахад дараах схем та нарт тусалж болно.

Дээр дурдсан үйл явдал тус бүрд юу тохиолдсоныг хураангуйлан дүгнэ. Мосег Синайн Уулан дээр дараагийн удаа гарахад юу тохиолдсоныг Египетээс Гарсан нь 20–23; 24:1–8-аас унш.



Б Ариун сүмийн төлөө бэлтгэ

Далын Ахлагч Ж. Баллард Воошбөрн, “Бид Бурханы шүүлтүүдийг өөрсөд дээрээ авчралгүйгээр, зохистойгүй байж Түүний ариун өргөө уруу явж чадахгүй. Учир нь Бурхан шоглуулахгүй” гэж хэлжээ (in Conference Report, 1995 оны 4-р сар, 12–13; Ensign, 1995 оны 5-р сар, 11–12).

1. Ахлагч Воошбөрнийн заасан зүйлийн ач холбогдлыг онцлон тэмдэглэсэн, Египетээс Гарсан нь 19-д Мосегийн, эсвэл Их Эзэний хэлсэн үнэнүүдийг жагсаа.
2. Ариун сүмд орохын өмнө зохистой байх нь яагаад чухал вэ? (чухал туслалцааны төлөө С ба Г 97:15–17-г үз).

Египетээс Гарсан нь 20

Арван Зарлиг

Синайн Уулан дээр гарсан Мосегийн гурван аяллын нэгнээр (Египетээс Гарсан нь 19-ийг үз) Бурхан түүнд заасан зарлигуудыг бид Египетээс Гарсан нь 20-д уншидаг. Эдгээр сургамжуудыг Арван Зарлиг гэдгээр нь өргөн хүрээнд мэддэг. Арван Зарлиг бол “гэрээний үгс” буюу гэрээг хүлээн авах шаардлагууд мөн гэж хожим нь Их Эзэн хэлжээ (Египетээс Гарсан нь 34:28-ыг үз). Иймээс, израилчуудыг Синайн Уулан дээр гарахыг зөвшөөрөхөөс өмнө тэдэнд зориулж Арван Зар

лигийг өгсөн ажээ. Тэр үед Арван Зарлиг нь өнөөдөр ариун сүмийн зөвшөөрлийн бичиг олж авахтай ихэд адилхан байв.

Хожим нь Арван Зарлиг чулуун хавтангууд дээр бичигдэж, гэрээний авдарт хадгалагдан (энэ тухай та нар хожим унших болно), “гэрчлэл” гэж нэрлэгдэх болжээ. Арван Зарлигийн зарчмуудын тухай гэрчлэлтэй байх нь хожим нь Аврагч, Бошиглогч Иосеф Смит нарын заасан Сайн мэдээний зарчмуудыг ойлгоход үндэс суурь болдог билээ (Дэд Хууль 10:1–5-ыг үз).

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын туслах Ахлагч Бернард П. Брокбанк, “Бурханаас өгсөн Арван Зарлиг бол Бурханы заасан амьдралын замын үндсэн хэсэг, хаант улсын Сайн мэдээний үндсэн хэсэг хэвээр байна. Бидний амьдардаг газар хийгээд гэр орондоо Их Эзэнийг болоод түүний зарлигуудыг хүндэтгэдэг арга зам нь үүнээс хойш бидний олж авах алдар суугийн зэрэглэлтэй холбоотой юм. Хэрэв бүх хүн төрөлхтөн Арван Зарлигаар амьдрах юм бол, өөрийгөө хүндлэн дээдлэх, амар амгалан, хайр хийгээд аз жаргал энэ дэлхий дээр бидэнд байх болно” хэмээн хэлжээ (in Conference Report, 1971 оны 10-р сар, 41; Ensign, 1971 оны 12-р сар, 63).

Судруудыг судлах нь

A Төгс Эзэмших Судар—Египетээс Гарсан нь 20:3—17

Дөрөв, тав дахь зарлигууд нь (Египетээс Гарсан нь 20:8–12-ыг үз) бид юу хийх ёстойг бидэнд өгүүлдэг. Бусад зарлигууд нь юу хийх ёсгүйг бидэнд өгүүлдэг. Зарлиг бүрийг сахих арга замуудыг харахын тулд “чи ёсгүй” гэсэн зарлигуудыг “чи ёстой” гэсэн мэдэгдлүүд болгон дахин бич.

B Та нар юу гэж бодож байна вэ?

Арван Зарлигийн алинд нь өнөөдөр дэлхий илүү их анхаарал тавих хэрэгтэй гэж та нар боддог вэ? Яагаад?

B Тэд хэрхэн хариулсан бэ?

1. Египетээс Гарсан нь 19–20 дахь зүйлүүдийг сонсож, харсны дараа Израилын хүүхдүүд юу хийсэн бэ? (мөн Египетээс Гарсан нь 20:18–21-ийг үз).
2. Зарим хүмүүс Бурханд ямар байдлаар ойр дөт байхгүй байхаар, эсвэл ямар байдлаар түүнээс хол байхаар сонгодог гэж та нар боддог вэ?

Египетээс Гарсан нь 21–23

Нүдийг нүдээр,
шүдийг шүдээр

Египетээс Гарсан нь 21–23 нь Бурханы хуулиудын өвөрмөц, нэг заалтын дараах нөгөө заалтын хэрэглээг агуулдаг. Жишээ нь, “чи алах ёсгүй” гэдэг нь Арван Зарлигийн нэг. Гэвч, чи өнөөдөр хэн нэгнийг хүндээр бэртээвэл яах вэ? Эсвэл чи хүн биш, харин мал амьтан албал яах вэ? Египетээс Гарсан нь 21–23 нь эдгээр олон төрлийн асуул-

туудын талаар өгүүлж, бас зарлигийг зөрчсөнөөс ирж болох шийтгэлийг дүрсэлсэн байдаг. Дурдагдсан шийтгэлүүд бол зөрчлийн төлөөх дээд шийтгэл бөгөөд аяндаа хэрэгжих албагүй юм. Хуучин Гэрээний энэ зарчим Есүс Христийн Сайн мэдээгээр солигдсон юм (Матай 5:38–48-ыг үз).

Египетээс Гарсан нь 24

Далан Ахлагч
Бурханыг харав

Египетээс Гарсан нь 20–23-т Мосе Бурханы хуулиудыг Израилын хүүхдүүдэд тайлбарлажээ. Тэдний хувьд цааш өссөн хөгжихөд, тэд юуны өмнө эдгээр хуулиудад өөрсдийгөө шийдвэр төгс болгох хэрэгтэй байв. Египетээс Гарсан нь 24 нь ариун сүмтэй холбоотой илүү дээд хуулиудыг хүлээн авахад израилчуудын харуулсан шийдвэр төгс байдлын тухай өгүүлдэг. Иймээс, түүний оршихуйд орох боломжийг хүмүүст олгох ёслолуудын тухай нэмэлт мэдээллийг хүлээн авахуулахаар Их Эзэн Мосег Синай дээр хүрч ирэхийг дөрөв дэх удаагаа дахин дуудсан ажээ.

Судруудыг ойлгох нь

Египетээс Гарсан нь 24

Нэгэн дуугаар (ш. 3)—
Санал нэгдмэлээр

Үзэгтүн (ш. 8)—Энэ бол

Хүндэт хүмүүс (ш. 11)—
Удирдагчид

Мутраа сунгаагүй (ш. 11)—
Бурханы хүч израилчуудад
хохирол учруулаагүй.
Ерөнхийдөө Бурханыг харах
нь тэдний хувьд тэвчихээс
илүү юм

Судруудыг судлах нь

A Гэрээнүүд хэр зэрэг чухал вэ?

1. Бурханы хуулиудыг хүмүүст өгсний дараа, тэд ямар гэрээ хийсэн бэ? (Египетээс Гарсан нь 24:3–8-ыг үз).
2. Египетээс Гарсан нь 24:9–11-д өгүүлснээр, далан Ахлагч энэ гэрээг хийсэн учир тэдэнд юу тохиолдсон бэ?
3. Та нар түүнтэй гэрээнүүд хийж, сахихад юу тохиолдох болно гэж Их Эзэн амласан бэ? (Мозай 18:8–10; С ба Г 20:77, 79-ийг үз). Эдгээр амлалтууд Мосе болон далан Ахлагчид тохиолдсон зүйлтэй хэрхэн холбогддог вэ?

Египетээс Гарсан нь 25–27, 30



Асар

Египетээс Гарсан нь 25–27, 30 нь асар байгуулах тухай Мосед Их Эзэний өгсөн заавруудыг агуулдаг. Асар нь, ариун сүм өнөөдөр бидний хувьд ариун газар байдаг шиг Израилын хүүхдүүдийн хувьд тийм ариун газар байлаа. Энэ асар авсаархан байхаар төлөвлөгдсөн нь Израилын хүүхдүүд цөлд байхдаа байнга нүүдэллэдгийнх байв. Асар барих зааврууд нэн нарийн тодорхой байсан нь ариун сүмийн тухайд юм бүхэн Их Эзэнд чухал болохыг тэрээр зааж, өөрийн хүмүүст сүнслэгээр нөлөөлдөг байсныг ойлгоход бидэнд тусалдаг. Ариун сүмийн зохион байгуулалт, тавилгууд нь түүнд ойр дотно байж, зарлигуудыг нь сахих хүслийг бидэнд төрүүлэх чухал зарчмуудыг бидэнд заадаг билээ. Асрын дараах схем асар дахь юм болгоныг буюу бүрдүүлбэр бүрийг нэрлэжээ. Мөн Бурхан болон өөрийн хүүхдүүдэд зориулсан түүний төлөвлөгөөний тухай бидэнд заахад эдгээр бүрдүүлбэрүүд юугаар туслах тухай зарим зөвлөмжүүд орсон байдаг.

Асрын тухай Египетээс Гарсан нь 25–27, 30-аас авсан мэдээлэл нь “Судруудыг ойлгох нь” мөн “Судруудыг судлах нь” хэсгүүдийг орлож байгаа болно. Доорх зүйлүүд нь та нарын хувьд тэмдэглэлийн дэвтэртээ хийх судрууд судлах үйл ажиллагааны хэлбэр бөгөөд асар болон түүний тавилгууд нь Сайн мэдээний зарчмуудыг хэрхэн заагдийг илүү сайн ойлгоход та нарт туслах ёстой.



Асар



Гэрээний авдар

Аароны дэлбээний болцууг бас авдар дотор хийжээ. Таг нь Бурханы оршихуйг төлөөлөх бөгөөд өршөөлийн суудал гэж нэрлэгддэг. Хүмүүсийн төлөө Цагаатгал хийхийн тулд санваартан жилд нэг удаа өршөөлийн суудал дээр ёслол гүйцэтгэдэг байжээ (Хуудас 60 дахь Левит 16-д зориулсан мэдээллийг үз). Египетээс Гарсан нь 25:22-д Их Эзэн өршөөлийн суудлын тухай Мосед юу хэлсэн бэ?




Оршихуйн талхны ширээ

байжээ. Талх, дарс юуг төлөөлдөг байсан байж болох вэ?




Ариун дэнлүүний суурь ба иш

Ариун дэнлүүний суурь ба иш (Египетээс Гарсан нь 25:31–40-ийг үз) бол иудейчүүдийн итгэлийн нэрд гарсан бэлэгдэл бөгөөд үүнийг еврей нэрээр нь менора хэмээн олонтаа нэрлэдэг байсан аж. Дээр нь байх долоон хундгыг чидуны цэвэр тосоор дүүргэж, дотор нь зулын гол хийж таг тавьдаг байжээ. Долоогийн тоо нь еврейчүүдийн дундах ариун байдал буюу төгс байдлыг төлөөлдөг аж. Есүсийн ярьсан арван онгон охины тухай сургаалт зүйрлэл дэнлүүн доторх тос юуг төлөөлдөг тухай түлхүүрийг өгүүлдэг (Матай 25:1–13; С ба Г 45:56–59-ийг үз). Тос юуг бэлэгддэг байсан гэж боддог тухайгаа бич.



Гол ширээ буюу тахилын ширээ

Бүх шатаалт өргөлүүд тахилын ширээн дээр гүйцэтгэгддэг байв (Египетээс Гарсан нь 27:1–8-ыг үз). Золиослол нь, хэрэв хувь хүн цааш явахыг аль нэг байдлаар хүсвэл асарт орохдоо хийдэг анхны зүйл байв. Их Эзэн өнөөдөр золиослолын замаар юу хийхийг өөрийн хүмүүсээс хүсдэг вэ? (3 Нифай 9:19–20-ийг үз). Сайн мэдээний зарчмууд болон ёслолуудаас энэ ширээ алийг нь төлөөлдөг вэ? (Итгэлийн Тунхаг 1:4-ийг үз). “Хувь хүний золиослолын жинхэнэ үйлдэл нь эдүгээ болоод үүнээс хойш тахилын ширээн дээр мал тавих явдал биш. Үүний оронд, бид өөрсдийн дотоод сэтгэл дэх нүгэлт хүслүүдийг тагдан хаях хүсэл эрмэлзэлтэй байх хэрэгтэй! Энэ бол ‘харууссан зүрх, гэмшсэн сэтгэлийг Их Эзэнд тахил болгон өргөх явдал мөн’ (3 Нифай 9:20)” хэмээн Ахлагч Нийл А.Максвелл хэлжээ (Meek and Lowly [1987], 94).



Утлагын ширээ

Дээд санваартан өглөө бүр бас орой бүр утлага уугиулахын тулд утлагын ширээн дээр халуун нүүрс тавьдаг байжээ (Египетээс Гарсан нь 30:1–10-ыг үз). Дуулал 141:2; Илчлэлт 5:8; 8:3–4-ийг уншиж, энэ ширээ юуг төлөөлдөг байсан гэж боддогоо тайлбарла.



Угаалгын сав буюу усны хувин

Санваартнууд угаалгын сав буюу усны хувинг (Египетээс Гарсан нь 30:18–21-ийг үз) асрын ариун газруудад орохын тулд бэлтгэхэд ашигладаг байжээ. Мосегийн үед угаалгын сав нь зүгээр л усны том хувин байлаа. Гэвч Соломон байнгын ариун сүм барьсан үед тэрээр угаалгын савыг арванхоёр шарын нуруун дээр байрлуулжээ. Их Эзэн

угаалгын савыг асрын хамгийн ариун газруудад нэвтрэх орцын өмнө байрлуулснаар өөрийн хүмүүст юуг заахыг хичээсэн гэж та нар боддог вэ?

Египетээс Гарсан нь 28–29

Ариун сүм дэх санваартнууд

Египетээс Гарсан нь 28–29 нь хүмүүст зориулж ёслолуудыг гүйцэтгэхийн тулд асарт ажилладаг байсан санваартнуудын талаар Мосед өгсөн Их Эзэний илчлэлтүүдийг агуулдаг. Эдгээр илчлэлтүүд санваартнуудыг хэрхэн онцгойлон адислах хийгээд ариулан адислах, тэд ямар хувцас өмсөх, мөн тэдний зарим үүргүүдийн талаарх заавруудыг агуулдаг. Асарт зориулж хийсэн зүйлүүдийн бэлэгдлийг авч үзэх нь Сайн мэдээний тухай болон Их Эзэн биднээс юуг хүсэн хүлээдэг тухай илүү их зүйлийг бидэнд зааж чадна.



Ефод
(Египетээс Гарсан нь 28:6–12-ыг үз)

Шүүхийн цээживч
(Египетээс Гарсан нь 28:15–30-ийг үз)

Нөмрөг
(Египетээс Гарсан нь 28:31–35-ыг үз)

Малгай
(Египетээс Гарсан нь 28:36–38-ыг үз)

Судруудыг судлах нь

Египетээс Гарсан нь 28–29-ийг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А–В) хоёрыг хий.

А Тэднийг хэн гэж нэрлэдэг байсан бэ?

Египетээс Гарсан нь 28:1; Еврей 5:1, 4; Итгэлийн Тунхаг 1:5-ыг унш. Аарон болон түүний хөвгүүд санваартан болохын тулд яаж дуудагддаг байсан хийгээд энэ нь Сүмд санваарын албан тушаал хүлээн авдаг бүх хүмүүсийн хувьд хэрхэн загвар болохыг тайлбарла.

Б Ариун ёслолыг тоймлон дүрсэл

Египетээс Гарсан нь 29:1–21 нь санваартан асарт ажиллахын тулд хэрхэн ариулан адислагддаг буюу онцгойлон адислагддаг байсан тухай дүрсэлдэг. Дараах шүлэгт өгүүлнээр юу болдог байсан тухай дүрслэх замаар уг ёслолыг тоймлон харуул:

- Эхний үйл явдал (ш. 4-ийг үз)
- Хоёр дахь үйл явдал (ш. 5–6-г үз)
- Гурав дахь үйл явдал (ш. 7-г үз)
- Дөрөв дэх үйл явдал (ш. 10–14-ийг үз)
- Тав дахь үйл явдал (ш. 15–18-ыг үз)
- Зургаа дахь үйл явдал (ш. 19–21-ийг үз)

В Бэлэгдэл нь юу вэ?

Аарон болон түүний хөвгүүд чих, гар, хөлөө цусаар ариулан адисалдаг байжээ. Цус нь Христийн Цагаатгал буюу биднийг ариун болгох хүчийг бэлэгддэг байсныг бид мэднэ. Чих, гар, хөл юуг бэлэгддэг вэ, мөн уг бэлэгдэл нь ариун сүмийн үүргүүддээ бэлтгэх тухай бидэнд юу заадаг вэ?

Египетээс Гарсан нь 31

Асарт ажиллахаар эрчүүд дуудагдсан нь

Египетээс Гарсан нь 31 нь асар барих болон үүний тавилгуудыг бэлтгэхэд туслахын тулд Их Эзэн хэрхэн ур чадвартай хүмүүсийг дуудсан тухай өгүүлдэг. Бурханы хаант улсыг урагш ахиулах нь олон төрлийн авьяас чадварыг шаарддаг. Тиймээс, бид авьяастнуудыг Их Эзэнд онцгойлон адисалсан үед барилгын, урлагийн, ажил хэргийн гэхчлэн ур чадвар бүхэн нь түүний хаант улсыг байгуулахад тусалж чадна. Египетээс Гарсан нь 31 нь бас Хүндэтгэлийн өдөр—тэр ч байтугай түүний асарт ч ажил хийхээс татгалзах тухай Израилд өгсөн Их Эзэний сануулгыг агуулдаг.

Египетээс Гарсан нь 32

Алтан тугал

Египетээс Гарсан нь 24 нь Мосе хэрхэн Синайн Уулан дээр гарч дөчин өдрийн турш Их Эзэнтэй харилцсан тухай өгүүлдэг. Энэ үеэр Мосе Египетээс Гарсан нь 25–31-д байдаг илчлэлтүүдийг хүлээн авчээ. Мосе уг уулан дээр гарахаас өмнө, тэр үед Мосегаар дамжуулан илчилсэн зарлигууд, түүний дотор Арван Зарлигийг сахих гэрээнд Израилын хүүхдүүд орсон байлаа. Өмнө дурдсаны дагуу, Синайн Уулан дээр Мосе Их Эзэнээс хүссэн илүү их адислалыг тэд хүлээн авч чадахын тулд Арван Зарлигаар амьдрах израилчуудын шийдвэр төгс байдал чухал байв. Хэрэв израилчууд Арван Зарлигийг зөрчих юм бол, Их Эзэн тэдэнд өгөхийг хүсэж байсан нэмэлт адислалуудыг алдах байв. Харамсалтай нь, яг ийм явдал болсон билээ.

Судруудыг ойлгох нь

Анхааруулга: Энэ болон бусад бүлгийн, Судруудын Удирдамж, “Библийн Иосеф Смитийн Орчуулгаас авсан түүврүүд” дэх өөрчлөлтүүдийг эрж олохыг сана.

Египетээс Гарсан нь 32:26—“ЭЗЭНий төлөө байгч хэн бэ?”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн, Ахлагч Жорж Альберт Смит Их Эзэний төлөө байхын чухлыг онцлон тэмдэглэхдээ: “Их Эзэний нутаг дэвсгэрийг Люсиферийнхээс тусгаарладаг зааглалтын тодорхой шугам байдаг. Хэрэв бид уг шугамын Их Эзэний төлөөх тал дээр амьдрах юм бол, Люсифер бидэнд нөлөөлөхөөр ирж чадахгүй. Гэвч бид түүний нутаг дэвсгэр дэх шугам уруу давж орох юм бол, бид түүний хүчин дор байх болно. Их Эзэний зарлигуудыг сахьснаар бид уг шугаманд Түүний төлөө аюулгүй байдаг. Бид Түүний заадаг зүйлүүдэд дуулгаваргүй байх юм бол, өөрийн эрхгүй уруу таталтын бүс уруу орж, тэнд үргэлж байдаг устгалыг урин дууддаг. Үүнийг мэддэг учраас, бид зааглах шугамын Их Эзэний төлөөх тал дээр амьдрахын тулд цаг үргэлж, хичнээн их анхаарал санаа тавих ёстой билээ” гэжээ (“Our M. I. A.,” *Improvement Era*, 1935 оны 5-р сар, 278).

Судруудыг судлах нь

А Тэд амархан мартсан уу?

Египетээс Гарсан нь 20:3–6; 24:3; 32:1–6, 8-ыг уншиж, дараах асуултуудад хариул:

1. Израилын хүүхдүүд Арван Зарлигаас ямар зарлигуудыг Египетээс Гарсан нь 32-т зөрчсөн бэ?
2. Тэд яагаад ингэсэн гэж та нар боддог вэ?

Б Зарчмыг хэрэглэ

1. Ямар байдлаар өнөөдөр хүмүүс юмсыг хийх Бурханы арга замд тэвчээргүй хандсанаар уруу татагдаж, түүний зарлигуудыг зөрчдөг вэ?
2. Ийнхүү тэвчээр дутагдах нь хуурамч бурхныг шүтэн бишрэхэд хэрхэн илэрдэг вэ?

В Нүгэл ба наманчлалын тухай мэдэж ав

Египетээс Гарсан нь 32:19–29-д Мосе хүмүүсийг наманчлалд шаргуу дуудсан байдаг. Нүглийн үр дагаврууд хийгээд наманчлалын шаардлагуудын талаар, Мосе хэрхэн үйлдэж, юу тохиолдож байснаас бид ямар сургамжууд авч болох вэ?

Египетээс Гарсан нь 33

Мосе Их Эзэнийг дахин харав

Израилын хүүхдүүд алтан тугал шүтэн биширсний улмаас, Их Эзэнтэй хийсэн гэрээгээ зөрчиж, Их Эзэний оршихуйг өөрсдөдөө байлгахад өөрсдийгөө зохисгүй болгосон билээ. Гэвч Их Эзэн өөрийн хүмүүсийг орхиогүй юм. Израилын хүүхдүүд хэдийгээр түүний оршихуйд байж чадаагүй ч гэсэн, өөрийнх нь тэнгэр элч тэдэнтэй хамт амлагдсан нутаг уруу явах болно хэмээн Египетээс Гарсан нь 32:34-т Их Эзэн амлажээ. Египетээс Гарсан нь 33 нь Их Эзэнтэй харилцаж байсан израилчуудын харилцаа, Их Эзэнтэй харилцаж байсан Мосегийн харилцааны хоорондох ялгааг харуулсан түүхүүдийг агуулдаг. Энэ ялгаа нь бид Их Эзэний бүрэн адислалуудыг хүсэж, бас эрэлхийлдэг үү. Эсвэл бид бошиглогчид болон Сүмийн бусад удирдагчид л сүнслэг чухал туршлагаудтай байх ёстой гэж боддог уу хэмээн өөрсдөөсөө асуухад биднийг хөтлөх учиртай. Хэрэв бид Их Эзэний бүрэн адислалуудыг хүсдэг бол, юу хийх ёстой вэ?

Судруудыг судлах нь

А Тэд юу алдсан бэ?

1. Египетээс Гарсан нь 33-ын шүлэг 3, 5-д Израилын хүүхдүүдийг дүрслэхийн тулд Их Эзэний хэрэглэсэн нэг үгийг ол. Энэ үгийг та нар судрууддаа онцгойлон тэмдэглэхийг хүсэж болно. Тэр үг юуг бэлэгддэг вэ?
2. Шүлэг 7–11-д өгүүлснээр, дээр өгүүлсэн хандлагын улмаас Израилын хүүхдүүд ямар адислалуудаа алдсан бэ?
3. Яг энэ хандлагаас болж, өнөөдөр хүн агуу адислалуудыг алдаж болох тухай богинохон жишээ бич.

Б Төгс эзэмших судрын шүлгийг ашиглан номлогч бол

Хүн Бурханыг харж чадахгүй гэж Библи хэлсэн учраас Анхны Үзэгдлийн тухай Иосеф Смитийн түүхэнд итгэдэггүй гэж таны сонирхогчид хэлжээ. Тэд Египетээс Гарсан нь 33:20-ийг танд уншиж өгч мэднэ. Та Египетээс Гарсан нь 33:11; Судруудын Удирдамж, “Библийн Иосеф Смитийн Орчуулгаас

авсан түүврүүд,” Египетээс Гарсан нь 33:20-ийг; тэрчлэн хүн хэрэг дээрээ Бурханыг харж чадахыг харуулсан Библийн өөр хоёр судрыг ашиглан, тэдний асуултад хэрхэн хариулахаа тайлбарла. Та өөрийн судрууд дахь судлах тусламжийг ашиглах хэрэгтэй байж болно. Өөрийнхөө судруудаас олсон ишлэлүүдийг Египетээс Гарсан нь 33:11-ийн дэргэд бич.

Египетээс Гарсан нь 34

Бага хууль

Синайн Уулан дээр Мосе чулуун хавтангууд дээр бичигдсэн хуулиуд, зарлигууд, ёслолууд, гэрээнүүдийг Их Эзэнээс хүлээн авчээ. Мосе Синайгаас бууж ирээд Израилын хүүхдүүд алтан тугал шүтэж байхыг хараад, тэрээр чулуун хавтангуудыг газар уруу шидэж, хагалжээ (Египетээс Гарсан нь 32:15–19-ийг үз). Хавтангууд дээр бичигдсэн бүхнийг израилчууд хүлээн авахаар зохистойгоо тэд харуулж чадсангүй.

Хэрэв бид дуулгаваргүй байх юм бол бид ч бас агуу адислалуудыг алдаж болно. Гэвч Их Эзэн Израилын хүүхдүүдийн хувьд тэвчээртэй байж, наманчлан, түүнд эргэж ирэх боломжуудыг тэдэнд олгосон билээ. Их Эзэн бидэнд туслахыг хүсдэг учраас, бид наманчилж, бидэнд түүний өгөхийг хүсдэг бүрэн адислалуудыг хүлээж авах боломж олгодог нэмэлт буюу шинэ, илүү чанга зарлигуудыг тэрээр байн байн бидэнд өгдөг. Египетээс Гарсан нь 34-т Израилын дуулгаваргүй хүүхдүүдэд Их Эзэний өгсөн нэмэлт зарлигуудыг цэдэглэсэн байдаг.

Судруудыг ойлгох нь



Египетээс Гарсан нь 34

Цэвэр (ш. 7)—гэм буруугүй-
гээ тунхаглах

Уучлах (ш. 9)—Өршөөх

Левитийн Ном

Левит бол Мосегийн таван номны гурав дахь нь юм (“Эхлэлийн, Мосегийн болон Абрахамын Номнуудыг үз” х. 56-г үз). Левит дэх зааврууд нь нэг бол Мосег Синайн Уулан дээр байхад, нэг бол Египетээс Гарсанд дүрслэгдсэн үйл явдлуудын дараахан удалгүй түүнд илчлэгдсэн гэж бид боддог, учир нь заавруудын нэг хэсэг нь асарт өргөгдөх ёстой золиослолуудыг авч үзсэн байдаг. Левит гэдэг нь “Левичүүдтэй хамт тэднээр хийлгэх” гэсэн утгатай ажээ. Асрыг харж хандаж, үүн дотор ажиллан, энэхүү ариун газарт ёслолууд гүйцэтгэхэд нь Израилын угсааны үлдсэн хэсэгт туслуулахаар Их Эзэн Левийн овгийг сонгожээ. Левитийн Номны нилгээд их хэсэгт нь асарт гүйцэтгэгдэх ёстой ёслолууд, эдгээр ёслолуудыг гүй-

Судруудыг судлах нь



А Иосеф Смитийн Орчуулгаас тусалцаа ав

Судруудын Удирдамж, “Библийн Иосеф Смитийн Орчуулгаас авсан түүврүүд,” Египетээс Гарсан нь 34:1–2-ыг уншиж, хоёр дахь чулуун хавтангууд нэг дэхээсээ ямар ялгаатай байсан тухай бич.

Б Тэдгээр нь яагаад өөр байсан бэ?

Мозая 13:29–30; Сургаал ба Гэрээ 84:19–27-г уншиж, яагаад хоёр дахь хавтангууд нэг дэхээсээ өөр байсан тухай бич.

Египетээс Гарсан нь 35–40

Асар баригдаж, онцгойлон адислагдсан нь

Египетээс Гарсан нь 35–40 нь асрын талаар Египетээс Гарсан нь 25–30-д өгөгдсөн Их Эзэний зарлигуудыг Израилын хүүхдүүд хэрхэн биелүүлсэн тухай өгүүлдэг. Египетээс Гарсан нь 35–40-д бичигдсэн зүйлээс их хэсэг нь израилчууд Их Эзэний зарлигуудыг ширхэгчлэн сахихыг хичээж байсныг харуулахын тулд Египетээс Гарсан нь 25–30-тай нэгэн адил үг хэллэгээр бичигдсэн ажээ.

Судруудыг судлах нь



А Асрыг онцгойлон адислах үед юу тохиолдсон бэ?

Египетээс Гарсан нь 40:34–38-ыг уншиж, асар дуусахад юу тохиолдсон тухай бич.

Левитийг судлахад бэлэн болох нь

ЛЕВИТИЙН ТОЙМ		
	Бүлгүүд	Тодорхойлолт
Хэсэг 1	Левит 1–16	Зөвтгөл, энэ нь өршөөгдөж, Бурханы өмнө зохистой байх гэсэн утгатай
	Левит 1–7	Нүглийн төлөө цагаатгадаг буюу Бурханы өмнө шийдвэр төгс байх хүсэл эрмэлзлийг илэрхийлдэг золиослолууд
	Левит 8–10	Өргөлүүдэд тусалдаг санваар атгагчдад зориулсан хуулиуд
	Левит 11–15	Хүмүүсийн цэвэр ариун байх тухай хуулиуд
	Левит 16	Израилын бүх угсаа ариусгагдаж болох Цагаатгалын Өдрийн тухай тайлбар
Хэсэг 2	Левит 17–27	Ариусгал, энэ нь илүү ариун хийгээд бурханлиг болох явдал мөн
	Левит 17	Хувийн цэвэр ариун байдал
	Левит 18	Гэр бүлийн харилцаан дахь цэвэр ариун байдал
	Левит 19–20	Нийгмийн харилцаан дахь хийгээд цугларалтын үе дэх цэвэр ариун байдал
	Левит 21–22	Санваарын цэвэр ариун байдал
	Левит 23–25	Цэвэр ариун байдлыг хөхиүлэн дэмждэг баяр ёслолууд хийгээд ариун үйл явдлууд
Хэсэг 3	Левит 26	Бурханы хуулиудыг дуулгавартай дагаснаас ирдэг адислалууд
Хэсэг 4	Левит 27	Их Эзэнд өргөл болгосон өмч хөрөнгөнүүд

Левит 1

Шатаалт өргөл

Мосегийн хууль бол “биднийг Христ уруу хандуулах зааварлагч” (Галат 3:24) байсныг Төлөөлөгч Паул заасан байдаг. Өөрөөр хэлбэл, Мосегийн хуулийн зорилго бол тэднийг Есүс Христ өөд чиглүүлэх зарчмуудад анхаарлаа төвлөрүүлэхэд нь израилчуудад туслах явдал байлаа (Иаков 4:4–5; Жером 1:11; Алма 34:13–14-ийг үз). Мосегийн хууль нэн чанд байсан бөгөөд Бурханыг байнга санахад нь Израилын хүүхдүүдэд туслах зорилготой өвөрмөц олон ёслолыг, түүнчлэн түүний талаар тэдний хүлээх үүргүүдийг шаарддаг байлаа. Жишээ нь: Нүглийн

төлөө мал нядалж, тахилд өргөх нь нүглийн үр дагаврууд “үхсэнийг” хувь хүнд сануулдаг байж. Нөгөө талаар, нүгэл үйлдсэн хүний оронд үхдэг байсан гэм зэмгүй мал нь нүгэлгүй Аврагч дэлхийд ирж, биднийг нүглээс авран, бидний төлөө цусаа урсгах болно гэдгийн бэлэгдэл болж үйлчилдэг байсан аж.

Левит 1 шатаалт өргөлд зориулсан заавруудыг өгдөг. Энэ өргөлийг санваартнууд өдөрт хоёр удаа хийдэг байв. Хувь хүмүүс Бурханд бүхнээ зориулсан, шийдвэр төгс байдлаа харуулахын тулд бас шатаалт өргөл өргөдөг байв. Шатаалт өргөлийн талаарх заавруудаас олон нь Левитэд тайлбарласан бусад өргөлүүдтэй адил юм. Шатаалт өргөл болон бусад өргөлүүдийн хоорондох хамгийн том ялгаа нь тахилд өргөх малыг бүхлээр нь тахилын ширээн дээр шатаадаг байсан нь, Бурханд бүрмөсөн шийдвэр төгс байгааг буюу бүхнээ зориулах хүсэлтэй байгааг бэлэгддэг ажээ.

Та нар уншихдаа, шатаалт тахил Есүс Христийн Цагаатгалын тухай бидэнд зааж болох арга замуудын талаар, түүнчлэн энэ нь Бурханы өмнө хүлээсэн тэдний үүргүүдийг израилчуудад хэрхэн сануулдаг байсан тухай бод.

Судруудыг судлах нь

А Наманчлалын бэлэгдлүүдийг ол

Дараах схемд жагсаасан, Левит 1:1–9-д байдаг шатаалт өргөлийн өвөрмөц шаардлагуудыг онцлон тэмдэглэ. Схемийг тэмдэглэлийн дэвтэртээ хийж, шатаалт өргөлийн бүрдүүлбэр бүр нь Есүс Христийн Цагаатгалаар дамжсан наманчлалын тухай бидэнд юу заадгийг тайлбарла.

Шаардлага	Наманчлал буюу Есүс Христийн Цагаатгалын тухай та нар юу мэдэв
Та “өөрийнхөө өргөлийг” (Левит 1:2) хийх ёстой гэдэг нь, та нар өөр хэн нэгэнд харьяалагддаг зүйлээр өргөл өргөж болохгүй гэсэн утгатай.	
Та малаар өргөл өргөх ёстой гэдэг нь “согоггүй эр мал” гэсэн үг юм (ш. 3).	
Та өргөлөө эхлээд “хурлын майхны үүдэнд” авчрах ёстой, уг майхан нь Бурханы амьдардаг газрыг төлөөлдөг (ш. 3).	
Та гараа тахилд өргөх малын толгой дээр тавьж, дараа нь малыг өөрөө нядлах ёстой (ш. 4–5-ыг үз).	
Та өргөлийг “өвчих” буюу арьсыг нь хуулах ёстой (ш. 6).	
Санваартнууд “толгой,” “гадар өөх,” “гэдэс дотор,” түүнчлэн “мөчүүдийг” тахилын ширээн дээр тавина (ш. 8–9).	
Тахилыг галаар дуустал нь шатаана (ш. 9-ийг үз).	

Левит 1:8–9 нь биеийн янз бүрийн хэсгүүдийг тахилд өргөх тухай өгүүлдэг. Толгой нь бидний бодол санааг төлөөлдөг. Мөчүүд нь бидний явалтыг эсвэл бидний явж байгаа зүг чигийг төлөөлдөг. “Тэдэс дотор” нь бидний санаа бодол, хүсэл эрмэлзэл хийгээд учир үндэслэлүүдийг төлөөлдөг. Өөх нь бидний хүч чадал, эрүүл мэндийг төлөөлдөг. Шүлэг 8–9 дэх үйл явдлуудаар юуг бэлэгддэг вэ? (мөн С ба Г 59:5-ыг үз).

Левит 2–7

Бусад өргөлүүд

Левит 2–7 нь израилчуудын өргөл болгодог байсан төрөл бүрийн золиослолуудыг нарийвчлан дүрсэлдэг. Левит 2-т махан буюу идээн өргөлийг дүрсэлдэг. Левит 3-т эвийн тахилыг дүрсэлдэг. Левит 4–5-д төрөл бүрийн нүгэл хийгээд гэм буруугийн төлөөх өргөлүүдийг дүрсэлдэг. Левит 6–7-д төрөл бүрийн бүх өргөлүүдийн тухай нэмэлт заавруудыг агуулдаг.

Судруудыг судлах нь

А Золиослолын хууль

Левитэд дүрслэгдсэн золиослолуудыг өнөөдөр Сүмийн гишүүдээс шаарддаггүй. Гэвч золиослолуудаар заагддаг зарчмууд өнөөдөр ч гэсэн үнэн бөгөөд хэрэв бид Бурханы хувьд зөв байхыг хүсдэг бол, энэ нь бидний амьдралын нэг хэсэг байх ёстой.

1. 3 Нифай 9:19–20-ийг уншиж, бид малаар тахил өргөхийн оронд юуг золиослох ёстой гэж Их Эзэн хэлсэн тухай бич.
2. 3 Нифай 9:19–20-д Есүсийн зарлигласан зүйлийг та нар хэрхэн хийж чадна гэж боддог тухайгаа жишээнүүд гарга.

Левит 8–9

Аарон болон түүний хөвгүүдийг ариулан адисалсан нь

Левит 8–9 нь асарт санваартны албан тушаалд үйлчлэх Аарон болон түүний хөвгүүдийг ариулан адисалсан жинхэнэ үйл явдлыг цэдэглэжээ (Египетээс Гарсан нь 28–29-ийг үз). Ариулан адислалтын дараа, хийгдсэн зүйлийг тэрээр сайшаасныг харуулж, Их Эзэний алдар сууг нэн тоддоор харуулжээ.



Левит 10

Санваар атгагчид ариун байх ёстой

Левит 10 бол зүгээр л зааврууд өгөхийн оронд түүх өгүүлдэг, Левитийн Номон дахь цөөн хэдхэн бүлгийн нэг юм. Энэ нь санваар дахь итгэлтэй байдлын тухай хүчирхэг захиасыг агуулдаг. Та нар уншихдаа, Ариун ёслолуудыг гүйцэтгэдэг бидний арга замын талаар Их Эзэн ямар бодолтой байдаг вэ? гэсэн асуултыг авч үз.

Судруудыг ойлгох нь

Левит 10

Бойпор (ш. 1)—Утлагын сав
Ёс бус (ш. 1)—Хориглогдсон
Хувь (ш. 13–14)—Төлбөр буюу цалин
Даллах өргөлийн өвчүү (ш. 14–15)—Дээш өргөж, энхийн тахилын хэсэг болгон далладаг, малын өвчүү
Гэм (ш. 17)—Нүгэл

Левит 10:12–20—Аарон яагаад тахилын идээг идээгүй вэ?

Аарон болон түүний хөвгүүд Елеазар, Итамар нар нүглийн өргөлийг тэдэнд зааварлагдсан байдлаар идсэнгүйг Мосе ажиглажээ. Үүний хариу болгож, Аарон Мосед ярихдаа, тэдний дуулгаваргүйн улмаас бусад хөвгүүдэд нь тохиолдсон зүйлийн дараа тэрээр махыг идэх нь зөв гэж бодоогүй гэжээ. Энэ хариултад Мосе сэтгэл хангалуун байжээ. Бид наманчлаагүй буюу эсвэл санваарын удирдагчид маань зөвлөсөн үед бид ариун ёслол мэтийн зарим ёслолуудад оролцохгүй байх ёстой. Хэрэв хүн наманчилж, сайжрахыг хүсэж, бишоптойгоо хамтран шийдвэрлэх ноцтой нүгэл үйлдээгүй бол, түүнчлэн санваарын хязгаарлалт дор байхгүй байгаа бол, хүн ариун ёслолоос хүртэх зохистой байдаг.

Судруудыг судлах нь

А Санваарыг зохих ёсоор хүндэтгэх тухай зөвлөгөө өг

Зөв шударга биш, хүндэтгэлгүй санваар атгагчдыг Их Эзэн өнөөдөр үхэлд хүртэл нь цохьдоггүй. Гэвч Левит 10-г, Их Эзэн Бурханы алдар сууг тэдний ариулан адислалтад нэн тодоор үзүүлсний дараа тун удалгүй Аароны хөвгүүд санваарт хөнгөн хуумгай хандсан үед Их Эзэн энэхүү албадлагын сургамжийг өгсөн нь чухал ач холбогдолтой юм (Левит 9-ийг үз). Санваарыг зохих ёсоор хүндэтгэхийн ач холбогдлыг онцгойлон авч үзэж, ариун ёслолд оролцох үедээ тоглохыг “байдаг л нэг наргиан” гэж үздэг байж болох залуу хүнд зөвлөгөө өгөхийн тулд Левит 10:1–7; Сургаал ба Гэрээ 121:36–38-ыг ашигла.

Б Яагаад үгүй гэж?

1. Аарон болоод түүний амьд байгаа хөвгүүдэд яахгүй байхыг Их Эзэн зарлигласан бэ? (Левит 10:8–11-ийг үз).
2. Энэ зарлигийнхаа шалтгааныг Их Эзэн юу гэсэн бэ?

Левит 11

Израилчуудад зориулсан “Мэргэн Ухааны Үг”

Аль нэг өдөр, хүмүүс залбирахаа мартаж, эсвэл ажиллах буюу шүтэн бишрэхээ үл тоомсорлож болох юм. Гэвч тэд идэхээ мартаж нь ховор байдаг. Мосегийн хуулийн нэг зорилго нь Бурханы өмнө хүлээсэн үүрэгт нь израилчуудыг өдөр тутам байнгын сануулгуудаар хангах явдал байсан учраас Израилын хүүхдүүд юу идэж болох мөн юу идэж болохгүй тухай заавруудыг уг хууль агуулдаг байв. Левит 11 нь эдгээр заавруудыг агуулдаг. Дүрэм заавруудыг “кошерын хуулиуд” гэж нэрлэх нь нийтлэг байдаг. Кошер гэдэг нь еврей үгнээс гаралтай бөгөөд “шашины хувьд цэвэр” гэсэн утгатай ажээ. Манай өнөө үед Мэргэн Ухааны Үг илчлэгдсэн лугаа адил, кошерын хуулиуд нь сайн эрүүл мэндийг хөхиүлэн дэмжиж байсан хэдий ч, тэдгээрийн үндсэн зорилго нь дуулавартай байдлыг заах явдал байв. Эрүүл мэндийн энэ хууль өнөөдрийн Мэргэн Ухааны Үгийн нэгэн адил, Мосегийн хуулийн өөр нэг зорилго нь Бурханы хүмүүсийг дэлхийн зурилуудаас хол байлгаж, цэвэр ариун болгоход нь тэдэнд туслах явдал байжээ.

Судруудыг судлах нь

Левит 11-ийг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А–В) хоёрыг хий.

А Энэ Кошер мөн үү?

Кошер гэдэг нь Иудейн хуулиар зохих ёсны буюу ариусгагдсан гэсэн утгатай аж. Дараах амьтдыг тэмдэглэлийн дэвтэртэй жагсаа: эмгэн хумс, хонь, хулгана, царцаа,

өрөвтас, гахай, үхэр, тэмээ, бүргэд, аварга загас. Амьтан бүр нь израилчууд хүнсэнд хэрэглэхийн хувьд “кошер,” “кошер бишийг” бичиж, яагаад гэдгийг тайлбарла. Шалтгаан бүрд өөрийн чинь хариултад тохирч байгаа нэг шүлгийг Левит 11-ээс иш тат.

Б Мэргэн Ухааны Үгийг нэгтгэн дүгнэ

Сургаал ба Гэрээ 89:5–17-г уншиж, өнөө үед юу идэх буюу юу идэж болохгүйг Их Эзэн Сүмийн гишүүдэд зарлигласныг жагсаа.

Эдгээр заавруудыг Левит 11-д Израилын хүүхдүүд юу идэж болох, юу идэж болохгүй талаар Их Эзэний заасан зүйлтэй харьцуул.

В Энэ яагаад чухал вэ?

Их Эзэн яагаад өөрийн хүмүүст зарим зүйлүүдийг идэхгүй байхыг зарлигласан гэж та нар боддог вэ? (Хэрэв танд тусламж хэрэгтэй бол, Левит 11:43–47; 1 Коринт 6:19–20; С ба Г 89:1–4, 18–21-ийг үз).

Левит 12

Цэвэр ба бузар

Левитийн бүлэг 12–15-д Их Эзэн Мосегийн хуулийн дагуу бие эрхтний үйл ажиллагаа болон өвчнүүдэд ямар зүйл “цэвэр” болон “бузар” талаар Их Эзэн заавар өгсөн байдаг. Левит 12 нь төрөлтийн дараа эмэгтэйчүүдэд холбогдох хуулиудыг тайлбарладаг. Тодорхой цаг үед тэд “бузарт” тооцогдож байсан боловч Их Эзэн бас тодорхой цаг хугацааны дараа тэднийг ёслолоор “цэвэр” болгож болох өвөрмөц ёслолуудыг тоймложээ. Есүсийн эх Мариа Есүсийг төрсний дараа эдгээр ёслолуудыг дагасан ажээ. (Лук 2:21–24, 39-ийг үз).

Төрөлхийн бие эрхтний үйл ажиллагаа хүнийг яагаад цэвэр биш болгодог тухай санаанд зарим хүмүүс гайхаж тээнээгэлздэг. Гэвч Мосегийн хуулиар бол, “бузар” гэдэг нь хир буртагтай буюу ой гутмаар гэсэн утга байхгүй, харин ариун ёслолуудад оролцоход хүлээн авч болохгүй гэсэн утгатайг бид ойлгох ёстой. Бас Мосегийн хууль илүү гүнзгий сүнслэг үнэнүүдийн тухай израилчуудад өдөр тутмын амьдралд нь бодит, гадна талын сануулагчдаар хангах зорилготой байсныг сана.

Левит 13–14

Уяман өвчин

Левит 13–14 нь уяман өвчний тухай өгүүлдэг. Эдгээр бүлгүүд дэх дүрслэлүүдээс үзвэл уяман өвчин нь арьсны халдварт нилээд хэдэн өөр өвчнийг багтаадаг байсан бололтой. Дэлгэрэнгүй мэдээллийг Судруудын Удирдамж дахь “Уяман өвчин” –өөс үз.

Судруудыг судлах нь

А Уяман өвчнөөс цэвэршихийг бид нүглүүдээсээ цэвэршихтэй харьцуул

Уяман өвчин нь нүдэнд ил харагддаг бөгөөд биеийг ялзруулах буюу илжрүүлэх үйлчилгээтэй учир энэ нь нүглийн онцгой тохиромжтой бэлэгдэл болдог байжээ. Уяман өвчин хүний биеийг ялзруулдаг шиг, нүгэл нь хүнийг сүнсний хувьд ялзруулдаг. Левит 14 нь уяман өвчнөөс эдгэрсний дараа хүн шашин шүтлэгийн зан үйлийн хувьд цэвэр байхын тулд юу хийх ёстойг дүрсэлдэг. Уяман өвчнөөс цэвэрших үйл явц, түүнчлэн бид нүглийн үр дагавруудыг хэрхэн даван туулахын хоорондох ижил болон ялгаатай талуудыг бид харж болно.

Та нар Левит 14-ийг судлахаасаа өмнө, хүн уяман өвчнөөр өвчилсөн үед тэрээр нийтийн байрнаас гадна амьдрах шаардлагатай байсныг мэдэх хэрэгтэй. Нүглийн хувьд ч мөн ийм юм. Бид нүгэл үйлдсэн үедээ Их Эзэн болон түүний Сүмтэй бүрэн харилцаатай байхаас таслагддаг. Жишээ нь, ариун ёслолоос хүртэхийг, эсвэл ариун сүмийн зөвшөөрлийн бичиг хүлээн авахыг бидэнд зөвшөөрөхгүй байж болно.

Уяман өвчнөөс цэвэрших ёслолын шинжтэй алхмууд дараах бүлэг шүлгүүдэд байдаг. Левит 14-өөс бүлэг шүлэг тус бүрийг уншиж, алхам бүрийг хураангуйлан дүгнэж, эдгээр алхмууд нүглийн болон наманчлалын үйл явцыг хэрхэн заадгийг тайлбарла. Бүлэг шүлэг бүрээс та нар өөрсдийн бодол санааг төвлөрүүлэхэд өөрсдөдөө туслах асуултыг олох болно.

1. Шүлэг 2–3. Хэрэв уяман өвчин нүглийг бэлэгддэг бол хэн санваартныг төлөөлдөг вэ?
2. Шүлэг 4–8. (а) Хуш мод бусад зүйлүүдийг илжрэл буюу ялзралаас хамгаалахад тусалдаг зүйл гэдгийг; (б) час улаан өнгө нь амьдрал хийгээд Цагаатгалын бэлэгдэл болох цусыг бидэнд санагдуулдаг; (в) Хуучин Гэрээнд хэрэглэгддэг хиссоп нь ариутгагч ургамал гэдгийг; мөн (г) цус болон ус нь төрөлтийн бэлэгдэл гэдгийг та нар мэдэх хэрэгтэй (Мосе 6:59-ийг үз). Энэ мэдээллийг авч үзээд, эдгээр шүлгүүдэд бэлэгдэл болсон зүйл нь юу гэж та нар бодож байна?
3. Шүлэг 9. Сая төрсөн хүүхдүүд ихэвчлэн толгойноосоо өөр газар маш бага үстэй буюу үсгүй байдаг. Энэ шүлгийн захиас юу байж болох вэ? (3 Нифай 11:37-г үз).
4. Шүлэг 10–14. Египетээс Гарсан нь 28–29 дэх үүнтэй төстэй бэлэгдлийг эргэн сана. Уг бэлэгдэл энд хэрхэн холбогдож болох вэ?
5. Шүлэг 15–18. Чидуны мод бол амар амгалангийн хийгээд цэвэр ариуны бэлэгдэл бөгөөд чидуны тос нь Ариун Сүнсний, түүнчлэн зөв шударга үйлсийн хийгээд үйлчлэлийн үйл ажиллагааны бэлэгдэл болжээ (С ба Г 45:56–57-г үз). Энэ нь нүглээс цэвэршигдэх үйл явцын хэсэг хэрхэн болдог вэ? (2 Нифай 31:17-г үз).
6. Шүлэг 19–20. Чухамдаа, наманчлахыг юу боломжтой болгодог вэ?

Левит 15–16

Цагаатгалын өдөр

Золиослолоор, эсвэл цэвэр ариуны тухай түүний хуулиудад дуулгавартай байснаар дамжуулан, хувь хүмүүс Бурханы өмнө хэрхэн “зөв” болдог тухай, тэрчлэн ёслолын хувьд хэрхэн “цэвэр” болдог тухай Левитийн эхний арвантаван бүлэгт бүгдэд нь ямар нэг зүйл байдаг. Левит 15 нь Мосегийн хуулийн дагуу хүмүүний үйл ажиллагаа хэрхэн цэвэр буюу бузар байхад холбогддог тухай цаашидын заавруудыг агуулдаг. Гэвч чин сэтгэлийн наманчлал, Христийн Цагаатгалгүйгээр нүглүүдийн жинхэнэ уучлал гэж байхгүйг бид ухамсарлан ойлгох ёстой. Левит 16 нь Есүс Христ хэрхэн бүх хүмүүсийн нүглийн төлөө цагаатгал хийхийг бэлэгдсэн, жилд нэг удаа онцгой цаг үеэр гүйцэтгэж байхыг Их Эзэн израилчуудад зарлигласан ариун ёслолыг дүрсэлдэг. Левит 1–15-д дүрслэгдсэн ёслолуудыг хувь хүмүүс хийлгэдэг байсан бол, Левит 16-д дүрслэгдсэн Цагаатгалын өдөр нь бүх израил үндэстний нүглүүдийн төлөөх Цагаатгалыг бэлэгддэг бөгөөд Израилын угсаа бүхлээрээ мацаг барьж, амардаг өдөр байжээ.

Судруудыг ойлгох нь

Левит 16:10—Нүглийг үүрэх ямаа

Нүглийг үүрэх ямаа гэдэг нь өөр дээрээ цус буюу хүмүүсийн нүглүүдийг авч хэзээ ч эргэж ирэхгүйгээр цөл уруу “зугтсан” ямаанд өгсөн нэр ажээ. Нүглийг үүрэх ямаа нь Цагаатгалаар дамжин Израилын бүх нүгэл өршөөгдөж, дахин хэзээ ч ирэхгүйг бэлэгддэг байв.

Судруудыг судлах нь

А Ариун хийгээд чухал ёслол

Левит 16:3–28 нь Цагаатгалын өдрийн талаар санваартнуудад зориулсан заавруудыг агуулдаг. Дараах тойм нь уг ёслолд багтдаг зургаан ерөнхий алхмыг агуулдаг. Алхам бүрийн тухай асуултуудад хариулт бич.

1. Шүлэг 4-т Их Эзэн Аароноос хийхийг хүссэн зүйл юуг бэлэгддэг вэ? (ш. 3–5-ыг үз). (Санамж: “Маалинга” гэж юу болохыг мэддэг байхад анхаар.)
2. Ааронд яагаад хоёр ямаа хэрэгтэй байсан бэ? (ш. 6–10-ыг үз).
3. Хүмүүсийн төлөө цагаатгал хийхээс өмнө яагаад өөрийнхөө төлөө цагаатгал хийх нь Ааронд хэрэгтэй байсан гэж та нар бодож байна? (ш. 11–14). Энэ алхам Христ Өөрийн Цагаатгалыг гүйцэтгэсэн үеэс ямар ялгаатай байсан бэ? (Еврей 9:6–14; Алма 34:8–12-ыг үз).
5. Ариун сүмийн ариун газрыг цэвэршүүлэх нь Ааронд яагаад хэрэгтэй байсан бэ? Энэ шаардлага Бурханы мэлмийд цэвэр ариун байх шаардлага болон Цагаатгалын хүчний тухай та нар юу заадаг вэ? (ш. 15–19-ийг үз).

6. Ямаанууд *аль аль нь* (тахилд ашиглагддаг болон нүгэл үүрдэг) Христ болон түүний Цагаатгалыг хэрхэн төлөөлдөг вэ? (ш. 20–22-ыг үз).
7. Аароны үүргүүд, нүгэл үүрэх ямааг цөл уруу авч явдаг хүний үүргүүд юуг бэлэгддэг вэ? (ш. 20–22; мөн С ба Г 36:5–6-г үз).

Левит 17–18

Хиймэл шүтээний зуршлаас зайлхий

Левит 17–18 нь тэдний цаг үед тэднийг хуурамч шашинуудаас тодорхойгоор тусгаарладаг байсан зурилчуудын тухай израилчуудад өгсөн Их Эзэний заавруудыг цэдэглэдэг.

Левит 17 нь израилчууд мал нядлах тухайд юу хийх тухай заавруудыг агуулдаг. Малыг тахил болгон өргөхгүй байлаа ч гэсэн, израилчууд үүнийг асарт Их Эзэн байгаагаар төлөөлүүлэн боддог байжээ. Энэ зуршил нь хуурамч бурхдад тахил өргөхөөс сэрэмжлүүлж, тэд бүгдээрээ Их Эзэнээс ирснийг санахад нь израилчуудад тусалдаг байв. Левит 17-д бас цус идэхгүй байхыг Их Эзэн израилчуудад зарлигласан байдаг. Цус бол амьдралын нийтлэг бэлэгдэл бөгөөд тэр үеийн зарим хуурмаг шашинууд цус уухыг шашиныхаа ёслолуудын хэсэг болгосон байжээ. Итгэгчид энэ зуршилаар насаа уртасгахыг эрэлхийлдэг байж. Есүс Христийн аугаа золиослогыг, тэрчлэн түүний нэрэнд итгэж, түүний зарлигуудыг дагадаг бүх хүмүүст мөнх амьдралыг өгөхийн тулд энэхүү золиослолд түүний цус урсах болно гэдгийг бэлэгдсэн янз бүрийн золиослолуудыг Их Эзэн израилчуудад өгсөн билээ (Левит 17:11-ийг үз).

Левит 18 нь бэлгийн харилцааны ёс суртахуунгүй зан авир үндэстнүүдийг сүйрэлд хүргэхийг, хэрэв тэд эдгээр зурилчуудад оролцох юм бол израилчууд устгагдах болно хэмээн израилчуудад өгсөн Их Эзэний сэрэмжлүүлгийг агуулдаг.

Левит 19–20

“Ариун байгтун, учир нь би ариун билээ”

Левит 19–20 цэвэр ариун байхад Их Эзэн анхаарал төвлөрүүлдгийг цэдэглэдэг. Ариуныг тэмдэглэдэг еврей “гадаш” нь ариусгагдах, ариулан адислагдах, онцгойлон адислагдах эсвэл дэлхий болоод дэлхийн шинж байдлаас тусгаарлагдах гэсэн утгатай аж. Их Эзэн зөвхөн ариун байхыг зарлигласан төдийгүй, бас тэд энэ зарлигийг дагахын тулд өдөр тутмын амьдралдаа хийж болох зүйлүүдийн тодорхой жишээнүүдийг тэрээр энэ хоёр бүлэгт өгчээ. Эдгээр зуршил тус бүр нь өөрсдийгөө дэлхийгээс, үүний бурханлиг

бус зурилчуудаас тусгаарлахыг израилчуудад сануулахад тусалдаг байв. Ариун байдлын цаадах үндсэн зарчмыг Есүс, тэднийг дэлхийгээс авахгүй боловч хилэнцээс хол байлгах болно хэмээн Өөрийн төлөөлөгчдөд заах үед хожим нь тайлбарласан юм (Иохан 17:14–16-г үз).

Та нар уншихдаа, Их Эзэний өгсөн зарлиг бүрийн цаадах зарчмыг тогтоо. Бид “дэлхийнх байхгүйг” хичээхдээ өнөөдөр ямар арга замуудаар эдгээр зарчмуудаар амьдралыг тэрээр биднээс хүсдэг вэ?

Судруудыг ойлгох нь

Левит 19–20

Эзэмшигдсэн (ш. 20)—Мөнгө төлж, түүнийг чөлөөт болгосон

Цээрлэгдсэн (ш. 23)—Ариун бус

Мэргэ төлөг, ид шид (ш. 26)—Хүний хувь заяаг урьдаас хэлэх төрөл бүрийн хэлбэр

Толгойнхоо хажуугийн санчгийг бүү тойруулан хус (ш. 27)—Хуурамч шашин шүтэгчдийн хэрэглэ-

дэг байсан үс засалтын хэлбэрийг хэлжээ

Бөө (ш. 31)—Нас барагсдын сүнстэй өөрсдийгөө харилцдаг гэж мэдэгддэг хүмүүс

Сүнс дуудагчид (ш. 31)—Нас барагсдын сүнсийг эргүүлж дууддаг гэх хүмүүс

Эфа, хин (ш. 36)—Хэмжүүрийн нэгжүүд (Судруудын Удирдамж “Жин, хэмжүүрүүд”-ийг үз)

Судруудыг судлах нь

А Зарчмыг ол

Хэрэв та нар Левит 19 дэх зарлиг бүрийн ар дахь зарчмыг авч үзэх юм бол, энэ бүлэг дэх бараг зарлиг бүр өнөөдөр ХҮГ-д амьдралдаа хэрэгжүүлж болохоор юм. Зарим нь илт тодорхой (ш. 11–12-г байгаа шиг) харин бусад нь бидэнд хачирхалтай мэт санагддаг. Левит 19 дэх зарлигуудаас тэр үеийн хүмүүст тусгайлан хандсан хоёр зарлигийг сонго. Зарлигуудын ар дахь зарчмуудыг тогтоож, тэдгээрийг манай өнөө үед тохируулан дахиж бич. Жишээ нь, шүлэг 19-д хоёр өөр ургамалтай талбайтай буюу эсвэл хоёр өөр төрлийн утас орсон хувцастай байх ёсгүйг Их Эзэн хэлсэн байдаг. Эдгээр зарлигуудаар дамжуулан, тэд дэлхийтэй холилдон, хутгалдаж болохгүй, харин ариун хэвээр үлдэхийг Израилд сануулжээ. Өнөөдөр бид энэ зарчмыг болзох буюу гэрлэх зарчимд холбогдуулан хэрэглэж болно. Бид Сүмийн гишүүдтэй болзож, гэрээний хүрээнд гэрлэх ёстой.

Б Төгс Эзэмших Судар—Левит 19:18

Матай 22:35–39 дэх Есүсийн зарлигийг унш. Энэ зарлигийн ач холбогдлын талаар Их Эзэн Левитэд юу гэж хэлсэн бэ?

Левит 21–22

Санваарын ариун байдал

Левит 21–22 нь санваартнууд, тэдний гэр бүлүүд, тэрчлэн тэдний өргөдөг золиослолуудын талаарх зарлигуудыг агуулдаг. Өнөөдөр бас номлолд болон эрх мэдлийн албан тушаалуудад үйлчилдэг хүмүүст зориулсан тусгай жишгүүд, мөн манай ёслолууд гүйцэтгэгдэх арга хэлбэрийн жишгүүд бидэнд байдаг.

Левит 23–25

Ариун өдрүүд ба үйл явдлууд

Левит 23 нь Израил ариун байж, түүнд улам ойртохын тулд Израил онцгой хүч чармайлт гаргах таван ариун үеийг Их Эзэн хэрхэн бий болгосон тухай өгүүлдэг. Эдгээр үеүд нь Хүндэтгэлийн өдрөөр (ш. 1–3-ыг үз); Исгээгүй талхны баяр буюу Дээгүүр Өнгөрөх Баяр (ш. 4–14-ийг үз); Долоо хоногуудын баяр буюу Пентекост (Төлөөлөгчид дээр Ариун Сүнс бууж ирсний баяр)-ын үеэр (ш. 15–23-ыг үз); Цагаатгалын өдрийн үеэр (ш. 26–32); түүнчлэн Асруудын баярын үеэр (ш. 33–44-ийг үз) байжээ.

Левит 25 нь уг сэдвээр бүлэг 23-т илчлэгдсэн ажээ. Левит 25-д израилчууд долоо дахь өдөр бүр Хүндэтгэлийн өдөртэй байх төдийгүй, бас долоо дахь жил бүрийг хүндэтгэлийн жил болгон тунхаглахыг Их Эзэн тэдэнд зарлигласныг бид уншдаг. Хүндэтгэлийн энэ жил тэд тариа тарьдаггүй, газрыг амраадаг байж. Түүнээс гадна, долоон долоо дахь жилийн дараа (дөчин есөн жил), тавь дахь жил нь Хүндэтгэлийн онцгой жил байсан бөгөөд ойн баярын жил гэж нэрлэгддэг байв. Ойн баярын жилд израилчууд зөвхөн тариа тарьж, ургац хураадаггүй байсан төдийгүй, бас тэд бүх өр ширийг уучилж, бүх боолчуудыг чөлөөлөх ёстой байжээ. Ойн баяр нь Бурхан тэдэнд нигүүлсэнгүй байдаг учир, тэд ч бас бусдад хийгээд газарт нигүүлсэнгүй байх ёстойг Израилд сануулахад тусалдаг байв.

Левит 24 нь лааны тавиур болон оршихуйн талхны ширээг асарт ашиглах зарим заавруудыг агуулдаг. Бүлэг 24 дараа нь, Израилын хүүхдүүдэд Бурханы өгсөн зарлигуудад Бурханы нэрийг гутаан доромжлох нь онцгойлон хориглогдсон учраас Бурханы нэрийг гутаан доромжилж, улмаар үхэлд хүргэгдсэн нэг хувь хүний тухай түүхийг

өгүүлдэг. Түүний шийтгэлийн тухай тайлбарын хэсэг нь “нүдийг нүдээр, шүдийг шүдээр” гэдэг алдарт хэлцүгийг багтаадаг (ш. 20).

Левит 26–27

Адислалууд эсвэл зүхлүүд

Шашны цэвэр ариун байдлын талаар тэрээр израилчуудаас юу хүсэн хүлээдгийг Их Эзэн тайлбарлаад, эдгээр зарлигуудыг дагах буюу дагахгүй байхын үр дагавруудын тухай тайлбараар Левитийн Номыг төгсгөжээ (Левит 26-г үз). Өөрийгөө Их Эзэний үйлчлэлд бүрэн зориулах талаар дүгнэлтийн зарим зөвлөгөөг Их Эзэн бас өгчээ.

Судруудыг судлах нь

А Сонголтууд ба үр дагавруудыг олж тогтоо

Цаасан дээр доорхтой адил хоёр баганатай схем хий. Нэг баганыг “Хэрэв” нөгөөг “Тэгвэл” гэж нэрлэ.

Хэрэв	Тэгвэл
Израилчуудын хийж болох байсан сонголтууд	Тэдгээр сонголтуудын үр дагаврууд

1. Левит 26-г уншихдаа, хэрэв гэдэг үгийг ол. Та нар үүнийг судрууддаа тэмдэглэх буюу дугуйлж болно. “Хэрэв” багананд Израил хийж болно хэмээн Их Эзэний хэлсэн зүйлүүдийг бич.
2. Анхны алхмаар өөрийн олсон Хэрэв гэдэг үгсийн дараа ойрхон байгаа Тэгвэл гэсэн үгсийг ол. Үүнийг судрууддаа тэмдэглэх буюу дугуйл.

“Тэгвэл” багананд хэрэв Израил зарим сонголтууд хийвэл юу тохиолдох болно гэж Их Эзэн хэлснийг жагсаан бич. Бүлгийг дуустал үргэлжлүүлж, илүү олон “хэрэв-тэгвэл” холбоосуудыг ол.

Цөлд хэрэн бэдэрсэн нь



Тооллогын ном нь үүнийг грек хэлэнд орчуулахад ингэж нэрлэгдсэн аж, учир нь Мосе Израилын хүмүүсийг “дугаарлах” буюу тоолоход тохиосон хоёр үйл явдлын шастирыг агуулдаг (Тооллого 1–4; 26-ыг үз). Зарим еврейчүүд

үүнийг *Вяидаббар* (Еврейн номон дахь анхны үг) гэж нэрлэдэг нь “Мөн Тэр ярьсан” гэсэн утгатай аж. Тооллого нь Мосед айлдсан Бурханы 150 шастирыг агуулдаг учир энэ нэр оносон мэт санагдана. Энэ ном еврей хэлэнд *Бемидбар* хэмээн нийтлэгээр нэрлэгддэг нь “Цөлд” гэсэн утгатай бөгөөд энэ нь бараг л уг номыг бүхэлд нь дүрсэлдэг. “Тооллого” гэдэг нэр хэдийгээр нилээд энгийн сонсогддог ч гэсэн, энэ ном Синайн цөлд дөчин жил хэрэн бэдэрсэн Израилын тухай нэн чухал, сүнслэгээр нөлөөлөгдсөн түүхүүдийг агуулдаг.

Тооллогын Номыг уншихад бэлтгэх нь

Тооллого нь бүр Мосегийн хамгийн ойр дотнын хүрээлэл хийгээд гэр бүлийнх нь гишүүдийн дүргүйцэл, гомдол, эсэргүүцлийн тухай нилээд хэдэн түүхийг агуулдаг. Израилын хүүхдүүд Египетийг орхин гарснаас хойш жил орчмын дараа өөрсдийн амлагдсан нутагт орох боломжийг Их Эзэн тэдэнд олгосон боловч тэд айж, дургүйцэж, эсэргүүцсэн учраас уг боломжийг алдсан юм. Та нар уншихдаа, Израилын хүүхдүүдийн адил бидэнд өнөөдөр бошиглогч байдгийг анхаарч үзэх ёстой. Түүний зөвлөгөөг бид хэрхэн хүлээн авдаг вэ? Бошиглогчийн зөвлөгөөг дагах буюу дагахгүй байхын үр дагаврууд юу вэ?

Тооллогын Номыг гурван хэсэгт хувааж болно: (1) Синайг орхисон нь (бүлэг 1–10-ыг үз), (2) цөлд аялсан нь (бүлэг 11–21-ийг үз), (3) амлагдсан нутагт орохоор бэлтгэсэн нь (бүлэг 22–36-г үз).


Тооллого 1–4

Хүн амын тооллого

Тооллого 1–4 Израил овгоор болон гэр бүлээр хэрхэн тоологдсон тухай өгүүлдэг. Ууган хүүгийн эрхийн улмаас Иосефын овог хоёр дахин их өв хүлээн авчээ. Энэхүү хоёр дахин их өв нь Иосефын хоёр хүү Ефраим Манассе хоёрын дунд хуваагдсан аж. Үүний үр дүнд энэ хоёр хүүд Израил дахь тусгаар овгийн статус олгосноор Израил дахь арван гурван овгийг авсан ажээ (Эхлэл 48:5-ыг үз). Левийн овог

нь санваарыг эзэмшиж, Мосегийн хуулийн дагуу ёслолмудыг гүйцэтгэх тусгай дуудлагатай байв. Энэ дуудлагын улмаас тэд бусад бүх овгийн дотор амьдарч байсан учир дээрхийн адилаар тоологдоогүй ажээ. Левичүүдийг нэмээд Израил ерөнхийдөө арванхоёр овогтой гэж тооцогддог байв. Тооллого 1–2 нь арванхоёр овог тоологдож, аяны болоод хуарангийн бүлгүүдэд зохион байгуулагдсан тухай өгүүлдэг. Тооллого 3–4 нь левичүүд хэрхэн тоологдож, ажил үүрэг нь тэдэнд хэрхэн өгөгдсөнийг өгүүлдэг.

Тооллого 3–4 нь бас Израилын хүүхдүүдийн бүх ууганууд нь Их Эзэнд харьяалагддагийг тайлбарладаг, учир нь гэвэл Египетэд арав дахь тахлын үеэр тэд хаалганы тотгон дээр цус түрхэх үед тэд гагцхүү Их Эзэний нигүүлслээр дамжин аврагдсан билээ (Египетээс Гарсан нь 12–13-ыг үз). Гэвч гэр бүлийн ууган төрсөн нь түүнд бүрэн цагаар үйлчлэхийн оронд, тэрээр левичүүдийг тэдний оронд үйлчлүүлэх болгосноо Их Эзэн тайлбарлажээ. Тэдний оронд левичүүд үйлчлэх болсныг тэд хүлээн зөвшөөрснөө харуулахын тулд бусад арванхоёр овгийн ууган хүү бүр асар дахь левичүүдийн ажлыг дэмжихийн тулд жил бүр тодорхой тооны мөнгө төвлөх ёстой байв. Үүнийг “золиосны мөнгө” гэж нэрлэдэг байжээ (Тооллого 3:44–51-ийг үз).



Судруудыг судлах нь

А Энэ нь та байж болно

Тооллого 3:12–13; 4:40–41-ийг, түүнчлэн Тооллого 1–4 дэх Израилын ууган төрөгсдийн талаарх тайлбарыг уншиж, Израил дахь ууган төрөгсдийн талаар Их Эзэн юу хэлснийг мэд. Дараа нь 2 Нифай 9:6–9-ийг уншиж, бид Израилын ууган төрөгсөдтэй хэрхэн харьцуулагдаж болохыг тайлбарла. Өөрөөр хэлбэл, Христийн Цагаатгал байгаагүй бол бидэнд юу тохиолдох байсан бэ? (мөн 1 Коринт 6:19–20; 1 Петр 1:18–19-ийг үз).

Б Та нар юу хийх ёстой вэ?

Та нар А үйл ажиллагаанд мэдсэн зүйлээ авч үзэн, бид өөрсдийн эн тэргүүнд эрхэмлэдэг зүйлүүдээр хэнд нөлөөлөх ёстойгоо яаж мэдэх вэ? “Золиослолын мөнгөтэй” харьцуулж болох юу хийхийг Их Эзэн биднээс хүсдэг вэ?

Тооллого 5–8

Мосегийн хууль дээрх нэмэлтүүд

Тооллого 5–6 нь өвчин (5:1–4-ийг үз), наманчлал (5:5–10-ыг үз), эр хүн эхнэр нь түүнд итгэлгүй байна гэж бодсон үед яах ёстой талаар (5:11–31-ийг үз), Их Эзэнд үйлчилсэнд нь тусгай хүндэтгэл үзүүлэх ёстой хүмүүсийн талаар (Назирчууд; 6:1–21-ийг үз), түүнчлэн санваартнууд хүмүүс дээр дуудах ёстой адислалын талаар (6:22–27-г үз) Их Эзэний өгсөн нэмэлт заавруудыг агуулдаг. Тооллого 7–8-д бид асрыг онцгойлон адислах үед хийгдсэн өргөлүүдийн талаар, тэрчлэн санваарын тусгай дуудлагуудаа гүйцэтгэхэд нь левичүүдийг онцгойлон адисалсан тухай уншидаг.

Энэ судлах удирдамж нь Назирын хуулиудыг дүрсэлсэн Тооллого 6-д онцгой анхаарал хандуулсан байдаг. Еврей хэлэнд назир гэдэг үг “ариулан адислагдсан буюу зориулагдсан хүн” гэсэн утгатай. Тийнхүү, хүмүүс өөрсдийгөө аль нэг онцгой замаар Их Эзэнд зориулах буюу эсвэл эцэг эхчүүд нь тэднийг Их Эзэнд зориулан өгсөн бол тэд “назирчууд” гэж нэрлэгддэг байжээ.

Судруудыг ойлгох нь

Тооллого 6:22–27—Израилд удирдагчдаас нь ирдэг адислал

Их Эзэний тослогдогсод бүх цугларагсад буюу Сүмд бүхэлд нь адислалуудыг олонтаа санал болгосоор байдаг. Жишээ нь, гурван өөр Ерөнхийлөгч Сүмийн ерөнхий чуулган дээр өгсөн дараах адислалуудыг авч үз:

“Эдүгээ, надад оногдсон ариун санваарын эрх мэдлээр миний бие Хожмын үеийн Гэгээнтнүүд болон газар газрын сайн хүмүүс дээр адислалыг хүсэмжлэн гуйж байна.

“Христ болон Христийг эсэргүүцэгчдийн хооронд шүүхэд тань ялган таних өндөр чадвараар би та нарыг адисалж байна. Сайныг үйлдэх, хилэнцийг эсэргүүцэх өсөн нэмэгдсэн хүчээр би та нарыг адисалж байна. Мормоны Номыг ойлгох өсөн нэмэгдсэн *ойлголтоор*” би та нарыг адисалж байна. (Езра Тафт Бенсон, in Conference Report, 1986 оны 4-р сар, 100; *Ensign*, 1986 оны 5-р сар, 78).

“Мөн эдүгээ, хайрт ах эгч нар минь, надад оногдсон санваарын хүч, эрх мэдлээр, түүнчлэн эдүгээ өөрийн гүйцэтгэдэг дуудлагын ариун журмаар дамжуулан би та нарын дээр өөрсдийн адислалуудыг хүсэмжлэн дуудаж байна. Христийнхтэй илүү адилхан амьдралаар амьдрах хүч чармайлтад тань би та нарыг адисалж байна. Ариун сүмийн зөвшөөрлийн бичиг хүлээн авахуйц зохистой байж, нөхцөл байдал боломж олгохын хэрээр ариун сүмд аль болох олон удаа очиж байх өсөн нэмэгдсэн хүсэл эрмэлзлээр би та нарыг адисалж байна. Гэр орондоо бидний Тэнгэрлэг Эцэгийн амар амгаланг хүлээн авч, гэр бүлүүддээ Их Эзэнийг дагахын тулд гэр бүлүүддээ заахад удирдагддаг байхын төлөө би та нарыг адисалж байна” (Ховард В.Хантер, in Conference Report, 1994 оны 10-р сар, 119; *Ensign*, 1994 оны 11-р сар, 88).

“Бид та нар дээр адислалыг, бүр төлөөлөгчийн адислалыг үлдээж байна. Их Эзэн та нар дээр ивээл таашаалаар инээмсэглэхийн төлөө, гэр орон, амьдрал ахуйд тань аз жаргал, амар амгалан байхын төлөө, эхнэр нөхрүүд, хүүхдүүд, эцэг эхчүүдийн хооронд хайр, хүндэтгэлийн уур амьсгал мэдрэгдэж байхын төлөө бид та нарыг адисалж байна. Та бүгд аз жаргалаар, аюулгүй байдлаар, амар амгалангаар, итгэл бишрэлээр Бурхан өөд харж, амьдрах болтугай (Алма 37:47)” (Гордон Б.Хинкли, in Conference Report, 1995 оны 4-р сар, 118; *Ensign*, 1995 оны 5-р сар, 88).

Судруудыг судлах нь

Тооллого 6-г судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А–Г) хоёрыг хий.

А Зарлал бич

Хүмүүсийг назирчууд болгон элсүүлэх дуураймал зарлал бич. Таны зарлалд Назираас Их Эзэний хүсэн хүлээдэг, дор хаяж гурван зүйл орсон байх ёстой (Тооллого 6:3–7-г онцгой анхаар).

Б Хэн нэрд гарсан назирчууд байсан бэ?

Дараах судруудыг уншиж, назирчууд байсан гурван хүнийг нэрлэ: Шүүгчид 13:5, 24; 1 Самуел 1:11, 19–20, 28; Лук 1:13–15.

В Үүнийг өнөө үетэй холбо

Өнөөдөр Бурханд өөрсдийгөө зориулах талаар юу хийхийг биднээс хүсдэг нь дэлхий дэх бусад олон хүмүүсээс биднийг ямар ялгаатай болгодог вэ?

Г Өөрсдийнхөө удирдагчдаас ирдэг нэг адислалын тухай бод

Өмнөх “Судруудыг ойлгох нь” хэсгээс өөрсдийн хүлээж авахыг хүсдэг адислалуудаас нэгийг сонгож, яагаад гэдгийг тайлбарла. Энэ адислалыг хүлээж авахын тулд та нар юу хийх ёстой вэ?

Тооллого 9

Цөл дэх анхны Дээгүүр Өнгөрөх Баяр

Тооллого 9 нь Египетээс амлагдсан нутгийн зүг хийсэн израилчуудын аяны хоёр дахь жилийн эхлэлийг тэмдэглэдэг. Бүлэг 9 нь Израилын хүүхдүүд Их Эзэнд зориулагдсан хэвээр үлдэхийн тулд юу хийх ёстойг, тэрчлэн тэрээр тэдэнтэй хамт байгааг тэд хэрхэн мэдэж болох тухай өгүүлдэг. Бид түүнд зориулагдсанаа өнөөдөр Их Эзэнд хэрхэн харуулах вэ, тэрчлэн тэрээр бидэнтэй хамт байгаа гэдгээ бидэнд хэрхэн мэдэгддэг вэ?

Судруудыг ойлгох нь

Тооллого 9:6–14—Дээгүүр Өнгөрөх Баярт хэн оролцох ёстой вэ?

Хүүртэй харьцсан зарим хүмүүс, магадгүй зүгээр л нас барсан төрлөө оршуулсан хүмүүсийг Дээгүүр Өнгөрөх Баярт оролцохыг зөвшөөрдөггүй байсныг Тооллого 9-д ажиглах нь сонин юм. Мосегийн хуулийн дагуу, тэд “бузар” байдаг байсан аж. Гэвч, Дээгүүр Өнгөрөх Баяр их чухал учраас нас барсан хүний биед хүрснээс бузартсан хүмүүс ч гэсэн үүнд оролцох ёстойг Их Эзэн Мосед илчилсэн ажээ. Түүнээс гадна, Дээгүүр Өнгөрөх Баярын зоогт оролцохоос татгалзах нь бүрэн хэмжээгээр цэвэр ариун байх хийгээд үүнд тэнцсэн байхын тухайд бол маш ноцтой нүгэл мөн гэж Их Эзэн хэлжээ.

Дээгүүр Өнгөрөх Баярыг ариун ёслолоор орлуулахаар Аврагч санаачилсан учраас, бид өөрсдөө үүнд хэрхэн холбогдохыг авч үзэж болно. Жишээ нь: Бид ариун ёслолын цуглаанд зохистойгоор оролцох боломж бүрийг ашиглах ёстой. Боломжтой атлаа, ариун ёслолын цуглаанд оролцохоос татгалзах нь нүгэл мөн. Бидний амьдралд хувийн зарим нэгэн сэв толбо байлаа ч гэсэн, Их Эзэн биднийг оролцохыг хүсдэг учраас ариун ёслолд оролцох нь маш чухал юм. Бид хэзээ ариун ёслолоос хүртэх ёстой. Хэзээ хүртэх ёсгүй талаар манай санваартны удирдагчид бидэнд зөвлөгөө өгч чадах бөгөөд энэ нь бүлэг 9-д гардаг зүйлийн цаадах зарчим юм.

Судруудыг судлах нь

А Үргэлж сана

Тооллого 9 нь Египетэд болсон Дээгүүр Өнгөрөх эхний Баярын тухай өгүүлдэг. Дараах түлхүүр үгс, нийлмэл үгсийг авч үзэн, эдгээр нь Дээгүүр Өнгөрөх Баярт хэрхэн холбогддогийг дүрсэл (Египетээс Гарсан нь 12-ыг судалснаа та нар эргэн харж болно):

1. Эхний сарын арвандөрөв дэх өдөр
2. Исгээгүй талх ба гашуун ургамал
3. Хугалаагүй яснууд

Б Их Эзэн тэднийг хэрхэн удирдсан бэ?

1. Их Эзэн Израилын хүүхдүүдийг удирдсан тухай Тооллого 9:15–23-г хэрхэн өгүүлснийг дүрсэл.
2. Ийм байдлаар цөл дундуур удирдагдсанаараа Израилын хүүхдүүд юу мэдсэн гэж та нар боддог вэ?
3. Өнөөдөр Их Эзэн өөрийн хүмүүсийг яаж удирддаг вэ?

Тооллого 10

Синайг орхисон нь



Тооллого 10 нь тэнд удаан байсны дараа Синайн Уулнаас анх хөдөлсний дараах Израилын буудлын тухай өгүүлдэг. Израилчууд явахдаа, Мосегийн хадам ахтай уулзаж, бид Бурхан уруу буцаж очих аяндаа бусдыг урьдаг шиг—түүнийг өөрсөдтэйгөө нэгдэхийг тэд урьсан ажээ.

Тооллого 10 нь бас тэдний аяллын үеэр Их Эзэний оридог газрыг төлөөлдөг асарт тэдний анхаарлыг төвлөрүүлдэг байсныг тайлбарладаг.

Тооллого 11

Дур хүсэлдээ хөтлөгдсөн израилчууд

Та нар Тооллого 11-ийг уншихдаа, дараах асуултууд израилчуудад хэрхэн холбогдохыг авч үз: Та өөр хүний төлөө сайн юм хийсэн байтал хариуд нь тэрээр гомдолловол та юу гэж бодох вэ? Хэрэв Их Эзэн өөрийн чинь хүссэн болгоныг, таны хүссэн зүйл өөрт чинь сайн уу, үгүй юу гэдгийг асуулгүйгээр өгвөл юу тохиолдох вэ?

Судруудыг ойлгох нь

Тооллого 11

Холилдсон хүмүүс (ш.4)— Израил бус хүмүүс

Кориандр (ш. 7)—Яншуйн төрлийн ургамал

Бделлиум (ш. 7)—Давирхай шиг зунгааралдсан бодис

Уур (ш. 8)—Аяга шиг босоо сав

Явган хүн (ш. 21)—Хориос дээш настай цэрэг байж чадах хүмүүс

Арван омер (ш. 32)— Ойролцоогоор 2,300 литр

Тооллого 11:29—Бүх хүмүүс бошиглогчид байхыг Мосе хүсэв

“Арванхоёрт мэдүүлээгүй ямар ч зүйлийг Бурхан Иосефт илчлээгүй юм, тэр ч байтугай хамгийн наад захын Гэгээнтэн хэр хурдан ойлгож буйгаасаа хамааран бүгдийг мэдэж авах болно” (Teachings of the Prophet Joseph Smith, түүвэрлэсэн, Иосеф Фиелдинг Смит [1976], 149).

Судруудыг судлах нь

Тооллого 11-ийг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А–Д) гурвыг хий.

А Өнөө үеийн зарим гомдол ба шүүмжлэл

Тооллого 11:1–9-д израилчуудын хийсэн зүйлийн талаар та өөрөөр боджээ гэж төсөөл. Тэр үед хүмүүс юу гэж хэлэх байсан гэсэн өөрийнхөө бодлыг тусган, Мосед гомдол мэдүүлсэн захидал бич.

Б Хариу бич

Тооллого 11:10–15-д Мосегийн хэлсэн зүйлийг, түүнчлэн өдий хол газар аялсан энэ аяллын тухай юу мэдсэнээ ашиглаж, хэрэв та тэдний удирдагч байсан бол израилчуудад юу гэж хариулах байснаа бич.

В Бид гомдоллосон үед юу тохиолддог вэ?

Тооллого 11:1–4; Иуда 1:14–16-г харж, Их Эзэн болон түүний үйлчлэгчдийн эсрэг гомдоллосон буюу дургүйцсэн хүмүүст эцэстээ юу тохиолддогийг ярь. Израилын хүүхдүүд Их Эзэн болон Мосегийн талаар гомдоллосноороо хэрэг дээрээ чухам тэд юу хийж байгаа тухай Тооллого 11:20-д Их Эзэн юу хэлснийг ажигла.

Г Чухал үгсийг ол

Далан хүн юу хийснийг, мөн яагаад тэд Мосегийн урам хугаралтын хариуд дуудагдсаныг дүрсэлсэн гэж өөрийн бодсон чухал гурван үг буюу хэлц үгийг ол.

Д Сургамж нь юу вэ?

Галат 5:16–17-г уншиж, эдгээр шүлгүүд Тооллого 11-ийн гол санааг хэрхэн илэрхийлж болохыг авч үз. *Шунахайрал* гэдэг үгийн утгыг, түүнчлэн, ийм нөхцөл байдлын хариуд Их Эзэн далан Ахлагчийн талаар юу хийсэн тухай бод.

Тооллого 12

Бошиглогчийг дэмжих буюу эсэргүүцэх нь

Их Эзэний Сүмийн талаарх гайхамшигтай зүйлүүдийн нэг нь эдгээрийг хүссэн зохистой бүх хүмүүст Сүнсний бэлгүүдийг боломжтой болгосон явдал мөн. Тооллого 11-д Их Эзэнийн Сүнс далан израил эрчүүд дээр ирж, тэгээд тэд бошиглосон үед энэхүү үнэн харагдсан билээ. Хүн эдгээр бэлгүүдийг хөгжүүлэх юм бол, Бурханы хаант улсад дэг журам байх болно. Тэрбээр хүмүүсийг тэргүүлүүлэхээр дуудаж, Сүмийг удирдахад хэрэгтэй тусгай сүнслэг нөлөөг тэдэнд өгдөг билээ. Сүнсний бэлгүүдтэй байх нь биднийг тэргүүлэхээр Бурханаар сонгогдсон санваартны удирдагчдад одоо бид халмаагүй гэсэн хэрэг биш юм.

Зарим гишүүд сүнсний бэлгүүд буюу мэдлэгийг хүлээж авсны дараа, өөрсдийгөө тэргүүлдэг хүмүүсээс өөрсдийгөө илүү дээр гэж үзэж эхэлдэг. Энэхүү бардам зан аль нэг удирдагчийг шүүмжилж, зөвлөгөөг нь дагах хүсэлгүй байхад олонтаа хөтөлдөг. Хэрэв шүүмжлэгч хүмүүс өөрсдийгөө даруусгаж, бодол санаагаа наманчлахгүй бол, удалгүй

тэд өөрсдийгөө Сүнснээс тусгаарлаж, улмаар урвалтын зам уруу хальтран орсноо мэдэх болно. Тооллого 12 нь зөвхөн бид өөрсдийн удирдагчдыг дэмжих зарчмыг заадаг төдийгүй, бүр илүү сайн мэдэх ёстой хүмүүс ч гэсэн энэхүү уруу таталтад унаж болохыг бас заадаг.

Судруудыг судлах нь

А Бошиглогчийг буюу Сүмийн бусад удирдагчдыг бид шүүмлэхэд бидэнд юу тохиолддог вэ?

1. Мириамд тохиолдсон зүйлүүд ямар сургамжийг бэлэгдэг гэж та нар бодож байна?
2. Мириадын шийтгэл Сургаал ба Гэрээ 1:14-т бидний уншдаг зүйлтэй хэрхэн холбогдох вэ?

Тооллого 13–14

Амлагдсан нутгийг тандан судалсан нь

Их Эзэний зарлигуудыг сахихад буюу амлагдсан адислалыг түүнээс хүлээн авахад танд тохиолдсон хамгийн хэцүү зүйл юу вэ? Та яагаад үүнийг хийгээгүй вэ? Хэрэв та хийгээгүй бол танд юу тохиолдож болох вэ?

Их Эзэн израилчуудыг Египетээс чөлөөлөх үед, Абрахам, Исаак, Иаков болон тэдний үр удамд үүрд амлагдсан нутаг байсан Канааны нутаг уруу тэднийг тэрээр удирдах болно хэмээн тэрээр хэлжээ. Олон гайхамшиг хийгээд цөл дэх хүнд хэцүү аяллын нэг жилийн дараа израилчууд эцэстээ энэхүү амлагдсан нутгийн хилийн дэргэд иржээ. Тооллого 13–14 нь уг нутаг ямархуу болохыг мөн тэнд ямар хүмүүс амьдардгийг тандаж мэдэхийн тулд овог бүрээс нэг, бүгд арванхоёр хүний тухай түүхийг өгүүлдэг. Бид бас хүмүүст хийсэн тэдний илтгэлийн тухай, бас ямар хүмүүс өөрсдийн сонссон зүйлийн талаар юу хийхээр шийдсэн тухай уншидаг.



Та нар Тооллого 13–14-ийг уншихдаа, дараах асуултыг өөрөөсөө асуу: Их Эзэнээс ирсэн нэн хэцүү мэт зүйлтэй учирсан үед би айдсаар, эсвэл итгэлээр хариу үйлдэл үзүүлэх үү? Хэрэв таны эргэн тойрон дахь олонх хүмүүс итгэлийг биш, айдсыг сонгож байвал, танд хэрхэн нөлөөлж болох вэ? (С ба Г 30:1–2-ыг үз). Таны хариулт та Их Эзэнд хэр зэрэг их итгэдгийг—зарлиг буюу амлалтыг тэрээр өглөө гэхэд бас үүнийг биелүүлэх аргыг нь ч бас танд бэлтгэн өгдөгт та хэр зэрэг их итгэдгийг харуулдаг (1 Нифай 3:7-г үз).

Судруудыг судлах нь

Тооллого 13–14-ийг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А–Г) хоёрыг хий.

А Ухуулга зохио

Иошуагийн буюу Калебын үзэл бодлын үүднээс, амлагдсан нутагт ороход нь израилчуудыг зоригжуулсан ухуулга зохио.

Б Израилчуудад итгүүл

1. Израилчуудын олонх нь амлагдсан нутагт орохыг хүсэхгүй байсан шалтгаануудыг нэрлэ.
2. Урагш хөдөлж, өөрсдөд нь амлагдсан нутагт орохыг израилчуудад ухуулахын тулд Эхлэл, Египетээс Гарсан нь, Левитээс буюу Тооллогын эхний хэсэгт өөрсдийн уншсан үйл явдлууд хийгээд заадаг зүйлүүдийг ашигла.

В Уг түүхэн дэх үйл явдлуудыг харьцуул

1. Туршуулуудын илтгэлд Израилын хүүхдүүдийн өгсөн хариултыг хураангуйлан бич (Тооллого 14:1–4-т байдаг).
2. Тооллого 14:28–33-ыг уншиж, Их Эзэн тэдний итгэлийн талаар хэлсэн зүйлийг Израилын хүүхдүүдийн хэлсэн зүйлтэй харьцуул.

Г “Бид үүнийг дангаараа хийж чадна”

Израилчууд юу хийхээр шийдсэн бэ, мөн тэд яагаад амжилт олоогүй вэ?

Тооллого 15

Уучлалыг олж авах нь

Израилчуудын ихэнх хэсэг нь итгэл дутмагаа харуулж (Тооллого 13–14-ийг үз), Их Эзэний эсрэг нүгэл үйлдсэний дараа, Тооллого 15 нь нүглүүдийн уучлалын төлөө зайлшгүй шаардлагатай золиослолын өргөлүүдийн тухай өгүүлдэг нь гайхмаар зүйл биш юм. Тооллого 15 нь “зориудаар” нүгэл үйлдэх буюу буруу юм хийж байна гэдгээ мэдсээр байж нүгэл үйлдэх тухай онцгойлон өгүүлдэг (Тооллого 14:44-ийг Тооллого 15:30–31-тэй харьцуул). Тооллого 15 нь зарлигуудыг сахихын ач холбогдлыг үргэлж санахад нь Израилд тусалж чадах нэг зарлигаар төгсдөг.

Тооллого 16

Бошиглогчийг эсэргүүцэх нь

Бошиглогчид бол бидний л нэгэн адил хүн бөгөөд ердөө л юмсын талаар өөрсдийнхөө санал бодлыг илэрхийлдэг гэж зарим хүмүүс боддог учраас тэд бошиглогчдын заадаг зүйлүүдийг үнэхээр дагах шаардлагагүй гэж боддог. Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн, Ахлагч Харольд Б. Лий, “Энэ Сүмийн удирдагчдыг шүүмжилдэг хүмүүс, хэрэв хязгаарлахгүй бол тэдэнд сүнсний үхлийг зайлшигүй авчрах сүнсний үхлийн шинж тэмдгүүдийг харуулдгийг миний олж авсан туршилага надад заадаг тухай би гэрчлэлээ хэлэхийг хүсэж байна” гэж хэлжээ (in Conference Report, 1947 оны 10-р сар, 67). Хэдэн жилийн дараа Ерөнхийлөгч Лий Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ерөнхийлөгч, Тэргүүн Зөвлөлийн гишүүн байхдаа, “Их Эзэн өөрийн сүмийг тэргүүлэхээр тавьсан хүмүүсийг бид дагах уу, үгүй юу гэдгээ таны болоод бидний аюулгүй байдал хамаарна” хэмээн хэлжээ (in Conference Report, 1970 оны 10-р сар, 153).

Биднийг тэргүүлэхээр Их Эзэний сонгосон хүмүүст Сүмийг чиглүүлэх, тэрчлэн биднийг зөв шударга ёсонд чиглүүлэхэд илчлэлт хүлээн авах ариун түлхүүрүүд өгөгдсөн байдаг. Бид өөрсдийн удирдагчдад хэрхэн харцуудаг нь Тэнгэрлэг Эцэгийн төлөөх бидний санаа бодол хийгээд Түүнд итгэх бидний итгэлийг тусган харуулдаг. Сургаал ба Гэрээ 1:14; 121:16–17; 124:45–46-д Их Эзэн хожмын үеийн Израилд юу гэж хэлснийг унш. Тооллого 16 эдгээр мэдэгдлүүдийн үнэнийг хэрхэн эмгэнэлтэйгээр харуулсныг эрж ол.

Судруудыг ойлгох нь

Тооллого 16

Бойпорууд (ш. 6, 17–18, 37–39)—Утлага уугиулах савнууд

Тусгаарласан (ш. 9)—Сонгогдсон

Басамжилсан (ш. 30)—Уурлуулсан

Судруудыг судлах нь

А Түүхийг өөрийнхөө үгээр ярь

1. Тооллого 16 дахь түүхийг өөрийнхөө үгээр бич.
2. Энэ түүх хэрхэн энэ бүлгийн оршил дахь Ерөнхийлөгч Харольд Б.Лийгийн мэдэгдлийн жишээ болохыг тайлбарла.

Тооллого 17–19

Эмгэнэлт явдлын үр дагаврууд

Та нар уншихдаа, Тооллого 16-д болсон үйл явдлуудын тухай бодох юм бол Тооллого 17–19-ийг илүү бүрэн дүүрэн ойлгох боломжтой байх болно. Бүлэг 16 дахь бодитой асуудал бол, тэр үед санваартнууд байсан Аарон болон

түүний хөвгүүд л гүйцэтгэхээр үүрэг хүлээсэн санваарын зарим ёслолуудыг өөрсдөө гүйцэтгэх боломжтой гэж хэсэг хүмүүс бодож байсан явдал мөн. Уг эсэргүүцэл тэдгээр эсэргүүцэгчдийн үхэлд нөлөөлсөн ажээ. Эсэргүүцэгчдийг дагасан олон хүн бас үхжээ.

Ноцтой нүглийн үр дагавар болсон үхлийн шийтгэл нь ноцтой, удаан үргэлжилсэн нүглийг бүрэн наманчлах нь маш хэцүү учраас энэ нь сүнсний үхэлд хүргэж болно гэдгийг эртний Израил, түүнчлэн бидэнд заадаг Их Эзэний арга зам юм гэдгийг ажигла.

Тооллого 17 нь Бурхан Аароныг сонгож, тэр үеийн санваарын ёслолуудыг гүйцэтгэх эрх мэдлийг түүнд олгосныг тэд мэдэж болохын тулд тэсэн гарсан хүмүүсийг Их Эзэн хэрхэн гайхамигаар хангадаг тухай өгүүлдэг.

Тооллого 18 нь санваартны албан тушаалд томилогдсон, зөвхөн Аарон болон түүний хөвгүүдэд харьяалагддаг байсан нэмэлт үүргүүдийг дүрсэлдэг. Тооллого 18 нь бас бусад левичүүдэд харьяалагддаг үүргүүдийг дүрсэлж, Левийн санваарын албан тушаал болон санваарын бусад бүх үүргүүдийн хоорондох ялгааг харуулдаг.

Эцэст нь, Тооллого 19 нь Тооллого 16 дахь үйл явдлуудын дараа асуудал болж гарч ирсэн, цогцостой хэрхэн харьцах тухай дүрмүүд, мөн зарлигуудыг тайлбарладаг.

Тооллого 20

Цөхрөлийн гучин есөн жил

Тооллого 20 нь Тооллого 16 дахь эсэргүүцэгч үйл явдлын дараа ойролцоогоор гучин есөн жилд болсон үйл явдлуудыг цэдэглэдэг. Эдгээр жилүүдэд юу болсныг түүнчлэн яагаад бидэнд тэр үеийн тухай цэдэг байдаггүйг бид мэдэхгүй. Тэр жилүүдэд юу ч өөрчлөгдөөгүй учраас юу ч цэдэглэгдээгүй байж магадгүй. Жишээ нь, Тооллого 20 нь яг гучин есөн жилийн тэртээ орхисон газраасаа Мосе болон Аароны эсрэг Израилын дургүйцлийн түүхээр эхэлдэг. Гэхдээ энэ удаад түүх бага зэрэг ялгаатай байсан бөгөөд хүмүүстэй хандахдаа дутуу дулимаг шийдвэр гаргасандаа Иосе Аарон хоёр харамсаж байгааг үзүүлжээ. Тэд дутуу дулимаг шийдвэр гаргасан учир Их Эзэн тэднийг шүүмжилж, Израилын хүүхдүүдийг амлагдсан нутаг уруу удирдах онцгой боломж тэдэнд байхгүй байх болно хэмээн тэдэнд хэлжээ.

Дэд Хууль 1:37; 3:25–28-ыг уншсанаар Мосе дуулгаваргүй байсныхаа улмаас шүүмжлэгдсэнийг бид мэддэг. Мосег шийтгэснээр, амлагдсан нутагт ороход хүн бүр, тэр ч байтугай (үүнийг онцгойлон авч үзсэн ч байж болох юм) бошиглогч ч гэсэн дуулгавартай байх шаардлагатайг Их Эзэн Израилын хүүхдүүдэд хүчтэйгээр заажээ. Хэрэв Мосе Их Эзэний зарлигуудаас зөрж, шийтгэлгүй үлдсэн бол, энэхүү хатуу сэтгэлт хүмүүс Мосе Их Эзэний зарлигуудаас зөрснийг харж, тэрээр шийтгэлгүй өнгөрлөө гэж хэлснээр өөрсдийнхөө нүглүүдийг хаацалж, дөвийлгөх болзошгүй байв. Их Эзэн Мосег ноцтойгоор

зэмлээгүйн нотолгоог бид бусад судруудад уншдаг бөгөөд тэрээр үхлийг үзэлгүйгээр тэнгэрт зөөгдөж, ирээдүйн үеийнхэнд санваарын түлхүүрүүдийг өгөхийн тулд маш чухал үйл явдлуудаар дэлхий дээр хүрч ирсэн билээ. (Лук 9:28–36; Алма 45:19; С ба Г 110:11-ийг үз).

Тооллого 20 нь бас Израил Едомын нутгаар дамжин энх тайвнаар өнгөрөх гэж оролдоод, эсэргүүцэлтэй тулгарсан тухай шастырыг агуулдаг. Едомын нутаг бол Есавын (Иаковын ах) үр удмынхны нутаг байв. Та нар израилчуудын явсан замыг харахын тулд Судруудын Удирдамжийн ар тал дахь газрын зураг 2-ыг харж болно.

Тооллого 20-ийн эхлэл нь Мосегийн эгч Мириамын үхлийн тухай өгүүлдэг; бүлгийн төгсгөл нь Мосегийн дүү Аарон нас барсан тухай, тэрчлэн Аароны хүү Елеазар дээд санваартан болсон тухай өгүүлдэг.

Тооллого 21

Гуулин могой

Тооллого 20 дахь Мириам, Аарон нарын нэгэн адил, цөлд гучин есөн жил оршин амьдарсан израилчуудаас олон нь нас барсан бололтой. Мөн, хориос дээш насны бүх хүмүүс (амлагдсан нутгийн талаар нааштай мэдээлэл өгсөн Хошеа Калев хоёроос бусад) Израилын буудал амлагдсан нутагт орохоос өмнө нас барах болно хэмээн Египетээс Гарсаны эхэн үед Их Эзэн хэлсэн ажээ. Тооллого 21 нь улам олон хүн нас барсан нэгэн явдлыг цэдэглэжээ. Энэ түүхэнд Христийн хэв шинж—гуулин могой гардаг учраас онцгой ач холбогдолтой юм. Израилчуудын бүхэл нэг үеийнхэн уг могойг хараагүй учир тэд биеийн хувьд мөн сүнсний хувьд үхсэн бөгөөд амлагдсан нутагт орох нь тэдэнд үгүйсгэгдсэн билээ. Энэ үйл явдал итгэл нь хамгийн сул байсан хүмүүсийг итгэл нь хүчтэй байсан хүмүүсээс тусгаарлан заагласан бололтой, учир нь Тооллого 21-ийн үлдсэн хэсэг нь тэднийг эсэргүүцсэн хүмүүсийг израилчууд хэрхэн байлдан дагуулж, амлагдсан нутгийн зүг хэрхэн амжилттайгаар урагшлан давшсан тухай өгүүлдэг. Израилчууд итгэлээрээ хүчтэй байсан үед тэд илүү их амжилт олдог байв.



Судруудыг судлах нь

А Түүхийг өөрийнхөө үгээр ярь

Өөрийгөө Хүүхдийн Хэсгийн багш гэж бод. Тооллого 21:4–9-ийн түүхийг хүүхдүүд ойлгож чадахаар өөрийнхөө үгээр ярь. Та уг түүхийг ярьж байх үедээ нэг юм уу хоёр зураг үзүүл.

Б Бусад судруудаас чухал тайлбаруудыг ол

Доорхтой адил схем хийж, Тооллого 21 дэх үйл явдалд хамаарах ойлголтуудаар схемийг бөглө.

Судруудын ишлэл	Хэн хэлсэн бэ	Тэр юу хэлсэн бэ
Иохан 3:14–16		
1 Нифай 17:40–41		
Алма 33:18–22		
Хиламан 8:13–15		

Тооллого 22–24

Балаамын түүх



Зөв биш гэдгийг нь өөрөө мэдэж байсан ямар нэг зүйлийг хийхэд хэн нэгэн хүн хичнээн мөнгө төлөх вэ? Тооллого 22–24 нь ийм шийдвэр гаргах ёстой болсон нэгэн хүний тухай түүхийг өгүүлдэг. Түүний нэрийг Балаам гэдэг байв. Тэр мэргэ төлөгч (ирээдүйг угтан хэлэхэд мэргэжисэн хүн) байсан бөгөөд үүндээ итгэдэг байсан буюу наанадаж л тэрээр ямар нэг хэмжээгээр Сүнсээр

нөлөөлөгддөг байсан байж болохыг Израилын Бурхан мэддэг байсан аж. Моабчууд тулалдаанд ялж болохын тулд Моабын хаан Израилыг хараалгахаар Балаамыг хөлслөх гэж оролджээ. Та нар уншихдаа, хэрэв та Балаам байсан бол юу хийх байсан бэ гэдгийг, мөн уг туршилагаас та юу мэдэж болох тухай бод.

Судруудыг ойлгох нь

Тооллого 22:20–35—Түүнд хэлсэн зүйлийг хийснийх нь төлөө Бурхан яагаад Балаамд ууртай байсан бэ?

Хэрэв Моабын хунтайж нар түүнийг өөрсөдтэйгөө хамт явахыг дахин гуйвал *Их Эзэн түүнд хэл гэсэн тэр үгсийг л хэлэхээр* тэр тийшээ очих ёстойг Их Эзэн Балаамд хэлжээ (Тооллого 22:20-ийг үз). Шүлэг 21-д ердөө маргааш өглөө нь Балаам босч, замдаа гарсан тухай цэдэглэсэн байдаг. Зарим хүмүүс Балаам өөрийнх нь үйлчлэлийн төлөө түүнд санал болгосон мөнгөн дээр зүрх сэтгэлээ тавьсан гэж хэлсэн байдаг (2 Петр 2:15-ыг үз); тэрээр Их Эзэнийг дагах ямар ч бодолгүйгээр явжээ. Иймээс, түүний илжиг болон гартаа сугалсан илдтэй тэнгэр элчийн талаарх туршлага нь, тэрээр Их Эзэнийг сонсох ёстой байсныг харуулдаг. Түүний туршлагын төгсгөлд, хэрэв тэрээр Их Эзэн өөрт нь хэлсэн үгсийг л хэлэхээр хунтайжуудтай хамт явж болно гэдгийг Их Эзэн Балаамд дахин нэгэнтээ сануулсан аж (Тооллого 22:35-ыг үз).

Судруудыг судлах нь

Тооллого 22–24-ийг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А–В) хоёрыг хий.

А Таны ариун журам худалдагдах уу?

Зөв гэдгийг нь өөрөө мэддэг байсан зүйлийнхээ эсрэг Балаам мөнгөний төлөө явахыг (Тооллого 22-ыг үз) Балак хүсэж байсан лугаа адил, өнөөдөр хүмүүс зөв гэдгийг нь мэддэг зүйлийнхээ эсрэг мөнгөний төлөө, эсвэл “үнэхээр их . . . хүндэтгэгдэх” боломжийн төлөө хэрхэн явдгийг та нар хэрхэн харсан бэ? (ш. 17).

ЭСВЭЛ

Зөв гэдгийг нь тэрээр мэддэг зүйлийг хийхийн тулд мөнгө, алдар хүндэтгэлийг орхисон, өөрийн таньдаг нэг хүний тухай бич.

Б Хүний зан төлвийн тухай ишлэл хэл

Өөрийгөө Балак гэж бод, мөн нутгийн өөр нэг хаан дайсуудаа хараалгахын тулд Балаамыг хөлслөхөөр бодож байна гэж танд бичжээ. Өөрийнхөө хариуг бичиж, тэрээр Израилыг хараалгахын тулд Балаамыг гурвантаа гуйхад юу болсныг хариундаа оруул (эхний удаа: Тооллого 23:1–13; хоёр дахь удаа: Тооллого 23:14–30; гурав дахь удаа: Тооллого 24:1–13).

В Бошиглолыг тайлбарла

Тооллого 24:17-д “Иаковын од,” “Израилын очирт таяг” гэдэг нь хэнийг гэж та нар боддог вэ? (мөн ш. 14–16, 18–29-ийг үз). Та яагаад тэгж бодож байна?

Тооллого 25–26

Израилыг хараасан нь

Балаам Тооллого 22–24-т Израилыг хараагаагүй ч гэсэн, моабчуудын түүнд санал болгосон баялгийг хүсэх нь түүний хувд эсэргүүцэхэд хэтэрхий хүнд байсан ажээ. Тооллого 31:7–8, 15–16; Илчлэлт 2:14 нь Израил шашин

шүтлэгтэй учир тэд түүнийг тийм ч амархан бут цохьж чадахгүйг Балаам моабчуудад заасанд итгэхэд биднийг хөтөлдөг, ингэхлээр Израилыг ёс суртахуунгүй явдал хийгээд хиймэл шүтээн шүтэхээр уруу татаж, улмаар тэднийг Их Эзэний тусламжийг алдахад хүргэжээ Балаам моабчуудад хэлжээ. Иймээс, Тооллого 25 нь амлагдсан нутагт орохын өмнө Израилын буудалд олон израилчуудыг хөнөөсөн сүүлчийн тахлын тухай өгүүлдэг. Энэхүү тахал нь моаб эмэгтэйчүүдтэй үйлдсэн тэдний ёс суртахуунгүй хэрэг явдлын улмаас тэдэн дээр иржээ.

Тахлын төгсгөлөөр, Израилыг орхин гарсан бараг бүх насанд хүрэгчид үхсэн байлаа. Тооллого 26 бол тэдний эцгүүд амлагдсан нутагт орох боломжийг эсэргүүцэж, ингээд цөлд хэрэн тэнүүлчилж, үхэхээр хараагдсанаас хойш гучин есөн жилийн дараах израилчуудын дараагийн үеийнхний өөр нэгэн тооллого буюу хүн амын тооллого юм.

Тооллого 27

Израилд шинэ удирдагчийг сонгосон нь

Моше Израилын хүүхдүүдтэй хамт үүрд байж чадаагүй нь мэдээж хэрэг. Та нар Тооллого 27:12–23-ыг уншихдаа дараах асуултуудыг авч үз: Мосег явснаас хойш израилчуудад ямархуу удирдагч хэрэгтэй байсан гэж та нар боддог вэ? Сүмд өнөөдөр удирдагчид хэрхэн сонгогддог вэ? Тэдний сонгогддог арга зам яагаад чухал вэ?

Судруудыг ойлгох нь



Тооллого 27

Өвөг дээдэс уруугаа одох : Тэрэлсэн (ш. 14)—
(ш. 13)—Үхэх : Эсэргүүцсэн

Судруудыг судлах нь



А Бид . . . итгэдэг

Иошуаг Израилын удирдагчаар сонгоход Итгэлийн тавдахь тунхгийн ямар зарчмууд ашиглагдсан байна вэ?

Тооллого 28–30

Хуучин зарлигууд хэвээр хэрэглэгдсэн нь

Тооллого 28–30 нь бараг дөчин жилийн тэртээ аяллын эхэнд Их Эзэний өгсөн золиослолууд, баярын өдрүүд, хуулиуд хийгээд зарлигуудыг тэд хэвээр хадгалах үүрэгтэйг Моше израилчуудад хэрхэн сануулсныг өгүүлдэг.

Тооллого 31

Балаам үхэв

Тооллого 31 ёс суртахуунгүй явдал, хиймэл шүтээнээр дамжуулан медечүүд израилчуудыг устгахыг эрэлхийлсэн учир Их Эзэн Израилын цэргийг медечүүдийн эсрэг хэрхэн илгээснийг цэдэглэдэг. Их Эзэн болон түүний хүмүүсийн эсрэг эргэсэн мэргэ төлөгч Балаам алагдагсдын дунд байв. Ялалтынхаа төлөө талархал илэрхийлэхийн тулд Израилын цэргүүд олзолсон зүйлээсээ Их Эзэнд өргөн барьжээ.

Тооллого 32

Реубен Гад хоёрын нутаг



Израилын хүүхдүүд Канаан уруу нэвтрэн орохоор Иордан голын зүүн талд хүлээж байх үед Реубен Гад хоёрын овог тэр нутаг үхэр малд сайн юм гэж бодсон учир зүүн талд өөрсдийн өвийг авч болох эсэхийг Мосегоос асуужээ. Хэрэв тэд Иорданы (Канаан) баруунтаах нутгийг эзлэхэд туслахгүй бол бусад овгууд дургүйцэх болно гэж Моше тэдэнд хэлжээ; Канааны оршин

суугчдыг байлдан дагуулах нь бүх арванхоёр овгийн хувьд ч яггүй хэцүү байх болно гэж израилчуудын ихэнх нь бодож байсан аж. Овог бүр өвтэй болох хүртэл өөрсдийн эрчүүдийг туслуулахаар явуулахыг Реубен Гад хоёр зөвшөөрчээ. Гэвч тэд эхнэр хүүхдүүд, мал сүргээ зүүн эрэгт орших ёстой байв. Моше энэ зохицуулалтыг зөвшөөрч, мөн түүнчлэн Иорданы зүүн талд Манассегийн овгийн хагаст бас өв өгсөн ажээ. Судруудын Удирдамжийн ар тал дахь газрын зураг 3-ыг үз.

Тооллого 33–36

Амлагдсан нутагт зориулсан зааврууд

Тооллого 33–36 нь израилчуудыг амлагдсан нутгийн хилийн ойролцоо буудалласан үед Их Эзэн тэдэнд өгсөн нэмэлт заавруудыг агуулдаг.

Тооллого 33 нь израилчуудыг Канаанд хүргэхийн тулд хийсэн тусдаа дөчин аяллыг, магадгүй тэд аялалдаа хичнээн азтай байсныг израилчуудад сануулахын тулд Их Эзэн Мосегоор тэмдэглүүлсэн зүйлийг цэдэглэдэг. Жэгсаалт дахь газруудын ихэнхийг нь газарзүйн байршилын хувьд тогтоох боломж бидэнд байхгүй. Канааны оршин суугчид сүнслэг байдлын хувьд тэдэнд тахал болох

байсан учраас тэднийг бүрмөсөн хөөн гаргах буюу устгахыг Их Эзэн тэр үед зарлигласан ажээ.

Тооллого 34 нь израилчуудын эзлэн авах нутгийн хил хязгааруудыг Их Эзэн хэрхэн тоймлосон хийгээд уг нутгийг арванхоёр овог болон тэдний гэр бүлүүдийн дунд хуваах ажлыг хариуцах хүмүүсийг тэрээр хэрхэн нэрлэсэн тухай өгүүлдэг.

Тооллого 35 нь левичүүдэд зориулж Канаан даяар тусгай хотууд байгуулах тухай Их Эзэний зарлигийг агуулдаг. Энэ нь левичүүд бүх овгуудын дотор байж, тэдэнд зориулсан ёслолуудыг гүйцэтгэх боломж олгох байв. Их Эзэн бас эдгээр хотуудын заримыг нь хүн алсан хүмүүсийн хоргодох газар байхаар нэрлэсэн ажээ. Толгой хоргодох ийм газруудтай байх нь эдгээр хүмүүсийг зохих ёсоор шударгаар шүүхээс өмнө хэн нэг нь өс хонзон авахаас урьдчилан сэргийлэх учиртай байжээ.

Тооллого 36 нь өвийн нутаг нь тухайн овгийнхоо хүрээнд үлдэхийн тулд хүн өөрийнхөө овгийн дотроос гэрлэж байх талаар Их Эзэнээс ирсэн зөвлөгөөг агуулдаг.

Дэд Хуулийн Ном



Хуулийн давталт

Дэд Хууль бол Мосегийн сүүлчийн ном. Дэд Хууль дахь үйл явдлууд Их Эзэн израилчуудыг Египетээс гаргаж авчирснаас хойш барагцаалбал дөчин жилийн дараа тохиожээ. Гучин есөн жилийн тэртээ Их Эзэнд итгэх итгэлээ хөгжүүлэхээс татгалзсан учир—Мосе, Хошеа Калев нараас бусад, Египетийг орхин гарах үед насанд хүрсэн байсан бүх израилчууд цөлд үхсэн ажээ (Тооллого 13–14-ийг үз).

Мосе Дэд Хуулийг бичиж байх үед, үхсэн хүмүүсийн хүүхдүүд амлагдсан нутагт орохоор бэлтгэгдэж байжээ. Бошиглогч Мосе тэдэнтэй хамт орохгүйгээ мэдэж байсан боловч,

тэднийг орхин одохоосоо өмнө израилчуудын энэ үеийнхэнд заавар, зөвлөгөө өгөх боломж түүнд олдсон аж. Дэд Хуульд цэдэглэгдсэн “үгсийг” Мосе Моабын талд, Иордан голын болон амлагдсан нутгийн зүүнтээ хэлсэн ажээ. Сүүлчийн удаа нэгэнтээ хүмүүст заасны дараа Мосе үхлийг үзэлгүйгээр тэнгэрт аваачигдсан ажээ (Алма 45:19-ийг үз).

Дэд Хуулийг судлахад бэлтгэх нь

Дэд Хуулийн эхний дөрвөн бүлэг бол Израилын түүхийн “дурсамж” юм. Дэд Хуульд өөр хорь гаруй тохиолдолд итгэлтэй хэвээр үлдэхэд нь тэдэнд туслах зарим чухал сургамжуудыг “санан дурсаж байх” буюу “мартахгүй байхыг” Мосе хүмүүст сануулжээ. Дэд Хуулийн талаарх дараах зүйлийг ажигла:

- Арван зарлиг Дэд Хууль 5-д давтагджээ.
- Дэд Хууль Шинэ Гэрээнд зуу гаруй удаа иш татагдсан байдаг. Сатаны уруу таталтуудыг хайхрахгүй байхын тулд Дэд Хуулиас гурван шүлэг ашигласан мэдэгдэхүйц хоёр жишээг оруулсан байдаг (Дэд Хууль 6:13, 16; 8:3; Матай 4:1–11-ийг үз), мөн “Хууль дахь агуу тушаал аль нь вэ?” гэсэн асуултад хариулахад Есүс Дэд Хуулиас нэг шүлэг иш татсан байдаг (Матай 22:36; мөн ш. 35, 37–38; Дэд Хууль 6:5-ыг үз).

Дэд Хуулийн номны талаар илүү ихийг мэдэхийн тулд, Судруудын Удирдамж дахь “Дэд Хууль”-ийг үз.

Дэд Хууль 1–3

Түүхийн тойм

Дэд Хууль 1–3 нь өмнөх дөчин жилийн түүхийг нэгтгэн дүгнэх замаар Мосе өөрийн захиасыг Израилын хүүхдүүдэд хэрхэн танилцуулсныг үздэг. Энэхүү нэгтгэн дүгнэлт нь олон талаараа Тооллогын номны сайн хураангуйлал юм. Мосе зарим санаануудыг онцлон тэмдэглэхийн тулд Дэд Хуулийн үлдсэн бүх хэсэгт Израилын энэ түүхийн жишээнүүдийг ашиглажээ.

Дэд Хууль 4

“Өөртөө анхаарал тавь”

Дэд Хууль 4 нь Бурханы өмнө тэрчлэн шашиныхаа өмнө хүлээсэн үүргийг нь тэдэнд заахын тулд Мосе израилчуудын түүхийг хэрхэн ашигласныг өгүүлдэг. Түүний заадаг зүйлүүд израилчуудын бүх үеийнхэнд холбогдоно гэдгийг Мосе бас хэлж, түүний заасан энэхүү үнэнүүдийг хүүхдүүддээ заахыг эцэг эхчүүдэд захъжээ.

Судруудыг ойлгох нь



Дэд Хууль 4

Хяна (ш. 9)—Анхааралтай бай

Хороб (ш. 10)—Синайн Уулын өөр нэг нэр

Иорданы наад тал буюу нар мандах зүгт (ш. 41, 47)—Иордан голын зүүнтээ

Дэд Хууль 4:9, 15, 23—“Өөртөө анхаарал тавь” гэсэн зөвлөгөөг бид хэрхэн хэрэглэх вэ?

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн, Ахлагч М.Рассел Баллард энэ санааг хэрэглэх нэг арга замыг санал болгожээ. Тэрээр Сүмийн залуучуудад хандаж хэлсэн үгэндээ: “Долоо хоног бүр телевизороос, бас найз нөхдөөсөө хол, ганцаархнаа байх цаг гаргахад би та нарыг урамшуулан дэмжиж байна. Судруудаа гар дороо байлга. Тэгээд та нар уншихдаа, тунгаан бодож, залбирч, амьдралаа шударга үнэнээр хар. Тэнгэрлэг Эцэгт өөрийн хийсэн амлалтуудын хувьд чи хаана байгаадаа үнэлэлт дүгнэлт өг. Хэрэв чамд асуудал байгаа бол, үүнийг Их Эзэнд чин сэтгэлийн, даруухан залбиралд хэл. Эцэг эхтэйгээ зөвлө. Тэд чамд туслах болно. Танай бишоп, танай Залуу эрэгтэйчүүдийн болон Залуу эмэгтэйчүүдийн удирдагчид та нарт туслах болно. Тэд та нарт хайртай. Мөн та нар долоо хоног бүр ариун ёслолоос зохистойгоор хүртдэг байхын тулд амар амгаланг мэдрээсэй хэмээн хүслэг. Гэвч, Бурхантай хийсэн гэрээнүүддээ үнэнчээр амьдарч байна уу гэдгээ эцсийн эцэст зөвхөн та нар л мэднэ шүү дээ” гэжээ (in Conference Report, 1993 оны 4-р сар, 7; *Ensign*, 1993 оны 5-р сар, 8).

Судруудыг судлах нь



А Номлогч бол

Сүмийн гишүүн чиний нэг найз, Христэд итгэгчид зөвхөн Библийг л судар гэж ашиглах ёстой гэж хэлжээ. Тэрээр

өөрийнхөө бодлыг хамгаалахын тулд Илчлэлт 22:18–19-өөс иш татаж. Эдгээр шүлгүүдийг хараад тэдгээрийг Дэд Хууль 4:2-той харьцуул. Энэ хоёр судар хэрхэн адил болохыг, тэрчлэн хэрэв чи Дэд Хуулийг Илчлэлт 22-ыг түүний хэрэглэсэн тэр байдлаар хэрэглэвэл юу болохыг тайлбарласан зурвасыг найздаа бич. Бас эдгээр судрууд чухамдаа юу гэсэн утгатайг тайлбарла.

Б Судрууд дахь загварыг ажигла

Дэд Хууль 4:9, 15, 23 дахь адил төстэй өгүүлбэрүүдийг олж тэмдэглэ. Бид зарлигуудыг сахихын төлөө хэн хариуцлага хүлээдгийг ойлгоход энэ гурван шүлэг бидэнд хэрхэн тусалдаг вэ? (Тэрчлэн “Судруудыг ойлгох нь” хэсэг дэх энэ зөвлөгөөг хэрхэн хэрэглэх тухай Ахлагч Баллардын мэдэгдлийг ажигла.)

В Нүгэл үйлдсэн хүнд туслахын тулд судруудыг ашигла

Зөв гэдгийг нь мэддэг зүйлээсээ гажсан хэн нэгэнд зөвлөгөө өгч, найдвар төрүүлэхийн тулд Дэд Хууль 4:25–31 дэх санаануудыг ашигла. Зөвлөгөөг тэмдэглэлийнхээ дэвтэрт бич.

Дэд Хууль 5

Арван Зарлиг



Дэд Хууль 5 нь Египетээс Гарсан нь 20-д анх үздэг. Үлдсэн Арван Зарлигийн тухай Мосегийн нэгтгэн дүгнэлтийг агуулдаг. Эдгээр Арван Зарлиг нь Бурханы гэрээт хүмүүсийн дундах зөв шударга ёсны үндэс суурь учраас израилчуудын үр удмынхны хувьд чухал юм гэдгийг Мосе онцлон тэмдэглэжээ.

Дэд Хууль 6

Агуу Зарлиг

Та нарт онцгой хүч чадал, удирдамж болдог тийм судар байдаг уу? Уг судар яагаад ийм нөлөөтэй байдаг вэ? Та нар үүнийг хэр зэрэг олон удаа санадаг вэ? Та нар үүнийг бусадтай хэр зэрэг олон удаа хуваалцдаг вэ?

Дэд Хууль 6 нь иудейчүүдийн хамгийн их иш татдаг нэг судрын хэсгийг агуулдаг. Энэ хэсэг бол “анхны бөгөөд агуу зарлиг” хэмээн (Матай 22:38; мөн ш. 36–37-г үз) Есүсийн нэрлэсэн хэсэг мөн. Та нар энэ хэсгийг олж, уншихдаа энэ нь яагаад агуу зарлиг байдгийг өөрөөсөө асуу. Энэ нь Арван Зарлигаас хойш хэдэн зуун жилийн дараа өгөгдсөн атлаа яагаад “анхны бөгөөд агуу зарлиг” байдаг вэ?

Дэд Хууль 6 нь бас израилчууд энэ зарлигийг хэрхэн, юуны учир сахих ёстой талаарх Мосегийн тайлбарыг агуулдаг.

Судруудыг ойлгох нь



Дэд Хууль 6

Сахиус (ш. 8)—Духан дээр зүүдэг тууз : Амьд байлгах (ш.24)— Аврах

Дэд Хууль 6:4–5—Анхны бөгөөд агуу зарлиг

Еврей хэлэнд *сонсох* гэдэг үгийг *шема* гэдэг. Үүнээс үүдэн, иудейчүүд Дэд Хууль 6:4–5-ыг *Шема* гэдэг. Бүх хуулинд хамгийн агуу зарлиг аль нь вэ гэж асуухад, Есүс *Шемаг* иш татсан байдаг (Матай 22:36–38-ыг үз). Сүмийн Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон энэ нь яагаад анхны байх ёстойг тайлбарлахдаа: “Бид Бурханыг нэгдүгээрт тавихад бусад бүх юмс байрандаа орж, хэрэггүй зүйлс бидний амьдралаас гээгддэг. Их Эзэнийг хайрлах бидний хайр нь бидний хайрыг шаардах зүйлүүдийг, бидний баримтлах ашиг сонирхлыг, түүнчлэн бидний эн тэргүүнд баримтлах зүйлүүдийн дарааллыг чиглүүлэн зохицуулах болно” гэжээ (in Conference Report, 1988 оны 4-р сар, 3; *Ensign*, 1988 оны 5-р сар, 4).

Дэд Хууль 6:8–9—Энэ зааврыг израилчууд хэрхэн хэрэглэсэн бэ?

Есүсийн үед, олон иудейчүүд Дэд Хууль 6:8–9-ийг хэт үгчлэн тайлбарладаг байжээ. Тэд шүлэг 4–5-ыг жижигхэн хуйлаастай цаасан дээр бичиж, хуйлаастай цааснуудаа “филактери” гэж нэрлэдэг жижигхэн хайрцагнуудад хийж, нэг хайрцгийг гартаа, нөгөөг духан дээрээ тааруулан толгойгоо ороож уядаг байжээ. Тэд бас хуйлаастай цааснуудын нэгийг “мезулот” хэмээн нэрлэгддэг жижигхэн саванд хийж, гэрийнхээ хаалганы баруун хатавчин дээр хаддаг байв.



Судруудыг судлах нь



А Харьцуулах ишлэл

Матай 22:35–38-ын ишлэлийг Дэд Хууль 6:4–5-ын дэргэд (*Шема*) бич. Матай дахь шүлгийг уншиж, *Шемагийн* тухай Есүс юу гэж хэлснийг хураангуйл.

Б Та нар хэрхэн дурсан санадаг вэ?

1. Шүлэг 4–5 дахь зарлигийг тэд илүү сайн дурсан санаж, сахихын тулд Дэд Хууль 6:7–9-д хүмүүст хандан Мосегийн хэлсэн зүйлүүдийг жагсаа.
2. Мөн энэхүү зарлигийг *та нар* илүү сайн дурсан санаж болох арга замуудын тухай бич. Өөрсдийн бодсон санаануудаас наад тал нь нэгийг сонгож, хэрэглэ.

В Асуулт бич

Дэд Хууль 6:24-өөр хариулж болох чухал, утга учиртай асуулт бич.

Дэд Хууль 7

Гэрээнд гэрлэ

Канааны нутаг дахь хүмүүс туйлын ёс бус байжээ. Тэдний ёс бусын улмаас, тэднийг бүрэн устгахыг Их Эзэн израилчуудад зарлигласан ажээ. Дэд Хууль 7 нь израилчууд яагаад энэ зарлигийг дагах ёстойн нэн чухал учир шалтгааныг Мосе хэрхэн тайлбарласныг, тэрчлэн Их Эзэн тэднийг энэхүү сорилт бүхий ажил үүрэгт нь хэрхэн адислах тухай цэдэглэсэн байдаг.

Судруудыг судлах нь



А Та нар юу гэж хэлэх вэ?

Нэг найз чинь Сүмийн гишүүн биш хүнтэй гэрлэх талаар зөвлөгөө өгөхийг өөрөөс чинь хүсжээ. Найздаа зөвлөхийн тулд чи Дэд Хууль 7:1–6-г хэрхэн ашиглаж болох тухай бич.

Дэд Хууль 8

Санагтун!

Ахлагч Спенсер В. Кимбалл, Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн байхдаа: “Та нар маш чухал үгийг толь бичгээс харахдаа, энэ нь юу болохыг мэддэг үү? Энэ нь ‘санах’ байж болно. Та нар бүгдээрээ гэрээнүүд хийсэн учраас . . . бидний хамгийн агуу хэрэгцээ бол санах юм” гэж хэлжээ (Circles of Exaltation [address to religious educators, 1968 оны зургадугаар сарын 28], 8). Дэд Хууль 8 нь тэдний санах хэрэгтэй зүйлүүдийн тухай, мөн яагаад гэдэг талаар Мосе Израилын гэрээт хүмүүст юу гэж хэлснийг цэдэглэсэн байдаг. Хэрэв тэд эдгээр зүйлүүдийг мартвал тэдэнд юу тохиолдохыг тэрээр бас тэдэнд ярьжээ.

Судруудыг ойлгох нь



Дэд Хууль 8:2—Цөлд дөчин жил хэрэн бэдэрсний зарим зорилго

Дэд Хууль 8:2-ыг Их Эзэн дэлхийн амьдралын зорилгыг тайлбарласан Абрахам 3:24–25-тай харьцуул. Цөл дэх

Израилын аялал нь бидний мөнх бус амьдралын хэв шинж буюу бэлэгдэл юм.

Судруудыг судлах нь

А Захиас нь юу вэ?

Дараах бүлэг шүлгийг харж, тухайн бүлэгт хамгийн чухал гэж өөрийн бодсон нэг түлхүүр үгийг бүлэг тус бүрээс сонгож авах замаар Дэд Хууль 8 дахь Мосегийн захиасын гол санааг тодорхойл. Та яагаад тэр үгийг сонгож авснаа товч тайлбарла. Мэдээллийг зохион байгуулахад туслалцаа авахын тулд дараах схемийг тэмдэглэлийн дэвтэртээ хий.

Шүлэг	Түлхүүр үг	Тайлбар
1		
2		
3		
4-6		
7-10		
11-17		
18-19		
20		

Дэд Хууль 9–10

Их Эзэн туслах болно

Израилчуудын өмнөх үеийнхэн амлагдсан нутагт орохоос татгалзсан үндсэн нэг шалтгаан бол тэнд амьдарч байгаа хүмүүсээс айсных байлаа. Дэд Хууль 9–10 нь канаанчуудыг устгаж, амлагдсан нутагт ороход нь Их Эзэн тэдэнд туслах болно гэдгийг Мосе израилчуудад ятгаж байсан тухай өгүүлдэг. Гэвч өөрсдийн хүлээж авах тусламжийн тухайд бардамнаж болохгүйг Мосе израилчуудад сануулдаг байжээ.

Судруудыг ойлгох нь

Дэд Хууль 9:3–6—Яагаад израилчууд канаанчуудыг уг нутгаас хөөн гаргах боломжтой байсан бэ?

1 Нифай 17:32–38-ыг үз.

Судруудыг судлах нь

А Их Эзэн юу шаарддаг вэ?

1. Израилаас юуг, яагаад тэрээр шаарддаг гэж Их Эзэн хэлсэн бэ? (Дэд Хууль 10:12–22-ыг үз.)

2. Түүний шаарддаг зүйлийг хийхийг хүсэхэд өөрт чинь тусалж болох Бурханы тухай юуг та нар эдгээр шүлгүүдээс мэдсэнээ жагсаа.

Дэд Хууль 11

Адислалуудыг эсвэл үхлүүдийг та нар сонгодог

Уналт хийгээд Цагаатгал нь бүх хүн төрөлхтний сонгох эрхийг хамгаалдаг (2 Нифай 2:25–27-г үз). Сонгох эрх бол агуу адислал юм. Гэвч бид өөрсдийнхөө шийдвэрүүдийн үр дагавруудыг хүлээн авч, хариуцлага хүлээхийг энэ нь шаарддаг учраас энд эрсдэл байдаг. Дэд Хууль 11 нь Мосе Израилын өмнө “адислал болон зүхлийг” (иш. 26) тавьсан тухай өгүүлдэг. Өөрөөр хэлбэл, амлагдсан нутагт тэд хэрхэн амьдрахаар сонгосноос хамааран адислалуудыг эсвэл зүхлүүдийг хүлээн авч болно гэдгийг Мосе Израилын хүүхдүүдэд хэлжээ. Үр дүн нь тэднээс хамаарах байв.

Дэд Хууль 12–13

Хилэнцэт зуршлуудаас зайлсхий

Дэд Хууль 12–13 нь хуурмаг бурхдыг шүтэн бишрэх талаар израилчуудад өгсөн Мосегийн сэрэмжлүүлгүүдийг агуулдаг. Гэрээт хүмүүс бусад бүх үндэстнүүдээс ялгаатай байх ёстой атал, хуурмаг зуршлуудаас зайлсхийсэнгүйгээр барахгүй, харин ч хуурмаг зуршлуудтай орооцолдсон нь илт байлаа. Бүлэг 12-т хуурмаг бурхад шүтэн биширдэг газруудаас зайлсхийхийг израилчуудад сануулж, хуурмаг шашнуудын бурхдыг шүтэн бишрэхэд оролцдог буюу оролцоход тэднийг удирдаж болзошгүй хүмүүсийн тухай израилчуудад сэрэмжлүүлсэн байдаг.

Дэд Хууль 14–17

Бурханы хүмүүсийн зуршлууд

Дэд Хууль 14–17 нь Их Эзэний өмнөх зарлигуудыг сануулдаг шүлгүүдийг агуулдаг. Бүлэг 14 нь хүнсний талаарх хуулиудыг агуулдаг (мөн Левит 11-ийг үз). Бүлэг 15 нь долоо дахь жил бүр өр, боолчлолоос чөлөөлөх тухай зарлигуудыг агуулдаг (Левит 25-ыг үз). Бүлэг 16 нь гол баярууд: Дээгүүр

Өнгөрөх Баяр, Пентекост (Ургацын баяр), түүнчлэн Майхан Баярт оролцохын ач холбогдлыг израилчуудад заасан Их Эзэний сануулгыг цэдэглэдэг. Эдгээр баяруудын талаарх зарлигууд өмнө нь Египетээс Гарсан нь 12, 23; Левит 23; Тооллого 28-д гарсан болно. Бүлэг 17 нь золиослолын зарим зуршиллууд, хуурамч бурхад шүтэн бишрэгсэдтэй ажиллах, тэрчлэн бусдыг шүүх тухай өгүүлдэг. Бүлэг 17 нь бас ирээдүйд израилчууд хаантай байхаар шийдэх тухай заавруудыг өгдөг. Эдгээр бүлэг тус бүрд Их Эзэний өгсөн бүх зааврууд нь израилчуудыг дэлхийн зуршиллуудаас тусгаар байлгахад туслах явдал байв.

Дэд Хууль 18

Үнэн ба хуурамч бошиглогчид

Канааны хүмүүст олон төрлийн мухар сүсэг байлаа. Ийм мухар сүсэг хүмүүсийн анхаарлыг татах нь олон-таа байдаг. Учир нь эдгээр зуршиллууд үүнийг эрхлэх ямарваа жишгийг шаарддаггүй, дэлхийн амжилт буюу хувь хүний талаас ямар ч хүч чармайлт гаргалгүйгээр “ид шидээр” эдгээх мэтийн үр дүнг амладаг байв. Дэд Хууль 18 нь эдгээр зуршиллуудын алиныг ч дагахгүй байхыг Мосе израилчуудад хэрхэн сануулсан тухай өгүүлдэг. Удирдамжийн үнэн эх сурвалж бол хиймэл шүтээн эсвэл ид шидийн буюу нууцлаг ур чадвараар хэрэгжүүлэгч бус, харин өөрийн бошиглогчдоор дамжуулан ярьдаг үнэн, амьд Бурхан мөн хэмээн Мосе бас тэдэнд зөвлөжээ. Үнэн бошиглогчийг тэд хэрхэн ялган таних тухай тэрээр хүмүүст ярьдаг байв.

Дэд Хууль 19–25

Сонгогдсон хүмүүст зориулсан тусгай хуулиуд

Дэд Хууль 19–25 нь өдөр тутмын амьдралын олон өөр салбар, тухайлбал, хөдөө аж ахуй эрхлэх, гэр бүлийн харилцаа, цэрэг дайн, шашны цэвэр ариун байдал, ажил хэрэг эрхлэх гэх мэтийн өвөрмөц хуулиуд хийгээд зарлигуудыг агууладаг. Эдгээр хуулиудын зарим нь хачирхалтай сонсогдож болох хэдий ч, тус бүрд нь санаж байхыг Израилаас Их Эзэний хүссэн зарим зарчмууд дээр үндэслэгдсэн юм. Эдгээр дүрмүүд хийгээд зарлигуудыг өснөөр израилчууд мэдээсэй хэмээн өөрийн хүссэн зарчмуудын байнгын, заримдаа өдөр тутмын сануулагчдаар Их Эзэн хангасан юм. Жишээ нь, Дэд Хууль 22:9-д нэг талбайд хоёр өөр төрлийн үр тарихгүй байхыг Их Эзэн израилчуудад хэлсэн байдаг. Үр тарих нь амьдралын чухал хэсэг байсан бөгөөд тэд хэдий ч тарилаа гэсэн, өөрсдийн

үрийг өөр нэгэнтэй холихгүй байхыг, өөрөөр хэлбэл тэд гэрээнээс гадуур гэрлэхгүй байхыг израилчуудад санууладаг байв. Дэд Хууль 19–25 дахь хуулиудын цаадах зарим зарчим нь бусдыг бодвол олж харахад илүү хэцүү ч гэсэн, хэрэв бид эдгээр бүлгүүдийг уншиж, зуршил тус бүрээс зарчмыг гарган авахыг эрэлхийлэх юм бол, эцсийн эцэст эдгээр хуулиуд—ялангуяа “Их Эзэн Бурханаа санахад удаан” хүмүүст хачирхалтай биш юм (Мозая 13:29).

Дэд Хууль 26

Бурханд төлөх бидний өр

Биднийг аравны нэгээ төлөхөд Их Эзэнд ямар нэг ашиг тус байдаг уу? Яагаад тэрээр үүнийг төлөхийг биднээс хүсдэг вэ? Аравны нэгийг төлөх нь бидэнд ямар хэрэгтэй вэ? Аравны нэгээ хүсэлтэйгээр төлдөг, хармын сэтгэлээр төлдөг хүмүүсийн хооронд ямар ялгаа байдаг гэж та нар боддог вэ? Дэд Хууль 26-д Израилын хүүхдүүдэд Мосегийн заасан зүйлүүдийг та нар уншихдаа эдгээр асуултауудын тухай бод.

Судруудыг судлах нь

А Жагсаалт хий

Дэд Хууль 26-гаас Израилын төлөө Их Эзэн хийсэн хэмээн Мосегийн хэлсэн зүйлүүдийг жагсаа.

Б Баярласнаа илэрхийлсэн зурвас бич

Их Эзэн та нарын төлөө хийсэн бүх зүйлийг авч үз. Хэрэв түүний зарим адислалын тухай бодоход туслалцаа хэрэгтэй бол, Мозая 2:21–25-ыг унш. Бидэнд зориулсан түүний адислалуудын төлөө бид талархлаа Их Эзэнд хэрхэн харуулж болох арга замуудын талаар бич.

Дэд Хууль 27–28

Адислалууд ба зүхлүүд

Левит 26-д хэрэв тэд түүний зарлигуудыг сахьвал тэдний хүлээн авч болох адислалуудыг, мөн хэрэв тэд дуула-варгүй байвал тэдний хүлээн авч болох зүхлүүдийг Их Эзэн Израилын өмнө тавьсан юм. Дэд Хууль 27–28 нь Левит 26 дахь үйл явдлуудын үеэр тэднийг хүүхэд байсан цагаас хойш мөнхүү эдгээр адислалууд хийгээд зарлигуудын талаар Мосе израилчуудад хэрхэн ярьдаг байсныг өгүүлдэг. Гэвч энэ үед, Мосе илүү нарийвчилсан зааврууд

өгч “үзүүлэнт хичээл” ашигладаг байв. Тэрхүү үзүүлэнт хичээл нь Канааны нутаг дахь хоорондоо ихэд ойрхон хоёр уул Ебал уул, Геризим ууланд очих тухай зарлигаар



эхэлдэг. Нэг ууланд зургаан овог хуваарилагдсан бөгөөд тэнд амлагдсан адисла-луудын тухай тэдэнд хэлж өгсөн бол, нөгөө уулан дээр бусад зургаан овог очиж зогсох үед тэнд зүхлүүдийг тэдэнд мэдэгджээ.

Энэхүү үйл явдал нь дуулгавартай байдлаараа тэд ирээдүйгээ сонгох онцгой боломжтойгоо санахад нь Израилын хүүхдүүдэд туслах явдал байжээ.

Та нар Дэд Хууль 28-ыг уншихдаа, Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ерөнхийлөгч асан, Жозеф Ф.Смитийн дараах мэдэгдлийн талаар бод: “Эдгээр нь Түүний үгсийг анхааран сонсож, Түүний хуулиудыг дуулгавартай дагах юм бол Их Эзэн эртний Израилын хүмүүст хийсэн амлалтууд юм.”

“Эдүгээ, тэдгээр үгс нь [Дэд Хууль 28:1–13 дахь] тэр үед Израилын хүүхдүүдэд холбогддог байсан лугаа адил та нарт бас холбогдоно гэдгийг би . . . ямар ч эргэлзээгүйгээр хэлэхийг хүсэж байна. Та нар бол өнөө үеийн Израил, харин тэд бол эртний Израил байлаа. Өөрийн үйлчлэгч Мосегоор дамжуулан ярьж байсан мөнхүү тэр Бурхан өнөөдөр Өөрийн үйлчлэгчээр [бошиглогч] дамжуулан ярьж байгаа билээ. Бурханы хуулиудад дуулгавартай байх нь эрт дээр үед төрүүлдэг байсан мөнхүү тэр үр дагаварт өнөө үед бас хүргэх болно” (in Conference Report, 1899 оны 10-р сар, 45).

Судруудыг ойлгох нь



Дэд Хууль 28

Мөөгөнцөр (ш. 22)—
Ургамлын овчин
Үргээн айлгах (ш. 26)—
Цочоох, үргээх
Тэмтчих (ш. 29)—Харж ча-
дахгүйн улмаас өмнөх газраа

гараараа тэмтчин баримжаа
авах
Сүй тавих (ш. 30)—
Гэрлэхээр тохирох
Зүйр үг, хэл амны бай (ш.
37)—Хүмүүс басамжлан,
инээд тохуу болгодог зүйл

Судруудыг судлах нь



Дэд Хууль 28-ыг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А–Г) наад тал нь хоёрыг хий.

А Өнөөдөр энэ нь хэрхэн холбогдох вэ?

Дэд Хууль 28:1–13 нь хэрэв итгэлтэй байх юм бол Израилын хүлээн авах адислалуудын тухай өгүүлдэг. Адислал бүр нь өнөөдрийн хүмүүсийн хувьд ямар учир утгатайг ярьж, тэдгээрийг тэмдэглэлийнхээ дэвтэрт доор харуулсантай адил хүснэгт болгож тэмдэглэ.

Шүлэг	Адислал	Уг зарчим онов үетэй хэрхэн холбогдох вэ
1	Чамайг бүх улс үндэстнээс илүү дээгүүрт тавина	
2	Чи хотод ч, хөдөөд ч адислагдана	
3	Үр хүүхэд, газар, мал амьтдаар адислагдана	
4	Чиний сагс, талх исгэдэг сав адислагдана	
5	Чи орохдоо ч, гарах даа ч адислагдана	
6	Дайснуудаас чи хамгаалагдана	
7	Чиний гар оролцох бүх зүйл адислагдана	
8	Чамайг ариун ард түмэн болгон байгуулна	
9	Чи ЭЗЭНий нэрээр дуудагдана	
10	ЭЗЭН сайхан сан хөмрөгөө нээгээ	
11	Чи доор орохгүй, ямагт дээр нь байна	

Б Та нар алийг нь хүсэх вэ?

Дээрх жагсаалтуудаас та нар алийг нь хүлээн авмаар байгааг бичиж, яагаад гэдгийг тайлбарла.

В Зүхлүүдийг авч үз

Дэд Хууль 28:15–68 нь зүхлүүдийн нэн урт хэсгийг агуулдаг. Та нар тэдгээрийг уншаад, Бурханы зарлигуудыг дагадаггүй хүмүүст тохиолддог зүйлүүдээс өөрсдийн харсан хоёр жишээг сонгож, тэдгээрийн тухай бич. Таны жишээнүүд нь өөрийн чинь таньдаг буюу эсвэл судруудаас өөрийн чинь мэддэг хүмүүсийнх байж болно. Та нар таньдаг хүмүүсээ нэр заах хэрэггүй.

Г Сонгож хийх үйл ажиллагаа

Хэрэв Бурхан бидэнд хайртай юм бол, бид наманчлаагүй тохиолдолд яагаад зовох учиртай юм бэ? (С ба Г 19:17-г үз). Дараах судрууд энэ асуултад хариулахад чинь тусалж болно: Алма 39:7; 42:16–24; Хиламан 12:2–3; Сургаал ба Гэрээ 90:36; 95:1–2.

Дэд Хууль 29–30

Их Эзэнд эргэж очих нь

Дэд Хууль 29–30 нь израилчуудад хандан хэлсэн Мосегийн үгсийн төгсгөлийг агуулдаг. Дуулгавартай байснаас ирдэг адислалууд, дуулгаваргүй байснаас ирдэг зүхлүүдийг тэрээр үргэлжлүүлэн тайлбарлажээ. Хэрэв тэд түүнээс урваж, улмаар наманчлахгүй бол Их Эзэн тэдэнд юу хийж болохыг, түүнчлэн тэд түүний хувьд дахин хүлээн авч болохуйц байхыг хүсвэл, тэд юу хийх

ёстойг Дэд Хууль 30 өгүүлдэг. Их Эзэн нэн нигүүлсэнгүй хийгээд өөрийн хүүхдүүдэд тэвчээртэй ханддагийг бид энэ бүлгээс мэддэг.

Судруудыг судлах нь

А Схем хий

Дэд Хууль 30:1–10 нь Дэд Хууль 28-д өгүүлэгдсэн зүхлүүд юу хийсэн тохиолдолд, хэзээ тэдэн дээр ирэх талаар израилчуудад өгсөн Их Эзэний зөвлөгөөг агуулдаг. Хүмүүс хийх ёстой гэж Их Эзэн хэлсэн долоон зүйл, мөн Их Эзэн хийх болно хэмээн хэлсэн нилээд хэдэн амлалт байгааг ажигла.

Хэрэв	Тэгвэл

Тэмдэглэлийн дэвтрийнхээ нэг хуудсанд хоёр багана гарга. Нэг баганыг “Хэрэв” нөгөөг нь “Тэгвэл” гэж нэрлээд “Хэрэв” багананд, израилчууд зүхэгдсэн нөхцөлдөө юу хийх ёстой талаар Их Эзэний хэлсэн зүйлүүдийг (ш. 1–2, 6, 8, 10-ыг үз) жагсаан бич. “Тэгвэл” багананд израилчуудад зориулж, Их Эзэн хийхээр амласан зүйлүүдийг жагсаа (ш. 3–7, 9-ийг үз).

Б Эдгээр сургамжуудыг хэрэглэ

Нүгэл үйлдэж, Сүмээс холдон хөндийрсөн хүнд туслахын тулд та нар Дэд Хууль 30-аас ямар шүлгийг ашиглах вэ? Уг шүлгийг хэрхэн ашиглахаа тайлбарла.

Дэд Хууль 31–32

Мосегийн Дуун

Мосе израилчуудын энэ шинэ үеийнхэнд Бурханы хуулиуд хийгээд эдгээр хуулиудад дуулгавартай болон дуулгаваргүй байхын үр дагавруудын тухай заасны дараа, тэднийг орхин одоход бэлэн болжээ. Гэвч тэрээр орхин одохоосоо өмнө, Бурханыг бүх зүйлүүдээс илүүгээр хайрлаж, дагахад нь тэднийг, бас шинэ удирдагч Иошуаг зоригжуулжээ. Энэ үед, Мосе израилчуудад заах ёстой байсан нэг дууг Их Эзэн түүнд илчилсэн аж (Дэд Хууль 32:1–43-ыг үз). Уг дуу нь Их Эзэнийг болон Мосегийн заасан зарлигуудыг санахад нь тэдэнд туслах учиртай байжээ.

Судруудыг ойлгох нь

Дэд Хууль 32

Хариу барих (ш. 6)—Төлөөс төлөх

“шулуун шударга хүн” гэсэн утгатай нэр

Ешурун (ш. 15)—

Цөс (ш. 32)—Гашуун

Хүмүүсийнх нь хувьд израилчуудад хандсан

Өшөө авалт (ш. 35, 41, 43)—
Шүүлт

Судруудыг судлах нь

А Дууны нэрийг ол

Дэд Хууль 32 нь “Мосегийн Дуун” гэж нэрлэгддэг. Та нар уг бүлгийг эхнээс нь дуустал уншаад, дууллын нэр байж болно хэмээн өөрсдийн бодож байгаа үгсийг эрж ол.

Б Зөв шударга байхад чинь хөгжим та нарт хэрхэн тусалдаг вэ?

- Их Эзэн израилчуудад өгч болох бүх адислалууд дотроос, яагаад тэрээр өөрийг нь дурсан санахад тэдэнд туслахын тулд, мөн тэдэнд гэрчлэл байхын тулд тэдэнд дуу өгсөн гэж та нар боддог вэ?
- Зарлигуудыг сахих болон Их Эзэнийг дурсан санахад чинь тусалдаг Сүмийн дуулал буюу дууны үгсийг тэмдэглэлийнхээ дэвтэрт бич. Хэрэв та нар үгсийг нь тогтоогоогүй бол, уг дууг хэрэгтэй болсон үед дуулж чаддаг байхын тулд үгийг нь цээжлэхийг хичээ.

В Сонгож хийх үйл ажиллагаа

- Мосегийн дуунд хад гэдэг үг хичнээн удаа давтагдсаныг ажигла. 1 Коринт 10:1–4-т өгүүлснээр, хад гэж юу вэ?
- Хадны тухай энэ дуу юу гэж өгүүлснийг жагсаан бич.

Дэд Хууль 33

Овог бүрд зориулсан адислалууд

Эхлэл 48–49 Иаковын (Израил) хийсний нэгэн адил, Мосе тэднийг орхин одохоосоо өмнө Израилын арванхоёр овог бүрийг адисалжээ. Иосефын үр удмыг (Ефраим, Манассе хоёр) адисалсан нь бүр ч онцгой сонирхол татдаг. (Дэд Хууль 33:13–17-г үз). Иосефын овгуудыг адисалсан нь тэдний ирээдүйн үр удмын тухай, түүнчлэн Бурханы хүүхдүүдийн үлдсэнийг нь “газар дэлхийн хязгаарууд хүртэл” (ш. 17) түрэхэд тэдний гүйцэтгэх хамтын үүргийн тухай өгүүлдэг. Израилын тараагдалтын нэг хэсэг болох Иосефын хүүхдүүд газар дэлхийн бүх хэсгүүдэд тарагдсан байлаа. Өнөө үед тэд Мосегийн энэхүү бошиглолын адислалыг ийнхүү хэрэгжүүлэн, Есүс Христийн Сүмд эргэн цуглуулагдаж байна.

Дэд Хууль 34

Мосетой салах ёс гүйцэтгэсэн нь

Одоо та нар бошиглогч Мосегийн бичсэн Библийн гурван зуу гаруй хуудсыг үзээд байна, энэ бол Хуучин Гэрээний бусад аль ч бошиглогчийн бичсэнээс илүү их юм. Дэд Хууль 34 нь Мосег нас барсан хэмээн өгүүлдэг; гэвч дээр дурдсанчлан (х. 71-ийг үз), Алма 45:19 нь Мосе үхээгүй, харин зөөгдсөнийг заадаг. Мосегийн зөөгдөлтийн

талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Судруудын Удирдамж дахь “Моце”-гоос үз.

Судруудыг судлах нь

А Намтрын товч тойм бич

Алдарт хүмүүс нас барахад сонинууд тэдний амьдралд тохиолдсон зүйлүүдийг, гарамгай ололт амжилтуудыг нь онцлон тэмдэглэж, амьдралын товч түүх буюу ихэвчлэн “товч тоймыг” нийтэлдэг. Хэрэв та Мосегийн үеийн сонин сурвалжлагч байсан бол, Мосегийн намтрын товч тоймд юуг оруулах байсан бэ? Мосегийн амьдрал, заадаг зүйлүүдийг судлах үед та нарт илүү их сэтгэгдэл төрүүлсэн зүйлүүдийг оруул.

Иошуагийн Ном

Гэрээ гүйцэлдсэн нь

Иошуагийн ном нь үүний гол баатар, Иошуагийн нэрээр нэрлэгддэг. Израилын хүүхдүүдэд тэдний амлагдсан нутаг—Канааны нутгийг өгөх гэрээгээ Бурхан хэрхэн гүйцэлдүүлсэн тухай түүхийг уг ном өгүүлдэг.

Еврей хэлэнд, “Иошуа” гэдэг нь “Их Эзэн авардаг,” эсвэл “Их Эзэн ялалтыг өгдөг” гэсэн утгатай ажээ. Энэ нэрний грек хэлбэр нь англи хэлэнд “Есүс” гэж орчуулагддаг. Иошуагийн цэдэгт Иошуа Израилын хүүхдүүдийг амлагдсан нутаг уруу удирдсан тухай байхад, харин Есүс Христ биднийг мөнх амьдралын “амлагдсан нутаг” уруу удирддаг учраас энэ нэрэнд сонирхолтой бэлгэдэл байдаг.

Дайнуудын тухай ном

Израилын хүүхдүүд тулалдаанд дайснуудаа ялснаар Их Эзэний гэрээнүүдийг хэрхэн гүйцэлдүүлсэн тухай олон шастырыг Иошуагийн ном өгүүлдэг. “Чи хүн алах ёсгүй” гэж Бурхан хүмүүст хэлсэн атлаа, дараа нь зарим хотуудын хүн амыг бүгдийг нь устгахыг мөн нөгөөх хүмүүст хэрхэн хэлж чаддаг байна аа хэмээн бид гайхаж болно. Бид эдгээр асуудлаарх Бурханы санаа бодлыг бүрэн гүйцэд мэддэггүй, харин бид дараах зүйлийг мэддэг:

1. Иошуагийн номон дахь үйл явдлууд нь үндэстнүүд өөрсдийн Бурханы нэрээр тулалдаж байсан үед тохиосон ажээ. Израилчууд Их Эзэний хүчээр канаанчуудыг ялахад, тэдний ялалт нь тэр бол үнэн бөгөөд амьд Бурхан байсны гэрч болсон аж. Иошуагийн болон Шүүгчдийн номнууд дахь бараг шастир бүр нь дайн тулаанд аль нэг хүн буюу стратеги ялаагүй, харин Их Эзэн гайхамшигтай арга замаар тулалдаанд ялсныг израилчууд, тэдний дайснууд хэн хэнд нь харуулж, үүнийг мэдэхэд тэдэнд тусалсан ажээ. Түүнээс гадна Израил өөрсдийн байлдан дагуулсан хүмүүсийн эд хөрөнгийг булаан авах замаар баяжихыг Их Эзэн зөвшөөрдөггүй байв (Иошуа 7-д та нар унших болно).

Уг нутаг өөрт нь харъяалагддаг боловч, өөрийнхөө хүмүүсийн хувьд тэдэнд ашиглуулахаар үүнийг өгдөг гэдгийг Их Эзэн израилчуудад олонтаа сануулдаг байлаа. Канааны ёс бус, хиймэл шүтээн шүтэгч үндэстнүүдийг устгасан нь, энэ бол Бурхан ёс бусчуудыг цээрлүүлдэг нэг арга зам гэдгийг бүх хүмүүст сургамж болгон

харуулах явдал мөн. Мөн энэ нь шүүлтийн үед тохиох ёс бусчуудын агуу устгалыг бидэнд сануулдаг.

2. Их Эзэн “дэлхийн төлөө бус аваас ямар ч зүйлийг эс хийдгийг” (2 Нифай 26:24) бошиглогч Нифай заасан байдаг. Их Эзэн ёс бусчуудын үхэлд баярладаггүй (Езекиел 18:32; 33:11) хэмээн бошиглогч Езекиел цэдэглэжээ. Тиймээс, канаанчуудыг хөөн гаргах буюу устгахыг Их Эзэн израилчуудад зарлигласан юм, тэрээр бүх оролцогчдод хамгийн ашигтай зүйлийг тэдний нөхцөл байдаг дээр тулгуурлан хийж байлаа.
3. Канаанчуудын алдас дээд цэгтээ хүрсэн байжээ. (Левит 18:3, 24–25; Дэд Хууль 18:10–12; 1 Нифай 17:32–35-ыг үз). Энэхүү дээд цэг нь тэд бошиглогчид, Гэгээнтнүүдийг алахыг хүсэж байсан явдал мөн (2 Нифай 26:3-ыг үз). Бүх үед Гэгээнтнүүд өөрсдийн эргэн тойрон дахь дэлхийгээс өөрөөр амьдрах нь хүсэн хүлээгдэж байсан болохоор, энэ тохиолдолд, хэрэв тэд канаанчуудын ер бусын ёс бус байдалтай хаяа нийлэн амьдрах юм бол, Их Эзэн тэднээс хүсдэг зөв шударга байдлаар амьдрах нь израилчуудын хувьд нэн хэцүү байх байв. Нийгмийн ёс бус байдал тийм байхад өсөн өндийж байгаа үеийнхэн зөв шударга амьдрахаар сонгох боломжгүй байв. Иймд Бурхан ирээдүйн үеийнхний төлөө уг нийгмийг газар дэлхийгээс нигүүлсэнгүйгээр устгадаг билээ. Бид үүнийг Ноа болон Үерийн тухай түүхээс мэддэг шүү дээ.
4. Бурханы арга зам бол бидний арга зам биш (Исаиа 55:8–9-ийг үз). “Хүмүүний үхэшгүй байдал хийгээд мөнх амьдралыг тохиолгон авчрах нь” (Моце 1:39) түүний ажил гэдгийг, мөн тэр бол Бүтээгч бөгөөд өөрийн бүтээлүүдийн дээр хүчтэй, түүний дотор тэднийг аврах чадвартай гэдгийг бид авч үзсэн үед, Бурханы үйл хэрэг түүний ажлыг гүйцэлдүүлэхэд тусалдаг гэдэгт бид итгэлтэй байж чадна. Бидний ойлголт хязгаарлагдмал учраас, бид юмсыг Бурханы үзэл бодлын үүднээс харах чадваргүй байдаг.

Иошуаг судлахад бэлтгэх нь

Иошуагийн номны эхний сэдвүүдийн нэг нь Их Эзэний заавруудыг чанд мөрдөх явдал мөн. Израилын цэргүүд дуулгавартай байсан үед тэд амжилт олдог байв. Тэд дуулгаваргүй байсан үедээ бүтэлгүйтдэг байлаа. Дуулгавартай байдлын үр

дагаврууд ялалт авчрахад тусалсныг ухаарч ойлгоход израилчуудад тусалсан ажээ.

Иошуагийн номыг гурван ерөнхий хэсэгт хувааж болно:

- Канааныг эзэлсэн нь
- Иошуа нутгийг хуваасан нь
- Иошуагийн сүүлчийн зааврууд болон гэрчлэл

Иошуа 1

“Тууштай бөгөөд зоригтой бай”

Түүхэн дэх хамгийн агуу бошиглогчдын нэг Мосегийн дараа Иошуа Израилын хүүхдүүдийг удирдахаар дуудагдсан үедээ Иошуа хэрхэн өөрийгөө тэнцэхгүй хэмээн даруухнаар бодож байсныг авч үз. Та нар Иошуа 1-ийг уншихдаа, түүнийг энэ шинэ дуудлагад нь зоригжуулахын тулд Их Эзэн Иошуад юу хэлснийг эрж ол. Их Эзэн өөрт чинь өгсөн дуудлагуудад, бас амьдралынхаа туршилагад та энэ зөвлөгөөг хэрхэн хэрэглэж болохыг бод.

Судруудыг судлах нь

Иошуа 1-ийг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А–В) хоёрыг хий.

А Тууштай бөгөөд зоригтой бай

1. Тууштай бөгөөд зоригтой байх талаар Их Эзэн Иошуад хэлсэн шүлгүүдийг ол. Та тэдгээрийг судрууддаа онцлон тэмдэглэхийг хүсэж болно.
2. Та хэрхэн тууштай бөгөөд зоригтой байх тухайгаа бич.

Б Төгс Эзэмших Судар: Судруудад найдахын ач холбогдол

Иошуа 1:8-ын захиасыг хамгийн сайнаар төлөөлж чадна гэж өөрийн бодсон нэг үзүүлэнг тэмдэглэлийн дэвтэртээ зур. Таны үзүүлэн бид судрууд (хуулийн ном) дээр хэрхэн ажиллах ёстойг, тэрчлэн ингэсэн тохиолдолд бидэнд ямар адислалууд амлагдсаныг үзүүлэндээ оруулахад анхаар.

В Танд ямар санагдах вэ?

1. Өөрийнх нь хүмүүс бошиглогчийг дэмжих нь түүнд хэр зэрэг чухал вэ?
2. Хэрэв та өнөө үеийн Сүмийн бошиглогчид хандан товчхон ярих боллоо гэвэл, та түүнийг хэрхэн дэмждэг талаараа юу хэлэх сэн бол?

Иошуа 2

Иерихо дахь туршуулууд



Итгэл бишрэл гэдэг бол өөрийн итгэлийг Бурхан дээр тавих явдал мөн гэж Алма заасан байдаг (Алма 36:3-ыг үз). Та нар Иошуа 2-ыг уншихдаа, хүмүүс энэ бүлэгт өөрсдийн итгэлийг харуулсан арга замуудыг эрж ол.

Судруудыг ойлгох нь

Иошуа 2

Түүний цус өөрийнх нь толгой дээр буух болно (ш. 19)—Үхлийнхээ төлөө тэр өөрөө хариуцлага хүлээх болно.

Түүний цус бидний толгой дээр бууна (ш. 19)—Түүний үхлийн төлөө бид хариуцлага хүлээх болно.

Иошуа 2:1—Туршуулууд яагаад янхан эмэгтэйн гэрт буусан бэ?

Бид Библийг уншиж байтал ямар нэг юм ойлгогдохгүй мэт санагдвал, Их Эзэн болон түүний заадаг зүйлүүдийн талаар юу мэддэгээ санах ёстой. Жишээ нь, ариун явдалтай байхыг, мөн биднийг ариун бус байхад өдөөн турхирах хүмүүс хийгээд нөхцөл байдлаас зайлсхийхийг тэрбээр биднээс хүсдэг байлаа. Бид энэхүү баримтыг мэдсэнээр, “янхан” гэдэг нь бидний ердийн бодлогоос өөр зүйл буюу энэ янхан эмэгтэй наманчилсан гэсэн утгатай юм. Энэ түүхэнд болсон явдал, тэр эмэгтэй бол Бурханд итгэх итгэлтэй, сайн эмэгтэй байжээ гэдгийг бидэнд сануулдаг. Бид бас туршуулуудын нөхцөл байдлыг анхаарч үзэх хэрэгтэй. Гаднын хүмүүс өөр хаа нэгтээ бууснаас янхан эмэгтэйн гэрт буух юм бол хүмүүс ажиглах нь бага байх учиртай.

Судруудыг судлах нь

Иошуа 1-ийг судлахдаа А буюу Б үйл ажиллагааг хий.

А Сайн Рахаб

Иошуа 2; Еврей 11:30–31; Иаков 2:24–25-ыг уншсаны дараа, өөрийгөө туршуулуудын нэг байсан гэж бодон, Рахаб итгэлийг хэрхэн харуулсныг нотлох тайлбар хийж, израилчууд Иерихог эзлэхдээ яагаад түүнийг аварсан гэж бодлогоо тайлбарла.

Б Улаан утас

Улаан утас юуг төлөөлсөн гэж та нар боддог вэ? Израилчууд Египетэд байхдаа энэ улаан утастай адилхан юу хийсэн бэ? (Египетээс Гарсан нь 12:7, 13-ыг үз).

Иошуа 3–4

Иордан голыг гаталсан нь

Манай амьд бошиглогчид, төлөөлөгчдөд итгэх итгэлтэй байхад та нарт юу тусалдаг вэ? Тэдэнд итгэх итгэлтэй байх нь яагаад чухал вэ? Тэрээр Мосетой хамт байсныхаа нэгэн адил Иошуатай хамт байсныг мэдэх хүсэлтэй хүмүүст гэрчлэхийн тулд Их Эзэн юу хийснийг Иошуа 3-4-т үздэг. 3-4-т үздэг.



Судруудыг ойлгох нь



Иошуа 3


Хуаран (ш. 2)—Буудал, буу-сан газар

Голыг гатлан (ш. 6)—Иордан голыг гатлан

Өргөмжилж (ш. 7)—Агуу их болгон

Иорданы ус таслагдаж, дээрээс урсаж байгаа ус овоорон тогтох болно (ш. 13)— Иордан гол доошоо урсахаа болино.

Судруудыг судлах нь



Иошуа 3-4-ийг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А-В) хоёрыг хий.

А Тэмдэглэл хий

Авдар авч яваа левичүүдийг өөрөө харж байна гэж төсөөлөн бод. Иошуа 3-4-т дүрслэгдсэн үед зориулсан өөрийн тэмдэглэлийг бич. Иошуаг Бурханы бошиглогчийн хувьд юу гэж боддогоо оруул.

Б Өнөө үед энэ нь хэрхэн тохиолддог вэ?

Сүмийн Ерөнхийлөгч бол Бурханы бошиглогч гэдгийг өнөөдөр бидэнд нотлохын тулд Их Эзэн ямар арга замуудаар тусалдаг вэ?

В Дурсгалын зүйл

Иошуа 4-т чулуунуудаар дурсгал хийхийг Их Эзэн Иошуад зарлиглажээ. Дурсгалын зүйл дээр байрлагдсан тахал юуны тухай өгүүлж болно гэж боддогоо тэмдэглэлийнхээ дэвтэрт бич.

Иошуа 5

Онцгой зочин

Иошуа 5 Израилын хуаран Иордан голын баруун талд амлагдсан нутагт байхад тохиолдсон зарим үйл явдлуудыг үздэг. Израилчууд Их Эзэнд өөрсдийн шийдвэр төгс байдлыг харуулж, мөн тэднийг дараагийн сорилттой тулгарахад—Канааны нутгийг эзлэхэд тэрээр мөн тэдэнтэй хамт байх болно гэдгийг харуулжээ.

Судруудыг судлах нь



А Их Эзэний цэргийн жанжин

1. Иошуа 5:13-15-д, Их Эзэний цэргийн “жанжин” хэн байсан нь тодорхойгүй боловч, шүлэг 14 Иошуа “нүүрээрээ газарт унан . . . шүтэн биширснийг” өгүүлдэг билээ. Судрууд дахь бусад хүмүүс Иошуагийн хийсэнтэй адил хариу үйлдэл үзүүлдэг: Корнели, Петртэй уулзсан аж (Үйлс 10:25-26); Иохан дээр тэнгэр элч хүрч ирэв (Илчлэлт 19:10; 22:9-ийг үз); мөн Нифайн ах нар Нифай уруу заав (1 Нифай 17:55-ыг үз). Мөн Мосе Их Эзэнтэй тэнд уулзсан Египетээс Гарсан нь 3:1-6-г унш. Эдгээр үйл явдлууд Иошуад болон “жанжинд” тохиолдсон зүйлтэй хэрхэн харьцуулагддаг вэ? Эдгээр үйл явдлууд Иошуатай хэн ирж уулзсан тухайд бидэнд юу заадаг вэ?
2. Энэ цаг үед ийм туршлагатай байх нь Иошуагийн хувьд яагаад чухал байсан гэж та нар боддог вэ?

Б Сонгож хийх үйл ажиллагаа

Өөрийг чинь сорилттой тулгарахад Их Эзэн чамд нэмэлт хүч чадал өгсөн тохиолдлын тухай бич.

Иошуа 6

Хана нурж унасан нь

Иошуа 2-т Иериход тандуул хийж байсан хоёр израил хүн хэрхэн Рахабаар хамгаалагдаж, тэгээд дараа нь Иошуад буцан мэдээлэл авчирсан тухай бид уншидаг. Иошуа 6 нь Израилын цэрэг хотыг хэрхэн эзэлсэн хийгээд, туршуулуудын амласнаар Рахаб хэрхэн аврагдсаныг өгүүлдэг.



Судруудыг ойлгох нь



Иошуа 6—Долоогийн тоо

Энэ түүхэнд долоогийн тоо хичнээн удаа хэрэглэгдсэнийг ажигла. Еврей хэлэнд, долоо нь (*шева*) “бүрэн, бүтэн буюу төгс” гэсэн утгатай аж. Их Эзэн долоогийн тоог ашиглан, хэрэв Израил түүний зарлигуудыг хийгээд түүнтэй хийсэн өөрсдийн гэрээнүүдийг бүхэлд нь сахих юм бол тэд амжилт олох болно гэдгийг онцлон тэмдэглэжээ.

Судруудыг судлах нь



А Иерихогийн тулалдааныг дүрсэл

Бүслэх, бүрээ, долоо, авдар, Рахаб гэсэн үгсийг оруулан, Иерихогийн тулалдааныг товч дүрсэл.

Б Тэдэнд ямар санагдаж байсан бол? Тэд юу бодож байсан бол?

Иерихог эзэлсний нэг хэсэг байсны хувьд дараах хүмүүс тус бүрдээ бодсон байх ёстой гэж өөрийн санасан ямар нэг зүйлийн тухай бич: Израилын бүрээтэй санваартан, армийн цэрэг, Рахабын үеэл, Иерихогийн иргэн. Иерихо бол Израилын цэрэг Канааны нутагт орсны дараа тулалдаан хийсэн анхны хот байв. Израилын хүүхдүүд энэ тулалдаанд ялснаасаа, мөн энэ нь амлагдсан нутгийг цаашид эзлэхэд ямар сургамж авах ёстой байсан гэж та нар боддог вэ?

Иошуа 7

Аи хотыг эзэлсэн нь

Бид нүгэл үйлдээд үүнийгээ нуух гэж оролдоход юу тохиолддог вэ? (С ба Г 121:37-г үз). Бид нүглээ нууж байгааг бусад хүмүүс мэдэхгүй байлаа ч гэсэн, хэн мэддэг вэ? Бид нүглүүдээ нуухыг оролдоход бидний сүнснэг байдлын өсөлтөд юу тохиолддог вэ? Дуулгавартай байдлын ач холбогдол хийгээд энэ нь бусад хэрхэн нөлөөлдөг, түүнчлэн бид дуулгаваргүй байдлаа Их Эзэнээс нууж чаддаггүй талаар Израилын хүүхдүүд маш чухал, сэтгэл хөдөлгөм сургамж авсан тухай Иошуа 7 цэдэглэдэг.

Судруудыг ойлгох нь



Иошуа 7

Хориглогдсон зүйл (ш. 1, 11–13, 15)—Устгагдах ёстойг нь Бурхан зарлигласан зүйлүүд

Шекел (ш. 21)—Зоосон мөнгө

Иошуа 7:22–26—Аханы гэрийнхэн түүнтэй хамт алагдсан уу?

Иошуа 7-д Аханы гэрийнхэн түүнтэй хамт алагдсан уу, эсвэл түүнийг алагдаж, олзны зүйлүүд нь шатаагдахыг тэд харж байх шаардлагатай байсан уу гэдэг нь тодорхой бус байдаг. Гэвч тэд, ялангуяа тэд түүний авсан зүйлүүдийг нуухад нь Аханд тусалсан бол, алагдсан байж болзошгүй. Хотоос юу ч авч болохгүйг бүх хуаран даяар зарлигласан байжээ.

Судруудыг судлах нь



А Нүглийн үр дагаврууд

1. “Нууц нүгэл гэгч юм ерөөсөө байдаггүй” гэж Ахлагч Дийн Л.Ларсен хэлжээ (in Conference Report, 1983 оны 4-р сар, 49; *Ensign*, 1983 оны 5-р сар, 35). Энэ үнэнийг Аханы түүх ямар замаар харуулдаг вэ? Жишээ нь, Аханы нүгэл гучин зургаан израил хүн болон тэдний гэрийнхэнд яаж нөлөөлсөн бэ? Түүний нүгэл Израилын бүх хуаран даяар, түүний дотор Иошуад хэрхэн нөлөөлснийг, мөн энэ нь Аханы гэрийнхэнд хэрхэн нөлөөлснийг оруул.
2. Хүний “хувийн нууц нүгэл” мэт санагддаг зүйл үнэн хэрэг дээрээ бусад олон хүмүүст хэрхэн нөлөөлдөг тухай өнөө үеийн жишээний тухай бодож, бич.

Иошуа 8

Аи хотыг эзэлсэн нь

Аханы нүглээр бий болсон нөхцөл байдлыг шийдвэрлэсний дараа, буцаж, Аигийн хотыг устгахыг Их Эзэн Иошуад хэрхэн зарлигласныг Иошуа 8 цэдэглэжээ. Иошуа 8 нь бас Дэд Хууль 27-д өгөгдсөн, Израилд ирж болох адислалууд болон зүхлүүдийг Иошуа хэрхэн гүйцэлдүүлснийг өгүүлдэг.

Иошуа 9

Гибеончуудад залилуулсан нь

Иошуа 9 дэх үйл явдлуудын үеэр, израилчуудын алдар уг нутаг даяар тархсан байлаа. Нэг бүлэг хүмүүс гидеончууд, израилчуудтай энхийн гэрээ хийхээр тэднийг мэхлэхээр шийдсэн ажээ. Израилчууд Их Эзэний зөвшөөрлийг асуул-гүйгээр энхийн гэрээ байгуулж. Гидеончууд тэднийг мэхлэхснийг мэдээд тэд ууртай байсан хэдий ч, тэд уг гэрээг хүндэтгэсэн хэвээр байлаа. Амлалтаа хүндэтгэлтэй хандах нь маш чухал гэж хүмүүс бодож байж. Гэрээтэй холбоотой үйл явдал, ажил хэргийнхээ талаар Их Эзэнтэй улам ихээр зөвлөж байх сургамжийг энэ нь израилчуудад өгчээ (мөн Алма 37:37-г үз).

Иошуа 10

Нар, сар мандсан хэвээр


Уг нутагт израилчуудын хийсэн зүйлүүдийн тухай мэдээ үргэлжлэн тарсаар байлаа. Иошуа 10 нь нилээд хэдэн өөр бүлэг хүмүүс Их Эзэний хүмүүсийг зогсоохын тулд юу хийхээр хичээж байсан тухай өгүүлдэг. Дайснуудаа ялахад нь өөрийн хүмүүст туслахын тулд Их Эзэн юу хийсэн тухай бид бас уншидаг. Та нар уншихдаа, мөнх амьдрал олж авахын төлөөх та нарын хүч чармайлтад хэн та нарын “дайснууд” болохыг бод. Та нар Иошуагийн үлгэр жишээг ямар байдлаар дагаж болох вэ? Иошуагийн төлөө Их Эзэний хийсэн зүйлийг өөрсдийнхөө төлөө Их Эзэний хийж чадах зүйлтэй ямар арга замаар та нар харьцуулж болох вэ?

Судруудыг ойлгох нь

Иошуа 10

Зарц нараа бүү хөсөр хаяач
(ш. 6)—Бидэнд туслахаас
бүү нүүр буруулаач

Иошуагийн цэргийн хүчээр эзэлсэн газрууд



Судруудыг судлах нь

А Их Эзэний нэмэлт тусламж

1. Дайснуудтайгаа тулалдахад нь израилчуудад туслахын тулд Их Эзэн ер бусын ямар хоёр үйл хэрэгжүүлсэн бэ?
2. Уруу таталт, ёс бус явдалд автахгүйн тулд өнөө үед бидэнд ямар туслалцаа байдаг вэ? (Та нар зарим санаа авахын тулд 1 Нифай 14:12–14-ийг уншиж болно.)

Б Судруудыг өөртэйгөө адилтга

1. Иошуа 10:24–25-ыг уншиж, уншсан зүйлээ 1 Коринт 15:21–26; Сургаал ба Гэрээ 76:58–62, 101–6; 103:5–8-д Их Эзэний хэлсэн зүйлүүдтэй харьцуул. Иошуа ахмадуудад хэлсэн зүйлийг, түүнчлэн энэ нь Есүс өөрийн хүмүүсийн төлөө хийх зүйлийн бэлгэдэл хэрхэн болдгийг дүрсэл.
2. Их Эзэний тусламж, хамгаалалтад зохистой байхын тулд бид өөрсдийгөө хэрхэн бэлтгэж болох вэ?

Иошуа 11–21

Канааныг эзлэх нь үргэлжлэв

Иошуа 11 нь Иошуа болон израилчуудын ялсан илүү олон тулалдааныг дүрсэлдэг. Бүлэг 11 бас израилчууд зарим хаадтай “удаан хугацаагаар дайтсан” тухай дурддаг. Тэдний дайтсан зарим хотыг эзлэхэд анхны хотуудаас яагаад илүү удаан хугацаа израилчуудад шаардлагатай болсныг бид мэдэхгүй. Иошуа 12 израилчуудын устгасан хотууд болон хаадын жагсаалтыг агуулдаг бол, Иошуа 13:1–14 тэдний устгаагүй буюу хөөн гаргаагүй зарим хот болон хаадын жагсаалтыг агуулдаг. Эдгээр бүлгүүд яагаад устгагдаагүй буюу хөөн гаргаагаагүйг бид яг тодорхой мэддэггүй.

Иошуа 13-аас эхэлж, Иошуа 21-ийг дуустал, уг нутаг Израилын овгуудын дунд хэрхэн хуваагдсан тухай бид уншидаг. Овог тус бүрийн хүлээн авсан нутгийн хилийг ойролцоогоор харахын тулд Судруудын Удирдамж дахь газрын зургийн хэсгээс эрж ол (Судруудын Удирдамжийн ар тал дахь газрын зураг 3-ыг үз).

Иошуа 22

Иорданы зүүнтээ суурьшсан нь

Моше зөөгдөхийнхөө өмнө хэрэв тэд Иордан голын баруун-таах нутгийг олж авахад нь бусад овгуудад туслах юм бол

Иордан голын зүүнтээх газрыг Реубений овог, Гадын овог хоёрт, тэрчлэн Манасегийн овгийн хагаст өгөх болно гэжээ. Энэ нь Иошуа 22 дахь үйл явдлуудын үед гүйцэлдсэн ажээ.

Иошуа 22 энэ хоёр болон өөр хагас овог Иорданы зүүнтээх өвийн нутгаа хүлээн авахаар буцаж явсан тухай өгүүлдэг. Бусад овгууд тэдний замдаа хийсэн нэг зүйлийг Мосегийн хуулийг зөрчсөн мэтээр буруу ташаа ойлгож, үүний улмаас тэд бараг л дайтах шахсан аж. Гэвч овгуудын удирдагчид хамтран цуглаж, асуудлыг энхийн журмаар шийджээ. Эртний эдгээр хүмүүсийн нэгэн адил, бид бас бусдыг шүүхийн өмнө хэрэг явдлыг бүхэлд нь ойлгож мэдэх ёстой.

Иошуа 23–24

“Энэ өдөр та нар сонго”

Иошуа залуу эр байхдаа Египетээс гарч, Мосегийн үйлчлэгч байжээ. Тэрээр Египет дэх тахлууд, цөл дэх гайхамшигууд, израилын дургүйцэл, эсэргүүцлүүдийг гэрчилдэг байв. Эцэст нь, тэрээр Канааны хотууд болон хаадыг гайхамшигтайгаар ялсан ялалтад Израилын цэргийг удирдсан юм. Иошуа 23–24 Израилын энэ агуу удирдагчийн (эдүгээг нилээд өтөлсөн) сүүлчийн номлолыг үздэг гэсэн байдаг. Түүний амьдрал, түүний туршилагуудын тухай багахан зүйл судалсны дараа, түүний үгийн гол сэдэв юу байсан гэж та нар боддог вэ?

Судруудыг ойлгох нь

Иошуа 23

Үлдсэн тэдгээр үндэстнүүд (ш. 12)—Канааны үндэстнүүдээс амьд үлдэгсэд

Нуруунд чинь ташуур (ш. 13)—Ташуурдалтын улмаас бий болдог шарх

Бүх дэлхийнхний жамаар одох (ш. 14)—Үхэх

Шүүгчдийн Ном

Шүүгчдийн ном Иошуагийн үхэл, Самуэлыг бошиглогчоор сонгосон үеийн хоорондох Израилын түүхийг өгүүлдэг. Шүүгчдийн ном Израилын түүхээс авсан түүхүүдийг агуулдаг бөгөөд эдгээр түүхүүд түүхийн он дарааллаар байх шаардлагагүй, түүнчлэн Израилын түүхэнд холбогдохын хувьд бүрэн биш нь мэдээж юм. Шүүгчид нь өнөөдөр манай нийгэмд ч зэрэгцэн оршсоор байгаа хиймэл шүтээн шүтэх хийгээд хууль бус явдлын түүхүүдийг агуулдаг. Түүхүүдийн зарим нь хачирхалтай, эмгэнэлтэй буюу жигшүүртэй элементүүдийг агуулдаг бөгөөд израилчууд яагаад ийм ёс бус байж чадсанд бид гайхдаг. Гэвч бас Израилд—

Иошуа 24

Би та нарын өмнө хорт зөгийг илгээсэн (ш. 12)—Бусдыг айлгахын тулд би та нарын нэр хүндийг зөвшөөрсөн

Залгих (ш. 20)—Устгах
Тэдэнд зориулсан тогтоол ба зарлигийг үйлдэв (ш. 25)—Гэрээгээр хүлээн авах ёстой хуулиудыг тэдэнд өгөв

Судруудыг судлах нь

А Иошуагийн зөвлөгөөг схем болго

Иошуа 23-т Иошуа израилчуудад хэлсэн зүйлийг төлөөлөх, доорхтой адил хоёр схемийг тэмдэглэлийн дэвтэртээ хий. Эхний схемд Израилыг хий хэмээн Иошуагийн хэлсэн зүйлүүдийг; дараа нь “Үр дагаврууд” схемд амлагдсан адислалуудыг жагсаа. Хоёр дахь схемд, “Үйл ажиллагаануудын” дор бүү хий хэмээн Израилд Иошуагийн хэлсэн зүйлүүдийг; дараа нь “Үр дагаврууд” схемд дуулгаваргүй байдлын улмаас тохиолдох зүйлүүдийг жагсаан бич.

Үйл ажиллагаанууд
Иошуа 24:6–8, 11

Үр дагаврууд
Иошуа 24:9–10

Үйл ажиллагаанууд
Иошуа 24:12, 16

Үр дагаврууд
Иошуа 24:15–16

Б Төгс Эзэмших Судар—Иошуа 24:15

1. Иошуа 24:1–13-т дурдагдсан, израилчуудыг адисалсан Их Эзэний арга замуудыг жагсаа.
2. Израилын гэр бүлийн төлөө Их Эзэний хийсэн бүх зүйлийн улмаас, шүлэг 14–15-д юу хийхийг Иошуа тэднээс хүссэн бэ?
3. Шүлэг 15 дахь Иошуагийн зөвлөгөө өнөөдөр та нарын амьдралыг хэрхэн адисалж болох вэ?

тэр ч байтугай эдгээр цаг үеийн туршид тэд ихэнхдээ сүнсэлг байдлын хувьд сул дорой байсан ч, Их Эзэний мутар тусалж байсныг бид олж мэддэг. Шүүгчдийн ном бол, хэрэв бид түүн уруу эргэх юм бол Их Эзэн бидний сул дорой байдалд бидэнд тусалж чаддаг тухай гэрчлэл юм.

“Шүүгчид хэн байсан бэ?”

“Шүүгчид” бол израилчуудыг дайснуудаас нь чөлөөлөхийн тулд Бурханаар буюу хүмүүсээр шилэгдэн сонгогдсон

Израилын овгуудын удирдагчид юм. Шүүгчид нь хуулийн асуудлуудыг шийддэг жинхэнэ шүүгчдээс илүүгээр цэргийн удирдагчидтай илүү адилхан байжээ. Хүмүүс тэднийг баатрууд болгодог байсан хэдий ч, Их Эзэн бол Израилын жинхэнэ удирдагч мөн гэдгийг зөв шударга шүүгчид заахыг хичээдэг байжээ (Шүүгчид 8:23; 11:27-г үз)


Хэн бэ?	Тэд юу хийсэн бэ?
Ехүд	Дайсны хааныг алсан
Дебора	Бошиглогч эмэгтэй Израилын цэргүүдэд сүнслэгээр нөлөөлдөг байв
Гидеон	Нэн цөөхөн тооны цэрэгтэйгээр Израилыг ялалтад удирдахад Их Эзэнд найдлага тавьдаг байв
Иефта	Израилыг ялалтад удирдахын тулд хүмүүсээр шилэгдэн сонгогдсон хэдий ч, тэнэг амлалт хийжээ
Самсон	Агуу ажилд урьдчилан томилогдсон боловч, бэлгүүдээ дэмий үржээ.

Үндсэн сэдэв

Их Эзэн гайхамшигт хүчээр израилчуудыг амлагдсан нутаг уруу удирдсаны дараа, тэдний итгэл, шийдвэр төгс байдалд цаашид өсч хөгжих нь зогссон ажээ. Тэд бүх канаанчуудыг хөөн гаргасангүй, түүгээр ч барахгүй, канаанчуудын хилэнцэт зуршлуудаас заримыг нь өөрсдөдөө авч эхэлжээ. Үүний улмаас, Израилын хүүхдүүд эв нэгдлээ алдаж, овгууд, гэр бүлүүд болон задран хуваагдсан аж. Шүүгчдийн номонд урвалт, чөлөөлөлтийн мөчлөг дахин дахин тохиодог (доорх зураглалыг хар). Бурханаар адислагдсан хүмүүс түүнийг мартаж, канаанчуудын шашнууд мэтийн түүний хориглодог зуршлуудад оролцож эхэлснээр энэхүү мөчлөг үе эхэлжээ. Үүнээс үүдэлтэй нүгэл, ёс бус явдал өөрийн үр дагавруудтай байдаг. Нэгэн ноцгой үр дагавар бол израилчууд дайснуудынхаа эсрэг Их Эзэний хамгаалалтыг алдаж, улмаар боолчлолд аваачигдсан явдал мөн. Эцэст нь, тэдний чин сэтгэлийн даруу байдал, наманчлалын дараа, Их Эзэн өөрийн хүмүүсийг чөлөөлж, тэднийг дахин цэцэглүүлэн хөгжүүлсэн билээ.

Шүүгчдийн номноос бид юу мэдэж болох вэ

Яагаад израилчууд өөрсдийгөө энэхүү мөчлөг үеэр дахин дахин—ганцхан Шүүгчдийн номонд л гэхэд арванхоёр удаа дамжин гарахад хүргэсэн юм бол? Манай өнөө үед ч гэсэн хувь хүмүүс хийгээд бүлэг хэсэг хүмүүс мөн л энэ мөчлөгт автагдах нь бий. Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл: “Цөөн тооны хүмүүс Бурхан болон түүний заадаг зүйлүүдийг мэдсээр байж, эсвэл зориудаар эсэргүүцэхээр сонгодог. Харин, итгэлийг хөгжүүлэх нь тэр даруйд гарт орж ирэх зүйлүүдэд найдлага тавихаас илүү хэцүү байдаг учир, дэлхийн шунаг хүн Бурханд итгэх итгэлээ материаллаг зүйлүүдэд шилжүүлэх хандлагатай байдгийг бид судруудаас мэддэг билээ. Тиймээс, бүх эрин зуунд хүмүүс Сатаны хүчин дор унаж, итгэлээ алдахад тэд үүний оронд ‘махан биеийн гарт,’ бас хардаггүй, сонсдоггүй, мэддэггүй ‘мөнгөн, алтан, гуулин, төмөр, модон, бас чулуун бурхдын гарт буюу хиймэл шүтээний гарт найдлага тавьдаг’ (Дан. 5:23)” хэмээн хэлжээ (“The False Gods We Worship,” *Ensign*, 1976 оны 6-р сар, 4). Та нар Шүүгчдийн номыг уншихдаа, энэ мөчлөг үеийг эрж ол.




Шүүгчид 1

Хэн бидний төлөө тэмцэх вэ?

Шүүгчид 1-ийн эхний шүлэг: “Канаанчуудын эсрэг тулалдахад хэн бидний тэргүүнд явах вэ?” гэсэн уг номны үндсэн асуулыг агуулдаг. Иошуагийн номонд бидний уншдаг зүйлээс, хариулт нь: Их Эзэн гэдэг нь тодорхой юм. Ерөнхийлөгч Кимбалл дээрх шүлгийг иш татаж: “Итгэлийг хөгжүүлэх нь тэр даруйд гарт орж ирэх зүйлүүдэд найдлага тавихаас илүү хэцүү байдаг” гэж хэлжээ. Энэ нь Шүүгчдийн номон дахь хүмүүсийн хувьд үнэн нь тодорхой юм. Израилчууд итгэлээс гажиж, өөрсдийгөө чөлөөлөхийн төлөө Их Эзэний оронд мөнх бус байдлын хүмүүн хийгээд цэргүүдэд найдлага тавин харах болжээ.

Шүүгчид 1 нь Израилын овгуудаар хөөгдөөгүй бүлэг хүмүүсийн тухай бидэнд өгүүлэх замаар Шүүгчдийн номон дахь өөр нэг гол санааг толилуулдаг. Эдгээр хүмүүсийг хөөж гаргах буюу устгахын оронд Израилчууд тэдэнтэй гэрээ хийснийг Шүүгчид 1 өгүүлдэг. Энэ нь Бурханыг орхиж, хиймэл шүтээнийг тэврэн авахад эхний алхам болсныг доорх схем харуулдаг.



Шүүгчид 2–3

Ехүд Израилыг чөлөөлсөн нь

Дээрх схемийн загварыг баримтлан, Шүүгчид 1 нь израилчууд канаанчуудыг хэрхэн хөөн гаргасан хийгээд дараа нь хэрхэн тэдэнтэй гэрээ байгуулсныг дүрсэлдэг. Израилын хүүхдүүд канаанчуудтай гэрлэсний улмаас хэрхэн хиймэл шүтээнд унасныг Шүүгчид 2–3 дүрсэлдэг. Уг мөчлөг үе үргэлжилж, Ехүд хэмээх шүүгчийн тусалцаатайгаар эцэстээ байдал дээрджээ.

Шүүгчид 2–3-т израилчууд Их Эзэнийг “уурлуулсан” тухай бид нилээд хэдэн удаа уншидаг. Хэрэг дээрээ, Их Эзэний уур “шатаж” (Шүүгчид 2:14, 20; 3:8-ыг үз) байсныг бид мэддэг. Энэ нь чихэнд чимэггүй сонсогдож болох ч гэсэн Баал болон Аштарот бурхдын тухай бага боловч мэдэх юм бол Их Эзэн яагаад ийнхүү ихэд уурласныг ойлгоход бидэнд энэ нь тусалж болно. Баал бол газрын үржил шимийн эрэгтэй бурхан, харин Аштарот бол түүний эмэгтэй хамтрагч бөгөөд газрын үржил шимийн эмэгтэй бурхан байсан аж. “Шүтлэг бишрэл” нь ариун явдлын хуулийг үндсээр нь зөрчих явдлыг багтаадаг байв. Ариун явдлын хуулийн бүх зөрчил бол ноцтой нүглүүд бөгөөд сүнслэг байдлыг устгагч шинжтэй ч, эдгээрийг шүтлэг бишрэлийн нэрээр үйлдэх нь Тэнгэрлэг Эцэгийн өмнө бүр ч жигшүүртэй юм.

Шүүгчид 4–5

Эмэгтэй бошиглогч Дебора

Шүүгчид 4–5 нь шүүгч бөгөөд эмэгтэй бошиглогч асан Дебора хэмээх эмэгтэйн удирдлаган дор Израил дайснуудынхаа боолчлолоос хэрхэн чөлөөлөгдсөн тухай өгүүлдэг. Нэгэн эмэгтэй дайсны удирдагчдыг устгах болно хэмээн тэрээр бошигложээ. Иаел хэмээх израил бус эмэгтэй дайсны цэргийн удирдагчийг алахад энэ бошиглол биелсэн аж. Хэрэв тэд Их Эзэнд итгэх юм бол тэрээр тэднийг чөлөөлж чадна гэдгийг хүмүүс мэдсэн байлаа.

Шүүгчид 5 энэ чухал үйл явдлын тухай израилчуудын дуулдаг байсан нэг дууны үгийг агуулдаг. Хөгжим бол Бурханыг магтан дуулах нэг хүчирхэг арга зам байж чадна (мөн С ба Г 25:12-ыг үз).

Шүүгчид 6–8

Гидеон

Шүүгчид 6–8 нь израилчууд дахин нэгэнтээ урвалтад унасны дараа Их Эзэний өсгөн бойжуулсан Гидеон хэмээх нэгэн агуу шүүгчийн тухай түүхийг агуулдаг.

Судруудыг ойлгох нь



Шүүгчид 6

Ефа (ш. 19)—Бушелиэс (36,3 л) бага зэрэг илүү хэмжүүрийн нэгж

Шүүгчид 6:17—“Надад тэмдэг үзүүл”

Тэмдгүүд эрэлхийлэхгүй байхыг Их Эзэн бидэнд зарлигласан билээ; харин бид гэрчлэл хүлээн авахын өмнө итгэл, дуулгавартай байдлыг хөгжүүлэх ёстой (Ифер 12:6; С ба Г 63:7–12-ыг үз). Энэ тохиолдолд, Гидеон тэмдэг эрэлхийлсэн нь төдийлөн бус, харин түүнтэй ирж уулзсан элч үнэн элч байсан уу гэдгийг тогтоохыг хичээсэн аж, учир нь тэрээр хуурамч шашнууд хийгээд хуурамч шүтлэг бишрэлийн үед амьдарч байсан бөгөөд хуурамч эх сурвалжийн элчээр мэхлэгдэхийг хүсээгүй ажээ.

Шүүгчид 7

Шөнийн харуул эхлэх цаг (ш. 19)—Оройн 10:00 цагаас хойш

Шүүгчид 8

Ефод (ш. 27)—Хүзүү, мөр болон цээжинд таарсан хэсэгхэн даавуу

Завхайрцагах (ш. 27, 33)—Бурханы оронд өөр ямар нэг зүйл шүтэн бишрэх

Татвар эм (ш. 31)—Эзэнтэйгээ гэрлэсэн зарц буюу шивэгчин

Судруудыг судлах нь



Шүүгчид 6–8-ыг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А–Г) гурвыг хий.

А Анхны зүйлүүд анхных байдаг

1. Шүүгчид 6:25–32-т өгүүлснээр, израилчуудыг медечүүдээс чөлөөлөгдөх оролдлогодоо Гидеоны хийсэн анхны зүйл юу вэ?
2. Яагаад Их Эзэн энэхүү анхны зүйлийг хийхийг Гидеонд зарлигласан гэж та нар боддог вэ?

Б Та нар юу гэж боддог вэ?

Тулалдахаар явахын өмнө Их Эзэн яагаад Израилын цэргийн тоог цөөрүүлсэн гэж та нар боддог вэ?

В Эдгээр өгүүлбэрүүдийг төгсгө

Шүүгчид 7-гоос мэдсэн зүйлээ ашиглан доорх өгүүлбэрүүдийг өөрийнхөө үгээр төгсгө.

1. Гидеон 300 хүнийг сонгосон нь тэд . . .
2. Нэг хүн . . . гэж зүүдэлсэн зүүдээ Гидеонд ярьжээ.
3. Цэргийн хүмүүс . . . тулд сав, бүрэнүүдээ ашиглажээ.

Г Хаан уу?

1. Гидеоныг Израилын хаанд нэр дэвшүүлэхээр өөрийгөө шилэн сонгогджээ гэж төсөөлөн бод. Тэрээр сайн хаан болно гэдгийг бусдад үнэмшүүлэхийн тулд та түүнийг тухай юу ярих вэ?
2. Түүнийг та нэр дэвшүүлсний дараа Гидеон юу гэж хэлэв болно гэж бодлогоо бич (Шүүгчид 8:22–23-ыг үз).

Д Сургамж нь юу вэ?

Шүүгчид 6–8 дахь Гидеоны түүх хэрхэн Сургаал ба Гэрээ 1:19-ийн жишээ болдог вэ?

Шүүгчид 9–10

Мөчлөг үе үргэлжлэв

Шүүгчид 9 нь эцгийнхээ нэрд гарсан давуу талыг ашиглан Шехемийн хаан болсон Гидеоны хүү Абимелехийн тухай өгүүлдэг. Уг түүх нь Их Эзэнийг үл ойшооход хийгээд бид өөрсдийгөө удирдан, захирах тухайд итгэлээ бүхэлд нь хүнд найдан тавихад гардаг асуудлуудыг харахад бидэнд тусалдаг.

Шүүгчид 10 нь Израил хиймэл шүтээнүүдийг шүтэн бишрэхээ үргэлжлүүлснийг цэдэглэдэг. Иймээс, тэд Их Эзэний хамгаалалтыг алдаж, дайснауддаа эзлэгдсэн байлаа. Тэгээд тэд тусламжийн төлөө Их Эзэнд хандан хаширч эхэлжээ. Энэ тохиолдолд, уг хүмүүс тусламж гуйн хаширахад Их Эзэн тэднийг хатуу зэмлэсэн ажээ. Өөрсдийнхөө шүтэн биширдэг хиймэл шүтээнүүд уруу очиж, “хаширагтун,” тэгээд эдгээр бурхад чөлөөлөх нь үү гэдгийг хар хэмээн Тэрээр тэдэнд хэлжээ (Шүүгчид 10:13–14-ийг үз).

Шүүгчид 11–12

Иефтагийн түүх

Шүүгчдийн номон дахь удирдагчдын загварыг баримтлах юм бол, Иефта өөр маягийн удирдагч байв. Тэрээр янхан эмэгтэйн хүү байсан бөгөөд өсч том болсон үедээ эцэг өөр, эх нэгт ах нь түүнийг гэр бүл, гэр орноос нь хөөсөн аж.

Гэвч доод гаралтай энэ хүнийг Их Эзэн Израилыг дайснуудаас нь чөлөөлөхөд ашигласан юм. Тэрээр Бурханд итгэх итгэлтэй байж, хиймэл шүтээнүүдийг хаясан нь түүнийг хүч чармайлтуудад Их Эзэн хүч чадлыг өгсөн ажээ.

Шүүгчид 13

Самсоны төрөлт

Өөрийнхөө төрөлттэй холбоотой үйл явдлуудын талаар та нар хэзээ нэгэн цагт эцэг эхээсээ асууж байсан уу? Эцэг эх чинь чамайг амьдралдаа хүлээн авахад бэлтгэгдсэн байхын тулд тэд ямар бодолтой байсан бол? Чамайг өсч томрох үед чиний төлөөх тэднийг найдвар юу байсан бол? Шүүгчид 13 Самсоны төрөлтийн үйл явдлуудын тухай өгүүлдэг. Та нар уншихдаа, Самсоны төрөлтийн үед түүний эцэг эх юу бодож, юунд найдаж байсныг эрж ол.

Судруудыг ойлгох нь

Шүүгчид 13

Тэр хөвгүүний тэргүүнд тонгорог хүргэж болохгүй (ш. 5)—Түүний үсийг авч болохгүй

Назир хүн (ш. 7)—Мосегийн хуулийн дагуух тусгай дуудлага (Тооллого 6:1—21-ийг үз)

Хөвгүүний амьдралын хэв маяг болон үйлчлэл нь ямар байх вэ? (ш. 12)—Ямар дүрмүүд буюу зарлигуудаар бид тэр хүүхдийг өсгөх ёстой вэ?

Судруудыг судлах нь

А Тусгай дуудлага

Дараах нэр томъёонууд Самсоны онцгой төрөлт болон дуудлагатай хэрхэн аль нэг талаар холбоотойг дүрсэл: хүүсэр, уух, тонгорог, тэнгэр элч, шатаалт тахил.

Б Захидал бич

Та өөрийгөө Самсоны авга эгч буюу авга ах, одоо Самсон арван хэдэн настай гэж төсөөлөн бод. Шүүгчид 13-аас уншсан зүйл дээрээ тулгуурлан, тэрээр хичнээн гайхамшигтай эцэг эхтэйг ойлгоход нь туслахын тулд Самсонд захидал бич.

Шүүгчид 14–15

Нэг алдааны дараа өөр нэг алдаа

Самсон хэдийгээр агуу амлалтууд хийгээд адислалуудтай төрсөн ч, Бурханы соёрхсон бэлгүүдийг тэрээр хэрхэн буруугаар ашигласныг Шүүгчид 14–15 бидэнд өгүүлдэг. Самсонд амлагдсан бэлгүүд нь бидний патриархын адислалуудад бидэнд амлагддаг адислалуудтай яг адилхан юм: амлалтууд хийгээд адислалууд нь гагцхүү бид зохистойг амьдарсан үед л гүйцэлдэх ажээ (С ба Г 130:20–21-ийг үз). Та нар уншихдаа, Самсоны ямар үйлдлүүд, амьдрал түүний анхаарал төвлөрүүлдэг зүйлийн тухай бидэнд заадгийг бод.

Судруудыг ойлгох нь



Шүүгчид 14:6, 19; 15:14—“Эзэний Сүнс түүний дээр хүчтэйгээр бууж ирэв”

“Их Эзэний Сүнс” Самсон дээр байсныг бид эдгээр жишээнүүдэд уншдаг, энэ нь тэрээр нэгэн үед Сүнсгүй байхаар зохистой амьдарч байгаад дараа нь тэрээр бардам зантай, дуулгаваргүй болсноос үүнийг алдсан гэсэн үг юм.

Судруудыг судлах нь



А Асуудал нь юу вэ?

1. Дараах хүснэгтийг тэмдэглэлийн дэвтэртээ хийж, жагсаасан судрын ишлэлүүдээс олж мэдсэн мэдээлэлээр бөглө:

Ишлэл	Самсон юу хийсэн бэ	Яагаад
Шүүгчид 14:5-6		
Шүүгчид 14:19		
Шүүгчид 15:1-5		
Шүүгчид 15:6-8		

2. Самсоны хамгийн сул тал юу байсан гэж боддог тухайгаа бич (Шүүгчид 14–15-ыг үз).

Шүүгчид 16

Самсон Делила хоёр



Шүүгчид 13–15-ыг унисаны дараа, Самсон өөрийн турилагуудаас ямар сургамжууд авсан байж болно гэж та нар бодож байна? Та нар

Шүүгчид 16-г уншихдаа, тэд эдгээр сургамжуудыг үнэхээр авсан эсэхийг хар.

Судруудыг судлах нь



А Өнөө үеийн Бошиглогчид, Төлөөлөгчдийн үгсийг хэрэглэ

Дараах зөвлөгөө Самсонд ямар ашиг тустай байж болох вэ? Хариултаа тэмдэглэлийн дэвтэртээ бич. Тэргүүн Зөвлөлийн Ерөнхийлөгч Н.Элдон Таннер: “Гэрээнүүдийг сахигтун гэсэн энэ хоёр үгийг сана хэмээн би та нарт дахин хэлэхийг хүсэж байна. Тэрчлэн хэрэв та нар болон та нарын гэр бүлүүд эдгээр гэрээнүүдийг сахих юм бол, та нар аз жаргалтай байна, та нар амжилттай байна, та нар хүндлэгдэх болно, та нарыг бидний Тэнгэрлэг Эцэгийн оршихуйд буцаан аваачиж чадах сайн гэр бүлүүд та нарт байх болно гэдгийг би та нарт хэлэхдээ сэтгэл хангалуун байна гэж бодож байна. Та нарын хийх ёстой бүх зүйл бол та нар өөрсөд дээрээ үүрэг хүлээх учиртай, та нарын ийнхүү үйлдсэнийг нотолдог: гэрээнүүдийг сахигтун гэсэн энэ хоёр үгийг санагтун. Гэрээнүүдийг сахигтун” гэжээ (in Conference Report, 1966 оны 10-р сар, 99).

Б Төдийлөн дуулгавартай биш

Тооллого 6:1–9-ийг уншиж, назир хүн байх шаардлагуудыг жагсаа. Шаардлага бүрийн хажууд, Самсон уг шаардлагад дуулгаваргүй байсныг харуулдаг судрын ишлэлийг Шүүгчид 14–16-аас бичиж, дараа нь тэрээр юу хийснийг товч тайлбарла.

Шүүгчид 17–21

Дуулгаваргүйнхээ төлөө Израил зовсон нь

Шүүгчид 17–21 нь Шүүгчид 17:6-д хийгдсэн мэдэгдэлтэй нийлж, дараа нь Шүүгчид 21:25 дахь: “Тэр үед Израилд хаан байсангүй: хүн бүр өөрийнх нь нүдэнд зөв хэмээн үзсэнээ үйлдэж байв” гэсэн сүүлчийн шүлэг болж давтагддаг. Шүүгчид 17–21-д бичсэн зүйлээрээ зохиогч эдгээр шүлгүүдийн үнэнийг бидэнд харуулсан бололтой. Эдгээр шүлгүүд Израилын түүхэн дэх хамгийн муу үеийг дүрсэлдэг нь Израилд хаан хэрэгтэй гэж тэд яагаад боддог байсныг (энэ нь дараачийн ном, 1 Самуелын эхэнд тохиодог) ойлгоход биднийг бэлтгэсэн бололтой. Харамсалтай нь, Израил Их Эзэнийг хаанаа болгож, улмаар тэрээр энх амгаланг тэдэнд өгч, тэдэнд тулгарсан бэрхшээлүүдийг шийдвэрлэх арга замаар хангах болно гэдгийг ойлгоогүй юм. Энэ тохиолдолд, бид тэдний амжилтаас илүүгээр Израилын алдаануудаас сургамж авах ёстой.

Энэхүү богинохон, чухал түүх нь Шүүгчдийн Номны үед тохиожээ. Гэвч Шүүгчдийн номон дахь ихэнх түүхүүдтэй адилгүй нь, энэ нь найдвар, итгэлээр дүүрэн, бас аятай сайхан төгсгөлтэй.

Хөрвөгчийн итгэл

Рут бол төрөлтөөрөө израил хүн биш, харин моаб хүн байсныг ажиглах нь сонин юм. Өлсгөлөнгийн үед Моабд (Судруудын Удирдамж, “Моаб”-ыг үз) амьдарч байсан израил хүнтэй Рут гэрлэсэн ажээ. Рутын номноос бид үнэн Сайн мэдээнд хөрвөсөн хөрвөгчийн итгэлийн тухай мэдэж болно. Бас Их Эзэний хайр, нигүүлсэл нь, гэрээнээс гадуур өссөн ч гэсэн, үүнийг хүсдэг хүмүүст хүртээлтэй байдгийг бид мэддэг.

Сурвалжит үр удам

Рутын үр удамд Израилын хаан асан Давид, түүнчлэн Их Эзэн Есүс Христ байдгийг мэдэх нь та нарт сонирхолтой байж болох юм. Та нар уншихдаа, Рут өөрийгөө Аврагчийн зохистой дээд удам болохоо харуулж, юу хийснийг эрж ол.

Рут 1

“Таны явах газар уруу би явна”

Та үнэн Сайн мэдээнд шийдвэр төгс байдаг учраас нэгэн цагт өөрийн чинь орхисон хамгийн чухал зүйл юу вэ?
Та нар Рут 1-ийг уншихдаа, Рутын орхисон зүйлийн талаар бод.

Судруудыг судлах нь

А Сорилтуудтай тулгарсан нь

1. Рут 1-д хүмүүст тулгарсан гурван хүнд сорилтыг жагсаа.
2. Өөрт чинь тулгарсантай адил нэг хүнд сорилтыг сонгож, товч дүрсэл.
3. Өөртөө тулгарсан сорилтуудын тухайд та нар энэ бүлэг дэх жишээнүүдээс юу мэдэж болох вэ?

Рут 2

Рут Боазтай учрав



тухай түүхийг цааш нь уншихдаа энэ санааг эрж ол.

“Бурхан биднийг ажиглаж, бас бидний дээрээс харж байдаг. Гэвч тэрээр ихэвчлэн өөр хүнээр дамжуулан бидний хэрэгцээг хангадаг” гэж Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл хэлжээ (“The Abundant Life,” Ensign, 1978 оны 7-р сар, 4). Рутын

Судруудыг ойлгох нь

Рут 2

ТҮРҮҮ, ТҮРҮҮ ТҮҮВ (ш. 2–3, 7–8, 15–19, 23)—Тариа хадсаны дараа талбайд хаягдсан үр, тариан түрүүг түүх

Ураг (ш. 3)—Гэр бүл

Далавч (ш. 12)—Хамгаалалт

Юүжилсэн (ш. 15)—Хадсан, боосон

Тариа цохих (ш. 17)—Улаан буудайг хальснаас салган цэвэрлэх

Ефа (ш. 17)—Бушелиэс (36,3 л) ялигүй илүү хэмжүүрийн нэгж

Рут 2—Боазын талбайгаас “хаягдсан тариан түрүү түүсэн нь”

Мосегийн хуулиар, ядуучууд талбайгаар явж, хаягдсан тариан түрүү түүж хоол хүнсэндээ нэмэрлэхийн тулд тариачид бүх ургацаа хадаж авах ёсгүй, талбайдаа хэсэг үр тариа үлдээх ёстой байв (Левит 19:9–10-ыг үз).

Судруудыг судлах нь

А Та нар юу гэж бодож байна?

Боаз Рутэд яагаад тийм их эелдэг байсан гэж бодож байгаагаа тайлбарла.

Рут 3–4

Рут Боаз хоёр гэрлэсэн нь

Өнөөдөр хэрэглэгддэггүй нилээд хэдэн заншлыг Рут 3–4 цэдэглэсэн байдаг. Та нарыг уншихад дараах тайлбарууд тусалж болно:

- Мосегийн хуулиар бол, хамгийн ойрын хамаатнууд нь бэлэвсэн эмэгтэйчүүдийг харж хандах, түүний дотор хүүхэдтэй болох боломжтой хүмүүстэй гэрлэх үүрэг хариуцлага хүлээдэг байжээ (Дэд Хууль 25:5–10-ыг үз).

- Рут 3-т Рут өөрийгөө гэрлэх боломжтойг Боазд мэдэгдэхийн тулд зарим заншлуудыг дагасан ажээ. Ёс суртахуунгүй ямар ч юм болоогүй аж. Намайг “бүтээлгээрээ” бүтээгээч хэмээн Рут Боазаас хүсээд “Намайг анхаарч халамжилна уу” хэмээн өгүүлжээ.
- Боазаас илүү ойрын нэг хамаатан эрэгтэй Рутэд байсан боловч тэрээр Наоми, Рут хоёрт анхаарал тавих—тэр тусмаа Руттэй гэрлэх үүргийг өөр дээрээ авах хүсэлгүй байжээ. Ийм учраас Боаз энэ үүргийг хүлээн авсан аж.

Судруудыг ойлгох нь



Рут 3

Арвай шигших (ш. 2)—Үр тариаг хальснаас салгах

Утрэм (ш. 2)—Үр тариаг хальснаас салган цэвэрлэдэг газар

Рут 4

Нас барагчийн нэрийг түүний өвд өргөх (ш. 5, 10)—

Нас барсан төрөл сандандаа хүүхэд гаргаж өгөх

Судруудыг судлах нь



А Нөхөр буюу эхнэрээ сонгох нь

Боаз нөхөр болохын тулд ямар чанаруудтайг (хэрэв чи эмэгтэй бол), эсвэл Рут эхнэр болохын хувьд (хэрэв чи эрэгтэй бол) ямар чанаруудтайг харуулсан жишээнүүдийг Рут 1–4-өөс ол.

Б Сонгож хийх үйл ажиллагаа—Асуултуудад хариул

1. Рутын төлөө Боазын хийсэн зүйлүүд бидний төлөө Христийн хийсэн (мөн хийдэг) зүйлтэй хэрхэн төстэй байж болох вэ?
2. Рутын үйлдлүүд “Христэд ирэхийн” тулд бидний хийж чадах зүйлийн жишээ хэрхэн болдог вэ?

Самуелын нэгдүгээр Ном

Бошиглогчид уу, эсвэл хаад уу?

1 Самуелын ном Самуелын төрөлтөөр эхэлж, түүний тохирууллын тухай шастирыг агуулдаг. Уг ном Израилын хаадад хийсэн нэгэн бошиглогчийн тохирууллыг дүрсэлдэг учраас Израил үндэстний түүхийн хувьд ч нэн чухал юм. Өөрт нь итгэхийг, түүнчлэн хааныг хүсэн гуйхын оронд шүүгчид, бошиглогчдоор удирдуулахыг зөвлөсөн Их Эзэний зөвлөгөөг израилчууд эсэргүүцсэн ажээ.

1 Самуелыг судлахад бэлтгэх нь

1 Самуелын төгсгөлөөс өмнө бид түүний үхлийн тухай уншдаг болохоор 1–2 Самуелыг Самуел бичээгүй нь тодорхой. 1 Самуелын номыг Соломон Хааны үед хэн нэгэн нь бичсэн ажээ. 1 Самуелын тухай дэлгэрэнгүй мэдээллийг, Судруудын Удирдамж “Хуучин Гэрээний бошиглогч Самуел, түүний номнуудаас үз.”

1 Самуел дахь чухал хүмүүс



Ели Самуел хоёр



Саул

Ионатан



Давид Голиат хоёр

1 Самуел 1

“Энэ хөвгүүний төлөө би залбирсан юм”



“Хэзээ нэгэнтээ энэ болон өмнөх эрин үеүдийн бүхэл түүх өгүүлэгдэхэд энэ нь манай эмэгтэйчүүдийн, тэдний мэргэн ухаан хийгээд бүхнээ зориулсан байдлын, тэдний эрэлхэг зоригийн түүхүүдээр дүүрэх болно, учир нь Их Эзэн Есүс Христийн амилалтын дараа түүний булшны дэргэд эхлээд эмэгтэйчүүд л очсоныг хүн мэддэг лугаа адил мөнхийн

үр дагавартай зүйлсийг манай зөв шударга эмэгтэйчүүд өдий олон удаа зөн бэлгээрээ мэдэрсэн юм” гэж Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл хэлжээ, (in Conference Report, 1978 оны 4-р сар, 6; Ensign, 1978 оны 5-р сар, 5).

Самуелын эх Ханна бол Ерөнхийлөгч Кимбаллын дурдсан эмэгтэйчүүдийн нэг болох нь тодорхой байна. Та нар 1 Самуел 1-ийг уншихдаа, түүний аугаа шинж чанарыг харуулсан жишээнүүдийг эрж ол. Ханна, Елена нар шиг эцэг эхтэй байх нь хүүхдүүдийн хувьд ямар учир холбогдолтой болохыг авч үз. Тэдний тухай мэдэх нь биднийг эцэг эхчүүд болох үед дагах жишээнүүдийг өгдөг билээ.

Судруудыг ойлгох нь



1 Самуел 1

Хувь . . . хүртээх (ш. 4)— Мосегийн хуулиар тахилын идээнээс нэг хэсгийг хүнс болгон өөртөө үлдээхийг санваартанд зөвшөөрдөг байж. Үлдсэн идээний заримыг тахилын ширээн дээрх махыг болгосны дараа гэр бүлд буцааж өгдөг байв. Гэр бүлд

буцааж өгсөн зүйлээс гэр бүлийн гишүүн бүр өөрийн “хувь” буюу өөрт ноогдох хэсгийг хүлээн авдаг байжээ.

Түүний толгойд тонгорог хүргэхгүй (ш. 11)—Түүний үсийг авахгүй

Судруудыг судлах нь



1 Самуел 1-ийг судлахдаа үйл ажиллагаануудаас (А–В) хоёрыг хий.

А Сорилтуудыг хэрхэн шийдвэрлэх вэ

1 Самуел 1-д уншсан үйл явдлуудаас, өөрсдийн чинь амьдралын туршлагад холбогдох юуг та нар Ханнагаас сурч болох вэ?

Б Энэ нь юутай адилхан байна гэж та нар боддог вэ?

Ханнагийн хүүхэд байх нь юутай адилхан байна гэж боддог дүрсэл. 1 Самуелаас өөрсдийн уншсан, Ханна ямархуу эх болохыг харуулсан зарим шинж чанаруудыг хариултандаа оруул.

В Та нар өөрсдийгөө Бурханд яаж зориулдаг вэ?

Ханна Самуелыг Их Эзэний үйлчлэлд онцгойлон зориулсан учраас, Самуел санваартнуудтай хамт өсч бүх насаараа сруудад ажиллах учиртай байв. Өнөө үед бид ийм замаар хүүхдүүдээ Их Эзэнд зориулдаггүй нь мэдээж юм; гэвч, та нар эцэг эхийн хувьд, Самуелыг өсөх үед түүнд байсан мэдрэмж, тэрээр Их Эзэнд харъяалагддаг, ялангуяа бүх насаараа Их Эзэний үйлчлэлд онцгойлон адислагдсан гэдэг тэрхүү мэдрэмжийг хүүхдүүдээ төрүүлэхийн тулд та нар юу хийж чадна гэж боддог вэ? Бурханыг өргөлүүдээс нь дээрэмдэж, хүмүүсийг луйвардсан ажээ. Елигийн хөвгүүдийн үйлдлүүдээс болж, хүмүүс тахилын өргөлүүдэд дургүй болсон аж (1 Самуел 2:17-г үз). Тэд юмсыг бүр дордуулж, ариун сүм рүү ирж байсан эмэгтэйчүүдтэй завхайрсныг шүлэг 22 өгүүлдэг.



1 Самуел 2

Елигийн хөвгүүд

Хүүхдүүдээ буруу юм хийсэн үед лагаад эцэг эхчүүд тэднийг залруулах ёстой вэ? Хэрэв тэднийг засч залруулахгүй бол юу болох вэ? Хүүхдүүдийг зөнд нь орхих тухайд

Их Эзэн ямар бодолтой байдаг вэ? Хүүхдүүдийнхээ амьдралд үзүүлэх эцэг эхчүүдийн нөлөөний өөр жишээг 1 Самуел 2-оос олж үзэж болно.

Судруудыг ойлгох нь



1 Самуел 2

Хүүсэр (ш. 5)—Хүүхэд гаргадаггүй

Багананууд (ш. 8)—Тулгуурууд (*Анхааруулга:* Энэ бол яруу найргийн хэл. Дэлхий тулгуурууд дээр тогтдог гэж хүмүүс ч боддог байгаагүй, Библи ч ингэж заадаггүй.)

Хөлийг хамгаалах (ш. 9)—Хамгаалж, харж хандах

Тосолсон (ш. 10, 35)—Сонгогдсон

Ефод (ш. 18, 28)—Дээд санваартны өмсгөлийн нэг хэсэг

Орших газар (ш. 29, 32)—Гэр орон

Гарын хүчийг тасалж (ш. 31)—Хүчийг чинь үгүй болгох замаар шийтгэх. Гар бол хүч чадлын бэлгэдэл мөн.

1 Самуел 2:12–17, 22—Елигийн хөвгүүдийн нүглүүд

Мосегийн хуулиар бол, тахилын идээний нилээд хувийг санваартнууд идэхийн тулд хүлээн авах ёстой байсан боловч, зөвхөн өөх нь тахилын ширээн дээр шатаагдсаны дараа л тэд үүнийг хүлээн авах ёстой байж, мөн тэд нэмэлт хэсгүүдийг ч хүлээн авах ёстой байв. Елигийн хөвгүүд өөрсдөд нь ноогдох ёсгүй зүйлийг, бас цагаас нь өмнө авснаараа Бурханыг өргөлүүдээс нь дээрэмдэж, хүмүүсийг луйвардсан ажээ. Елигийн хөвгүүдийн үйлдлүүдээс болж, хүмүүс тахилын өргөлүүдэд дургүй болсон аж (1 Самуел 2:17-г үз). Тэд юмсыг бүр дордуулж, ариун сүм рүү ирж байсан эмэгтэйчүүдтэй завхайрсныг шүлэг 22 өгүүлдэг.

Судруудыг судлах нь



1 Самуел 2-ыг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А–Г) хоёрыг хий.

А Их Эзэнд зориулсан дуу

- 1 Самуел 2:1–10 дахь Ханнагийн дуунд тохирох сайн нэр юу байж болно гэж та нар бодож байна вэ?
- Өөрт чинь гүнзгий сэтгэгдэл төрүүлсэн, энэ дуунд Их Эзэний талаар Ханнагийн хэлсэн ямар нэг зүйлийг сонгож, яагаад гэдгийг тайлбарла.

Б Уг түүхийг өнөө үед холбогдуулах нь

1 Самуел 2:12–17-г уншсаны дараа, өнөө үеийн Аароны санваар атгагчид энэ түүхээс юу сурч болно гэж бодогоо тайлбарла. Ялангуяа шүлэг 17-д өгүүлж байгаа зүйлийг авч үз.

В Хууль цаазны өмгөөлөгч бол

Та Ели болон түүний хөвгүүдийг шүүхэд авчрах даалгавар авчээ. 1 Самуел 3:13-ыг уншиж, тэднийг ялах гэмт хэргүүд болон тэдний гэм буруутайг нотлох баримтуудыг жагсаа.

Г Эцэг эхчүүдийн үүрэг

Мозая 4:14–15; Сургаал ба Гэрээ 68:25–31; 93:40–43-ыг уншиж, хүүхдүүдээ юу заахыг Их Эзэн эцэг эхчүүдэд зарлигласныг жагсаа.

1 Самуел 3

Самуел Их Эзэнийг сонссон нь



1 Самуел 2-т Ели Их Эзэний дургүйцлийг төрүүлсэн тухай бид уншидаг. Их Эзэн өөр нэгэн бошиглогчийг гаргаж ирэх болно гэдгийг тэрээр Елид хэлжээ. Бүлэг 3 нь Елигийн оронд Самуелыг санваартнаар, түүнчлэн Израилд бошиглогчоор дуудсан тухай өгүүлдэг.

Та нар Самуелд юу тохиолдсоныг уншихдаа, дараах асуултуудыг өөрөөсөө асуу: Их Эзэн өөрийн тааллыг надад хэзээ, хэрхэн мэдүүлж болох вэ? Түүний өгдөг удирдамж, сүнсний нөлөөнд би хэрхэн хариулдаг вэ?

Судруудыг судлах нь



А Шинэ бошиглогч дуудсан нь

- 1 Самуел 3:1-д өгүүлснээр, Их Эзэн яагаад шинэ бошиглогч дуудах хэрэгтэй болсон бэ?
- Их Эзэн өөрийн үйлчлэгчдээр дамжуулан, биднийг үйлчлэхээр дуудахад хэрхэн хариулах тухай Самуелын үлгэр жишээнээс бид юу сурч болох вэ?

1 Самуел 4–6

Гэрээний авдар

Бид зарлигуудыг сахихад Бурханд итгэх итгэлдээ өсч хөгждөг. Бид зарлигуудыг сахихгүй бол, итгэлээ алдаж эхлэн, дотоод хүч чадал дутагдахад хүргэдэг гадаад зүйлүүд рүү бид олонтаа эргэдэг. 1 Самуелд израилчууд ийм нөхцөл байдал байжээ. Хэрэв израилчууд тулалдахаар явахдаа гэрээний авдрыг авч явах юм бол тэд дайснуудаа бут цохьж чадна гэдэгт итгэдэг байсан тухай бүлэг 4 өгүүлдэг. Гэрээний авдар нь ариун сүмийн нэгэн адил гүнзгий сүнслэг утга учрын бэлгэдэл бөгөөд энэ нь зөвхөн тэд Их Эзэнд болон түүний гэрээнүүдэд итгэлтэй байсан цагт израилчуудыг адисалдаг бөгөөд үүнийг гэрээний авдар төлөөлдгийг ойлгосонгүй ажээ. Өөрөөр хэлбэл, хэрэв тэд түүнд үнэнч байх юм бол Бурхан

израилчуудыг дайснуудаас нь чөлөөлж чадах байв, гэвч үүний оронд тэд үүний бэлгэдлийг харж, биет зүйл нь өөрөө ер бусын хүчтэй гэдэгт итгэсэн байжээ. Туйлын харамсалтай нь, израилчууд зөвхөн тулалдаанд ялагдсан төдийгүй, гэрээний авдрыг эзэмшилдээ аваах боломжийг филистчүүдэд олгожээ.

Хэдийгээр израилчууд гэрээний авдрыг мухар сүсгийн байдлаар ашиглах буруу таашаа ойлголттой байсан хэдий ч, уг авдар нь Израилын шашины чухал бэлгэдэл хэвээр үлдэж, үүнийг асарт байрлуулахыг Их Эзэн хүсжээ. Тийнхүү, 1 Самуел 5–6 нь уг авдрыг олзолж авсны дараа филистчүүдэд юу тохиолдсон хийгээд үүний улмаас тэд үүнийг израилчуудад буцааж өгөхөөр шийдсэн тухай өгүүлдэг.

1 Самуел 7

Наманчлал ялалт авчирдаг

Гэрээний авдрыг аз хийморийн бэлгэдэл болгон ашиглахыг хичээж, филистчүүдтэй хийсэн тулалдаанд ялагдсаны дараа, израилчуудад хоёр сонголт тулгарсан ажээ. Тэд өөрсдийгөө аврах өөр Бурхан олж авч болох байв (мухар сүсэгт олон хүмүүсийн үйлдэгчлэн), эсвэл тэд наманчилж, амьд Бурханы бэлгэдийн оронд амьд Бурханд итгэх илүү их итгэлийг хөгжүүлж болох байв. Та нар 1 Самуел 7-г уншихдаа, Самуел хүмүүст юу хийхийг зөвлөснийг, мөн хүмүүс түүний зөвлөгөөг дагахад юу тохиолдсоныг ажигла.

Судруудыг судлах нь

А Юу авардаг вэ?

- 1 Самуел 4:3-ыг уншиж, тэднийг юу аварна хэмээн хүмүүс бодож байсныг тайлбарла.
- Өнөөдөр тэднийг юу аврах болно хэмээн хүмүүс итгэдэг вэ?
- 1 Самуел 7-д Самуел юу хийсэн бэ, мөн хүмүүс дайснуудаасаа аврагдахын тулд тэрээр юу хийхийг тэднээс хүсэн бэ?
- Өнөөдөр бид өөрсдөөдөө учирсан сорилтууд болон уруу таталтуудыг даван туулахад мөн эдгээр зүйлүүдийг ямар арга замаар ашиглаж болох вэ? Жишээ гарга.

1 Самуел 8

“Хааныг бидэнд томилж өгөөч”

Филистчүүдийн эсрэг израилчуудын амжилт 1 Самуел 7-д өгүүлэгддэг. Тэдний ялалтын дараа, израилчууд өөрсдөөс нь Самуелын хийхийг хүссэн зүйлийг хийх илүү их хүсэл эрмэлзэлтэй байсан бололтой. Гэвч тэд итгэлдээ сул дорой хэвээр байлаа. Израилчууд Самуелыг дагахыг хүссэнгүй. Тэд хаантай болохыг шаардаж байв! Их Эзэн өөрсдийнх нь хаан байхыг тэд эсэргүүцэж байлаа. 1 Самуел бүлэг 8 нь Их Эзэн Самуелыг тайвшруулж, хүмүүс Самуелыг биш, харин Их Эзэнийг эсэргүүцэснийг түүнд хэлжээ. Хожим нь, тэд гэрээний авдарт итгэх нь тэднийг хамгаалах эх сурвалж мөн гэдэгт итгэхээсээ илүүгээр тэд хүчтэй удирдагчтай байх нь тэдний амжилт олох түлхүүр мөн гэдэгт итгэхэд шилжсэнийг үздэг.лэдэг.

Эргэн тойрны бусад үндэстнүүд хаадтай байв. Гэвч, Израил бол түүний хувьд “онцгой” хүмүүс байсан нь юув гэвэл, тэд тусгайлан сонгогдож, түүний хүүхдүүдийн үлдсэнийг нь аврах ажил хийхийн тулд түүний хүмүүс байхаар дэлхийгээс онцгойлон адислагдсан хүмүүс гэдгийг бошиглогч Мосегоор дамжуулан Их Эзэн Израилд хэлсэн ажээ. Мосегийн хуулийн ихэнх хэсэг нь тэд бол бусад үндэстнүүдээс ялгаатай бөгөөд хэрэв тэд ялгаатай хэвээр үлдэж, дэлхийн хүлээн зөвшөөрөлт хийгээд баялгуудыг эрэлхийлэхгүй бол тэдэнд агуу адислалууд амлагдсаныг израилчуудад сануулахад тусалдаг байж. Эргэн тойрныхоо үндэстнүүдтэй адил байх израилчуудын хүсэл бол зөвхөн эрт дээр үеийн асуудал биш нь мэдээжийн хэрэг. Өнөөдөр ч гэсэн өөрсөдтэйгөө адил итгэл, жишгүүдийг хуваалцдаггүй эргэн тойрныхоо хүмүүстэй адилхан амьдрахыг хүсдэг Сүмийн гишүүд байдаг. Дэлхийн арга замууд нилээд анхаарал татахуйц байх нь олонтаа тохиолддог.

Бурхан амьдардаг бөгөөд тэрээр бидний сайн сайхны төлөө бидэнд зарлигууд өгдөг гэсэн хүчтэй гэрчлэлгүй бол, “бусад хүн болгон л ингэдэг” учраас бид зарим арга замыг сонгож, үйлдэж мэднэ, улмаар Бурханы гэрээт хүмүүс байхаас ирдэг адислалуудыг алддаг. 1 Самуел 8-д дэлхийн зурилуудад сэтгэл татагдан шохоорхсон нь израилчуудыг уруу татаж, тэднийг “Бурханы эзэмшлийн ард түмэн” байхад нь заналхийлснийг бидэнд сургамжилдаг.



Судруудыг судлах нь

1 Самуел 8-ыг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А–Г) хоёрыг хий.

А Юу тохиолдох вэ?

Хэрэв хүмүүс хаантай байх юм бол юу тохиолдохыг Их Эзэн Самуелаар хүмүүст тайлбарлуулжээ. 1 Самуел 8:10–18-ыг ашиглан, хэрэв Израил хаантай болсон бол дараах тохиолдол тус бүрд юу тохиолдох байсныг бич. Өөрийн чинь хариунд тохирох судрын ишлэлийг тохиолдол бүрд өг.

1. Өөрийнх нь ажилтнуудад илүү олон үйлчлэгч хэрэгтэй гэж хаан шийджээ.
2. Хааныг өөр нэг хаан гомдоож, улмаар тэрээр нэр хүндээ хамгаалахын тулд дайн хийжээр явах болж.
3. Хаан өөрийнхөө үрлэг зардлын төсөв хийж, түүнд илүү их мөнгө хэрэгтэй гэж шийджээ.
4. Хүмүүс хаантай болсондоо баярласангүй, бас хаан тэдний гомдлыг мэджээ.

Б Учир үндэслэлүүд

1. 1 Самуел 8:1–9, 19–22-ыг уншиж, хүмүүс яагаад хааныг хүсэж байсныг тайлбарла.
2. Хааныг хүссэн тэдний учир үндэслэлд юу нь буруу байсан бэ?

В Хэлэх үгийн тойм бэлтгэ

1 Самуел 8-аас Хожмын үеийн Гэгээнтнүүдийн мэдэж авч болох зүйлийн талаар үг хэлэхийг танаас хүсжээ гэж бод. Хэлэх үгэндээ өөрийн оруулах гурван гол санааг жагсаан бич.

Г “Үүнийг, бодгаль бүр чөлөөтэйг мэдэгтүн”

Хаантай байхыг тэрээр израилчуудад зөвшөөрснийг мэдсэнээр 1 Самуел 8 Их Эзэний тухай та нарт юу заадаг вэ? (Алма 29:4–5 таны хариултад тусалж болно.)

1 Самуел 9–10

Саул хааныг тослон адисалсан нь



1 Самуел 8-д бошиглогч Самуел хаантай байхын эсрэг тэдэнд зөвлөсөн ч гэсэн, Израилын хүмүүс хаантай байхыг хүсэж байна гэдгээ хэлжээ. 1 Самуелын бүлэг 9 нь Их Эзэн өөрийн хүмүүст хичнээн их хайртайг, тэр ч байтугай Израилын хүмүүс Их Эзэний зөвлөгөөг дагагүй үед ч гэсэн, тэдний

төлөө хааныг сонгож, сургахад нь өөрийн бошиглогчид сүнс-лэгээр нөлөөлөх замаар тэрээр бас л тэдэнд тусалсныг заадаг. Та нар уншихдаа, Их Эзэнээс ирдэг дуудлагуудын талаар өөрсдийн мэдэж болох зүйлүүдийг эрж ол.

Судруудыг ойлгох нь



1 Самуел 9–10—Бошиглогч Израилын хааныг сонгосон нь

Өнөөдөр бид Сүмд ашигладаг тэрхүү загварыг ашиглан, Их Эзэнээс эрх мэдэл хүлээн авсан нэгнээр Саул дуудагдаж (Итгэлийн Тунхаг 1:5-ыг үз), эрх мэдэл бүхий нэгнээр онцгойлон адислагдаж, сургагдан, мөн хүмүүсийн саналаар дэмжигдэхийн тулд тэдэнд танилцуулагдсан ажээ (1 Самуел 10:24-ийг үз).

Судруудыг судлах нь



1 Самуел 9–10-ыг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А–В) хоёрыг хий.

А Сонины мэдээ бич

Та өөрийгөө 1 Самуел 9–10-ын бүх туршлагаудад Саулыг дагасан, израилын итгэлтэй сонины сурвалжлагч гэж төсөөлөн бод. Яагаад Саул Израилын хааны хувьд сайн сонголт болохыг дүрсэлсэн товч өгүүлэл бич. Өөрийн чинь санаануудыг дэмждэг судрын ишлэлүүдийг ашигла.

В Тэмдэглэл бич

1 Самуел 9–10-аас мэдсэн зүйл дээрээ тулгуурлан, Саул Израилын хаанаар дуудагдсан туршлагынх нь дараа түүнд ямар бодол төрсөн гэж боддог тухайгаа бич. 1 Самуел 9:21; 10:6, 9, 20–27-г тусгайлан анхаар.

В Өнөө үеийн Бошиглогчид, Төлөөлөгчдийн үгсэд холбогдох нь

Ерөнхийлөгч Харольд Б. Лийгийн иш татсан дараах мэдэгдэл 1 Самуел 10:26–27-д болсон үйл явдалтай хэрхэн холбогдох вэ: “Энэ Сүмийн удирдагчид дээр оршдог Бурханы хүчийг харах хүртлээ, мөн энэ нь гал лугаа адил түүний зүрх сэтгэлд доош бууж ирэх хүртэл уг хүн жинхэнэ хөрвөгч байдаггүй” (in Conference Report, 1972 оны 4-р сар, 118; *Ensign*, 1972 оны 7-р сар, 103).

1 Самуел 11

Саул Израилыг тулалдаанд удирдсан нь



Самуел Саулыг дуудаж, түүнийг тэдний удирдагчийн хувьд хүмүүст танилцуулсан тухай түүх 1 Самуел 9–10-д гардаг. 1 Самуелын бүлэг 11 нь Израилыг дайснуудынх нь эсрэг амжилттай удирдсан Саулын тухай шастирьг агуулдаг. Израил амжилттай байсан учраас өөрсдийг нь удирдах Саулын чадварт хүмүүс итгэлтэй болсоор байлаа.

1 Самуел 12

Их Эзэн хаан хэвээр байлаа

1 Самуел 11-д израилчууд дайснуудаа бут цохьсоны дараа, хүмүүс, “Хаан бидний хувьд сайн байх болно гэж бид танд ярьж байсан шүү дээ” гэж Самуелд хэлэхээр уруу татагдаж болох байв. Гэвч 1 Самуел 12 нь энэхүү уруу таталтад орохгүй байх талаар Самуел израилчуудад юу хэлснийг цэдэглэжээ. Тэдний мөнх бус удирдагч хэн байсан нь хамаагүй, Их Эзэн тэднийг дайснуудаас нь чөлөөлснийг тэрээр Израилд сануулсан байдаг. Их Эзэн хэдийгээр хүн тэдний хаан байхыг зөвшөөрсөн ч гэсэн, тэрбээр Израилын жинхэнэ хаан хэвээр байлаа (1 Самуел 12:12-ыг үз). Хэрэв хүмүүс Их Эзэний эсрэг тэмцэх юм бол, тэдний дэлхийн хаан хичнээн ч агуу байсан ялгаагүй, тэд түүний туслагч мутрыг алдах болно хэмээн Саул тэдэнд амлажээ.

1 Самуел 13

Саул мунхгаар үйлдсэн нь

Та өөрийгөө нэгэн арал дээрх Сүмийн хорин гишүүний нэг бөгөөд санваар атгагчид нь зөвхөн Аароны санваарын диконууд байна хэмээн төсөөл. Бүх гишүүдийг энэхүү чухал ёслолгүйгээр явуулснаас эдгээр диконууд ариун ёслолыг гүйцэтгэх нь хүлээн зөвшөөрч болохуйц байж болох уу? Яагаад үгүй гэж? 1 Самуел 13-т бид үүнтэй адил нөхцөл байдлын тухай уншдаг.

Судруудыг ойлгох нь

1 Самуел 13:8—“Самуелын тогтоосон хугацаанд”

Самуел 10:8-д, Самуел түүнд зориулж тахилууд өргөх Гилгалд түүнтэй уулзахыг Саулаас хүсжээ.

Судруудыг судлах нь

A Хэрэв тэр үүнийг дахин хийж чадсан бол

Заримдаа бид тодорхой нөхцөл байдалд дахин амьдарч, өөрөөр сонгож чаддаг болоосой гэж хүсдэг. 1 Самуел 13:1–16 дахь түүх нь Саулын хийсэн зүйл Их Эзэнийг болон Самуелыг баярлуулах тийм байдлаар уг түүхийг дахин бич.

1 Самуел 14

Мунхаг тангараг

Бид дуулгаваргүй, бас наманчилдаггүй бол, бид Ариун Сүнсний нөхөрлөлийг алддаг. Ариун Сүнсгүйгээр бид муу шийдвэр гаргах илүү их магадлалтай байдаг. 1 Самуел 14 дэх Саулын үйлдлүүд бол энэ зарчмын нэг жишээ мөн.

1 Самуел 14 дэх шастир нь Саул өөрийн хүмүүст хэрхэн сүнслэгээр нөлөөлөн, Бурханаас тусламж хүлээн авах найдвартайгаар, филистчүүдийн эсрэг тулалдах бэлтгэлийг түргэвчлэхийг Израилын цэрэгт зарлиг болгосныг дүрсэлдэг. Уг зарлигийг албадан мөрдүүлэхийн тулд, хоол идсэн хэн боловч үхэлд хүргэгдэх болно хэмээн Саул хэлжээ. Гэвч өөрийнх нь хүү Ионатан, түүнийг зарлигаа буулгахад байсангүйг тэрээр мэдээгүй аж. Ионатан жаахан зөгийн бал идчихэж, ингээд Саул хүүгийнхээ амийг авахаар бэлтгэж байв. Аз болоход, хүмүүс Саулаас гуйж, тэгээд тэр энэхүү мунхаг тангаргийг хэрэгжүүлээгүй гэдэг.

1 Самуел 15

Дуулгавартай байдлын ач холбогдол

“Дуулгавартай байдал бол тэнгэрийн анхдагч хууль, бүх зөв шударга ёс, өсөлт дэвшил үүн дээр суурилдаг суурийн чулуу мөн” гэж Ахлагч Брус Р.МкКонки хэлжээ (Мормон Doctrine, 2d. ed. [1966], 539). Та нар 1 Самуел 15-ыг уншихдаа, энэ нь дуулгавартай байдлын зарчмыг заагчийг авч үз.

Судруудыг ойлгох нь

1 Самуел 15:2–3—Яагаад амалекчуудыг бүрмөсөн устгасан бэ?

Сударт нэн цөөхөн удаа хүмүүс устгагдахыг Бурхан зарлигласан байдаг. Амалекчууд Израилын хүүхдүүдийг Египетээс гарч ирсэн үед тэдэнд хэтэрхий харгис бурангуй хандсан ажээ (Дэд Хууль 25:17–19-ийг үз). Тэд аяллын ар талд хоцрон явсан сул дорой, өвчтэй, настай хүмүүсийг түүж авладаг байв.

Судруудыг судлах нь

1 Самуел 15 -ыг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (A–B) хоёрыг хий.

А Харьцуулалт хий

Саулыг хий (1 Самуел 15:1–3-ыг үз) хэмээн Самуелын хэлснийг хэрэг дээрээ Саулын хийсэн зүйлтэй (1 Самуел 15:4–9-ийг үз) харьцуул.

Б Шалтгууд

1. Хий хэмээн түүнд зарлиг болгосон зүйлд дуулгавартай байхын оронд Саул өөрийнхөө хийсэн зүйлүүдэд ямар шалтаг хэлж байсан бэ?
2. Дуулгаваргүй байснаа хаацайлсан түүний шалтгийг хүлээн зөвшөөрөх боломжгүйг тайлбарласан захидлыг Саулд бич. Түүний заасан шалтаг бүрд хариулахад анхаар.



В Жинхэнэ шалтгаан нь

1. Эцэстээ 1 Самуел 15:24-т Саул өөрийнхөө хийсэн зүйлийг яагаад хийсэн бэ гэдгээ хүлээсэн. Дуулгаваргүй үйлдлүүдлээ өнөөдөр хүмүүсийн заадаг зарим шалтгааныг нэрлэ. Эдгээр нь Саулын хариуилуудтай хэрхэн адил байдаг вэ?
2. Өөрсдийн үйлдлүүдийг зөвтгөж, уруу таталтанд автагдахаас биднийг юу хүчирхэгжүүлж чадна гэж та нар боддог вэ?

1 Самуел 16

Их Эзэн шинэ хааныг сонгосон нь

Тэрээр дуулгаваргүй байсан учраас Израилд өөр хааныг сонгох болно гэдгийг Саулд хэлжээ (1 Самуел 13:13–14; 15:26–28-ыг үз). Хэрэв та нар шинэ хааныг сонгох болбол, юуг эрж хайх вэ? Та нар 1 Самуел 16-г уншихдаа, шинэ хааныг сонгох талаар Самуелд Их Эзэний хэлсэн зүйлийг ажигла.



Судруудыг ойлгох нь



1 Самуел 16:14–15—“Их Эзэнээс ирсэн муу ёрын сүнс”

Иосеф Смитийн Орчуулга 1 Самуел 16:14–15-ыг муу ёрын сүнс Их Эзэнээс ирээгүй хэмээн өөрчилжээ.

Судруудыг судлах нь



А Төгс Эзэмших Судар—1 Самуел 16:7

Их Эзэн биднийг хардаг арга зам, тэрчлэн бид бусдыг хардаг арга замын талаар 1 Самуел 16:7 бидэнд юу заадаг вэ?

Б Хөгжмийн хүч

1. Бидний мэдрэмжид нөлөөлөх агуу хүч хөгжимд байдаг. Давидын хөгжим Саулд яаж нөлөөлсөн бэ?
2. Давидын хөгжим Саулд зөвхөн түр зуур нөлөөлснийг бид ойлгох ёстой. Эдгээр мэдрэмжүүд илүү их байнгын шинжтэй юуг Саулд өгч болох байсан бэ?
3. Өнөөдөр хүмүүс хөгжмийг Саулын адилаар хэрхэн ашигладаг вэ?
4. Ариун Сүнсний нөлөөг мэдрэхэд өөрт чинь нөлөөлдөг нэг дуулал буюу дууг нэрлэ.

1 Самуел 17

Давид Голиат хоёр

Давид, Голиат хоёрын түүх бол Библи дэх хамгийн алдартай түүхүүдийн нэг юм. Та нар 1 Самуел дахь уг түүхийг энэ удаад уншихдаа, Давид өөрийн хүч чадал, эр зоригийн эх сурвалжийг юу гэж үзэж байсныг эрж ол. Бас дараахтай адил асуултуудыг өөрөөсөө асуу: Бүлэг 16 дахь үйл явдлууд бүлэг 17 дахь үйл явдлуудад ямар нөлөө үзүүлж болох байсан бэ? Давид Их Эзэний бошиглогчоор “тослогдон адислагдсаны” дараа Голиатыг ялсан нь яагаад чухал ач холбогдолтой байсан бэ?

1 Самуелын бүлэг 17 нь: Та нарын амьдралд ямар “Голиатууд” байдаг вэ? Өөрсдийнхөө “Голиатуудыг” даван туулахад хүч чадал өгч чадах ямар гэрээнүүдэд та нар Их Эзэнтэй орсон бэ? Их Эзэний амлалтуудад

итгэх өөрийн итгэлийг харуулахын тулд Давидын хийсэн зүйл та нарын амьдрал дахь нөхцөл байдлуудад хэрхэн холбогдох вэ? гэхчлэнгийн асуултуудын хариултын талаар бодоход та нарт тусалж болно.

Судруудыг ойлгох нь



1 Самуел 17

Ирүүл дайчин (ш. 4, 51)—
Бүх цэргийг төлөөлж, нөгөө талын цэргийн төлөөлөгчтэй халз тулалдаж, хэн ялагч болохыг шийддэг хүн
Зургаан тохой, нэг сөөм (ш. 4)—Уртын хэмжүүр

Хайрст хуяг (ш. 5, 38)—
Жижиг төмөр хэсгүүдийг хооронд нь залгаж хийсэн хуяг

Шекел (ш. 5, 7)—Хүндийн хэмжүүр

Ефа (ш. 17)—Бушелиэс (36,3 л) арай их хэмжүүрийн нэгж

Судруудыг судлах нь



1 Самуел 17 -г судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А–В) хоёрыг хий.

А Тэд юу хэлсэн бэ?

- 1 Самуел 17-дахь дараах хүмүүс: Голиат, Иесси, Елиаб, Давид, израил эрчүүд тус бүрийн хэлсэн нэг зүйлийг тэмдэглэ.
- 1 Самуел 17-д Давидын хэлсэн буюу хийсэн хоёр чухал зүйлийг юу гэж боддогоо бичиж, яагаад гэдгийг тайлбарла.

Б Зураг зур

Давид Голиат хоёрын түүхийн зарим хэсгийг зурахын тулд 1 Самуел 17 дахь мэдээллийг ашигла.

В Жагсаалт хий

- Танай бүс дэх өөрийн чинь насны, Сүмийн хүмүүст учирдаг хамгийн том гурван уруу таталгыг юу гэж боддогоо жагсаан бич.
- “Хувь хүнийхээ сорилтуудыг даван туулах нь” сэдвээр үг хэлэхэд ашиглах таван санаа буюу ишлэлийг 1 Самуел 17-гоос жагсаан бич.

1 Самуел 18–23

Саул Давидын амь насыг эрэлхийлсэн нь

Голиатыг ялсны дараа Давид үндэсний баатар болов. Түүнийг Саултай хамт амьдар гэж урихад тэрээр Саултай нягт хамтран ажиллаж, Саулын хүү Ионатантай дотнын андууд болжээ. Давид нэрд гарсанд Саулын атаархах нь улам нэмэгдэж, Давидыг алах гэж

нилээд хэдэн удаа оролдохдоо Давидын дайснуудаар түүнийг алуулахыг хичээсэн аж.

1 Самуел 18–23 Саул Давидын амь насыг бүрэлгэх гэж оролдоход Давид зугтаж, Саулаас нуугддаг. Эдгээр хэрэг явдлуудын туршид Давид Ионатан хоёр үерхлээ хадгалсаар байв. Нилээд хэдэн тохиолдолд, Ионатан Давидыг аюулаас хамгаалахад тусалжээ.

Бурханы хувьд зөв шударга байхыг эрэлхийлж байсан Давид, дуулаваргүй байдал хийгээд наманчлах хүсэлгүй байсан нь өөрийг нь Бурханы нөлөөнөөс тасалсан Саул нарын хоорондох ялгаа улам өссөөр байсныг бид эдгээр бүлгүүдээс хардаг. Саул улам бүр ёс бус, алуурчин шинжтэй болж байхад, Давид чөлөөлөлтийн төлөө Их Эзэний туслацааг хүлээн авч байлаа.

Эдгээр бүлгүүдийн төгсгөлд, Давид өөрийг нь Израилын хаан болохыг хүсэн хүлээж байсан олон дагалдагчидтай болсон байдаг.

1 Самуел 24

Их Эзэний тослогдогсдыг хүндэтгэх нь

Саул Давидын амь насыг бүрэлгэхийг оролдсон нилээд хэдэн тохиолдлыг 1 Самуел 18–23-т цэдэглэсэн байдаг. 1 Самуел 24-т Саулын амь насыг бүрэлгэх боломж Давидад гарсан боловч тэрээр үүнийг ашиглаагүй тухай бидэнд өгүүлдэг. Тэрээр үүнийг үйлдээгүйн шалтгаан нь Их Эзэнээр дуудагдсан хүмүүсийг хүндэтгэж, тэдэнд үнэнч байх талаар чухал сургамжийг бидэнд зааж чадна.

Судруудыг судлах нь



А Та нар хэрхэн хариулах вэ?

Саулыг алаагүй Давидын шалтгааныг найз нар чинь өөрийн чинь дэргэд Сүмийн удирдагчдыг шүүмжилдэг нөхцөл байдалтай холбон авч үз. Үүнд та нар хэрхэн хариулахаа бич.

1 Самуел 25–26

Дайснуудаа хайрла

Өөрийг нь алахыг хичээж байсан Саулд Давид найрсаг байдлаа харуулж байлаа. 1 Самуел 25-д тэрээр Саулд хандаж байсныхаа нэгэн адил тийм байдлаар бусдад хандаж байхыг Давидад заасан байдаг. Набал гэдэг нэртэй нэг

хүнээс Давид болон түүний хүмүүс жаахан юмс гуйжээ; Набал тэдэнтэй бүдүүлгээр харьцсан аж. Хариуд нь Давид болон түүний хүмүүс дайрахаар бэлтгэж. Набалын эхнэр Абигаил болж байгаа юмсыг сонсоод, Давид дайрч, нөхрийг нь алахаас түүнийг ухаалгаар сэрэмжлүүлжээ. Давид хэрэг явдлын өрнөлд өөрийнх нь хонзогногч үйлдэл зөв бишийг ойлгосон аж. Тун удалгүй Набал нас барж, тэгээд уг асуудал ч нэг тийш болжээ. Набалыг үхсэний дараа Давид Абигаилтай гэрлэж эхнэрүүдийнхээ нэг болгожээ.

Есүс Уулан дээр өгсөн Номлолдоо, “дайснуудаа хайрла” бас “та нарыг хавчдаг хүмүүсийн төлөө залбир” (Матай 5:44) гэж хэлсэн байдаг. Мянга гаруй жилийн тэртээ, Давид Саултай харилцахдаа эдгээр зарчмуудыг амьдралд хэрэгжүүлж байжээ. Та нар уншихдаа, зөвхөн энэ бүлэгт төдийгүй, өнөөдрийн бидний амьдралд бүр ч илүү чухал холбогдолтой, Ерөнхийлөгч Ховард Хантерын дараах мэдэгдлийн тухай бодож үз:



“Энэ зөвлөгөө [дайснуудаа хайрлах] дангаараа таны болоод миний хөршүүдэд, таны болоод миний хүүхдүүд дунд нь амьдардаг хамт олноудад, дэлхийн бөмбөрцөг даяарх бидний агуу гэр бүлийг бий болгодог үндэстнүүдэд хэрхэн нөлөөлөхийг бодоод үз л дээ. Энэ сургаал чухал сорилт бий болгогчийг

би ойлгож байна, гэвч энэ бол дэлхийд учирсаар байгаа дайн дажин, ядуурал хоосрол, өвчин эмгэгээр бидэнд тулгардаг аймшигт хүнд хэцүү үүрэг зорилгуудыг бодвол илүү хүлээн авч болохуйц сорилт гэдэг нь бат ноцтой юм.

“Биднийг гомдоосон, биднийг буруу ойлгосон, бидэнд шударга бусаар буюу найрсаг бусаар хандсан, эсвэл бидний эсрэг нүгэл үйлдсэн үед бид хэрхэн үйлдэх ёстой вэ? Хэрэв өөрсдийн маань хайртай хүмүүс биднийг гомдоосон бол, эсвэл албан тушаал ахисан улмаас биднийг тоохгүй болсон бол, эсвэл бидэнд хилсээр ял тулгасан бол, эсвэл биднийг итгэл үнэмшлийг шударга бусаар дайран довтолсон бол бид яах ёстой вэ?”

“Бид хариуд нь тэмцэх үү? Бид бүр илүү их хүчийг тийш нь хаях уу? Бид нүдийг нүдээр, шүдийг шүдээр хариулснаар . . . энэ нь эцэстээ биднийг хараагүй, шүдгүй болгож орхихыг хүлээн зөвшөөрөхөд хүрэх үү?” (in Conference Report, 1992 оны 10-р сар, 23; Ensign, 1992 оны 11-р сар, 18).

Судруудыг судлах нь

A Харьцуулалт хий

1 Самуел 18:10–11; 19:9–12; 24:1–2-т Саул Давидад хэрхэн хандахыг хичээж байсныг эхлээд унш, дараа нь 1 Самуел 24; 26-д Давид Саулад хэрхэн хандсаныг нэгтгэн дүгнэ. 1 Самуел 26:23 дахь Давидын мэдэгдэл, 1 Самуел 26-д тэрээр юу хийсэн, бас яагаад үүнийг хийсэн тухай юуг бидэнд өгүүлдэг вэ? Давидын үлгэр жишээг амьдралдаа хэрэглэх арга замын талаар бодож, өнөөдрөөс үүнийг хийж эхэл.

1 Самуел 27

Давид филистчүүдийн дунд

1 Самуел 26 дахь үйл явдлуудын дараа Давид Саулд итгэхээ больсон байлаа. 1 Самуел 27-д Давид зугтаж, филистчүүдийн дунд хэсэг хугацаагаар амьдарчээ. Хиймэл шүтээн шүтэгч, ёс бус бүх хүмүүсийг уг нутгаас устгах тухай израилчуудад өгсөн Их Эзэний анхны зарлигуудыг биелүүлэхийг тэр үеийн туршид тэрээр хэрхэн хичээж байсан тухай бүлэг 27 бас өгүүлдэг.

1 Самуел 28

Саулын сүнсний харанхуй

Саулын амьдралын хамгийн доод цэг 1 Самуел 28-д цэдэглэгдсэн бололтой. Тэрээр Израилыг хэрхэн удирдах ёстой талаар Бурханаас ямар ч илчлэлт хүлээн авч чадахгүй болсон учир, Саул сүнс дуудагчид буюу зөвлөгөө, зөвлөмжийн төлөө үхсэн хүмүүсийн сүнсстэй холбоо тогтоохыг эрэлхийлдэг хүмүүсээс туслалцаа авч болох эсэхийг мэдэхийн тулд тэрээр нэгэн төлөгч эм рүү очжээ. Бүлэг 28-д нөгөөх төлөгч эм, бошиглогч Самуэлыг үхэгсдээс дуудан авчирлаа хэмээн мэдэгджээ. Нас барсан бошиглогчид төлөгч эмсийн дуудлагад хариулдаггүй бөгөөд Саулын амьдралд тохиосон зүйлд мэдээж бах нь ханасан байх ёстой чөтгөрийн нөлөөн дор уг үйл явдал бүхэлдээ болж өнгөрсөн нь тодорхой гэж Ерөнхийлөгч Жозеф Фиелдинг Смит хэлжээ (Answers to Gospel Questions, 5 боть. [1957–66], 109-ийг үз).

1 Самуел 29–31

Давидын амжилт ба Саулын үхэл

1 Самуел 29–31-д филистчүүд израилчуудыг хэрхэн дахин нэгэнтээ довтолхоор шийдсэнийг цэдэглэдэг. Давид тэдний эсрэг эргэж магадгүй хэмээн санаа зовсноос тэд түүнийг нутгаасаа гарч явахыг хүссэн аж. Давид болон түүний эрчүүд явав. Давид болон түүний эрчүүд явахдаа ч хиймэл шүтээн шүтэгч, Израилын дайснуудыг устгахаа үргэлжлүүлсээр байв. Давид эд хогшил, мал сүрэг олж

авсан үедээ тэдгээрийн зарим хэсгийг Иудагийн хот бүрд явуулж байлаа. Давид ийм замаар Саул үхэж, тэрээр Израилыг удирдаж болох цагийн төлөө дэмжлэг бий болгож эхэлсэн ажээ.

1 Самуелын ном Израилын анхны хааны үхлээр төгсдөг. Тэд филистчүүдийн эсрэг тулалдаанд ялагдах нь гэдгийг

Саул харжээ. Саул филистчүүдийн гарт орж үхсэнээс, өөрийнхөө зэвсэг үүрэгчээс амийг нь егүүтгэхийг хүссэн хэдий ч, зэвсэг үүрэгч нь ингэсэнгүй. Иймээс Саул илдээ авч, дээрээс нь унан, амиа егүүтгэжээ.

Самуелын хоёр дугаар ном

Хоёр дахь хааны түүх

Саулын түүх Израилын анхны хааны түүхийн хувьд 1 Самуелд байдаг бол, 2 Самуел нь хоёр дахь хаан Давидын түүх юм. Самуел 1 Самуелын төгсгөлөөс өмнө нас барсан учир 2 Самуелыг бичиж чадаагүй ажээ. 1–2 Самуелын талаар дэлгэрэнгүй мэдээллийг Судруудын Удирдамж, “Самуел, түүний номнууд”-аас үз.

2 Самуел дахь чухал хүмүүс

Ишбошет—Эцгийнхээ үхсэний дараа хаант улсыг шаардсан, Саулын хүү

Абнер—Эхлээд Ишбошетыг дэмжиж байсан боловч дараа нь Давидтай нэгдсэн Саулын цэргийн жанжин

Иоаб—Абнерыг алсан, Давидын цэргийн жанжин

Мефибошет—Давидаар хүндлэгдэн, хамгаалагдсан, Ионатаны тахир дутуу хүү

Батшеба—Давидтай садар самуун үйлдсэн эмэгтэй

Уриа—Эхнэртэй нь гэрлэхийн тулд Давидын алсан, Батшебагийн нөхөр

Натан—Давидын үе дэх бошиглогч

Амнон—Өөрийнхөө дүү Абсаломд алуулсан, Давидын хүү

Абсалом—Ахыгаа алж, хаант улсыг эцгээсээ булаан авахыг оролдсон, Давидын хүү

2 Самуел 1–3

Саулын үхлийн дараа

1 Самуелын сүүлчийн бүлэгт, Саул өөрийн зэвсэг үүрэгчээс амиа егүүтгэхийг хүссэн тухай бид уншидаг. Тэр хүн ингээгүй учраас Саул илдэн дээрээ унаж үхдэг. 2 Самуел 1-д өөрийгөө Саулыг алсан хүмүүсийн нэг хэмээн мэдэгдсэнээр Давидын ивээлийг олж болно хэмээн бодсон нэг хүний тухай түүхийг өгүүлдэг. Энэ хүн бас Саул хаан байсныг гэрчилсэн титэм, бугуйвчийг Давидын өмнө авчирсан аж. Саул, Ионатан хоёр үхсэнийг Давид мэдээд, гашууджээ. Саулын үхлийн төлөө сайшаал хүлээх гэсэн нөгөөх хүнийг ч тэрээр цаазлуулжээ.

2 Самуел 1-ийн сүүлчийн шүлэг бол нэг Дуулал буюу уг үйл явдлаар Давидын бичсэн дууны үгс юм.

Тэгээд Давид Иудагийн нутаг уруу явахаар Их Эзэнээр чиглүүлэгджээ. Тэнд хүмүүс түүнийг Иудагийн хаан болгов. Тэр үед Саулын цэргийн жанжин Саулын хүү Ишбошетыг Израилын үлдсэн хэсгийн хаан болгоход тусалсан аж. Давидын хүмүүс, Ишбошетын хүмүүсийн хоорондох зарим тэмцэлдээнийг 2 Самуел 2–3-т тайлбарласан байдаг. Давид дайснуудынхаа эсрэг өс хонзон авах замаар үйлдэх хүсэлгүй байсныг ойлгоход эдгээр бүлгүүд бидэнд тусалдаг.

2 Самуел 4–5

Давид хаан болов



2 Самуел 4-т, Давидын ивээлийг эрэлхийлэгч хүмүүс эцэстээ Ишбошетыг алж, толгойг нь Давидад авчирсныг үздэг гэсэн байдаг. Тэдний үйлдлийн төлөө Давид эдгээр хүмүүсийг цаазлуулсан аж. Саул өөрийг нь хөнөөхийг элдвээр хичээж байсан ч гэсэн,

Давид Саулыг болон түүний гэр бүлийг хайрлан, хүндэтгэдэг байжээ. Ишбошет үхсэнээр, Израилын удирдагчдын үлдсэн хэсэг Давид уруу хүрч ирэн, өөрсдийнхөө хаан болохыг түүнээс хүсжээ.

Гурван гүнзгий хөндийгөөр хүрээлүүлсэн, байгалийн өндөр толгой дээр байрласан, тэр үед эзэлж авах нь бараг боломжгүй мэт санагддаг байсан хот—Иерусалимын хотыг Давид хэрхэн эзэлснийг—2 Самуелын бүлэг 5-т өгүүлдэг. Эдгээр хөндийнүүдийн улмаас Иерусалимыг хамгаалахад тун амархан байсан аж. Иерусалим бол эзэлж авахад чухал хот байсан нь юу вэ гэвэл хот Исаакийг тахилд өргөхөөр Абрахамын очсон Мориа Уулыг өөртөө багтаадаг байж. Давид Иерусалимыг Израилын улс төрийн гол хот болгосон аж.

2 Самуел 6

Гэрээний авдар Иерусалимд ирэв



Израилчууд гэрээний авдрыг филистчүүдээс эргүүлж авсны дараа, авдрыг аюулгүй газарт байрлуулж, дахин олзлуулахаас сэргийлэн хамгаалах болжээ. 2 Самуел 6-д Давид Иерусалимыг хэрхэн Израилын улс төрийн гол хот болгон үндэслэсэн хийгээд гэрээний авдрыг энд байлгахгаар шийдсэн нь тэдний улс төрийн гол хотод Их Эзэн тэдэнтэй хамт байдгийг бэлгэдсэн тухай өгүүлдэг.

2 Самуел 7

Давид ариун сүм барихыг хүссэн нь

Хэрэв чи Их Эзэн болон түүний Сүмд зориулж, маш онцгой чухал нэг зүйл хийе гэж бодож, төлөвлөөд байтал тэрээр өөр зүйл хийхийг чамаас хүссэнийг мэдвэл чамд ямар санагдах вэ? 2 Самуелын бүлэг 7 нь чухамдаа яг ийм зүйл Давидад тохиолдсоныг үздэг гэсэн байдаг. Та нар уншихдаа, Их Эзэн өөрт нь хэлсэн зүйлд Давид хэрхэн хариулсныг ажигла.

Судруудыг ойлгох нь



2 Самуел 7:11—Ямархуу маягийн өргөө барьж өгөхийг Их Эзэн Давидад амласан бэ?

Их Эзэнд зориулан барихаар Давидын хүсэж байсан “өргөө” бол ариун сүм байлаа. Их Эзэн Давидад барьж өгөхөөр амласан “өргөө” бол үр удам—ялангуяа захирагчдын үр удам байлаа. Хэдийгээр ариун сүм барихыг Давидад зөвшөөрөөгүй ч гэсэн (доорх А үйл ажиллагааг үз), Их Эзэн Давидад өөрийн амласан өргөөг барьсан юм. Иудагийн хаад бол Давидын үр удам байлаа, түүнчлэн Хаадын Хаан—Есүс Христ өөрийг нь дагах бүх хүмүүст ирэх дэлхийд “харшүүд” олж авахад нь туслахыг хангалттай сонирхолтойгоор амласан билээ (Иоанн 14:1–3-ыг үз).

Судруудыг судлах нь



А Бусад судраас олж авах ойлголт

Шастирын Дээд 22:7–8-ыг уншиж, Давид байнгын ариун сүм барихыг Их Эзэн яагаад хүсээгүйг тайлбарла.

Б Давидад ямар санагдсан бол?


1. 2 Самуел 7-гийн оршлыг дахин уншиж, хэрэв та нар Давидынхтай адил нөхцөл байдалд орсон бол ямар санагдах байсан тухай бод. Дараа нь 2 Самуел 7:18–29-ийг уншиж, Их Эзэний түүнд хэлсэн зүйл Давидад ямар санагдсан тухай ярь.
2. Давидын бодол санааг хамгийн сайн илэрхийлсэн гэж өөрийн боддог шүлгийн хэсгүүдийг тэмдэглэлийнхээ дэвтэрт бичиж, судрууддаа тэмдэглэ.
3. Давидад яагаад тэгж бодогдсоныг тайлбарла.

2 Самуел 8–10

Давидын улс төрийн болон хувийн амжилт

2 Самуел 8, 10 бол Бурхан израилчуудад амласан нутгийг Давид хэрхэн эзэлсэн тухай дүрслэл юм. Иошуагийн үеэс тэдэнд амлагдсан нутаг дахь хүмүүсийг байлдан дагуулахыг Их Эзэн израилчуудад зарлиг болгосон хэдий ч, Давид бол уг зарлигийг хамгийн бүрэн дүүрэн, эцэслэн биелүүлсэн хүн байлаа. Үүний хамт, тэрээр өөрийн хүмүүсийг шударгаар захирч байсныг үздэг өгүүлдэг. 2 Самуелын бүлэг 9 нь Саулын гэр бүлийг харж хандан анхаарал халамж тавих тухай Саулын хүү Ионатанд өгсөн амлалтаа тэрээр хэрхэн биелүүлсэн тухай шастир дахь Давидын шударга зан чанарын агуу үлгэр жишээг агуулдаг.

Давидын эзэнт гүрэн



- Эзэнт гүрний хил оргил үедээ
- ▨ Эхний үед Давидын эзэлсэн нутаг
- ▨ Саулын хаант улс

Судруудыг судлах нь

А Та нар юу гэж бодож байна вэ?

2 Самуел 9-д Саулын үр удмынхны нэгний төлөө Давид яагаад тэр зүйлийг хийсэн юм бол гэж зарим хүмүүс гайхаж болох вэ?

Б Судрыг ол

Давидын хийсэнтэй адилаар үйлдэхийг бидэнд заадаг судрын шүлгийг 2 Самуел 9-өөс ол. Шүлгийг тэмдэглэлийн дэвтэртээ бичиж, өөрөө яагаад үүнийг сонгосноо тайлбарла. Уг шүлэлийг өөрсдийнхөө Библи дэх 2 Самуел 9-ийн зах дээр бич.

2 Самуел 11–12

Давидын ЭМГЭНЭЛТ алдаанууд

Заримдаа бид амьдралдаа гаргадаг зарим “жижигхэн” шийдвэрүүдийн ач холбогдлыг ухаардаггүй. Ахлагч Гордон Б. Хинкли, төмөр замын нэг компанид ажиллаж байхад нь түүнд тохиолдсон нэг туршилагын талаар ярихдаа жижигхэн шийдвэрүүдийн ач холбогдлын нэгэн жишээг өгсөн байдаг. Нью Жерсигээс түүнд утасдаж, зорчигчдын галт тэрэг тээшний вагонгүйгээр хүрч ирсэн тухай хэлсэн гэнэ.



“Тэр галт тэргийг Калифорнийн Өүкландад зохих журмаар нь бүрдүүлж, Сейнт Льюист зохих журмаараа хүрч ирсэн байв. . . . Гэвч Сейнт Льюисийн зогсоолд анхааралгүй нэгэн сумчин ердөө л гурван инчийн нэгэн ганг шилжүүлээд тавьчихаж.

“Тэр ган нь шилжүүлэх цэг байсан юм санж, тэгээд Нью Жерсийн Нью Аркт ирэх ёстой вагон гурван зуун милийн тэртээ Льюизианагийн Нью Орлеанд очсон ажээ” (in Conference Report, 1972 10-р сар, 106; Ensign, 1973 оны 1-р сар, 91).

Та нар Давидын тухай анх уншихад, тэрээр Израилын хааны эх загвар мэт харагдах болно. 2 Самуел 1-10 нь улс орныхоо удирдагчийн хувьд түүний олсон их амжилтыг цэдэглэсэн байдаг. Та нар 2 Самуел 11–12-ыг уншихдаа, тэрээр залуу насандаа эхэлсэн өөр “зам” дээр түүнийг тавьсан, Давидын амьдрал дахь “шилжүүлэх цэгүүдийг” эрж ол.

Судруудыг ойлгох нь

2 Самуел 12:1—“Их Эзэн Натаныг Давидад илгээв”

Нүгэл нь Давидынхтай адил ноцтой байгаа үед, наманчлал үнэн бөгөөд чин сэтгэлийн байгаа үед, нүгэл үйлдэгч нь Бурханд, гомдоосон хүндээ, түүнчлэн өөрийн санваарын удирдагчид гэмшлээ хүлээдэг (С ба Г 58:42–43-ыг үз). Гэвч Натантай хийсэн Давидын ярилцлага, Давид Батшебагаас

төрсөн хүүхдийн эцэг болсны дараа болсон ажээ. Тиймээс, уг ярилцлага Давидын эхний зөрчлөөс хойш наад тал нь есөн сарын дотор болох ёстой байв. Түүнээс гадна, Давид Натанд гэмшлээ хүлээхээр очихын оронд Их Эзэн Натаныг Давид уруу явуулах учиртай байв. Тийм урт хугацааны дараа түүний нүглийн тухайд түүнтэй нүүрэлдэхийн тулд Натан Давид уруу очих ёстой болсон Давидын гэмшил, наманчлалын тухай та нар юу мэдсэн бэ?

Судруудыг судлах нь

Та нар судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А–Д) хоёрыг хий.

А Шилжүүлэх цэгүүд

Дараах хүснэгтийг тэмдэглэлийн дэвтэртээ хийж, дараа нь 2 Самуел 11-ээс өөрсдийн мэдсэн мэдээллээр, мөн түүнчлэн хувийнхаа санал бодлуудаар бөглө. Дунд талын багананд нэгээс дээш зүйл байж болно.

Давидын амьдралыг өөрчилсөн шийдвэрүүд		
Шүлэг	Давид юу хийсэн бэ	Давид юу хийх ёстой байсан бэ
1		
2		
3		
4		
6–8, 14–17		
26–27		

Б Шилжүүлэх цэгүүд өнөөдөр

“Шилжүүлэх цэг” бүр нь Давидыг нүгэл уруу улам бүр ойртуулдаг байсныг та нар ажигласан байх. Өөрийнхөө насны хэн нэгэнд товч захидал бичиж, “шилжүүлэх цэгүүд” ёс суртахуунгүй үйлдлүүд рүү хөтөлж мэднэ гэдэгт итгэдэг тухайгаа хуваалцаж түүнийг сэрэмжлүүл. *Залуучуудын Бат Бөх Байдлын Төлөө* товхимол (34285) зарим зөвлөмжүүдээр хангаж чадна. Ийм сонголтуудын үр дагавруудыг харахад нь уг хүнд туслахын тулд Давидын түүхийг бас ашигла.

В Сургаалт зүйрлэлийг тайлбарла

2 Самуел 12:1–4 дэх Натаны сургаалт зүйрлэл Давидад хэрхэн холбогдохыг тайлбарла. Сургаалт зүйрлэлийн хэсэг бүр нь юуг төлөөлж байгааг ярь.

Г Гэмшлийн мэдрэмжүүд

Натантай ярилцсаныхаа дараа нэгэн үед, Давид Дуулал 51-ийг бичжээ. Дуулал 51-ийг уншиж, та ямагт залбирч болох учраас нүгэл гэгч юу ч биш гэдэгт итгэдэг хүнд Давид юу гэж хэлэх байсан гэж бодож байгаагаа бич (мөн С ба Г 132:38–39-ийг үз).

Д Том өөрчлөлт

Давид Голиаттай тулалдах үед ямар хүн байсныг, тэрээр 2 Самуел 11–12-т ноцтой нүгэл үйлдэхдээ ямар хүн болсонтой харьцуул. Яагаад ийм их ялгаа гарсан гэж та нар бодож байна? Хүмүүс юуны улмаас ийм огцом өөрчлөгддөг вэ?

2 Самуел 13–14

Давидын хүүхдүүдийн нүгэл

Нүгэл бидний эргэн тойрон дахь хүмүүс—ялангуяа бидний гэр бүлийнхэнд ямагт нөлөөлдөг. Эцэг эхчүүдийн үлгэр жишээ хүүхдүүдийн зан төлөвт олонтаа нөлөөлдөг. Бүр тэрч байтугай, эцэг эхчүүд муу үлгэр дуурайл үзүүлдэг бол хүүхдүүдийнхээ ийм муу зан авирыг засч залруулах нь бүр ч хэцүү байдаг. Та нар 2 Самуел 13–14-ийг уншихдаа, Давидын хөвгүүдийн үйлдлүүд түүний өөрийнхтэй нь хэрхэн адил байгаа тухай бод. Хэрэв та нар ийм нөхцөл байдалд байсан бол яах байснаа бас бодож үз.

Судруудыг ойлгох нь

2 Самуел 13

Тэр намайг танаас харамлахгүй (ш. 13)—Тэр таныг : надтай гэрлэхийг зөвшөөрөх болно

2 Самуел 14

Очийг минь унтрааж (ш. 7) : варгүйгээр орхиж” гэсэн
—Галыг минь унтрааж (Энэ : утгатай)
нийлмэл үг “намайг найд- : Удам (ш. 7)—Хүүхдүүд

2 Самуел 13—Аммон эгчийгээ хайрлахын оронд түүнийг үзэн ядав

Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон хэлэхдээ, “Ёс суртахуунгүй явдалд удаан үргэлжлэгч баяр хөөр гэж байдаггүй. . . Зөвхөн үүний эсрэг зүйл байдаг нь л үнэн. Түр зуурын баяр хөөр байж болно. . . Гэвч харилцаа нь ээдэж гашлах болно. Гэм буруу, ичгүүр бий болно. . . Хайр мөхөж эхэлнэ. Хорон санаа, атаа жөтөө, уур хилэн, тэр ч байтугай үзэн ядалт өсч эхэлнэ. Энэ бүгд бол нүгэл, зөрчлийн жам ёсны үр дагаврууд юм.



“Нөгөө талаар, бид ариун явдлын хуулийг сахьж, өөрсдийгөө ёс суртахууны хувьд цэвэр ариун байлгах юм бол, бид өсөн нэмэгдсэн хайрын хийгээд амар амгалангийн адислалуудыг хүртэж, ханийнхаа илүү их итгэл, хүндэтгэлийг хүлээж, бие биендээ илүү гүн гүнзгийгээр тагтдаг болно, мөн үүнээс үүдэн, баяр хөөр, аз жаргалын гүнзгий, чухал утга учиртай мэдрэмж бий болдог” гэжээ.

(“The Law of Chastity,” in *Brigham Young University 1987–88 Devotional and Fireside Speeches* [1988], 51).

Судруудыг судлах нь

А Уншаад, хариул

2 Самуел 14:14-ийг уншаад: Бурхан өөрийнхөө дэргэдээс “хөөгдсөн” хүмүүсийг Өөрөөсөө бүрмөсөн “хөөхгүй” байхад тэдэнд туслахын тулд ямар “арга замуудыг” (төлөвлөгөөнүүдийг) төлөвлөсөн бэ? гэсэн асуултанд хариул.

2 Самуел 15–18

Абсалом хаан болохыг эрэлхийлсэн нь

2 Самуел 14-ийн сүүлчийн шүлэг Абсалом Иерусалимд эцэг Давидаараа хэрхэн хайраар хүлээн авагдсан тухай өгүүлдэг. 2 Самуелын бүлэг 15 нь Давид хааныг түлхэн унагахын тулд Абсалом хүмүүсийн дэмжлэг олж авахаар хэрхэн явсан тухай өгүүлдэг. Абсалом хүмүүсийн дунд таашиал олж буйг Давид сонсоод, уг үйл явдлыг өөрийнхөө үйлдсэн зүйлүүдийн төлөөх Бурханы шийтгэл хэмээн харжээ. Их Эзэн түүнд нигүүлсэнгүй хандах байх гэсэн найдвар өвөрлөн, тэрээр даруухан байдалтайгаар Иерусалимыг орхисон ажээ.

Өөрийгөө шинэ хаан болгох гэсэн Абсаломын оролдлогын түүх 2 Самуел 16–17-д гардаг. Улс төрийн таашиал олохыг найдсан, Давидын зөвлөхүүд, үйлчлэгчдийн заримыг нь тэрээр хүлээн авсан аж. Тэдний нэг нь Абсалом одоо хаан болсны бэлгэдэл болгож, эцгийнхээ татвар эмсийн нэгэнтэй унтахад түүнийг өдөөн тухирчээ. Энэ нь Натаны бошигلولуудын нэгийг гүйцэлдүүлсэн аж. (2 Самуел 12:11–12-ыг үз).

Эцэст нь, Абсаломыг Давид болон түүний эрчүүдтэй тулалдахаар явахад өдөөн тухирсан байна. Иоаб Абсаломыг хэрхэн олж, алсан тухай түүх 2 Самуел 18-д гардаг. Энэ мэдээг сонсоод Давид уйлжээ. Давидын уйлсан шалтгаануудын нэг бол өөрийнх нь нүглүүд хүүхдүүдийнх нь амьдралд туссаныг тэрээр харсных биз ээ.

2 Самуел 19–20

Давидын гай зовлон үргэлжилсэн нь

2 Самуел 19 нь Абсаломын үхлийн төлөөх Давидын гашиудал үргэлжилсэн тухай өгүүлснээр эхэлдэг. Тэрээр өөрийг нь хааны хувьд түлхэн унагаах гэж оролдон, түүний эсрэг тулалдахаар явсан хүний төлөө гашиудан үйлсан гэж олон хүмүүс учраа олохгүй байна гэж Иоаб Давидад ярьжээ. Давид дайснуудаа хайрладаг, харин найз нараа үзэн яддаг бололтой хэмээн Иоаб ярьсан аж. 2 Самуел 19-ийн үлдсэн хэсэг нь Давид Иоабын зөвлөгөөг хэрхэн хүлээн авч, найз нар хийгээд хуучин дайснуудтайгаа аль алинтай нь найрсгаар харьцахыг хичээдэг болсон тухай өгүүлдэг. Жишээ нь, Иудагийн овог ерөнхийдөө Абсаломыг дэмжиж байсан аж.

Давид өөрийгөө дэмжихэд Иудаг дахин нэгэнтээ урьж, тэдний нэгэнд өөрийнхөө цэргийг хариуцуулах болно хэмээн хэлжээ. Гэвч энэ нь, Иоаб, Израилын бусад овгууд аль алиныг нь уурлуулав. Израилын бусад овгуудын эсэргүүцэл нь тэд өөр хүнийг хаан болгох оролдлого болж хувирсан тухай 2 Самуел 20-д цэдэглэсэн байдаг. Цэргийнхээ удирдлагад Давидын тавьсан хүнийг Иоаб алсны дараа, Иоабаар удирдуулсан Давидын эрчүүд эсэргүүцлийг даржээ.

2 Самуелын бүлэг 19–20 нь Давидын хүслүүд ихэвчлэн сайн боловч, түүнийг залуу эр байхад түүнд байсан уужуу мэргэн ухаан түүнийг орхин оджээ гэсэн сэтгэгдлийг бидэнд үлдээдэг.

2 Самуел 21–23

Давидын тухай өөр зүйлүүд

2 Самуел 21 дэх түүх нэг бол буруу орчуулагдсан, нэг бол Давид үнэхээр урвалтад гүнзгий унасныг харуулдаг. Өвөг эцгийнх нь хийсэн ямар нэг зүйлийн төлөө ач хөвгүүдийг нь үхэлд хүргэхийг Бурхан хэзээ ч сайшаадаггүй билээ. Өлсгөлөнг дуусгавар болгохын тулд Бурхан хүмүүнээс золиослол шаарддаг байсан гэсэн санаа бол хиймэл шүтээн шүтэх сургаал лугаа адил, ердөө л хуурамч сургаал юм.

2 Самуелын бүлэг 22–23 бол Давидын түүхийн үргэлжлэл үнэхээр биш боловч, Давид болон түүний хаант улсын тухай зарим зүйлүүдийг зохиогч хураангуйлан дүгнэхийн тулд 2 Самуелын төгсгөлд байрлуулсан бололтой. 2 Самуелын бүлэг 22 бол Давидын дуулал юм. Бүлэг 23 нь Давидын “хүчирхэг эрчүүд” буюу түүний цэрэг эрсийн тухай өгүүлдэг.

2 Самуел 24

Давидын өөр алдаануудын тухай

Бүлэг 24 бол 2 Самуелын төгсгөлийн бүлэг; энэ нь Давид Израилын хүмүүсийг тоолох буюу хүн амын тооллого хийхээр шийдсэнийг цэдэглэдэг. Үүний улмаас Их Эзэн түүнд дургүй байсныг уг цэдэг нотолдог. Давид хүмүүсийг тоолох гэсэн нь тэрээр хэрэг дээрээ хэр зэрэг амжилттай хаан байснаа үзэх гэсэн бололтой. Гэвч Израилын дайснуудыг байлдан дагуулахад Давидад хүч чадал өгсөн хүн нь Их Эзэн байлаа. Давидын нүгэл Израилын амжилтын төлөөх гавьяаг нь сэвтүүлсэн юм.

2 Самуел 24-ийн сүүлчийн хэсэгт, Давид нэг хүнээс үтрэм худалдаж авдаг. Тэр үтрэм дээр Давид нүглүүдийнхээ төлөө Их Эзэнд тахил өргөдөг. Энэ үтрэм бол Абрахам Исаакийг тахилд өргөх гэсэн уламжлалт газар, бас Давидын хүү Соломон ариун сүм барьсан тэр газар байжээ. Өнөөдөр энэ газар дээр лалын шашинтны мөргөлийн сүм байдаг бөгөөд энэ нь “Чулуун бөмбөгөр оройт” хэмээн нэрлэгддэг.

Хаадын дээд Ном

Номын тойм

Хаадын Дээд бол Израилыг хаад захирдаг байсан үе дэх Израилын түүхийг өгүүлдэг дөрвөн бүлэг номны гурав дахь нь юм. Уг ном Давидын дараа Соломон хаан болон сонгогдсоноор эхэлдэг. Энэ ном түүхийн нэг зуун хорь орчим жилийг хамарч, Израилын түүхэн дэх илүү ёс бус хаадын нэг Ахабын түүхээр төгсдөг. Тэнгэр дэх бидний Эцэг уг ажил үүргээс дээгүүр нэгэн, бошиглогч Елиаг илгээж, Ахабтай учруулжээ.

Израилын хамгийн агуу бошиглогч хэмээн олонтаа хүндлэгддэг Елиа Кармел Уулан дээр хуурамч бурхан Баалын дээр Бурханы хүчийг эмгэнэлт үзүүлбэрээр харуулсан юм. Хаадын Дээд нь хэдийгээр улс төрийн зарим түүхийг хүүрнэдэг ч гэсэн, уг ном нь улс төрийн удирдагчид Израилтай Бурханы хийсэн гэрээнүүдийг, ялангуяа хиймэл шүтээний талаарх гэрээнүүдийг хэрхэн сахьдаг байсан тухай түүх юм. Гэрээг сахьдаг буюу сахьдаггүй байсан талаараа хамгийн их

тодорсон хаад, тэрчлэн тэдэнд номлодог байсан бошиглогчид дээр гол анхаарал төвлөрчээ. Бид Хаадын Дээдээс сайн ба муу үлгэр жишээ аль алианаас нь сургамж авч болно.

Баалыг шүтэн биширдэг байсан нь

Хиймэл шүтээн Баалыг шүтэн биширдэг байсан тухай Хаадын Дээд болон Хаадын Дэдэд олон удаа дурдсан байдаг. Баал бол Израилын олон хөршийн хуурамч бурхан байв. Түүнийг шүтэн бишрэгчид тэдний үр тариа ургахад, мал сүрэг нь өсөхөд тэрээр тусалдаг гэдэгт итгэдэг байв. Сатаанаар урамшуулагддаг энэ хуурамч шашинд үүнийг шүтэн бишрэх ёс суртахуунгүй үйлдлүүдийг өөртөө багтаадаг байсан бөгөөд бошиглогчид үүнийг “гутамшиг” гэдэг байжээ (Судруудын Удирдамж, “Баал”-ыг үз). Янз бүрийн цаг үед, олон израилчууд Бурханыг орхиж, үнэн хийгээд амьд Бурханыг шүтэхийн оронд энэ шашнаар өөрсдийгөө бузарлаж байв.

Хаадын Дээдийн цаг хугацааны дараалал



Анхааруулга: Бүх оныг ойролцоогоор авсан болно.

Хаадын Дээд 1–2

Давидын үхэл

Давидыг нас өндөр болж хөгширөхөд, түүнийг таалал төгсөхөөр орыг нь хэн залгамжлах талаар олон хүн боддог байжээ. Хаадын Дээдийн бүлэг 1 Давидын хөвгүүдийн нэг Адониа (Абсаломын дүү), дараагийн хаан болохыг ихэд хүсэж байсан тухай өгүүлдэг. Тэрээр Давидын цэргийн жанжин Иоаб, мөн санваартан Абиатар нарын дэмжлэгийг хүлээжээ. Гэвч Давид Соломонд (Батшебагийн хүү) тэрээр дараагийн хаан болно хэмээн амласан байв. Бошиглогч Натан Батшебагийн хамт Давидад үүнийг сануулж, Соломоныг Израилын дараагийн хаанаар нийтийн өмнө зарлан тунхаглахад түүнийг өдөөн түлхэж байв. Давид өөрийнхөө луусыг Соломонд унуулж явуулсан нь тэрээр Давидыг залгамжлагч болохыг хүмүүст харуулсан өвөрмөц тэмдэг болжээ.

Соломоныг олны өмнө тослон адисалсныг Адониа мэдээд, Соломон түүнийг алах байх гэж айжээ. Гэвч Соломон түүнд хор хүргэхгүй гэж Адониад амлав. Хаадын Дээд 2-т Адониа Давидыг нас барсны дараа эхнэрүүдийнх нь нэгэнтэй гэрлэснээр хаан болохыг дахин нэг оролдоод үзэж. Энэхүү урван тэрсэлсэн үйлдлийнх нь төлөө түүнийг үхэлд хүргэжээ.

Давидын үхлийн тухай шастир бас Хаадын Дээд 2-т байдаг. Давид нас эцэслэхээсээ өмнө Соломонд зааврууд, түүний дотор гэмгүй хүмүүсийн амь насыг хөнөөснийх нь төлөө Иоабыг, Адониаг хаан болгохыг дэмжсэнийх нь төлөө Абиатарыг шийтгэх чиглэл өгчээ.

Судруудыг судлах нь

А Хэлэх үг бэлтгэ

“Хаан Давидын амьдралаас бидний авч болох сургамжууд” сэдвээр чи үг хэлэх даалгавар авчээ гэж бод. Хэлэх үгэндээ оруулах дөрвөн сэдвийг нэрлэ. Сэдэв бүрийн дараа, уг сэдвийг заахад өөрийнхөө ашиглах, Давидын амьдралын нэг түүхийг нэрлэ (үүнийг судруудад хаанаас олсныг заа).

Хаадын Дээд 3

Би чамд юу өгөх вэ?

Хэрэв та нар Их Эзэнээс ямар нэг зүйл авахаар хүсэх боллоо гэхэд, та нар юу хүсэх вэ? Яагаад? Хаадын Дээд бүлэг 3 Соломонд ийм боломж олдсоныг цэдэглэжээ. Түүний хүслийг та нарынхтай хэрхэн харьцуулж болохыг хар.

Судруудыг судлах нь

А Өмнө нь, тэр үед, дараа нь

Хаадын Дээд 3-т, Соломон Их Эзэнийг зүүдэндээ харсан нэгэн онцгой туршлага түүнд тохиожээ. Энэ туршлагын талаар дараах асуултуудад хариул:

Өмнө нь. Хаан байх нь хичнээн хэцүү болохыг Соломонд харуулсан юу аль хэдийн тохиолдсон бэ?

Тэр үед. Соломон яагаад өөр ямар нэг зүйл биш, харин ойлгогч зүрх сэтгэлийг гуйсан гэж та нар бодож байна? Соломоны *гуйгаагүй* ямар зүйлүүд Их Эзэний таалалд нийцсэн байж болох вэ?

Дараа нь. Тэрээр энэхүү сүнсний бэлгийг хаанчлалынхаа эхэнд хүлээн авснаа Соломон хэрхэн харуулсан бэ?

Б Мэргэн ухааныг би яаж хөгжүүлэх вэ?

Дараах судруудыг уншиж, та нар өөрсдийн мэргэн ухаан, ойлголтыг нэмэгдүүлэхийн тулд юу хийж болохыг хэлж байгаа зүйлүүдийг жагсаа: Алма 37:35–37; Сургаал ба Гэрээ 89:18–21; 136:32–33.

Хаадын Дээд 4

Соломон хаант улсыг зохион байгуулсан нь

Хаадын Дээд 4-т Соломон өөрийн хаант улсын засгийн газрыг хэрхэн арванхоёр дүүрэг болгон зохион байгуулсныг товч дүрсэлсэн байдаг. Бүлэг 4 нь бас тэр үе дэх Соломон болон Израилын эд баялаг хийгээд цэцэглэл хөгжилтийг дүрсэлжээ. Соломон болон Израилын мэргэн ухаан хийгээд цэцэглэл хөгжилт нь бусад олон үндэстний удирдагчид Соломоны мэргэн ухаан, зөвлөгөөг эрэлхийлж ирэхээр тийм ихээр нэрд гарсан байлаа.

Хаадын Дээд 5–7

Соломон ариун сүм барив

Давид дайчин хүн байсан учраас, ариун сүм барихыг Их Эзэн түүнд зөвшөөрөөгүй аж. Гэвч түүний хүү энх амгаланд хаанчилж, ариун сүм барих болно хэмээн Их Эзэн Давидад амлажээ. (Шастирын Дээд 22:8–10-ыг үз). Хаадын Дээдийн бүлэг 5–7 нь Соломоны ариун сүм хэмээн нэрд гарсан тэрхүү ариун сүмийг барьсан тухай өгүүлдэг.

Хаадын Дээд 5-д Соломон, Тирийн хаан Хирам хоёрын хооронд гэрээ байгуулагдсан тухай өгүүлдэг. Соломон Ливанаас (Хирамын захирч байсан нутгийн хэсэг) хуш мод авч оронд нь Израилаас улаан буудай, тос өгдөг байж. Түүнээс гадна, Соломон “хөдөлмөрийн татварыг” бий болгосноор израил хүмүүс ариун сүмд зориулан Иерусалимд авчрах хуш модыг бэлтгэхийн тулд Ливанд тодорхой хугацааг өнгөрүүлэх шаардлагатай байлаа.

Хаадын Дээд 6-д ариун сүмийн зарим тавилгууд, түүнчлэн тэдгээрийг хийсэн материалуудын тухай дүрсэлсэн байдаг. Энэ бүлэг бас хэрэв хүмүүс ариун сүмтэй холбоо бүхий хуулиудаар амьдрах юм бол, Их Эзэн тэдний дунд өөрийн өргөөнд орших болно хэмээн Соломонд өгсөн Их Эзэний амлалтыг цэдэглэжээ.

Хаадын Дээдийн бүлэг 7 нь ариун сүм барихад ердөө долоон жил шаардагдсан байхад, бүрэн дуусгахад арван гурван жил шаардагдсан өргөөг Соломон өөртөө зориулан барьсныг бас дурддаг. Бүлэг 7 бас ариун сүмд хамгийн дээд нарийн ур чадвар орсон гэсэн санааг дахин онцгойлон тэмдэглэсэн байдаг. Энэ нь өнөөдөр ч гэсэн үнэн юм. Бурханы өргөөг бидний барьдаг арга зам нь Их Эзэнийг бид хэрхэн шүтэн биширдгийн тусгал мөн.



Хаадын Дээд 8

Ариун сүм онцгойлон адислагдсан нь

Ерөнхийлөгч Жозеф Фиелдинг Смит, “Бид Их Эзэнд өргөөг онцгойлон адислахдаа, үнэн хэрэг дээрээ бидний хийдэг зүйл бол, уг өргөөг энэ нь ийм байдлаар ашиглагдах ёстой хэмээн Түүний бодож төлөвлөсөн тэрхүү арга замаар ашиглах гэрээгээр бид өөрсдийгөө Их Эзэний үйлчлэлд зориулах явдал” хэмээн хэлжээ (“Hyrum Smith Honored By Pres. Smith,” Church News, 1972 оны 2-р сарын 12, 4).

Манай өнөө үед Сүмийн барьсан ариун сүм бүрийг Тэргүүн Зөвлөлийн нэг гишүүний хэлсэн залбирлаар онцгойлон адисалдаг. Бошиглогч Иосеф Смит манай эрин үе дэх анхны онцгойлон адислах залбирлыг сүнсний нөлөөгөөр бэлтгэж, уг залбирлыг Көртландын Ариун Сүмийн онцгойлон адислалт дээр уншсан билээ. Уг залбирал Сургаал ба Гэрээний хэсэг 109-д цэдэглэгдсэн байдаг. Тэр цагаас хойш, Бошиглогч Иосефын бий болгосон загварыг Сүмийн Ерөнхийлөгчид баримталсаар иржээ.

Соломоны удирдлага дор баригдсан ариун сүмийн онцгойлон адислалт Хаадын Дээд 8-д байдаг. Та нар уншихдаа, ариун сүмүүдийн ач холбогдлын тухай заадаг мэдэгдлүүдийг эрж ол.



Судруудыг ойлгох нь

Хаадын Дээд 8:12—“Их Эзэн өтгөн үүлэн дотор оршино хэмээн хэлэв”

“Өтгөн үүл” хэмээн орчуулагдсан еврей үгс нь Бурханы алдар суу халхлагдсан гэсэн үгсийг төлөөлдөг аж (R.Laird Harris, ed. *Theological Wordbook of the Old Testament*, 2 боть. [1980], 2:698 [1701b]-г үз). Өөрөөр хэлбэл, Бурхан өөрийн хүмүүст нилээд ойрхон орших боловч, харахад үзэгдэхгүй байх болно хэмээн амласан ажээ.

Хаадын Дээд 8:22–54—Ариун сүмийн адислалууд

Ариун сүмийг онцгойлон адислахад Соломоны хэлсэн залбирал Хаадын Дээд 8:22–54-т байдаг. Ариун сүм зарим онцгой арга замуудаар хүмүүст адислал байх болно хэмээн Соломон залбирсан байдаг. Эдгээр арга замуудаас олон нь өнөөдөр манай ариун сүмүүдэд хэрэглэгдсээр байна. Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон, “Бидний Бурханы ариун сүмүүдэд өргөнөөр оролцох юм бол, та нар өөрсдийн чинь амьдралыг адислах хувь хүний өсөн нэмэгдсэн илчлэлт хүлээн авахын хамт та нар нас барагсдыг бас адислах болно гэдгийг би та нарт амлаж байна” гэж хэлжээ (in *Conference Report*, 1987 оны 4-р сар, 108; *Ensign*, 1987 оны 5-р сар, 85).

“Их Эзэний ариун сүмийг өөрсдийнхөө гишүүнчлэлийн агуу бэлэгдэл болгон харахад би Хожмын үеийн Гэгээнтнүүдийг урьж байна. . . .

“Сайн мэдээг тунхаглах, Гэгээнтнүүдийг төгөлдөржүүлэх, нас барагсдыг гэтэлгэх бидний бүх хүч чармайлтууд ариун сүм рүү хөтөлдөг. Яагаад ийм байдаг вэ гэвэл ариун сүмийн ёслолууд туйлын шийдвэрлэх ач холбогдолтой юм; эдгээр ёслолуудыгээр бид Бурханы оршихуйд буцаж очиж чадахгүй” гэж Ерөнхийлөгч Ховард В.Хантер хэлжээ (in *Conference Report*, 1994 оны 10-р сар, 8, 118; *Ensign*, 1994 оны 11-р сар, 8, 88).

Судруудыг судлах нь

А Нүдээр харсан гэрчийн шастир бич

Орон нутгийнхаа сонинд зориулж, ариун сүмийн онцгойлон адислалтын тухай нүдээр харсан гэрчийн шастир бичихээр өөрийгөө сонгогджээ гэж бод. Хэмжээ хязгаарлагдмал учраас таны өгүүлэл тавь буюу түүнээс цөөн үгэнд багтсан байх ёстой. Өгүүллийг тэмдэглэлийн дэвтэртээ бич.

Б Ариун сүмийн адислалууд

Ариун сүмийн улмаас хүмүүс дээр ирэх болно хэмээн Соломоны залбирсан наад тал нь дөрвөн адислалыг жагсаа (Хаадын Дээд 8:22–54-ийг үз).

В Сонгож хийх үйл ажиллагаа—Ариун сүмийн нөлөө

Ариун сүмийн талаарх өөрийн хамгийн шилдэг туршлагын тухай бич. Өөртөө хамгийн ойр байгаа ариун сүмийн зургийг авч, уг ариун сүмийг олонтаа харж болох газарт үүнийг өлгөхийг бод.

Хаадын Дээд 9

Их Эзэн Соломон дээр хүрч ирсэн нь

“Аюулгүй байдлын нэг л зам хожмын үеийн Гэгээнтнүүдийн хувьд байдаг бөгөөд энэ зам нь үүргийн зам юм. Энэ бол гэрчлэл биш, энэ бол гайхамшигтай илэрхийлэлт биш, энэ бол та нарыг бас намайг авчрах Есүс Христийн Сайн мэдээг үнэн гэдгийг мэдэх явдал биш, . . . харин энэ бол Бурханы зарлигуудыг сахьж, Хожмын үеийн Гэгээнтний амьдралаар амьдрах явдал мөн” хэмээн Ерөнхийлөгч Хебер Ж.Грант хэлжээ (“*The President Speaks: Excerpts from the Utterances of Heber J. Grant*,” *Improvement Era*, 1936 оны 11-р сар, 659).

Ариун сүмийн онцгойлон адислалт дээр Соломон болон израилчууд сүнслэг агуу туршлагаудтай байсан хэдий ч, сүнслэг туршлагауд нь авралыг баталгаатай болгодоггүй (С ба Г 3:4-ийг үз). Хаадын Дээдийн бүлэг 9 нь түүний хүмүүс байхын тулд Их Эзэн тэднээс юу шаарддаг тухай Их Эзэн Соломонд хэлсэн зүйлийг цэдэглэсэн байдаг. Та нар уншихдаа эдгээр шаардлагаудыг эрж ол.

Судруудыг судлах нь

А Зарлигууд болон үр дагавруудыг олж тогтоо

Хэрэв	Тэгвэл

Дараах хүснэгтийг хийж, Хаадын Дээд 9:1–9-д Соломонд Их Эзэний хэлсэн зүйлүүдээр үүнийг бөглө.

Хаадын Дээд 10

Хатан хаан Шеба айлчилж ирэв

Хэрэв өөр орноос хэн нэг нь танайд айлчилж ирэн, өдөр тутмын үйл ажиллагаанд чинь та нарыг харах юм бол, тэд танай Бурхан, танай шашинд сонирхолтой болох уу, эсвэл уг сонирхол нь үгүй болох уу? Соломоны тухай сонссон бүх агуу зүйлүүдэд итгээгүйн улмаас түүн дээр айлчлан ирсэн нэгэн онцгой зочны (Хатан хаан Шеба) тухай бид Хаадын Дээд 10-аас мэддэг. Соломон дээр айлчилж ирсний дараа, ялангуяа түүний мэргэн ухаан, эд баялагт Шебагийн сэтгэл нэн их хөдөлжээ. Бүлэг 10-ын үлдсэн хэсэг нь Соломоныг ихэд биширмээр хаан болгосон тэр зүйлүүдийг Шеба үзэж харсан тухай дүрсэлдэг ажээ.

Хаадын Дээд 11

Соломон Их Эзэнээс эргэсэн нь

Бид Израилын эхний хоёр хааны түүхээс ямар нэг юм мэдэж болно гэж үзвэл, энэ нь: эхлэлд та нарт хэр зэрэг сайн байсан буюу таалагдсан нь хамаагүй, та нар эцсийг хүртэл тэвчих ёстой гэсэн зүйл байх болно. Энэхүү үнэн Соломоны түүхийг бүр ч ээдрээтэй болгодог. Тэрээр яагаад эцсийг хүртэл итгэлтэйгээр тэвчээгүй вэ? Та нар Хаадын Дээд 11-ийг уншихдаа, Соломон Их Эзэнд итгэх итгэлгүй байснаас юу тохиолдсоныг ажигла.

Судруудыг ойлгох нь



Хаадын Дээд 11

Тагвар эмс (ш. 3)—Хүнтэй гэрлэсэн боловч, “эхнэрээс” доогуур байдалтай, ихэвч-

лэн өрх гэрт үйлчлэгчийн үүрэг гүйцэтгэдэг эмэгтэйчүүд

Судруудыг судлах нь



А Гэрээнээс гадуурх гэрлэлт

1. Хаадын Дээд 3:1-д Соломон израил бус эхнэртэй гэрлэсэн тухай бид уншдаг. Тэр эмэгтэй Египетийн фараоны охин байлаа. Фараоны охинтой гэрлэсэн нь ухаалаг зүйл мэт санагдаж байв, учир нь охинтойгоо гэрлэсэн хааныг нөгөө хаан ихэвчлэн довтолдоггүй байлаа. Гэрлэлт бол тэр үед гэрээ байгуулах ихэд нийтлэг арга зам байжээ. Дэд Хууль 7:1–4-т гэрээнээс гадуур гэрлэх талаар Их Эзэн зөвлөгөө өгсөн байдаг. Дэд Хууль дахь зөвлөгөө Хаадын Дээд 11:1–8-д Соломонд хэрхэн холбогдох вэ?
2. Энэ зарчим өнөөдөр өөрийн чинь насны хүмүүст хэрхэн холбогдох тухай жишээ гарга.

Б Үр дагаврууд нь юу вэ?

Соломоны зүрх сэтгэл Их Эзэнээс эргэсний улмаас тохиолдсон наад тал нь хоёр зүйлийг нэрлэ (Хаадын Дээд 11:11–40-ийг үз).

Хаадын Дээд 12

Хуваагдсан хаант улс



Соломонтой ойр дотно ажиллаж байсан, Ефраимын овгийн Иеробоам гэдэг хүн Израилын арван овгийн хаан болно хэмээн бошиглогч Ахиа түүнд хэлснийг бид Хаадын Дээд 11-д уншидаг. Соломон Иеробоамын эсэргүүцлийг мэдэж, түүний амь насыг бүрэлгэхийг эрэлхийлж байсан боловч, Иеробоам зугтжээ.

Соломоныг нас эцэслэхэд түүний хүү Рехобоам хаан болов. Соломоныг нас эцэслэх үед, Израил дахь олон хүмүүс өөрсөд дээр нь Соломоны ноогдуулсан олон татварт дургүйцэж байв. Рехобоам татваруудын талаар нааштай зүйл хэлэх хүртэл түүнийг дэмжихээр тэд хүлээж байв. Энэ бол Хаадын Дээд 12-т болсон үйл явдлууд юм.

Хаадын Дээд 12-т юу хийх ёстой талаараа Рехобоам янз бүрийн бүлэг хүмүүсээс зөвлөгөө эрэлхийлсэн байдаг. Амьдралд чинь та нарт зөвлөгөө өгдөг ямар ямар хүмүүс байдаг вэ? Хэний зөвлөгөөг та нар сонсдог вэ, яагаад? Та нар уншихдаа, өөрсдийгөө Рехобоамын оронд тавин төсөөлж бод. Хэний зөвлөгөөг та нар юуны учир сонгох байсан бэ? Өдөр тутмын амьдралд удирдамж, сүнслэг нөлөөний төлөө бид хэнд хандаж болох вэ?

Судруудыг судлах нь



А Тэр юу хийх ёстой байсан бэ?

1. Дараах хүснэгтийг хийж, Хаадын Дээд 12:1–20-д байдаг түүхийг энэ нь өгүүлж байгаа байдлаар хүснэгтийг бөглө.

Уг асуудал нь (ш. 1–5-ыг үз)	
“Настай хүмүүсийн” өгсөн зөвлөгөө (ш. 6–7-г үз)	
“Залуу хүмүүсийн” өгсөн зөвлөгөө (ш. 9–11-ийг үз)	
Рехобоам юу хийсэн бэ (Хаадын Дээд ш. 8, 12–15-ыг үз)	

2. Рехобоам яагаад залуу хүмүүсийн зөвлөгөөг авахаар шийдсэн гэж та нар боддог вэ?

3. Ямар бүлэг хүмүүс та нарын шийдвэрүүдэд нөлөөлөхийг хичээдэг вэ? Аль зөвлөгөөг дагахыг та нар хэрхэн сонгодог вэ? Шийдвэр гаргах явцад залбирал яагаад чухал байдаг вэ? (С ба Г 30:1–2-ыг үз).

Б Та нар юу хийх байсан бэ?

1. Хаадын Дээд 12:25–33 дахь түүхэнд, Иеробоам юунд санаа нь зовж байсан бэ?
2. Хэрэв та нар тэр үед Израилд амьдарч байсан бол, юу хийх нь зөв зүйл байсан бэ, яагаад?

Хаадын Дээд 13–14

Гай зовлонг хоёр дахин ихэсгэсэн нь

Иеробоам Рехобоам хоёр хоёул өөрсдийн хүмүүсийг хэрхэн нүгэлд удирдсаныг Хаадын Дээд 13–14 бидэнд өгүүлдэг. Бүлэг 13,14 аль аль нь Бурханы хүчийг танин мэдэхэд түүнд тусалсан Иеробоамын туршлагауудын тухай шастырыг агуулсан нь сонирхолтой юм. Гэвч, Иеробоам “өөрийн хилэнцэт замаас эргээгүй” (Хаадын Дээд 13:33) бид уншидаг.

Хаадын Дээдийн бүлэг 13 бас бошиглогчийн тухай нэгэн түүхийг агуулсан байдаг нь дуулгавартай байдлын ач холбогдлыг ойлгоход бидэнд тусалж чадна.

Иеробоамын нэгэн адил, Рехобоам бас уг нутагт хиймэл шүтээн шүтэхийг зөвшөөрсөн тухай бид Хаадын Дээд 14-өөс мэддэг. Дуулгаваргүйнхээ улмаас Рехобоам Их Эзэний хамгаалагч мутрыг алдсанаар, Египетийн хаан Иерусалим дахь ариун сүмийг эзэлж, үнэт эрдэнэсийн зүйлүүдийг нь олзлон авч явахаас хамгаалах чадваргүй байв.

Хаадын Дээд 15–16

Шинэ хаад, хуучин асуудлууд

Хаадын Дээдийн бүлэг 15–16 нь Иеробоам Рехобоам нарын дараах Израилын болон Иудагийн хаадын тухай өгүүлдэг. Ганцхан Иудагийн хаан Аса л ёс бус байгаагүйг дурдсан байдаг. Түүний үеийн туршид тэрээр уг нутаг дахь хиймэл шүтээнүүдийг устгасан ажээ. Гэвч, бүр Аса ч гэсэн “мөргөлийн өндөрлөгүүдээс” зайлж чадаагүй аж.

Хаадын Дээд 15-д Иеробоамын талаарх нэгэн бошиглол гүйцэлдсэнийг: түүний бүх үр удам устгагдаж, гэр бүлийнх нь үндэс таслагдсан тухай бид уншидаг.

Хаадын Дээд 16-гийн төгсгөлд Ахаб хэмээх нэртэй Израилын нэгэн хаан бидэнд танилцуулагддаг. Ахаб хиймэл шүтээн шүтэхийг зөвшөөрсөн төдийгүй, тэрээр Иезебел гэдэг нэртэй, хиймэл шүтээн шүтэгч, израил бус эмэгтэйтэй гэрлэжээ. Бүх хуурамч бурхдаас Бурханы мэлмийд хамгийн жигшүүртэй нь болох Баалыг Израилын хаан шүтэн биширч эхэлсэн ажээ.

Хаадын Дээд 17

Бошиглогч Елиа



Хүмүүс Их Эзэний үйлчлэгчдийн захиасыг сонсохгүй болсон үед, Их Эзэн тэднийг наманчлалд авчрахын тулд ямар нэг эмгэнэлт зүйлийг ашиглах нь байдаг. Хаадын Дээд 16-гийн төгсгөлд Израил улам бүр ёс бус болж, ёс бус хаанаар

удирдуулж, тэднийг наманчлалд урьсан Бурханы үйлчлэгчдийг сонсохгүй болсныг бид мэддэг. Хаадын Дээд 17-д, Елиа хэмээх нэртэй бошиглогч, тэнгэрийг хааж, Израилд ган болгох хүчтэйгээр, Бурханаар илгээгдсэн тухай бид мэддэг (бошиглогч Елиагийн тухай илүү ихийг мэдэхийн тулд Судруудын Удирдамж, “Елиа”-г үз).

Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл Faith Precedes the Miracle (1972) гэдэг нэртэй ном бичжээ. Хаадын Дээд 17 тэр зарчмын зарим агуу жишээг өгсөн байдаг. Елиа, бэлэвсэн эмэгтэй хоёр аль аль нь хожим гайхамшигтай учрахаас өмнө ямар нэг байдлаар итгэлийг хөгжүүлсэн байдаг. Та нар уншихдаа, тэдгээр гайхамшигуудыг эрж ол.

Судруудыг судлах нь

А Итгэлийг харуулах нь

Хаадын Дээд 17:17–23-т залуу хүнийг үхэгсдээс босгосон гайхамшиг бол судрууд дахь хамгийн ховор, хамгийн биширмээр гайхамшгуудын нэг юм. Ийм хэв шинжийн үйл явдлууд гагцхүү уг үйл явдал агуу байж, Их Эзэний тааллын дагуу болж, үүнд бүх хүмүүсийн итгэл оролцсон цагт л тохиодог ажээ. Их Эзэн болон түүний үйлчлэгчид бидэнд хандаж хэлсэн зүйлийг бид дуулгавартай дагасан үед бид итгэлээ харуулдаг, учир нь бидэнд хандан тэдний хэлсэн зүйлд итгэдэг—тэр ч байтугай зарим үйлдлүүд яагаад, бас хэрхэн бидний сайн сайхны төлөө эргэх учиртайг бид бүрэн харж, ойлгохгүй байлаа ч гэсэн тэр шүү дээ. Энэ зарчмыг 1 Нифай 3:7-д Нифай хамгийн сайнаар илэрхийлсэн байдаг.

1. Елиа Их Эзэнд итгэх итгэлийг харуулсан арга замуудын тухай бич.
2. Бэлэвсэн эмэгтэй Их Эзэнд итгэх итгэлийг харуулсан арга замуудын тухай бич.
3. Их Эзэн Елиад анхаарал халамж тавьж, адисалсан арга замуудыг, тэрчлэн тэрээр бэлэвсэн эмэгтэйд анхаарал халамж тавьж, адисалсан арга замуудыг жагсаа.

Б Зарчмуудыг хэрэглэ

Өнөө үеийн дараах нөхцөл байдлыг авч үз: Жонсын гэрийнхэн Сүмийн гишүүд биш ажээ. Тэд маш ядуу, тиймээс хэрэгцээгээ хангах гэж үйлээ үзэх нь олонтаа байлаа. Тэдэнд Сайн мэдээг заахад, тэд Сүнсийг мэдэрч, улам ихийг мэдэхийг хүсэж, тэгээд Сүмд нэгджээ. Дараа нь номлогчид аравны нэгийн тухай заахад, тэдний сэтгэл гонсгор байлаа, учир нь тэд үүнийг төлж чадахгүй гэж боджээ.

1. Сайн мэдээний ямар зарчмуудыг та энэ гэр бүлд заах вэ?
2. Та өөрөө эсвэл өөрийн чинь таньдаг хэн нэгэн аль нэг зарлигийг дагахад итгэл дээр тулгуурласан үеийнхээ тухай бод, тэгээд энэ тухай бич.

Хаадын Дээд 18

Елиа Баалын 450 санваартны эсрэг

Гурван жилийн ган Хаан Ахаб болон израилчуудын зүрх сэтгэлийг зөөлрүүлэх янзгүй байв. Их Эзэн Елиагаар дамжуулан, ихэнх хүмүүсийн шүтэн биширч байсан, ямар ч хүчгүй хиймэл шүтээн Баалын дэргэд тэр бол амьд Бурхан гэдгийг хүчтэйгээр харуулсан эмгэнэлт үйл явдлын тухай бид Хаадын Дээд 18-д уншдаг.

Энэ түүхийн онцгой учир холбогдол нь Баал бол газрын үржил шимийн бурхан бөгөөд тэрээр бороо, нар, сайн хөрс гэх мэтийг өснөөр ургац ургуулдаг гэсэн санаа байв. Баал хүмүүст бороо илгээх чадвартай байх ёстой атал, тэр бол хуурамч бурхан байсан бөгөөд ямар ч хүчгүй байв (С ба Г 29:28–29-ийг үз). Тиймээс яг Елиагийн хэлсэнчлэн—гурван жил бороо орсонгүй. Энэ бүлэг дэх үйл явдал Елиа болон Баалын санваартнууд Кармел Уулан дээр уулзсан нь байгалийн үзэгдлүүдийн дээр Баал биш—Их Эзэн хүчтэй байдгийг үнэхээр харуулсан арга зам мөн.



Судруудыг судлах нь

А Энэ асуултын буруу нь юу вэ?

1. Хаадын Дээд 18:17-д Елиагаас Ахабын асуусан асуултнаас бид түүний тухай юу мэддэг вэ?
2. Өнөөдөр зарим хүмүүст Ахабын харуулсан зан төрх хэрхэн байдаг гэж боддог тухайгаа жишээ гарга.

Б “Та бүхэн хэдий болтол хоёр замын хооронд тээнэгэлзэх юм бэ?”

1. Хаадын Дээд 18:19–46-д байдаг энэ түүхэн дэх юу та нарт гүнзгий сэтгэгдэл төрүүлдэг вэ?
2. Елиа асуусны нэгэн адил, Их Эзэний замууд, эсвэл аврах хүчгүй дэлхийн замуудын аль нэгийг сонгохыг өнөө үеийн бошиглогчид биднээс хүсдэг. Орчин үеийн бошиглогчид дэлхийн замууд, Их Эзэний замуудын аль нэгийг сонгохыг биднээс хүссэн гурван жишээ гарга.

Дэлхийн зам	“Та бүхэн хэдий болтол хоёр замын хооронд тээнэгэлзэх юм бэ?” (Хаадын Дээд 18:21).	Их Эзэний зам

В Үнэмшсэн үү?

Хаадын Дээд 18:39 дэх хүмүүсийн хариу үйлдэлүүдийг ажигла. “Их Эзэн, тэр бол Бурхан” гэдэгт та нарыг хамгийн ихээр үнэмшүүлсэн зүйлийн тухай бич.

Хаадын Дээд 19

Елиа Ариун Сүнсний тухай илүү ихийг мэдсэн нь

Хаадын Дээд 18-д цэдэглэгдсэн үйл явдлууд нь эдгээрийг гэрчилсэн буюу сонссон хэнийг ч гэсэн, Бурхан бол үнэн Бурхан гэдэгт Елиа үнэмшүүлсэн бололтой. Гэвч, хүн бүхэн үнэмшсэнгүй, учир нь жинхэнэ хөрвүүлэгч—хүчирхэг гайхамшигуудаар биш, харин гагцхүү Ариун Сүнсээр дамжин тохиодог билээ. Хаадын Дээд 18 дахь үйл явдлуудад Сүнс байсан хэдий ч, зөвхөн үүнийг хүлээн авсанд нь л зүрх сэтгэлийн өөрчлөлт гарчээ. Зүрх сэтгэлийн өөрчлөлт нь тэнгэрээс илгээсэн галаар биш, харин зүрх сэтгэл дэх аажуухан шаталтаар тохиодог ажээ. Хаадын Дээд 19-д энэ зарчмын тухай Их Эзэн Елиад хэрхэн сануулсныг эрж ол.

Та нар уншихдаа, та нар зөв зүйл хийсэн атлаа дараа нь гаргасан шийдвэрийнхээ улмаас ямар нэг байдлаар зовсон үед ямар санагдахыг авч үзэхийг бас хүсэж болно. Хэрэв

өөрийгөө хэзээ нэгэн цагт шударга бусаар зовсон гэж боддог бол, Хаадын Дээд 19 дэх Елиатай үүнийг тусгайлан холбогдуулан үзэж болно. Хаадын Дээд 19-д Елиаг урам хугарахад Их Эзэн юуг, яаж түүнд заасныг ажигла. Елиагийн түүхийг мэдэх нь, та зөвийн төлөө тэмцсэн боловч, энэ тэмцэлдээ ганцаар байгаа юм шиг санагдсан үед тань тусалж болно.

Судруудыг ойлгох нь



Хаадын Дээд 19:11–12—Их Эзэний хамгийн хүчирхэг илэрхийлэлт юу байсан бэ?

Кармел Уулан дээрх гайхамшгууд Иезебел болон бусад олон хүмүүсийн зүрх сэтгэлийг өөрчлөөгүйд Елиа урам хугарсан байлаа. Тэгэхэд нь Их Эзэн, зүрх сэтгэлийг өөрчлөх сүнслэг туршлагауд нь “хүчтэй шуурга,” эсвэл “газар хөдлөлт,” эсвэл “гал,” эсвэл бусад хатуу чанга, биет зүйлүүдэд биш, харин “намуухан зөөлөн дуу хоолойд” (Хаадын Дээд 19:11–12) байдгийг Елиад сургамжилсан ажээ.

“Сүнс хашгирах буюу хүнд гараар биднийг сэгсчиснээр бидний анхаарлыг татдаггүй. Харин энэ нь шивнэдэг. Хэрэв бидний санаа бодол өөр зүйлд эзэмдэгдсэн бол бид үүнийг ерөөсөө мэдрэхгүйгээр, энэ нь тийм зөөлхөн намуухан байдаг” хэмээн Ахлагч Бойд К.Пакер сургамжилжээ (“The Candle of the Lord,” *Ensign*, 1983 оны 1-р сар, 53).

Судруудыг судлах нь



Хаадын Дээд 19-ийг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А–В) хоёрыг хий.

А Урам хугаралт

Хаадын Дээд 19:1–4, 9–10-ыг харж, Елиа яагаад урам хугарсныг тайлбарла.

Б Урам хугаралтыг даван туулах нь

1. Хаадын Дээд 19-д Елиаг урам хугаралтаас өргөхийн тулд Их Эзэний хийсэн, наад тал нь гурван зүйлийн тухай бич.
2. Жагсаан бичсэн зүйл бүрийнхээ хувьд энэ нь Елиаг ямар байдлаар өргөсөн гэж бодлогоо тайлбарла. Өнөөдөр бидний урам хугаралт, цөхрөлүүдээр дамжуулан Их Эзэн ямар арга замуудаар бидэнд тусалдаг вэ?

В Тэр юу мэдсэн бэ?

Хаадын Дээд 19 дэх Елиагийн туршлага бүлэг 18 дахь үйл явдлуудын дараа юмс яагаад түүний найдаж байснаар эргээгүйг ойлгоход түүнд хэрхэн тусалсан бэ?

Хаадын Дээд 20–21

Ахабын дуулгаваргүй зан үргэлжлэв

Хаадын Дээд 20-д бид Ахаб болон Израил, Сири болон тэдний удирдагч Бен-хададтай хийсэн тулалдаануудын тухай уншидаг. Тулалдаануудад ялахад нь Ахаб болон Израилд Их Эзэн тусалжээ. Гэвч Бен-хададыг олзолж авсны дараа, бошиглогч өөрт нь зарлиг болгосны дагуу, Ахаб түүнийг цаазаар авахын оронд Бен-хададтай гэрээ байгуулав. Үүний улмаас, дуулгаваргүйнхээ төлөө тэрээр шийтгүүлэх болно гэдгийг Ахабт хэлжээ.

Ахаб, Иезебел хоёр хичнээн их ёс бус байсан тухай өөр нэг түүх Хаадын Дээд 21-д байдаг. Нэг израил хүний эзэмшдэг өмчийг Ахаб авахыг хүссэн боловч эзэн нь үүнийг түүнд худалдахгүй гэжээ. Иезебел Ахабт уг өмчийг авч өгөхийн тулд тэр өмчийг эзэмшигчийн эсрэг шүүхэд гэрчлэх хуурамч гэрч нарт хэлс төлөхөөр шийдэж, тэгээд түүнийг цаазаар авах ялаар шийтгүүлсэн аж. Энэ бүхэн болж өнгөрөн, Ахаб нөгөөх өмчийг эзэмшилдээ авсан аж. Хожим нь Елиа түүнтэй уулзаж, нөгөөх хүнийг тэрээр үхэлд хүргэсэнтэй яг адил тийм үхэл түүнд нүүрлэх болно гэдгийг хэлжээ.

Хаадын Дээд 22

Бошиглогч Микаиа

Ахабын үхлийн түүх Хаадын Дээд 22-т байдаг. Тулалдахаар бүү яв хэмээн түүнд хэлсэн үнэн бошиглогчийн зөвлөсөө дагахаас татгалзсан учир Ахабын үхэл тохиосонд гайхах юун. Үүний оронд, Ахаб тэд юу ч бодлоо гэсэн тэрээр сонсохыг хүсдэг дөрвөн зуун хуурамч бошиглогчийг Ахаб сонссон аж.

Бошиглогчдыг дагах тухай энэ сэдвээр Ахлагч Харольд Б.Лий хэлэхдээ: “Сүмийн эрх мэдлээс ирдэг зүйлийг та нар таашаахгүй байж болно. Энэ нь та нарын улс төрийн үзэл бодолтой харшилж болно. Энэ нь та нарын нийгмийн үзэл бодолтой харшилж болно. Энэ нь та нарын нийгмийн амьдралын зарим зүйлд саад тотгор болж мэднэ. Гэвч та нар эдгээр зүйлүүдийг Их Эзэний амнаас ирсэн хэмээн үзэж, тэвчээр хийгээд итгэлтэйгээр сонсох юм бол, амлалт нь, ‘тамын үүд та нарыг дийлэх нь үгүй; тийм ээ, мөн Их Эзэн Бурхан харанхуйн хүчийг та нарын өмнөөс сарниулж, мөн та нарын сайн сайхан хийгээд түүний нэрийн алдар суугийн төлөө тэнгэрийг сэгсрэхэд хүргэх болно’ гэжээ (С ба Г 21:6)” (*in Conference Report*, 1970 оны 10-р сар, 152–53).

Хаадын Дэд ном

Хаадын Дэд ном бол израилчууд хаантай байсан үеийн түүхэнд холбогдох цуврал номнуудын дөрөв дэх нь, бас сүүлчийнх нь юм. Хаадын Дэдэд бид Израил (Умард Хаант улс), Иудагийн (Өмнөд Хаант улс) аль алиных нь уналт, эзлэгдэлтийн тухай уншдаг.

Гунигтай төгсгөл

Ассиричууд Израилын хаант улсыг ойролцоогоор МЭӨ 725–20 онд эзэлж, ихэнх хүмүүсийг нь умардад Ассири уруу аваачжээ. Израилын эдгээр арван овгийн “тараагдалтын” дараа, Аврагч тэдний зарим дээр нь очсон тухай өгүүлсэн Мормоны Номон дахь нэг ишлэлээс өөр, тэдэнд юу тохиолдсон тухай цэдэг байдаггүй (3 Нифай 17:4-ийг үз). Тэднийг Израилын алдагдсан арван овог гэдгээр нь мэддэг. Иудагийн хаант улсыг эзэлж, хүмүүсийг нь Вавилонд боолчлолд аваачсан вавилончуудын цэдгээр Хаадын Дэд төгсдөг. Вавилонын боолчлол ойролцоогоор МЭӨ 605–587 онуудын хооронд тохиожээ.

Хаадын Дэдийг судлахад бэлтгэх нь

Хаадын Дэд ном Их Эзэний гэрээт хүмүүсийн уналт, эзлэгдэлт, боолчлолын тухай өгүүлдэг учраас, унших үедээ бид тэдний адил алдаа гаргахаас зайлсхийхийн тулд израилчуудыг юу эдгээр гай зовлонгууд уруу хөтөлсөнд онцгой анхаарал хандуулах ёстой. Жишээ нь: Бошиглогчид нь тэдэнд юу зааж байсан бэ? Тэд сонсож дагадаг байсан уу? Өнөөдөр манай бошиглогчид бидэнд юу заадаг вэ? Хэрэв бид сонсож, дагахгүй бол, израилчуудад тохиосон яг тэр зүйлүүд бидэнд тохиох уу? Эдгээр нь та нар уншиж, судлахдаа авч үзэх ёстой чухал асуултууд мөн.

Хаадын Дэд дэх гол үйл явдлуудын тойм

Израилын хаант улс	Иудагийн хаант улс
Бүлэг 2—Елиа зөөгдөв; Елишагийн гайхамшгууд	
Бүлэг 4—Елиша хүүхдийг үхэгсдээс босгов	
Бүлэг 5—Елиша Сирийн жанжныг эдгээв	
Бүлэг 6–9—Сиритэй хийсэн дайн; Их Эзэн тэдний байлдаанд тулалдаж, Елишаг хамгаалав.	
	Бүлэг 12—Ариун сүмийг засварлав
Бүлэг 13—Елишагийн үхэл	
	Бүлэг 16—Иуда Ассириатай холбоотон болов
Бүлэг 17—Израил Ассириар боолчлолд аваачигдав	
	Бүлэг 18–20—Хезекиагийн зөв шударга хаанчлал; Хезекиа бошиглогч Исаиагаас зөвлөгөө эрэлхийлэв
	Бүлэг 21—Хиймэл шүтээн эргэж ирэв

Бүлэг 22–23—Иосиа зөв шударга ёсоор хаанчлав; ариун сүмээс олдсон судрууд наманчлахад нь хүмүүст туслав

Бүлэг 24–25—Иуда вавилончуудаар боолчлолд аваачигдав

Хаадын Дэд 1

Хаан хиймэл шүтээнүүдээс тусламж эрэлхийлэв

Ахабын хүү Ахазиа хэрхэн бэртэж, хиймэл шүтээнээс зөвлөгөө эрэлхийлсэн тухай түүх Хаадын Дэд 1-д байдаг. Юу болсныг Их Эзэн Елиад хэлжээ. Тэгээд Елиа хааны үйлчлэгчидтэй уулзаж, тэднийг шүүмжлэн, Ахазиа хаан бошиглогчдоор дамжуулан амьд Бурханаас зөвлөгөө эрэлхийлээгүйн улмаас Ахазиа үхэх болно хэмээн бошиглогчид хэлжээ. Ахазиа бошиглогчдын тухай сонсоод Елиаг авчруулахаар цэргүүд явуулав. Тэд Ахазиагийн тушаалыг биелүүлэхээр оролдох үед Их Эзэн тэдний зуун цэргийг устгахаас өмнө тавин цэргийн ахмад Елиаг барих оролдлогоо эцэстээ зогсоосон аж. Бошиглогчид дагуу Ахазиа бэртэлтээсээ огт илаарисангүй, тэгээд үхжээ.

Хаадын Дэд 2

Елиа тэнгэрт аваачигдсан нь

Бид Хаадын Дэдэд 17-д Елиатай анх учрахад, тэнгэрийг хааж, Израилд ган бий болгох хүч, эрх мэдлийг тэрээр аль хэдийн эзэмисэн байсан билээ. Гэвч Исаиа, Иеремиа, эсвэл нэрд гарсан бусад бошиглогчидтой адилгүй нь, Елиа ямар ч бичээсүүд үлдээгээгүйгээс түүний тухай бид өөр зүйл мэддэггүй билээ. Елиа “Их Эзэний аугаа, аймшигт өдрийн” (Малахи 4:5) өмнө Мессаиагийн ирэлтэд хүмүүсийг бэлтгэхийн тулд ирэх болно хэмээн бошиглогчид Малахи хэлснийг бид мэднэ.

Малахийн бошиглогчдын улмаас өөр зарим шашины хүмүүс өнөөдөр түүний ирэлтийг хүлээсээр байна. Гэвч Елиа зөөгдсөн хүмүүн биеийн хувьд Есүсийн гурван Төлөөлөгч Петр, Иаков, Иохан нар (Матай 17:1–4-ийг үз) дээр уулын оргил дээр хүрч ирсэн тухай Шинэ Гэрээ цэдэглэсэн байдаг. Түүнээс гадна, Елиа манай эрин үед амилуулагдсан хүмүүн биеийн хувиар, 1836 оны 4-р сарын 3-нд



Көртландын Ариун сүмд үүнийг онцгойлон адислагдсаны дараахан хүрч ирсэн билээ. Тэрээр Малахийн бошиглолыг гүйцэлдүүлэхээр ирснээ хэлж, Их Эзэний ирэлтэд бэлтгэхийн тулд лацдалтын хүчний түлхүүрүүдийг дэлхий дээр сэргээсэн ажээ (С ба Г 110:13–16-г үз).

Христ бушинаас амилан гарч ирэх хүртэл нэг ч хүн амилуулагдаж чадахгүй байв. Иймээс Елиа, өөрийн тусгай үүрэг зо-

рилгыг гүйцэтгэхийн тулд зөөгдөх хэрэгтэй байжээ. Зөөгдөлт гэдэг нь хүний бие өвчин, үхэл өвдөлтийн эрхшээлд дахин автахгүйгээр өөрчлөгдөнө гэсэн үг юм. Зөөгдөлт бол амилуулалт биш. Энэ нөхцөл нь санваарын эрх мэдлээрх гар тавилт мэтийн бодит биеийг шаарддаг тохинууллуудыг гүйцэтгэх боломжийг хувь хүмүүст олгодог. Хожим нь зөөгдсөн хувь хүмүүс амилуулагдахын тулд дахин “өөрчлөгдөх” болно. 3 Нифай 28:36–40-д Мормон зөөгдсөн зарим нифайчуудыг дүрсэлсэн байдаг. Хаадын Дэд 2-т бид зөөгдсөн Елиагийн тухай түүхийг унидаг.

Судруудыг ойлгох нь

Хаадын Дэд 2:8–15—Елиагийн нөмрөг Елиша дээр унав

Елиагийн нөмрөг түүний хүч, эрх мэдлийг бэлгэджээ. Елиа тийм агуу бошиглогч байсан хийгээд Елиша түүний орыг залгамжлах болно гэдэг нэмэлт ойлголт хүмүүст хэрэгтэй байсан учир энэ туршлага чухал байсан юм. Үүнтэй адил нөхцөл байдал манай эрин үед тохиосон юм. Бошиглогч Иосеф Смитийг талийгаач болсны дараа, хэн Сүмийг удирдах ёстой тухайд зарим эргэлзээ гарсан билээ. Наувуд болсон цуглаан дээр, эрх мэдлийн түлхүүрүүд арванхоёр Төлөөлөгчид буйг Бригам Янг хэлэв. Үг хэлж байхад нь, түүний дуу хоолой—тэр ч байтугай түүний төрх байдал—Бошиглогч Иосефынхтой адилхан байсныг олон хүн гэрчилжээ. Энэ туршлага “нөмрөг” Бригам Янг дээр унасныг тэнд байсан хүмүүст гэрчилсэн онцгой гэрчлэл болсон ажээ.

Хаадын Дэд 2:9—“Таны сүнснийг хоёр дахин илүүгээр над дээр байлгаач”

Елиша Елиагийн сүнсийг “хоёр дахин илүүгээр” хүссэн ч, тэрээр хүмүүст бошиглогч болон үйлдэх Елиагийн тэрхүү хүч, эрх мэдлийг хүлээн авахыг хүссэн хэрэг ажээ. “Хоёр дахин илүү” гэсэн нь, ууган хүүгийн эрхтэй хүү эцгийнхээ үр удмыг анхаарч халамжлах зорилгын үүднээс эцгээсээ хоёр дахин илүү өв хүлээн авдаг гэсэн санааг заасан ажээ.

Хаадын Дэд 2:23–24—“Халзан толгойт оо, чи дээшээ яв”

Хаадын Дэд 2 дахь түүхийн хувьд илүү нарийн тодорхой зүйлдүгтэй байх нь нэн ашиг тустай байхсан. Энд дурдсан “залуу хөвгүүд” Их Эзэний тослогдсон үйлчлэгчид туйлын үл хүндэтгэсэн байдлаар хандаж, бүр түүнийг яв хэмээн хэлж байна. Елиша Бурханы үйлчлэгчдийн үйлдэх эрх мэдлээр Их Эзэний нэрээр тэднийг ердөө л зүхэж (С ба Г 24:15–16-г үз), дараа нь Их Эзэн шийтгэлийг тогтоосныг ажигла.

Судруудыг судлах нь

Хаадын Дэд 22-ыг судлахдаа А буюу Б үйл ажиллагааг хий.

А “Хэрэв та нар хүсэх аваас”

1. Елиша Елиагийн нэгэн адилаар Их Эзэнд үйлчлэхийг хичнээн их хүсэж байсныг харуулсан, наад тал нь хоёр зүйлийн тухай бич.
2. Аврагчид буюу бошиглогчид, өөрийн харсан удирдагчийн шинж чанаруудыг тогтоож, эдгээр шинж чанарууд яагаад чухал болохыг тайлбарла.

Б Их Эзэний үйлчлэгчдийг хүндэтгэх нь

1. Хаадын Дэд 2 дахь түүх Их Эзэн болон түүний үйлчлэгчдийн талаар бидэнд юу заадаг вэ?
2. Их Эзэний сонгогдсон үйлчлэгчдийг хүндлэн дээдэлдгээ харуулахын тулд өөрийн хийж болох наад тал нь гурван зүйлийг нэрлэ.

Хаадын Дэд 3–4

Гайхамшгууд

Их Эзэн бол гайхамшгуудын Бурхан гэдгийг судрууд гэрчилдэг (Мормон 9:10–11, 15–20-ийг үз). Иймээс, хэрэв тэдэнд итгэл байгаад, Их Эзэний тааллын дагуу тэд үйлдэх юм бол, түүнийг төлөөлдөг хүмүүс бас гайхамшгуудыг үйлдэж болно. Бошиглогч Елиша бол дуулгавартай байдал хийгээд итгэл нь олон гайхамшгуудад оролцох боломжийг түүнд олгосон нэгэн байлаа. Та нар Елишагийн зарим гайхамшгуудын тухай Хаадын Дэд 1-д унидаг, мөн та нар дахиад өөр хэдэн гайхамшигийн тухай дараачийн бүлгүүдэд унших болно.

Та нар эдгээр бүлгүүдийг уншихдаа, итгэлээ хөгжүүлэхэд Елишагийн гаргасан хүч чармайлтууд хийгээд гайхамшгууд нь Их Эзэн тэдэнд туслах боломжийг итгэлтнүүдэд олгон, тэднийг адисалж, тэдэнд заахад хэрхэн ашиглагддаг байсныг ажигла. Гайхамшгууд хөрвүүлэх нь ховор боловч итгэдэг хүмүүст найдвар төрүүлэн, хайрлагч Бурханы юүлдэг онцгой ач ивээлээр итгэлтнүүдийг адисалдгийг санагтун (С ба Г 63:7–12-ыг үз).

Елиша Израил, Иуда, Едомын нэгдсэн цэргийнхэнд ус өгөхөд тусалсан гайхамшигийг хэрхэн үйлдсэн тухай түүх Хаадын Дэд 3-т байдаг. Хаадын Дэдийн бүлэг 4 хэд хэдэн гайхамшигийг агуулдаг.

Судруудыг судлах нь

А Елишагийн санваарын адислалууд

1. Доорхтой адил схемийг тэмдэглэлийнхээ дэвтэрт хий. Христийн амьдралаас дараах ишлэлүүдийг уншиж, эдгээр нь Хаадын Дэд 4-т болсон зүйлтэй хэрхэн адилхан байгаа тухай ярь:

Есүсийн хийсэн зүйлүүд	Хаадын Дэд 4 дэх Елишагийн санваарын адислалууд
Матай 14:15–21	
Лук 7:11–16	
Иохан 2:1–11 (мөн ИСО-г үз)	

2. Саяхан өөрийнхөө дуусгасан үйл ажиллагааг авч үзвэл, Есүс бол тэдний Мессиа гэдэг гэрчлэлийг ирээдүйн ираилчуудад Елиша хэрхэн үлдээсэн бэ?

Хаадын Дэд 5

Нааманыг эдгээсэн нь

Таны байнга хийвэл зохих, амьдралыг чинь их хэмжээгээр дээшлүүлэх чадамжтай нэг “жигжиг зүйл” юу вэ? Та яагаад үүнийг эхлээгүй байгаа юм бэ? “Их Эзэний агуу ажил ихэнхдээ Түүний Сайн мэдээний заадаг үндсэн зүйлүүдийн жишээ болох жигжигхэн, нинжин сэтгэлийн үйлсээр дамжин хэрэгждэг” хэмээн Ахлагч Рекс Д.Пинегар хэлжээ (in Conference Report, 1994 оны 10-р сар, 106; Ensign, 1994 оны 11-р сар, 80).

Зарим үед жигжигхэн зарлигууд хэрэг дээрээ бидний амьдралд том өөрчлөлтүүд гаргаж чадах зарлигууд байдаг ч гэсэн, бид амьдралдаа тэдгээрийг хэрэгсдэггүй эсвэл тоохгүй байх нь бий. Хаадын Дэдийн бүлэг 5 нь энэ зарчмыг дүрсэлдэг нэг түүхийг агуулдаг.

Судруудыг ойлгох нь

Хаадын Дэд 5

Уяман өвчтэй; уяман өвчин (ш. 1, 3, 6–7, 27)—Арьсны халдварт өвчин (Судруудын Удирдамж, “Уяман өвчин”-ийг үз)

Өршөөн хэлтрүүлээ (ш. 20)—Түүний бэлэгнээс татгалзсаны улмаас ичихээс түүнийг аврав

Судруудыг судлах нь

А Өчүүхэн хүмүүс, том итгэл

Бид чухал хүмүүс биш учраас бидний хийдэг, хэлдэг зүйл хэрэг дээрээ ямар ч өөрчлөлт гаргадаггүй гэж бид зарим үед боддог. Нааманы түүхэнд ийм хоёр баатар байдаг. Нэг нь өчүүхэн шивэгчин, нөгөөх нь Нааманы зарц. Энэ хоёр хүний нэрийг бид мэдэхгүй, гэвч тэдний итгэл Нааманы амьдралыг адисалсан ажээ.

1. Харийн нутагт байсан өчүүхэн шивэгчний итгэлийг Израилын хааны итгэлтэй харьцуул.

2. Елишад үзүүлсэн Нааманы хариу үйлдлийг түүний зарцын зөвлөгөөтэй харьцуул.
3. Өчүүхэн ач холбогдолтой хэн нэгэн танд том арга замаар тусалсан үеийн тухай бичих буюу Нааманы түүх нь хэрхэн Алма 37:6–7, 46-д байдаг зарчмын жишээ болохыг тайлбарла.
4. Өчүүхэн мэт тооцогдож болох хэдий ч, манай өнөө үеийн бошиглогчид биднээс хийхийг хүсдэг хоёр зүйлийг нэрлэж, хэрэг дээрээ эдгээр нь үнэхээр хэрхэн том өөрчлөлт гаргаж болохыг тайлбарла.

Хаадын Дэд 6–7

Бошиглогчид итгэ

Заримдаа манай бошиглогчдын зөвлөгөөнд итгэж, тэдний заадаг зүйлүүдэд дуулгавартай байх нь их итгэлийг шаарддаг. Хаадын Дэд 6–7-д Их Эзэн өөрийн бошиглогчдод хүчийг хэрхэн өгдөг хийгээд тэдний үгсийн биелэлтийг хэрхэн тохиолгон авчирдгийн жишээнүүдийг бидэнд өгсөн байдаг. Та нар уншихдаа, бошиглогчдод итгэдэг хүмүүст юу тохиодгийг ажиглаж, Их Эзэний бошиглогчдыг эргэлздэг хүмүүстэй харьцуул.

Судруудыг ойлгох нь

Хаадын Дэд 6

Таар (ш. 30)—Ямааны хялга-цаас, үүнийг гашуудаж байсаар бүрсэн, хар өнгөтэй хув-гаа хүмүүс өмсдөг байжээ

Хаадын Дэд 6:16–17—Бидэнтэй хамт байгчид”

Бэрхшээлийн үед “бидэнтэй хамт байгчид гэдэнтэй хамт байгчдаас илүү олон” (мөн С ба Г 38:7; 84:88-ыг үз) гэсэн энэхүү үнэнийг бид хайхрахгүй байх нь олонтаа байдаг.

Судруудыг судлах нь

А Асуудлуудыг шийдвэрлэхэд судруудыг ашигла

Дараах нөхцөлүүдийг авч үзэн, нөхцөл бүрд туслах ямар нэг зүйлийн тухай Хаадын Дэд 6-гаас бич:

1. Та номлолд үйлчилж байгаа аж, энд таны ажлын эсрэг зүйл маш их байна. Тэр бүсэд гишүүд бараг амьдардаггүй, өөртэй чинь ярьсан бараг л хүн бүр Сүмийн эсрэг байна.
2. Сургууль дахь хэн нэгэн хүн эсвэл хөршүүд чинь танд дургүй, мөн танд найрсаг бишээр хандах нь олонтаа. Тэдэнтэй эргэн харьцах боломж танд ховор байдаг.
3. Сүмийн жишгүүдийг сахихыг та хүсдэг, гэвч та тухайн бүс дэх Сүмийн цөөхөн гишүүдийн нэг учраас ингэх нь хэцүү байдаг.

Хаадын Дэд 8

Их ёс бусын дундах зөв шударга байдал

Хүү нь үхэгсдээс босч ирсэн Шунем эмэгтэйд Елиша байнга нинжин сэтгэлээр ханддаг байсан тухай Хаадын Дэд 8-д өгүүлдэг. Бүлэг 8 нь бас Сири, Израил, Иудагийн удирдлагад гарсан өөрчлөлтүүдийн талаарх зарим товч тайлбаруудыг агуулдаг. Хүмүүсийг илүү их ёс бусаар удирдаж байсныг мэдэхэд зохиогч бидэнд тусалдаг.

Хаадын Дэд 9–10

Ахабын үр удам устгагдсан нь

Хаадын Дэд 9–10-т бид дахин биелэгдсэн бошиглолын нэгэн шастирьг уншидаг. Энэ удаад уг бошиглол нь Ахаб, Иезебел нар болон тэдний үр удмын талаар Елиагийн хэлсэн бошиглолуудын нэг байжээ. Эдгээр тогтуун өнгө аястай бүлгүүд Бурханы эсрэг тэмцдэг хүмүүсийн аймшигт төгсгөлийг гэрчилдэг. Гэвч уг бошиглолын биелэлт хүссэн үр дүнг нь хүмүүст авчраагүй бололтой. Ахаб, Иезебел нарын үр удмыг хөнөөсөн хүн, Хаан Иеху бас Баалын санваартнуудыг алсан боловч, хуваагдсан Израилын анхны хаан Иеробомын хиймэл шүтээнүүдийг орхисонгүй. Иймээс Елиагийн бошиглолууд гүйцэлдэж, Баалын шүтлэгээс энэ нь өөр байсан хэдий ч, Израил хиймэл шүтээний өөр нэг хэлбэрийг үргэлжлүүлжээ.

Хаадын Дэд 11–14

Бүр илүү их ёс бус хаад, Хэсэг 1

Израил, Иудагийн хаадын түүх Хаадын Дэд 11–14-т үргэлжилдэг. Хаан бүрийн товч түүх нь түүний хаант улс ямархуу байдалтай байсан тухай зохиогчийн нэг юм уу хоёр санааг уншигчид өгдөг богинохон түүхийг энгийнээр өгүүлдэг. Хаадын ном нь хиймэл шүтээнийг бүрмөсөн үгүй болгосон Израилын нэг ч хааны тухай өгүүлдэггүй. Нөгөө талаар, зөв шударга байдлынх нь талаар—гэхдээ товчхон дурдсан, Иудагийн ганц хоёрхон хаан байдаг.

Жишээ нь, Хаадын Дэд 12-т Иехоаш ариун сүмийн хэсгүүдийг засварлах хөтөлбөрийнхөө учир магтан сайшаагдсан байдаг. Гэвч тэрээр, алт мөнгөөр хийгдсэн хамгийн үнэт зарим зүйлсийг ариун сүмээс авч, тэдгээрийг гэрээний нэг хэсэг болгон Сирийн хаанд өгснийг бид бас уншидаг.

Бошиглогч Елиагийн үхэл Хаадын Дэд 13-т дүрслэгдсэн байдаг.



ХЭРЭГТЭЙ БАЙСАН ЗҮЙЛ

Израил, Иудад зөв шударга хаан, хиймэл шүтээн шүтэгчид үүнийг хэрэглэх хэрэггүй байв.

Хаадын Дэд 15–16

Бүр илүү их ёс бус хаад, Хэсэг 2

Хаадын Дэд 15–16-д тэр жилүүд дэх Израил болон Иудагийн янз бүрийн хаадын тухай шастир үргэлжилдэг бөгөөд энэ нь өмнөх дөрвөн бүлэгтэй адил юм. Энэ хоёр бүлэг дэх тусгайлан анхаарах зүйл бол Ассири орон энэ хоёр хаант улсад заналхийлж эхэлсэн явдал мөн. Иудагийн хаад ассиричууд өөрсдийг нь довтолж, устгахгүйн тулд тэдэнд мөнгө төлдөг байв (Хаадын Дэд 15:17–20; 16:5–9-ийг үз). Хаан Ахаз (Хаадын Дэд 16-г үз) тэр ч байтугай, ариун сүмээс үнэт зүйлсийг авч, хамгаалах төлбөр болгон тэдгээрийг Ассирийн хаанд өгчээ.

Израилын хаант улс уруу Ассири довтлон, Израилын хойд хэсгээс олон хүмүүсийг олзлогдогсад болгон авч явжээ (Хаадын Дэд 15:27–29-ийг үз).

Хаадын Дэд 17

Умард Хаант Улс (Арван овог) боолчлолд аваачигдав



Сэлүүрт завиар гол уруудан хөвж явсан хоёр залуу хүний тухай нэг түүх байдаг. Тэдний хөвж явсан гол намуун тогтуухан байсан хэдий ч, тэд усны хурд, давалгаа ихэссэн газарт дөхөж ирэхэд, гол огцом өндөр хүрхрээ рүү чиглэсэн байлаа.

Эрэг дагуу явж байсан нэг хүн гол доторх хоёр хүнийг хараад, дуудаж “Сайн байна уу! Та нарын өмнө ширүүн давалгаа байгаа, тэгээд хүрхрээ залгана шүү!” гэжээ.

Залуу хүмүүс сэрэмжлүүлгийг сонссон хэдий ч, аялынхаа тухайд аятай сайхан бодолтой байж, завь нь ч хялбархан сэлүүрдэгдэж байлаа. Тэд инээж, шог наргиан хийж, эрэг дээр байгаа хүнийг, эсвэл өмнөө байгаа аюулыг тоосонгүй.

Эрэг дээрх хүн нилээд түгшиж, “Ширүүн давалгаа, хүрхрээ удахгүй та нар дээр унана шүү!” хэмээн дахин хашигирч гэнэ.

Нөгөөх хоёр хүн анхаарсан шинж ер алга. Гэвч, усны хурд ихэсч эхлэхэд, мань хоёр бага зэрэг сандран тэвдэж, завийг эрэг рүү залах гэж оролдов. Гэвч нэгэнт хожимдсон байлаа. Усны урсгал маш хүчтэй байв, тэгээд тэд хүрхрээ уруу орж, амь насаа алджээ. Хэрэв тэд сэрэмжлүүлсэн дуу хоолойг сонссон бол ийм хувь тавиланаас зайлсхийж чадах байв (Давид О.МсКау, Gospel Ideals [1953], 912-ыг үз).

Энэхүү зохиомол түүх Хаадын Дэд 17 дахь израилчуудын нөхцөл байдал, ялангуяа, Хаадын Дэд 1-д та нарын уншсан, чухамдаа хаан болгон нь хиймэл шүтээнийг ямар нэг байдлаар хөхиулэн дэмжиж байсан Умард Хаант улсын байдалтай маш адилхан юм. Соломоны дараа хоёр хаант улс болон хуваагдсан үеэс хойш Хаадын Дэд 17 дахь үйл явдлыг хүртэл хоёр зуу орчим жил өнгөрсөн ажээ. Өөрөөр хэлбэл, өөрчлөгдөхөд нь Их Эзэн израилчуудад ийм урт удаан хугацаа олгож, нигүүлсэнгүй байсан нь лавтай.

Хаадын Дэд 17-д Их Эзэн израилчуудыг боолчлолд аваачин, тэднийг амлалтын нутгаас зайлуулахыг ассиричуудад хэрхэн зөвшөөрснийг бид бас уншидаг.

Ассиричууд бол түүхэн дэх байлдан дагуулагч бүх хаант улсуудаас хамгийн харгис нь байв. Тэд хүмүүний мэдэх хамгийн харгис хэрцгий аргаар боолчлолд аваачсан олзлогдогсодтой харьцдаг байжээ. Түүнээс гадна, тэд өөрийнхөө хаант улс, өөрийнхөө соёлыг өргөжүүлэхийн төлөө, олзлон аваачсан хүмүүсээс тэдний соёл заншилыг салгахын тулд чадах бүхнээ хийдэг байв. Үүний улмаас, ассиричууд Умард Хаант улсаас олзлон аваачсан мянга мянган израилчуудад юу тохиолдсоныг бид үнэнээр нь огт мэддэггүй. Хэдийгээр зарим нь тэр нутагт үлдэж, өөрсдийг нь олзлон аваачсан ассиричуудтай гэрлэсэн хэдий ч, олонх нь бидний мэдлэгээс “алга болж” “Израилын алдагдсан арван овог” хэмээн нэрлэгддэг болсон билээ.

Та нар уншихдаа, израилчууд яагаад Их Эзэний хамгааллыг алдаж, ассиричуудаар боолчлолд аваачигдсан шалтгаануудыг эрж ол.

Судруудыг ойлгох нь

Хаадын Дэд 17:5–18—Ассиричууд Израилыг довтолж, олзлон аваачив

Сүмд бид “алдагдсан арван овгийн” тухай ярьдаг (Итгэлийн Тунхаг 1:10-ыг үз). Эдгээр алдагдсан овгууд нь Израилын Умард Хаант улс бөгөөд энэ нь бүтэн арван овгийн өвийн нутгийг багтаадаг. Хаадын Дэд 18-д хэрхэн, юуны улмаас олон хүмүүс Ассирид аваачигдан, улмаар тэдгээр хүмүүсийн тухай дахин сонсогдохоо больсон тухай бид мэддэг. Их Эзэн хожмын өдрүүдэд Израилын угсааг цуглуулж байна. Арван овгийн тухай илүү ихийг мэдэхийн тулд Судруудын Удирдамж, “Израил, түүний цугларалт,” “Израил, түүний сэргээлт”; “Израил, түүний алдагдсан арван овог”-ийг үз.

Судруудыг судлах нь

Хаадын Дэд 17-г судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А–В) хоёрыг хий.

А Сэрэмжлүүлэг биелэгдэв

Их Эзэн израилчуудад амлагдсан нутгийг нь анх өгөхдөө, тэрээр тэдэнд зарим сэрэмжлүүлэг өгсөн ажээ:

1. Дэд Хууль 4:24–28-д Израилд Их Эзэний өгсөн бошиглолыг хураангуйлан дүгнэ.
2. Уг бошиглол Хаадын Дэд 17-д ямар арга замуудаар гүйцэлдсэн бэ? Хариултандаа тодорхой ханд.

Б Арга замуудыг би тоолъё

1. Израил Их Эзэний эсрэг нүгэл үйлдсэн арга замуудыг жагсаа (Хаадын Дэд 17:7–23-г үз).
2. Сургаал ба Гэрээ 1:14–16-г уншиж, манай өнөө үед хүмүүс Израилын хүүхдүүдийн үйлдэж байсан нүглүүдийн адил тийм гэмтэй гэж хэрхэн үзэж болохыг дүрсэл.

В Алдагдсан боловч мартагдаагүй

Дэд Хууль 4:29–31-ийг уншиж, эдгээр хүмүүс болон тэдний тарагдсан үр удамд Их Эзэний хийсэн амлалтыг хураангуйлан дүгнэ.

Хаадын Дэд 18–19

Зөв шударга хаан Хезекиа

Ассири Израилыг эзэлж байх үед, Хезекиа Иудагийн хаан болжээ. Тэрээр хүмүүсийг өсөн нэмэгдсэн зөв шударга ёс өөд удирдах боломжтой байсан нь, тэд Израилд тохиолдож байгаа зүйлийг харж, өөрийнх нь үндэстэнд ассиричуудын учруулж болох аюул заналаас айсных биз ээ. Гэвч нүглээс зөв шударга ёс уруу эргэсэн хүмүүст олонтаа тохиодог лугаа адил Хезекиа болон Израилын шийдвэр төгс байдал сорилтод орсон ажээ. Жишээ нь, аравны нэгийг төлдөггүй байсан хүн үүнийг төлж эхлэхэд, зарим нэг сард тэрээр бүрэн аравны нэгийг төлж чадахгүй юм шиг санагдахад тэр хүн “Цааш явахад би Их Эзэнд хангалттай итгэж, аравны нэгээ төлж чадах уу, мөн тэрээр надад хэрэгтэй байгаа тэр арга замаар намайг адислах болно гэдэгт итгэж болно гэж үү?” хэмээн асуух хэрэгтэй байж мэднэ. Ифер 12:6-г унш. Ийм сорилтын цагт дагах замд Их Эзэн биднийг чиглүүлдгийг ажигла.

Хезекиа болон түүний хаант улсын итгэлийн хүнд сорилтын тухай Хаадын Дэд 18–19-д өгүүлдэг. Та нар уншихдаа, хэрэв та нар Хезекиагийн нөхцөлд, итгэлийн энэ сорилтын өмнө болон дараа аль алинд нь байсан бол, ямар санагдах байсныг авч үз.

Судруудыг ойлгох нь

Хаадын Дэд 18:26—“Арамей хэлээр” яригтун

Ассиричууд Иерусалимын хэрэмний гадна талд еврей хэлээр ярьдаг байв, учир нь дотор байгаа бүх хүмүүс тэдний хэлж байгааг ойлгохын тулд ингэдэг байж. Хэрмэн дээрх иудей хүмүүс ассиричуудыг арамей хэлээр ярихыг хүсдэг байж. Тэр үед дэлхийн хамгийн хүчирхэг армийн ихэд бардам цэргүүдийн айдас төрүүлэм үгсийг олон хүмүүс ойлгохыг тэд хүсдэггүй байсан аж.

Хаадын Дэд 19

Таар (ш. 1–2)—Ямааны хялгасаар хийсэн хар өнгийн хувцас, үүнийг гашуудлын үеэр өмсдөг байжээ

Гутамшиг, гутамшиг болох (ш. 3, 22)—Бурханыг гутаан доромжлох

Херубуудын дээр залрагч (ш. 15)—Бурханы оршдог газрыг бэлэгдсэн, ариун сүмийн доторх Ариунаас Ариун газар дахь гэрээний авдрыг хэлжээ

Судруудыг судлах нь

Хаадын Дэд 18–19-ийг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А–В) хоёрыг хий.

А Амжилтын томъёо

Номлогчийн Үгс 3:5–6-гийн үнэнийг Хаадын Дэд 18:1–8 хэрхэн дүрслэн харуулдаг вэ?

Б Өөрийнхөө үгээр

Хаадын Дэд 18–19-т байдаг түүхийг өөрийнхөө үгээр бичиж, хураангуйлан дүгнэ:

1. Рабшаке Хезекиагийн зарц нарт юу гэж хэлсэн бэ (Хаадын Дэд 18:19–35-ыг үз).
2. Рабшакегийн үгст Хезекиагийн үзүүлсэн хариу үйлдэл (Хаадын Дэд 19:1–5-ыг үз).
3. Хезекиад хэлсэн Исаиагийн захиас (Хаадын Дэд 19:6–7-г үз).
4. Хезекиагийн залбирлын хариуд Исаиа Хезекиад юу гэж хэлсэн бэ (Хаадын Дэд 19:20–34-ийг үз).
5. Ассиричуудад юу тохиолдсон бэ (Хаадын Дэд 19:35–37-г үз).

В Өнөөдөр энэ нь хэрхэн тохиодог вэ?

Өнөө үеийн израилчууд Хаадын Дэд 18–19 дэх түүхээс ямар сургамж авч болох вэ? Та нар бичихдээ, дараах асуултуудыг авч үз: Та нар ямар байдлаар Хезекиагийн болон Иерусалимын хүмүүсийн байдалд байгаа гэж бодож болох вэ? Бошиглогчид бидэнд хэлдэг зүйлүүдийн зарим нь үнэхээр тохиохоор ирэх болно гэдэгт итгэхэд итгэл шаардлагатай юу? Эдгээр бүлгүүд дэх Хезекиагийн түүх Ифер 12:6-тай хэрхэн холбогдох вэ?

Хаадын Дэд 20

Хезекиагийн тухай өөр зүйлүүд

Хаадын Дэд 20-д Хезекиа үхэхэд ойрхон болсон цаг үеийн тухай бид уншдаг. Тэрээр дахиад хэдэн жил амьд явахын тулд итгэлд залбирч, Их Эзэн түүний хүслийг ёсоор болгожээ. Бүлэг 20 бас Хезекиа ариун сүм доторх эрдэнэсийг Вавилоны хаанд хэрхэн үзүүлсэн тухай өгүүлдэг. Энэ бол алдаа гэдгийг, учир нь ирээдүйн жилүүдэд вавилончууд ариун сүмийн доторх агуу эд баялгийг санаж, Иерусалимыг эзлэхээр ирж, тэдгээр үнэт зүйлсийг авч явж мэднэ гэж Исаиа хэлжээ.

Хаадын Дэд 21

Ёс бус хаан Манассе

Хезекиагийн хүү, эцэгийнхээ зөв шударга хаанчлалын дараа, Иудагийн түүхэн дэх хамгийн ёс бус захирагчдын нэг болон хаанчилж асан Манассегийн тухай бид Хаадын Дэд 21-д унидаг. Бүлэг 21-ийн төгсгөл нь Манассегийн хүү Амон алагдахаасаа өмнө богинохон хугацаагаар хаанчилж байсан тухай өгүүлдэг. Хүмүүс Амоныг алсан этгээдүүдийг олж, тэднийг цаазалж, өөр нэг хааныг хаан ширээнд суулгажээ. Хэрэв хүмүүс үнэхээр хүссэн бол, ёс бус Манассег түлхэн унагааж, түүний оронд зөв шударга хааныг тавьж чадах байсныг энэ үйл явдал харуулдаг. Хүмүүс түүний ёс бусыг зөвшөөрч, бас өөрсдөө ч ёс бус болсон учир Манассегийн хаанчлал тийм их ёс бус байжээ. Хүч, эрх мэдэлд байгаа ёс бус хүн маш их хор уршиг тарьж чаддаг аж. Гэвч хүмүүсийн дийлэнх олонх нь зөв шударга байгаа үед, тэр ч байтугай ёс бусын дотор ч гэсэн, тэд сайн сайхан зүйлийг ихээр авчирч чадна.

Хаадын Дэд 22–23

Бурханы Үгийн хүч

Гуулин ялтсуудыг олж аван, Нифайн Нэгдүгээр Ном, мөн Нифайн Хоёрдугаар Номыг бичихэд амьдралынхаа их хугацааг зориулахыг Их Эзэн Нифайд Мормоны Номонд зарлиг болгосон байдаг. Их Эзэн судруудын ач холбогдлын тухайд ямар бодолтой байсныг энэ нь харуулдаг.

Хэрэв та судруудыг ерөөсөө уншаагүй, эсвэл тэдгээрийн тухай огт мэддэггүй байсан бол амьдрал чинь хэр зэрэг өөр байх байсан бол? Одоо судрууд таны өдөр тутмын амьдралд ямар өөрчлөлт гаргаж байна?

Хаадын Дэд 22-т судруудыг “хуулийн ном” хэмээн нэрлэсэн байдаг. Та нар энэ бүлгийг уншихдаа, судруудын ач холбогдлын тухай зохиогч бидэнд юу заахыг хичээснийг авч үзэн, судрууд Иосиа Хаан болон түүний хүмүүст ямар нөлөө үзүүлснийг ажигла.

Судруудыг ойлгох нь

Хаадын Дэд 22

Гүүш (ш. 3)—Хаан, дээд санваартны нарийн бичгийн дарга буюу бичиг хэргийн

туслах ажилтан (түүхийн энэ үед)

Хаадын Дэд 22:8—Ариун сүмээс хуулийн ном олдов

Хаадын Дэд 22-ын үед хэвлэх суурь машин байсангүй. Номын хувь бүрийг гараар бичих шаардлагатай байв. Иймээс, ном цөөхөн хувь байдаг байв; ариун сүмээс хуулийн ном буюу судруудыг олсон нь агуу нээлт байлаа. Манай өнөө үед судруудыг олж авах нь маш хялбар зүйл. Бидэнд учирдаг сорилт бол судруудыг олж авах нь биш, харин тэдгээрийн юу зааж байгааг олж мэдэх явдал мөн. Иосиагийн үед олдсон судруудын түүхийн талаар Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл зааж, хэлэхдээ, “бидний хүн нэг бүр, амьдралынхаа аль нэг

үед, өөрсдийнхөө төлөө судруудыг нээж олно гэдэгт—зөвхөн тэдгээрийг нэгэнтээ нээгээд зогсохгүй, харин тэдгээрийг дахин дахин, бас дахин нээх болно, бас дахин нээх болно гэдэгт би итгэн үнэмшсэн” гэжээ (“How Rare a Possession—the Scriptures!” *Ensign*, 1976 оны 9-р сар, 4).

Судруудыг судлах нь

А Бурханы Үгийн хүч

Дараах дөрвөн үйл ажиллагаанаас гурвыг нь хий:

1. Хаан Иосиа хуулийн номны үгсийг сонсоод түүнд хэрхэн хариулсан бэ? (Хаадын Дэд 22:11, 19; 23:4–14, 21, 24–25-ыг үз).
2. Хаан Иосиа эдгээр үгсийг хүмүүст уншиж өгөхөд тэд хэрхэн хариулсан бэ? (Хаадын Дэд 23:1–3-ыг үз).
3. Өөрийн чинь амьдралд судрууд чухал нөлөө үзүүлсэн үеийн тухай бич.
4. 2 Тимот 3:15–17; 1 Нифай 15:23–24; 2 Нифай 32:3; Алма 31:5; Хиламан 3:29–30-ийг уншиж, өөрсдийн чинь амьдралд үзүүлж болох судруудын хүчний тухай жагсаалтыг эдгээр судруудаас хий.

Хаадын Дэд 24–25

Иуда Вавилоноор боолчлолд аваачигдав

Хаадын Дэд 23-ын сүүлчийн хэдэн шүлэгт бид Иосиагийн хүү, хүмүүсийг ёс бус уруу буцаан удирдсан, ёс бус хаан байсан тухай унидаг. Тэр үеийн туршид египетчүүд хамгаалалтын төлөө өөрсдөдөө мөнгө төлөхийг Иудагийн хаадад тулган шаарддаг байв. Хуучин хаан нь амьд байхад тэд Иудад шинэ хаан тавьдаг тийм их нөлөөтэй байсан аж.

Хаадын Дэд 24-ийн эхэн үеэр, Египетийн хүч шинээр үүсэн бий болж байсан дэлхийн гүрэн—Вавилоноос сул болсон байлаа. Небухаднезар хаанаар удирдуулсан вавилончууд Иерусалимыг довтолж, Иерусалим дахь баян, боловсролтой, хүчирхэг олон гэр бүлийг боолчлолд аваачив. Хаадын Дэдийн бүлэг 24 Иудагийн “төгсгөл эхэлснийг” тэмдэглэжээ.

Энэ үед, бошиглогч Лихай Иерусалим Вавилоноор бүрмөсөн устгагдах тухай хүмүүст сэрэмжлүүлж байжээ. Мормоны Номон дахь 1 Нифайн эхлэлээс өмнө Небухаднезар Иерусалимыг аль хэдийн амжилттай довтолсныг мэдсээр байж, Лихайн сэрэмжлүүлгийг хүмүүс эсэргүүцсэн нь илүү гайхал төрүүлэх биз ээ. Хаадын Дэд 24:17–20-д дурдагддаг “Зедикаягийн хаанчлалын эхний жил” (1 Нифай 1:4) Мормоны Ном эхэлсэн ажээ.

Лихай болон бусдын бошиглолуудын дагуу Небухаднезар Иерусалим уруу эргэж очин, хотыг бүрмөсөн “сүйтгэсэн” билээ (Хаадын Дэд 25-ыг үз). Өөрийнхөө хөвгүүдийн үхлийг гэрчлэхээр албадуулсны дараа Зедикаягийн нүд хараагүй

болсон гэдэг. Зедикаягийн хөвгүүдээс Мюлек хэмээх нэг хүү нь аврагдаж, өрнөд тив рүү аялсан хэсэгтэй хамт явсныг Мормоны Ном цэдэглэсэн байдаг. Эдгээр “мюлекчүүдийн” үр удмыг тэд Зарахемлагийн хүмүүс хэмээн нэрлэдэг байсныг нифайчууд хожим нь илрүүлжээ.

Их Эзэний сонгогдсон хүмүүс ёс бусчуудаар Вавилонд боолчлолд аваачигдсан тухай шастир Хаадын Дэд 25-д гардаг. Израилын “алтан” үе Мосе тэднийг Египетийн боолчлолоос удирдан гаргаж, Их Эзэнтэй ариун гэрээнүүд хийсэн үед эхэлсэн билээ. Энэ үе нь израилчууд ёс бус болох нь үргэжилсээр байсны дараа, Умард Хаант улсыг

Ассири эзэлж, тарааснаар, дараа нь Өмнөд Хаант улсыг Вавилон эзэлж, тарааснаар төгсгөл болсон юм. Ийнхүү Израил, Иудагийн Умард, Өмнөд Хаант улсууд аль аль нь Их Эзэний бошиглогчид угтан хэлж байсны дагуу эзлэгдсэнийг бид харж байна. Ойролцоогоор зургаан зуун жилийн турш Израил өөрсдийн өвөг дээдэс Абрахам, Исаак, Иаковын Бурханыг шүтэн биширэх боломжтой, үлэмж чөлөөт хүмүүс байлаа. Гэвч тэд өөрсдийн Бурханыг орхиж, улмаар боолчлолд аваачигдан, үнэн хийгээд амьд Бурханыг шүтэн биширдэггүй хүмүүсийн дунд тараагдсан юм.

Шастирын Дээд ба Дэд номнууд

Ойролцоогоор МЭӨ 540–35 онуудад, медечүүд болон персүүд Вавилоныг бут цохьж, Ойрхи Дорнод болон Азид гол их гүрэн болжээ. Персийн хаан Кореш засгийн эрхэнд гарсныхаа дараа удалгүй, Вавилоны боолчлолд тавь гаруй жил болсон иудейчүүдийг эх нутагтаа буцаж ирэхийг урьсан аж. Шастирын Дээд ба Дэд номнууд иудейчүүдийг эргэж ирснээс хойш нэгэн цагт бичигджээ. Эхлээд Шастирын Дээд ба Дэд нь нэг ном байж, гэвч дараа нь орчуулагчид тэдгээрийг хоёр ном болгон салгажээ.

Шастирын Дээд ба Дэд номнуудыг судлахад бэлтгэх нь

Шастируудыг зохиогчид хаадын үе дэх иудейчүүдийн түүхийг дахин өгүүлэхийг эрэлхийлсэн учраас Шастирууд нь 1–2 Самуел болон Хаадын Дэд 1-ийн цаг хугацааг давхцан хамардаг. Чухамдаа, Шастируудын зарим нь зүгээр л дээрх номнуудаас иш татсан мэт байдаг. Гэвч Шастирууд нь үе үе өөр зүйлүүдийг онцгойлон тэмдэглэдэг. Жишээ нь, Шастирууд ариун сүмийн эд зүйлс хийгээд ариун сүм дэх үйл явдлуудын талаар илүү нарийн тодорхой зүйлүүдийг оруулсан байдаг, учир нь Шастирууд бичигдсэн үед иудейчүүд ариун сүмтэй байсан боловч хаадгүй байлаа.

Шастирууд та нарын аль хэдийн судалсан их мэдээллийг агуулдаг учраас энэ судлах удирдамж бүлэг бүрийг ярилцдаггүй. Та нар зөвхөн Шастирын Дэд 15; 20-д зориулсан уншлагын тусламжийг хүлээн авах болно, учир нь эдгээр нь Хаадын Дэдийн 1 дэх түүхүүдийг агуулдаггүй. Шастирын Дээд ба Дэдийн бусад сонгон авсан хэсгүүдийн хувьд, та нар зөвхөн үйл ажиллагаануудыг хийх болно.

Шастирын Дээд 22:5–19

Ариун сүм барихаар бэлтгэсэн нь

Судруудыг судлах нь

А Давид ба Ариун сүм

1. Ариун сүм барихад бэлтгэхийн тулд Давид юу хийсэн тухай Шастирын Дээд 22:5–19-д өгүүлсэн зүйлүүдийг жагсаа.
2. Шүлэг 5–19-д өгүүлснээр, ариун сүм барихыг Давидад яагаад зөвшөөрөөгүй вэ?

Шастирын Дээд 29:29

“Давид Хааны үйлс”

Судруудыг судлах нь

А Энэ нь хэрхэн тусалж чадах вэ?

Библид Бурханы бошиглогчдын бүх бичээсүүд байдаг бөгөөд судрын өөр ямар ч номнууд байж болохгүй гэж хэлэн, Мормоны Номыг шүүмжилдэг хэн нэгэнд хариулахад Шастирын Дээд 29:29 та нарт хэрхэн тусалж чадах вэ?

Шастирын Дэд 3:1

Соломон ариун сүм барьж эхлэв

Судруудыг судлах нь

А Энэ газрын ач холбогдол юу вэ?

1. Шастирын Дэд 3:1-д өгүүлснээр, Соломоны ариун сүмийг хаана бариулсан бэ?
2. Энэ бол ариун сүмийн хувьд сайн газар гэж та нар яагаад бодож байна?

Шастирын Дэд 7:1–12

Их Эзэний алдар суу

Судруудыг судлах нь

А Нүдээр үзсэн гэрчийн шастир бич

Өөрийгөө сонины сурвалжлагч гэж бод. Шастирын Дэд 7:1–12-ын мэдээллийг ашиглан, Соломоны ариун сүмийг онцгойлон адисалсны дараа юу болсон тухай тэргүүн нүүрний өгүүллийг өөрөө тэнд байсан хүний хувьд бич.

Шастирын Дэд 11:13–17

Левичүүд эргэж ирсэн нь

Судруудыг судлах нь

А Хэн хаана, яагаад байсныг хэл

Израил хоёр үндэстэн болж хуваагдахад Иуда, Бениамин хоёрын овог Өмнөд Хаант улс, бусад арван овог Умард Хаант улс болж, левичүүд бүх овгууд дотор таран суурьшсаныг бид ерөнхийд нь хэлж чадна. Харин Мормоны Номны Лихай Иудагийн овгийнх ч биш, Бениамины овгийнх ч биш атлаа тэрээр Иерусалимд амьдарч байсныг бид мэддэг. Шастирын Дэд 11:13–17-г уншиж, хаант улсууд хуваагдан салсан үед хэн Иерусалим уруу шилжсэнийг, мөн тэд яагаад тийшээ шилжсэнийг тайлбарла.

Шастирын Дэд 15

Аса Бошиглогчийн зөвлөгөөг дагав

Бошиглогч зөвлөгөө өгөхөд та нар хэрхэн хариулдаг вэ? Түүний зөвлөгөө ямар нэгэн ер бусын зүйл хийхийг та нараас шаардвал яах вэ? Шастирын Дэдийн бүлэг 15 Иудагийн хаан Аса Бурханы бошиглогчийн зөвлөгөөг сонсоод юу хийснийг өгүүлдэг. Та нар уншихдаа, Асагийн хариултаас та нар юу сурч болохыг авч үз.

Судруудыг судлах нь

А Асуудлууд ба шийдлүүд

Иуда дахь асуудлууд	Хүмүүс юу хийх ёстой байсан бэ
<input type="checkbox"/>	
<input type="checkbox"/>	
<input type="checkbox"/>	

Тэд ямар буруу зүйл хийснийг, түүнчлэн нөхцөл байдлыг залруулахын тулд тэд юу хийж болохыг Бошиглогч Азариа Иудагийн хүмүүст хэлснийг харуулах энгийн схем хий. Схемийг бөглөх мэдээллийг та нар Шастирын Дэд 15:1–7-гоос олох болно.

Б Бошиглогчийг дагахын тулд _____ шаардлагатай.

1. Бошиглогчийн зөвлөгөөг дагахын тулд олонтаа шаардагддаг зүйлийг Шастирын Дэд 15:8-д ямар үг дүрсэлсэн байна вэ?
2. Аса болон түүний хүмүүс Их Эзэнийг дуулгавартай дагах хичнээн их хүсэлтэй байснаа харуулахын тулд юу хийсэн бэ?
3. Та нар Аса болон түүний хүмүүстэй илүү адилхан байж чадах зарим өвөрмөц арга замуудыг дүрсэл. Ер нь, Сүмийн гишүүд яаж түүнтэй илүү адилхан байж чадах вэ?

Шастирын Дэд 20

Асагийн хүү Иехошафат

Шастирын Дэд 20-д бид Их Эзэн болон түүний бошиглогчдод итгэхээс ирдэг адислалуудын өөр нэг жишээг олддог. Уг түүхийн тохиосон цаг үе нь Иудагийн хаан

Иехошафатын хаанчлалын үе юм. Судрууд дахь Иехошафатын бүрэн түүх Шастирын Дэд 17–20-д байдаг.

Судруудыг ойлгох нь



Шастирын Дэд 20:7–9—Ариун сүм дэх залбирлын амлалт

Бид хаана ч түүнд хандан залбирлаа гэсэн Бурхан бидний залбирлуудыг сонсох болно гэдгийг бид мэддэг ч Шастирын Дэд 20:7–9-д Иехошафат Соломоны ариун сүмийн онцгойлон адислалтад байдаг өвөрмөц амлалтуудын биелэлтийг хүссэн байдаг (Хаадын Дээд 8:37–40, 44–45-ыг үз).

Судруудыг судлах нь



А Их Эзэний туслалцааг хэрхэн хүлээж авах вэ

Том сорилттой тулгарсан үедээ Их Эзэний тусламжийг хүлээн авахын тулд Иехошафат болон түүний хүмүүсийн хийсэн зүйлүүдийн жагсаалт гарга.

Б Жишээ гарга

Та өөрөө буюу судруудаас таны уншсан хэн нэгэн хүн Шастирын Дэд 20:20 дахь зөвлөгөөг хэрхэн хэрэглэж, үүний үнэний тухай хэрхэн мэдсэн тухай өнөө үеийн жишээ гарга.

Шастирын Дэд 26:14–21

Уззия уяман өвчтөн болсон нь


Судруудыг судлах нь



А Асуудал нь юу вэ?

1. Хаан Уззия яагаад уяман өвчтэй болсон бэ?

Езрагийн Ном



Ойролцоогоор МЭӨ 605–586 оноос вавилончууд иудей үндэстнийг эзэлж, иудейчүүдийг Вавилонд боолчлолд аваачсан билээ. Энэ боолчлолын үед (Дуулал 137:1–4-ийг үз), тэд Бурхантай хийсэн гэрээнүүдээ зөрчиж, Абрахамын гэрээний хэсэг болон тэдэнд амлагдсан адислалуудыг алдаж эхэлжээ.

2. Их Эзэн Уззияг шийтгэсэн арга зам нь санваарын түлхүүрүүд болон эрх мэдлийн талаар Их Эзэн ямар бодолтой байдгийг бидэнд хэрхэн заадаг вэ?

Шастирын Дэд 29:1–11

“Одоо бүү хайхрамжгүй бай”

Судруудыг судлах нь



А Жагсаалт хий

1. Шастирын Дэд 29:1–11 дэх дараах бүлгүүд: левичүүдэд, “бидний эцгүүдэд” мөн “өөрийн хөвгүүдэд” хандаж тэдний тухай Их Эзэн юу хэлснийг жагсаа.
2. Их Эзэний өмнө цэцэглэн хөгжиж болохын тулд бид Шастирын Дэд 29:9–11 дэх Хезекиагийн зөвлөгөөг хэрхэн хэрэглэж болох вэ? (мөн С ба Г 97:10–21-ийг үз).

Шастирын Дэд 36:11–16

Иерусалим дахь ёс бус явдал

Судруудыг судлах нь



А Судрын хоёр өөр номыг харьцуул

Шастирын Дэд 36:11–16-д Лихай Иерусалимд байсан үеийн тухай өгүүлдэг. Шастирын Дэдийн шүлэг 11–16, 1 Нифай 1 хоорондоо хэрхэн адил байна вэ?

Шинэ найдвар

Вавилончуудын түрэмгийллээс хойш тавь орчим жилийн дараа, медечүүд болон персүүд вавилончуудыг бут цохиход нэгдэж, Ази, Ойрхи Дорнодод нэгэн эзэнт гүрнийг байгуулжээ. Меде-Персийн энэ эзэнт гүрнийг, өөрийн захирагдагсад, түүний дотор Вавилон дахь иудейчүүдэд найрсаг хандах бодлогыг хэрэгжүүлж байсан Кореш гэдэг хаан удирдаж байлаа. МЭӨ 539 онд Вавилоньг байлдан дагуулсныхаа дараахан Кореш, Вавилон дахь иудейчүүд Иерусалим уруу буцаж,

ариун сүмээ барьж болно хэмээн зарлан мэдэгджээ (Шастирын Дэд 36:22–23; Езра 1-ийг үз). Энэхүү мэдэгдэл боолчлолд байсан олон иудейчүүдийн сэтгэлийг ихэд догдлуулсан аж. Дуулалыг зохиогч ийнхүү бичжээ, “Ай Иерусалим, хэрэв би чамайг мартсан сан бол, баруун гар минь чадвараа алдах болтугай” (Дуулал 137:5; мөн 137:6-г үз). Иудейчүүдийн зүрх сэтгэлд шинэ найдвар төрөх нь тэр.

Иерусалим уруу гурван удаа олноороо: нэг дэх нь ойролцоогоор МЭӨ 538 онд Зеруббабелын удирдлага дор, хоёр дахь нь ойролцоогоор МЭӨ 465–25 онуудад Езрагийн удирдлага дор, гурав дахь нь МЭӨ 444 онд Нехемиагийн удирдлага дор буцсан ажээ.



Езраг судлахад бэлтгэх нь


Езра бол санваартан бөгөөд Аароны удам, Мосегийн дүү байв. Тэрээр бас судруудыг судалж, бичдэг, заадаг хуулийн багшаар дуудагдсан байжээ. Езра МЭӨ 465–25 оны орчимд иудейчүүдийн хоёр дахь том бүлгийг Иерусалим уруу удирдан буцааж авчирсан аж.

Хуулийг (судрууд) судлахад тэрээр онцгой хүч чармайлт гаргасны учир зарим хүмүүс Езраг орчин үеийн Иудейн шашны “эцэг” гэж нэрлэдэг. Иудейчүүд үндэстэн гэхээсээ илүүгээр Сүм болоход илүү их анхаарал төвлөрүүлж байсан үед тэрээр тэднийг удирдсан юм. Езрагийн номны зарим хэсгийг нэг бол Езра бичсэн, нэг бол эх зохиогч нь Езрагийн бичсэн цэдгээс шууд иш татсан байж таарна, учир нь сүүлчийн дөрвөн бүлэгт Езра нэгдүгээр биеэр ярьсан байдаг (“Би хэлэв,” “Би тэднийг илгээсэн,” гэхчлэн).



Иудейчүүдийг Иерусалим уруу буцахыг зөвшөөрсөн Корешийн түүхийг давтан ярьсны дараа (эхлээд Шастирын Дэд 36-д өгүүлсэн), буцаж ирэн, ариун сүмийг дахин барьж, бас иудейн амьдралын хэв маягийг сэргээхийг эрэлхийлсэн

Зерубабелын удирдсан бүлгийн түүхийг Езра өгүүлжээ. Энэ бүлэг цөхрөлд орсон боловч, хожим нь ариун сүмийг дуусгахад бошиглогч Хаггаи, Зехериа нар тэднийг урамшуулан дэмжжээ. Ариун сүм бол Езрагийн номонд онцгойлон анхаарсан хоёр чухал сэдвийн нэг юм. Нөгөө нэг санаа нь хууль буюу судрууд хэмээн бидний нэрлэдэг ариун цэдгүүдийн ач холбогдол юм. Езра тэдэнд хуулийг зааснаар иудейчүүд дотроосоо гадагшаа зөв шударга болоход тэдэнд туслахыг хичээж байв. Езрагийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг Судруудын Удирдамж, “Езра”-гаас үз.



Езра 1

Кореш бошиглогчлыг гүйцэлдүүлэв

Кореш зөвхөн иудейчүүдийг Иерусалим уруу буцахыг нь урамшуулан дэмжсэн төдийгүй, бас ариун сүмээс Невухаднезарын авчирч Вавилоны сүмүүдэд тавьсан бүх зүйлийг буцааж өгсөн тухай Езра 1 өгүүлдэг. Энэ тогтоолыг гаргахад Бурхан түүнд сүнслэгээр нөлөөлсөн гэж Кореш боддог байжээ. Корешийн тогтоол Исаиа, Иеремиа нарын хийсэн бошиглолуудыг гүйцэлдүүлжээ (Исаиа 44:28—45:1-ийг үз).

Езра 2

Хэн эргэж ирсэн бэ?

Иудагийн хаадын удам байсан бөгөөд иудейчүүдийг буцаж ирэхэд нутгийн захирагч болсон Зерубаббел гэгч хүний удирдлага дор Иерусалимд буцаж ирсэн хүмүүсийн тоог Езра 2-т өгүүлсэн байдаг. Энэ бүлэгт нэрс нь жагсаагдсан хүмүүсийг Израилын аль хотоос ирснээр нь, дараа нь уг хот дахь гэр бүлүүдээр нь бүлэглэсэн ажээ. Езра 2 бас буцаж ирсэн санваартнууд өөрсдийгөө левичүүд гэдгийг нотолж, санваартны албан тушаалаа ажиллахын тулд гэр бүлийнхээ түүхийн судалгаа гаргахыг тэмдэглэжээ.

Езра 3–6


Ариун сүмийг барьсан нь

Буцаж ирсэн иудейчүүд Зарубаббел, Иешуа (санваартнуудын удирдагч) нарын удирдлага дор ариун сүмийг хэрхэн дахин барьж эхэлснийг бид Езра 3-т уншидаг. Тэд Мосегийн хуулинд зарлиглагдсан тахилуудыг гүйцэтгэж болохын тулд тахилын ширээнээс эхэлсэн аж. Тэгээд тэд сууриас эхэлжээ. Суурь дуусахад тэд үүнийг тэмдэглэсэн аж. Соломоны ариун сүм ямар байсныг дурсан санаж чадах хүмүүс энэ ариун сүмийг хараад уйлсан аж, учир нь энэ ариун сүм гоё сайхнаараа тэдний дурсан санаж буй тэр ариун сүмийн хаана нь ч хүрэхгүйг тэд мэдэж байв.

“Көртланд дахь, мөн Науву дахь ариун сүмийг бид дуусгалаа: мөн талмын хонхнууд бид тэдгээрийг барьсан бүх үеийн туршид гай тоггор учруулаагүй юу? Учруулсан, долоо хоног бүр, өдөр бүр учруулсан” гэж Ерөнхийлөгч Бригам Янг хэлжээ (Journal of Discourses, 8:356). Езра 4 энэхүү мэдэгдлийн үнэнийг харуулдаг. Самаричууд гэгддэг бүлэг хүмүүс ариун сүм барихад иудейчүүдэд туслахыг хүссэн гэнэ. Иудейчүүд тэднээс тусламж авахыг хүссэнгүй, энэ нь самаричуудыг уурлуулсан аж. Тэр үеэс эхлэн самаричууд ариун сүмийн барилгыг зогсоохын тулд бүхнийг хийхээр хичээх болжээ.

Самари хүн бол Ассирийн суурьшигчид болон израилчуудын үр удам байсан аж. Иудейчүүд самаричуудыг үндэстэн хоорондын гэрлэлтийн улмаас ариун биш гэж үздэг байжээ.

Самаричууд барилгын төслийг амжилттайгаар зогсоосны дараа иудейчүүд Иерусалим дахь ариун сүмийн барилгыг үргэлжлүүлэх зөвшөөрлийг хэрхэн дахин олж авсан тухай түүхийг Езра 5–6 өгүүлдэг. Ариун сүмийн барилгыг зогсоохыг тэднээс хүссэн ч гэсэн, үүнийг үргэлжлүүлэхэд Бошиглогч Хаггаи Зехариа нар хүмүүсийг урамшуулан дэмжжээ (Езра 5:1–2-ыг үз). Ариун сүмийг барих зөвшөөрөл иудейчүүдэд байгаа эсэхэд уг нутаг дахь иудей биш хүмүүс эргэлзэхэд иудейчүүд Кореш хааны тогтоолыг ариун сүмийг барих өөрсдөдөө олгосон зөвшөөрөл хэмээн иш татсан аж, тэгэхэд нь иудей биш хүмүүс Дари хаанд бичиж, Корешийн тогтоол үнэн эсэхийг шалгаж өгөхийг хүсжээ. Уг тогтоол олодож, Дари ариун сүмийн барилгыг үргэлжлүүлэхийг зөвшөөрснийг Езра 6 цэдэглэдэг.



Езра 6-гийн төгсгөлд бид ариун сүм дуусч, онцгойлон адислагдсан тухай уншидаг. Бурханы өргөөний ажлыг үргэлжлүүлэх хүч чадлыг тэд олсон учраас ариун сүмийн онцгойлон адислалт хүмүүст баяр хөөр авчирсан аж (шүлэг 2-ыг үз). Энэ хоёр бүлэг дэх баяртай үйл явдлууд нь бошиглогч Хаггаи Зехариа нарын зөвлөгөөг хүмүүс дагах хүсэлтэй байсны үр дүн гэдгийг ажигла.

Езра 7

Езра—хуулийн багш

Езра бол бас санваартан, хуулийн багш байсныг Езра 7 танилцуулдаг. Бүлэг 7-гийн эхний таван шүлэг дэх нэрсийн жагсаалт тэрээр Мосегийн дүү Аароны шууд удам байсныг бидэнд өгүүлдэг. Вавилоноос Иерусалим уруу иудейчүүдийн бүлгийг авч явахыг Артаксеркс Езрад зөвшөөрснийг бид бас энэ бүлгээс уншидаг. Түүнээс гадна, Артаксеркс ариун сүмд зориулж мөнгө өгөн, Вавилон дахь сүмээс эрдэнэсийн зүйлсийг Езрагаар авахуулж, Иерусалим дахь ариун сүмд буцааж өгчээ. Иудейчүүдийн орон нутгийн удирдлагад үйлчлэх шүүгчдийг хүмүүсийн дунд томилох хүчийг Езрад олгосныг бид бас уншидаг.

Судруудыг судлах нь

А Езрагийн хүч чадлын эх сурвалж

1. Езра 7:10-т өгүүлснээр, Езра ямар гурван зүйл хийсэн бэ? (“Их Эзэний хууль” гэдэг нь судрууд юм.)
2. Эдгээр зүйлүүдийг хийснээр Езрагийн хүлээн авсан, наад тал нь хоёр ашиг тусыг тайлбарла.
3. Эдгээр гурван зүйл тус бүрийг та нар хэрхэн хийж чадах тухай жишээ гарга.

Езра 8

Иерусалим уруу явсан нь

Езра 8-ын эхний энэ хэсэг Езратай хамт Вавилоноос Иерусалимд буцаж ирсэн бүлэг хүмүүсийн жагсаалт, мөн бүлэг тус бүр дэх хүмүүсийн тоог агуулдаг. Бүлэг 8 дараа нь Иерусалим уруу хийсэн иудейчүүдийн аяны түүх, түүний дотор тэд хамгаалалтын төлөө замдаа хэрхэн мацаг барьж, залбирч явсан хийгээд Их Эзэн сонсож, тэдний залбирлуудад хариулж байсан тухай түүхийг хүүрнэдэг.

Езра 9–10

Израил бус эхнэрүүдтэй гэрлэсэн нь

Израил Иуда хоёр тараагдаж, боолчлолд аваачигдсаны хамгийн том шалтгаан нь тэд хиймэл шүтээнүүд шү-

тэж байсных юм. Езра Иудейн бусад удирдагчид тэднийг амлагдсан нутагт буцаж ирэхэд ийм алдаа дахин гаргахаас хол байлгахыг хичээж байв. Гэвч олон иудейчүүд гэрээнээс гадуур гэрлэж, эхнэр буюу нөхрийнхөө бурхдыг шүтэхэд уруу татагдах нь нэмэгдсээр байсныг та нар Езра 9–10-аас унших болно. Та нар энэ хоёр бүлгийг уншихдаа, гэрээнд гэрлэх талаар эдгээр бичээсүүдийн заадаг зүйлүүд та нарт хэрхэн холбогдохыг авч үз.

Судруудыг ойлгох нь

Езра 9

Холилдсон (ш. 2)—
Хоорондоо гэрлэсэн

Ураг төрөл (ш. 14)—Дотно харилцаа

Езра 10:9—“Уг үйл явдлаас болон ширүүн бороо орсноос болж чичирсэн нь”

Езра 10:9-д дүрслэгдсэн үйл явдал жилийн хамгийн хүйтэн, бороотой үед болжээ. Хүйтнээс, бас тэдний нүглүүдийн улмаас Их Эзэн сэтгэл санаагаар гонсойсноос болж хүмүүс чичирч байсан аж.

Судруудыг судлах нь

А Езрагаас ярилцлага ав

Өөрийгөө Езра 9 дэх үйл явдлын үеийн нэг сонины сурвалжлагч гэж бод. Езрагаас асуух гурван асуулт сонгож, Езра 9-өөс уншсан зүйл дээрээ тулгуурлан, тэрээр юу гэж хариулах байсан гэж боддогоо бич.

Б Наманчлалын зарчмуудыг олж тогтоо

1. Хүмүүс Езраг сонсож, олон нь илүү зөв шударга байхыг хичээдэг байв. Езра 10-т өөрийн олсон, жинхэнэ наманчлалын гурван зарчмыг тэмдэглэлийн дэвтэртээ бичиж, судрууддаа доогуур нь зур.
2. Дээр олсон зарчим тус бүр нь наманчлалын явцад яагаад чухал болохыг ярь.

Нехемиагийн Ном

Нехемиагийн ном Езрад эхэлсэн түүхийг үргэлжлүүлдэг. Эртний Иудейн судруудад Езра Нехемиа хоёр нэг ном байжээ. Нехемиа болон Нехемиагийн номын талаарх ашигтай мэдээллийг энэ судлах гарын авлага дахь Езрагийн оршил, мөн Судруудын Удирдамж, “Нехемиа”-гаас олж үз.

Нехемиаг судлахад бэлтгэх нь

Та нар уншихдаа, үүнийг барихын тулд Нехемиа ихэд шаргуу ажилласан Иерусалимын хэрэмний бэлгэдлийг авч үз. Энэ хэрмийг барих нь яагаад тийм их чухал байсан бэ? Хэрэм нь иудейчүүдтэй хэрхэн адилхан байсан бэ?



Нехемиа 1

Нехемиагийн залбирал

Өөрийнхөө бүс дэх, эсвэл дэлхийн өөр хэсэг дэх хүмүүст тулгарсан асуудлуудын тухай сонсоод та нар хэрхэн хариу үйлдэл үзүүлдэг вэ? Нехемиа 1 нь бусдын зовлонг сонссон үедээ Нехемиа юу хийснийг цэдэглэдэг.

Судруудыг ойлгох нь



Нехемиа 1

Энэ хүн (ш. 11)—Хаан

Судруудыг судлах нь



А Чухал үгсийг эрж ол


Нехемиа 1 дэх, хамгийн чухал гэж өөрийн бодсон дөрвөн үгийг сонго. Нехемиагийн үйл ажиллагаануудыг дүрсэлсэн наад тал нь нэг үг, түүний хэлсэн зүйлийн хувьд чухал болох наад тал нь нэг үгийг сонгоход анхаар. Эдгээр үг тус бүрийг яагаад сонгосноо тайлбарла.

Нехемиа 2


Нехемиа Иерусалим уруу явсан нь

Нехемиа 1-д цэдэглэгдсэн Нехемиагийн залбиралд Их Эзэн хариулсан юм. Нехемиа яагаад гунигтай байснаа Артаксеркс Хаанд хэлэх боломж түүнд олдсон хийгээд түүнтэй уулзаад хааны зүрх сэтгэл зөвлөрснийг Нехемиа 2 өгүүлдэг. Улмаар хотын хэрмийг дахин барихад нь туслахын тулд Нехемиаг Иерусалим уруу буцаж явахыг нь хаан зөвшөөрчээ. Тэр ч байтугай Артаксеркс санхүүгийн дэмжлэг үзүүлж, Нехемиа, хааны зөвшөөрлөөр явж байгааг мужуудын захирагчдад харуулахаар авч явах захидлыг Нехемиад өгчээ. Нехемиа Артаксеркс Хааны зөвшөөрлөөр Иерусалим уруу явахдаа, нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, Иерусалимын хэрмийг барихад тэрээр туслах ёстой гэдэг талаараа хэзээ хэзээн хийхээсээ илүү их зүйлийг ухаарч ойлгосон ажээ.

Персийн эзэнт гүрэн МЭӨ 500 он



Нехемиагийн үе дэх Иерусалим



Судруудыг судлах нь



А Итгэлийн жишээ

1. Хүмүүсийг урамшуулан дэмжихийн тулд Нехемиа юу хэлсэн бэ?
2. Хүмүүс хэрхэн хариулсан бэ?
3. Нехемиа “шоологчдод” хэрхэн хариулсан бэ?
4. Их Эзэн болон түүний үйлчлэгчид биднээс хийхийг хүсэн ямар нэг зүйлийг биелүүлэх гэж хичээхдээ бид Нехемиагийн хийсэн зүйлийг хэрхэн хэрэглэж болох вэ?

Нехемия 3–4

Барилгачид эсэргүүцэлтэй тулгарав

Нехемия 3 Иерусалимын хэрмийг дахин барихад ажиллаж байсан хүмүүсийн нэрсийг жагсааж, тэд хэрэмний аль хэсэг дээр ажиллаж байсныг өгүүлдэг.

Самаричуудын захирагч Санбаллат Иерусалимын хэрмийг дахин барихыг хэрхэн тохуурхан шоглож, эсэргүүцэхээ үргэлжлүүлсээр байсныг Нехемия 4 өгүүлдэг. Тэрээр хүмүүсийг доог тохуу хийх замаар уг ажлыг зогсоож чадахгүйгээ мэдээд, тэднийг зогсоохын тулд ажилчдыг дайран довтолохоор оролдох болжээ. Гэвч Нехемия болон хүмүүс Их Эзэний тусламжийн төлөө залбирч, ажилчдын хагасыг “харуул хамгаалалтын үүрэгт” томилжээ. Тэд ажлаа үргэлжлүүлэн хийж чадахаар Их Эзэн тэднийг хамгаалсан аж. Эдгээр иудейчүүд, бүр өөрсдийнх нь сайн үйлсийг Сатан лугаа адил доог тохуу хийж, эсэргүүцэж байсан үед ч гэсэн Их Эзэнд итгэх агуу итгэлтэй байжээ.

Нехемия 5

Нехемия: Агуу Удирдагч

Нехемия, Мормоны Номон дахь (Моза 2-ыг үз) Хаан Бенжамин лугаа адил, өөрийн хүмүүсийг тэдэнд татвар ноогдуулалгүйгээр хэрхэн удирдаж байсныг Нехемия 5 өгүүлдэг. Тэрээр бас иудейчүүд өөрсдөдөө өртэй иудейчүүдийг боолчилдог зуршлыг зогсоож, бие биендээ өгдөг байсан зээлэнд өндөр буюу хэтэрхий их хүү (“мөнгө хүүлэх” гэж нэрлэгддэг) ноогдуулахаас иудейчүүдийг сэрэмжлүүлсэн хуулиудыг гаргажээ.

Нехемия 6

Нехемия хэрмийг дуусгав

Зарим үед бидний төлөө хэн хамгийн сайн сайхан зүйлийг үнэхээр хүсдэгийг хэлэхэд хэцүү байж болно л доо. Хилэнцэт санаа бодолтой хүмүүс бидний золгүй явдлаас хувийн ашиг хонжоо олохын тулд биднийг мэхлэхээр оролдож болно. Гэвч, хэрэв бид Бурханд дуулгавартай байж, Сүнсний удирдамжинд итгэх юм бол, мэхлэлтээс

зайлсхийж болно. Бусад хүмүүс түүнд хор хүргэж, ажлыг нь тасалдуулахыг эрэлхийлж байсан нөхцөлд Нехемия юу хийсэн тухай Нехемия 6 өгүүлдэг.

Судруудыг ойлгох нь



Нехемия 6:10–13—Нехемия яагаад ариун сүм рүү ороогүй вэ?

Шемаиа бол Нехемиагийн хүч чармайлтуудыг тасалдуулах төлөвлөгөөний хэсэг байсан бололтой, мөн Шемаиа гэртээ “амаа хамхисан нь” уг төлөвлөгөөний хэсэг байсан аж. Нехемиагийн амь насанд аюул учирч байгаа мэтээр Шемаиа зохимлоор ойлгуулж, тэгээд Нехемия ариун сүм уруу орж, тахилын ширээний эврээс зууран барьж, амь нас нь аврагдахын төлөө гуйх ёстой гэж түүнд хэлсэн аж, энэ бол Мосегийн хуульд өгүүлэгдсэн үйлдэл байж (Египетээс Гарсан нь 21:14; Хаадын Дээд 1:50–51; 2:28; Хаадын Дэд 11:15-ыг үз). Нехемия өөрийнх нь эсрэг хуйвалдааныг мэдэж, хамгаалалтын төлөө Их Эзэнд итгэхээр сонгожээ. Нехемия ариун сүм рүү ороогүйн өөр нэг шалтгаан бол, тэрээр санваартан биш байсных аж. Шемаиа болоод бусад хүмүүсийн дунд Нехемиагийн нэр хүндийг унагаахаар найдаж байсан хэдий ч, тэд сансандаа хүрээгүй юм.

Судруудыг судлах нь



А Мэхлэлтээс зайлсхий

1. Нехемия 6-д, Нехемиад хор хүргэхийг хичээж байсан хүмүүсийг нэрлэж, яагаад гэдгийг тайлбарла.
2. Нехемия тэдний “урхинд” орохоос зайлсхийхийн тулд ямар зүйлүүд хийсэн бэ?
3. Бид мэхлэгдэхээс зайлсхийхийн тулд дараах судрууд юу гэж хэлсэн тухай бич: Хиламан 3:29–30; Сургаал ба Гэрээ 43:2–6; 46:7–8; Иосеф Смит—Матай 1:37.

Нехемия 7

Эргэж ирэгсдийн нэрс

Нехемия 7 бол Зарубаббелтай хамт Иерусалимд буцаж ирсэн хүмүүсийн тухай үздэг юм (Езра 2-ыг үз). Езрад өгүүлсний нэгэн адил, өөрсдийгөө зохих удмынх гэдгийг угийн бичгээрээ харуулж чадаагүй хүмүүс санваартай байхыг зөвшөөрөөгүйг Нехемия 7 нотолдог.

Нехемия 8

Езра судруудыг хүмүүст уншиж өгсөн нь



Хэрэв та судруудын тухай огт сонсоогүй, уншаагүй, эсвэл ерөөсөө судрууд танд огт байхгүй бол таны амьдрал хэр зэрэг өөр байх сан бол? Нехемиагийн үед судруудыг гараар хуйлмал бичиг болгон бичдэг байснаас, судар олж авахын тулд их хүч чармайлт, золиослол шаардагддаг байжээ. Судруудын бүрэн

хувьтай хүн азтайд тооцогддог байж. Нехемиагийн үеийн хүмүүс хэдэн жилийн турш судрууд уншидаггүй буюу сонсдоггүй байж. Та нар Нехемиа 8-ыг уншихдаа, хүмүүс судруудыг сонссон үед тэдэнд ямар бодол төрдөг байсныг, судруудыг унших буюу сонсох боломж та нарт олдсон үед өөрсдөдөө төрдөг бодолтой харьцуул.

Судруудыг ойлгох нь



Нехемиа 8:13–18—Тэд “майхнуудад” амьдрах ёстойг судруудаас уншив



Езрагийн үед иудейчүүд “майханд амьдрах” нэг зарлигийг судруудаас нээн олжээ. Уг зарлиг нь Мосе болон Израилын хүүхдүүдэд Их Эзэн анх өгсөн ариун баяр—Асруудын Баярт холбогддог (Левит 23:33–44-ийг үз).

Судруудыг судлах нь



А Чухал үгсийг ол

1. Нехемиа 8:2–12-ыг уншиж, Езра тэдэнд судруудыг уншиж өгөн, тайлбарлахыг сонсоод хүмүүст төрсөн бодлыг хамгийн сайн дүрсэлсэн гэж өөрийн бодсон үгсийн жагсаалт хий. Та нар эдгээр үгсийг судрууддаа онцгойлон тэмдэглэж болно.
2. Жагсаалтдаа бичсэн үгнүүдээс нэгийг сонгож, өөрөө мөн гэж бодсон үеийнхээ тухай ярь; эсвэл, жагсаалт дахь үгсээсээ нэгийг сонгож, Езра тэдэнд судруудыг заахад хүмүүс яагаад тийм байдлаар хариулсан гэж бодлогоо ярь.
3. Нехемиа 8:2–12 дахь ямар үгс, судруудын талаар агуу туршлагатай болоход нь хүмүүст туслахын тулд Езрагийн хийсэн зүйлийг дүрсэлсэн гэж та нар бодож байна?

Нехемиа 9–10

Үгийн хүч

“Үгийг номлох нь . . . хүмүүсийн оюун ухаанд илднээс, эсвэл өөр юунаас ч илүү хүчтэйгээр нөлөөлдгийг” (Алма 31:5) бид Мормоны Номонд уншдаг билээ. Нехемиа 9–10 энэ үнэний жишээнүүдийг агуулдаг.

Бурханы үгийг сонссон (Нехемиа 8-ыг үз) учраас хүмүүс мацаг барьж, нүглээ гэмшин, Их Эзэнийг шүтэн биширснийг бид Нехемиа 9-өөс уншдаг. Тэгэхэд нь санваартнууд, тэдний үеийг хүртэл Их Эзэн тэдэнд хичнээн нигүүлсэнгүй байсныг харуулан, тэдний түүхийн тоймыг Абрахамын үеэс хойш хүмүүст өгсөн ажээ.

Нехемиа 10-т, зарлигуудыг бүрэн сахих гэрээнүүдийг санваартнууд хийснийг бид уншдаг. Хүмүүсийн үлдсэн нь санваартнуудынхаа үлгэр жишээг даган, бас энэ гэрээг хийжээ. Бүлэг 9–10-т цэдэглэгдсэн үйл явдлууд нь бид судруудыг уншиж, судлан, тунгаан бодоход хийгээд амьдралдаа хэрэглэхэд ирдэг зарим адислалуудыг харуулдаг.

Нехемиа 11–12

Хэрмийг онцгойлон адисалсан нь

Нехемиа 11 Израил дахь хүмүүсийн удирдагчдын нэрсийг, түүнчлэн тэднээс хэн хэн нь Иерусалимд амьдрахаар томилогдсоныг өгүүлдэг. Бүлэг 11 бас уг нутаг дахь бусад хотуудад амьдрахаар томилогдсон бусад хүмүүсийг дурдсан байдаг.

Нехемиа 12-ын эхний хэсэг Зарубаббелын бүлэгт Иерусалимд буцаж ирсэн санваартнууд болон левичүүдийн (санваар атгагчид) нэрсийг агуулдаг (ш. 1–9-ийг үз). Дараагийн хэсэг нь анхны бүлгийн (ш. 10–26-г үз) үр удам байсан, Нехемиагийн үе дэх санваартнууд болон левичүүдийн нэрсийг агуулдаг. Бүлгийн үлдсэн хэсэг нь Иерусалимын хэрмийг (ш. 27–47-г үз) онцгойлон адисалсан тухай өгүүлдэг.

Нехемиа 13

Нехемиа наманчлалыг номлохоо үргэлжлүүлэв

Иерусалимын хэрмийг онцгойлон адисалсны дараахан, Нехемиа Вавилонд Артаксеркс Хаантай уулзахаар буцжээ. Тэрээр Иерусалимд буцаж ирээд юу олж мэдсэн тухай түүхийг Нехемиа 13 өгүүлдэг. Гурван зүйл: (1) Израилын Бурханд итгэдэггүй гадаадын нэг хүнийг Их Эзэний өргөөнд амьдрахыг зөвшөөрсөн байв, (2) Хүндэтгэлийн өдрийг хүмүүс ариунаар нь сахьдаггүй

байлаа, (3) хүмүүс— тэр ч байтугай санваартнууд болон левичүүд гэрээнээс гадуур гэрлэсэн нь түүнийг ихэд гутраажээ. Эдгээр зарлигуудыг сахих замаар Их Эзэнд итгэлтэй байхад нь хүмүүсийг Нехемиа урамшуулан дэмжсэн ажээ. Өнөөдөр бид ариун сүмд зохистойгоор орон, Хүндэтгэлийн өдрийг ариунаар сахьж, гэрээнд гэрлэх замаар Бурханд итгэх итгэлээ харуулдаг.

Естерийн Ном

Иудейн эмэгтэй баатрын тухай түүх

Естерийн номыг Естер бичээгүй боловч, түүний түүх уг номонд бүхлээрээ байдаг. Уг түүх олон иудейчүүд Персэд байх үед (ойролцоогоор МЭӨ 460–30 онуудад) тохиосон бөгөөд Естерийн эрэлхэг зоригт үйлдлүүд түүний хүмүүсийг устгалаас хэрхэн аварсныг өгүүлдэг. Иудей хүмүүс энэхүү гайхамшигт үйл явдлыг Пурим хэмээн өөрсдийн нэрлэдэг баярын хамт одоог хүртэл тэмдэглэсээр байдаг ажээ. Иудейчүүд энэ түүхийг дахин уншиж, хүмүүсийн зарим нь алга ташин, баатруудад баяр хүргэж, олиггүй хогнуудыг зүхдэг. Естерийн ном бол түүх учраас “Судруудыг ойлгох нь,” “Судруудыг судлах нь” хэсгүүд номыг бүхэлд нь хамарсан болно. Естерийн номны талаарх бусад мэдээллийг Судруудын Удирдамж, “Естер, түүний ном”-ноос үз.

Естерийг судлахад бэлтгэх нь

Кореш бол Персийн эзэнт гүрний анхны хаан байв. Богинохон хугацаанд захирсан түүний хүү Камбисес түүнийг залгамжилжээ. Камбисесийн үхлийн дараа Дари гэгч хүн олон жилийн туршид хаан байлаа. Дарийг нас барсны дараа түүний хүү Ксеркс Персийн эзэнт гүрний дөрөв дэх хаан болон захирсан аж. Ксеркс гэдэг нь түүний грек нэр байв, Естерийн номонд перс нэрээрээ Ахашверош гэж гардаг.

Та нарын Библид Естер Нехемиагийн дараа гардаг ч гэсэн, Естер дэх үйл явдлууд Нехемиа дахь үйл явдлуудаас хэрэг дээрээ гуч орчим жилийн өмнө болсон байдаг. Ксеркс буюу Ахашверош нь Нехемиагийн үед хаан байсан бөгөөд Нехемиа болоод иудейчүүдэд ихэд найрсаг байсан бололтой. Энэ нь Естерийн болсон үйл явдлууд байгаагүй бол, Нехемиагийн ном байхгүй байж ч болох талтай!



Судруудыг ойлгох нь

Естер 1

Цаг үеийг ойлгодог мэргэн хүмүүс (ш. 13)—Зурхайчид (одон орон судлаачид)

Естер 2

Халдахаар (ш. 21)—Алахаар

Естер 3

Шавга (ш. 7)—Шоо хаяж, гарсан тоогоор ямар нэг зүйлийг сонгох

Естер 4

Очирт алтан таяг (ш. 11)—Эрх мэдлийн бэлгэдэл болсон таяг



Чимээгүй байх (ш. 14)—Юу ч ярихгүй байх

Судруудыг судлах нь



А Тэдний үлгэр жишээг ашигла

Естерийн номон дахь дараах гурван хүн: Хатан хаан Вашти, Мордехай, Естер нарын, хүн нэг бүрийн үлгэр жишээнээс өөрийн чинь насны хүн юу сурч болно гэж бодож байгаа тухайгаа бич. Хувь хүн бүрийн хувьд, өөрийнхөө тайлбарын хэсэг болгон өвөрмөц жишээнүүд болон судрын ишлэлүүдийг гарга.

Б Санах ёстой чухал шүлэг

1. Естер 4:14-ийг уншиж, дараа нь өөрийнхөө үгээр бич.
2. Естер 4:14-т Естерт тавьсан Мордехайн асуултыг өнөөдөр та нараас асуухад сайн асуулт байж болно. Ерөнхийлөгч Эра Тафт Бенсон, “Их Эзэний Хоёр дахь Ирэлтийн өмнөх сүүлчийн өдрүүдэд та нарыг байлгахын тулд Бурхан та нарыг бараг зургаан мянган жилийн турш хадгалсаар байгаа билээ. Зарим хувь хүмүүс унах болно; Бурханы хаант улс—өөрийнхөө тэргүүн Есүс Христийг эргэж ирэхэд баяртай угтахын тулд бүрнээрээ үлдэх болно. Их Эзэн дэлхийг үерээр цэвэршүүлсэн Ноагийн үе дэх ёс бус явдалтай бидний үеийнхэн харьцуулагдахуйц болох тэр үед их өөрчлөлт гарах болно. Энэ бол хаант улсыг ялгууснаар авч явахад туслах, Өөрийн хамгийн хүчирхэг зарим хүүхдүүдийг сүүлчийнх нь буудаллах газрын

төлөө Бурхан аварсан явдал болно. Энэ бол та нарын орох газар, учир нь та нар бол өөрсдийнхөө Бурханыг угтахаар бэлтгэгдэх ёстой үеийнхэн мөн” хэмээн хэлж, уг асуулгад хариулахад тусалжээ (*The Teachings of Ezra Taft Benson* [1988], 104–5).

Ерөнхийлөгч Бенсон бас хэлэхдээ, “Бүх эрин үеүдэд бошиглогчид цаг хугацааны хонгилоор дамжуулан манай өнөө үеийг харсан юм. Олон тэрбум нас барагсад хийгээд бас

ирээдүйд төрөх тэд бидэн дээр хараа тавьсаар байна. Энэ тухайд бүү алдаа гарга—та нар бол онцгой үеийнхэн. Бидний үеийнх шиг ийм богино хугацаанд ийм их итгэл хүсэн хүлээгдэж байсан нь хэзээ ч үгүй билээ” (*Teachings of Ezra Taft Benson*, 105). Ангийнхандаа зориулан тэмдэглэл бичиж, тэд “үүн шиг ийм цагийн төлөө л” хаант улсад ирснээ санах нь тэдний хувьд яагаад чухал болохыг ярь.

Иовын Ном

Яагаад сайн хүмүүст муу зүйлүүд тохиодог вэ?



Хүмүүсийн амьдралд эмгэнэлт явдал, зовлон бэрхшээл өдөр бүр ирж болно. Хайртай хүмүүс маань нас барах буюу өвчин эмгэг, осол аваар, байгалийн гамшгаар байнгын бэртэл гэмтэл авч болно. Ийм зүйлүүд болохыг Бурхан хэрхэн тэвчдэг юм бэ? Тэр ч байтугай, эдгээр нь Их Эзэнд хичээнгүйлэн

үйлчилдэг хүмүүст ч тохиолддог нь юуных вэ? Энэ бүх гай зовлон, уй гашуу, үхэл хагацлыг Бурхан бий болгодог уу? Иймэрхүү асуулгуудын талаар, Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл хэлэхдээ, “Хэрэв та нар чадвал хариул л даа. Би бол чадахгүй, учир нь бидний амьдралд Бурхан зонхилох үүрэгтэйг би мэддэг ч гэсэн, үйл явдлыг тэрбээр хэдий хэмжээгээр тохиоход хүргэдгийг, бас хэдий хэмжээгээр тэрбээр ердөө зөвшөөрдгийг би мэдэхгүй. Энэ асуулгад яаж ч хариуллаа гэсэн, миний баттай боддог нь өөр юм.

“Эдгээр эмгэнэлт явдлуудаас Их Эзэн урьдчилан сэрэмжлүүлж чадах уу? Хариулт нь гэвэл, Тийм ээ, чадна. Их Эзэн бол бүхнийг чадагч, хэрэв тэр хүсэх юм бол, бидний амьдралыг бүх хүчээр хянаж, биднийг өвчин эмгэгээс хамгаалж, бүх осол аваараас сэрэмжилж, бүх онгоц, машиныг залан чиглүүлж, биднийг тэжээж, биднийг хамгаалж, биднийг хүнд хэцүү хөдөлмөр, хүнд бэрх хүч чармайлт, өвчин эмгэг, тэр ч байтугай үхлээс аварч чадна. Гэвч тэр тэгэхгүй” гэжээ (*Faith Precedes the Miracle* [1972], 96). Их Эзэн биднийг амьдралын туршлагад тохиолддог бүх бэрхшээл зовлон, сөрөг зүйлүүдээс яагаад хамгаалдаггүй вэ? (Абрахам 3:25-ыг үз). Ингэснээрээ биднийг хүчирхэгжүүлдэг үү, эсвэл сул дорой болгодог уу?

Иовын ном хэцүү асуултууд тавьсан байдаг. Их зовлон үзсэн зөв шударга хүний тухай түүхийг Иов хүүрнэдэг. Тэрээр бэрхшээлийг хэрхэн даван туулж, өөрийнхөө туршлагаадаас юу сурсан нь бидний эргэн тойрон дахь хүмүүсийн зовлон зүдгүүр, уй гашуугийн тухай бидэнд чухал сургамжууд өгч чадна. Бошиглогч Иосеф Смитийг Либертийн шоронд байхад, Бошиглогчид тохиолдсон гай зовлонгийн тухай, тэрчлэн яагаад тэрээр ийнхүү зовох болсныг түүнд заахад Их Эзэн Иовын түүхийг ашиглажээ (С ба Г 121:1–33-ыг үз). Та нар Иовыг уншихдаа, Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөний тухай юу мэдсэнээ, түүнчлэн уг төлөвлөгөөнд зовлон ямар зорилготойг авч үз.

Иовын номыг судлахад бэлтгэх нь

Иовын тухай бид нэн бага мэддэг ч гэсэн, тэрээр патриархуудын үед (Абрахам, Исаак, Иаков) үед амьдарч байсан бололтой. Түүний ном Библийн “яруу найргийн” хэсэгт орсон байдаг, учир нь уг түүх яруу найргийн хэлбэрээр хүүрнэгддэг бөгөөд энэ нь уг номыг Хуучин Гэрээний, уншиж ойлгоход илүү хүнд хэцүү номнуудын нэг болгодог биз ээ. Гэвч яруу найраг нь уг түүхийг илүү их соргог мэдрэмжээр уншихад тусалдаг. Яруу найраг нь чангаар уншихад зохимжтой байдаг учир та нар өөрсдийн дуртай цөөн шүлгийг, Иовын мэдрэмж хийгээд утгыг тийм байдлаар ойлгоход туслах нь уу гэдгийг харахын тулд чангаар уншихыг хүсэж болно. Иовын номны тоймыг, Судруудын Удирдамж, “Иов, түүний ном”-оос үзэж болно.

Иов 1

... бусад, бүх зүйлээ Иов алдав

Ямар нэг муу юм та нарт тохиолдоход та нар хэрхэн хариу үйлдэл үзүүлдэг вэ? Бурханы талаар та нар юу гэж боддог вэ? Хэрэв танд муу юм тохиолдож, тэгээд та “буруу юм юу ч хийгээгүй” бол, Бурханы талаар, бас өөрийнхөө талаар ялгаатайгаар боддог уу? Иов өөртөө тохиолдсон зүйлд хэрхэн хариу үйлдэл үзүүлснийг Иов 1 өгүүлдэг. Ийм нөхцөлд та нар хэрхэн хариу үйлдэл үзүүлэхээ авч үз.

Судруудыг ойлгох нь

Иов 1:6–12—Бурхан Сатан хоёр үнэхээр тохиролцдог уу?

Их Эзэн Сатаны дээр хүчтэй бөгөөд түүнтэй “хэлэлцэн тохирох” хэрэг байхгүй нь мэдээж юм. Иовын амьдарч байсан арга маягт Их Эзэн баярладаг байсан хэдий ч, Иовыг уруу татаж, түүнд хүнд сорилтууд учруулахыг тэрээр Сатанд бас зөвшөөрснийг бид Иов 1:6–12-оос мэддэг. Иов 2 үүнтэй адил нөхцөл байдлыг агуулдаг. Иовын соригдсон хоёр удаагийн тохиолдолд Сатан юу хийж чадах хийгээд юу хийж чадахгүй

талаарх “дүрмүүдийг” Их Эзэн тогтоосон ажээ. Бид Их Эзэнд хэдий чинээ удаан хугацаагаар итгэлтэй байх аваас, бидний даван туулж чадахаас илүү хүнд сорилтоор биднийг сорихыг тэрээр Сатанд хэзээ ч зөвшөөрөхгүйг мэдсэнээр бид төдий чинээ бат итгэлтэй байж чадна (1 Коринт 10:13-ыг үз).

Судруудыг судлах нь

А Иовд зориулан зөвлөмж бич

Хэрэв Иов ажилд орох хүсэлт гаргаж, өөрийнхөө ямархуу хүн болох тухай зөвлөмжийн захидал бичиж өгөхийг танаас хүсвэл, Иов 1-д уншсан зүйл дээрээ тулгуурлан та түүний тухай юу мэдэх вэ?

Б Адилхан уу эсвэл өөр үү?

Иов өөртөө тохиолдсон зүйлд хэрхэн хариулсан хийгээд түүний хариу үйлдэл, зөв шударга хүмүүс ингэж хариулах ёстой хэмээн та нарын боддог арга замтай хэрхэн харьцуулагдахыг дүрсэл.

Иов 2

Иовт дахиад олон хүнд сорилт тулгарав

Иов 1-д учирсан сорилтыг Иов давсан хэдий ч, Иовыг бүр илүү ихээр зовоохыг Их Эзэн Сатанд зөвшөөрчээ. Иов өөртөө учирсан хүнд сорилтуудад хэрхэн хариулсныг Иов 2 дахин харуулах болно.

Судруудыг судлах нь

А Саналаа хэл

Иов 1–2-т Иовт тохиолдсон бүх зүйлээс, өөрийн чинь хувьд хамгийн хэцүү туршлага байж болох нэг зүйлийн тухай бичиж, энэ нь яагаад тийм хэцүү байх болно гэж бодсоноо тайлбарла.

Иов 3

Би ер нь яах гэж төрсөн юм бол?

Иов өөртөө тохиолдсон гай зовлонгуудын төлөө хэдийгээр Бурханыг буруутгаагүй ч гэсэн, тэрээр хичнээн их урам нь хугарч цөхөрсөн тухай санааг Иов 3 гаргадаг.

Судруудыг судлах нь

А Бэлэгдлийн үгсийг ол

Иовын бодол санаа ямар байсныг дүрсэлсэн гэж өөрийн боддог гурван үгийг Иов 3-аас жагсаан бичиж, та яагаад эдгээр үгсийг сонгосноо тайлбарла.

Иов 4–31

Иовын найз нар зөвлөгөө өгөв

Иов 4–31 нь Иов болон түүнтэй уулзахаар ирсэн гурван найзын хооронд болсон яриаг агуулдаг (Иов 2:11–13-ыг үз). Найз болгон нь нүгэлтнүүдийг Бурхан шийтгэдгийг өөр өөрийнхөө маягаар Иовт хэлж, иймээс Иов нүгэл үйлдсэн байх ёстой аж. Гэвч Иов 1-ээс мэдсэн зүйлээсээ та нар, Иов нүгэл үйлдээгүйг мэднэ. Иов өөрийгөө болон өөрийн зөв шударга байдлыг хамгаалахыг хичээхэд эдгээр “найз” нар түүнийг сагсуурлаа гэж зэмлэсэн ажээ. Олон ёс бус хүмүүс өөрийнх нь хүлээн авсан шиг тийм шийтгэлтэй хэзээ ч тохиолдож байгаагүйг мэднэ гэж Иов тайлбарлажээ. Бурхан түүний хүнд сорилтуудыг зайлуулан авч болохын тулд түүнийг наманчлахад “найз нар нь” урамшуулан дэмжжээ. Гэвч Иов ямар ч буруу юм хийгээгүй хэмээн зүтгэсээр байлаа.

Судруудыг судлах нь

А Төгс Эзэмших Судар—Иов 19:25–26

1. Иов 14:14-ийг уншиж, Иовын асуусан асуултыг олоод, асуултыг тэмдэглэлийнхээ дэвтэрт бич. Тэгээд Иов 19:23–27-г уншиж, Иов хожим нь уг асуултад хэрхэн хариулсныг хураангуйлан дүгнэ.
2. Иов 19:25–26 дахь Иовын гэрчлэл тэрээр үүнийг хэлсэн тэр үед түүний хувьд яагаад тийм их ач холбогдолтой байсан гэж та нар бодож байна?

Б Бусад гэрчлэлүүдийг ол

Иов 32–37

Дөрөв дэх найз

Иов 32–37 нь Елиху нэртэй хүний үгсийг агуулдаг. Тэрээр хэзээ уг бүлэгт нэгдсэнийг бид мэдэхгүй, гэвч тэрээр Иов болон нөгөө гурван хүний хоорондын яриаг сонссон бололтой.

Тэр насаар дүү байсан учраас ярианд шууд оролцолгүй, бас ахмад настнуудаа хүндэтгэж байжээ (Иов 32:4-ийг үз). Эцэст нь Елиху ярихаар сонгоход, тэрээр Иов өөрийгөө гэм зэмгүй гэж хэллээ хэмээн Иовыг шүүмжилжээ. Иов өөрийгөө гэм зэмгүй гэж хэлснээр түүнийг зовлонд унахад Бурхан шударга бус буюу төгс бус байсан хэмээн Иов хэлж байна гэдэгт Елиху итгэсэн аж. Хэрэв Иов нүгэл үйлдэгчийн хувьд буруутгагдаагүй юм бол яагаад зовох болсны үнэн хариуг Иовд өгөөгүй учраас Елиху бас Иовын найз нарыг ч шүүмжилжээ. Елиху гурав дахь үзэл бодлыг санал болгожээ. Тэрээр Бурханы аугаа чанарыг, түүнчлэн тохиодог юм бүхнийг тайлбарлах арга замаар Бурханы оюун ухааныг хүмүүн ойлгох чадваргүйг мэдэгджээ. Зовлон бол үргэлж нүглийн төлөөх шийтгэл байдаггүй, харин Бурхан өөрийн хүүхдүүдийн төлөө сайн зүйлүүдийг хийдэг болохоор зовлон нь хүнд ямар нэг байдлаар ашиг тус өгч болно хэмээн тэрээр санал болгожээ.

Иов 38–39

Их Эзэн хэлсэн нь

Их Эзэн эцэст нь Иовын залбирлуудад хариулжээ. Гэвч Тэрээр: Яагаад Иов зовох болов? гэхчлэн Иовын болон найз нарынх нь дэвшүүлсэн асуултуудад хариулаагүй бололтой. Үүний оронд, Их Эзэн илүү олон асуултын хэлбэрээр хариултыг өгсөн аж. Их Эзэний асуултуудын хариулт нь амьдралдаа хүнд сорилтуудтай тулгарсан хүмүүсийн хувьд нэн чухал зүйл болох Бурхан хийгээд амьдралын талаарх ойлголтыг бидэнд өгдөг.

Амьдралын сорилтуудын тухай Ахлагч Ричард Г.Скотт өгүүлэхдээ, “Танд бэрхшээл тохиолдсон үед та олон асуулт асуухад хөтлөгдөж болно. Зарим нь ашигтай зорилгод үйлчилдэг; бусад нь үгүй. Яагаад энэ нь надад тохиолдох ёстой юм бол? Яагаад би одоо үүнийг хүлцэх ёстой юм бол? Ийм юманд хүргэх юуг би хийчихсэн юм бол доо? гэж асуух нь таныг мухардал уруу хөтлөх болно. Бурханы тааллын эсрэг сөрөх асуулт асуух нь үнэхээр сайн биш. Харин, Би юу хийх ёстой вэ? Энэ турлилагаас би юу сурах ёстой вэ? Би юуг өөрчлөх ёстой вэ? Хэнд би туслах вэ? Хүнд сорилтуудын үед би өөрийн олон адислалыг хэрхэн санаж болох вэ? . . . гэхчлэн асуу.

“Энэ амьдрал бол гарамгай итгэлийн—Есүс Христэд итгэх итгэлийн, Түүний заадаг зүйлүүдэд итгэх итгэлийн, эдгээр заадаг зүйлүүдийг дуулгавартай дагахын тулд Ариун Сүнсээр удирдагдах бидний чадварт итгэх итгэлийн туршилага юм. . . . Итгэх гэдэг нь төгсгөлийг эхлээд мэдэхгүйгээр, хүсэл эрмэлзэлтэйгээр дуулгавартай дагана гэсэн үг юм (Номлогчийн Үгс 3:5–7-г үз). Үр жимс гаргахын тулд, Их Эзэнд итгэх таны итгэл өөрийнхөө хувийн бодол, туршилагад итгэх итгэлээс илүү хүчирхэг, илүү урт удаан байх ёстой” гэжээ (in Conference Report, 1995 оны 10-р сар, 18–19; Ensign, 1995 оны 11-р сар, 17).

Иовт тохиолдсон ямар ч хүнд сорилтууд нь түүний тусын тулд байх болно гэдэгт тэрээр бүрэн итгэхийн тулд Их Эзэнд итгэх илүү их итгэлтэй болоход нь Иовт юу тусалж болох тухай санааг Иов 38–39 бидэнд өгдөг.

Судруудыг ойлгох нь



Иов 38

Гарсан (ш. 29)—Төрсөн
Мичид зургаа, Марал гурав, Долоон бурхан, оддын

ордууд (ш. 31–32)—Бүлэг оддын нэрс, тэнгэрийн эрхэсүүд

Судруудыг судлах нь



А Их Эзэний асуултуудад хариул

1. Их Эзэн Иовоос асуусан асуултуудад та нар хэрхэн хариулах вэ?
2. Их Эзэний асуусан асуултуудад тэрээр хариулснаараа Иов юу мэдэх ёстой байсан гэж бодлогоо ярь.

Иов 40–42

Иов сорилтыг даван гарав

Бурханы аугаа их чанарыг та нар хэзээ жинхэнэ ёсоор ойлгож эхэлсэн бэ, та нарт ямар санагдсан бэ?

Их Эзэнд товч хариулах боломж тохиосон үед Иов Их Эзэний асуултуудад хариулсныг Иов 40 цэдэглэсэн байдаг (Иов 38–39-ийг үз). Их Эзэн өөрт нь хэлсэн зүйлд Иов хариу болгож, зүгээр л даруу байдлаа мэдэгдсэн ажээ. Их Эзэн тэгэхэд нь бүлэг 41-ийн төгсгөл хүртэл Иовт сургамжлахаа үргэлжлүүлжээ. Их Эзэний захиас нь бүлэг 38–39-ийн захиастай маш адилхан бөгөөд энэ нь, Их Эзэн бүх зүйлийг хянадаг бөгөөд бид даруу, дуулгавартай байх юм бол бүх зүйл бидний адислал, аз жаргалын төлөө байх болно гэсэн захиас юм.

Иов дахин ярьж, Их Эзэнээс тэрээр юу сурснаа, тэрчлэн сурсан зүйлийнхээ талаар ямар бодол өөрт нь төрсөн тухай илэрхийлснийг Иов 42 цэдэглэдэг. Тэгэхэд нь Их Эзэн Иовын найз нарыг наманчил гэжээ. Сүүлчийн хэдэн шүлэг нь эцэстээ Иовт юу тохиолдсоныг өгүүлдэг.

Судруудыг ойлгох нь



Иов 42

Миний уур асжээ (ш. 7)—
Би маш их ууртай байна

Мунхаглал (ш. 8)—Тэнэг үйлс

Иов 42:6—Өөрийгөө жигших нь зөв үү?

Иов 42:6-д Иов өөрийгөө жигшиж байна гэж хэлснээр, тэрээр өнгөрсөн үеийнхээ бардамнагч үйлдлүүдийн төлөө ихэд харамссанаа яруу найргийн аргаар илэрхийлсэн ажээ. Энэхүү гэмшил бол наманчлалын хийгээд Бурхантай илүү адилхан болох өсөлтийн чухал хэсэг мөн.

Судруудыг судлах нь

А Үүнийг өөрийнхөө үгээр хэл

Иов 42:5-ыг өөрийнхөө үгээр бичиж, дараа нь өөрийнхөө юу хийснийг тэрээр хэлсэн нь, Иовын хувьд ямар утга учиртай байсан гэж бодож байгаагаа илэрхийлсэн нэг догол мөр бич.

Б Тэр юу мэдсэн бэ?

Иов туршлагаараа дамжуулан юу ойлгосон гэж та нар бодож байна? Та нар хариулахаасаа өмнө дараах асуултууд болон мэдэгдлийг авч үз:

- Иов хүнд сорилтуудаасаа хэзээ чөлөөлөгдсөн бэ? Иовын гаднах, эсвэл доторх зүйлүүд, эхлээд юу өөрчлөгдсөн бэ?
- Иов амьдралдаа хожуу олж авсан зүйлийг (Иов 42:10–17-г үз) түүнд анх байсан зүйлтэй хэрхэн харьцуулж болох вэ (Иов 1:2–3-ыг үз)? Өсөлт нь юуг бэлэгдэж болох вэ?
- “Өөрсдийг тань хайрладаг Тэнгэрлэг Эцэг та нарт бий гэдгийг би гэрчилж байна. Та нарын аз жаргалын төлөө Аврагч Амиа өргөснийг би гэрчилж байна. Би Түүнийг мэднэ. Тэрээр та нарын хэрэгцээ бүрийг ойлгодог. Та нар Тэдний тааллыг гомдолгүйгээр хүлээн авах юм бол Тэд та нарыг адисалж, дэмжих болно гэдгийг би маш сайн мэднэ” хэмээн Ахлагч Ричард Г. Скотт хэлжээ (in Conference Report, 1995 оны 10-р сар, 21; *Ensign*, 1995 оны 11-р сар, 18).

Дуулалын Ном

Эртний Дуулалын Ном

Дуулалын Ном бол Бурханд магтаал, залбирал өргөдөг ариун яруу найргийн түүвэр юм. Энэ номны еврей хэл дээрх нэр нь *Телхиллим* бөгөөд “магтаалууд” гэсэн утгатай. Энэ номны грек хэл дээрх нэр нь *Дуулал* буюу “дуунууд” гэсэн утгатай юм. Энэ номон дахь яруу найргийн ихэнх нь дуу болж бичигдсэн бөгөөд чавхдаст хөгжмөөр ая хамтран дуулахад зориулагдсан ажээ. Дуулах нь ариун сүмийн шүтээний үйлчлэл, оршуулга, гэрлэлт, бусад баяр ёслол тэмдэглэх зэрэг олон нийтийн үйл ажиллагааны хэсэг байжээ.

Дээр дурдсаны дагуу, олон дуулал ердөө л Их Эзэнд магтаал өргөхийн тулд бичигдсэн аж. Түүнээс гадна, хууль, ариун сүм, байгаль буюу түүхийн үйл явдлуудад тусгайлан зориулагдсан тухай дууллуудыг та нар олох болно. Хамгийн сайхан бөгөөд зарим онцгой дууллууд Мессиа, Есүс Христийн тухай заадаг. Дуулалын ном нь Хуучин Гэрээний аль ч номноос илүүгээр Шинэ Гэрээнд иш татагдсан байдаг.



Бид бүх Дуулалын зохиогчийг мэдэхгүй, мөн олон нь зохиогчийг нэрлээгүй байдаг. Хаан Давид олон өөр дууллын зохиогч хэмээн хамгийн олон удаа дурдагдсан байдаг. Бусад хүмүүс: Мосе, Соломон, Асаф (Давидын хөгжимчин), мөн Левийн санваартнууд (Корагийн хөвгүүд) дурдагдсан байдаг. Зарим үед зохиогчийн нэр байдаггүй.

Дуулалыг судлахад бэлтгэх нь

Еврей яруу найргийн тухай бага сага ойлголттой бол, Дуулалыг илүү сайн ойлгоход тань тусалж чадна. Ихэнх яруу найраг нь сэтгэл хөдлөлийн хэл дээр бичигдсэн байна. Яруу найрагчид үйл явдлуудыг “итгэхэд” биш, харин аль болохоор өөрсдийн бодол санааг илэрхийлэхийг хичээдэг. Тэд өөрсдийгөө илэрхийлэхийн тулд бэлгэдлийн хэл, хэтрүүллийг ашигладаг. Түүнээс гадна, тэд айзам хэмнэлийн загвар ашиглах замаар өөрсдийн бодол санааг илэрхийлэх буюу уншигчиддаа гүнзгий сэтгэгдэл төрүүлэхийг бас хичээдэг.

Еврей яруу найраг нь “зэрэгцүүлэл” хэмээн нэрлэгддэг найруулгын хэлбэрт санаануудыг давтах замаар айзамт хэмнэлийг бий болгодог байна. Зарим үед зохиогч адил зүйлийг өөр өөр байдлаар хэлдэг байхад, өөр үед хоёр санааг бие биенд нь сөргүүлэн тавьдаг байна. Дуулал 1-ийн дараах жишээг авч үз. Энэ дуулал давтагдсан санаануудыг хамтад нь бүлэглэх замаар бичигдсэн байна. Зарим үед санаанууд нь эхний санааны нэмэлт жишээнүүд болдог байхад, өөр үед сүүлчийн санаанууд нь эхнийхээ санааны эсрэг утгатай байдаг.

- Дуулал 1:1–2 бол зэрэгцүүллийн эсрэг найруулгын жишээ мөн:

“Хорон муу хүний зөвлөгөөг дагадаггүй, нүгэлтнүүдийн зам дээр ч зогсдоггүй, басамжлагчдын суудалд ч суудаггүй хүн ерөөлтэй ээ!

“Харин тэрээр Эзэний хуульд баярлаж, түүний хуулийг өдөр шөнөгүй тунгаан бясалгадаг.”

- Дуулал 1:3–4 нь хоёр сөргөцүүллийн бэлгэдлийн хэлийг харуулдаг:

Санаа. “Тэрээр урсгал усны дэргэд тарьсан мод адил билээ, тэр мод цагтаа үр жимсээ ургуулдаг бөгөөд, навчис нь ч хатдаггүй, тэр хүний үйлс бүхэн нь өлзийтэй.”

Эсрэг санаа. “Хорон муу хүмүүс бол тийм бус: харин тэд салхинд хийсдэг тарианы хальс мэт.”

- Дуулал 1:5 бол давтагдсан санааны жишээ мөн:

“Тийм учраас хорон муу хүн шийтгэлд, нүгэлтнүүд ч зөв шударга хүний цуглаанд зогсож чадахгүй.”

- Дуулал 1:6 бол эсрэг зэрэгцүүллийн өөр нэг жишээ мөн:

“Зөв шударга хүний замыг Эзэн мэддэг: харин хорон муу хүний зам сөнөх болно.”

Зохиогч дүрслэлүүдийг ашигласан нь зургуудыг үгээр будсан мэт байгааг дээрх жишээнээс ажигла. Ийм маягийн бичээс нь санаануудад илүү их хүчийг өгдөг. Бурханлиг хийгээд Бурханыг баярлуулдаг хүн адислагдах болно гэдгийг бид хэлж болно. Гэвч Дуулал нь үүний оронд, голд маш ойрхон тарьснаас байнгын тэжээл, шинэ сэргэг эрчмээр сэлбэгддэг, үргэлж ургаж, үр жимсээ өгдөг модыг дүрсэлдэг. Энэ дүрслэл нь зүгээр л хүн адислагддаг гэж хэлснээс илүү их хүчийг уншигчийн буюу сонсогчийн оюун санаа, зүрх сэтгэлд авчирдаг.

Хэрэв та нар еврей яруу найргийн тухай эдгээр санаануудыг дотроо санаж, Дуулалын номыг унших юм бол, Дуулалаас та нар илүү олон сонирхолтой зүйлийг олж, тэдгээрийн заадаг зүйлүүд илүү агуу хүчтэйгээр та нарын зүрх сэтгэлд ирэх болно.

Дуулалын номыг бүхэлд нь судлах боломжгүй учраас, энэ судлах удирдамж Шинэ Гэрээний зохиогчдоор иш татагдсан, нилээд хэдэн чухал дуулал, Аврагчийн тухай дууллууд, Сайн мэдээний чухал сургаалын тухай өвөрмөц ойлголт агуулдаг дууллуудад та нарыг чиглүүлэх болно. Гэвч та нар Дуулалыг бүхэлд нь уншвал, сайн хэрэг. Энэ судлах удирдамжид дурдаагүй аль нэг дуулал та нарын дуртай дууллуудын нэг байж болно.

Дуулал 22

Есүс Христийн тухай дуулал

Дайснуудынх нь довтолгоо үргэлжийнх юм шиг санагдсанд хариу болгож Хаан Давидын хэлсэн буюу дуулсан үгсийг Дуулал 22 агуулдаг. Аврагч махан биенд ирэх үед түүнд юу тохиох тухай энэ дуулалын угтан хэлсэн арга хэлбэрүүдийг эрж ол.

Судруудыг судлах нь

А Аврагчийн тухай зүйлүүдийг эрж ол

Дуулал 22 дахь шүлэг	Юу тохиолдсон бэ	Матай 27 дахь ишлэлүүд
1		
6-8		
16		
18		

1. Дуулал 22-оос гадна, Матай 27:27–50-ийг унш. Дараах хүснэгтийг тэмдэглэлийн дэвтэртээ хийж, Матай 27-д цэдэглэгдсэнчлэн, Дуулал 22-ын нэг шүлэг Есүсийн амьдралд хэрхэн биелэгдсэнийг тэмдэглэ.
2. Дуулал 22-ын шүлэг 19-өөс эхлэн, Давид илүү найдвар бүхий санаа бодлуудыг илэрхийлжээ. Шүлэг 19–31 нь залбиралтай адил боловч, тэдгээр нь чухал үнэнүүдийг агуулдаг. Бид яагаад “хэлэх” (ш. 22), “магтах” (ш. 22–23), “алдаршуулах” (ш. 23), эсвэл “эмээх” (ш. 23) ёстойг тайлбарласан зүйлийг шүлэг 24–31-ээс сонго.

Дуулал 23

“ЭЗЭН бол миний Хоньчин”



Дуулал 23 бол Хожмын үеийн Гэгээнтний дуулалын номон дахь “ЭЗЭН бол миний Хоньчин” гэдэг үгсийн эх сурвалж болсон алдарт дуулал юм, энэ нь Их Эзэний хайр халамжийн тухай бидэнд заадаг.

Судруудыг судлах нь

А Дүрслэлүүдийг тайлбарла

Та нар бол Дуулал 23 дахь Их Эзэний хурганууд юм. Энэ Дуулал дахь: “ЭЗЭН бол миний хоньчин” (ш. 1), “Тэр намайг ногоон бэлчээрт хэвтүүлдэг” (ш. 2), “Тэр миний сэтгэлийг сэргээдэг” (ш. 3), “таны саваа, таны таяг намайг тайвшруулдаг” (ш. 4), “аяга минь дүүрч бялхдаг” (ш. 5) гэсэн өгүүлбэрүүд ямар утгатайг өөрийн үгээр тайлбарла.

Б Өөрийн дуртай өгүүлбэрийг сонго

Их Эзэний тухай өөрийн чинь бодол санааг илэрхийлдэг нэг өгүүлбэрийг Дуулал 23-аас сонгож, өөрийн сонголтыг тайлбарла.

Дуулал 24

Их Эзэний Ирэлтийн баяр хөөр



Дуулал 24 бол Их Эзэнийг ирэхэд түүнтэй хамт байх тухай юм.

Судруудыг ойлгох нь

Дуулал 24:6, 10—“Села” гэж юу вэ?

Дуулалд *села* хэмээн орчуулагдсан еврей үг “дээш өргөх” гэсэн утгатай язгуур үгнээс гаралтай ажээ.

Судруудыг судлах нь

А Энэ нь ямар өөрчлөлт гаргадаг вэ?

Дуулал 24:1-д илэрхийлэгдсэн үнэнд хүн үнэхээр итгэсэн үед энэ нь ямар өөрчлөлт гаргана гэж боддогоо дүрсэл.

Б Төгс Эзэмших судар—Дуулал 24:3–4

1. Бид Их Эзэний өргөөнд болон түүний оршихуйд орохын тулд хийх ёстой гэж Дуулал 24:4-д өгүүлсэн зүйлүүдээс жагсаалт хий. Өөрийн жагсаасан үг буюу өгүүлбэр бүрийг өөрийн үгээр дүрсэл.
2. Сургаал ба Гэрээ 97:15–17-г уншиж, бид Их Эзэний оршихуйд хэрхэн байж болох талаар уг шүлэг юу гэж өгүүлснийг ярь. Та нар судруудынхаа зах дээрх ишлэлийг Дуулал 24:3–4-ийн дэргэд бичихийг хүсэж болно.

В Иосеф Смитийн Орчуулгаас авах тусламж

“Судруудын Удирдамж дахь Библийн Иосеф Смитийн Орчуулгаас авсан түүврүүд” ямар чухал ойлголтуудыг Дуулал 24:7–10 дээр нэмсэн байна вэ?

Дуулалаас сонгож авсан шүлгүүд

Дараах судлах хэсэг нь өөр өөр дуулуудаас сонгож авсан зарим өвөрмөц, чухал шүлгүүдийг сурахад та нарт туслах болно. Та нар дуулал бүрийг нэг бүрчлэн унших шаардлагагүй, гэвч яах нь та нарын хүслийн хэрэг юм.

Судруудыг судлах нь

Дуулалд зориулсан дараах үйл ажиллагаануудаас (А–Е) наад тал нь дөрвийг хий.

А Санаануудыг харьцуул

1. Дуулал 8:3–4; Мосе 1:8–10-ыг унш. Мосегийн туршлага Дуулал 8-ын зохиогчийнхтой хэр зэрэг адилхан байсан бэ?
2. Бурханы аугаа чанарыг танин мэдэхэд, түүнчлэн илүү даруу байхад та нарыг урамшуулан дэмжихэд юу та нарт тусалсан тухай бич.
3. Дуулал 8:4-т асуусан асуултад хариул.

Б Христийн тухай нэгэн бошиглол

Дуулал 41:9 дэх санаанууд хийгээд бодролууд Есүсийн амьдралд хэрхэн биелэгдсэнийг тайлбарла (Матай 26:14–16; Иохан 13:18–26-г үз).

В Бошиглогчийнхоор утгыг тайлбарла

Дуулал 118:22-ыг, дараа нь Үйлс 4:10–12-ыг унш. Дуулал 118:22-т Петр юуны тухай хэлснийг өөрийн үгээр бич.

Г Бурханы Үгийн хүч

1. Их Эзэний үг түүнд байж, түүний заадаг зүйлүүдийг мэдсэн учраас тэрээр ашиг тусыг олсон хэмээн Дуулал 119:97–105-ыг зохиогч хэлсэн бүх арга замыг жагсаа.
2. Их Эзэний үг та нарын хөл дэх “дэнлүү,” та нарын зам дахь “гэрэл” болдог гэж өөрсдийн боддог арга замуудын тухай ярь. 1 Нифай 17:13-ыг унш.

Д Бурханы нэрнүүд ба тодорхойлолтууд

1. Дуулалд өөрсдийн олсон Бурханы таван өөр нэрний (энд наад тал нь хорин долоо байгаа) жагсаалт хий.
2. Дуулал яагаад ийм олон өөр нэр хэлсэн гэж та нар бодож байна?
3. Дуулалд Бурханыг дүрсэлсэн наад тал нь таван өөр (энд хамгийн наад тал нь гучин хоёр байгаа) өгүүлбэрийг жагсаан бич.

4. Өөрийнхөө хийсэн жагсаалтнаас Их Эзэний талаар өөрийн чинь бодол санааг хамгийн сайн дүрсэлсэн нэг өгүүлбэрийг сонго.

Е Ишлэлийг ол

Өөрийнхөө сонгож авсан хэдэн дууллыг анхааралтай унш. Зурагт хуудасны сайн тайлбар болно гэж өөрийн бодсон нэг санааг эрж ол. Уг өгүүлбэрийг тэмдэглэж аваад, яагаад энэ өгүүлбэрийг сонгосноо тайлбарла.

Сургаалт Үгс

Сургаалт үг бол, ёс суртахууны зохих зан төлвийг илэрхийлдэг товч хэллэг юм. Сургаалт Үгс ном нь хүн өөрийн шашнаар амьдрах болон зохих ёс суртахуун бүхий зан төлвийн талаар илүү практик шинжтэй зөвлөгөө өгдөг. Энэ номон дахь дараах зөвлөгөөнүүдээс бид бүгд ашиг тус олж чадна.

Сургаалт Үгсийг судлахад бэлтгэх нь

Соломон олон сургаалт үгсээр ярьдаг байсныг бид Хаадын Дээд 4:32-оос уншсан; Соломон бол энэ номон дахь сургаалт үгсийн зохиогч мөн хэмээн Сургаалт Үгс 1:1 өгүүлдэг хэдий ч, бусад зохиогчид бас дурдагдсан байдаг (жишээ нь, Сургаалт Үгс 30:1; 31:1-ийг үз).

Сургаалт Үгс нь өргөн цар хүрээтэй сэдвүүдийг хамарсан үг хэллэгийг агуулдаг. Нэг шүлэг нь үүний өмнө буюу дараах шүлэгтэй (сургаалт үг) ямар ч холбогдолгүй байж болно. Ихэнх Сургаалт Үгс Дуулалын номны оршилд дүрслэгдсэн еврей яруу найргийн хэлбэрээр бичигджээ.

Та нар Сургаалт Үгс номыг Дуулалын номыг судалсны адилаар судлах болно. Бүлэг бүрийг судлахын оронд, та нар зарим чухал шүлгүүдийг судалж, авч үзэх болно.

Сургаалт Үгс

Тойм

Судруудыг судлах нь

Сургаалт Үгсийн номыг судлахдаа дараах арванхоёр үйл ажиллагаануудаас (А–К) зургааг нь хий.

А Нэр өг

1. Сургаалт Үгс 1:7; 9:10 бол Сургаалт үгсийн номын сэдэв мөн гэж зарим хүмүүс боддог. Эдгээр шүлгүүдийг унш. Уншсан зүйл дээрээ тулгуурлан, Сургаалт Үгсийн номонд нэр зохион бич. (Анхааруулга: эмээх гэдэг үг энд Бурханыг хүндлэх, Бурханыг дээдлэн хүндэтгэх гэсэн утгаар хэрэглэгджээ.)
2. Өөрсдөдөө тохиолдсон болон мэдсэн зүйлээсээ эдгээр шүлгүүдийн заадаг зүйлүүд үнэн болохыг тайлбарла.

Б Төгс Эзэмших Судар—Сургаалт Үгс 3:5–6

1. Сургаалт Үгс 3:5–6-гийн утгыг илэрхийлсэн ямар нэг зүйл зур. Жишээ нь, та нар схем буюу богинохон хялбар өгүүлбэртэй зураг зурж болно. Зургаа гэрийнхэндээ үзүүлж, утгыг нь тэд ойлгох нь уу гэдгийг шалга, тэгээд уг судрыг уншиж, утгыг нь тэдэнд тайлбарла.
2. Сургаалт Үгс 3:5–6-гийн үлгэр жишээ болсон ямар хүний тухай та нар Хуучин Гэрээнд уншсан бэ? Яагаад гэдгийг тайлбарла.

В Жишээ гарга

Сургаалт Үгс 3:11–12 дахь “зэмлэх” гэдэг үг залруулах зорилгоор шийтгэх гэсэн үг юм. Энэ сургаалт үгийн үнэнийг харуулсан, богинохон нөхцөл буюу түүх бич.

Г Хүснэгт хий

Дараах хүснэгтийг хийж, Сургаалт Үгс 6:16–19 дэх мэдээллээр, түүнчлэн Их Эзэн юуг “жигшдэг” тухай хувийнхаа бодол санаа, туршлагаадаас хүснэгтийг бөглө (Сургаалт Үгсэд долоон янзын зан чанарыг жагсаасан байх ёстой).

Их Эзэний жигшдэг зан чанарууд	Тэрээр яагаад эдгээр зан чанарыг жигшдэг гэж та нар бодож байна

Д Найздаа зөвлөгөө өг

Яагаад ариун явдлын хуулиар амьдрах ёстой юм бэ гэдэг талаар эргэлзэж байгаа нэг хүнд өөрийгөө тусалж байна гэж бод. Сургаалт Үгс 6:23–33-аас та ямар шүлгийг түүнд уншиж өгөх вэ? Өөрийнхөө сонгосон шүлэг бүрийн хувьд, тухайн шүлэг юу заадгийг та хэрхэн тайлбарлах вэ? Жишээ нь, хэрэв та шүлэг 32-ыг сонгосон бол, “Садар самууныг үйлддэг хүнд ямар ойлголт дутагддаг гэж та боддог вэ?” гэж асууж болно.

Е Үүнийг туршиж үз

Сургаалт Үгс 15:1, 18; 16:32-т заагдсан зарчмуудаар хоёр буюу түүнээс дээш хоног амьдрахыг хичээ, тэгээд өөрийнхөө туршлагын талаар тэмдэглэлийн дэвтэртээ бич.

Ё Өөрийнхөө үгээр бич

Сургаалт Үгс 27:12-ыг өөрийнхөө үгээр бич. Шүлэг 12 *Залуучуудын Бат Бөх Байдлын Төлөө* товхимлоос (34285) бидний хүлээн авдаг зөвлөгөөтэй хэрхэн холбогдож болох вэ?

Ж Эсрэг утгыг нь бич

Судруудад байгаа санаануудын эсрэг утгыг уг шүлэг илэрхийлэхээр Сургаалт Үгс 30:11–14-ийг дахин бич. Тухайлбал, зөв шударга бус үеийнхний тухай өгүүлж байгаа шүлгийн оронд, энэ нь Хожмын үеийн Гэгээнтнүүдийн зөв шударга үеийнхний тухай өгүүлэх болно. Энэхүү зөв шударга үеийнхнийг төлөвшүүлэхэд туслахын тулд та юу хийж болох вэ?

З Агуу эмэгтэйчүүдийн төлөө

Сургаалт Үгс 31:10–31 нэгэн бурханлиг эмэгтэйн тодорхойлолтыг өгдөг. Энд дурдагдсан хамгийн чухал таван чанар юу болохыг жагсааж, өөрийн чинь сонгосон чанар бүр яагаад чухал болохыг тайлбарла.

И Хэрэв та тийм ухаалаг юм бол . . .

Сургаалт Үгсийн ихэнхийнх нь зохиогч Соломон байх учиртай. Соломоны амьдралын тухай өөрийнхөө мэддэг зүйлийг авч үзэн, амьдралынх нь хожуу үед түүнд тулгарсан асуудлуудаас түүнийг аварч болох байсан гэж өөрийн боддог нэг сургаалт үгийг ол.

Й Эд баялгийн тухай сургаалт үгс

Дараах сургаалт үгсийг уншиж, эдгээр нь эд баялгийн тухай юу гэж хэлснийг хураангуйлан дүгнэ: 11:4, 28; 13:7–8; 15:16; 19:17; 21:6, 17; 22:1–2, 4, 7, 9, 16, 22–23; 28:6, 8, 11, 20, 22, 27; 30:7–9.

К Ажил хөдөлмөрийн тухай сургаалт үгс

Дараах сургаалт үгсийг уншиж, эдгээр нь ажил хөдөлмөрийн тухай юу гэж хэлснийг хураангуйлан дүгнэ: 6:6–11; 10:4, 26; 12:24, 27; 13:4; 14:23; 19:15; 20:4, 13; 21:25–26; 24:30–34; 26:13–16; 28:19.

Номлогчийн Үгс буюу Номлогч

Төлөвлөгөөний тухай мэдлэггүй амьдрал

Хэрэв та энэ амьдрал бол зөвхөн бидний оршин тогтнолт юм—үхлийн дараа бидний амьдралын төлөөх хариуцлага гэж үгүй гэдэгт итгэдэг байсан бол, амьдралын тухай таны бодол санаа, үзэл хэр зэрэг өөр байх байсан бол?

Номлогчийн Үгсийн зохиогч энэ номын ихэнхийг, энэ амьдралаар бүх зүйл дуусдаг гэдэгт тэрээр итгэдэг итгэлийн үүднээс бичжээ. Энэ үзэл бодлын үүднээс бичсэнээрээ, Сайн мэдээгүй бол амьдрал хичнээн урам хугарам байхыг тэрээр харуулсан аж. Хамгийн сүүлчийн бүлэгт тэрээр үхлийн дараа амьдрал үргэлжилдэг гэдэгт үнэхээр итгэдэггүйгээ хүлээн зөвшөөрч, хэрэв бид Бурханд үйлчилж, Шүүлтийн төлөө бэлтгэхгүй юм бол амьдрал үүрд үргэлжилдэг учраас амьдрал өнө удаан үргэлжлэгч утга учиргүй буюу аз жаргалгүй юм—энд бүх зүйл “хоосон” (түр зуурын хийгээд сэтгэл ханамжгүй) гэдэг нь үнэхээр бодитой харагдах болно гэжээ.

Номлогчийн Үгсийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг, Судруудын Удирдамж, “Номлогчийн Үгс”-ээс үз.

Номлогчийн Үгс 1–2

“Бүгд хоосон”



“Номлогч” (тэр өөрийгөө ингэж нэрлэжээ) баяр хөөр, аз жаргалын удаан үргэлжлэгч мэдрэмжийг олохоор хийсэн эрлийнхээ тухай өгүүлсэн зүйлийг Номлогчийн Үгс 1—2 цэдэглэдэг. Та нар уншихдаа, түүний үзсэн, хийсэн,

эрж хайсан зүйлүүдийн талаар ямар бодол санаатай байдаг тухайгаа бод.

Судруудыг ойлгох нь



Номлогчийн Үгс 1

Наран доор (ш. 3, 9)—Газар дэлхий дээр

Тойргоороо (ш. 6)—Нэгэн хэвээр буюу загвараар

Шаналгах (ш. 13)—Зовоох

Номлогчийн Үгс 2

Юу болж байна? (ш. 2)—Ямар сайныг энэ нь үйлддэг вэ?

Шан харамж (ш. 10, 21)—Цалин

Тэднийг хоёуланг нь нэг хувь заяа нөмөрч (ш. 14)—

Тухайн хүн ухаалаг байна уу, эсвэл тэнэг байна уу ялгаагүй, хүн бүрд ямар нэг юмс тохиолдоно

Бөөгнүүлэх (ш. 26)—Нөөцлөх

Судруудыг судлах нь



А Жагсаалт хий

Зохиогч өөрийг нь баяртай болгох ёстой гэж хэлсэн боловч ингээгүй, наад тал нь таван зүйлийг Номлогчийн Үгс 1–2-оос жагсаа. Өөрийн жагсаалт дахь зүйл бүрийн дараа, уг шүлгийн ишлэлийг хаанаас олсноо бич. Жагсаалт хийхээр өөрийн сонгосон таван зүйлийг та нар судрууддаа онцгойлон тэмдэглэхийг хүсэж болно.

Б Та нар зөвшөөрөх үү, эсвэл эс зөвшөөрөх үү?

Номлогчийн Үгс 1:18-ыг унш. Энд өгүүлсэн түүний мэдэгдлийг та нар яагаад зөвшөөрч байгаа, эсвэл яагаад зөвшөөрөхгүй байгаагаа номлогчид бичиж, хэл.

Номлогчийн Үгс 3

Та чадах л юм бол амьдралыг хамгийн сайхан болго

Номлогчийн Үгс 3 нь амьдралд гутрал цөхрөл хэрхэн байдгийг өгүүлдэг; ёс бусчууд хийгээд зөв шударга хүмүүс, ухаалаг хүмүүс хийгээд тэнэг хүмүүс бүгдэд нь сайн болон муу зүйл тохиолддог. Хэдийгээр сайн ба муу цаг үе бүгдэд тохиодог ч гэсэн, хэрэв хүн сайн амьдралаар амьдарч, бүр баяр хөөр удаан үргэлжлэхгүй байлаа ч гэсэн, тэрээр баяр хөөрийг эрэлхийлэх юм бол, тэр хүн илүү аз жаргалтай байдаг гэснээр бүлэг 3 төгсдөг. Өөрөөр хэлбэл, сайн ба муу бүгдэд адилхан тохиолддогос хойш, сайныг байгаа дээр нь бид эдэлж болох ажээ.

Номлогчийн Үгс 3:1–8 бол Номлогчийн Үгсэд хамгийн олон удаа давтагддаг шүлгүүд юм. Гэвч эдгээр нь буруу ойлгогдож болно. Юм бүхэн өөрийн цаг хугацаатай байдаг

гэж хэлснээрээ, бүх хүмүүст тохиолддог зарим үйл явдлууд байдгийг номлогч энгийнээр хэлсэн ажээ. Алах буюу үзэн ядах, эсвэл бусад сөрөг зүйлүүдийг үйлдэх цаг бид бүгдэд байдаг гэж тэр хэлээгүй юм. Зарлигуудад дуулгаваргүй байх тохиромжтой цаг гэж ерөөсөө байдаггүй.

Номлогчийн Үгс 4–5

Та нарыг юу аз жаргалтай болгодог вэ?

Бурхан, түүний зарлигууд болоод мөнх амьдралын тухай үнэнүүдэд итгэдэггүй буюу эдгээрийг хүлээн аваагүй тохиолдолд хүмүүсийг аз жаргалтай болгодог амьдралын тийм арга зам байдаг уу? Хэдийгээр сайхь номлогч дэлхийд өдий төдий “хоосон зүйлийг” харсан ч гэсэн, түүний хувьд өөрөөр төдийлөн учир холбогдолгүй ч, (Бурханы төлөвлөгөөг ойлгохгүйгээр) илүү их аз жаргал уруу хөтөлдөг зөв зүйтэй зүйлүүд дэлхийд бас байдгийг тэрээр Номлогчийн Үгс 4–5-д хүлээн зөвшөөрчээ.

Судруудыг ойлгох нь



Номлогчийн Үгс 4

Дарамт дарлал (ш. 1)—Хүмүүст тохиолддог муу зүйлүүд

Номлогчийн Үгс 5

Хувь хишиг (ш. 18–19)—Шагнал буюу ашиг

Судруудыг судлах нь



А Зарим сайн зөвлөгөөг ол

Хэдийгээр “бүгд хоосон” ч гэсэн, хийх нь утга учир бүхий зарим үйлсийг Номлогчийн Үгс дурдсан байдаг. Номлогчийн Үгс 4–5-д өөрсдийн уншсан зүйлээсээ, бүр Бурханд итгэдэггүй хүнд ч гэсэн сайн зөвлөгөө болох хоёр зүйлийн тухай бич. Бурханд итгэдэггүй хүнд та энэ зөвлөгөөг өгч байна гэж үзэн, үүнийг тайлбарла.

Номлогчийн Үгс 6

Бүгд хоосон хэвээр

Эд баялаг, нэр хүнд, үр хүүхэд хэрхэн төгс аз жаргал авчирч чаддаггүйн илүү олон жишээг Номлогчийн Үгс 6 агуулдаг. Хэрэв дэлхийн эд баялаг, магтаал сайшаал, үр удам бүх зүйл юм бол, амьдрал утга учиргүй юм гэдгээр уг бүлэг төгсдөг.

Номлогчийн Үгс 7–11

Амьдралд сэтгэл ханамжийг олох нь

“Бүгд хоосон” гэж хэлсний дараа, эсвэл тэрхүү юу ч биш нь үнэхээр бүрэн баяр хөөрийг авчирдаг гэж хэлсний дараа, түүний бодсон зүйл хүнд түр зуурын зарим аз жаргалыг авчирдаг гэж хэлэхийн тулд номлогч Номлогчийн Үгс 7–11-ийг ашиглажээ. Хэдийгээр “бүх зүйл хоосон” ч, бусдыгаа бодвол илүү аз жаргал авчирдаг амьдралын зарим арга зам байдаг хэмээн тэрээр номложээ.

Судруудыг судлах нь

А Сургамжуудыг хураангуйлан дүгнэ

Номлогчийн Үгс 7–11-ийн дараах шүлгүүдийг уншиж, хүн мэдэх ёстой, эсвэл өөртөө байлгах ёстой, амьдрал дахь аз жаргал хийгээд сэтгэл ханамжийн хэмжээний тухай номлогчийн хэлсэн зүйлийг хураангуйлан дүгнэ: 7:1, 11–12, 17–22; 8:12–13; 9:4–10; 10:8, 12–14; 11:1, 8–10.

Соломоны Дуун

Судруудын Удирдамж, “Соломоны Дуун”-г үз.

Исаиагийн Ном

Исаиагийн ном бусад ямар ч номноос илүүгээр судрын бусад зохиогчдын анхаарал, магтаал сайшаалыг хүлээдэг билээ. “Их Эзэн өөрсдийн Гэтэлгэгчид итгэхийг [өөрийн ах нарт] илүү бүрэн дүүрнээр ятгахын” (1 Нифай 19:23) тулд Нифай Исаиагийн бичээсүүдийг ашиглаж, “миний бодгаль түүний үгсэд баясах бөлгөө” (2 Нифай 11:2) хэмээн хэлжээ. Түүнээс гадна, Исаиагийн үгс “гэдний зүрх сэтгэлийг өргөж, мөн бүх хүмүүсийн төлөө баясахад” (2 Нифай 11:8) хүмүүсийг хүргэх болно хэмээн Нифай хэлжээ. Израилын угсааных болох тэд Исаиагийн үгсийг өөрсөдтэйгөө адилтгах ёстой гэж Нифайн

Номлогчийн Үгс 12

Дүгнэлт

Хэрэв та өнөөдрөөс хойш долоо хоногийн дараа үхэхээ мэдвэл, та сүүлчийнхээ өдрүүдэд юу хийх вэ?

Номлогчийн Үгс 12 нь номлогчийн дүгнэлтийн захиасыг агуулдаг. Залуу хүмүүс боломжтой байгаа үедээ л сайн амьдрахыг тэрээр тэдэнд сануулжээ, учир нь тэдний үхэх өдөр ирэх болно. Номлогчийн Үгс 12-ын сүүлчийн хоёр шүлэг нь тэрээр амьдралын мөнхийн мөн чанарт итгэдэг байжээ гэсэн анхны бодит санааг бидэнд өгдөг. Өмнөх арваннэг хагас бүлэгт, Бурхангүйгээр амьдрал багаахан утга учиртай хэдий ч, сайн амьдралаар амьдрах нь бас ч чухал гэдгийг нотлохыг хичээснийг эдгээр шүлгүүд өгүүлдэг. Амьдрал мөнх бөгөөд нэгэн цагт бид Бурханы өмнө зогсож, шүүгдэх болно гэдгийг бид мэдэх нь сайн амьдралаар амьдрахыг бүр ч илүү утга учиртай болгодог. Энэхүү шалтгааны улмаас, Номлогчийн Үгс 12-ын сүүлчийн хоёр шүлэг бол энэ номны жинхэнэ захиас юм.

Судруудыг судлах нь

А Үзүүлэн хий

1. Номлогчийн Үгсийн өгүүлдэг зүйл бол хүний бүхий л үүрэг болох тухай бичмэл үзүүлэн хий (хамгийн багаар тэмдэглэлийн дэвтрийнхээ нэг хуудас хэмжээтэй).
2. Номлогчийн Үгс 12:13–14-т өгүүлснээр, “хүн бүхний үүргийг” бид мэдэж, биелүүлэхийн шалтгаан нь юу вэ?

нэг зуу орчим ишлэл татсан байдаг. Христ Амилалтынхаа дараа нифайчууд дээр хүрч ирсэн тэр үед, тэд “эдгээр зүйлүүдийг хичээнгүйлэн судлах ёстой; учир нь Исаиагийн үгс агуу юм” (3 Нифай 23:1) гэдгийг Христ хүмүүст хэлжээ.

Исаиагийн үеийн онцлог

Исаиа ойролцоогоор МЭӨ 740–700 оноос амьдарч, бошиглож байжээ. Тэр үед ассиричууд Умард Хаант улс Израилыг эзэлсэн аж. Исаиагийн амьдарч байсан Өмнөд Хаант Улс Иуда Ассирид татвар төлж, түүнчлэн тэдэнд устгал нүүрлээд байжээ. Гэвч Иудагийн Хаан Хезекиа Исаиагийн зөвлөгөөг дагасан учир тэд аврагдсан юм. Тэд наманчлахаа үргэлжлүүлэх ёстой, эс бөгөөс тэднийг Ассиричууд бус харин Вавилончууд устгах болно гэдгийг Исаиа Иудад сануулж байжээ.

Есүс Христийн нэг дэх болон хоёр дахь ирэлтийн тухай Исаиа Хуучин Гэрээний бусад аль ч бошиглогчдоос илүү ихээр өгүүлсэн юм. Тэрээр хосгүй өвөрмөц, сүнслэгээр нөлөөлөгдсөн заах арга барилтай байв; түүний бошиглолуудаас олон нь зөвхөн түүний үед төдийгүй, Есүс Христийн үед, манай өнөө үед, тэрчлэн ирээдүйд холбогддог. Заримдаа бүр нэг шүлэг буюу бүлэг шүлэг нь нэгээс дээш цаг үед холбогдож чаддаг.



Исаиаг хэрхэн унших вэ

Исаиа бол Бурханы бошиглогч, авьяаслаг зохиолч, түүнчлэн Израилын овгуудын хувьд яруу найрагч байлаа. Энэ шалтгааны улмаас, түүний зарим бичээсүүд еврей хэлнээс бусад хэлнүүдэд орчуулагдсан тохиолдолд ойлгоход хүнд байж болдог. Дуулалын оршилд еврейн яруу найргийн тухай мэдсэн зүйлээ эргэн сана (х. 131–132-ыг үз). Тэнд дурдагдсан санаанууд Ариун Сүнсний Мэдрэмжтэй нэгдэн нийлснээр Исаиагийн номыг ойлгоход та нарт туслах болно. Дүрслэлүүд хийгээд бэлэгдлүүдийг ашиглах явдлаар дамжуулан, Исаиа өөрийн захиасыг хүчтэйгээр заасан байдаг. Ичиж байгаа сарны тухай, моднууд алгаа ташихад баясч байгаа газар, тэрчлэн газраас ярьж байгаа номны тухай та нар унших болно. Тэдгээрийн тухай Исаиагийн бичсэн бодлууд хийгээд зарчмуудыг ойлгохын тулд та нар эдгээр болон бусад дүрслэлүүдийн цаад утгыг нээн унших бол, түүний үгс илүү агуу санааг илтгэх болно. Та нар Ариун Сүнсний тусламжийг эрэлхийлэх юм бол, Исаиа бол бүх судраас сүнсний нөлөө хамгийн ихтэй, хамгийн хүчирхэг номнуудын нэг гэдгийг та нар олж мэдэх болно.

Бошиглогч Исаиа болон түүний бичээсүүдийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг *Судруудын Удирдамж*, “Исаиа”-гаас үз.

Исаиагийн тойм									
Ерөнхий сэдвүүд	Шүүгчид				Түүхийн хэсэг		Мессиагийн амлалт		
Ишлэл	1:1	13:1	24:1	28:1	36:1	40:1	49:1	58:1	66:24
Сэдвүүд	Иуда	Үндэстнүүд	Их Эзэний өдөр	Шүүлт ба адислалууд	Иерусалим устгалаас хамгаалагдан үлдсэн нь; Хезекиагийн амьдрал уртсав	Израилын чөлөөлөлт	Израилыг чөлөөлөгч	Израилын алдар суут ирээдүй	

Исаиа 1

Исаиа Израилыг наманчлалд дуудав

Өөрийн номон дахь бүлгүүдийг Исаиа Библид байдаг тэдгээрийн дэс дарааллаар бичсэн гэдэгт бид итгэдэггүй. Гэвч эдгээр бүлгүүд Исаиагийн бүрэн захиасыг хамгийн сайнаар дамжуулахын тулд дэс дарааллыг нь анхаарч тогтоосон бололтой. Исаиа 1 бол: (1) Их Эзэний хувьд харуусалтай юуг хүмүүс үйлдсэнийг (ш. 1–9), (2) тэд яагаад наманчлах хэрэггүй гэж боддог байсан тухай (ш. 10–15), (3) хэрэв тэд наманчлах юм бол Их Эзэн тэдэнд юу амласныг (ш. 16–19, 25–27), мөн (4) хэрэв тэд наманчлахгүй бол юу болохыг (ш. 20–24, 28–31) өгүүлснээр, номыг нийтэд нь урьдчилан тоймлож, хураангуйлан дүгнэсэн Исаиагийн номны өмнөх үг лугаа адил юм.

Та нар уншихдаа: Бид Израилын угсааных учраас, бид эдгээр үгсийг өөрсөдтэйгөө адилтгах ёстой гэсэн Нифайн болон Иаковын зөвлөгөөг сана (1 Нифай 19:23; 2 Нифай 6:5-ыг үз). Исаиагийн заадаг зүйлүүд болон бошиглолуудаас олон нь тэдгээрийг тэрээр өнөөдөр өгүүлсэн лугаа адил бидэнд холбогддог.

Судруудыг ойлгох нь



Исаиа 1

Гэмд дарагдсан (ш. 4)—
Нүглийн хүнд дарамт
үүрч яваа
Ялзарсан хөвгүүд (ш. 4)—
Нүгэл үйлдэгчид
Усан үзмийн талбай дахь
нуувч, өргөст хэмхийн тал-
бай дахь манаачийн овоо-

хой (ш. 8)—Түр хоргодох
оромж
Миний хашааг дэвслэхийг
хэн шаардсан бэ? (ш. 12)—
Миний өргөөнд ир гэж хэн
та нарыг урьсан бэ?
Та нар гараа өргөх (ш. 15)—
Залбирах

Судруудыг судлах нь



А Израил . . . лугаа адил

1. Исаиа 1:2–9, 21–22, 30–31-ийг уншиж, Иудагийн хүмүүс, тэдний нүглүүдийг дүрслэхэд Исаиагийн ашигласан бүх дүрслэл буюу бэлгэдлийг жагсаа.

2. Иудагийн ямар нүглүүд өнөө үеийн хүмүүсийн нүглүүд вэ?

Б Төгс Эзэмших Судар—Исаиа 1:18

Их Эзэн хэдийгээр израилчуудын хувьд хатуу чанга байж, хүчтэй хэллэг ашигладаг байсан ч, тэрээр тэднийг наманчлахад урьсан байдлаар нь бид түүний хайрыг мэдэрч болно. Бидний нүглүүд хийгээд асуудлуудын талаарх Их Эзэний шийдлүүд ямагт түргэн буюу амар хялбар байх боломжгүй ч гэсэн, тэдгээр нь удаан хугацаанд үргэлжлэх шийдлийг бидэнд өгдөг.

1. Иудагийн зовлон зүдгүүрийн талаарх Их Эзэний шийдлийг хураангуйлан дүгнэ (Исаиа 1:16–19-ийг үз).
2. Сургаал ба Гэрээ 58:42–43-ыг уншиж, Их Эзэн Исаиа 1:18-д өөрийн хийсэнтэй адил амлалтыг эдгээр шүлгүүдэд тэрээр хэрхэн хийснийг, түүнчлэн энэ амлалтыг хэрэгжүүлэхийн тулд бид юу хийх ёстойг ярь.

Исаиа 2

Эзэний Ууланд ирэгтүн

Мянган Жил хэмээн нэрлэгдэх, мянган жилийн амар амгалангийн үеийг Есүс Христийн Хоёр дахь Ирэлт дэлхийд эхлүүлэх болно. Аврагчийн Ирэлтийн үед ёс бусчууд устгагдах болно, харин түүнийг утгахаар бэлтгэгдсэн хүмүүс аврагдаж, түүнтэй хамт баясах болно. Бэлтгэхийн тулд бид юу хийх ёстой вэ? Их Эзэнийг угтах хийгээд Мянган Жилд амьдрахад бэлтгэхийн тулд тэд юу хийх ёстойг эртний болон өнөө үеийн Израилд Исаиа ихэд нэрд гарсан нэгэн бошиглолд хүүрнэсэн билээ. Энэ бошиглол “давхацсан” буюу нэгээс илүү олон цаг үе, нэгээс илүү олон газарт холбогдож болно гэсэн утгатай юм. Ийм учраас, уг бошиглол нь эртний Израил өөрийн хаант улсыг байгуулахын тулд юу хийх ёстой байсан ерөнхий зарчмуудыг заадаг төдийгүй, бас Хоёр дахь Ирэлт болон Мянган Жилийн өмнөх эцсийн өдрүүд дэх уг хаант улсын өвөрмөц байршилг өгүүлдэг.



Мормоны Номонд, Нифай Исаиагийн бүлэг 2–14-ийг иш татсан байдаг. Түүнчлэн эдгээр бүлгүүдийг 2 Нифайн бүлгүүдтэй харьцуулах нь уншсан зүйлээ илүү сайн ойлгоход тань тусалж болно.

Судруудыг ойлгох нь



Исаиа 2

Мэргэ төлөгчид (ш. 6)—
Тэмдгүүд болон совингоор
ирээдүйг угтан хэлдэг
хүмүүс

Жавхлант сүр хүч (ш. 10, 19,
21)—Аугаа их чанар ба хүч
Ан цав (ш. 21)—Нүхнүүд

Исаиа 2:2–4—Их Эзэний Уул

“Их Эзэний уул” гэдэг бол ариун сүм юм. Исаиа 2:2–4-т, Исаиа нэг үзэгдлийн тухай өгүүлж, олон байдлаар гүйцэлдээд байгаа нэг бошиглол хийсэн байдаг. Цаг нь ирэхэд Их Эзэний хүмүүс түүнийг болон түүний өргөөг бүх зүйлээс дээгүүрт тавьж, түүний өргөө уруу очсоноор түүний зөвлөгөөг идэвхтэйгээр эрэлхийлсэн тэр үед, тэдний дунд Сион үндэслэн байгуулагдаж, амар амгалан хийгээд мөнх амьдралын амлалт тэдэнд байх болно. Өнөө үеийн бошиглогчид чухамхүү энэ сургаалыг бидэнд заадаг. Ерөнхийлөгч Ховард Хантер, “Өөрсдийгөө ариун сүмийн шүтээнтэй, ариун сүмийн гэрээ нүүд хийгээд ариун сүмийн гэрлэлттэй, өөрсдийн дэлхийн дээд зорилго хийгээд мөнх бус байдлын эрхэм дээд туршлагатай ариун сүм болгоцгооё” хэмээн хэлжээ (in Conference Report, 1995 оны 10-р сар, 118; *Ensign*, 1994 оны 11-р сар, 88).

Их Эзэний өргөө “уулсын тэргүүн” (Исаиа 2:2) дээр үндэслэн байгуулагдах нь энэхүү бошиглолын өөр нэг хэрэгжилт юм. Энэ бошиглол ариун сүмийг бидний амьдрал дахь хамгийн өндөр газарт тавих бэлгэдлийн ишлэл төдийгүй, бас эцсийн өдрүүд дэх Сүмийн төв удирдлагын байршлын шууд хэрэгжилтийг өгүүлжээ. Исаиагийн энэхүү бошиглолын талаар Ахлагч Брус Р.МкКонки хэлэхдээ, “Энэ нь Солт Лейкийн Ариун Сүм болон Хадат Уулсын оргил дээр баригдсан бусад ариун сүмүүдийг тусгайлан заасан бөгөөд энэ нь бас Миссурийн Жаксон гүнлэг дэх Шинэ Иерусалимд баригдах ариун сүмийг ерөнхийд нь нэрлэн заасан юм” гэжээ (*A New Witness for the Articles of Faith* [1985], 539).

Ахлагч Б. Х.Робертс Сионоос гарсан хуулийн ач холбогдлыг зааж, хэлэхдээ, “Миний хувьд, зарим талаар, Сионы хууль нь—улс орны иргэний хуулийн үндсэн зарчим—Сионоос гарч ирэх хуулийн зарчим—эрх чөлөөний энэхүү адислагдсан нутагт үндэслэгдэн бий болж, хэрэгжих, мөн тэрхүү, эцэстээ, бүх дэлхий дэх нутаг бүрийг шууд буюу шууд бусаар адисалж, чөлөөтэй болгох иргэний хууль юм” гэжээ (in Conference Report, 1908 оны 4-р сар, 108).

Судруудыг судлах нь



А Зураг буюу ноорог хий

Исаиа 2:2–3 дахь санаануудыг төлөөлсөн зураг зур.

Б Өнөө үеийн жишээ гарга

Исаиа 2:2–4-ийн үндсэн захиас бол ариун сүм болон үүний ёслолууд хийгээд хуулиудыг Израил өөрсдийн амьдрал

дахь бүх зүйлээс дээгүүрт тавьсан үед Сион үндэслэгдэн бий болно гэсэн санаа юм.

1. Исаиа 2:6-9-ийг уншиж, Их Эзэний хэлсэн ямар зүйлүүд тэр үед ариун сүмийн адислалуудыг хүлээн авахаас хүмүүсийг хөндийрүүлж байсныг жагсаа. Жагсаагдсан зүйл бүрийн талаар өнөө үеийн жишээ гарга. (Шүлэг 9-ийг 2 Нифай 12:9-тэй харьцуулахад анхаар.)
2. Исаиа 2:10-22-г өгүүлснээр, Есүс Христийн Хоёр дахь Ирэлтийн үед, бардам зангийнхаа улмаас түүнийг хүлээж аваагүй бүх хүмүүст юу тохиох вэ?

Исаиа 3

Бардамнагчдын эсрэг бошиглолууд

Түүний үе дэх Израилын болон Иудагийн ёс бус нөхцөл байдал хийгээд тэдний ёс бусын улмаас юу тохиох тухай Исаиагийн цаашдын дүрслэлийг Исаиа 3 агуулдаг. Израилын угсааг тэр үеийнхээ хамгийн шилдэг загвараар төгс гангарсан, бардам зантай эмэгтэйчүүдтэй зүйрлүүлснээр, Исаиа сэтгэлд тод буухуйц дүрслэлүүдийнхээ нэгийг ашиглажээ. Гадна талаараа үзэсгэлэн гоо харагдахад нэн их санаа тавьдаг эдгээр эмэгтэйчүүд дотоод сэтгэлийн сүнслэг байдлыг огоорсон байлаа. Хэрэв бид бардам зантай, ёс бус байх юм бол, бидэнд юу тохиох тухай эсрэмжлүүлэг болгон, бид эдгээр сургамжуудыг өөрсөдтэйгөө адилтгаж болно.

Исаиа 4

Даруу хүмүүст ирдэг адислалууд

Израил даруу байдалд Их Эзэн уруу эргэвэл юу тохиолдохыг өгүүлснээрээ Исаиа 4 нь бүлэг 3-ын эсрэг байдалтай юм.

Судруудыг ойлгох нь

Исаиа 4

Бүхээг (ш. 6)—Хоргодох газар

Судруудыг судлах нь

А Дүрслэлүүдийг тайлбарла

Энэ богинохон бүлэгт Исаиагийн бий болгосон дүрслэлүүдийг анхааралтай ажигла. Исаиа 3-ын төгсгөл дэх

эмэгтэйчүүдтэй адилгүй нь, Исаиа 4-т дүрслэгдсэн эмэгтэйчүүд даруу байна.

1. Шүлэг 2-6-д өгүүлснээр, эдгээр эмэгтэйчүүдийн даруу үйлдлүүдийн үр дүн юу вэ?
2. Бид өөрсдийн ичгүүрийг хөнгөвчилж болохын тулд, бузар зүйлээс цэвэршиж болохын тулд, “гоё сайхан, алдар суут” хүмүүс болохын тулд, түүнчлэн Их Эзэнээр удирдуулж, хамгаалагдаж болохын төлөө, эдгээр эмэгтэйчүүдтэй адилхан болохын тулд бид юу хийж болох вэ? (ш. 5-6-г үз). Та нар хариулахынхаа өмнө дараах судруудыг үзэхийг хүсэж болно: 2 Нифай 31:13, 17; 32:1-3; Алма 7:14-15; Моце 6:52, 57.

Исаиа 5

Израилын нүглүүд

Израилын нүглүүд болон эдгээр нүглүүдийн үр дагавруудыг Исаиа үргэлжлүүлэн дүрсэлснийг Исаиа 5 агуулдаг. Та нар уншихдаа, Исаиагийн үе дэх хүмүүсийн нүгэл манай өнөө үе дэх хүмүүсийн нүгэлтэй хэрхэн адил болохыг, түүнчлэн наманчлахаас татгалздаг хүмүүст юу тохиох болно хэмээн Их Эзэн хэлснийг авч үз.

Судруудыг ойлгох нь

Исаиа 5

Хоосорч (ш. 9)—Эзгүйрч : Бат, ефа (ш. 10)—
Хэмжүүрийн нэгжүүд

Судруудыг судлах нь

Исаиа 5-ыг судлахдаа А буюу Б үйл ажиллагааг хий.

А Сургаалт зүйрлэлийг өнөө үед зориулж тайлбарла

Исаиа 5:1-7 дахь сургаалт зүйрлэл бол Сайн мэдээ тэдэнд өгөгдсөн хүмүүсийн тухай юм. Манай өнөө үеийн гишүүдэд хандсан энэ сургаалт зүйрлэлийн захиас юу вэ? Та нар өөрсдийн хариултыг бичихдээ Сургаал ба Гэрээ 1:27; 82:3; 105:6-г авч үзэж болно.

Б Гаслантайяа!

Исаиа 5:8-25-д өгүүсний дагуу, “гасланг” биеэр амсах болно хэмээн Их Эзэний хэлсэн бүх хүмүүсийг жагсааж, бүлэг хүмүүс бүрийг өөрийн үгээр дүрсэл.

Исаиа 6

Исаиа Эзэнийг харсан нь

Исаиа бошиглогч байхаар хэрхэн дуудагдсан хийгээд бошиглогчийн үүрэг зорилгын талаар Их Эзэн юу хэлснийг Исаиа 6 өгүүлдэг. Шүлэг 1,5 нь тэрээр Их Эзэнийг харсан тухай Исаиагийн гэрчлэлийг агуулдаг.

Исаиа 7–8

Эзэнд итгэ

Исаиа 7–8 нь Иудагийн хаант улс дахь өвөрмөц түүхэн үйл явдлын тухай өгүүлдэг хэдий ч, бошиглол нь зөвхөн тэдэнд холбогддог төдийгүй, бас долоон жилийн дараах Есүс Христийн төрөлтийг утган хэлсэн байдаг.

Исаиа 7 нь Израилын хаан (Умард Хаант Улс, бас Ефраим гэдэг байв), Сирийн хаан хоёр цэргийн илүү хүч чадлын төлөө хамтран нэгдсэнийг тайлбарладаг. Тэд хамтарснаар Иудаг байлдан дагуулахад найдаж байв (ш. 1–2, 5–6-г үз). Тэдний үйлдлүүд Иудагийн хаан Ахазыг айлгажээ (ш. 2-ыг үз). Ахаз айх хэрэггүй, учир нь ассиричууд умардаас ирж Сири, Ефраим хоёрыг хоёуланг нь эзлэх болно гэдгийг Ахазад хэл хэмээн Их Эзэн Исаиад хэлжээ. Энэ бошиглолын биелэлт нь, хүмүүсийн хувьд Их Эзэн тэднийг хадгалан хамгаалахаа үргэлжлүүлэх болно гэдгийг Иудад гэрчилнэ хэмээн Исаиа хэлсэн аж. Тэгээд Исаиа өөрийнх нь үгс үнэний гэрчлэл болгон Ахазад нэг тэмдэг өгөв. Онгон бүсгүй жирэмсэлж, хүү төрүүлэн, “Бурхан бидэнтэй хамт” гэсэн утгатай Иммануел гэдэг нэрийг түүнд өгөх болно хэмээн тэрээр хэлжээ. Иммануел гэдэг нэр Бурхан өөрийн хүмүүс Иудатай хамт байх болно гэдгийг бэлэгддэг байв. Тэр хүүхэд сайн ба муугийн ялгааг мэдэхэд хангалттай насанд хүрэхээс өмнө ассиричууд Сири, Ефраимын хаадыг хоёуланг нь олзолж авах болно гэдгийг Исаиа бас бошиглосон ажээ (ш. 14–16-г үз).

Исаиа 7:10–16 дахь энэ бошиглол илүү их гүнзгий утгатай юм. Иудаг хүмүүсийн хувьд Бурхан хадгалан үлдээх болно гэсний нэг шалтгаан нь тэрээр Иудагийн овог болон Давид Хааны үр удмаар дамжуулан өөрийн Хүүг дэлхийд илгээхээр амласанд байлаа. Бурханы энэ Хүү бол Иммануел байх болно. Бурхан Иудаг Сири, Ефраимын зүгээс тулгарч байгаа одоогийн сорилттой нь хамт, мөн тэрчлэн олон жилийн туршид Мессиагийн төрөлт өөд удирдан, хамгаалах болно гэдгийг Исаиа Ахазад хэлсэн аж.

Исаиа 7-д эхэлсэн түүхийг Исаиа 8 үргэлжлүүлдэг. Ассири тэднийг устгах учраас Сири, Израилын Умард Хаант Улсын талаар санаа зовохгүй байхыг Исаиа Иудагийн хүмүүст хэлдэг байв. Гэвч нэг шинэ түгшүүр байсан нь Ассири бас Иудаг ч довтолж мэдэх байв. Иудагийн хүмүүс Ассирийн эсрэг тэмцэхийн тулд бусад үндэстнүүдтэй “холбоонд” нэгдэхийг авч үздэг байв (ш. 9–10-ыг үз). Хэрэв тэд Их Эзэнд итгэх юм бол, тэрээр тэдний аюулгүй байдал, эсвээс “дуган” (ш. 13–14) байх болно гэдгийг Исаиа хүмүүст ярьдаг байлаа. Илчлэлт хэмээн мэдэгддэг хэдий ч, үүнийг Бурханаас хүлээн авдаггүй хүмүүсийн үгсийг сонсохгүй байхыг тэрээр бас тэдэнд сэрэмжлүүлж байв (ш. 19–22-ыг үз).

Судруудыг судлах нь

А Есүс Христийн тухай бошиглолуд

1. Шинэ Гэрээг зохиогч Исаиа 7:14-ийг хаана, хэрхэн ашигласан тухай бич.
2. Исаиа 8:13–14-ийг уншиж, Есүс хэрхэн дээр нь бид бат бөх суурь тавих хад (Хиламан 5:12-ыг үз), бас “бүдрүүлэх чулуу,” “цохих хад” (ш. 14) аль аль нь байдгийг тайлбарла.

Исаиа 9

Мессиагийн ирэлтийн тухай бошиглол

Есүс Христийн ирэлтийн тухай өөр нэгэн ихэд нэрд гарсан бошиглолыг Исаиа 9 агуулдаг. Шүлэг 1 нь Ассири мэт үндэстнүүд умардаас ирэхэд тэдний анх удаа довтолсон бүс нутаг болох Израилын Умард Хаант Улсын хойд хэсгийг дүрсэлдэг. “Галил” хэмээн нэрлэгддэг энэ бүс нутаг үргэлж ийнхүү зовлонд байхгүйг Исаиа бошиглосон ажээ. “[Тэдний] дарамтлах буулгыг” (Исаиа 9:4) эвдэж, “Гайхамшигт, Зөвлөгч, Хүчит Бурхан, Үүрдийн Эцэг, Энхийн Жонон” (ш. 6) хэмээн нэрлэгдэх Хүүгийн төрөлтөөр дамжуулж, Бурхан тэдэнд гэрэл, баяр хөөрийг илгээх болно хэмээн Исаиа амлажээ. Эдгээр бүх нэр Хаадын Хаан—Мессиаг хэлдэг бөгөөд—Есүс өөрийн мөнх бус байдал дахь тохинууллын ихэнхийг энэхүү Галилын бүсэд (Матай 4:12–16-г үз) өнгөрүүлснээр энэ бошиглол хамгийн төгс байдлаар гүйцэлдсэн билээ. Хувь хүмүүс түүнийг өөрсдийн хаан хэмээн хүлээн зөвшөөрч, мөнх амьдралын адислалуудыг хүлээн авах боломжтой болж, Есүс Христийн удирдан хөтлөх үүрэг өргөжин тэлж байгаагаар энэ бошиглол үргэлжлэн гүйцэлдсээр байгаа билээ (Исаиа 9:7-г үз).

Исаиа 10

Сүйтгэгчид устгагдах болно

Исаиа 9-д, Умард Хаант Улс дахь Израилын хүүхдүүдийг эзлэн авахыг Их Эзэн Ассирид зөвшөөрсөн нь тодорхой байдаг. Ассири мөн түүнчлэн Иудагийн хаант улсын заримыг устгах болно гэдгийг Исаиагийн бошиглалууд бас битүүхэн хэлсэн бололтой. Их Эзэн яагаад өөрийнхөө гэрээт хүмүүсийг эзлэн авахыг Ассири шиг ёс бус, үл итгэгч үндэстэнд зөвшөөрсөн юм бол? Исаиа 10-т Их Эзэн энэ асуултанд хариулсан байдаг. Израил ихэд ёс бус, хоёр нүүртэй байсан учраас тэрээр тэднийг цаашид хамгаалахгүй гэдгийг Тэрээр хэлжээ. Гэвч ассиричууд өөрсдийнхөө ёс бусын улмаас мөн л шийтгэгдэх болно гэдгийг Исаиа 10 тодорхой мэдэгддэг. Бурхан өөрийн “тослогдсон нэгэн” буюу Мессиагийн ирэлтийн талаарх амлалтаа ирээдүйд гүйцэлдүүлэх учраас Иудаг бүрмөсөн устгахыг тэдэнд зөвшөөрөөгүй юм (Исаиа 10:27–34-ийг үз).

Исаиа 11

Ирээдүйн үйл явдлууд

Исаиа манай өнөө үеийн хувьд чухал ном байдгийн нэг шалтгаан нь Исаиагийн үед болж байсан зүйлсээс маш олон нь өнөөгийн бидний үед бас болж байгаа явдал мөн. Бид ч бас ёс бус цаг үед аж төрж байна, мөн ёс бусчууд—яг Исаиагийн үеийнхтэй нэгэн адил өөрсдийнхөө үйлүүдийн үр дагавруудыг биеэр амсах болно гэдгийг Их Эзэн амласан билээ. Манай өнөө үе, Исаиагийн үе тодорхой зүйлүүдээр ялгаатай ч гэсэн, зарчмууд нь адилхан юм. Бошиглогч Иосеф Смит Исаиа 11-ийн ач холбогдлыг зааж, хэлэхдээ, “Эдгээрээс гадна, тэрээр [Моронай] Исаиагийн арваннэгдүгээр бүлгийг иш татаж, энэ нь гүйцэлдэхийн даваан дээр байлаа хэмээн хэлжээ” (Иосеф Смит—Түүх 1:40) гэсэн байдаг.

Их Эзэнийг хайрладаг бөгөөд зөв шударгаар аж төрөхийг хичээдэг хүмүүс ийм их ёс бусын дунд амьдрахдаа урам хугарч болох юм. Урам хугаралтын цагт Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөний “илүү том зургийг” харж, эцсийн бүлэгт зөв шударга ёс давамгайлах болно гэдгийг ухааран, хүсэлтэй өөрийн бүх хүүхдүүдийг гэтэлгэх замаар Тэрбээр хангасныг харах нь чухал юм. Исаиа 11 нь тэрхүү “илүү том зургийн” тухай бөгөөд түүнийг мэдэж, түүний тааллыг хэрэгжүүлэхийг эрэлхийлдэг хүмүүсийн төлөө Их Эзэн юу хийх тухай найдварын захиасыг агуулдаг.

Судруудыг судлах нь

Исаиа 11-ийг судлахдаа А буюу Б үйл ажиллагааг хий.

А Бусад судрын туслалцаатайгаар Исаиаг тайлбарла

1. Сургаал ба Гэрээ 113:1–2-т өгүүлснээр, Исаиа 11:1–5 юуны тухай өгүүлдэг вэ?
2. Сургаал ба Гэрээ 113:5–6-д өгүүлснээр, Исаиа 11:10 дахь “Иессийн үндэс” хэн бэ?
3. Иосеф Смит—Түүх 1:40-д өгүүлснээр, Исаиа 11 дэх үйл явдлууд ерөнхийдөө хэзээ тохиох вэ?

Б Эцсийн өдрүүд ба Мянган Жил

Исаиа 11:1–9 нь ихэнхдээ ирээдүйн үйл явдлуудын тухай өгүүлдэг. Исаиа 11:10–16 нь шүлэг 1–9-д өгүүлсэн үйл явдлуудыг тохиолгон авчрахын тулд Их Эзэн юу хийх тухай өгүүлдэг.

1. Исаиа 11 дэх бошиглалуудын аль нь аль хэдийн гүйцэлдсэн буюу гүйцэлдэж байгааг та нар харсан бэ?
2. Их Эзэнд итгэлтэй хэвээр үлдэхэд та нарыг урамшуулан дэмждэг Исаиа 11 дэх нэг сургамжийн тухай бич.

Исаиа 12

Эзэнийг магтан дуул

Исаиа 12 бол өөрийнхөө хүмүүсийг аврахын тулд хийдэг зүйлийнх нь төлөө Их Эзэнд өргөсөн магтаалын богинохон яруу найраг юм. Исаиа 12 Мессиа, эцсийн өдрүүд дэх Израилын цугларалт хийгээд Мянган Жилийн тухай Исаиа 11-д өгүүлсэн агуу үнэнүүдийн хариу болж ирсэн бололтой. Бүлэг 12 дахь сургамжууд нь бас Их Эзэнийг мэдэхийн төлөө ирж, Их Эзэний Сүмд цуглардаг хийгээд, зөвхөн Есүс Христийн өгч чадах амар амгаланг хүлээн авдаг аливаа хувь хүмүүст хамаатай юм.

Судруудыг судлах нь

А Есүс Христийн нэрнүүд

Исаиагийн эхний 12 бүлгээс дараах шүлгүүдийг уншиж, Исаиагийн ашигласан Есүс Христийн бүх нэрийг жагсаа: Исаиа 1:24; 2:3; 3:1; 5:16; 5:24; 7:14; 8:14; 9:6; 11:1; 12:2. Шүлэг бүрд өөр нэр хэрэглэсэн нь ямар ач холбогдолтой гэж бодож байгаагаа хэл. Их Эзэний зан төлөв буюу үйлүүдийн тухай юуг нь уг нэр онцгойлон тэмдэглэдэг вэ?

Исаиа 13–14

Вавилон ба Люсифер

Исаиа 13–14, Исаиа 10-ын адил, Их Эзэний гэрээт хүмүүсийг эзлэн түрэмгийлсэн улс орон устгагдах тухай бошиглолуудыг агуулдаг. Исаиа 10-т, уг бошиглол нь Умард Хаант Улсыг ойролцоогоор МЭӨ 725–21 онуудын хооронд эзэлсэн орон, Ассирийн тухай юм. Исаиа 13–14 нь Иудаг ойролцоогоор МЭӨ 600–588 онуудын хооронд эзэлсэн орон, Вавилоны тухай өгүүлдэг. Эртний Вавилон бол түүхэн дэх хамгийн баян, хамгийн их дэлхийн шинжтэй эзэнт гүрнүүдийн нэг байжээ. Үүний улмаас, Их Эзэн Вавилоныг дэлхий зүйлүүдэд анхаарлаа төвлөрүүлдэг хүмүүсийн бэлэгдэл болгон, Сион болон тэнгэрт сөргүүлэн тавьж ашигласан ажээ. Исаиа 13-т бошиглогдсон Вавилоны устгал нь Бурханы хүмүүсийн эсрэг тэмцдэг хийгээд Бурханы зүйлүүдийн оронд дэлхийн зүйлүүд дээр зүрх сэтгэлээ тавьдаг хүмүүст юу тохиохыг бэлэгддэг.

Исаиа 14 Люсифер буюу Сатантай Исаиагийн зүйрлүүлсэн Вавилоны хааны тухай ихэнхдээ тусгайлан өгүүлжээ. Люсифер хэрхэн Сатан болсон хийгээд бас түүнд болон түүнийг дагалдагчдад юу тохиох тухай бид энэ бүлэг дэх бичээсүүдээс илүү их зүйлийг мэддэг.

Судруудыг ойлгох нь



Исаиа 14

Босоо ятга (ш. 11)—
Хөгжмийн зэмсэг

Судруудыг судлах нь



А Та нар яагаад түүнийг дагах вэ?

- Исаиа 14:12–14 нь Люсифер хэрхэн Сатан болсон тухай өгүүлдэг. Исаиагийн хэлсэн зүйлүүдээс хамгийн сонирхолтой нь юу гэж та нар боддог вэ?
- Сургаал ба Гэрээ 76:25–27; Моисе 4:1–4-ийг уншиж, Люсиферийн уналтын тухай өөрсдийн мэдсэн нэмэлт үзэл баримтлалын тухай бич.
- Исаиа 14:4–11, 15–20-д өгүүлснээр, эцэстээ Люсиферт юу тохиолдох вэ?
- Сургаал ба Гэрээ 76:30, 33, 36–38, 44–46-гаас та нар ямар нэмэлт мэдээллийг мэдсэн бэ?
- Есүс Христийн тухай мэдэхийг бид хичээдэг шалтгаануудын нэг нь түүний үлгэр жишээг дагаж, түүнтэй илүү адилхан болж чадах явдал мөн. Сатан хэрхэн чөтгөр болсныг судрууд товчхон дурддаг болохоор бид түүнийг дагахаас зайлсхийхийн тулд юу хийх ёстойг мэдэж болно. Исаиа 14-г Люсиферийн талаар уншсан зүйлээ бодон, та нарын мэдсэн зүйл яагаад Есүс Христийн

үлгэр жишээг бүрнээр дагахыг хүсэхэд та нарыг хүргэдэг тухай бич. Бас Сатан болон түүний уруу таталтуудаас зайлсхийхэд өөрсдийнхөө мэдсэн зүйлийн улмаас та нар хэрхэн илүү сайн болж чадах тухай бич.

Исаиа 15–23

Эзэнд үйлчилдэггүй үндэстнүүдийн тухай бошиглолууд

Исаиа 15–23 нь Израилын эргэн тойрон дахь үндэстнүүдийн устгалын тухай нилээд хэдэн бошиглолыг агуулдаг. Эргэн тойрон дахь бүх үндэстнүүд нь устгагдах болно гэдгийг Израил, Иуда хоёрт Тэрээр илчилснээр, эдгээр хөрш зэргэлдээх орнуудтай хийх аливаа гэрээнүүд буюу холбоотон байхад итгэхийн оронд Их Эзэнд итгэх сайн учир шалтгаануудыг тэдэнд өгсөн ажээ.

Исаиа 15–16 Моабын тухай бошиглолуудыг агуулдаг. Лотын ууган охины (Эхлэл 19:37-г үз) хүү бөгөөд энэ оронд гэр бүлийнхээ хамт суурьшсан Моабын нэрээр энэ орон нэрлэгдсэн аж. Моабчууд израилчуудтай олон удаа байлдсан боловч, энэ үед израилчууд дайснуудаа ялахад Моабтай холбоотон байж болох юм гэж үзэж байсан аж.

Исаиа 17 Дамаск (Сири) болон Ефраимд (Умард Хаант Улс) чиглэсэн бошиглолыг өгүүлдэг. Иудаг эзлэхийн тулд Дамаск, Ефраим хоёр холбоотон болж нэгдсэн ч гэсэн, тэднийг довтлохоос өмнө ассиричууд умардаас ирж, түрэмгийлэгч болж мэдэх байсан энэ хоёрыг устгажээ. Исаиа 17 энэ хоёр үндэстний устгалын тухай, бас энэ хоёр үндэстэнд нөлөөлсөн устгалын зарим нөлөөний тухай бошиглолыг үздэгддэг.



Исаиа 18 “Кушийн голуудын чанад дахь” (ш. 1) нутгийн тухай өгүүлдэг. Олонх орчуулагчид энэ нутгийг Куш хэмээн нэрлэдэг, энэ нь зарим хүмүүсийн бодогоор Египетийн өмнөд үндэстэн байв. Бүлэг 18 нь энэ хэсэг дэх олон бүлгээс илүү найдвар төрүүлдэг бөгөөд бүлэг 18-д өгүүлсэн зүйлийн тухайд энд зөрчилтэй зүйл их байдаг.

Хэдийгээр энэ үндэстний хүмүүс “тараагдаж, нүд үзүүрлэгдэж” мөн “хөл дор дэвслэгдэх” хэдий ч, тэд Сионы Ууланд цуглахаар уригдаж, тэнд тэд аятай сайхнаар хүлээн авагдах болно гэсэн Исаиагийн бошиглолыг Исаиа 18

цэдэглэдэг. Уг бүлгийн сүүлчийн шүлэг “тараагдсан хүмүүс” Их Эзэнд “бэлэг” өгөх тухай өгүүлдэг учраас энэ нь өвөрмөц сонин байж болох юм. Дэлхийн хүмүүсийг цуглуулж, Их Эзэнийг уртагд тэднийг бэлтгэх нь эцсийн өдрүүд дэх Сүмийн агуу зорилгуудын нэг мөн.

Исаиа 19–20 нь Исаиагийн үе дэх дэлхийн хамгийн хүчирхэг үндэстнүүдийн нэг байсан Египетийн тухай бошиглолуудыг цэдэглэдэг. Египетэд зовлон зүдгүүр тохиолдож болох арга замуудын тухай, түүнчлэн египетчүүд өөрсдийн чадвар болон хуурамч бурхдаараа дамжуулан асуудлуудаа шийдвэрлэх чадваргүй тухай Исаиа бошиглодог байв. Исаиа 19 бас ирээдүйд нэгэн цагт, Египет Израил хоёр нэг Бурханыг шүтэн биширч, Египет Их Эзэнээр эдгээгдэх болно гэсэн нэгэн гайхамшигт бошиглолыг агуулдаг. Мөн цааш нь, Бурханыг шүтэн биширэхэд Ассири бас Израил Египет хоёртой нэгдэх болно гэдгийг уг бошиглол өгүүлдэг.

Исаиа 20 Ассири Египетийг боолчлолд авах үеийн тухай тусгайлан өгүүлсэн нь—Иудагийн хүмүүс яагаад Ассирийн эсрэг өөр аль нэг оронтой хамтран нэгдэж болохгүйн шалтгааныг бас дахин харуулсан хэрэг байлаа.

Исаиа 21 нь гурван үндэстэн: Вавилон (ш. 1–10), Едом (ш. 11–12), Арабын (ш. 13–17) зайлигүй устгалын тухай өгүүлдэг.

Исаиагийн үеэс хойш бараг хоёр зуун жил Вавилонд боолчлолд байх бөгөөд Вавилоны устгалын тухай энэхүү бошиглолыг мэдүүлснээр урам зоригийн дэмжлэг хэрэгтэй болох Израилын усааны гишүүдэд Их Эзэн шүлэг 10-т тусгайлан хандаж ярьсан бололтой.

Исаиа 22 нь Иерусалимын уналтад холбогдох бөгөөд энэхүү “дарамт” буюу уйтгар гунигийн захиас зайлуулан авагдаж, тэгээд Иерусалим байнгын энх амгаланд байх цаг үеийн тухай өгүүлдэг. Энэ бошиглолд Исаиа Иерусалимын устгалын нэг хэсэг болон юу тохиохыг тайлбарласан төдийгүй, бас Иерусалим яагаад устгагдахыг тайлбарлажээ. Хүмүүс усны асуудлуудаа шийдвэрлэхийн тулд өөрсдийн барьсан хонгил, сүвгуудаар ихэд бардамнаж байсан атлаа, усыг Бий болгогчийг ч шүтэн биширсэнгүй, бас түүнээс ирдэг бүх адислалуудыг ч танин мэдсэнгүйг тэрээр тэмдэглэжээ (ш. 11-ийг үз). Эргэн тойрных нь үндэстнүүд устгагдах болно гэсэн захиаст хүмүүс даруухнаар, бас наманчилж хариу үйлдэл үзүүлэхийн оронд үүнийг тэмдэглэхийн тулд үдэшлэгүүд зохиосных нь төлөө тэднийг тэрээр бас шүүмжилжээ (ш. 12–14-ийг үз).

Исаиа 22 нь бас бэлгэдлийн чухал учир холбогдолтой богинохон түүхэн өгүүллийг агуулдаг. Уг түүх бол тэр үе дэх Иерусалимын хүмүүсийн зан төлвийн бэлгэдэл болсон Иерусалимын эрдэнэсийн сангийн нярав Шебнагийн тухай юм. Иерусалимын эд баялгийн улмаас бардам зантай байсных нь төлөө Исаиа Шебнаг зэмлэн буруутгажээ. Тэгэхэд ассиричууд Иерусалимын эрдэнэсийн сангаас олныг нь авч явах төдийгүй, бас Иерусалимын хамгийн сайхан эрдэнэсийн зүйлүүд Ассирийн хааны ордонд “хамгийн хямд төсөр” зүйлүүд байх болно гэдгийг Исаиа хэлсэн аж (ш. 18-ыг үз). Түүнээс гадна, еврей хэлээр “Бурхан чамайг бий болоход хүргэнэ” гэсэн утгатай Елиаким гэдэг нэртэй нэг хүн Шебнаг залгамжлах болно хэмээн

Исаиа хэлжээ. Энэ нэр болон уг түүхийн утганд чухал бэлгэдэл байжээ. Эрдэнэсийн зүйлсийг хайрлах хайрыг гагцхүү Бурханыг хайрлах хайраар сольсноор Иерусалим устгалаас гэтэлгэгдэж чадах байлаа. Тийнхүү Иерусалим Бурхан уруу эргэсэн үед л ариун хот болж, дахин бий болно. Елиаким гэдэг нэр Цагаатгалыг зааж байсан учир энэ нь бүр ч илүү агуу бэлгэдлийн утгатай байв. Есүс Христийн Цагаатгалын улмаас, Бурхан бүх хүмүүнийг бий болоход хүргэх бөгөөд энэ дэлхийн бүх устгал, гутрал цөхрөл хийгээд үхлийг даван туулах боломжтой болно. Бүлэг 22-ын сүүлчийн шүлэгт, Исаиа гэтэлгэлийн агуу хүчний тухай, хадаас нь сугарахгүйн тулд түүнийг хатуу газарт“ бэхлэн чангалахтай зүйрлүүлэн гэрчилжээ. Энэхүү дүрслэл Есүс Христийн санал болгосон байнгын гэтэлгэлийг, түүнчлэн түүний үхлийн зам болон бүх хүн төрөлхтний баттай тогтсон авралыг бэлгэдсэн ажээ.

Фоеникийн нэг хот Тирийн тухай бошиглолыг агуулсан Исаиа 23 бол Израил, Иуда хоёрын эргэн тойрон дахь үндэстнүүдийн уналтыг бошиглосон бүлгүүдийн сүүлчийнх нь юм. Тир бол дэлхийн эрдэнэсийн зүйлсийг худалдах, худалдаж авах дээр анхаарал төвлөрүүлсэн хот байв. Тирийн оршин суугчдын хувьд дэлхийн зүйлүүд бусад аливаа зүйл, түүний дотор Бурханаас ямагт илүү чухал байлаа. Исаиа Тирийг янхан хэмээн нэрлэжээ. Энэ нь, хүмүүс өөрсдийгөө болон Бурхантай харицах ариун харилцаагаа мөнгөөр худалддаг нь—янхан эмэгтэй өөрийн ариун журмыг мөнгөөр худалдагтай агаар нэг юм.

Исаиа 24

Ёс бус дэлхий устгагдана

Өөр өөр үндэстнүүдийн устгалыг өгүүлсэн хэдэн бүлгийн дараа (Исаиа 13–23-ыг үз), Исаиа 24 бүх дэлхий нийтийг хамарсан устгалын талаар илүү ихийг өгүүлдэг. Исаиа 24 нь израилчуудад тусгайлан хандаж, ёс бусынх нь улмаас тэдэнд юу тохиохыг өгүүлсэн хэдий ч, энэ нь бас Хоёр дахь Ирэлтийн өмнөх эцсийн өдрүүдэд холбогддог.

Исаиа 24 өдий олон устгалын тухай өгүүлдэг учраас маш их гутрангуй мэт боловч, энэ нь бас аврагдах зөв шударга хүмүүсийн талаарх найдварын багаахан захиасыг агуулдаг. Энэхүү найдвар бүхий захиас нь дараачийн хэдэн бүлэгт бүр ч илүү хүчтэй илэрдэг.

Судруудыг ойлгох нь

Исаиа 24

Хувхайрна (ш. 4, 7)—Хүч чадлаа алдана

Хуулиуд (ш. 5)—Ариун ёслолууд

А Хоорондоо холбоотой судруудаас мэд

1. Сургаал ба Гэрээ 5:19; 84:96–98-ыг уншиж Исаиа 24:1-д хийх болно хэмээн хэлсэн зүйлээ Их Эзэн юуны учраас, хэрхэн хийх тухай бич.
2. Сургаал ба Гэрээ 1:17, 35–36; 45:31–35; 97:22–28-ыг уншиж, Исаиа 24:1–12, 19–23-т бошиглогдсон устгалуудын дунд хүн хэрхэн аврагдаж болохыг тайлбарла.
3. Исаиа 24:5-д Их Эзэний хэлсэн, дэлхийн хүмүүсийн нүгэл үйлддэг замуудыг жагсаа. Исаиад түүний хэлсэн зүйлийг Сургаал ба Гэрээ 1:15–16-д түүний хэлсэн зүйлтэй харьцуулж, Исаиа 24:5 ямар утгатай гэж бодож байгаагаа ярь.

Б Авралын төлөвлөгөөний хэсэг

1. Исаиа 24:21–22-т өгүүлснээр, энэ бүлэг тохиохоор ирэх үед устгагдах хүмүүст юу тохиолдох вэ?
2. Сургаал ба Гэрээ 138:29–35-д өгүүлснээр, эдгээр хүмүүс хэрхэн “айлчлагдах” вэ?

Исаиа 25

Исаиа Эзэнийг магтан дуулав

Исаиа 25 Их Эзэний хийсэн болон хийх зүйлийн төлөө, түүний дотор бардамнагчид, ёс бусчуудын зайлшгүй устгал, даруу, итгэлтэй, дуулгавартай хүмүүсийн шагналын төлөө Исаиагийн талархлыг цэдэглэдэг. Их Эзэнийг итгэлээрээ “хүлээдэг” (Их Эзэн өөрийн бүх үгсийг биелүүлэхийг—тэр ч байтугай, ингэх нь тэр үед болоогүй юм шиг байлаа ч гэсэн, хүлээх, тэд Их Эзэнд итгэлтэй хэвээр үлдэнэ гэсэн утгатай) хүмүүс цаг нь болоход шагнагдах болно, бас тэдний шагнал аугаа их байх болно гэж тэрээр хэлжээ.

Исаиа 26

Исаиагийн магтаалын дуу

Та нар Бурханд талархлаа илэрхийлэхийн тулд ямар дуу дуулах вэ? Исаиа 26 бол өөрийн хүмүүсийн төлөө Их Эзэний хийдэг зүйлийн төлөө өргөх талархлын дуу юм. Шүлэг 19-д дурдагддаг Есүс Христийн амилалт бол бидний талархлын үндсэн гол шалтгаан юм.

Исаиа 27

Эзэн ба түүний усан үзмийн талбай

Их Эзэн өөрийн хүмүүстэй ажилладаг арга замыг, хүн өөрийн усан үзмийн талбайг арчилдаг арга замтай харьцуулсан Исаиагийн харьцуулалтыг Исаиа 27 цэдэглэжээ (Исаиа 5:1–7; Иаков 5-ыг үз). Энэ харьцуулалд, ёс бусчууд тайрч, шатаах үүний үхсэн мөчрүүд лугаа адил болохыг, харин зөв шударга хүмүүс үндсээ илүү гүнээс авч, нахиадан, “бүх дэлхийг жимсээр дүүргэх” (Исаиа 27:6) хүчирхэг усан үзмийн модод лугаа адил болохыг Их Эзэн тайлбарлажээ.

Исаиа 28

Бардам зант хүмүүст өгсөн зөвлөгөө

Бардам зан бол израилчуудын гол нүгэл болохыг Исаиа 28 тогтоосон байдаг. Бардам зан Их Эзэний өгөхийг хүсдэг адислалуудаас хүмүүсийг салгадаг байв. Шүлэг 23–29-д, хэрхэн тарьж, ургац хэрхэн хураадаг тухай тариачны мэдлэгийг, өөрийн хүүхдүүдтэй хэрхэн зохих ёсоор ажиллах тухай Их Эзэний илүү агуу мэдлэгтэй Исаиа харьцуулжээ.

Исаиа 29

Гайхамшигт ажил ба гайхалтай зүйл

Библийг мэддэг, Сүмийн гишүүн биш хүмүүс зарим үед, “хэрэв Мормоны Ном Бурханы ажлын тийм чухал хэсэг юм бол, яагаад үүнийг Библид дурддаггүй юм бэ?” гэхчлэнгийн ямар нэг зүйлийг биднээс асуух болно. Энэ асуултад нилээд хэдэн хариулт байдаг, тэдгээрийн нэг нь, “байгаа шүү дээ!” гэсэн хариулт. Исаиа 29 бол, хэдийгээр энд нэрээр нь дурдаагүй ч гэсэн, Библид Мормоны Номны тухай өгүүлдэг нэг газар юм. Та нар энэ бүлгийг уншихдаа, Мормоны Ном гарч ирэх тухай болон дэлхийд энэ ном нөлөө үзүүлэх тухай бошиглолуудыг эрж ол.

Судруудыг ойлгох нь



Исаиа 29

Ариел (ш. 1, 3, 7)—
Иерусалим

Мөхөж (ш. 14)—Устгагдаж
Элэглэгч (ш. 20)—Шоологч

Алга болж (ш. 20)—
Устгагдаж

Занганд оруулах (ш. 21)—
Урхи тавих

Исаиа 29:11–12, 18–24—Энэ бүлэгт өгүүлэгддэг “ном” юу вэ?

Эдгээр шүлгүүд Мормоны Ном болон хожмын өдрүүд дэх Сайн мэдээний Сэргээлтэд уг номын гүйцэтгэсэн үүргийг хэлж байгааг сэргээгдсэн Сайн мэдээтэй танил хүмүүс мэдэх байх аа. Ахлагч Брус Р.МкКонки хэлэхдээ:

“Сүмийнх, мөн түүнийх биш дэлхий дээрх цөөхөн хүмүүс Мормоны Ном бол бүх зүйлийн тухай юм гэдгийг ойлгосон юм. Түүний ирэлтийн замыг бэлтгэхэд үүний гүйцэтгэсэн үүрэг мөн ирээдүйд гүйцэтгэх үүргийг хийгээд энэ бол Түүний тухай гэрчлэл гэдгийг мэддэг нь тэдний дунд цөөхөн юм. . . .

“ . . . Бүх дэлхий хийгээд үүний хүмүүс үүгээр нөлөөлөгдөж, үүгээр удирдагдахаар Мормоны Ном хүмүүст ийм ихээр нөлөөлөх болно. . . .

“ . . . Өнөө үед: Мормоны Ном бүх хүмүүст хандсан Бурханы оюун ухаан, таалал, дуу хоолой мөн үү? гэсэн асуултаас өөр хүн төрөлхтөнд тулгарсан илүү агуу асуулт гэж үгүй” гэжээ (The Millennial Messiah [1982], 159, 170, 179).

Судруудыг судлах нь



А Бошиглол гүйцэлдэв

1. Исаиа 29:1–6, Иерусалимын устгалын дараа “газраас ярьсан” бүлэг хүмүүсийн тухай өгүүлдэг. Тэд “газар хөдлөлт, их дуу чимээ, хуй салхи, шуурга, түймэрдэгч галаар шийтгэгдэх болно” (Исаиа 29:6) хэмээн Исаиа хэлжээ. 2 Нифай 26:15–17; 33:13; 3 Нифай 8:2–19; Мормон 8:23, 26, 34–35-ыг уншиж, Исаиа 29:1–6 дахь бошиглолыг Мормоны Ном гүйцэлдүүлж байгаа арга замуудын тухай бич.
2. Иосеф Смит—Түүх 1:61–65-ыг уншиж, цэдэглэгдсэн үйл явдал нь хэрхэн Исаиа 29:11–12-ын гүйцэлдэлт байсныг ярь. Та нар бас 2 Нифай 26:9–22-ыг уншиж, эдгээр шүлгүүд энэ бошиглолын тухай илүү ихийг тайлбарласныг харж болно.

Б Төгс Эзэмших Судар—Исаиа 29:13–14

“Урвалт” гэдэг нь “нүүр буруулан тэрслэх” гэсэн утгатай бөгөөд Сайн мэдээний бүрэн байдал, Сайн мэдээний ёслолуудыг гүйцэтгэх санваарын эрх мэдэл дэлхий дээрх хүмүүний дундаас татан авагдсан үеийг бид “Урвалт” хэмээн нэрлэдэг. “Сэргээлт” бол дэлхийд буцаан авчрагдсан Сайн мэдээний бүрэн байдал хийгээд санваарын эрх мэдэл юм.

1. Исаиа 29-ийн дараах шүлгүүдийг уншиж, эдгээр нь Урвалтын тухай юу, эсвэл Сэргээлтийн тухай юу гэдгийг ярьж, дараа нь эдгээр шүлгүүд Урвалтын тухай эсвэл Сэргээлтийн тухай юу заадгийг тайлбарла: ш. 9–10, 13–14, 15, 18–21, 24.
2. Исаиа 29:13–14-ийг Иосеф Смит—Түүх 1:18–19-тэй харьцуул. “Гайхамшигт ажил хийгээд гайхалтай зүйлийг” юу гэж та нар бодож байна? (бас ш. 33–34-ийг үз).

3. Исаиа 29:11–12, 18–24 “гайхамшигт ажил хийгээд гайхалтай зүйлд” чухал үүрэг гүйцэтгэх нэг номны тухай өгүүлдэг. Энэ ном авчрах болно хэмээн эдгээр шүлгүүдийн өгүүлсэн үнэнүүдийг жагсааж, тэгээд энд ямар номны тухай өгүүлж байгааг хэл.

Исаиа 30–32

Эзэнд итгэ

Ассири хөрш зэргэлдээ бусад орнуудыг эзэлсний дараа Израилд довтлохоор заналхийлж байсан үед Исаиа 30–32 бичигджээ. Израил дахь айн балмагдсан олон хүмүүс ассиричуудаас өөрсдийгөө хамгаалахад Египетийн тусламжийг эрэлхийлж байв. Гэвч Мосегийн үед ёс бус Египетээс зугтан гарахад нь Их Эзэн Израилын хүүхдүүдэд тусалсан юм; тэрээр тэдний тулалдаануудад оролцож, амлагдсан нутгийг олж авахад нь тэдэнд тусалсан билээ. Өнгөрсөн үед тэднийг чөлөөлсөн Их Эзэнд найдахын оронд Египеттэй гэрээнд нэгдэх нь израилчууд өөрсдийн Бурханд итгэх хичнээн өчүүхэн итгэлтэй байсныг харуулж байлаа. Бүлэг 30—32 дахь Исаиагийн зөвлөгөө нь, чөлөөлөлтийн төлөө Египетэд биш, харин Их Эзэнд итгэх явдал юм. Хэрэв тэд Их Эзэнд итгэж, түүнд итгэхгүй байхын үр дагавруудаас сэргэмжлүүлэгдэх юм бол, тэдний хүлээн авах адислалуудын тухай Исаиа Израилын хүүхдүүдэд бас ярьсан ажээ.

Хэн нэгэн хүнд итгэх буюу итгэхгүйгээ та нар яаж шийддэг вэ? Итгэсэн хүн чинь таныг ашиглачихаад, танаас нүүр буруулж байсан тохиолдол танд учирч байсан уу? Бид хэнд итгэх ёстой вэ? Түүнд итгэлтэй байсны төлөө Их Эзэн биднийг адислах болно гэдэгт бидний итгэдгээс бусад хүмүүс илүү итгэвэл бид айдаг уу? Асуудлуудыг шийдвэрлэхийн тулд Их Эзэний арга замыг туршиж үзэхийн оронд бид өөрсдийнхөө хүчинд итгэдэг үү? Эдгээр асуултууд ухаалаг биш юм шиг санагдаж болно, гэвч зарлигууд “хэтэрхий хэцүү” эсвэл зарлигуудыг сахьснаар тэр даруйд ирэх шагналуудыг хардаггүй учраас, өөрсдийнхөө хүч чадал, үнэлэлт дүгнэлтэд эсвэл бусдын хүч чадал, үнэлэлт дүгнэлтэд итгэж, зарлигуудыг эс хайхардаг гэж боддог хүмүүс олон байдаг.

Судруудыг судлах нь



А Өөрийнхөө үгээр

Исаиа 30:15–21-д, израилчууд өөрсдийн хүч чадал, бусдын хүч чадал, эсвээс тулалдаанд тусална гэж бодсон эд юмст итгэхийн оронд яагаад өөртөө итгэх ёстой Их Эзэн тайлбарлажээ. Та нар эдгээр шүлгүүдийг уншсаны дараа дараах асуултуудад өөрийн үгээр хариул:

1. Хэрэв израилчууд өөрсдийнхөө хүч чадалд итгэх юм бол тэдэнд юу тохионо гэж Их Эзэн хэлсэн бэ? (ш. 16–17).
2. Израилчууд юунд итгэх ёстой вэ? (ш. 15).

- Шүлэг 18–21-д өгүүлснээр, Их Эзэн хүмүүсээс юу хийхийг хүссэн бэ, ингэсэн үед дараа нь Их Эзэн тэдний төлөө юу хийх вэ?
- Ямар нөхцөлд өнөөдөр энэ зөвлөгөө ашиг тустай гэж та нар бодож байна?

Исаиа 33–34

Есүс Христийн Хоёр дахь Ирэлт

Есүс Христийн Хоёр дахь Ирэлт хэзээ, хэрхэн болно гэж та нар боддог вэ? Та нар үүнийг хүсэн хүлээдэг үү, эсвэл айдаг уу? Зарим хүмүүс ёс бусынхаа улмаас, мөн Их Эзэнтэй хамт байхад бэлтгэгдээгүй учраас Хоёр дахь Ирэлтээс айдаг тухай Исаиагийн үгсийг Исаиа 33 цэдэглэдэг. Исаиа бас Их Эзэнтэй хамт амьдрах хүмүүсийн тухай өгүүлж, тэд ямархуу маягийн хүмүүс байхыг дүрсэлжээ. Их Эзэнтэй хамт амьдрахыг хүсдэг хүмүүс эдгээр чанаруудыг онцгой анхаарч, хөгжүүлэхийн төлөө хичээх ёстой ажээ.

Энд иртэл, Исаиа 34-ийн бүх бүлгүүд устгалын тухай өгүүлдэг нь хахир хатуу мэт санагдаж болох юм. Бүлэг 34 нь Исаиагийн үед болон Хоёр дахь Ирэлтийн яг өмнөхөн ёс бусчууд дээр зайлиггүй тохиох шүүлтийг дүрсэлдэг. Гэвч, энэхүү аймшигт шүүлт сэрэмжлүүлэгдсэн боловч ёс бус байхаар сонгосон хүмүүс дээр л зөвхөн ирэхийг бид санах ёстой. Шийтгэлийн эдгээр хэлбэрийг өөрийнх нь хүүхдүүдээс аль нь ч хамаагүй биеэр туулахыг Их Эзэн хүсдэггүй ч гэсэн (2 Нифай 26:23–28-ыг үз), шударга хуулийг зөрчсөний үр дагаврууд гүйцэлдэх ёстой (С ба Г 63:33–34-ийг үз).

Судруудыг судлах нь

A Жагсаалт хий

- Исаиа 33:14–17-г уншиж, Христийн Хоёр дахь Ирэлтийн үе дэх устгалыг тэсэн гарна хэмээн Исаиагийн хэлсэн хүмүүсийн жагсаалт хий.
- Жагсаалт дахь зүйл бүр нь ямар утгатайг ярь.
- Шүлэг 17-д өгүүлснээр, эдгээр хүмүүст өөр юу тохиолдох вэ?

Исаиа 35

Найдварын захиас

Бүлгүүдийн зарим нь устгалын барсар захиасуудыг дамжуулсан билээ. Гэвч Исаиа Их Эзэнд итгэдэг хүмүүс

дээр ирэх адислалуудын тухай найдвар төрүүлэгч нэг бүлгээр өөрийн бичээсүүдийн энэ хэсгийг төгсгөжээ. Зөв шударга хүмүүст Их Эзэний санал болгодог агуу адислалуудыг бид авч үзсэнээр, наманчлалын замаар явах, уруу таталтуудыг даван туулахад бидэнд хэрэгтэй хүч чадлыг бид олж авч чадна.

Исаиа 36–39

Хаан Хезекиагийн түүх

Исаиа 36–39-ийн ихэнх нь бараг л Хаадын Дэд 18–20-тэй яг адилхан юм. Цорын ганцхан анхаарал татахуйц ялгаа бол Исаиа 38-д цэдэглэгдсэн Хезекиагийн “дуулал” юм. Хэрэв та нар бүлэг 36–39-д тохиолдсон зүйлийг нэгтгэн дүгнэхийг хүсвэл, Исаиа дахь бүлгүүдийг уншиж, энэ удирдамжийн 116–117 дугаар хуудсан дахь Хаадын Дэд 18–20-д зориулсан тусламжийг харж болно.

Исаиа 40

Их Эзэний хүч ба аугаа их чанар

Бүлэг 36–39-д түүхийн үйл явдлуудыг цэдэглэсний дараа, Исаиа бүлэг 40 дэх өөрийн бичээсийн бошиглолын хийгээд илүү яруу найргийн хэлбэр рүү эргэж орсон байдаг. Исаиа 40 дэх шүлгүүдийн олон нь хөгжмийн гайхамшигтай бүтээлүүдийн үг болсон юм, учир нь энэ бүлэг Их Эзэний хүч хийгээд тэрээр өөрийн хүмүүсийг хэрхэн гэ-тэлгэхийг эрхэм сайхнаар дүрсэлсэн байдаг. Исаиа болон бусад бошиглогчид устгалын тухай олонтаа бошиглогсны дараа, Исаиа 40 бол Их Эзэнд итгэдэг хүмүүст зориулсан агуу, найдвар төрүүлэгч захиас юм. Бүлэг 40-ийн бошиг-лолууд Мессиагийн нэг дэх, хоёр дахь ирэлт хоёуланг нь угтан хэлжээ. Хэрэв бид бүлэг 40-ийг өөрсөдтэйгөө “адилтагч” юм бол тэдгээр нь Их Эзэн болон бидний хувийн амьдрал дахь түүний хүчний тухай эрхэм сайхан, хүчирхэг гэрчлэл байж чадна.

Судруудыг ойлгох нь

Исаиа 40

Хатах, гандах (ш. 7–8)—Үхэх
Төөлөх (ш. 12)—Гарын сар-
вууны уртын хэмжээгээр
хэмжих
Сууринаас (ш. 21)—Эхлэлээс

Сүрэл (ш. 24)—Хадаж, ша-
таасны дараа үлддэг тари-
ны богинохон хэсгүүд
Элэн халина (ш. 31)—Дээш
хөөрөн ниснэ

Судруудыг судлах нь

Исаиа 40-ийг судлахдаа дараах гурван үйл ажиллагаануудаас (А–В) хоёрыг хий.

А Шинэ Гэрээнээс авах тусламж

Судруудын Удирдамж, “Библийн Иосеф Смитийн Орчуулгаас авсан гүүврүүд” дэх Лук 3:4–11-ийг унш.

1. Лукийн хэлсэн ямар зүйл Исаиа 40:3–5-д холбогдохыг дүрсэл.
2. Ямар нэмэлт мэдээлэл ИСО-д байна вэ.

Та нар ишлэлийг Исаиа 40:3–5-ын хажууд бичиж болно.

Б Үүнийг өөртөө болон бусдад холбогдуул

1. Исаиа 40:3 дахь захиасыг та нар ямар байдлаар өөртөө холбогдуулж болох вэ?
2. Их Эзэн Исаиа 40:4-ийг шууд хэрэгжүүлнэ гэж өөрийн боддог арга замыг дүрсэл. Та нар шүлэг 5-ыг уншиж, хэрхэн бүх махан бие “хамтдаа үзэхийг” авч үз.
3. Шүлэг 4 сүнслэг, илүү хувь хүний арга замаар биелэгдэж байгаа буюу биелэгдэх болно гэж өөрийн боддог арга замыг дүрсэл.
4. Зөв шударга ёс хүч чармайлт шаарддаг эсэх, эсвэл тэд Бурхантай хамт амьдрахын тулд хувиараа эргэн очиж болох эсэх, эсвэл ирээдүйд юу тохиох вэ гэдэг талаар санаа нь зовдог хүнд эдгээр шүлгүүд хэрхэн холбогдож болох вэ?

В Судрын асуултуудад хариул

Исаиа 40:12–31-ийн хариултууд тодорхой учраас Их Эзэн ч, Исаиа ч хариулаагүй олон асуултыг агуулдаг. Дараах шүлгүүдийг уншаад, асуултуудад өөртөө хариул: 12, 13, 14, 18, 21, 25, 27, 28. Эдгээр шүлгүүд дэх Исаиагийн захиас юу вэ гэж боддог тухайгаа бич.

Исаиа 41–47

Израилын Гэтэлгэгч

Хиймэл шүтээнүүдийг шүтэн бишрэх нь Исаиагийн үе дэх Израилын хүүхдүүдийн хамгийн жигшүүртэй бөгөөд ил тод нүгэл байсан бололтой. Тэд хиймэл шүтээнүүдийн оронд яагаад өөрт нь итгэж, өөрийг нь шүтэн бишрэх ёстойг Их Эзэн өөрийн хүмүүст хэрхэн хэлдэг байсныг Исаиа 41–47 өгүүлдэг. Өөр олон чухал нэр, цолнуудын дотроос, тэр бол тэдний Гэтэлгэгч (өөрийн цагаатгагч золиослолоор тэднийг сүнсний боолчлолоос гэтэлгэсэн хүн гэсэн утгатай; Исаиа 41:14; 43:1, 14; 44:6, 24; 47:4-ийг үз), тэдний Аврагч Исаиа 43:3, 11; 45:15, 21-ийг үз), мөн тэдний Бүтээгч (Исаиа 42:5; 43:1, 7, 15, 21;

44:24; 45:9, 11, 18) болохыг тэрээр тэдэнд гэрчилдэг байв. Гэрээний хүүхдүүдэд тэрээр: “Би бол чиний Бурхан ЭЗЭН, . . . чиний Аврагч . . .

“ . . . чиний Гэтэлгэгч . . .

“ . . . чиний Ариун Нэгэн, . . . чиний Хаан ” хэмээн онцлон тэмдэглэжээ (Исаиа 43:3, 14–15).

Хэдийгээр эдгээр бүлгүүд Израилын хүүхдүүдийг наманчилж, Их Эзэнд эргэн очиход уриалан дууддаг ч гэсэн, хэрэв тэд түүнийг дагахаар сонгох юм бол Их Эзэн тэднийг хүлээн авах болно, мөн тэднийг өөрсдийнх нь бүх нүгэл зовлонгоос аврах гэтэлгэх хүч түүнд бий гэсэн амлалтын найдвараар тэд дүүрэн юм.

Эдгээр бүлгүүдийн захиасууд манай өнөө үед холбогдож болох ч гэсэн, тэдгээр нь Исаиаг нас барснаас хойш 150 орчим жилийн дараа Вавилонд боолчлолд байсан иудейчүүдийн хувьд онцгой учир холбогдолтой юм. Гэрээт хүмүүсийн хувьд тэд хиймэл шүтээнүүдийг шүтэн биширдгээ наманчлахыг татгалзсаны улмаас боолчлолд аваачигдсан аж. Их Эзэний санал болгосон аврагч, гэтэлгэгч хүч тэдэнд хэрэгтэй байлаа, иймээс тэд өөрсдийнх нь чөлөөлөгч болно гэсэн Персийн хаан Корешийн амлалтад (Исаиа 45-ыг үз), түүнчлэн Вавилоны устгал бошиглогдсон (Исаиа 47-г үз) онцгой зоригжсон ажээ.

Судруудыг ойлгох нь

Исаиа 47:5–10

Халдеичуудын охин (ш.

5)—Вавилоны хүмүүс

Хаанчлалуудын хатан (ш.

5)—Хаант улсуудын хамгийн агуу нь

Илбүүд, ид шид (ш. 9,

12)—Илбэ ид шидийн зурш-

лууд, тэмдгүүд, оддын хө-

дөлгөөн дээр тулгуурлаж

ирээдүйн тухай угтан хэлэх

Исаиа 45:1—Кореш гэж хэн байсан бэ?

МЭӨ 600–586 оны хооронд вавилончууд Иудаг эзэлснийг та нар Хуучин Гэрээнд өмнө нь уншсан билээ. Ойролцоогоор МЭӨ 540 онд Меде—Персийн эзэнт гүрэн Кореш Хааны удирдлагаар вавилончуудыг байлдан дагуулжээ. Үүнээс хойш удалгүй Кореш иудейчүүдийг Иерусалим уруу буцаж, өөрсдийн ариун сүмийг барихыг зөвшөөрсөн тогтоол гаргасан ажээ.

Судруудыг судлах нь

Исаиа 41–47-г судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А–Г) хоёрыг хий.

А Энэ хэн бэ?

1. Исаиа 42:1–7; Матай 12:14–21-ийг уншиж, Исаиагийн бичсэн зарц хэн бэ гэдгийг ярь.
2. Өөрт чинь онцгой сэтгэгдэл төрүүлсэн, энэ зарцын тухай хоёр үзэл баримтлалыг Исаиа 42:1–7-гоос олж бичээд, эдгээр нь яагаад танд гүнзгий сэтгэгдэл төрүүлснийг тайлбарла.

Б “Библийн Иосеф Смитийн Орчуулгаас авсан түүврүүд”-ээс авах тусламж

1. Судруудын Удирдамж дахь “Библийн Иосеф Смитийн Орчуулгаас авсан түүврүүд” дэх Исаиа 42:19–23-ыг уншиж, сүнсний зүйлүүдийн хувьд харалган, дүлий хүмүүсийн төлөө Их Эзэн юу хийнэ гэж хэлсэн тухай бич.
2. Өнөөдөр энэ нь хэрхэн тохиодог тухай бич.

В Найздаа зурвас бич

Урам нь хугарч цөхөрсөн хэн нэгэнд найдвар төрүүлэхийн тулд, Исаиа 43:1–7-д агуулагдсан үнэнүүдээс наад тал нь хоёрыг ашигласан зурвас бич.

Г Асуудлыг ол

Исаиа 47:5–10 Вавилоныг алдар суугаа алдсан хатан хаантай зүйрлэж, тэрээр яагаад унасныг тайлбарладаг.

1. Яагаад энэ “хатан” унасныг дүрсэлсэн наад тал нь хоёр өгүүлбэр бич. Эдгээр өгүүлбэрүүд ямар утгатайг өөрийн үгээр тайлбарла.
2. Өнөө үед сайхь “хатныхтай” адил алдааг хүн гаргаж болох нөхцөл байдлын тухай бичиж, үр дагаврууд нь юу байж болно гэж бодлогоо ярь.

Анхааруулга: Энэ бүлэг бол Мормоны Номны зохиогчдоор иш татагдсан, дараалсан нилээд хэдэн бүлгийн эхлэл юм. Та нар Мормоны Номонд бичигдсэн зүйлийг Исаиад бичигдсэн зүйлтэй харьцуулж, аливаа өөрчлөлтүүд болон эдгээр өөрчлөлтүүд утгад ямар нэмэлт оруулж байгаа талаар тэмдэглэл хөтөлж болно.

Исаиа дахь бүлгүүд	Мормоны Номонд хаана иш татагдсан
48	1 Нифай 20
49	1 Нифай 21
50	2 Нифай 7
51	2 Нифай 8
52:1–2	2 Нифай 8:24–25; мөн 3 Нифай 20:36–38-ыг үз
52:7–10	Мозая 15:18, 29–31; мөн 3 Нифай 16:17–20, 20:40-ийг үз
52:11–15	3 Нифай 20:41–45
53	Мозая 14
54	3 Нифай 22

Исаиа 48

Эргэж ирэх урилга

Исаиа 48 нь түүнтэй гэрээнүүд хийсэн боловч эдгээр гэрээнүүд болоод Сүмийн гишүүнчлэлдээ хөнгөн хуумгай ханддаг хүмүүстэй Их Эзэн хэрхэн харьцдагийг ойлгоход бидэнд тусалдаг. Та нар уншихдаа, Их Эзэнээс нүүр

буруулсан хүмүүсийн талаарх түүний санаа бодлын тухай энэ бүлэг юу заагдгийг авч үз. Өөрийгөө итгэлд үнэнч байлгаж, Их Эзэнд хандах шийдвэр төгс байдлынхаа төлөө тэмцэж байгаа бусад хүмүүст туслахын тулд эдгээр сургамжуудыг та нар хэрхэн ашиглаж болох тухай бод.

Судруудыг судлах нь

Исаиа 48-ыг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А–В) хоёрыг хий.

А Өөрчлөлтүүдийг ажигла

1. Исаиа 48:1–2-ыг 1 Нифай 20:1–2-той харьцуул. Эдгээр нь ямар ялгаатай байна вэ?
2. Харьцуулал хийхэд, эдгээр шүлгүүдэд Их Эзэн хэнтэй ярьж байна гэж та нар бодож байна?

Б Үг сонго

Исаиа 48-д тэдний талаар Их Эзэн яагаад бухимдаж байсныг тэрээр израилчуудад ярьжээ. Дараах шүлэг тус бүрд, израилчуудын талаар Их Эзэн юу хэлснийг хамгийн сайн дүрсэлсэн гэж өөрийн бодсон нэг үгийг бич: 4, 6, 8. (Үгсийг уг шүлгүүдээс авах хэрэггүй.)

В Их Эзэн өөрийн хүмүүст яаж тусалдаг вэ?

1. Төөрөлдсөн израилчуудад Их Эзэний хийсэн амлалтуудын жагсаалтыг Исаиа 48:9–22-оос хий.
2. Их Эзэн өнөөгийн хүмүүсийн хувьд эдгээр амлалтуудыг хэрхэн гүйцэлдүүлж байгаа жишээ гарга.
3. Амар амгалан, аз жаргалтай байхын тулд бид юу хийх ёстой гэж Их Эзэн хэлснийг өөрийнхөө үгээр бич (Исаиа 48:16–22-ыг үз).

Исаиа 49

Тараагдсан Израилд өгсөн захиас

1 Нифай 19:23-т “Их Эзэн өөрсдийн Гэтэлгэгчид итгэхийг илүү бүрэн дүүрнээр ятгахын” тулд тэрээр ах дүүстээ Исаиагийн зарим бичээсийг уншиж өгсөн хэмээн Нифай хэлсэн байдаг. Исаиа 48–49-ийг гуулин ялтсуудаас өөрийн “жижиг ялтсуудад” цэдэглэсэнээр Нифай энэ мэдэгдлийг дагасан ажээ (1 Нифай 20–21-ийг үз). Бүлэг 48–49 юу гэсэн утгатай тухай Нифайн тайлбар 1 Нифай 22-т байдаг. Хэрэв та нар 1 Нифай 22-ыг унших юм бол, Исаиа 48–49-ийн захиасыг илүү сайн ойлгох болно.

Есүс Христэд итгэхийг илүү бүрэн дүүрнээр ятгахын тулд Нифай ах дүүстээ эдгээр бичээсүүдийг уншиж өгснийг мэдэх нь бид унших үедээ юуг эрж хайх талаар бидэнд түлхүүрийг өгдөг. Та нар Исаиа 49-ийг, түүнчлэн бүлэг 50–53-ыг уншихдаа, Есүс Христийн аврагч хүчинд итгэх та нарын итгэлийг бэхжүүлэгч сургамжуудыг эрж ол.

Судруудыг ойлгох нь

Исаиа 49

Саадаг (ш. 2)—Бүсэлдэг буюу үүрч явдаг сумны гэр (сав)

Үндэстнүүд (ш. 6)— Израилын угсааны гишүүн бус хүмүүс

Судруудыг судлах нь

Исаиа 49-ийг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А–В) хоёрыг хий.

А **Есүс Христийн тухай өөрт чинь сургадаг зүйлүүдийг эрж ол**

Есүс Христ—түүний тохинуулал, хүч, болон түүний хайрыг дүрсэлсэн гэж өөрийн боддог шүлгүүдийг Исаиа 49-өөс сонгож—яагаад эдгээр шүлгүүдийг сонгосноо тайлбарла.

Б **Чухал нэмэлт**

- 1 Нифай 21:1-д Исаиа 49 дээр нэмсэн нэн чухал нэг нэмэлт байдаг.1 Нифай 21:1-ийг уншиж, Их Эзэн энэ бүлэгт хэнд хандаж ярьсан тухай бич.
2. Ямар байдлаар эдгээр хүмүүсийн дүрслэл манай өнөө үеийн хүмүүсийг бэлэгдэж чадна гэж та нар бодож байна?

В **Израилыг гэтэлгэх нь**

Исаиа 49-ийн үндсэн сэдэв бол Израилыг цуглуулах буюу гэтэлгэх юм. Израилын гэтэлгэлийн тухай дараах асуултуудад хариулсан нэг шүлгийг (эсвэл хэдэн шүлгийг) ол: Хэн? Хэрхэн? Яагаад? Эдгээр асуултуудыг тэмдэглэлийн дэвтэртээ бичиж, холбогдох шүлгийг асуулт бүрийн дараа бич. Та нар бас судрууддаа эдгээр шүлгүүдийн доогуур зурж, шүлэг бүр юунд хариулт өгч байгааг судрынхаа зах дээр уг шүлгийн хажууд бич.

Израил хэсэг бүлгийн хувьд цугларах тухай бид олонтаа ярихдаа, хувь хүн бүр Их Эзэн болон түүний Сүмд хувиараа цугласнаар уг цугларалт тохиох ёстойг бид ойлгох учиртайг сана. Израил эрт дээр үеийн дайснууд дундаасаа цуглардаг байсан лугаа адил бид нүгэл болоод шударга бус байдлын боолчлолоос хувиараа Их Эзэнд цуглаж байгааг харж болно.

Исаиа 50

Их Эзэнд эргэж ир

Исаиа 50 нь Исаиа 49-д эхэлсэн тэрхүү санаануудыг үргэлжлүүлдэг.

Судруудыг ойлгох нь

Исаиа 50

Таар (ш. 3)—Уй гашуудлын үед өмсдөг хар ямааны арьсаар хийсэн хувцас

Цохигчид (ш. 6)—Бусдыг зоддог хүмүүс

Цахиур (ш. 7)—Гантай харшилдахад оч үсэрдэг маш хатуу чулуу

Надтай тэмцэлдэх (ш. 8)— Миний эсрэг маргах

Исаиа 50:6—“Сахлыг минь үгтээх тэдэнд . . . би хацраа тавьж өглөө”

Хэрэв хүн нөгөө хүнээ даруусгахыг хүсвэл, үл хүндэтгэж байгаагийн тэмдэг болгон сахлынх нь үснээс үгтээж татдаг байжээ.

Исаиа 50:10—Хэн үнэхээр Их Эзэнийг дагасан атлаа адислагдахгүй, аз жаргалгүй байж болох вэ?

Исаиа 50 дахь Их Эзэнийг дагах урилга нь Хаан Бенжамин Мозая 2:41-д өөрийн хүмүүст өгсөн урилгатай адил юм.

Судруудыг судлах нь

Исаиа 50-ийг судлахдаа А буюу Б үйл ажиллагааг хий.

А **Есүс Христийн тухай бид юу мэдэв?**

Исаиа 50:5-7; 1 Нифай 19:9; Сургаал ба Гэрээ 19:16-19-ийг уншиж, судрын эдгээр хэсгүүд та нарт юуны тухай зааж байгааг бич.

1. Аврагч Цагаатгалыг хэрэгжүүлэхийн тулд юуг тэвчин гарсан бэ?
2. Урьд хожид үзэгдээгүй, ийм гашуун зүйлийг хийхэд юу түүнийг өдөөн түлхсэн бэ?

Б **Жишээ гарга**

1. Шүлэг 10-11-д Исаиагийн өгүүлсэн хоёр өөр маягийн хүмүүсийг дүрсэл.
2. Өөрийн чинь насны хүмүүст тулгардаг нөхцөл байдлын тухай бод. Исаиагийн дүрсэлсэн хоёр өөр маягийн хүмүүс тус бүр нь ийм нөхцөлд хэрхэн үйлдэх байсны жишээг гарга.

Исаиа 51-52

Сэрэгтүн! Тэгээд Түүнд ир

Исаиа 51-52 нь өмнөх бүлгүүдийн найдвар агуулагч сэдвийг хэвээр хадгалан, Их Эзэнд итгэдэг хүмүүсийг урамшуулан дэмжсэн үгсээр дүүрэн юм. Бүлэг 51-52-т бүх зүйлийн дээрх—ялангуяа Израилын дайснуудын дээрх Их Эзэний аугаа хүчний тухай бид унидаг. Нүглийн боолчлолд байгаа хувь хүмүүс эдгээр судруудыг өөрсөдтэйгөө адилтгаж: *Замаасаа гажсан хэдий ч, эдүгээ өөрсдийн итгэлийг түүнд*

тавьж, түүний зарлигуудыг сахьж байгаа өөрийн хүүхдүүдэд Их Эзэн хүчирхэг тусламж үзүүлэх болно гэсэн энэхүү захиасыг хүлээн авч болно.

Исаиа 53

Есүс Христийн зовлон угтан хэлэгдсэн нь



Есүс Христийн үүрэг зорилго болон үүний тухай сэтгэл хөдөлгөм гэрчлэлийн улмаас олон хүмүүс Исаиа 53-т дуртай бөгөөд үүнээс иш татдаг. Илд зэвсэг. Дайн дажнаар бус, харин даруухан зовлонгоор дамжуулан өөрийн хүмүүсийг аврах Мессиагийн тухай Исаиагийн бошиглолыг энэ бүлэг агуулдаг. Исаиа 53-ыг анхааралтай уншиж,

Мессиагийн тухай бодох хийгээд ойлоход бидэнд туслахын тулд Исаиагийн хийхийг хичээсэн зүйлд мэдрэмтгий бай.

Судруудыг ойлгох нь



Исаиа 53

Хяргагч (ш. 7)—Хонины ноосыг хяргадаг (хайчилдаг) хүн

Үүрэх (ш. 11)—Тээх, авч явах

Олз (ш. 12)—Бусдаас булаан авсан эд юмс

Зуучилсан (ш. 12)—Бусдын нэрийн өмнөөс ажилласан

Судруудыг судлах нь



А Төгс Эзэмших Судар—Исаиа 53:3–5

Дараах хүснэгтийг тэмдэглэлийн дэвтэртээ хий. Хоёр дахь баганан дахь шүлгүүдийг уншсаны дараа, өөрсдийн чинь уншсан үйл явдлын тухай бошиглол байж болох нэг шүлгийг Исаиа 53-аас ол. Гурав дахь багананд, Исаиа 53-аас уг шүлгийг яагаад сонгосон болон энэ нь Аврагчийн тухай юу өгүүлж байгааг товч тайлбарла.

Исаиа 53 дахь шүлэг	Гүйцэлдэлт	Тайлбар
	Матай 13:54–58	
	С ба Г 19:16	
	Лук 22:54–62	
	Иохан 1:11	
	Матай 26:36–46	
	Мозая 3:7	
	2 Нифай 9:21	
	Алма 7:11–13	
	Марк 15:25–28	
	Иохан 19:4–12	
	Иохан 19:38–42	
	С ба Г 45:3–5	

Б Энэ нь таныг юу гэж бодоход хүргэдэг вэ?

Дээрх бүх судрууд болон Исаиа 53-ыг уншаад, Бүлэг 53-т өөрт чинь хамгийн их сэтгэгдэл төрүүлсэн зүйлийн тухай, түүнчлэн таны төлөө бас бүх хүн төрөлхтний төлөө Аврагчийн хийсэн зүйлийн талаар та юу гэж боддог тухайгаа нэг буюу хоёр догол мөр бич.

Исаиа 54

Нинжин сэтгэлт эр нөхөр

Исаиа 54-т Израилын тараагдсан хийгээд боолчлолд орсон хүүхдүүдэд хандан ярихдаа, Их Эзэн тэдэнтэй харилцах өөрийн харилцааг гэрлэлтийн харилцаатай зүйрлэжээ. Хэдийгээр тэр түр хугацаагаар тусгаарлагдсан ч гэсэн, тэднийг нигүүлсэл хийгээд нинжин сэтгэлээр “эр нөхрийн” (Исаиа 54:5) хувьд үүрд эргүүлэн хүлээн авахаар амлажээ. Энэ амлалт нь бүр тэд наманчиллаа ч гэсэн Их Эзэн тэднийг хэзээ ч эргүүлж авахгүй гэж боддог, нүгэлд байгаа хувь хүмүүсийн хувьд бас хувь хүний найдварын захиас болон хүлээн авагдаж болно.

Исаиа 55

Эзэний урилга



Исаиа 55 бол өөртөө ирэхийг уриалсан Их Эзэний нэг дуудлага юм. Бүлэг 55-д яагаад тараагдсан Израил болон бид бүгд түүнд итгэж, түүнийг дагах ёстойн өөр олон учир шалтгааныг тэрээр өгдөг.

Судруудыг ойлгох нь



Исаиа 55

Чихээ нээ (ш. 3)—Сонсогтун

Исаиа 55:3–4—Тэрээр яагаад Давидын тухай өгүүлнэ вэ?

Энд “Давид” гэдэг үг хэрэг дээрээ Давидын хаан сэнтийний хууль ёсны залгамжлагч байсан Есүс Христийг хэлж байна. Еврей хэлэнд Давид гэдэг нэр “хайрлагдсан” гэсэн утгатай нь сонирхолтой юм. Хуучин Гэрээний хожуу үеийн бошиглогчид Давидыг дурдсан үедээ ихэвчлэн Давидын хаан сэнтий, түүнчлэн Мессиагийн тухай өгүүлдэг байсан ажээ.

Судруудыг судлах нь



А Өөрийнхөө үгээр

1. Исаиа 55:1–2-ыг 2 Исаиагийн үгсийг Иаков хэрэглэсэн байж болох Нифай 9:50–51-тэй харьцуул. Эдгээр шүлгүүд та нарын хувьд ямар утга учиртайг өөрийнхөө үгээр тайлбарла.
2. Эдгээр шүлгүүдэд Их Эзэний санал болгосон хоол хүнсийг хүн хэрхэн “худалдаж авах” буюу “идэж” болно гэж та нар бодож байна? Та нар хариултаа бичихдээ, туслалцаа авахын тулд Иохан 4:10–14 буюу Иохан 6:29–35, 47–51-ийг унш.

Б Төгс Эзэмших Судар—Исаиа 55:8–9

1. Энэ хоёр шүлгийн захиасыг төлөөлсөн схем зур.
2. Эдгээр шүлгүүдийн захиас нь хэрхэн хүний тайтгарал байдаг вэ?
3. Иаков 4:8-ыг уншиж, Бурханы бодол санаанууд хийгээд арга замуудыг бид хэрхэн ойлгож чадах тухай ярь.

Исаиа 56

Эзэн бүх үндэстнүүдийг аварна

Исаиа 56 тэрээр Израилын хүүхдүүдийг, мөн ийм адислалуудыг хүсдэг өөр хэнд ч болов, адислалуудыг санал болгоно хэмээн Их Эзэн хэлснийг цэдэглэжээ. Шүлэг 6 дахь “харь хүмүүс” мөн шүлэг 8 дахь “өөр хүмүүсийг” ажигла.

Исаиа 57

Эзэнд эдгээх хүч бий

Исаиа 56-гийн сүүлчийн дөрвөн шүлэгт, Исаиа хүмүүсийн нүглүүдийн тухай тэдэнд шууд ярьсан байдаг. Түүний сэргэмжлүүлгүүд бүлэг 59-ийг дуустал үргэлжилдэг. Исаиа 57 хиймэл шүтээн шүтэгчдийн эсрэг түүний хэлсэн хүчирхэг үгсийг цэдэглэдэг. Тэрбээр Израил, Их Эзэний хоорондох гэрээний харилцааг төлөөлүүлэхийн тулд гэрлэлтийн бэлэгдлийг дахин ашиглажээ. Хэрэв Их Эзэнтэй гэрээ хийсэн хүмүүс бэлэгдлийн хувьд түүнтэй гэрлэсэн гэж үзвэл, бусад бурхдыг шүтэн биширдэг байсан израилчууд “завхайрагчид” мөн. Тэдний нүглүүдийн улмаас тэдэнд юу тохиохыг Исаиа хэлж, зарим үед бид өөрсдийнхөө нүглүүдийн хэмжээгээр, тэдгээрийн төлөө өөрсдийнхөө байгаа тэр байдлаар шийтгэгддэгийг харуулжээ. Үнэнч хэвээр үлдсэн хүмүүсийн төлөө Их Эзэний хийх зүйлүүдийн тухай Исаиа бас өгүүлсэн байдаг. Тэр үед үнэнч хэвээр үлдэнэ гэдэг хэцүү байж, учир нь ихэнх хүмүүс Их Эзэнийг орхисон байлаа, мөн нийт үндэстнээрээ үр дүнг нь мэдэрч байв. Иймээс, Их Эзэн “сэргээх” (ш. 15), “эдгээх” (ш. 18–19), “тайвшруулах” (ш. 18) гэхчлэнгийн үгсийг ашиглажээ.

Исаиа 58

Мацаг ба Хүндэтгэлийн өдөр

Та нар Исаиа 58-ыг уншихаасаа өмнө, дараах асуултуудын тухай бод:

Мацгийн зорилго юу вэ? Та нарын барьсан хамгийн утга учиртай мацаг юу байв? Яагаад тэр вэ? Хүндэтгэлийн өдрийг ариунаар сахихын зорилго юу вэ? Хүндэтгэлийн өдрийг ариунаар сахьснаар та нар ямар адислалууд хүлээн авсан бэ?

Судруудыг ойлгох нь



Исаиа 58

Эгс (ш. 5)—Нарийхан өндөр ургамал

Буулга (ш. 6, 9)—Мухлаг тэрэг буюу анжис чирүүлэхэд хүчийг нь нэгтгэхийн тулд хос морь буюу үхрийн цээжинд угладаг модон буюу төмөр хэрэгсэл. Энэ шүлэг дэх “буулга” нь ядуурал буюу нүглийн дарамтыг бэлгэдлээр төлөөлжээ.

Цусан төрөл (ш. 7)—Гэр бүл

Зэрлэг балмад яриа (ш. 9)—Бусдын тухай муугаар ярих

Өөрийгөө өгөх (ш. 10)—Өгөх, зориулах

Хөлөө татвал (ш. 13)—Улан дороо дэвслэхгүй бол

Өв хөрөнгө (ш. 14)—Адислалууд

Судруудыг судлах нь



А Хүснэгт хий

Дараах хүснэгтийг гэмдэглэлийн дэвтэртээ хийж, Исаиа 58:3–12-т олсон зүйлсээрээ бөглө.


Бид мацаг барьж байхдаа яах ёстой вэ	Бид мацаг барьж байхдаа юунаас зайлсхийх ёстой вэ	Түүний зарлигласны дагуу мацаг барихад ирдэг, Их Эзэний амласан адислалууд

Б Жишээнүүд гарга

- Исаиа 58:13–14-д Хүндэтгэлийн өдрийг хэрхэн ариунаар сахихыг мэдэхэд бидэнд тусалдаг зарчмуудыг Их Эзэн бидэнд өгсөн билээ. Эдгээр зарчмуудыг жагсаа. Сургаал ба Гэрээ 59:9–14-ийг уншиж, Хүндэтгэлийн өдрийг ариунаар нь сахих зарчмуудыг жагсаалт дээрээ нэм.
- Өөрийн жагсаалт дахь зарчим бүрд, Хүндэтгэлийн өдрөөр уг зарчмыг хүн хэрхэн дагаж болох тухай жишээ гарга. Дараа нь Хүндэтгэлийн өдрөөр уг зарчмыг хүн хэрхэн зөрчиж болох тухай жишээ гарга.
- Исаиа 58:13–14-т өгүүлсний дагуу Хүндэтгэлийн өдрийг ариунаар сахьсаны төлөө Их Эзэний амласан адислалуудыг жагсаа.

Исаиа 59

Нүгэл ба түүний үр дагаврууд



Бид нүглүүдийнхээ улмаас шийтгэгддэгийн хамт бас нүглүүдээрээ олонтаа шийтгэгддэг, учир нь бүх нүглүүд үр дагавруудтай байдаг. Исаиа 59:1–15-д, Их Эзэн Израилд тэдний нүглүүдийн тухай хэлж, тэд нүгэлд хичнээн удаан үргэлжлүүлэхийн хэрээр, тэрээр тэдэнд тусалж чадахгүй; тэд нүглүүдийнхээ үр дагавруудыг амссаар байх ёстой гэжээ. Нөгөө талаар, шүлэг 16–21-д, тэрээр зөв шударга хүмүүст өгөх тусламжийн тухай Их Эзэн өгүүлжээ.

Исаиа 60

Гэрэл тань цацраг

“Дэлхий даяар, эдүгээ хэдэн арван мянгаараа ирж байгаа хүмүүс гэр бүл нь аюулгүй байгаа газар уруу үер лугаа адил зайлшгүй цутган ирэх болно. Энд [Сүмд] тэд Есүс Христийн нэрээр, Ариун Сүнсний бэлгээр Эцэгийг шүтэн биширч, Сайн мэдээ бол аз жаргалын, гэтэлгэлийн агуу төлөвлөгөө мөн гэдгийг мэдэх болно” хэмээн Ахлагч Боид К.Пакер бошигложээ (in Conference Report, 1994 оны 4-р сар, 26–27; Ensign, 1994 оны 5-р сар, 21).



Ахлагч Пакерын бошиглол Исаиа 60 дахь бошиглолтой маш адилхан юм. Бүлэг 60-д, Сион дахин баригдаж, хурц гэрэл лугаа адил сүндэрлэн, улмаар дэлхийн бүх үндэстнүүд түүнийг хүндлэн, түүний удирдлага өөд харах үед дэлхий дээр харанхуйн өдөр байх тухай Исаиа өгүүлжээ.

Исаиа 61

Их Эзэн болон Түүний үйлчлэгчдийн үүрэг зорилго

Исаиа 61 бол хэрэв Бурханд итгэлтэй байх юм бол түүний хүмүүст ирж болох адислалуудын тухай өгүүлдэг өөр нэг бүлэг юм. Эхний гурван шүлэгт, Исаиа Израилын угсааг өргөж, адислах өөрийн үүрэг зорилгын тухай өгүүлжээ. Гэвч, уг үүрэг зорилго Аврагчид илүү бүрэн дүүрнээр холбогдох бөгөөд Исаиа ердөө л хүмүүсийн өмнө түүнийг төлөөлдөг байв. Эдгээр шүлгүүд Аврагчийг төлөөлөхөөр дуудагддаг бүх хүмүүсийн үүрэг зорилгыг дүрслэхэд тусалж чадна.

Судруудыг ойлгох нь



Исаиа 61:1-3

Өшөө авах өдөр (ш. 2)—
Бурхан ёс бусчуудыг шийт-
гэж, зөв шударга хүмүүсийг
шагнах өдөр

Үнсний оронд цэцгийн
хэлхээ (ш. 3)—Гүнзгий уй

гашуу тохиолдсон үед хүн
толгой дээрээ үнс асгадаг
байсан заншлыг хэлж бай-
на. Хүмүүс дахиад гашуу-
дахгүй байх болно гэсэн
утгаар Их Эзэн гоё сайхан
малгай амлажээ.

Судруудыг судлах нь



А Биелэлтийг тайлбарла

1. Лук 4:16–21-ийг уншиж, Исаиа 61:1–3-ын талаар Есүс юу гэж хэлснийг тайлбарла.
2. Эдгээр шүлгүүд дэх бошиглолуудыг Аврагч ямар арга замаар биелүүлснийг мэддэг тухайгаа, эсвэл тэрээр эдгээр бошиглолуудыг ямар арга замаар үргэлжлүүлэн биелүүлэх тухай бич.

Исаиа 62

Израилын угсааны гэтэлгэл

Исаиа 62 тэдний гэтэлгэлийн өдөр Израилын угсаанд ирэх адислалуудыг дахин дүрсэлдэг. Эдгээр амлалтууд наманчилж, Есүс Христэд болон Сүмд цуглахаар ирдэг хувь хүмүүст бас холбогдож болно—адислалууд нь адил билээ.

Яригдсан бүх адислалууд тохиохоор ирэх хүртэл Исаиа болон Их Эзэний бусад үйлчлэгчид хүмүүсийн төлөө номлох, хөдөлмөрлөх хийгээд ажиллахаа зогсоохгүй гэдгийг Исаиа 62 бас заадаг (ш. 1, 6–7, 10-ыг үз).

Исаиа 63

Есүс Христийн Хоёр дахь Ирэлт

Исаиа 63 Есүс Христийн Хоёр дахь Ирэлтийн үед тохиох үйл явдлуудын тухай өгүүлдэг.

Судруудыг ойлгох нь



Исаиа 63:1–9

Өшөө авалт (ш. 4)—Шүүлт
Соёрхсон (ш. 7)—Адисалсан

Судруудыг судлах нь



А Хоёр дахь Ирэлтийн тухай мэдээллийг ол

Сургаал ба Гэрээ 133:45–53-ыг уншиж, Хоёр дахь Ирэлтийн тухай дараах асуултуудын хариултуудыг ол:

1. Их Эзэн ямар хувцастай байх вэ?
2. Тэр яагаад ийм байдлаар хувцаслах вэ?
3. Их Эзэн юу хэлэх вэ?
4. Их Эзэн ямар сэтгэл хөдлөлтэй байх вэ?
5. Түүнийг ирэхэд “гэтэлгэгдэгсэд” юу гэж хэлэх вэ?



Исаиа 64

Зөв шударга хүмүүсийн залбирал

Исаиа 64 залбирлын хэлбэрээр бичигдсэн юм. Залбирал нь Их Эзэн ирж, ёс бусчуудыг устган, зөв шударга хүмүүсийг шагнахын төлөөх хүслийг илэрхийлжээ. Сургаал ба Гэрээ 133:38–45 нь Их Эзэний үйлчлэгчид эцсийн өдрүүдэд энэ залбирлыг санал болно гэдгийг ойлгоход бидэнд тусалдаг.

Исаиа 65

Мянган Жил

Исаиагийн бичээсүүд ийм агуу байдгийн нэг шалтгаан нь эдгээр нь Бурханы агуу төлөвлөгөө хийгээд уг төлөвлөгөөн дэх бидний Аврагч Есүс Христийн гол төв үүргийн тухай өдий ихээр тайлбарласан байдаг. Мөнх бус байдлын өмнөх амьдралд тохиосон үйл явдлуудын тухай, мөн түүнчлэн Мянган Жилийн үед тохиох үйл явдлуудын тухай Исаиад бид уншдаг. Исаиа 65–66 Мянган Жилийн тухай өгүүлдэг. Гэвч Исаиа 65-ын шүлэг 1–16-д, Их Эзэн Исаиагийн үеийн израилчуудад өгсөн өөрийн захиасыг төгсгөжээ. Тэдэнд туслах, тэднийг гэтэлгэхийн тулд (ш. 1–2, 12-ыг үз), Тэрээр ямагт бэлэн байсан хэдий ч, тэд үүний оронд ёс бус явдлыг сонгож байсныг (ш. 3–4, 11-ийг үз) тэдэнд хэлсэн ажээ.

Их Эзэн израилчуудыг хайрладаг байсны улмаас тэднийг бүрмөсөн устгахгүй гэдгийг тэдэнд амласан юм (ш. 8–10-ыг үз). Тэдний эсэргүүцсэн адислалуудыг Тэрээр израилчуудын ирээдүйн үеийнхэн болон бусад хүмүүст өгөхөөр хичээх болно гэдгийг бас амласан аж (ш. 13–15). Тэр ч байтугай, Израилын шийтгэлд ч гэсэн тэднийг хийгээд бүх хүмүүсийг хайрлах Их Эзэний агуу хайрыг бид мэдэрдэг.

Судруудыг судлах нь

А Мянган Жилийн тухай мэдэж ав

1. Исаиа 65:17–25-аас Мянган Жилийн тухай мэдсэн зүйлүүдээ жагсаа.

2. Хэрэв та нар Мянган Жилийн үед амьдрах боллоо гэхэд ямар туршлагыг өөрсдөдөө байлгахыг хамгийн ихээр хүсэх болно гэдгийг уншсан зүйлээсээ бичих вэ? Яагаад?

Исаиа 66

Сионы найдвар

Хэрэв та нар итгэлтэй байх юм бол, бүр энэ үе дэх та нарын зовлон, хавчлага, хүнд сорилтуудаар дамжин шагнагдах өдөр ирэх болно. Их Эзэнийг хүлээгтүн, юм бүхэн зөв болгогдох—ёс бусчууд шийтгэгдэж, зөв шударга хүмүүс шагнагдах тэрхүү өдрийг та нар болоод бүх дэлхий мэдэх болно хэмээн Исаиагаар дамжуулан өгсөн Их Эзэний захиасыг Исаиа 66 хураангуйлан дүгнэдэг.

Иеремиагийн Ном

Иеремиагийн номлол ойролцоогоор МЭӨ 626 онд эхэлжээ. Тэр бол Хаан Иосиагийн хаанчлалын үед тохируулж байсан хэдэн бошиглогчийн нэг байв (Хаадын Дэд 22–23-ыг үз).

Эхлэл ба төгсгөл

Иеремиагийн тохирууллын үед вавилончууд Ассирийг эзэлж, дэлхийн их гүрэн болжээ. Иудагийн удирдагчид болоод хүмүүс өөрсдийнх нь жижигхэн үндэстнийг Вавилон бас эзлэхвий хэмээн сэтгэл түгшиж, улмаар хамгаалалтын төлөө Египеттэй холбоотон болохыг тэд оролдож байжээ. Наманчлахыг, мөн Египет буюу эсвэл өөр аль нэг орны оронд Их Эзэнээс чөлөөлөлтийг эрж хайхыг Иеремиа улс үндэстэндээ сануулдаг байв.



Олон жилийн туршид, нилээд хэдэн удаа довтолсноор вавилончууд олон иудейчүүдийг амлагдсан нутгаас нь Вавилонд аваачжээ. Бошиглогч Даниел, Езекиел хоёр тэдний дунд аваачигдсан байв. Вавилоны цэргийн гараар удахгүй тохиох устгалаас зайлсхийхийн тулд Лихай болон түүний гэр бүл Иерусалимаас гарч явахад Их Эзэнээр сэрэмжлүүлэгдсэн ажээ. Сонирхолтой нь гэвэл, Лихайн гэр

бүл өөрсөдтэйгөө авч явсан гуулин ялтсууд бошиглогч Иеремиагийн бошигلولуудыг агуулсан байжээ (1 Нифай 5:13-ыг үз). Иеремиа наманчлалыг номлохоо үргэлжлүүлсээр байсан хэдий ч, түүний номлол хүмүүст өчүүхэн нөлөө үзүүлдэг байж. Иерусалим дахь сүүлчийн хаан Зедекиа Иеремиагийн захиасуудад дургүйцэж, түүнийг баривчлуулж, шоронд хориулсан аж. Вавилончууд нэгэнтээ сүүлчийн удаа ирэхдээ Иерусалимыг устгаж, Зедекиаг боолчлолд аваачин, Иеремиа амь насаа аврахын төлөө зугтаж, Египетэд амьдрах болжээ.

Иеремиаг судлахад бэлтгэх нь

Исаиагийн нэгэн адил, Иеремиа бол өөрийн заадаг зүйлүүдэд яруу найраг, бэлгэдлийг ихээр ашигладаг, нэн яруугаар илэрхийлдэг зохиогч байв. Мормоны Номон дахь бошиглогч Мормоны нэгэн адил, огтхон ч наманчлахгүй, бараг л устгагдахын даваан дээр байсан хүмүүсийн устгалын талаар сэрэмжлүүлэг хийгээд амлалтуудыг хүргэх хүнд хэцүү үүрэг зорилго Иеремиад ноогдож байжээ. Номлолынхоо улмаас Иеремиа ихэд хавчигдаж байлаа.

Хэдийгээр Иеремиагийн захиас цаг үеэсээ шалтгаалан ихэд бараан баргар мэт боловч, тэрээр бас гэрээт хүмүүсээ хайрлах Бурханы хайрын тухай өгүүлдэг. Иеремиагийн бошиглож байсан шүүлтүүд гүйцэлдсэний дараа, тэрээр гэрээний хүүхдүүдэд дахин нигүүлсэнгүй байж, тэднийг өөртөө

цуглуулах болно гэдгийг Их Эзэн амласан нь өнөө үед түүний баримталж буй загвар юм.

Иеремиа болон Иеремиагийн номны тухай дэлгэрэнгүй мэдээллийг Судруудын Удирдамж, “Иеремиа”-гаас үз.

Иеремиа 1

Иеремиагийн дуудлага

Өнгөрсөн 150 жилд Сүмийн зарим номлолд харьцангуй цөөхөн хөрвөгчид баптисм хүртсэн байлаа. Хэрэв та өөрийг тань нэн цөөн хэдхэн хүмүүс сонсож, таныг ихээр хавчиж, олон хүнд сорилтууд өөрт чинь тулгаран, бас амжилт олох найдвар өчүүхэн байгаа газарт номлолд явахаар дуудагдвал та хэрхэн хариу үйлдэл үзүүлэх вэ? Энэ номлолыг биелүүлэхэд юу танд сүнслэгээр нөлөөлөх вэ? Их Эзэн Иеремиад түүний номлолын талаар юу хэлснийг Иеремиа 1 цэдэглэдэг. Та нар уншихдаа, хэрэв та нар Иеремиагийн оронд байсан бол ямар санагдах байсныг авч үз. Түүнчлэн Их Эзэн та нараар юу хийлгэхээр дуудсаныг, мөн амжилт олохын тулд ямар бэлтгэл хэрэгтэйг бодох цаг гарга.

Судруудыг ойлгох нь

Иеремиа 1

Чамайг ариусгаж (ш. 5)—
Чамайг онцгойлон адисалж

Бүсээ бүсэлж (ш. 17)—
Бэлтгэж, бэлэн болж

Иеремиа 1:5—“Эхийн хэвлийд чамайг бүрэлдүүлэхээсээ өмнө би чамайг ариусгасан”

“Дэлхийн оршин суугчдад тохинуулах дуудлага авсан хүн бүр энэ дэлхий байхаас өмнө Тэнгэрийн Их Зөвлөгөөн дээр энэхүү зорилгод томилогдсон юм” хэмээн Бошиглогч Иосеф Смит заажээ (*Teachings of the Prophet Joseph Smith*, эмхтгэсэн, Жозеф Фиелдинг Смит [1976], 365).

Судруудыг судлах нь

А Төгс Эзэмших Судар—Иеремиа 1:4–5

Иеремиа бошиглогч байхаар урьдчилан томилогдсон ажээ. Урьдчилсан томилолт бол мөнх бус байдлын өмнөх амьдрал хийгээд энэ амьдралд хэрхэн холбогддог тухай ойлгоход бидэнд тусалдаг чухал зарчим юм. Иеремиа 1:4–5; Алма 13:3; Абрахам 3:22–23-ыг уншиж, урьдчилсан томилолтын талаар юу ойлгосноо бич.

Б Биднийг дэлхийд ирэхээс өмнө

1. Иеремиагийн дуудлага хүнд хэцүү байсан ч гэсэн, тэрээр дуудлагынхаа талаар юу мэдсэн бэ? (Иеремиа 1:5-ыг үз).

2. Тэрээр төрөхөөсөө өмнө сонгогдсоноо мэдэх нь Иеремиад ямар нөлөө үзүүлж болох байсан бэ? Та нар дээрх “Судруудыг ойлгох нь” хэсэг дэх Бошиглогч Иосеф Смитийн мэдэгдлийг судруудынхаа зах дээр бичиж болно.

3. Патриархын адислал, бошиглогчдын сургадаг зүйлүүд юу хийхийн тулд та нар урьдчилан томилогдсоныг мэдэхэд та нарт хэрхэн тусалж болох вэ?

В Их Эзэний амлалтууд

1. Их Эзэнээс ирсэн дуудлагадаа хариулсан Иеремиагийн хариулт юу байсан бэ? (Иеремиа 1:6-г үз).
2. Сайн мэдээг номлох тухайд сэтгэлийг нь зовоож байсан зүйлүүдийг даван туулахад түүнд тусалсан гэж та нар боддог юуг Их Эзэн Иеремиад хэлснийг Иеремиа 1:7–11, 17–19-өөс олж, дүрсэл. Ингэж сэтгэл зовох нь өнөө үеийн номлогчид хэрхэн тусалж чадах вэ?

Иеремиа 2–3

Иудагийн нүгэл ба Иеремиагийн захиас

Иеремиа 2–3 нь хүмүүст номлохоор дуудагдсаны дараа тэдэнд юу ярих талаар Их Эзэн Иеремиад хэлсэн зүйлийг цэдэглэдэг. Их Эзэн Иеремиад хэлсэн зүйлийн их хэсэг нь Израилын хүүхдүүд Их Эзэний өмнө үйлдсэн нүглээ хэрхэн шийдвэрлэх замуудыг авч үзсэн байдаг. Иеремиа 2:13 тэдний асуудлуудыг: тэд амийн усыг (амьд Бурханыг) зөвхөн эсэргүүцсэн төдийгүй, сүнсний амьдралынх нь бэлгэдэл—усны нөөцлүүрүүд нь (усны савнууд) цоорч, ус тогтоож чадахгүй болсныг хамгийн сайнаар дүрсэлсэн байдаг. Өөрөөр хэлбэл, тэдний амьдрал нүглүүдээр дүүрсэн учраас тэд Их Эзэний адислалуудыг хүлээн авч чадахгүй болсон байлаа.

Их Эзэн гэрлэлтийг гэрээт хүмүүстэйгээ харилцаа харилцааны бэлгэдэл болгон хэрэглэсний өөр нэг жишээг Иеремиа 3 агуулдаг. Израил, Иуда хоёул бэлгэдлийн хувьд Их Эзэнтэй гэрлэсэн эгч дүү хоёр байлаа гэж Тэрээр хэлжээ. Израил нөхөртөө (Их Эзэнд) итгэлгүй байснаас, нөхөр нь түүнээс салсан (эсвэл эсэргүүцсэн) (ш. 8-ыг үз) ажээ. Иеремиа 3 дахь сэрэмжлүүлэг бол Израилын алдаанаас сургамж аваагүй Израилын “эгч” Иудаа холбогдоно.

Хэрэв тэд наманчилж, өөрсдийгөө түүний өмнө даруусгах юм бол, Израил, Иуда хоёрыг Их Эзэн эргүүлэн авах болно гэсэн амлалтуудыг Иеремиа 3 бас агуулдаг. Энэхүү эргэн очилтыг бид Израилын цугларалт хэмээн нэрлэдэг (ш. 14–25-ыг үз). Хэрэв тэд өөрсдийгөө даруусгаж, “гэрлэлтийн” гэрээнүүддээ үнэнч байх юм бол—Израилыг эргэж ирэхэд Их Эзэн тэднийг “эдгээхээр” амласан ажээ.

Иеремия 4–6

“Бид наманчлах хэрэггүй”

Иудагийн хүмүүст номлоход Иеремиад тулгарч байсан сорилтуудын нэг бол тэд аль хэдийнээс зөв шударга байгаа болохоор наманчлах хэрэггүй гэж боддог явдал байлаа. Тэд хиймэл шүтээний төрөл бүрийн хэлбэрт оролцдог байсны зэрэгцээгээр, бас тахилууд өргөж, өөрсдийн үнэн шашны бусад “гадаад” хэсгүүдийг хэрэгжүүлдэг байв. Тэд шашныхаа зарим хэсгүүдийг баримталдаг байсан учраас өөрсдийгөө зөв шударга гэж үзэн, зөв шударга хүмүүст ямарваа зүйл тохиохыг Их Эзэн зөвшөөрөхгүй хэмээн мэдэгддэг байсан аж.

Тэд түүний таалалд нийцэхгүй байсныг Иеремиагаар дамжуулан Их Эзэн Иудад хэлж, тэд зөв шударга мэтээр дүр эсгэдэг учраас тэдэн дээр устгалыг зарлан мэдэгдсэн ажээ. Тэр үе дэх иудейчүүдийн хоёр нүүрт шашны зан үйлүүдийн тухай Иеремиагийн хэлсэн зүйлийн жишээнүүдийг та нар Иеремия 4:2, 14; 5:3, 12; 6:14–15, 20-иос олох болно. Бүлэг 4–6-гийн үлдсэн хэсгийн ихэнх нь түүний нүглүүдийн улмаас Иуда дээр ирэх Бурханы шүүлтүүдийн тухай өгүүлдэг.

Иеремия 7

Иеремиагийн ариун сүмийн номлол

Хэрэв та нар гэр бүлтэйгээ үүрд мөнх хамт байж, мөнх амьдралыг эдлэхийг хүсдэг бол, та нар ариун сүмд гэрлэх ёстой. Гэвч ганцхан ариун сүмд гэрлэх нь Тэнгэрлэг Эцэг болон гэр бүлийнхэнтэйгээ хамт селестейл хаант улсад орох байрыг бидэнд баталгаатай болгодоггүй. Бид зарлигуудыг, мөн тэрхүү чухал ёслолын амин чухал хэсэг болсон гэрээнүүдийг сахьж, эцсийг хүртэл итгэлтэй хэвээр тэвчих ёстой.

Ариун сүмийн ёслолууд, шашны бусад ёслолуудад оролцдог л бол, тэд амьдралдаа өөр юу хийдэг нь хамаагүй, тэд зөв шударга байгаа хэрэг гэж Иеремиагийн үе дэх иудейчүүд итгэдэг байжээ. Та нар уншихдаа, Иеремиагийн хэлсэн юу жинхэнэ зөв шударга ёсыг тодорхойлдогийг эрж ол.

Иеремия 7:3–4—“Их Эзэний ариун сүм”

Ариун сүм чухал бус гэж Иеремиа хүмүүст хэлээгүй юм; ариун сүмд шүтэн биширч байгаа болохоор, тэд юу хийдэг нь хамаагүй, Бурханы өмнө зөвтгөгдөх болно гэж тэд боддог байжээ. “Бид баптисм хүртсэний дараа, бид ариун сүмд гэрлэсний дараа, бид эдгээр бүх гэрээнүүдийг хүлээн авсны дараа, бид эдгээрийг сахих ёстой. Бидний хүлээн авдаг гэрээ бүр бидний үргэлжийн итгэлтэй байдлаар нөхцөлддөг” гэж Ахлагч Брус Р.МкКонки сургажээ (in Conference Report, 1950 оны 10-р сар, 16–17).

Иеремия 7:12–14—Шило хаана байдаг вэ?

Шило бол Шүүгчдийн үед асрын болон гэрээний авдрын газар байжээ. Санваартан Елигийн үед санваартнууд болон хүмүүс ёс бус болоход, асрыг устгаж, авдрыг олзлон авахыг Их Эзэн филистчүүдэд зөвшөөрсөн аж. Хожим нь, Умард Хаант Улсын израилчууд хиймэл шүтээнд зориулан Шилод ариун сүм барьсныг нь ассиричууд устгажээ. Хэрэв хүмүүс наманчлахгүй бол, тэрээр Иерусалим дахь ариун сүм устгагдахыг зөвшөөрөх болно гэдгийг Бошиглогч Иеремиагаар дамжуулан Их Эзэн хэлжээ. Өөрсдийнхөө Библийн газрын зургийн хэсгийг үзэж, Шилог ол.

Судруудыг судлах нь

А Ариун сүмд зохистойгоор орох нь

1. Хүмүүс ариун сүмд зохистойгоор орохын тулд хийх ёстой гэж Иеремия 7:1–22-т Иеремиагийн хэлсэн зүйлүүдийг жагсаа.
2. Өнөөдөр ариун сүмд зохистойгоор ороход тавигддаг шаардлагууд юу вэ? (Хэрэв та нар өөрсдөө мэдэхгүй бол удирдагчдынхаа нэгнээс асуу.)
3. Иеремия 7:8–15-д өгүүлснээр, хэрэв хүмүүс зохистой бишээр ариун сүмд орохоо үргэлжлүүлсээр байх юм бол, юу тохиолдох болно гэж Их Эзэн хэлсэн бэ? “Бид [Их Эзэний] ариун өргөө уруу зохисгүйгээр явах юм бол Бурханы шүүлтүүдийг өөрсөд дээрээ авчрахгүй байж чадахгүй. . . .

“ . . . Хэрэв эр хүн хувийнхаа амьдралд шударга бус байх юм бол, энэ нь түүний эхнэр, хүүхдүүдэд, бас ажил хэрэгт нь, ариун сүмд явахад нь нөлөөлж, өөрийнхөө бодгаль дээр ялыг овоолох бөгөөд, наманчлах нь түүнд асар их хэрэгтэй болно” гэж Ахлагч Ж.Баллард Воошбөрн хэлжээ (in Conference Report, 1995 оны 4-р сар, 12–13; *Ensign*, 1995 оны 5-р сар, 11–12).

Б Их Эзэн чухам юуг хүсдэг вэ

1. Иудагийн хүмүүс ариун сүмд тахил өргөдөг байсан ч гэсэн, өдөр тутмынхаа амьдралд Их Эзэнийг дуулгавартай дагадаггүй байв. Ахлагч “Бид гэрээнүүд хийхээр ариун сүм уруу явдаг, харин хийсэн гэрээнүүдээ сахиаар гэр уруугаа явдгийг” Ахлагч Ж.Баллард Воошбөрн бидэнд сануулсан байдаг (in Conference Report, 1995 оны 4-р сар, 13; *Ensign*, 1995 оны 5-р сар, 12). Иеремия 7:21–28-д өгүүлснээр, Иудагийн нүгэл юу байсан бэ?
2. Ариун сүмд шүтэн бишрэхээс өөр юу хийхийг Их Эзэн иудейчүүдээс хүссэн бэ?
3. Энэ зарчмыг ариун ёслолд холбогдуул. Бид ариун ёслолд оролцохоос гадна Их Эзэн чухам юуг биднээс хүсдэг гэж та нар боддог вэ? (С ба Г 33:12–14).

Судруудыг ойлгох нь

Иеремия 7

Чихээ тавих (ш. 24, 26)—
Ихэд анхаарах

Иеремия 8

Иудагийн эсрэг бүр олон шүүлт

Иудагийн хүмүүс дээр, ялангуяа тэдний ёс бус удирдагчид дээр ирэх бүр олон шүүлтийн тухай Иеремия 8 өгүүлдэг. Бусад бүлгүүдийн нэгэн адил, Бүлэг 8 нь тэд нүгэлгүй, мөн дайснуудаасаа хамгаалагдах болно гэдэгт итгэдэг байсан Иуда хийгээд түүний доторх хамгийн том асуудлуудын нэгийг нь заадаг.

Иеремия 9–10

Иеремия уйлж, Иудагийн төлөө залбирав

Түүний дамжуулдаг уй гишүүтэй захиасны улмаас, бас тэрээр өөрийнхөө бошиглодог байсан Иудагийн хүмүүсийн устгалын тухай бошиглол гүйцэлдсэнийг харсны улмаас Иеремиаг “уйланхай” бошилогч хэмээн зарим хүмүүс нэрлэдэг байв. Бурханы бүх хүмүүсийн нэгэн адил, Иеремиа хүмүүсийг хайрлаж, тэднийг устгалаас сэрэмжлүүлэхийг хичээдэг байсан боловч, хэрэв тэд наманчлахгүй бол юу тохиох тухай үнэнийг тэдэнд хэлэхээс зайлсхийж чаддаггүй байв. Иеремиа 9 бол шудейчүүд хиймэл шүтээнүүдэд итгэж, шүтэн бишрэх нь үргэлжилсээр байсан учир Иудагийн айсуй устгалыг хараад Иеремиа “уйлан хайлсны” нэг жишээ юм. Иеремиа 10 уйтгар гунгийн нэгэн залбирлаар төгсдөг.

Судруудыг судлах нь

A Их Эзэнийг юу баярлуулдаг вэ?

1. Иеремиа 9:23–24-т өгүүлснээр, олон хүмүүс юугаар “алдаршдаг” вэ?
2. Их Эзэн юугаар алдаршиж, юунд баярладаг гэж хэлсэн бэ? Бид үүнийг хэрхэн өөрсдийн алдар суу, баяр болгож болох вэ?

Иеремия 11–15

Бурханы шүүлтүүд

Хэдийгээр Иеремиа Иуда дээрх Бурханы шүүлтийн тухай өөрийн захиасыг давтсан мэт боловч, бүлэг буюу номлол бүр нь эдгээр шүүлтүүдийн тухай арай ялгаатай үзэл бодол буюу сургамжийг агуулдаг.

Иеремиа 11 бол Их Эзэнтэй гэрээ хийхийн ач холбогдлын тухай юм. Мосе тэднийг Египетээс удирдан гаргасан үеэс эхлэн Их Эзэн тэдэнтэй тусгай гэрээнүүд хийснийг тэрээр тэдэнд сануулжээ. Тэд эдгээр гэрээнүүдийг зөрчсөөр байсан учир шийтгэгдэх болно. Захиасынх нь улмаас түүнийг алахыг хүсэж байсан Иеремиагийн төрсөн хотын хүмүүст хандсан нэг ишлэлээр Иеремиа 11 төгсдөг. Эдгээр хүмүүс дээр онцгой шүүлт ирэх болно гэдгийг Их Эзэн хэлжээ.

Ёс бусчууд яагаад зарим үед дэвжин дээшилж байгаа мэт санагдаагийг Их Эзэн Иеремиад хэрхэн тайлбарласныг Иеремиа 12 өгүүлдэг. Эцсийн эцэст ёс бусчууд дээр шударга ёс ирэх болно гэдэгт Их Эзэн түүнийг баттай итгүүлжээ. Түүнээс гадна, эцсийн эцэст зөв шударга хүмүүс ажил үйлсийнхээ төлөө шагнагдах болно гэдгийг тэрээр хэлсэн ажээ.

Нүглүүд нь тэднийг “хүлж” (2 Нифай 26:22), улмаар тэднийг өөрчлөгдөх чадваргүй болготол хүмүүс тийм ихээр ёс бус болж болдгийг Ноагийн үе дэх Үерийн тухай түүх бидэнд зааж чадна. Ийнхүү өөрчлөгдөх чадваргүй болсных нь улмаас Их Эзэн хүмүүсийг устгасан ажээ. “Бүрмөсөн дэндүү оройтох” (Хиламан 13:38) хуртлээ наманчлахаас татгалзсан хүмүүсийн тухай Мормоны Ном өгүүлдэг. Хүмүүс “хилэнцэтийг үйлдэж дадсан” учраас, ирвэс толбоо өөрчилж чаддаггүй лугаа адил, хүмүүс өөрсдийн ёс бус замуудыг өөрчилж чаддаггүй гэсэн үндсэн захиасыг Иеремиа 13 агуулдаг (Иеремиа 13:23-ыг үз).

Тэрээр өөрийн хүмүүсийн төлөө Их Эзэнд хандан тэдний төлөө гуйсан Иеремиагийн гүн гүнзгий бодлуудыг Иеремиа 14 цэдэглэдэг. Шүлэг 1–6 тэд яагаад уг нутагт “ган гагч” (өлсгөлөн) болсныг Иеремиа Их Эзэнээс мэдсэн тухай өгүүлдэг. Шүлэг 7–9 өлсгөлөнг зайлуулах тухай Их Эзэнд хандсан Иеремиагийн гуйлтыг, шүлэг 10–12 нь Их Эзэний өгсөн хариуг цэдэглэдэг. Иеремиа шүлэг 13-т, Их Эзэн шүлэг 14–18-д дахин ярьжээ. Бүлэг 14-ийн сүүлчийн дөрвөн шүлэг, залбирал лугаа адил сонсогддог Иеремиагийн үгсийг цэдэглэжээ.

Иеремиа 15:1–14 нь Иуда дээр тохиох устгалын тухай Их Эзэний тунхаглалыг агуулдаг. Их Эзэний дүрсэлсэн шүүлтүүдэд өөрийгөө багтсанд Иеремиа сэтгэл нь түгшиж байв. Шүлэг 15–18-д, тэрээр хичнээн их итгэлтэй байснаа Их Эзэнд ярьсан байдаг. Шүлэг 19–21-д түүний амьд явахыг хүлээн зөвшөөрсөн боловч тэрээр өөрийн хүмүүсийг хамгаалах гэж хичээсний хэрэггүйг Их Эзэн Иеремиад хэлжээ.

Иеремиа 16

Хожмын өдрүүд дэх найдвар



Иеремиагийн үеэс дөрвөн зуун жилийн тэртээ, Их Эзэн бошиглогчоороо дамжуулан Израилын хүүхдүүдийг өөртөө итгэж, өөрийг нь дуулгавартай дагахыг хүсэж, тэднийг амар амгалан, цэцэглэл хөгжилтөөр адислах болно хэмээн амласан ажээ.

Гэвч тэд хиймэл шүтээн, бусад хуурамч шашинуудыг шүтэх илүү амар хялбар, илүү дэлхийн шинжтэй замуудыг сонгожээ. Елиа Баалын санваартнуудтай Кармел Уулан дээр уулзсан (Хаадын Дээд 18-ыг үз) зэрэг өөрийн хүчний нотолгоог Их Эзэн израилчуудад үзүүлсээр байв. Гэвч хүмүүс нийтээрээ Их Эзэнийг дагасангүй хэвээр байлаа; түүний зам хэтэрхий хэцүү юм шиг санагдаж байжээ. Түүний зам бол амар амгалан, авралын цорын ганц зам гэдгийг тэд ухаарч ойлгоогүй юм. Харамсалтай нь, тэр бол цорын ганц үнэн бөгөөд амьд, Бүхнийг Чадагч Бурхан бөгөөд тэднийг хуурамч бурхад нь чөлөөлөхийн тулд хуурамч бурхаддаа итгэх газарт нь хаяж чадахаа Их Эзэн хүмүүст харуулж чадна, эдгээр бурхад амьгүй эсвэл хүчгүй учраас хэнийг ч аварч чадахгүйг мэднэ. Их Эзэн Иеремиа 16-д энэ аргыг ашиглахаар амласан билээ.

Гэвч Иеремиа 16 дахь захиас бүхэлдээ сөрөг биш юм. Их Эзэн Израилыг хожмын өдрүүдэд дахин эргүүлэн авч, тэр бол тэдний Бурхан гэдгийг мэдэхэд нь тэдэнд туслахыг амласан ажээ. Израилын цугларалт бол өнөөдөр бидний оролцох ёстой зүйл мөн.

Судруудыг судлах нь

А Юу? Яагаад?

Иудейчүүд Вавилонд аваачигдсаны улмаас суларсан газар дээр нэг харийн хүн Израилд иржээ. Тэр танаас юу болсныг бас яагаад ийм болсныг асуувал та юу гэж хариулах вэ? Туслацгаа авахын тулд Иеремиа 16:10–13-ыг үз.

Б Төгс Эзэмших Судар—Иеремиа 16:16

1. Иеремиа 16:14–16-г уншиж, Их Эзэн хожмын өдрүүдэд Израилын төлөө юу хийхээр амласныг ярь.
2. Эдгээр шүлгүүдэд өгүүлснээр, Их Эзэний үйл ажиллагаа тэдний хувьд хэр зэрэг сэтгэл догдлом байх вэ?
3. Шүлэг 16 дахь “загасчид,” “анчдыг” хэн гэж та нар боддог вэ?
4. Их Эзэн өөрийн хийх зүйлийг дүрслэхийн тулд “загасчид,” “анчид” гэдэг нэр томъёонуудыг яагаад хэрэглэсэн гэж та нар боддог вэ?

Иеремиа 17

Иудагийн нүгэл

Бурханы мэлмийгээс Иудаг юу салгасан тухай Их Эзэн, Иеремиа хоёрын өгүүлсэн зүйлийг Иеремиа 17 цэдэглэдэг. Хүмүүс нүгэлдээ байнга хүлэдэж (ш. 1–4-ийг үз), Их Эзэнд итгэхээ больж (ш. 5–8-ыг үз), Хүндэтгэлийн өдрийг ариунаар нь сахдаггүй байсан аж (ш. 19–27). Иеремиа хүмүүсийн төлөө залбирчээ (ш. 12–18-ыг үз).

Судруудыг судлах нь

А Зураг зур

Их Эзэнд итгэдэг, бас итгэдэггүй хүмүүсийн тухай Иеремиа 17:5–8-д өгүүлсэн зүйлсийг харуулсан нэг буюу хоёр зураг зур.

Б Нэг өгүүлбэр бич

Хүндэтгэлийн өдрийг ариунаар сахих тухай Иеремиа 17:19–27-д Их Эзэний заасан зүйлийг хураангуйлан товчилсон нэг өгүүлбэр бичихийн тулд дараах үгсийг ашигла: ачаа, ажил, хичээнгүй, ариусгах.

Иеремиа 18–19

Ваар сав ба Иуда


Иеремиа өөрийн захиасыг заахын тулд эд юмсыг олон-таа ашигладаг байв. Тэрээр энэ хоёр бүлэг тус бүрд нэг зүйлийг ашиглажээ. Бүлэг 18-д, ваарчны гэрт очихыг Иеремиад хэлсэн аж. Ваарчин нэг юм хийх гэтэл түүний хүссэнээр болохгүй бол, тэр шаврыг дугуй дээрх бөөн шаварт буцааж хийгээд, дахин хийж эхэлдэг. Бүх хүмүүс ваарчны ажилладаг шавар лугаа адил бөгөөд тэрээр Иудагийн хүмүүс дээр дахин дахин ажилласаар байгааг Их Эзэн хэлжээ.

Иеремиа 19 дууссан шавар савны тухай өгүүлдэг. Иеремиа Иудагийн нүглийг, түүнчлэн эдгээр нүглийн улмаас юу тохиохыг тайлбарласны дараа тэрээр ваар савыг хагалсан аж. Их Эзэн тэднийг “хагалж,” тэгээд хагарсан ваар савыг дахин нийлүүлж, анх ямар байсан тэр байдлаар нь эвлүүлэх боломжгүйтэй адил, Иудагийн хүмүүсийн яг энэ үеийнхний хувьд эх нутагт нь, Их Эзэнтэй харилцах харилцаанд нь сэргээх боломжгүй юм гэдгийг тэрээр хүмүүст заажээ.

Иеремиа 20

Иеремиагийн гай зовлон

Иеремиагийн номын ихэнх нь түүний бошиглолуудыг агуулдаг. Гэвч Иеремиа 20 түүний амьдралын тухай багахан өгүүлдэг. Бошиглолуудынхаа улмаас, Иеремиаг гэмт хэрэгт яллагдсан хүнийг дөнгөлдгийн адилаар хүзүү, гар, хөлөнд нь таарсан нүхтэй модон дөнгөөр дөнгөлснийг бид мэддэг.



Иеремиа өөрийг нь дөнгөлсөн хүний талаар бошиглосон боловч бас өөрийн нөхцөл байдлын талаар урам нь хугарч цөхөрсөн мэт сонсогдсон зүйлүүдийн тухай хэлжээ. Тэрээр Их Эзэн өөрөөс нь хийхийг хүссэн зүйлийг хийж, хэлэхийг хүссэн зүйлийг нь хэлсэн хэдий ч, дуулгавартай

байсныхаа төлөө зовсон ажээ. Зарим үед Их Эзэнийг бүх зүрх сэтгэлээрээ дагасан хүмүүс ийм хүнд сорилттой тулгардаг. Их Эзэний үг түүний хувьд “ясаар минь хаагдан хүрээлэгдсэн шатаж буй гал” (Иеремиа 20:9) байлаа хэмээн тэрээр хэлж, номлолоо орхиогүйг бид уншихдаа Иеремиагийн аугаа зан төлвийн тухай мэддэг билээ. Иеремиа үр дагавруудыг үл харгалзан Их Эзэнд итгэхээ үргэлжлүүлж, үгийг номлоход шийдвэр төгс байсан юм. Түүний эрэлхэг зориг бол бид бүхний хувьд үлгэр загвар мөн.

Судруудыг судлах нь

А Та нар юу хэлэх вэ?

Хүнд сорилтгуудынхаа улмаас Иеремиа санаа сэтгэл сайнгүй байсан аж. Тэрээр зөв гэдгийг нь мэдэж байсан зүйлийг хийсний төлөө зовж байлаа. Ийм үед нь түүнийг тайвшруулж, урамшуулан дэмжихийн тулд та нар түүнд юу хэлэх вэ?

Иеремиа 21–22

Хоёр хааны тухай бошиглолууд

Иудагийн хаадын талаар Иеремиагийн хийсэн бошиглолуудыг Иеремиа 21–22 үздэг. Эдгээр нь түүхийн дэс дарааллаар бичигдээгүй байна. Бүлэг 21 нь Вавилон Иерусалимыг болон ариун сүмийг устгаж, хүмүүсийг нь боолчлолд аваачихаас өмнөх Иудагийн сүүлчийн хаан Зедекиад зориулагдсан байна. Бүлэг 22 нь Иеремиа тохиуулаа эхэлсэн үед хаан байсан Иосиа Хааны хөвгүүд Шаллум, Иехоиаким нарт зориулагджээ. Бидний мэдэхээр Шаллум ерөөсөө хаан болоогүй, гэвч түүнийг вавилончууд боолчлолд аваачиж чадаагүй ажээ.

Бүлэг 21 дэх Зедекиад зориулсан захиас нь Вавилоноор тохиогдох устгал зайлшгүй тухай юм. Уг бошиглолд “хэррэг” гэдэг үг байсангүй. Иудейчүүдэд Иеремиагийн өгсөн цорын ганц сонголт бол Иерусалимд үлдэж, вавилончуудын гарт үхэхгүйн тулд, хотыг орхиж, боолчлолд аваачигдах явдал байв.

Иеремиа 22 хэдэн жилийн өмнө үздэг. Үздэгдсэн бөгөөд хэрэгтэд наманчлах юм бол зарим иудейчүүдийн хувьд чөлөөлөлт боломжтой хэвээр байсан тухай захиасыг агуулдаг. Энэ хоёр бүлгийн дэс дараалал нь Их Эзэний хатуу шийтгэлүүд гагцхүү олон жилийн дараа, наманчлах олон боломжуудын дараа ирснийг бидэнд заадаг. Өмнө нь Их Эзэн чөлөөлөлтийн боломжуудыг олгож байсан хэдий ч, хүмүүс наманчлахаас татгалзсан үед шүүлтүүд тодорхой болсон ажээ.

Иеремиа 23

Хуурамч бошиглогчид

Бид бошиглогчдын талаар бодохдоо, ихэвчлэн Сүмийн Ерөнхийлөгч эсвэл Их Эзэний үгийг зааж байсан судрууд дахь агуу хүмүүсийн тухай боддог. Бүх бошиглогчид бол багш нар юм. Гэвч бас үнэнийг заадаггүй, хуурамч бошиглогчид болон багш нар байдаг. Их Эзэн хүмүүсийн дундах хуурамч бошиглогчдын тухай юу хэлснийг Иеремиа 23 өгүүлдэг. Тэрээр тэдний хуурамч сургамжуудыг илчилж, хуурамч бошиглогчид хүмүүсийг хэрхэн нүгэлд хийгээд хуурамч санаануудад итгэхэд удирддаг тухай өгүүлдэг байв. Бид бас энэ бүлгээс үнэн болон хуурамч бошиглогчдын хоорондох зарим ялгаануудын тухай мэддэг.

“Бидний үргэлж мэдэхийг хүсдэг зүйлийг биш, харин бид юуг мэдэх хэрэгтэйг бошиглогч бидэнд хэлж өгдөг” гэж Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон хэлжээ (“Fourteen Fundamentals in Following the Prophet,” in Brigham Young University 1980–81 Devotional and Fireside Speeches [1981], 28). Энэ мэдэгдэл энэ бүлэг дэх Иеремиагийн заасан зүйлүүдтэй хэрхэн холбогдохыг эрж ол.

Иеремиа Аврагчийн тухай бошиглосон учраас Иеремиа 23:5–8 их ач холбогдолтой юм.

Судруудыг ойлгох нь

Иеремиа 23

Хоньчид (ш. 1–2)—Энэ тохиолдолд “удирдагчид”

Агь (ш. 15)—Гашуун ургамал

Гуйвуулсан (ш. 36)—Өөрчилсөн, урвуулсан

Судруудыг судлах нь

А Хуурамч бошиглогч гэж та нар хэрхэн хэлж чадах вэ?

1. Иеремиа 23:1–2, 9–11, 13–14, 16–27, 29–32-ыг уншиж, хуурамч бошиглогчид хэлдэг, хийдэг гэж Их Эзэний хэлсэн зүйлүүдийг жагсаа.

2. Жагсаалтаасаа нэг зүйлийг сонгож, тэр үйлдэл буюу заадаг зүйл яагаад хүнийг хуурамч бошиглогч бол- годгийг тайлбарла.
3. Хүмүүс яагаад хуурамч бошиглогчдыг дагадаг гэж та нар боддог вэ?
4. Үнэн бошиглогчийг таньж, дагах нь яагаад нэн чухал вэ? Та нар хуурамч бошиглогчийг хэрхэн ялган таньж болох вэ? (Дэд Хууль 18:20–22; С ба Г 42:11–12; 46:7-г үз).

Б Хуурамч бошиглогчдыг эдгээх нь

Иуда дахь удирдагчдаараа замаасаа гажсан хүмүүсийн тө- лөө тэрээр юу хийх болно гэж Иеремиа 23:3–8-д Их Эзэн хэлсэн бэ? (Энэ бошиглол ихэвчлэн хожмын өдрүүдэд гүй- цэлдэхийг анхаар.)

Иеремиа 24

Сайн ба муу жимс

Сагс дүүрэн инжрийн сайн жимс, бас сагс дүүрэн инжрийн илжирсэн жимсний дүрслэлээр, зарим иудейчүүд өөрс- дийнхөө сайн сайхны төлөө Вавилонд боолчлолд аваачиг- даж, ирээдүйн нэгэн цагт эх орондоо эргэж ирэх боломж тэдэнд олодох болно. Бусад нь ёс бусынхаа улмаас ичгүүрт тавигдаж, устгагдах болно гэдгийг Их Эзэн Иеремиагаар дамжуулан хэрхэн заасныг Иеремиа 24 өгүүлдэг.

Иеремиа 25–26

Бошиглогчдыг эсэргүүцэх нь боолчлолд хөтөлдөг

Иеремиа 25–26 нь дараалал, сэдвийн хувьд Иеремиа 21–22- той адил юм. Бүлэг 25-д, Иеремиа болон бусад бошиглогч- дын (Лихай гэхчлэн) үгсийг эсэргүүцсэн учир Иудаг Вавилон эзлэх болно гэдгийг Иеремиа тов тодорхой бошигложээ. Түүнээс гадна, Иуда Вавилонд далан жил үйлчлэх болно, энэ үед Вавилон нөгөө хаант улсыг эзлэх болно гэдгийг Иеремиа бошиглосон ажээ. Бүлгийн үлдсэн хэсэг нь ёс бус бусад үндэстнүүдийн устгалын тухай юм. Бурхан шуударга бус хүмүүсийг тэд ямар үндэстэн бэ гэдгийг нь харгалзахгүйгээр шийтгэдгийг энэ бүлэг заадаг.

Иеремиа 26 бүлэг 25-ын өмнөх зарим үйл явдлуудыг цэдэглэж, уг бүлэг дэх зарим түүхийг тайлбарлахад тус- салдаг. Хүмүүс наманчлах ёстой, эс бөгөөс боолчлолд аваачигдахыг Иеремиа хэрхэн бошиглосон тухай Иеремиа 26 өгүүлдэг. Наманчлахаар дамжин чөлөөлөлтийн зарим найдвар байсаар байсан тухай бошиглосных нь төлөө Иуда дахь удирдагчид Иеремиаг алахыг хүсэж байв. Мөн үүнтэй

адил бошиглол хийсний улмаас Уриа хэмээх бошиглогч алагдсан тухай бид бас унидаг. Бүлэг 25-д шүүлт яагаад тийм тодорхой байсныг тайлбарлахад энэ баримт тусалдаг.

Иеремиа 27–28

Вавилоны буулга

Иеремиа 27–28 бол нэг түүх юм. Их Эзэнээр чиглүүлэгд- сэнний дагуу, Иеремиа нэг буулга хийж, үүнийг хүзүүндээ углажээ. Буулга бол ачаа чирэх зорилгоор малын хүзүүнд угладаг зүйл. Буулга нь боолчлол, олзлогдолтыг бэлгэддэг байлаа. Иуда болон түүний эргэн тойрон дахь үндэст- нүүд Вавилоны “буулган” дор орох болно гэдгийг Иеремиа хүмүүст заадаг байв. Хуурамч бошиглогчид өөрөөр зааж болно, гэвч боолчлол гарцаагүй тохиох болно гэдгийг тэ- рээр сэрэмжлүүлж байжээ. Хэрэв Хаан Зедекиа болон түүний хүмүүс Вавилоны “буулганд” даруухнаар захираг- дах юм бол, тэд устгагдахгүй гэдгийг Иеремиа Зедекиа Хаанд хэлсэн аж. Түүний үгс биелэгдэхийн тэмдэг болгон, Вавилоны хаан Небухаднезар үлдсэн эрдэнэсийн зүйлүүд болон ариун эд юмсыг ариун сүмээс авч явахыг тэрээр бо- шиглосон байв. Энэ бошиглол гүйцэлдсэн билээ.

Өөрийгөө бошиглогч хэмээн мэдэгдсэн Хананиа хэмээх өөр нэг хүний тухай Иеремиа 28 өгүүлдэг. Бурхан Вавилоны буулгыг хоёр жилийн дотор эвдэх болно хэмээн тэрээр бошиглосон аж. Түүний зөв үү, буруу юу гэдгийг цаг хугацаа нотлон харуулах болно гэдгийг Иеремиа хэлжээ. Гэвч түүний бошиглолууд буруу, мөн тэр удахгүй үхэх болно гэдгийг Хананиад хэлэхэд Их Эзэн Иеремиад сүнсээр нө- лөөлсөн аж. Яг Иеремиагийн хэлснээр Хананиа үхжээ.

Судруудыг судлах нь

А Та нар хэрхэн хэлж чадах вэ?

Иеремиа 27–28 үнэн ба хуурамч бошиглогчийн жишээг өгдөг. Дэд Хууль 18:20–22; Сургаал ба Гэрээ 42:11–12; 46:7; Итгэлийн Тунхаг 1:5-ыг унш. Дараа нь хүн номлохоор үнэхээр Бурханаас илгээгдсэн эсэхийг бид хэрхэн мэдэж болохыг ярь.

Иеремиа 29

Боолчлогдогсдод Иеремиагийн бичсэн захидал

Боолчлолд аваачигдаж, Вавилонд амьдарч байсан хүмүүст Иеремиагийн бичсэн захидлыг Иеремиа 29 агуулдаг. Орон

байр барьж, ургамал ногоо тарин, тэнд аж төрөхөд бэлтгэж, чадах чинээгээрээ Вавилоныг таалахыг тэрээр тэдэнд захьсан ажээ. Тэд тэнд далан жил болно. Хэрэв тэд Их Эзэнийг бүх зүрх сэтгэлээрээ эрэлхийлэх юм бол (ш. 13; Дэд Хууль 4:26–31-ийг үз), Их Эзэн тэднийг Иерусалимд буцааж авчрах болно гэдгийг тэрээр дахин хэлжээ.

Иерусалимд өдийг хүртэл үлдэж, вавилончуудаас тэр даруйд чөлөөлөгдөх болно хэмээн амласан хуурамч бошиглогчдын заасан зүйлүүдэд итгэдэг байсан хүмүүсийг Иеремиа зүхсэн ажээ. Вавилонд байсан иудейчүүдэд хуурамч захиасууд илгээж байсан хуурамч бошиглогчийг тэрээр бас зүхжээ.

Судруудыг судлах нь

А Энэ нь хэрхэн тусалж чадах вэ?

Иеремиа 29:11–14-ийг уншиж, итгэлгүйнхээ улмаас Вавилонд боолчлолд байсан иудейчүүдэд хандсан энэ захиасыг, өнөөдөр нүглийн боолчлолд байгаа хүнд найдварын захиас болгон хэрхэн ашиглаж болох тухай бич.

Иеремиа 30

Их Эзэн туслахаар амласан нь

Вавилончууд Иудагийн хаант улсыг эзэлж, тэднийг боолчлолд авалцсан үед Иудагийн хүмүүс Бурхан тэднийг, бас Канааны нутгийг тэдэнд өгөхөөр, мөн тэдэнд түүний өгсөн үнэнүүд хийгээд адислалуудаар дамжин, дэлхийн үлдсэн хэсгийн хувьд адислал болох тухай Абрахамтай хийсэн гэрээгээ тэрээр орхисон юм болов уу хэмээн гайхширч байжээ. Давидын үр удмынхныг Израил дахь хаад болгохоор хийсэн гэрээгээ тэрээр эцэс болгосон юм болов уу хэмээн тэд бас гайхаж байжээ (2 Самуел 7:13-ыг үз). Тэрбээр тэднийг, эсвэл өөрийн гэрээнүүдийг орхиогүй хэмээн тараагдсан, мөн боолчлолд байсан Израилын хүүхдүүдэд Их Эзэний өгсөн баттай итгэлийг Иеремиа 30–33 агуулдаг.

Иеремиа 30–33 дахь бошиглолыг ярихаас илүүгээр бичихийг Иеремиад хэлсэн аж. Тэр үед Иеремиа шоронд байсан учир, бичигдсэн үг нь бошиглогчийн үгсийг хүмүүст хүргэх боломжтой болгодог байж. Бас, энэ илчлэлт өгөгдсөн үед хүмүүс Иеремиаг сонсдоггүй байсан болохоор, хэрэв энэ нь боолчлолд байсан хүмүүст бичигдвэл, илүү сайн заагдаж болох хийгээд үүнийг хожим нь унших боломжтой байлаа. Бас уг бошиглол Иуда, Израил хоёрт хоёуланд нь хандсаныг анхаар. Их Эзэн энэ бүлэг дэх захиасыг Иеремиад өгөхөөс 120 гаруй жилийн өмнө Израил ассиричуудаар эзлэгдсэн билээ.

Иеремиа 30-ийг та нар уншихдаа, Их Эзэн Иудагийн боолчлолын талаар, түүнчлэн хэрэв тэд түүнд итгэх юм бол, тэдний төлөө тэрээр юу хийнэ хэмээн хэлснийг эрж ол. Энэ захиас Бурханы хувьд алдагдсан гэж боддог, нүгэлд боолчлогдсон хүнд бас холбогдож болно. Их Эзэн түүнийг

мөн л орхисон хэмээн тэрээр боддог байж болно. Та нар уншихдаа, энэ бүлгээс хэн нэгний олж болох хувийн захиасыг бас эрж хай.

Иеремиа 30:12–13—Шархууд нь “эдгэшгүй” хүмүүст Их Эзэн хэрхэн тусалж чадах вэ?

Библийн Иосеф Смитийн Орчуулга гэмтэл хэдийгээр их муу ч гэсэн, эдгэшгүй биш гэж шүлэг 12 хэлдгийг ойгоход бидэнд тусалдаг. Иосеф Смитийн Орчуулгын шүлэг 13-т, Иудагийн шарх, хүмүүсийн боддог шиг, эдгэшгүй биш болохыг Их Эзэн дахин харуулсан байдаг.

Иеремиа 30:9—Аль Давид Хаан хүмүүст үйлчлэх вэ?

Энэ “Давид” бол түүнийг Давидын үр удам байх болно хэмээн Бурхан амласан Мессиа хийгээд Хаан юм. Энэ амлалт Есүс Христийн ирэлтээр гүйцэлдсэн бөгөөд Хоёр дахь Ирэлтийн үед дахин гүйцэлдэх болно.

Судруудыг судлах нь

А Үр дагавруудыг жагсаа

1. Иеремиа 30:5–7, 12–15-ыг уншиж, израилчууд Бурханаа орхиж, хиймэл шүтээнүүдийг шүтэн биширсний улмаас тэдэнд тохиолдсон зүйлүүдийг дүрсэл.
2. Хиймэл шүтээнүүдийг шүтэн биширсний үр дагаврууд нь өнөө үеийн нүглийн үр дагавруудтай хэрхэн адилхан байдаг вэ?

Б Харьцуулалт хий

Иеремиа 30: 8–11, 16–17-г унш. Боолчлолд байсан Иудагийн төлөө хийхээр Их Эзэний амласан зүйл, нүгэлд боолчлогдсон хүнд туслахын тулд түүний хийж чадах зүйлтэй хэр зэрэг адилхан бэ?

Иеремиа 31

Израилын цугларалт

Иеремиа 31 бүлэг 30-д эхэлсэн захиасыг үргэлжлүүлдэг. Израилын цугларалтын тухай, эрт дээр үед боолчлолоос Иерусалимд цуглуулах, түүнчлэн Израил тараагдсан дэлхий дээрх бүх газраас хожмын өдрүүдэд Есүс Христэд болон түүний Сүмд цуглуулах тухай агуу амлалтуудыг бүлэг 31 агуулдаг.

Судруудыг ойлгох нь

Иеремиа 31

Товшуурууд (ш. 4)—
Хөгжмийн зэмсэг

⋮ Рахел (ш. 15)—Рахел
⋮ (Иаковын [Израил] эхнэр,
⋮ Иосеф, Бениамин хоёрын эх)

Иеремиа 31—Израилын цугларалт

Иеремиагийн бүлэг 31 нь бүхэлдээ Израилын угсааны цугларалтын тухай юм. Израил хоёр замаар: хүмүүс эргэж ирэх болон сүнслэг байдлын хувьд цуглана. Израилын угсааны гишүүдийн хувьд хоёр цугларалт нь нэгэн зэрэг тохиох болно, эсвэл эдгээр нь тус тусдаа тохиож болно. Түүхийн туршид тохисон, мөн ирээдүйд тохиох энэ хоёр цугларалтын улмаас судруудад Израилын угсааны цугларалтын талаар санал зөрөлдөх явдал бий. Иеремиа 31:1–30 нь Израилын гэр бүл тараагдсан болон боолчлолд аваачигдсан нутгуудаас амлагдсан нутгууддаа биеэр цуглахад холбогдох нь тодорхой байна. Гэвч эдгээр шүлгүүд Их Эзэн болон түүний Сүмд сүнслэг байдлын хувьд цугларагсдад бас холбогдож болно. Иеремиа 31:31–34 сүнслэг байдлын цугларалтад өвөрмөцөөр холбогдож болно (С ба Г 45:56-г үз).

Иеремиа 31:9—“Ефраим бол Миний ууган хүү”

Ефраим бол Иаков буюу Израилаас ууган хүүгийн эрхийг авсан Иосефын ач хүү учраас Израилын шууд ууган хүү биш (Эхлэл 48–49-ийг үз). Иеремиа 31:9 дэх ууган хүү Ефраимын тухай ишлэл бол ууган хүүгийн эрхийг залгамжилсан байр суурийг нь хэлжээ.

Иеремиа 31:31–34—“Шинэ гэрээ”

Ахлагч Даллин Х. Өүкс “шинэ гэрээний” тухай дараах зүйлийг тайлбарлажээ: “Шинэ гэрээ бол Мормоны Номонд хийгээд хуучин зарлигуудад агуулагдсан гэрээ байлаа [С ба Г 84:57-г үз]. . . . Эдгээр хуучин зарлигууд Их Эзэний өмнөх илчлэлүүдэд, Библид (Хуучин ба Шинэ гэрээ) агуулагдсан байх ёстой, түүнчлэн өнөө үеийн илчлэлтүүдэд Гэгээнтнүүдэд аль хэдийн өгөгдсөн юм. . . .

“Судруудад дүрслэгдсэн гэрээ эдгээр хожмын өдрүүдэд шинэчлэгдэж, батлагдсанаар шинэ болдог нь Есүс Христтэй харилцах бидний гэрээний харилцаанд холбогддог. Энэ нь Сайн мэдээний бүрэн байдалтай нэгдэн нийлдэг. . . .

“. . . Мормоны Номонд болон хуучин зарлигуудад агуулагдах ‘шинэ гэрээ’ бол, хэрэв бид нүглүүдээ наманчилж, өөрсдийн Аврагчтай Сайн мэдээний гэрээ хийж, сахих юм бол, үхэшгүй байдлын баттай итгэл хийгээд мөнх амьдралын боломжийг бидэнд олгодог Цагаатгал, Есүс Христийн амилалтад үндэслэгдсэн Сайн мэдээний үндсэн гол амлалт юм. Энэ арга замаар, мөн түүний ач ивээлээр дамжуулан бид Сайн мэдээний хуулиуд хийгээд ёслолуудад дуулгавартай байснаар бүх хүн төрөлхтөн аврагдаж болно гэдэг агуу амлалтыг ухамсарлан ойлгож чадна (Итгэлийн Тунхаг 1:3)” (Даллин Х. Өүкс, “Another Testament of Jesus Christ” [СБС-ийн галын дэргэдэх ярилцлага, 1993 оны 6-р сарын 6], 4–5).

Судруудыг судлах нь

A Санааг зураглан харуул

Иеремиа 31:1–30-д өөрийн уншсан нэг санааг төлөөлөх ямар нэг зураг зурах буюу схем хий. Зураг буюу схемийнхээ товч тайлбарыг бич.

B Ялгааг дүрсэл

1. Иеремиа 31:31–34-г өгүүлснээр, Их Эзэн Израилын угсаатай хуучин гэрээг хэзээ хийсэн бэ?
2. Шинэ гэрээ нь хуучин гэрээнээс юугаараа, яагаад ялгаатайг дүрсэл.

Иеремиа 32

Иеремиа газар худалдаж авсан нь

Бүр Вавилоны устгалын дараа Израилын хүүхдүүд амлагдсан нутгууддаа цуглахыг санаанд хоногштол заахын тулд Их Эзэн шоронд байсан Иеремиад газар худалдаж авахыг зарлигласныг Иеремиа 32 үздэг. Тэгээд энэхүү бошиглолын нотолгоо болгон эрхийн бичгийг найдвартай газарт хадгалахыг Тэрээр Иеремиад хэлжээ. Вавилончуудын хүч үүнийг боломжгүй болгож чадаагүй бол, Бурханы хувьд боломжгүй юм гэж байдаггүй билээ (ш. 27-г үз). Мөнх бус хүмүүст олон зүйл боломжгүй мэт хэдий ч, “Надад ямар нэгэн зүйл дэндүү хэцүү юү?” (Иеремиа 32:27) гэсэн үгс бүхнийг чадагч Бурханд холбогдогийг санах нь чухал юм.

Иеремиа 33

Иерусалим дахь амар амгалан

Иеремиа 33 Иерусалимын талаарх хараахан гүйцэлдээгүй зарим амлалтуудыг агууладаг. Тэнд амьдардаг бүх хүмүүс Их Эзэнийг шүтэн биширдэг болох Иерусалим дахь амар амгалангийн агуу өдрийн тухай бүлэг 33 өгүүлдэг. Энэ бошиглол гүйцэлдээгүй байгаа хэдий ч, энэ нь “Мөчир” (Есүс Христ) Хаан болж, Давидын хаан сэнтийд хаанчлах өдрүүдэд тохиох болно гэж Иеремиа хэлжээ (ш. 15–16-г үз). Өөрөөр хэлбэл, бүх оршин суугчид нь Есүс Христийг өөрсдийнхөө Хаан гэж хүлээн авах хүртэл Иерусалим хэзээ ч төгс амар амгалан, аюулгүй байдлыг мэдэхгүй байх болно.

Судруудыг судлах нь

A Есүс Христийн тухай та нар юуг судлах вэ?

Иеремиа 33:15–18-ыг унш. Ирээдүйд нэгэн цагт Давидын хаан сэнтийд заларч, захирах хүнийг Израил “хүсэхгүй” (дутагдах буюу хэрэггүй байх) болох эсвэл золиослолууд гүйцэтгэх эрчүүд тэдэнд хэрэггүй болохыг эдгээр шүлгүүд өгүүлдэг. Есүс Христ ямар арга замаар өөрийн хүмүүсийн хаан, санваартан хийгээд золиослолын үүргүүдийг үүрд мөнхөд биелүүлдэг вэ? (Лук 1:32–33; Иохан 18:36–37; Еврей 2:17; 7:11, 22–27; 8:1–6; 9:11–15; 10:10–17; 3 Нифай 9:19–20-ийг үз).

Иеремиа 34

Зедекиа болон иудейчүүдийг зэмлэсэн нь

Зедекиа Хаан, бас Иудагийн хүмүүст юу тохиох тухай Иеремиагийн хийсэн бошиглолуудыг Иеремиа 34 агуулдаг. Иудей боолчууд болон үйлчлэгчидтэй байсных нь төлөө, түүнчлэн долоо дахь жил бүр бүх үйлчлэгчид, боолчуудыг чөлөөлж байх тухай Мосегийн хуулинд өгөгдсөн зарлигийг зөрчсөнийх нь төлөө Иудагийн хүмүүсийг Иеремиа 34-т Их Эзэн тусгайлан зэмлэсэн байдаг.

Иеремиа 35

Рехабууд

Иеремиа 35 өмнөх бүлгүүд дэх үйл явдлуудаас хэдэн жилийн өмнө бодитойгоор тохиосон үйл явдлуудыг цэдэглэдэг. Иехоиаким (ш. 1-д дурдагдсан) Зедекиагийн (бүлэг 33–34-т дурдагддаг) өмнө хаан байсан учраас бид үүнийг мэддэг. Иймэрхүү маягаар “арагшаа ухасхийх” нь Иеремиагийн номонд нилээд хэдэн удаа тохиолддог.

Иеремиа 35 рехабууд хэмээн нэрлэгддэг асан бүлэг хүмүүсийн тухай өгүүлдэг. Тэд хотуудын гадна талд майхнуудад амьдардаг байсан бөгөөд хэзээ ч нэг газарт суурьшидаггүй байв. Рехабууд бүлгийнхээ удирдагчийн тогтоож өгсөн тодорхой ёс заншлуудыг дагадаг байжээ. Эдгээр ёс заншлууд тэдний шашны хэсэг биш байсан хэдий ч, тэд дүрмүүд, ёс заншлуудыг туйлын итгэлтэйгээр дагадаг байсан аж. Их Эзэн эдгээр хүмүүсийг үзүүлэнт хичээл болгон ашигласан байдаг. Уг хичээл нь: Рехабууд хүмүүний ёс заншлуудыг итгэлтэйгээр сахьдаг байхад, Иудагийн хүмүүс амьд Бурханы зарлигуудыг—үнэн бодитой хийгээд мөнхийн адислалуудыг өөрсдөд нь хүртээдэг зарлигуудыг сахьж чаддаггүй гэсэн санааг илэрхийлжээ. Рехабуудыг чин үнэнч, итгэлтэй байдлынх нь төлөө адислах болно хэмээн Их Эзэн амлажээ.

Иеремиа 36

Бичээч Барух

Израил, Иуда болон бусад үндэстнүүдийн талаар хийсэн бүх бошиглолуудаа бичихийг Иеремиад Их Эзэн хэлснийг Иеремиа 36 цэдэглэжээ. Иеремиа баривчлагдсан учраас Барух хэмээх бичээч Иеремиагийн бүх бошиглолыг бичиж, дараа нь эдгээрийг ариун сүмийн довжоон дээр уншиж өгчээ. Хааны хүмүүсийн зарим нь бошиглолуудыг сонсож, бичээсүүдийг авч, эдгээрийг хаанд уншиж өгсөн аж. Бичээсүүдийг шатаахыг хаан зарлиглаж, Иеремиа Барух нарыг алуулахыг тэрээр эрэлхийлж байсан боловч, Их Эзэн тэднийг нуусан байлаа. Иеремиа дахиад нэг бошиглол хийж, үүнийгээ хаанд явуулав. Уг бошиглол Иехоиакийн үр удмын хүн хаан болохгүй гэсэн нь—биелэгдсэн бошиглол юм.

Иеремиа 37–44

Вавилон Иудаг эзэлсэн нь

Иеремиа 37–44 бол ихэнхдээ түүхэн хэсэг юм. Энэ хэсэг Иуда Вавилоноор устгагдаж, олон хүмүүс боолчлолд аваачигдсан үе дэх Иеремиагийн түүхийг товч өгүүлдэг.

Иудагийн нутгийг вавилончууд (эдгээр бүлгүүдэд заримдаа халдеичууд гэж нэрлэсэн байдаг) эзэлж байсан үед Египетийн цэрэг Иуда уруу хээрийн аянаар хөдөлсөн тухай Иеремиа 37 өгүүлдэг. Египетийн цэрэг ирж байгааг вавилончууд сонсоод тэд хэсэг хугацаагаар тэндээс явсан аж. Тийнхүү цэргээ буцаан татсан нь Египет тэднийг аврах болно гэсэн хуурмаг найдварыг Иудад төрүүлсэн ажээ. Ийм юм болохгүй гэдгийг Иеремиа Зедекиад хэлжээ. Энэ бошиглолын улмаас, Иеремиа гянданд хоригдов. Хожим нь Зедекиа түүнийг суллахыг зөвшөөрсөн хэдий ч, тэрээр баривчлагдсан хэвээр үлдсэн аж.

Иерусалим дахь удирдагчид вавилончуудаас тэсэн гарч чадна гэж бодож байсныг Иеремиа 38 цэдэглэдэг. Тэд Вавилонд аваачигдахыг өөрсдөө зөвшөөрөөл бүх юм сайн байх болно хэмээсэн Иеремиагийн байнгын захиаст ихэд дургүй байжээ. Уг захиаст цэрэг дайчдын сэтгэл санааны байдал бүр ч муугаар нөлөөлнө гэж бодсон учир Иеремиаг гянданд хорьсон нь эхнийхээсээ бүр ч дор юм болжээ. Ебед-мелех хэмээх Этиопийн тайган хүн Иеремиаг гяндангаас суллуулж, ингээд Иеремиа Зедекиагийн өмнө дахин нэгэнтээ очжээ. Хэрэв тэрээр дуулгавартай байх юм бол бүх зүйл сайн байх болно гэдгийг Иеремиа хаанд сануулав. Гэвч хаан уг зөвлөгөөг анхаарсангүй.

Иеремиа 39 Иерусалимын устгалын тухай, Зедекиа хааныг олзолж аван, хөвгүүдийг нь Зедекиагийн нүдэн дээр алж, Вавилоны эзлэн түрэмгийлэгчид Зедекиаг тарчлаан тамлаж, нүдийг нь сохолсон тухай өгүүлдэг. Зедекиагийн хөвгүүдийн нэг нь аврагдсаныг бид Мормоны Номноос мэддэг. Түүнийг аварсан хэсэг хүмүүс Өрнөд тал бөмбөрцөг рүү явсан бөгөөд Мормоны Номонд Зарахемлагийн хүмүүс хэмээн нийтэд мэдэгддэг билээ (Омнаи 1:14–19; Хиламан 8:21-ийг үз). Вавилончууд Иеремиад сайнаар

ханддаг байлаа. Бүлэг 39-ийн төгсгөлд, Иеремиад нинжин сэтгэлээр хандсаных нь төлөө Ебед-мелехийг адислахаар Их Эзэн амлажээ.

Иеремиа 40 вавилончууд Иеремиаг бүрмөсөн чөлөөлснийг цэдэглэдэг. Нэгэн нутгийг захирахаар томилогдсон Гедалиатай хамт явж тэнд амьдрахыг тэд түүнд санал болгоход Иеремиа зөвшөөрчээ. Эргэн тойрны нутгуудаас иудейчүүд Гедалиагийн оршин сууж байсан Мизрад цугларч эхлэв. Иоханан гэгч хүн хэсэг иудейчүүд Гедалиаг алахаар төлөвлөж байсныг мэдсэн боловч, уг төлөвлөгөөг тасалдуулах ямар нэг юм хийхийг Гедалиа Иохонанд зөвшөөрсөнгүй.

Ишмаел гэгдэгч нэгэн хүн Гедалиаг хэрхэн алсан тухай Иеремиа 41 өгүүлдэг. Ишмаел болон түүний эрчүүд Гедалиатай хамт амьдарч байсан хүмүүсийг, тэд иудейчүүд байна уу, вавилончууд байна уу, ялгаагүй бүгдийг нь бас алжээ. Иоханан цэрэг зохион байгуулж, Ишмаелын эрчүүдийг дайран, олныг нь алж, бусдыг нь олзлогдогсод болгон баривчилж, Гедалиаг дайрахад олзлогдсон хүмүүсийг чөлөөлсөн аж. Болсон үйл явдлын улмаас иудейчүүдэд үзүүлэх вавилончуудын харцу үйлдлийн тухайд сэтгэл түгшсэн бүх иудейчүүд Мизрагаас Чимхам хэмээх Бетлехемд ойр нутаг уруу явжээ. Тэндээс тэд аюулгүй байдлынхаа төлөө Египет рүү явахаар төлөвлөж байв.

Иеремиа 42 Чимхам уруу явсан бүлгийн дунд Иеремиагийн нэрийг дурдсан байдаг. Иоханан Иеремиа уруу очиж, Египет рүү явах төлөвлөгөөнийхөө талаар Их Эзэнээс асууж өгөөч хэмээн хүсжээ. Их Эзэн юу ч гэж хэлсэн ялгаагүй, тэд түүнийг л хийх болно хэмээн амласан аж. Тэд Египет рүү явах ёсгүй гэж Иеремиа хэлэв. Хэрэв тэд Иудагийн нутагт үлдэх юм бол, Их Эзэн тэднийг хамгаалах болно, харин хэрэв тэд Египет уруу явах юм бол, тэд илдээр, өлсгөлөнгөөр, эсвэл өөр гай гамшигаар үхэх болно гэж тэрээр хэлжээ.

Иоханан болон иудейчүүдийн энэ бүлгийн бардам зант бусад удирдагчид Иеремиагийн зөвлөгөөнд итгээгүйг Иеремиа 43 өгүүлдэг. Тэд Египет уруу явж, тэгэхдээ Иеремиаг хоригдол болгон өөрсөдтэйгөө хамт авч явжээ. Тэднийг тэнд хүрч очиход Вавилоны хаан Небухаднезар Египетийг ч бас эзлэх болно хэмээн Иеремиа бошигловсон аж.

Иудейчүүд хиймэл шүтээн шүтдэг хэлбэрүүдээ үргэлжлүүлэх учраас, бас тэд Их Эзэнийг дуулгавартай дагахгүй учраас тэд Египетэд устгагдах болно; зөвхөн цөөн хэдхэн хүн амьд үлдэж, Их Эзэний үг гүйцэлдсэнийг гэрч болон Иудад эргэж ирэх болно гэдгийг Иеремиа 44 цэдэглэдэг. Хэрэв тэд түүний бошиглогчийг дуулгавартай дагасан бол Их Эзэний мутар дахь адислалуудыг хүлээн авч чадах байсан иудейчүүдийн өөр нэг бүлгийн дунд ч энэ бошиглол бас гүйцэлдэж болох байсан биз ээ. Гэвч тэд өөрсдийн бодлод итгэсэн юм.

Иеремиа 45

Зөв шударга хүмүүст ч бас хүнд сорилтууд тулгардаг

Иеремиа 45 бол Иеремиагийн илчлэлтүүдийг бичиж, дараа нь эдгээрийг Хаан Иехоиакимын үед ариун сүмийн довжоон дээр хүмүүст уншиж өгсөн бичээч Барухад ирсэн илчлэлт юм. Тэрээр Их Эзэний ажлыг хийж байсан болохоор түүнд учирсан хүнд сорилтууд хийгээд гай зовлонгуудыг Их Эзэн зайлуулан авах байх гэдэгт Барух найдаж байсан бололтой. Гэвч Их Эзэн хүнд сорилтуудаас нь чөлөөлөхийг биш, харин тэр ойрын ирээдүйд үхэхгүй гэдгийг түүнд амласан аж.

Бид зөвөөр амьдарч байгаа учраас хүнд сорилтууд, хавчлага хийгээд бусад бэрхшээлүүдийг Их Эзэн биднээс зайлуулан авах болно хэмээн зүгээр л хүсэн хүлээж болохгүйг бас санах ёстой. Эхлэлийн үеэс хойш Их Эзэнд үнэнч, итгэлтэй байгаа хүмүүсийн нэгэн адил, бид сайн цагт ч, бас саар цагт ч итгэлтэй байх ёстой.

Иеремиа 46–51

Үндэстнүүдийн устгал

Израилын эргэн тойрон дахь нилээд хэдэн үндэстний устгалын тухай, түүнчлэн эдгээр үндэстэн тус бүр яагаад устгагдах тухай бошиглолуудыг Иеремиа 46–51 цэдэглэдэг. Египет (Иеремиа 46-г үз), Филист (Иеремиа 47-г үз) Моаб (Иеремиа 48-ыг үз), Аммон (Иеремиа 49:1–6-г үз), Едом (Иеремиа 49:7–22-ыг үз), Дамаск (Иеремиа 49:23–27-г үз), Кедар (Иеремиа 49:28–29-ийг үз), Хазор (Иеремиа 49:30–37-г үз), Елам (Иеремиа 49:34–39-ийг үз), мөн Вавилон (Иеремиа 50–51-ийг үз) бүгдээрээ устгагдана хэмээн Иеремиа бошигложээ.

Устгалын тухай эдгээр бүх захиасуудын зорилго нь Их Эзэн зөвхөн өөрийн хүмүүсийн ёс бус явдлыг шийтгэдэг төдийгүй, тэрээр бас бүх хүмүүсийн ёс бус явдлыг ямар үндэстэн болохыг нь харгалзахгүйгээр шийтгэдгийг заах, ялангуяа Израилын угсаанд заах явдал бололтой. Их Эзэн хэдийгээр эдгээр бүх бусад үндэстнийг устгах хэдий ч, тэрээр өөрийн хүмүүсийг хамгаалж, тэднийг бүрмөсөн устгахгүй гэж амласан нь Израилын хувьд Сайн мэдээ юм (Иеремиа 46:27–28-ыг үз). Устгалын тухай захиасууд бол бас эцсийн өдрүүд дэх ёс бусчуудын устгалын бэлгэдэл юм.

Иеремиа 52

Иеремиагийн сүүлчийн бичээсүүд

Иеремиа 52 бол Иеремиагийн номны зохих ёсны төгсгөл юм. Бүлэг 52 Иудагийн нийслэл Иерусалимыг Вавилон

эзэлж, Иудагийн үй олон хүмүүсийн заримыг нь алж, заримыг нь боолчлолд аваачсан тухай шастирыг өгүүлдэг.

Судруудыг судлах нь

А Үйл явдлуудыг дарааллаар нь жагсаа

Иеремиа 52 Иерусалимын уналтын үйл явдлуудын тухай өгүүлдэг. Дараах үйл явдлуудыг авч үзэн, дарааллаар нь жагсаахын тулд уг бүлэгт уншсан зүйлээ ашигла: Хаан Зедекиагийн нүдийг сохолсон: Небухаднезар хотыг бүсэлсэн; мянга мянган иудейчүүд боолчлолд аваачигдсан;

ариун сүм устгагдсан; Иерусалимын хэрэм устгагдсан. Үйл явдал бүрийн дараа, уг үйл явдлыг дүрсэлсэн шүлгийг бич.

Б Тайлбар бич

Вавилонд боолчлолд байсан Иудагийн хүмүүст захидал бич. Тэдний хот ягаад устгагдсан, тэд ягаад боолчлолд байсныг тайлбарла. Иудейчүүдийн устгал хийгээд боолчлолын талаар наад тал нь хоёр учир шалтгааныг нэрлэж, хариулт бүрд судрын ишлэл хэл.

Иеремиагийн гашуудал

Гашуудал гэдэг үг ихэд уй гашуу болсноос цурхиран уйлах гэсэн утгатай. Иудейчүүд ойрын төрөл төрөгсөд, найз нараа нас барахад гашуудал бичиж, дуулдаг заншилтай байжээ. Энэ бяцхан ном Иерусалимын төлөө, ариун сүмийн төлөө, түүнчлэн Иудагийн хүмүүсийн төлөө, яруу найргийн хэлбэрээр бичигдсэн Иеремиагийн гашуудлуудыг агуулдаг. Та нар уншихдаа, дараах санаануудыг хайн олж болно:

- Үр дагавруудгүйгээр бид нүгэл үйлдэж чадахгүй.
- Хуурамч бошиглогчдыг анхаарах нь үнэн бошиглогчдод анхаарал тавихаас амар хялбар байх нь олонтаа тохиолддог.
- Бурханы шийтгэлээс зайлахад чинь дэлхийн хүчнүүд та нарт тусалж чадна гэж бодох нь тэнэглэл мөн.
- Шийтгэгддэг нүгэл үйлдэгчид Бурхан шударга бус гэж бодох нь олонтаа байдаг.
- Тодорхой хэмжээгээр зовсны дараа л гагцхүү үнэн гэмшил ирдэг.
- Бид нүглээ хүлээн зөвшөөрөхөөс найдвар ирдэг.
- Бурханы хайр, нигүүлслийн улмаас, наманчилдаг бүх хүмүүст уучлалын болоод шинэчлэгдэлтийн хугацаа байдаг.

Дэлгэрэнгүй мэдээллийг Судруудын Удирдамж, “Гашуудлын ном”-оос үз.



Гашуудал 1

Нүглийн үр дагаврууд

“Судрууд болон бидний сүнсний удирдагчдын зааврууд нүглийн үр дагавруудаас ямагт үүдэлтэй зүрх сэтгэлийн эмзэглэлээс хэрхэн зайлсхийхийг бидэнд заадаг” гэж Ахлагч Теодор М.Бөөртөн хэлжээ (in Conference Report, 1985 оны 10-р сар, 81; Ensign, 1985 оны 11-р сар, 64).

Гашуудал 1 нь, Гашуудлууд дахь бүх бүлгийн нэгэн адил, Ахлагч Бөөртөний өгүүлсэн зүрх сэтгэлийн эмзэглэлийн жишээнүүдийг өгдөг. Зүрх сэтгэлийн эмзэглэл бүхий уй гашуу хийгээд гэмшил бол бид буруу зүйл хийхэд уруу татагдсан үедээ бидний хардаггүй буюу боддоггүй, нүглийн тийм хэсгүүд байдаг.

Та нар уншихдаа, Бүлэг 1 дэх үгс нь өөрийнхөө өдрүүдийг дэлхийд хий дэмий өнгөрүүлж, дэлхий дээр хийсэн муу шийдвэрүүдийнхээ мөнхийн үр дагавруудтай эдүгээ түлгарч байгаа хүмүүсийн үгстэй хэрхэн адилхан байж болох тухай бодож үз.

Судруудыг ойлгох нь

Гашуудал 1

Ариун газар (ш. 10)—Ариун сүм

Судруудыг судлах нь

А Яагаад?

Гашуудал 1:1–11-д Иеремиа өөрийнхөө тухай өгүүлжээ. Шүлэг 12–22-г тэрээр өөрөө Иуда орон бүхлээрээ байсан

мэтээр өгүүлжээ. Иеремиагийн үгсээс дөрвөн өгүүлбэр сонгож (ш. 1–11) тэрээр яагаад “Гашуудсан” гэж бодож байгаагаа тайлбарла.

Гашуудал 2–4

Иуда яагаад шийтгэгдсэн бэ

Гашуудал 2–4 бол Иудагийн хүмүүст тохиосон зүйлүүдийн талаарх уй гашуугийн илэрхийлэл юм. Их Эзэн өөрийн хүмүүсийг тэдний нүглүүдийн улмаас тэдний сайн сайхны төлөө шийтгэдгийг Гашуудал 2 тодорхой нотолдог. Гашуудал 3 Их Эзэнээр орхигдсон гэж боддог хэдий ч, тэрээр тэднийг бүрмөсөн орхиогүй гэдэг бодол, итгэл, найдварыг өдий хүртэл хадгалсаар байгаа хүмүүсийн тухай илэрхийллүүдийг агуулдаг. Гашуудал 4 нь Израил зөв шударга хүмүүсийн хувьд аж төрж байсан арга замыг Вавилоны эзлэлтийн дараа тэд ямар болсонтой харьцуулсан Иеремиагийн уй гашууг цэдэглэдэг.

Гашуудал 5

Иеремиагийн гуйлт

Та нар нүгэл үйлдсэн үедээ Ариун Сүнсний нөхөрлөлийг алдаж, нүглийн үр дагавруудаас ирдэг гутрал болоод Их Эзэнээс таслагдсаныг мэдэрч, хоёр сонголтын аль нэгийг гарцаагүй хийх ёстой болсон байдаг. Нэг сонголт бол нүглүүдээ нуух явдал мөн. Бид ихэвчлэн бусдыг буруутгах, өөрсдийгөө хариуцлагаас мултлах буюу шударга бус байснаар, түүнчлэн өөрсдийн хийсэн буруу зүйлийг үгүйсгэх замаар нүглээ нуудаг. Нөгөө сонголт бол өөрсдийгөө даруусах, наманчлах, түүнчлэн Их Эзэнтэй нийцэн эвлэрч эхлэх явдал мөн.

Гашуудал 5 нь даруу байдлын тухай гашуудлыг агуулдаг. Залбиралтай адил энэ гашуудалд, нүглээ ухааран ойлгож, уучлал хүссэн хүмүүст зориулан Иеремиа ярьсан байдаг.

Судруудыг судлах нь

А Та нар яаж хэлж болох вэ?

Хүмүүс үнэхээр наманчилж байсныг харуулсан үгс, өгүүлбэрүүдийг Иеремиа 5-аас жагсаа.

Б Та нар юу хийж чадах вэ?

Итгэлийн хоёр дахь Тунхгийг уншиж, тунгаан бод. Гэвч бид нүглийнхээ төлөө шийтгэгдэх, бусад хүмүүсийн нүглүүдийн үр дүнгээр зовох хоёрын хооронд ялгаа бий. Та нар өөрсдийгөө шүлэг 7-д дүрслэгдсэн нөхцөл байдалд байгааг мэдвэл юу хийж болох вэ, мөн Итгэлийн хоёр дахь Тунхагт тайлбарлагдсан сургаал та нарт хэрхэн тусалж чадах вэ?

Езекиелийн Ном

Бошиглогч боолчлолд

Вавилончууд Иудаг гурван удаа томоохон хэмжээгээр довтолжээ. Хоёр дахь нь ойролцоогоор МЭӨ 597 онд байлаа. Езекиел Вавилонд боолчлолд аваачигдсан бүлгийн дунд байв. Таван жил орчмын дараа тэрээр боолчлолд байсан иудейчүүдийн бошиглогчоор дуудагджээ. Алдаануудаасаа суралцахад нь хүмүүст туслахыг тэрээр хичээж байв.

Цамхаг дээрх харуул

Иеремиа Иерусалимд наманчлалыг хүчтэй тунхаглаж байхад, Езекиел Вавилоны боолчлолд байсан хүмүүстэй ажиллаж байлаа. Хүмүүсийг устгалаас аврахыг Иеремиа хичээж байсан бол, тэдний боолчлол өөрсдийнх нь ёс бусын улмаас үүдэлтэйг ойлгоход нь өөрийн хүмүүст туслахыг Езекиел хичээж байжээ. Хүмүүс Их Эзэн рүү эргэх юм бол ирээдүйн төлөөх найдварын учир шалтгаан буйг хоёр бошиглогч хоёул заадаг байлаа. Езекиел бүлэг 33-г ярилцах дуудлага болох цамхаг дээрх харуул байх ёстой байв.



Езекиелийг судлахад бэлтгэх нь

Хэрэв бид Езекиелийн номны гол сэдвийг сонгох хэрэгтэй боллоо гэхэд, энэ нь эцсийн эцэст бүх хүмүүс Их Эзэн бол Бурхан гэдгийг мэдэх явдал байж болно. Энэ зарчим нь, Езекиелд жаран таван удаа тохиолддог “тэгэхэд тэд Намайг ЭЗЭН мөн гэдгийг мэднэ” гэхчлэнгийн өгүүлбэрүүдээр харагддаг.

Дараах тойм Езекиелийн номон дахь зургаан гол сэдвийг харуулдаг:

1. Бошиглогч болох Езекиелийн дуудлага (Езекиел 1–3-ыг үз)
2. Израилын нутаг дахь, ялангуяа Иерусалим дахь хүмүүсийн нүглийг зэмлэсэн бошиглолууд (Езекиел 4–11, 20–24-ийг үз)
3. Вавилон дахь иудейчүүдийг наманчлалд дуудсан бошиглолууд (Езекиел 12–19-ийг үз)
4. Израилын дайснууд байсан түүний эргэн тойрон дахь улсуудын устгалын тухай бошиглолууд (Езекиел 25–32-ыг үз)
5. Израилын цугларалт болон Хоёр дахь Ирэлтэд бэлтгэх бусад үйл явдлуудын тухай бошиглолууд (Езекиел 33–39-ийг үз)
6. Ирээдүйн нэгэн цагт Иерусалимд баригдах ариун сүмийн тухай Езекиелийн үзэгдлийн дүрслэлт (Езекиел 40–48-ыг үз)

Езекиелийн Номны тухай дэлгэрэнгүй мэдээллийг Судруудын Удирдамж, “Езекиел”-ээс үз.

Езекиел 1

Бурханы алдар суугийн тухай Езекиелийн үзэгдэл

Езекиел 1, богинохон оршлын дараа Бурхан болон түүний алдар суугийн тухай Езекиелийн үзэгдлийг дүрсэлдэг. Бурханы болоод тэнгэрийн алдар сууг мөнх бус хүмүүний хэлээр дүрслэх нь нэн хэцүү учраас, бошиглогчид харсан зүйлээ дүрслэхийн тулд бэлгэдлийн нэр томъёонууд хийгээд дүрслэлүүдийг олонтаа ашигладаг. Бэлгэдлүүд юуг төлөөлдгийг зарим хүмүүс тайлбарлахыг хичээсэн хэдий ч, Бошиглогч Иосеф Смит хэлэхдээ, “Дүрслэл буюу амьтан, эсвэл аливаа зураглалын үзэгдлийг Бурхан хэзээ ч өглөө гэсэн, илчлэлт буюу үүний тайлбарын төлөө хариуцлагыг Тэрээр ямагт Өөрөө хүлээдэг, эс тэгвээс үүнд итгэх итгэлийнхээ төлөө бид хариуцлага хүлээх учиргүй. Хэрэв Бурхан уг зүйлийн талаар илчлэлт буюу тайлбар өгөөгүй бол, үзэгдэл буюу дүрслэлийн утгыг мэдэхгүйнхээ төлөө хараагдахаас бүү ай” гэжээ (Teachings of the Prophet Joseph Smith, 291).

Тэр ч байтугай бид Езекиелийн харсан зүйлийн утгыг бүрэн ойлгохгүй байлаа ч гэсэн, түүний эмгэнэлт дүрслэл уг үзэгдэл хэрхэн урьд хожид үзэгдээгүй өвөрмөц хийгээд Бурханы алдар суу үнэхээр хичнээн аугаа ихийг мэдрэх мэдрэмжийг мөн л бидэнд өгч чадна.

Езекиел 2–3

Езекиелийн үйлчлэх дуудлага

Езекиел 2–3 Бурханы алдар суугийн тухай үзэгдлийн хэсэг болгон Езекиелд Бурханы хэлсэн зүйлийг цэдэглэснээр эхэлдэг (Езекиел 1-ийг үз). Аль нэг байдлаар, эдгээр бүлгүүд түүний “номлолын дуудлагыг” агуулдаг. Езекиелийн номлолыг болон түүний заахаар дуудагдсан хүмүүсийг Их Эзэн дүрсэлсэн арга замын тухай уншихдаа, Бурханы бошиглогч өнөөдөр номлогчийг хэрхэн дууддагийг авч үз.

Судруудыг ойлгох нь

Езекиел 2

Өргөст халгай ба үүргэнүүд (ш. 6)—Өргөст зэрлэг ургамлууд (Езекиел өөрийн захиасуудыг хүргэхэд хүмүүс түүнд учруулж болох саад бэрхшээлийн бэлгэдэл)

Хилэнцэт хорхойнууд (ш. 6)—Хортой шавьж (Езекиелийн заах ёс бус хүмүүсийн бэлгэдэл)

Езекиел 2:9–10; 3:1–3—Хуйлмал номыг идэхийг Их Эзэн Езекиелээс хүссэн нь

Езекиел хуйлмал номыг идсэн дүрслэл нь Бурханы үгийг өөрийнхөө биеийн шууд хэсэг болгон заах түүний дуудлагыг төлөөлсөн бэлгэдэл юм. Мөн ийм туршлага Төлөөлөгч Иоханд тохиолдсон үеийг Илчлэлтийн Ном цэдэглэдэг (Илчлэлт 10-ыг үз).

Езекиел 3

Гэвч түүний цусыг би чиний гараас нэхнэ (ш. 18, 20)—Түүний нүглийн төлөө чи хариуцлага хүлээх болно

Би түүний өмнө саад тавих аваас (ш. 20)—Би түүнийг унахад хүргэнэ

Судруудыг судлах нь

Езекиел 2–3-ыг судлахдаа дараах гурван үйл ажиллагаанаас (А–В) хоёрыг нь хий.

А Езекиелийн номлолыг нэгтгэн дүгнэ

Езекиелийн номлолыг нэгтгэн дүгнэхийн тулд, дараах нийлмэл үгсийн утгыг тайлбарла: “зөрүүд хүүхдүүд” (Езекиел 2:4; мөн 3:7-г үз); өргөст халгай, үүргэнүүд, хилэнцэт хорхойнууд (2:6); хуйлмал ном (2:9–10; 3:1–3); очир алмааз (3:9); харуул (3:17–21); зэмлэдэг хүн (3:26).

ЭСВЭЛ

Дээр жагсаасан санаануудыг төлөөлсөн наад тал нь дөрвөн зургийг тэмдэглэлийн дэвтэртээ зур.

Б Хүнд хэцүү номлол

1. Езекиел 2–3-ыг судалж, Езекиелийн номлол хүнд хэцүү байх болно гэж өөрийнхөө боддог шалтгаануудыг жагсаа. Шалтгаан бүрд, өөрийн чинь санааг дэмждэг нэг шүлэг бич.
2. Езекиел 2–3-т Езекиелийн номлол ямар байх болно хэмээн Их Эзэний хэлсэн зүйлүүдийг, түүнчлэн номлолоо гүйцэтгэхэд нь Езекиелийг юу урамшуулан дэмжиж байсныг жагсаа.

В Харуул

1. Езекиел 3:17–21-ийг уншиж, харуулын дуудлагыг дүрсэл.
2. Өнөө үеийн Сүм дэх “харуулыг” нэрлэж, та нар яагаад энэ хүнийг сонгосноо тайлбарла.
3. Бид дуудлагуудаа биелүүлэх нь чухал болох талаар Езекиел 3:17–21 бидэнд юу заадаг вэ? Та нар эдгээр шүлгүүдийг Иаков 1:19-тэй харьцуулан ишлэл хийхийг хүсэж болно.



Езекиел 4–5

Иерусалимын устгалын тухай бошиглолууд

Их Эзэн Иеремиагийн нэгэн адилаар, ажиглах, санахад илүү дөхөмтэй аргаар хүмүүст заахын тулд эд юмс болон биет бэлгэдлийг Езекиелээр ашиглуулдаг байжээ. Израилчуудын ёс бус явдал, эсвэл Иерусалимын устгалыг төлөөлөхийн тулд ашигла хэмээн Их Эзэн Езекиелд хэлсэн бэлгэдлийг Езекиел 4–5 цэдэглэдэг.

Езекиел 6–7

Нүгэл ба устгал

Вавилоноор эзлэгдсэн үед Израилын нутагт юу тохиох тухай Их Эзэний албадсан захиасыг Езекиел 6–7 агуулдаг. Иерусалимын бүрэн уналт болон устгалын өмнө Езекиел Вавилонд аваачигдсан учраас энэ үйл явдлыг ирээдүйд болохоор өгүүлсэн ажээ. Бүлэг 6–7 дахь бошиглолуудад, Их Эзэн Израилын хиймэл шүтээнийг онцгойлон зэмлэж, иудейчүүд, “Би бол Их Эзэн гэдгийг мэдэхийн” (6:14) тулд Иерусалим устгагдах болно гэж хэлжээ. Бурхан бол үнэхээр амьд Бурхан гэдгийг, мөн түүний үгс биелэгдсэнийг амьд үлдэгсэд гэрчлэх боломжтой байсан билээ.

Езекиел 8–11

Иерусалим яагаад эзлэгдсэн бэ

Их Эзэн Езекиелд өгсөн үзэгдлийн тухай шастирыг Езекиел 8–11 агуулдаг. Езекиел бол Иудаг вавилончууд эхний үеүдэд довтлох үеэр боолчлолд аваачигдсан олон иудейчүүдийн нэг байлаа. Иерусалимд юу тохиолдсоныг, бас энэ нь яагаад тохиолдсоныг мэдэхэд энэ үзэгдэл цөлөгдөгсдөд (Вавилонд боолчлолд байсан хүмүүс) тусалсан ажээ.

Езекиел 8 Иерусалимын хүмүүсийн, түүний дотор тэдний шашны удирдагчдын ёс бус явдлын тухай өгүүлдэг. Их Эзэн зөв шударга хүмүүсийг устгалаас тэнгэрлэг элч “тэмдгээр” (Египет дэх Дээгүүр Өнгөрөх Баяр шиг) хамгаалсныг Езекиел 9 цэдэглэдэг. Иерусалимын устгалыг Их Эзэн зөвшөөрснийг Езекиел 10 тодорхой харуулдаг. Их Эзэн өөрийн хүмүүсийг амлагдсан нутгуудад нь буцаан цуглуулж, тэдний гэрээний харилцааг шинэчлэх болно гэдгийг бошигласноор Езекиел 11 ирээдүйн үеийнхэнд зарим найдвар төрүүлдэг.

Судруудыг судлах нь

А Цугларалт

1. Их Эзэн өөрийн гэрээт хүмүүсийн төлөө хийх болно хэмээн хэлсэн зүйлүүдийн жагсаалт хийхэд өөртөө туслахын тулд “. . . болно би,” мөн “би . . . болно” гэсэн үгсийг Езекиел 11:16–20-иос ол.
2. Та нар хэрхэн эдгээр шүлгүүдэд өгүүлэгдсэн зүйлийн хэсэг байдаг вэ, эсвэл Их Эзэн эдгээр амлалтуудыг өнөөдөр хэрхэн биелүүлж байна вэ?

Б Нийлмэл үгсийг тайлбарла

Езекиел 11:19-ийг уншиж, “чулуун зүрхтэй хүн,” “шинэ сүнстэй,” мөн “махан зүрхтэй” хүний хооронд ямар ялгаа байдаг гэж бодлогоо тайлбарла.

Езекиел 12–17

Яагаад боолчлолд оров?

Иерусалимыг Вавилон дахиад олон удаа довтолж, илүү олон иудейчүүдийг боолчлолд аваачих болно хэмээн Езекиелд илчилсэн Их Эзэний илчлэлтүүдийг Езекиел 12–17 агуулдаг. Яагаад эдгээр үйл явдлууд болсныг Их Эзэн бас илчилж, боолчлолд байгаа хүмүүст наманчлалыг номлохыг Езекиелд хэлжээ.

Езекиел 12 дахиад олон нь боолчлолд аваачигдахыг иудейчүүдэд нотолжээ.

Өөрийнх нь нэрээр ярьдаг мэтээр дүр үзүүлдэг хуурамч бошиглогчдыг, мөн янз бүрийн аргаар хүмүүсийг түүнээс зайлуулан удирддаг бусад хүмүүсийг Их Эзэн буруутган зэмлэснийг Езекиел 13 өгүүлдэг.

Иудейчүүдийн удирдагчид зөвлөгөө авахын тулд Езекиел дээр хүрч ирсэн тухай Езекиел 14 цэдэглэдэг. Тэд бас хиймэл шүтээнүүдээс хариулт эрэлхийлэхээ зогсох хүртэл нь тэрээр зөвлөгөө өгөхгүй гэдгийг Их Эзэн тэдэнд хэлсэн аж. Ирэх шүүлтүүдэд тэсэн гарахын тулд хувь хүн бүр зөв шударга байх ёстойг, түүнчлэн тэд удирдагчдынхаа зөв шударга байдалд найдвар тавьж болохгүйг тэрээр онцлон тэмдэглэжээ.

Езекиел 15 Израилын хүүхдүүдийг ямар ч хэрэггүй шаатагдсан усан үзмийн модтой зүйрлүүлжээ. Судруудад өөр олон удаа, Их Эзэн Израилын хүүхдүүдийг усан үзмийн мод буюу усан үзмийн цэцэрлэгтэй зүйрлүүлсэн байдаг (Исаиа 5; Иаков 5-ыг үз).

Езекиел 16, Хуучин Гэрээн дэх бусад судруудын нэгэн адил Израил, гэрээний гэрлэлт болон Их Эзэний хоорондын харилцааны харьцуулалтыг агуулдаг. Израил (Иерусалим) “нөхөртөө” хэрхэн итгэлгүй байсныг мөн тэрээр яагаад шийтгэгдэх болсныг Бүлэг 16 нарийн тодорхой агуулдаг.

Тэд боолчлолд байх үедээ Египетээс чөлөөлөлтийг эрэлхийлэх ёсгүй, харин вавилончуудад захирагдах хэрэгтэй, ингэвэл Их Эзэн эцэстээ тэднийг гэтэлгэх болно гэдгийг хүмүүст заасан сургаалт зүйрлэлийг Их Эзэн Езекиелд илчилснийг Езекиел 17 агуулдаг.

Езекиел 18

Нүглийн төлөөх хариуцлага

Ямар байдлаараа та нар эцэг эхтэйгээ адилхан эсвэл адилхан биш вэ? Яагаад?

Зарим үед “гэмтнүүдийн алдсын төлөө гэм зэмгүй хүмүүс зовохоор албадуулдаг” нь үнэн юм. (Teachings of the Prophet Joseph Smith, 34). Гэвч зарим хүмүүс өөрчлөх хүч өөрсдөд нь байгаа зүйлүүдийн төлөө эцэг эхчүүдээ болон бусдыг буруутгасаар байдаг. Израилын хүүхдүүд эцгүүдийнхээ нүглээс үүдэлтэйгээр өөрсдөө шийтгэгдлээ гэж боддог байсан аж. Тэр ч байтугай тэд эцэг эхчүүдийнхээ нүглийн төлөө зовсон тухай нийтийн мэдэх үг хэллэг Езекиел 18:2-т байдаг. Тэдний зүйр үг (хэллэг) зарим талаар үнэн байв. Эцгүүд нь Их Эзэний замуудыг хүүхдүүдээ зохих ёсоор заадаггүй, эсвэл хүүхдүүд нь Бурханы хуулиудад итгэлтэй болон өсч хөгжих таатай орчныг тэд бүрдүүлж өгдөггүй байсан ажээ.

Гэвч үнэнийг заах, тэдний наманчлах ёстой арга замуудыг хүмүүст заах бошиглогчдыг Их Эзэн үе үеийнхэнд илгээж байсан билээ. Бошиглогчдын үгсийг сонсож, дагахаар, эсвэл эцэг эхчүүдийнхээ ёс заншлуудыг дагахаар сонгох боломж үе үеийнхэнд байсан билээ. Сонгох эрхийн зарчмын энэхүү бүрдүүлбэрийг Их Эзэн энэ бүлэгт тодорхой заажээ.

Судруудыг ойлгох нь



Езекиел 18

Уулын бунхан дээр идэх (ш. 6, 11, 15)—Хиймэл шүтээн шүтэхэд оролцох

Бузарлах (ш. 6, 11, 15)—Ёс суртахуунгүй байх

Хүрдэггүй бол (ш. 6)—Бэлгийн харилцаа үйлдэхгүй байх

Дарлагч (ш. 7, 12, 16, 18)—Шударга бус хандах, дарамтлах

Судруудыг судлах нь



А Судруудыг хэрэглэ

Зөв шударга үйл ажиллагаанд түүнийг урамшуулан дэмждэггүй гэр оронд амьдардаг хүнд туслахын тулд та нар Езекиел 18:1–18-ыг хэрхэн хэрэглэж болох вэ? Та нар эдгээр шүлгүүдийг Итгэлийн хоёр дахь Тунхагтай харьцуулан ишлэл хийхийг хүсэж болно.

Б Чухал зарчмуудыг тогтоо

Езекиел 18:19–32-ыг уншиж, нүгэл, наманчлал, эцсийг хүртэл тэвчих тухай Их Эзэн юу заасныг түүнчлэн нүгэлд байдаг хүмүүсийн талаар тэр юу гэж боддогийг ол. Эдгээр

шүлгүүдэд заагдсан зарчмуудыг хураангуйлан дүгнэсэн, нэг өгүүлбэрээс бүтсэн, наад тал нь дөрвөн нотолгоо бич.

Езекиел 19–20

Үл сонсох удирдагчид

Езекиел 19–20 бол иудейчүүдийн удирдагчдад тусгайлан хандсан бөгөөд тэдний тухай юм. Агуу чадавхи бүхий удирдагчид тэнэглэлийнхээ улмаас адисла.луудаа алдсаныг заахын тулд бүлэг 19-д Их Эзэн хоёр сургаалт зүйрлэл ашигласан байдаг. Вавилон (Езекиел энд боолчлолд амьдарч байв) дахь иудейчүүдийн зарим удирдагчид Езекиелээр дамжуулан Их Эзэнээс заавар хүлээж авахыг хэрхэн хүссэн тухай бүлэг 20 өгүүлдэг. Их Эзэнийг эрэлхийлэхийн хамт бас бусад бурхдаас илчлэлт эрэлхийлж байсныхаа төлөө наманчлахад тэднийг Их Эзэн дууджээ. Израилын хүүхдүүдийг анх тэрээр Египетээс удирдан гаргасны адилаар, боолчлолоос гарахад нь удирдагдах боломжийг, түүнчлэн тэр бол тэдний Их Эзэн, Бурхан гэдгийг мэдэх бас нэгэн боломжийг тэрээр израилчуудын ирээдүйн үеийнхэнд олгох болно хэмээн Езекиел 20:33–44-т Их Эзэн амласан ажээ. Гэвч, энэ үед, тэднийг тараасан бүх үндэстнүүдийн дундаас тэрээр Израилыг цуглуулахаар амлажээ.

Эдгээр шүлгүүд дэх цугларалтын хэсэг болон дурдагдсан гайхамшигт үйл явдлууд эрт дээр үед зөвхөн зарим талаар биелэгдсэн аж. Эдгээрийн бүрэн биелэлт эцсийн өдрүүдэд Израилын хүүхдүүд үнэн Сүмд цугларч, нүглээс цэвэршигдэн, Их Эзэнд, түүний “ариун ууланд” (ариун сүм) үйлчлэх үед тохиох болно. Тэр үед тэд өөрсдийнхөө хэн болохыг, мөн тэдний Их Эзэн, Бурхан хэн болохыг үнэнээр мэдэх болно (ш. 42, 44-ийг үз).

Судруудыг ойлгох нь



Езекиел 20:33–44

Хүчит мутар, сунгасан гар
(ш. 33–34)—Хүчний
бэлгэдэл

Езекиел 20:37—“Би та нарыг таяган доогуур явуулна”

Езекиел 20:37 дахь таяг бол хоньчны таяг юм. “Таяган доогуур явуулах” гэдэг нь Хоньчин Езекиелд өгүүлснээр, “гэрээний хүлээсэнд оруулах” гэсэн үг ажээ. Таяган доогуур оруулах гэдэг нь бас хоньчид хонио аравны нэгд оруулан, арав дахь хонь бүрийг таягаар тэмдэглэн Их Эзэнд зориулсныг заадаг байсан бололтой гэж зарим хүмүүс үздэг.

Судруудыг судлах нь



А Үндсэн гол санаануудыг ашиглан хураангуйлан дүгнэ

Их Эзэн Израилыг цуглуулах болно, мөн тэд зүрх сэтгэлээ түүн рүү эргүүлэх болно гэдгийг Езекиел 20:33–44 өгүүлдэг. Дараах үндсэн гол санаануудыг ашиглан эдгээр шүлгүүдийн захиасыг тайлбарла: хүчит мутар (ш. 33); цуглуулах (ш. 34); нүүр нүүрээрээ (ш. 35); бузарлах (ш. 39); мийн ариун уул (ш. 40); ариун (ш. 41); санах (ш. 43); мэдэх (ш. 38, 42, 44).

Езекиел 21–24

Ёс бус явдал устгал уруу хөтөлдөг

Езекиел 21–23-т Иерусалим яагаад устгагдахыг Их Эзэн үргэлжлүүлэн тайлбарласан байдаг. Зарим зөв шударга хүмүүс энэ устгалд бас зовох болно гэдгийг Езекиел 21 тайлбарладаг. Зарим хүмүүс шударга бус хэмээн бодож болох энэхүү зовлон тохиохын учир нь Их Эзэн өөрийн хүүхдүүдийн сонгох эрхийг хүндэтгэдгийнх юм. Эцсийн өдрүүдийн шүүлтүүдийн заримд нь зөв шударга хүмүүс бас зовж болно, гэвч ийм хүмүүст Их Эзэн мөнхийн агуу шагналыг амласан билээ (С ба Г 58:2-ыг үз).

Бүлэг 21 дэх өөр нэг сонирхолтой бошиглол, “эрх нь түүнийх болох” Есүс Христийг хаанчлах (ш. 27) хүртэл өөр хаан энд байхгүй байх болно гэж хэлэн, Иудагийн хаан түлхэгдэн унагаагдахыг Езекиел бошигласон шүлэг 25–27-д байдаг. Иудейчүүд Вавилонд боолчлолд байсан тэр цагаас хойш тэд хаант улсаа дахин төвхнүүлээгүй байгаа билээ. Есүс Христ ирээдүйд тэдний цорын ганц хаан байх болно.

Иерусалим эдгээрээс болж устгагдсан, олон нүглийг Езекиел 22 өгүүлдэг. Ямар нүглүүдийн улмаас Их Эзэн тэднийг устгахыг зөвшөөрснийг харах нь түүний мэлмийд юу жигшүүртэй байдгийг ойлгоход бидэнд тусалдаг.

Езекиел 23 бол Израил (Самари), Иуда (Иерусалим) орнуудыг янхан байхаар сонгосон эмэгтэйчүүд хэмээн Их Эзэн нэрлэсэн өөр нэг бүлэг юм. Уг харьцуулалт нь түүний гэрээт хүмүүс бусад бурхдыг шүтдэг байсан тухайд Их Эзэн хичнээн хүчтэй мэдрэмжтэй байсныг бидэнд харуулдаг.

Тогоон дотор мах чанаж байгаа дүрслэлийг, иудейчүүд вавилончуудаар “чанагдаж” байсныг дүрслэхэд Их Эзэн ашигласныг Езекиел 24 цэдэглэсэн байдаг. Бүлэг 24 бас Езекиелийн эхнэрийн үхлийн тухай өгүүлсэн байдаг. Иудагийн агуу ёс бус нь түүний шийтгэлүүдийг зүй ёсны хийгээд шударга болгосон учраас Иерусалимын болон Иудагийн хаант улсын устгалын төлөө иудейчүүд гашуудах ёсгүйн тэмдэг болгон, эхнэрийнхээ төлөө гашуудахгүй байхыг Их Эзэн Езекиелд хэлжээ.

Езекиел 25–32

Бусад үндэстнүүдийн шийтгэл

Бошиглогч Исаиа, Иеремиа нарын нэгэн адил, Езекиел израилчуудын талаар эхлээд ярьж, дараа нь эргэн тойрных нь үндэстнүүдийн ёс бусын тухай өгүүлэн, тэдний устгалын тухай бошигложээ. Езекиел 25–32 эдгээр үндэстнүүдийн талаарх бошиглолуудыг агуулдаг: Аммончууд, моабчууд, едомчууд, филистчүүд (Езекиел 25-ыг үз); Тир болон Сидон (Езекиел 26–28-ыг үз); түүнчлэн Египет (Езекиел 29–32).

Дараах нутгуудын устгал бошиглогджээ



Езекиел 33

Цамхаг дээрх харуулууд

Сүмийн удирдлагын түвшин бүрд эцэг эхчүүд, удирдагчид хүмүүст заах, тэднийг наманчлахад урамшуулан дэмжихэд яагаад ихэд анхаарал тавьдаг вэ?

Түүхийн туршид хүмүүс хөрш зэргэлдээх овгууд буюу үндэстнүүдийн зүгээс халдан довтлохын эсрэг хамгаалах шаардлагатай байлаа. Тэд хамгаалалтын төлөвлөгөөний хөө нэг хэсэг болгон хотуудынхаа хэрмэн дээр цамхгууд барьж, дайсан ирж байгаа эсэхийг харахын тулд харуулуудыг цамхгууд дээр байрлуулдаг байв. Хэрэв хүмүүс

харуулуудыг эс хайхрах юм бол, тэд өөрсдийгөө их аюулд тавьж өгдөг байж. Үүний хамт, хэрэв харуулууд үүргээ биелүүлээгүй бол, хот бүхлээрээ устгагдаж мэдэхээр байдаг байв. Израилын удирдагчдыг харуулуудтай зүйрлүүлсэн харьцуулалтыг Езекиел 33 цэдэглэсэн байдаг.



Судруудыг ойлгох нь



Езекиел 33

Түүний цус (ш. 4–6, 8)—
Хариуцлага

Та нар цустай нь идэж (ш. 25)—Махны цусыг идэхгүй байх хуулийг зөрчсөнийг хэлж байна

Езекиел 33:30–32—Иудейчүүд бошиглогчиддоо хэрхэн ханддаг байсан нь

Бошиглогчтой байх нь агуу адислал—гэвч бид зөвхөн түүний зөвлөгөөг дуулгавартай дагасан тохиолдолд л тэр шүү. Езекиел 33-ын эдгээр сүүлчийн шүлгүүдэд, хүмүүс бошиглогчийг хайрлаж, түүний хэлснийг сонсоход санаа тавьдаг мэтээр ярьдаг хэдий ч, тэд өөрсдөд нь бошиглогчийн заасан зүйлийг дуулгавартай дагадаггүй байсныг Их Эзэн Езекиелд хэлжээ. Шүлэг 31-ийн төгсгөл нь Их Эзэн Бошиглогч Иосеф Смитэд өгсөн, урвалтад байгаа хүмүүсийн тодорхойлолтог маш адилхан сонсогддог (Иосеф Смит—Түүх 1:19-ийг үз).

Судруудыг судлах нь



А Судруудыг ашиглан асуудлуудыг шийдвэрлэ

Езекиел 33:1–9 харуулын үүрэг, ач холбогдлыг тайлбарладаг. Бошиглогчид, санваартны бусад удирдагчид, Сүмийн удирдагчид, түүнчлэн эцэг эхчүүдийг Их Эзэн өөрийн хүмүүсийн харуулууд байлгахад дууддаг. Дараах нөхцөлүүдийг авч үзэн, Езекиел 33:1–9-д заагдсан зарчмуудын дагуу төгсгөл дэх асуулт бүрд хариул:

1. Залуучуудын дуртай үйл ажиллагаануудын нэг нь кино, видео үзэх явдал мөн. Эдгээр видеонууд Сүмийн жишгүүдээс доогуур байх нь олонтаа тохиолддог. Эцэг эхчүүд юу хийх ёстой вэ? Бишоп? Залуу Эрэгтэйчүүдийн болон Залуу Эмэгтэйчүүдийн Ерөнхийлөгчид? Залуучууд? Чи өөрөө?
2. Бусад дасгал сургуулилтын цагуудаас гадна, дасгалжуулагч хөл бөмбөгийн багийн дасгал сургуулилтыг Бямба

гарагийн өглөө бүр хуваарьт оруулжээ. Тоглогч бүр үүнд оролцохыг тэрээр хүсдэг. Эцэг эхчүүд яах ёстой вэ? Бишоп? Багт оролцдог залуучууд?

Езекиел 34

Израилын хоньчид

Сүмийн удирдагчдын нэмэлт үүргүүдийг Езекиел 34 цэдэглэсэн байдаг. Их Эзэн энэ үед удирдагчдыг өөрийн хонийг (хүмүүсийг) хариулах хоньчидтой зүйрлэжээ. Дэлхийн тохинууллынхаа үед, Их Эзэн өөрийгөө “сайн хоньчин” (Иохан 10:14) хэмээн нэрлэжээ. Та нар Езекиел 34-ийг уншихдаа, ямар зүйлүүд өөрийг нь сайн хоньчин болгодог гэж Их Эзэн хэлснийг, мөн ямар зүйлүүд хүмүүсийн удирдагчдыг муу хоньчид болгодог гэж хэлснийг эрж ол. Бас хонины талаар тэр юу гэж хэлснийг ол.

Судруудыг ойлгох нь



Езекиел 34

Тэднээс өөрийнхөө хони-нуудыг шаардаж (ш. 10)—
Сүргийн төлөө тэднийг хариуцлага хүлээх болгож

Булингартуулах (ш. 18–19)—Бохир болгох
Тэдний буулгыг эвдэж (ш. 27)—Боолчлол, олзлогдолт, ачаа дарамтыг арилгах

Езекиел 34:23–24—“Миний зарц Давид”

Эдгээр шүлгүүд дэх “Давид” бол Мессиа юм. Еврей хэлэнд Давид гэдэг нь “хайрлагдсан” гэсэн утгатай аж. Иудейчүүд Бурханы хайртай Хүүг өөрсдийнхөө Мессиа хэмээн хүлээн авсан үед эдгээр шүлгүүдийн дүрсэлдэг гайхалтай нөхцөлүүд ирэх болно. Мөн Исаиа 9:6–7; Илчлэлт 22:16-г үз.

Судруудыг судлах нь



А Юу сайн удирдагч болгодог вэ?

1. Езекиел 34:1–10, 18–19-д өгүүлснээр, Израилын удирдагчид яагаад Их Эзэний хүмүүсийн муу “хоньчид” байсан бэ?
2. Езекиел 34:11–16-д байдаг сайн хоньчны шинж чанаруудыг жагсааж, Аароны Санваартны чуулга, эсвэл Залуу Эмэгтэйчүүдийн ангийн ерөнхийлөгчийн зөвлөлд үйлчилдэг хэн нэгэн өөрийнхөө дуудлагын шинж чанар бүрд хэрхэн тохирч байгааг тайлбарла.

Езекиел 35

Едомын устгал

Езекиел 35 бол Едом, бас Сеир Уул болон Идумеа хэмээн нэрлэгддэг байсан, Израилыг хүрээлсэн нэг үндэстэн дээр ирэх шүүлтийн тухай өөр нэг бүлэг юм.

Езекиел 36

Найдварын захиас

Хэдийгээр Израил эргэн тойрныхоо бүх үндэстнүүдийн нүдэн дээр ичгүүрт тавигдсан ч гэсэн, өөрийнх нь хүмүүс өөрийг нь болон өөртэй нь хийсэн гэрээнүүдээ тэд доог тохуу болгохыг тэрээр зөвшөөрөхгүй гэдгийн гэрчлэл болгон, тэднийг ичгүүрт тавихыг зөвшөөрснөө Их Эзэн Езекиел 36-д хэлсэн ажээ. Тэр бол цорын ганц үнэн хийгээд амьд Бурхан гэдгээ дэлхийд гэрчлэх гэрчлэл болгон— Их Эзэн израилчуудын ирээдүйн үеийг нутагт нь, мөн өөртэйгөө харилцах гэрээний харилцаанд нь буцаан цуглуулах болно гэсэн амлалтыг Езекиел 36 агуулдаг. Тэрээр тэднийг алдсуудаас нь цэвэрлэн угааж, тэдэнд “шинэ зүрх,” “шинэ сүнс” (ш. 26-г үз) өгөх болно гэж амласнаар, тэд Езекиелийн үгээс олон жилийн өмнөхтэй адилгүй болж, Их Эзэний зарлигуудыг сахих болно.

Езекиел 37

Сэргээлтийн тухай хоёр үзэгдэл

Сүнслэгээр нөлөөлсөн бэлгэдлийн заалтын гайхамшигтай зүйлүүдийн нэг бол, энэ нь нэгээс илүү утгатай байж, бас нэгээс илүү олон цаг үе буюу нөхцөлд хэрэглэгдэж болдог явдал мөн. Езекиел 37 бол олон утгын онцгой сайн жишээ мөн. Бүлэг 37 дахь Израилын цугларалтын тухай хоёр “үзүүлэнт хичээлийг” Их Эзэн Езекиелд заажээ. Эдгээр үзүүлэнт хичээлүүд Бурханы төлөвлөгөө болон эцсийн өдрүүд дэх түүний хаант улстай холбоотой бусад агуу үнэнүүдийг бас зааж, гэрчилдэг.

Судруудыг ойлгох нь



Езекиел 37


Шөрмөс (ш. 6)—Булчин болон яснуудыг хооронд нь холбож, хөдөлгөөнд тусалдаг биеийн эд буюу шөрмөс

Ариун газар (ш. 26, 28)—
Ариун сүм



Езекиел 37:15–20—Иудагийн саваа ба Ефраимын саваа

“Эртний Израилд цэдгүүдийг модон хавтан дээр буюу саваанд ороосон хуйлмал цааснууд дээр бичдэг байжээ. . . . Иудагийн саваа буюу цэдэг—Хуучин Гэрээ, Шинэ Гэрээ хоёр—Ефраимын саваа буюу цэдэг—Есүс Христийн бас нэгэн гэрээ—Мормоны Ном нь . . . чухамдаа бидний гарт байна. Езекиелийн бошиглал эдүгээ гүйцэлдэж байна” хэмээн Ахлагч Байд К.Пакер хэлжээ (in Conference Report, 1982 оны 10-р сар, 73; *Ensign*, 1982 оны 11-р сар, 51, 53).



Судруудыг судлах нь

А бэлгэдлийг ол

1. Езекиел 37:1–14-т цэдэглэгдсэн Езекиелийн үзэгдэл Израилын хүүхдүүдийг цуглуулах Их Эзэний амлалтыг тодорхой бэлгэдсэн. Дараах хүмүүс буюу нөхцөлүүдийг төлөөлсөн гэж өөрсдийн бодож байгаа үг буюу нийлмэл үгийг сонго: Израилын хүүхдүүд, Израилын хүүхдүүдийн алга болсон сүнслэг байдал, Израилын хүүхдүүдэд Ариун Сүнсний үзүүлэх нөлөө, Израилын хүүхдүүдийг алгуураар цуглуулах нь.
2. Израилын хүүхдүүдийн өөр нэг, бүр илүү агуу “сэргээлтийг” Езекиел 37:1–14 хэрхэн гэрчилдэг вэ? (мөн Алма 11:42–45; С ба Г 138:16–17-г үз).

Б Төгс Эзэмших Судар—Езекиел 37:15–17

1. Төгс эзэмших судрын эдгээр шүлгүүд дэх юмсын зураг буюу схемийг зур.
2. Езекиелийн өгүүлсэн энэ хоёр саваа буюу цэдэг 2 Нифай 3:11–12-т дурдагддаг. Энэ хоёр саваа “нэгдсэний” улмаас юу тохиох болно гэж Мормоны Ном өгүүлснийг жагсаа.

3. Та нар Езекиел 37-г шүлэг 22 хүртэл уншсанаар, Израилын цугларалтад энэ хоёр “саваа” чухал болохыг мэдэх болно. Библи, Мормоны Ном хоёр нийлснээр Израилын цугларалтад хэрхэн тусалж чадна гэж бодогоо тайлбарла. Мормоны Номны дэд гарчиг: Есүс Христийн Бас Нэгэн Гэрээний захиасыг хариулганаа авч үз.

Езекиел 38–39

Гог, Магогийн тулалдаан


“Хожмын өдрүүдэд” Израилд болох агуу тулалдааны тухай мөн үүн Гог хэмээх хаанаар удирдуулсан “Магогийн” хүмүүс оролцох тухай Езекиел 38–39 өгүүлдэг. Энэ дайн “Израилын уулсад” эдгээр нутгуудад Израилын хүүхдүүдийг цуглуулахын эсрэг дэгдэх тухай Езекиел дүрсэлжээ. Бүх үндэстнүүд, “Би бол Их Эзэн гэдгийг мэдэж” (Езекиел 38:23) болохын тулд өөрийн хүмүүсийг Магогийн цэргүүдээс гайхамшигтайгаар аврах болно гэдгийг Их Эзэн бас Езекиелд хэлжээ. Эдгээр дүрслэлүүдээс үзвэл, “Армагеддон” хэмээн нийтээр мэдэх, Хоёр дахь Ирэлтийн өмнөх агуу тулалдааныг Езекиел дүрсэлсэн бололтой.

Илчлэгч Иохан Мянган Жилийн төгсгөл дэх сайн ба муугийн хоорондох тулалдааныг Гог ба Магогийн тулалдаан хэмээн дүрсэлсэн нь төөрөлдүүлэх зүйл байж мэднэ (Илчлэлт 20:7–9-ийг үз). Иймээс Гог ба Магогийн хэмээх хоёр тулалдаан байгаагаас эхнийх нь Хоёр дахь Ирэлтийн өмнө, нөгөөх нь Мянган Жилийн төгсгөлд байх ажээ. Эдгээр тулалдаанууд Бурханы дайснуудыг бүрмөсөн устгаж, дэлхий дээр чухал өөрчлөлт гаргах хийгээд их устгалыг авчрах асар их цар хүрээтэйгээрээ адил байх ажээ.

Езекиел 40–42

Ариун сүмийн тухай Езекиелийн үзэгдэл

“Израилын газарт” (40:2) байх ариун сүм уруу очсон тухай нарийн тодорхой дүрслэлийг Езекиел 40–42 агуулдаг. Түүний хөтөч, тэнгэрлэг элч, ариун сүмийн хэсэг бүрийг хэмжсэн учраас Езекиелийн дүрслэл өрөөнүүд, хананууд, хаалгануудын гэхчлэн хэмжээг багтаасан байдаг. Түүний дүрслэсэн ариун сүм Соломоны ариун сүмтэй маш адилхан байжээ. Түүний үзсэн ариун сүм хэзээ баригдах, эсвэл өрөөсөө баригдах эсэхийг нь бид мэддэггүй.



Езекиел 43–44

Бурханы алдар суу ариун сүмийг дүүргэв

Та нар ариун сүмийн зураг харах буюу ариун сүмд орсон үед, түүнчлэн үүний хажуугаар явах буюу дотор нь орох үед ямар санагддаг вэ?

Их Эзэний алдар суу ариун сүм рүү орж, үүнийг ариун, нандин болгосныг Езекиел харсан тухай Езекиел 43 цэдэглэдэг. Их Эзэн ариун сүмд өөрийн хүмүүсийн дунд орших болно гэж Езекиелд хэлсэн аж. Хүмүүс өөрсдийнхөө алд-суудаас ичихийн тулд (ш. 11-ийг үз), мөн Их Эзэнд буцаж очих хүслийг тэдэнд төрүүлэхэд туслахын тулд түүнчлэн наманчлаагүй нүглийнхээ улмаас тэдний алдсан онцгой боломж ариун сүмийн адислалуудыг зохистойгоор хүртэхэд нь тэдэнд туслахын тулд үзсэн зүйлээ хүмүүст ярихыг бас түүнд хэлсэн ажээ.

Цэвэр ариун бус зүйл Езекиелийн үзсэн ариун сүмд орж, шүтэн биширч чадахгүй тухай Их Эзэний тодорхой үүрэг чиглэлийг Езекиел 44 дэвшүүлэн тавьдаг. Манай өнөө үед ариун сүмд орох хүмүүсийн хувьд Их Эзэн мөн ийм жишгийг тогтоосон билээ (С ба Г 97:15–17-г үз).

Езекиел 45–46

Ариун сүмийн тухай өөр зүйлүүд

Иудейчүүд өөрсдийн ариун сүмүүдэд гүйцэтгэдэг байсан зарим ёслолуудыг тэд Вавилонд боолчлолд аваачигдсан үедээ зохих ёсоор гүйцэтгэдэггүй байсан зэрэг ариун сүмтэй холбоотой зарим ёслолуудыг Их Эзэн цаашид дүрсэлснийг Езекиел 45–46 агуулдаг.

Езекиел 47

Ариун сүмийн эдгээгч ус

Иерусалим дахь ариун сүмийн доороос ус хэрхэн гарч, зүүн зүгт урсан, улам бүр томорсоор голын ус болох тухай Езекиелийн үзэгдлийг Езекиел 47 өгүүлдэг. Энэ гол Сөнөсөн Тэнгист цутгаж, үүнийг дахин “амьд” болгож, загас, ургамалтай болгох болно. “Иуда эргэж ирэх ёстой, Иерусалим, мөн ариун сүм дахин баригдах ёстой, мөн ариун сүмийн доороос гарсан ус, Сөнөсөн Тэнгисийн ус эдгээгдэх болно. Хотын хэрэмнүүд болон ариун сүмийг барихад нилээд хугацаа шаардагдах болно, . . . мөн энэ бүхэн Хүний Хүү өөрөө хүрч ирэхээс өмнө хийгдэх ёстой” гэж Бошиглогч Иосеф Смит хэлжээ (Teachings of the Prophet Joseph Smith, 286).

Энэ үйл явдал нь бас “амьд усны” эх сурвалж, бүр Есүс Христээс ирдэг ариун сүмийн ариун нандин, өөд өргөгч, хүч олгогч ёслолуудад оролцоход хувь хүмүүс хийгээд гэр бүлүүд сүнсний хувьд шинэчлэгдэж, дахин төрдгийн бэлэгдэл юм.

Езекиел 48

Израил цугларч, Эзэн тэдэнтэй хамт байна

Езекиел 47-гийн төгсгөлд, Езекиел эх нутагтаа цугларч буй Израилыг дүрсэлжээ. Овог бүр өөрсдийн өв болгон тус тусдаа нутаг хүлээн авч, Их Эзэн тэдний дунд амьдрах тухай Их Эзэн өгүүлснийг Езекиел 48 цэдэглэдэг.

Хэрэв танай шашин байдаггүй гадаад оронд та байгаа бол өөрийнхөө шашинд үнэнч итгэлтэй хэвээр байх нь таны хувьд хэр зэрэг хялбар байх бол? Хэрэв өөрийнхөө шашныг шүтэх нь тэнд байдаггүй зүйл, тэр ч байтугай улс орны хуулийн эсрэг зүйл хийхийг танаас шаардвал яах вэ?

Зоригт залуу эр

Даниел яг ийм нөхцөл байдалтай тулгарсан юм. Иудаг Вавилон анх эзлэхэд (ойролцоогоор МЭӨ 605 оны үед) өсвөр насны хөвгүүн Даниел бусад иудейчүүдийн хамт боолчлолд аваачигдсан аж. Даниел зоригтой, бас итгэлдээ үнэнч байсан учир, Их Эзэн түүнийг бошиглолын бэлэг хийгээд харийн нутаг дахь удирдагчдад нөлөөлөх нөлөөгөөр адисалжээ. Бид түүнд тохиолдсонтой адил төстэй дарамт шахалттай учирсан үед, түүнчлэн түүнд байсан тэрхүү эерэг нөлөөг бид өөрсдөдөө байлгахыг хүссэн үед түүний үлгэр жишээ бидэнд сүнслэг нөлөө, үлгэр дуурайл болно.

Даниелыг судлахад бэлтгэх нь

Даниелын Номон дахь гол хүмүүс

Даниел—Номыг бичжээ. Номыг эхлэхэд тэрээр залуу эр байсан бөгөөд номыг дуусгах үед ная гарсан байв.

Шадрах, Мешах, Абед-него—Шашиндаа үнэнч итгэлтэй байсан, Даниелын гурван иудей найз.

Небухаднезар—Ойролцоогоор МЭӨ 604 оноос МЭӨ 561 онд нас эцэслэх хүртлээ Вавилоны Эзэнт гүрний хаан байв. Тэр бол Иудаг эзэлж, олон иудейчүүдийг Вавилонд боолчлолд аваачсан хаан байлаа. Дэлгэрэнгүй мэдээллийг Судруудын Удирдамж, “Небухаднезар”-аас үз.

Белшазар—Эцгийнхээ дараа, персүүд Вавилоныг эзлэхээс өмнө захирч байсан Небухаднезарын хүү. Дэлгэрэнгүй мэдээллийг Судруудын Удирдамж, “Белшазар”-аас үз.

Кореш, Дари нар—Вавилоныг ойролцоогоор МЭӨ 539 онд эзэлсэн Mede-Персийн эзэнт гүрний захирагчид, Кореш эхлээд захирч байв. Тэр бол иудейчүүд эх орондоо эргэн очиж, ариун сүмээ дахин барьж болно хэмээн тогтоол гаргасан хаан юм.

Даниелын Номон дахь гол үйл явдлууд

- Даниел болон бусад иудейчүүд Мосегийн хуулийг (Даниел 1-ийг үз) зөрчихөд тэднийг хүргэх байсан зоог хүртэхээс татгалзав.
- Даниел зүүднүүд болон хаадад өгөгдсөн тэмдгүүдийг тайлав (Даниел 2; 4–5-ыг үз).
- Зоригт гурван залуу эр галт зууханд хаягдав (Даниел 3-ыг үз).
- Даниел арслангийн үүрэнд хаягдав (Даниел 6-г үз).
- Даниел өөрийн үеэс хойш дэлхийн төгсгөл хүртлэх ирээдүйн үйл явдлуудыг бошиглов (Даниел 7–12-ыг үз).

Даниел 1

Итгэлтэй залуу израилчууд

Илбэчид, мэргэ төлөгчид ирээдүйг мэдэх хүчтэй гэдэгт вавилончууд итгэдэг байжээ. Вавилоны хаан Небухаднезар олзлогдсон залуу израилчуудыг ирээдүйг харахад сургаж болох нь уу гэдгийг үзэхээр шийдсэн аж. Та нар уншихдаа, эдгээр залуу хүмүүсийн заримынх нь итгэлтэй байдал Их Эзэний адислалуудыг хэрхэн авчирч, хааны гайхлыг төрүүлснийг эрж ол.

Судруудыг ойлгох нь



Даниел 1

Тайганууд (ш. 3, 9–11)—Итгэмжлэгдсэн гэрийн үйлчлэгчид

Зурхайч нар (ш. 20)—Оддыг ажиглах замаар ирээдүйг угтан хэлдэг хэмээх хүмүүс

Судруудыг судлах нь



А Тэдний жишээг хэрэглэ

Даниел болон бусад залуу эрчүүд итгэлдээ үнэнч байхын, түүнчлэн Их Эзэн өөртөө итгэдэг хүмүүсийг хэрхэн адисалдгийн агуу жишээ болж чадна. Дараах нөхцөлүүдийг авч үзэн, Даниел 1-ээс өөрсдийн уншсан зүйл дээр тулгуурлан, шийдлийг санал болго:

1. Чамд бас танай ангийнханд чухал шалгалт ойртож байлаа. Тэдний зарим нь илүү удаан хугацаагаар хичээлээ үзэхийн тулд сэрүүн байлгах үрлэн эм уудаг аж. Тэд чамтайг энэ үрэлнээсээ уу гэжээ. Чи юу хэлэх буюу хийх вэ?
2. Чи анхныхаа ажилд саяхан ороод байлаа. Аятай сайхан сэтгэгдэл төрүүлэхийг чи хүсдэг. Албан газрын чухал үдэшлэг дээр хүн болгон даргатайгаа хундага тулгах ёстой байв. Чи яах вэ?

Б Биет болон сүнслийн адислалууд

Даниел болон түүний найз нарын адислагдсан замууд

1. Их Эзэнд итгэлтэй байснаа төлөө Даниел болон түүний найз нарын адислагдсан арга замуудыг жагсаа.
2. Эдгээр залуу хүмүүсийн хүлээн авсан адислалууд, манай өнөө үед Мэргэн Ухааны Үгийг дуулгавартай дагадаг хүмүүст амлагдсан адислалуудтай хэрхэн адилхан бэ? (С ба Г 89:18–21-ийг үз).

Даниел 2

Небухаднезарын зүүд

Дэлхий дэх олон хүмүүс бидэнд зөвлөгөө өгөх их хүсэлтэй байдаг. Небухаднезар Хаан өөрийн илбэчид, зурхайчдаас зөвлөгөө хүссэн боловч, түүнд үнэнийг хэлж чадах хүн ердөө ганцхан байсныг Даниел 2 заадаг. Энэ түүх Египетэд байсан Иосефт Эхлэл 41:14–43-т тохиолдсон зүйлтэй хэрхэн адилхан байгааг ажигла.

Небухаднезарын зүүд эцсийн өдрүүдэд Бурханы хаант улс байгуулагдах тухай бошиглодог учраас бидний хувьд чухал ач холбогдолтой юм.



Судруудыг ойлгох нь



Даниел 2

Нойр нь хулжих (ш. 1)— Унтаж чадахгүй болох

Илбэчид, зурхайчид, мэргэ төлөгчид, халдеичууд (ш. 2)—Илбэ үзүүлж ирээдүйг

болон зүүдний утгыг тайлж мэддэг хэмээгддэг хүмүүс

Хивэг (ш. 35)—Үр тарианы гадуурх хальс (улаан буудай, арвай мэтийн)

Даниел 2:45—“Гар хүрэлгүйгээр уулнаас цавчигдсан нэгэн чулуу”

Бусад бүх хаант улсуудтай адилгүй нь, чулуугаар төлөөлөгдсөн Бурханы хаант улс Бурханаар үндэслэгдэн байгуулагдах болно гэдгийг Даниел тайлбарлажээ. “Гар хүрэлгүйгээр” гэсэн нь хүний гар хүрэлгүйгээр гэсэн утгатай ажээ.

Небухаднезарын зүүд



ТӨЛӨӨЛӨГДСӨН ХААНТ УЛСУУД

Шижир алтан толгой
Вавилоны эзэнт гүрэн

Мөнгөн цээж, гар
Мед-Персийн эзэнт гүрэн

Гуулин гэдэс ба гуя
Македоны эзэнт гүрэн

Төмөр хөл
Ромын эзэнт гүрэн

Шавар тавхай ба хөлийн хуруунууд
Ромын эзэнт гүрний уналтын дараа үүсэн бий болох хаант улсууд

Судруудыг судлах нь



А Доорх өгүүлбэрүүдийг төгсгө

1. Зурхайчид болон илбэчид Небухаднезарын зүүдийг тайлахаас өмнө, эхлээд . . . ёстой гэж тэр хэлэв.
2. Хааны зүүдний утга нь . . . болохыг Даниел мэджээ.
3. Даниел . . . тайллыг оллоо гэж хаанд хэлэв
4. Даниел . . . тайллыг хаанд хэлсний дараа . . .

Б Төгс Эзэмших Судар—Даниел 2:44–45

1. Дэлхий дээрх Бурханы хаант улс болох хожмын өдрүүдийн Сүмийг Даниел 2:44–45 бэлгэддэг. Энэ хоёр шүлгэн дэх санаануудыг төлөөлсөн үзүүлэнгийн төсөл гарга. Үзүүлэнгийн ар талд зургийнхаа тайлбарыг бич.
2. Сургаал ба Гэрээ 65:1–2, 5–6-г уншиж, Даниелын харсан чулуутай Сүм хэрхэн адилхан болох тухай, түүнчлэн Сүм 1830 онд зургаан гишүүнтэйгээр эхэлсэн цагаас хойш түүнд тохиолдсон зүйлийн тухай бич.
3. Та нар дээрх “Судруудыг ойлгох нь” хэсэг дэх схемийг ашиглан, бэлгэдлүүдийн утгыг судрууддаа тэмдэглэхийг хүсэж болох юм.

Даниел 3

Эрэлхэг зоригт гурван залуу эр



Абед-него нар ийм л агуу итгэлтэй байсан юм.

Та нарт аягүй санагдаг галанд хэзээ нэгэн цагт нилээд их ойртож үзсэн үү? Та нар галд түлэгдэж үзсэн үү? Хэрэв тэгсэн бол, галд хаягдах нь хичнээн аймаар болохыг та нар ойлгож чадна. Ингээд, Бурхан та нарт заасан зүйлийн эсрэг явахын оронд галтай зуух уруу ороход бэлэн байх тийм итгэл та нарт байх учиртайг төсөөлөн бод. Шадрах, Мешах,

Итгэлээ харуулах нь

- Сургууль дээр
- Олон нийтийн дунд
- Найз нарынхаа дунд

Заримдаа өнөө үеийн Сүмийн гишүүд дэлхийн зүйлүүдийн өмнө бөхөлзөх буюу өөрөөр хэлбэл, дэлхийн хараанд хүлээн зөвшөөрөгдөхүйц байхын тулд өөрсдийн жишгийг доогуурт тавих нь байдаг. Өнөөдөр Сүмийн гишүүд Шадрах, Мешах, Абед-него нарын итгэлийг харуулж болно гэж өөрийнхөө боддог, дараах газар бүрд нэг жишээ гарга: (1) сургууль дээр, (2) олон нийтийн дунд, (3) найз нарынхаа дунд.

В Өөрийнхөө үгээр

1. Даниел 3:17–18-д гурван залуу эр юу гэж хэлснийг өөрийнхөө үгээр бич.
2. Юуны тухайд залуу эрчүүд итгэлгүй, юуны тухайд итгэлтэй байсан бэ?
3. Шадрах, Мешах, Абед-него нарын хэлсэн, хийсэн зүйлүүд дээр тулгуурлан, тэдний гэрчлэлүүдийн хамгийн чухал, хамгийн хүчирхэг бүрдүүлбэр нь юу байсан гэж та нар хэлэх вэ?
4. Хэрэв та нар Шадрах, Мешах, Абед-него нартай ярилцаж чадлаа гэхэд, тэднээс ямар асуултууд асуух вэ, мөн яагаад?

Судруудыг ойлгох нь



Даниел 3

Тохой (ш. 1)—Уртын хэмжүүр

Нэгэнт ийм болсон бол (ш. 17)—Хэрэв бид зууханд хаягдах болсон бол

Өөрсдийн биеийг тушаан (ш. 28)—Амь насаараа аз туршин

Судруудыг судлах нь



А Асуудлыг тайлбарла

1. Небухаднезар хүн бүрд юу хийхийг тушаасан бэ, мөн энэ нь яагаад буруу байсан бэ? (Египетээс Гарсан нь 20:1–6-г үз).
2. Бага итгэлтэй иудейчүүд уг түүхийн эхлэлд тэднийг галт зууханд хаяхаас өмнө Шадрах, Мешах, Абед-него нарт юу гэж хэлж болох байсан гэж та нар бодож байна? Тэр гурав хариуд нь юу гэж хэлэх байсан гэж та нар боддог вэ?

Б Өнөө үеийн жишээ хэл

Даниел 4–5

Бардам зант хоёр хаан

Небухаднезар дахин бардам болсон учраас, Бурхан түүнд бас нэг зүүд өгснийг Даниел 4 цэдэглэсэн байдаг. Даниел дахиад л зүүдийг нь тайлж. Зөвхөн Тэнгэрийн хаан л үүнийг түүнд зөвшөөрсөн учир тэрээр агуу эзэнт гүрний хаан байгааг Их Эзэн Небухаднезарт заасан ажээ.

Даниел 4–5-ын хооронд хорь гаруй жил өнгөрч, Белишазар хэмээх шинэ хаан Вавилонд гарч ирэв. Тэр бас л ихэд бардам зантай бөгөөд өөрийнхөө ордонд болсон нэгэн их найр дээр Израилын Бурханаар тохуурхжээ. Нэг гар гарч ирэн, ханан дээр бичсэн гэнэ. Даниел бичээсийг хөрвүүлж, энэ нь Вавилон унах болно хэмээн хэлсэн аж. Тэр шөнө медечүүд болон персүүд Вавилоныг эзэлсэн аж.

Даниел 6

Даниел арслангийн үүрэнд



Даниелыг ойролцоогоор наян настай байхад Даниел 6 бичигджээ. Даниел хэдийгээр Вавилоны хаадын зөвлөх байсан ч гэсэн, тэрээр бас Вавилоныг байлдан дагуулсан Мède-Персийн эзэнт гүрний хаадын зөвлөх болжээ.

Даниелын дайснууд

түүнийг устгахыг хэрхэн хичээж байсныг хийгээд итгэлийнх нь улмаас Их Эзэн түүнийг хэрхэн үргэлж адисалж байсныг эрж ол.

2. 1 Нифай 1:20; Алма 30:60-ыг унш. Эдгээр судрууд дахь зарчмууд хэнд, хэрхэн, Даниел 6 дахь түүхэнд холбогдох вэ?

Даниел 7–12

Даниелын бошиглалын зүүднүүд ба үзэгдлүүд

Өөрийнх нь хүмүүст, Израилын угсаанд, түүнчлэн дэлхийд юу тохиох тухай Даниелын нилээд хэдэн үзэгдлийн тухай цэдгийг Даниел 7–12 агуулдаг. Доорх хүснэгтэд харуулснаар, Даниелын зарим үзэгдэл Даниел 2 дахь Небухаднезарын зүүдтэй адил утгатай байжээ. Даниелын харсан бүхний утгыг Их Эзэн бидэнд хараахан илчлээгүй байгаа билээ.

Судруудыг ойлгох нь



Даниел 6

Тамган бөгж (ш. 17)—Дээр нь эрх мэдлийн тэмдэг сийлсэн бөгж

Хаанчлал (ш. 26)—Хааны эзэнт гүрэн

Судруудыг судлах нь



А Түүхийг дахин ярь

Даниел 6-гийн түүхийг бага насны хүүхэд ойлгохоор бич.

Б Бид ийнхүү ойлгодог

Даниел 6 дахь шийдвэрүүд

- Хаан юу хийсэн бэ
- Бусад ерөнхийлөгчид, хунтайж нар юу хийсэн бэ
- Даниел юу хийсэн бэ

1. Даниел 6-г бүгдийг нь нэгтгэн дүгнэж, хаан юу хийснийг, бусад ерөнхийлөгчид болон хунтайж нар юу хийснийг, мөн Даниел юу хийснийг эрж ол. Өөрсдийнх нь шийдвэрүүдийн улмаас тэдний хүн нэг бүрд юу тохиолдсон тухай бич.

Даниелын үзэгдэл дэх хаант улсууд

	Даниел 2	Даниел 7	Даниел 8	Даниел 11–12
Вавилон	Алтан толгой Ш. 32, 37–38-ыг үз	Арслан Ш. 4-ийг үз		
Мède-Перс	Мөнгөн цээж, гар Ш. 32, 39-ийг үз	Баавгай Ш. 5-ыг үз	Хуц Ш. 3–4, 20-ийг үз	11:1–2-ыг үз
Грек-Македон	Гуулин гэдэс, гуя Ш. 32, 39-ийг үз	Ирвэс Ш. 6–7-г үз	Ямаа Ш. 5–8, 21–22-ыг үз	11:3–20-ийг үз
Ром	Төмөр хөл Ш. 33, 40-ийг үз.	Аймшигт араатан Ш. 7, 19-ийг үз		
Олон хаант улс	Төмөр буюу шавар тавхай, хөлийн хуруунууд Ш. 33, 41–43-ыг үз	Арван эвэр Ш. 7–8, 20-ийг үз		
Хожмын өдрүүд дэх Бурханы хаант улс	Чулуу Ш. 34–35, 44–45-ыг үз	Адам ба Есус Христ Ш. 9–14, 22–28-ыг үз		12:1–3-ыг үз
Христийн эсрэг их гүрэн		Арван эврийн дундах жижиг эвэр Ш. 8, 20–22-ыг үз	Дөрвөн толгойн жижигхэн эвэр Ш. 9–12-ыг үз	11:21–45-ыг үз

Хосеагийн Ном

Түүхэн үндэс

Хосеа яг хэзээ амьдарч, номлож байсныг бид мэдэхгүй ч гэсэн, тэрээр ойролцоогоор МЭӨ 760–20 оны хооронд амьдарч байсныг түүний бичээсүүд өгүүлдэг. Энэ нь тэрээр Исаиа, Мика, магадгүй Амоштай нэгэн цаг үед амьдарч байжээ гэсэн үг. МЭӨ 722 онд ассиричууд эзэлж, авч явсан Умард Хаант Улсад түүний захиас ерөнхийдөө чиглэсэн байдаг. Умард

Хаант Улсын хүмүүс ёс бус болох нь—ялангуяа хуурамч бурхан Баалыг шүтэн бишрэх нь улам нэмэгдсээр байлаа. Хиймэл шүтээн шүтэгч энэ шашин ёс суртахуунгүй үйлдлүүдийг “ариун” ёслолуудын нэг хэсэг болгосон тийм ёс бус байсан аж. Эдгээр зуршлууд Бурханы өмнө нэн жигшүүртэй байсан бөгөөд, эдгээрийн улмаас Хосеа ийм хүчтэй, ил тод бэлгэдэл хийгээд сургамжуудыг ашигладаг байсан биз ээ.

Хайрын түүх



Хосеагийн ном нэгэн гэрлэлтээр эхэлдэг. Хэдийгээр уг гэрлэлт бид бүгдийн хүсэн хүлээдэг гэрлэлт биш ч гэсэн, энэ түүх ийм байдлаар өгүүлэгдсэн нь үнэнхүү гайхамшигтай байдлаар харуулсан хайрыг бид харж чадна. Хосеа бол нөхөр, гэвч “жинхэнэ” нөхөр нь Их Эзэн, харин эхнэр нь Израилын хүүхдүүд гэдгийг уг түүх өгүүлдэг.

Гэрлэлт нь өөрийн хүмүүстэй хийсэн Их Эзэний гэрээг төлөөлдөг. Уг түүх өөрийн хүүхдүүдийг хайрлах Их Эзэний хайр болон гэдэнтэй хийсэн өөрийн гэрээнүүдэд тэрээр шийдвэр төгс байдаг тухай, Бурхантай хийсэн өөрсдийн гэрээнүүдийг сахих хийгээд эрт үед болон өнөөдөр хиймэл шүтээний бүх төрлөөс зайлсхийхэд Израилын хүүхдүүдийн хүлээх хариуцлагыг дүрсэлдэг.

Бэлгэдлүүдээр заах нь

Хосеа өөрийн захиасыг заахын тулд олон дүрслэл болон бэлгэдлүүдийг ашигласан байдаг. Жишээ нь, тэрээр нөхөр, эцэг, арслан, ирвэс, эм баавгай, шүүдэр, бороог Их Эзэний бэлгэдлүүдийг болгон ашиглажээ. Мөн тэрээр Израилыг төлөөлөхийн тулд эхнэр, өвчтэй хүн, усан үзмийн ороонго, усан үзэм, чидуны модод, хүүхэд төрүүлэх эмэгтэй, өглөөний манан болон бусад бэлгэдлүүдийг ашиглажээ. Тэр ч байтугай *Хосеа* гэдэг нэр бэлгэдлийн юм. Энэ нэр *Иошуа* гэдэг еврей үгтэй үндэс нэг бөгөөд энэ нь *Есүсийн* еврей нэр юм. Түүний захиас Есүс Христийн Цагаатгалын тухай мэдэж, үүний хүчийг илүү гүнзгий мэдрэхэд бидэнд тусалж чадах учраас Хосеагийн нэр оновчтой юм. Хосеагийн хүүхдүүдийн нэр зэрэг, энэ номон дахь бусад нэрнүүд бас бэлгэдлийн утгатай ажээ.

Хосеа 1–3

Гэрлэлтийн гэрээ

Иеремиа Езекиел нарын амьдралд үйлдсэн нэгэн адил, Их Эзэн бошиглогч Хосеагийн амьдралыг нэгэн хүчирхэг хичээлийг бэлгэдлээр заахад ашиглажээ. Израилтай тогтоосон өөрийн гэрээний харилцааг Их Эзэн гэрлэлтийн харилцаатай зүйрлүүлдэг байсныг та нар санах юм бол, утгыг нь илүү сайн ойлгох нэгэн түүхийг Хосеа 1–3 агуулдаг. Израилчуудын шүтдэг байсан хиймэл шүтээн ёс суртахуунгүй хэрэг явдлыг янхнуудтай үйлдэхэд бас оролцдог байсан учраас Хосеагийн номонд хийсэн харьцуулалт бүр ч оновчтой юм. Зүүвэр тайлбаруудад энэ түүхийн зарим нэрнүүд, үгс, өгүүлбэрүүдийн утгыг эрж олох нь Хосеагаар дамжуулан өгсөн Их Эзэний захиасыг ойлгоход бас та нарт туслах болно.

Та нар уншихдаа, өөрийгөө Хосеагийн байранд тавьж, түүний хийснийг хийвэл юу болох тухай төсөөлөн бод. Хэрэв та нар Гомер байсан бол юу гэж бодох байснаа бас төсөөлөн бодохыг хүсэж болно. Хосеа Их Эзэнийг, харин Гомер Израилыг төлөөлдгийг сана.

Судруудыг ойлгох нь



Хосеа 1:2–3—Үнэхээр садар эмтэй гэрлэ гэж Их Эзэн Хосеад хэлсэн үү?

“Хосеагийн гэрлэлтүүдийн тухай зохиогчийн тайлбар эсвэл бусад зарим зүйлийг хүлээн зөвшөөрөх юм бол бүлэг 1–3-ын шашны ач холбогдол нилээд тодорхой юм. Иеховагийн итгэл эвдэгч, садар эхнэр Израил садар самуун байдлаар орхиж, тэрээр эрс огцом шинэчлэлт хийх шаардлагатай Израилыг Хосеагийн эхнэрүүд төлөөлж байлаа. Үлэмж их нүглүүдийнхээ улмаас тэрээр шалгагдаж, шийтгэгдэх бөгөөд ийнхүү нөхөр нь түүний хувьд өөрийнх нь анх бодож байснаас бүр илүү гашуун туршлага, сургаамж өгөх нь гэдгийг тэр мэдэх болно” (Sidney B.Sperry, *The Voice of Israelites Prophets* [1952], 282).

Хосеагийн номны захиасыг зөвөөр ойлгохын тулд, Хосеа энэ түүхэнд дүрслэгдсэн зүйлийг жинхэнээр үйлдэхийн тулд ямар хүч чадал түүнд байсныг бид авч үзэх ёстой.

Хосеа 3

Омер (ш. 2)—Хэмжүүрийн нэгж

Ефод, гэрийн шүтээн (ш. 4)—Энэ тохиолдолд, хиймэл шүтээнтэй холбоотой зүйлүүд

Судруудыг судлах нь



А бэлгэдлийг тайлбарла

1. Хэрэв Хосеа Их Эзэнийг, Гомер Израилыг төлөөлдөг бол, Хосеа 1-ийн захиас юу вэ?
2. Гомер яагаад хиймэл шүтээнүүдийнхээ хойноос явсныг Хосеа 2:5 тайлбарладаг. Эдгээр шалтгаанууд өнөөдөр гэрээнүүдээ зөрчсөн хүмүүсийн шалтгаануудтай хэр зэрэг адилхан байна вэ?
3. Хосеа 2:7-д Гомерын хэлсэн зүйл, ялангуяа энэ нь өнөөдөр нүгэлд байгаа хүнтэй холбогдоход яагаад чухал гэж бодож байгаагаа тайлбарла (Алма 30:60; 41:10-ыг үз).
4. Израилын (Гомер) хийсэн зүйлийн улмаас Их Эзэн түүний төлөө юу хийхийг Хосеа 2:1–13 өгүүлдэг. Эдгээр амлалтуудыг жагсааж, эдгээр нь хэрхэн түүнийг хайрлах хайрын илэрхийлэл болохыг тайлбарла (С ба Г 95:1-ийг үз).

Б “Нааш хүрч ир”

1. “Хайрлагч, өршөөгч Бурханы дүр төрх судруудыг уншиж, ойлгодог хүмүүст тод томруунаар ирдэг. Гэрбээр бидний Эцэг учраас, биднийг доош нь түлэх биш, бидний сүнсний үхлийг тохиолгон авчрахыг биш, харин биднийг өсгөн өндийлгөхийг, аж төрөхөд бидэнд туслахыг хүсдэг нь жам ёсны юм” хэмээн Ахлагч Спенсер В.Кимбалл хэлжээ (*The Miracle of Forgiveness* [1969], 344). Ахлагч Кимбаллын хэлсэн үнэнийг дүрсэлсэн хоёр жишээг Хосеа 2:14–23-аас сонгож, сонгосон шүлгийн юу нь өөрт чинь гүнзгий сэтгэгдэл төрүүлснийг тайлбарла.

- Их Эзэн өөртөө ирэхийг бидэнд ухуулдгийг харуулах өөрсдийн мэдэх зарим арга замыг Хосеа 2:14-аас жагсаа.
- Гомерын түүхэнд, түүний гаргасан алдаанууд түүнийг ямар нэг байдлаар хүлээс буюу боолчлолд оруулахтай адил байлаа. Иймээс, бүр Гомер (Израил) Хосеа дээр (Их Эзэн) эргэж ирэхийг хүслээ ч гэсэн, чадахгүй байв. Мөн энэ нь нүгэлд байгаа хүмүүсийн хувьд яг адил байдаг. Тэд дангаараа өөрсдийгөө нүглийн хүлээснээс чөлөөлөх чадваргүй байдаг. Хосеа 3:2–5-д өгүүлснээр, Их Эзэн өөрийн хүмүүсийн төлөө хийдэг зүйлийг бэлгэдсэн ямар зүйлийг Хосеа Гомерын төлөө хийсэн бэ?
- Мөн 1 Коринт 6:19–20; 1 Петр 1:18–20-ийг уншиж, эдгээр шүлгүүд Гомерын төлөө Хосеагийн хийсэн зүйлтэй хэрхэн холбогдохыг ярь.
- Хосеа 3:3–5-д өгүүлснээр, өөрийнх нь төлөө Хосеагийн хийсэн зүйлийг Гомер хүлээн авахын тулд юу хийхийг бодож байсан бэ?
- Лук 10:25–27, Мозая 2:21–24-т өгүүлснээр, Их Эзэн бидний төлөө хийсэн зүйлийг хүлээн авахын тулд бид юу хийх ёстой вэ? (С ба Г 59:8-ыг үз).

Хосеа 4–5

Израил Иуда хоёрын нүгэл

Их Эзэн Израилын хүүхдүүдийн нүглийг хаана тогтоосныг Хосеа 4–5 тэмдэглэжээ. Тэрээр Умард Хаант Улсыг удирдаж байсан овгийн нэрээр “Ефраим,” Өмнөд Хаант Улсыг өөрсдийн хааны овгоор “Иуда” хэмээн нэрлэжээ.

Хосеа 6

Бурхан чин сэтгэлийн наманчлалыг хүсдэг

Заримдаа хүмүүс нүгэл үйлдэж, тэгээд нүглүүдээ арилгахын тулд уучлал гуйж, хэдэн залбирал хэлээд, аравны нэгээ төлж, Сүмийн бүх цуглаануудад оролцох гэхчлэн хэдэн онцгой зүйл хийж болно гэж боддог. Эдгээр зүйлүүд чухал нь тодорхой ч гэсэн, наманчлал бол маш гүнзгий үйл явц юм. Наманчлал бол бидний нүглүүдийн төлөө гүнзгий уй гашууг авчирдаг харууссан зүрх, гэмисэн сэтгэл юм (3 Нифай 9:20-ийг үз). Хэрэв бид ийм байдлаар чин сэтгэлээсээ наманчилж, Их Эзэнтэй хийсэн гэрээнүүдээ шинэчлэх юм бол, Сүнс бидэнд ухамсрын амар амгаланг авчран, нүгэл үйлдэх хүслийг орхиход бидэнд тусалж, Их Эзэнд бид хэрхэн ойр дөт байхаа үргэлжлүүлэхийг бидэнд зааж, өөрсдийнхөө хийсэн

гэрээнүүдийг сахих хүч чадлыг бидэнд өгч, биднийг ариусгах болно.

Хосеа 6:1–3 нь тэд наманчлахад хичнээн хурдан найдсан тухай Израилын хүүхдүүдийн илэрхийлэл бололтой. Энэ богинохон бүлгийн үлдсэн хэсэг нь тэдний зан төлөв дэх гутралд Их Эзэний өгсөн хариуг өгүүлдэг. Шүлэг 6 нь дотоод сэтгэлийн зөв шударга байдал, шашны гадна талын зан үйлүүдийн төлөөх Их Эзэний хүслийг илэрхийлдэг.

Хосеа 7–10

Израил юу тарина, түүнийгээ хурааж авна

Их Эзэн Ефраимд (Израилын Умард Хаант Улс) тэдний нүглүүдийн тухай ярьсныг Хосеа 7–10 үздэг. “Эргүүлэгдээгүй талх” (7:8), “тэнэг тагтаа” (7:11), “орь ганц хулан мэт” (8:9), “цөл дэх усан үзэм” (цөл; 9:10), “саглагар усан үзмийн мод” (10:1) зэрэг олон зүйрлэлийг тэрээр тэдний нөхцөл байдал болгон ашигласан байдаг.

Ефраимын (Израилын Умард Хаант Улс) хүмүүс бүр өөрсдийг нь аварч эс чадах бурхдыг бүтээж, тэднийг шүтэн биширч байсан нь Их Эзэний үндсэн гол захиас байлаа. Ефраим эдгээр бурхад хүчгүйг мэдээд, үнэн Бурхан уруу эргэж, өөрсдийг нь аврахыг түүнээс хүсэн хүлээсэнд тэрээр туслахад удаан байсан аж, тэгэхээр нь тэд тэр бол хүчирхэг Бурхан биш байна гэгцээж, бүр түүнийг орхиноороо уй гашуу, устгалыг өөрсөд дээрээ авчирчээ. Их Эзэний захиасыг сайн хураангуйлан дүгнэхийн тулд Хосеа 10:13-ыг үз.

Хосеа 11

Бурханы хайрын нотолгоо

Мосегийн үед тэрээр тэднийг Египетээс хэрхэн нигүүлсэнгүйгээр гэтэлгэснийг Ефраимд (Умард Хаант Улс) сануулсан Их Эзэний сануулгыг Хосеа 11 агуулдаг. Гэвч тэд түүнийг бүрэн дагасангүй, мөн эдүгээ тэднийг хамгаалахын тулд Египетээс удирдан гаргасан Их Эзэнд итгэхийн оронд Ассириас хамгаалал эрж, Египет рүү буцахыг зарим нь хүсэж буй ажээ. Бүр ийм урван тэрслэлт байсан ч гэсэн, тэрээр тэдэнд нигүүлслийг санал болгосоор байх болно гэдгийг Их Эзэн хэлжээ. Тэрээр Ефраимыг боолчлолд аваахыг Ассирид зөвшөөрсөн хэдий ч, тэднийг бүрмөсөн устгахыг тэдэнд зөвшөөрөөгүй гэдгээ хэлсэн ажээ.

Хосеа 12–14

Их Эзэнд эргэж ирэх дуудлага

Хосеа 12–14 бол Хосеагийн бичээсүүдийн сүүлчийн бүлгүүд юм. Бүлэг 12–14-т Их Эзэн Ефраимын нүгэл болон тэдгээрийн сэтгэл өөтгөл үр дагавруудын тухай

ярихаа үргэлжлүүлдэг. Гэвч Их Эзэний сүүлчийн захиас нь нүгэлд байгаа өөрийнхөө хүүхдүүдийн төлөөх найдвар хийгээд хайрын захиас юм (Хосеа 13:9–14; 14-ийг үз).

Судруудыг судлах нь

А Та нарт хамгийн их сэтгэгдэл төрүүлсэн зүйл юу вэ?

Хэрхэн наманчлах хийгээд хэрэв бид наманчлах юм бол Их Эзэн юу хийх тухай Хосеа 13:9–14; 14 дэх өөрт чинь хамгийн их сэтгэгдэл төрүүлсэн нийлмэл үг, шүлэг буюу санааны тухай бич.

Иоелын Ном

Иоел бол Иудагийн бошиглогч байжээ. Иоелын ном бол наманчилснаар тэд Бурханы адислалуудыг олж авах болно гэсэн итгэлийг хүмүүст төрүүлдэг бошиглол юм. Бид бошиглогч Иоелын тухай маш бага зүйл мэднэ. Иоел 1:1 түүний эцгийн нэрийг бидэнд хэлдэг хэдий ч, түүний хувийн амьдралын тухай өөр ямар ч мэдээлэл байдаггүй. Энэ номыг бичсэн Иоел бол Библид өөр хаа нэгтээ дурдагддаг Иоел биш бололтой. Иоел Ассири Вавилон үндэстнүүдийг дурдаагүй учраас, тэрээр хэзээ амьдарч, бичиж байсныг хэлэх нь хэцүү юм. Гэвч тэрээр Иуда орныг мэддэг байсан бололтой, иймээс тэр тэнд бошиглож байсан гэж бид боддог.

“ЭЗЭНий өдөр”

Иоелын захиас “ЭЗЭНий өдөр” (Иоел 1:15; 2:1; 2:11; 2:31; 3:14) хэмээн түүний нэрлэсэн зүйл дээр төвлөрдөг. “ЭЗЭНий өдөр” нь Их Эзэн шагналууд болоод шийтгэлүүдийг тохиолгон авчрах шүүлтийн өдөр буюу цагт хамаардаг ажээ. Бид Хоёр дахь Ирэлтийг Их Эзэний өдөр хэмээн олонтаа нэрлэдэг бол, бас Их Эзэний өөр өдрүүд байдаг. Жишээ нь, Израилыг ассиричууд эзэлж авах үед Израил дээр Их Эзэний шүүлтийн өдөр байлаа. Хувь хүний түвшинд бол Их Эзэний өдөр нь түүний нас барах өдөр байж болно.

Хожмын үед холбогдох нь

Хэдийгээр Иоелын бошиглолууд түүний үе болон түүний үеийн хүмүүст холбогдолтой ч гэсэн, Иоел 2:28–32 дахь хэсэг “удахгүй” гүйцэлдэх болно хэмээн Моронай Иосеф Смитэд хэлсэн байдаг (ИС—Т 1:41). Иймээс, Иоелын бошиглолууд манай үед, ялангуяа “Их Эзэний өдөр” хэмээн бидний олонтаа нэрлэдэг Есүс Христийн Хоёр дахь Ирэлтэд холбогдох учиртайг бид авч үзэх ёстой.

Иоел 1

Голионы дайралтаас суралц

Байгалийн гамигуудын айдас төрүүлэм, хянагдашгүй хүчний өмнө бид тулгарсан үед өөрсдийн сул дорой байдал, хүчин мөхөсдөлтийг яах аргагүй мэдэрдэг. Байгалийн нэг гамшиг—голионы тахлыг ашиглан, хэрэв тэд “Их Эзэний өдөр” ирж, ёс бусчууд шүүгдэхээс өмнө наманчлахгүй бол тэд ийнхүү хүчин мөхөсдөх тухай хүмүүст Иоелын заасан тодорхой дүрслэлтэй сургамжийг Иоел 1 агуулдаг. Тэрээр голионы дайралтыг нутагт нь дайран орж ирж, Бурханы шийтгэлийн нэг хэсэг болгон наманчилдаггүй хүмүүсийг устгах цэргийн дайралттай өвөрмөц байдлаар зүйрлүүлжээ. Ийм маягийн шүүлтүүд бас эцсийн өдрүүдийн хувьд бошиглогдсон билээ (С ба Г 5:19; 45:31; 87-г үз). Эцсийн өдрүүдэд “ариун газруудад зогсохыг” (С ба Г 45:32) Их Эзэн Гэгээнтнүүдэд зарлигласан лугаа адил, өөрсдийнхөө хэцүү хүнд цаг үед Их Эзэний өргөөнд мацаг барилт хийгээд залбирлаар цугларахыг Иоел хүмүүст санал болгожээ.

Иоел 2

Тэр Өдрийг хэн тэсэн гарч чадах вэ?

Аврагчийн Хоёр дахь Ирэлтийн тухай хүмүүс айдас хүүдэстэйгээр бодох нь олонтаа тохиолддог. Гэвч “зөв шударгыг үйлдэгчид айх хэрэггүй” (1 Нифай 22:17) гэж Их Эзэн хэлсэн билээ. “Зөв шударга хүмүүсийн хувьд энэ нь аймшиг хийгээд айдсын өдөр байхгүй” хэмээн Жозеф Фиелдинг Смит нэмж хэлсэн байдаг. (Doctrines of Salvation, түүвэрлэсэн, Брус Р.МкКонки, 3 боть, [1954–56], 1:173). Иоел 2 зарим хүмүүсийг айхад хүргэдэг бараан баргар зарим бошиглолыг цэдэглэсэн байдаг. Та нар уншихдаа, эцсийн өдрүүдэд, түүнчлэн Их Эзэний Хоёр дахь Ирэлтийн үед та нарыг урамшуулан дэмжиж, та нарт найдвар төрүүлэх юуг Их Эзэн хийхийг бас эрж ол.

Судруудыг ойлгох нь

Иоел 2

Өв (ш. 17)—Хүүхдүүд

Судруудыг судлах нь

А Иоелын асуултад хариул

ЭЗЭНий өдрийг хэн тэсэн гарч чадах вэ?

Иоел 2-ын эхний арван шүлэг “ЭЗЭНий өдрөөр” тохиох аймшигтай устгалуудыг дүрсэлдэг. Ийм бараан баргар, аймшигтай бошиглолуудыг уншсаны дараа бид тунгаан бодвол зохих нэг асуултыг шүлэг 11 асуусан байдаг. Иоел

2:12–20; Сургаал ба Гэрээ 45:57-г уншсаны дараа, Иоел 2:11-ийн төгсгөл дэх асуултын хариуг бич.

Б Хожмын үеийн нэг бошиглол

Иоел 2:28–32; Иосеф Смит—Түүх 1:41-ийг унш. Энэ бошиглол ямар арга замуудаар гүйцэлдсэнийг та нар харсан бэ?

Иоел 3

Агуу тулалдаан

Иоел 3 нь их хэмжээгээр хожмын өдрүүдэд холбогддог. Хэрэг дээрээ, энэ нь Аврагчийн Хоёр дахь Ирэлтийн өмнө тохиох, судруудад Армагеддон хэмээн олонтаа дурдагддаг тулалдааныг дүрсэлсэн бололтой. Армагеддон бол бүх үндэстнүүд Их Эзэний хүмүүсийн эсрэг тулалдаж, мөн Их Эзэн өөрийн хүмүүсийн төлөө тулалдаж тэднийг ялахад туслах тулалдаан юм. Уг тулалдаан нь Мянган Жилийн өмнөх ёс бусчуудын шүүлт, устгалын нэг хэсэг юм.

Судруудыг судлах нь

А Дайнд ялах нь

Армагеддоны тулалдаан бол Их Эзэний хүмүүс дайн тулалдаанд байх буюу оролцох ганцхан цаг үе биш гэдэг нь тодорхой гэдгийг бид мартаж өсгүй. Хэрэг дээрээ, Сатантай хийх бидний дайн мөнх бус байдлын өмнөх амьдралд эхэлсэн юм (Илчлэлт 12:7–11-ийг үз). Тэр үед Сатан хөөгдсөн хэдий ч, өдий хүртэл “Бурханы гэгээнтнүүдтэй дайтсаар байгаа” (С ба Г 76:29) билээ. Энэ дайн бол мөнхийн үр дагавартай бөгөөд, Хоёр дахь Ирэлтийн цаг ойртох тутам, Сатан хүмүүсийг биет дайнд өдөөн хатгах төдийгүй, бас Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүдийг сүнслэг байдлын хувьд устгах тулалдаанаа үргэлжлүүлсээр байх болно гэдгийг бид санах ёстой. Ингэхлээр бид Армагеддоныг Аврагчийн ирэлтийн тэмдгүүдийн нэг гэж үзэхийн хамт, бид хилэнцэт хүчнүүдийн эсрэг агуу тулалдаанд аль хэдийнээс оролцож байгааг мартаж өсгүй, мөн бид энэхүү хүч чармайлтад зоригтой байх ёстой. Иоел 3:16–21; 1 Нифай 14:11–14; 22:16–17-г уншиж, эцсийн өдрүүдэд Их Эзэн биет хийгээд сүнсний дайнуудад өөрийн хүмүүст хэрхэн туслахаар амласныг тайлбарла.

Амосын Ном

Амар амгалан, цэцэглэл хөгжилтийн бошиглогч

Амос МЭӨ 760–50 онуудын орчим Умард Хаант Улсад, бошиглогч Хосеатай ойролцоо үед бошиглож байжээ. Тэр үед Израилын Умард Хаант Улс амар амгалан, цэцэглэл хөгжилтийн үед байлаа. Гэвч бүх хүмүүс цэцэглэл хөгжилтийг хуваалцаж байсангүй, учир нь зарим хүмүүс Их Эзэний хуулиудыг үл тоомсорлох замаар маш баян болсон байхад бусад нь улам ядуурсан аж. Түүнээс гадна, үндэстний ихэнх нь, түүний дотор хаад хиймэл шүтээнийг шүтэхэд оролцож, цөөн хэдхэн хүмүүс л зарлигуудыг сахьж байлаа. Нүглүүдээ наманчлахыг хүмүүст зарлиглахын тулд Их Эзэн Амосыг илгээжээ.

Гарал байдал

Амос бол жижигхэн хотын энгийн хоньчин байсан хэдий ч, Сайн мэдээний зарчмуудыг бид амьдралдаа хэрэглэх тухай, бардам зантай хүмүүс дээр ирэх Бурханы шүүлтүүдийн тухай

хүчирхэг бөгөөд чухал захиас түүнд байлаа. Амосын тухай дэлгэрэнгүй мэдээллийг Судруудын Удирдамж, “Амос”-оос үз.

Амос 1–2

Израил болон эргэн тойрны үндэстнүүдэд ирэх буруутгал

Израилыг тойрон хүрээлсэн нилээд олон үндэстнүүдийн талаарх Их Эзэний буруутгалын захиасуудаар Амос бошиглолуудаа эхэлжээ, тухайлбал: Сири (үүний нийслэлийг Дамаск гэж тогтоосон; Амос 1:3–5-ыг үз), Филист (гол хотууд нь Газа, Ашдод, Ашкелон, Екрон гэж тогтоо-

жээ; Амос 1:6–8-ыг үз), Фоеник (үүний гол хот нь, Тирийн Тир; Амос 1:9–10-ыг үз), Едом (Амос 1:11–12-ыг үз), Аммон (Амос 1:13–15-ыг үз), Моаб (Амос 2:1–3-ыг үз). Тус бүр нь өөрсдийн нүглүүд хийгээд Израилыг довтолсны улмаас буруутгагдсан аж.

Эдгээр буруутгалууд Израилын хүүхдүүдийн анхаарлыг татсан байх ёстой, мөн тэд Амосын мэдэгдлүүдтэй санал нэг байсан хэдий ч, тэрээр бас Иуда (Иоел 2:4–5-ыг үз) Израил (Иоел 2:6–16-г үз) хоёрыг буруутгасан ажээ. Түүний эсрэг нүгэл үйлдсэн бүх хүмүүсийн хувьд Бурханы шударга ёс адил тэгш юм—тэд бүгдээрээ гарцаагүй ишийтгэгдэх болно гэдгийг Амос израилчуудад мэдүүлсэн билээ. Амосын номны үлдсэн хэсэг нь ихэнхдээ наманчлахыг сэрэмжлүүлэн Израилд хандсан захиас юм.

Амос 3

Бошиглогчдын үүрэг

Тэнгэрлэг Эцэг бошиглогчдоор дамжуулан өөрийн хүүхдүүдтэй ярьдаг больсон гэдэгт өнөөдөр дэлхийд олон хүмүүс итгэдэг. Их Эзэн хийгээд бошиглогчдын тухай Амосын хэлсэн зүйлүүдийг Амос 3 цэдэглэдэг. Бошиглогчдын тухай түүний заадаг зүйлүүдийг, түүнчлэн хэрэв Израил бошиглогчдоо сонсохгүй бол тэдэнд тохих болно хэмээн Их Эзэний хэлсэн зүйлүүдийг эрж ол.

Судруудыг ойлгох нь

Амос 3

Тахилын ширээний эврүүд таслагдана (ш. 14)—Бурханыг тэд тахин шүтэх нь хүчгүй, хоосон хэлбэртэй болно. (Эврүүд бол хүчний бэлэгдэл байжээ.)

Өвлийн байшин, зуны байшин (ш. 15)—Бурхан, түүний бошиглогчдыг үл тоомсорлодог байсан чинээлэг хүмүүсийн гэр орон

Амос 3:7—Их Эзэн өөрийн үгийг хүргэхийн тулд ямагт бошиглогчдыг дууддаг

Бурхан өөрийн үгийг, бас өөрийн ажлуудыг хүмүүний дунд үндэслэн бий болгохын тулд ямагт бошиглогчдоор дамжуулан ажилладаг гэсэн Сэргээлтийн захиасны нэн чухал үнэнийг Амос 3:7 агуулдаг. Ахлагч ЛийГранд Ричардс Амос 3:7-г иш татсаны дараа хэлэхдээ: “Хэрэв эдүгээ бид үүнийг ойлгох юм бол, энэ дэлхий дээр бошиглогчоор тэргүүлэгддэггүй ажил байдаггүйг нэг ч хүн эрж хайх учиргүй. Бошиглогч тэргүүлээгүйг тэрээр хүлээн зөвшөөрсөн нэг ч ажлыг Их Эзэн хэзээ ч хийгээгүй юм” гэжээ (in Conference Report, 1975 оны 10-р сар, 75; *Ensign*, 1975 оны 11-р сар, 50).

Судруудыг судлах нь

А Төгс Эзэмших Судар—Амос 3:7

1. Амос 3:3–6-д, Амос долоон асуулт асуусан байдаг, эдгээрийн хариултууд нь “үгүй” гэдэг нь тодорхой юм. Тэрбээр эдгээр асуултуудыг шүлэг 7-д өөрийн зөв гэж бодсон нэг зүйлийг тэмдэглэхийн тулд асуусан ажээ. Юуг “гарцаагүй” тохионо гэж Амос хэлсэн бэ? (1 Нифай 22:2-ыг үз).
2. Их Эзэн манай үед илчилсэн “нууцын” жишээ, түүнчлэн сонсож, дуулгавартай дагадаг хүмүүсийн амьдралыг энэ нь хэрхэн адисалдгийн жишээ гарга.



Б Үр дагаврууд нь юу вэ?

Амос 3:11–15; Сургаал ба Гэрээ 1:11–16-г уншиж, бошиглогчдыг сонсож, дуулгавартай дагахаас татгалздаг хүмүүст юу тохих болно гэж Их Эзэн хэлснийг бич.

Амос 4

“Би та нарт туслахыг хичээсэн”

Таныг болон таны санал болгосон зүйлийг эсэргүүцсэн хүний төлөө ямар нэг аятай сайхан зүйл хийхийн тулд та замаасаа гажиж үзсэн үү? Өөрсдийг нь Египетээс чөлөөлж, амлаадсан нутгийг тэдэнд өгсөн Бурханыг Израил эсэргүүцсэн юм (Амос 2:9–10-ыг үз). Израилыг өөртөө “эргэж” ирүүлэхийн тулд юу хийх болно хэмээн Их Эзэн хэлснийг Амос 4 өгүүлдэг. Та нар уншихдаа, түүний хэлсэн зүйлүүдийг эрж ол.

Судруудыг ойлгох нь

Амос 4

Башаны үнэнүүд (ш. 1)—Шууд утгаараа, арвин их өвс-тэй газрын үнэнүүд; бэлгэдийн утгаараа, зөвхөн өөрсдийнхөө төлөө санаа тавьдаг чинээлэг эмэгтэйчүүд

Бетел, Гилгал (ш. 4)—Ялзран доройтсон шүтлэгийн газрууд

Исгэсэн юм (ш. 5)—Исгэх хөрөнгө (Шатаалт өргөлийн хамт исгэсэн талхаар өргөл өргөхийг хориглодог байжээ.)

Цуцал (ш. 11)—Шатаж байгаа нарийхан мод

Амос 4:2—Их Эзэн яаж өөрийн хүмүүсийг “дэгээгээр,” бас “загасны дэгээгээр” авч явах вэ?

Ассиричууд дайснуудынхаа уруул, хамар буюу хацрыг нь цоолж, дэгээгээр бие биенээс нь гинжлэн холбодог байжээ. Олзлогдогсдыг ингэж холбох нь харгалзах болон тэднийг “сүрэг” болгон боолчлолд аваачихад амар хялбар байжээ.



Судруудыг судлах нь

А Энэ нь хэрхэн нөлөөлж болох вэ?

1. Амос 4:6–11-д өөртөө эргэж ирэхийг Израилд ятгахын тулд юу хийснээ Их Эзэн тайлбарлажээ. Түүний хэлсэн зүйлүүдийн жагсаалт хий.
2. Их Эзэний шүүлтүүд Израилыг түүнд эргэж ирэхэд хэрхэн нөлөөлнө гэж та нар бодож байна? (Алма 32:13; Хиламан 12:2–6-г үз).
3. Сургаал ба Гэрээ 122:7–8-ыг уншиж, өөртөө тохиолдсон зарим хүнд үеүдийн тухай бод. Хүндрэл хэрхэн адислал болж болох вэ?

Амос 5

Их Эзэнийг эрэлхийлж амьдар

Израилчууд Их Эзэнийг эрэлхийлэх хийгээд хилэнцэт замуудаа наманчлахад хэрхэн дахин урамшуулагдсан тухай Амос 5 өгүүлдэг. Их Эзэн тэдний шунаг сэтгэл, тэдний хиймэл шүтээнийг онцгойлон буруутгасан ажээ. Хэрэв тэд “Их Эзэнийг эрэлхийлэх” юм бол, тэд “амьдрах” болно (ш. 3–6, 14–15-ыг үз), харин хэрэв тэд тэгэхгүй аваас, боолчлолд аваачигдах болно гэж Тэрээр хэлжээ.

Судруудыг судлах нь

А Та нар юу гэж бодож байна?

Амос 5:4–6, 14–15-ыг унш. Бид бүгдээрээ хэзээ нэгэн цагт эсвэл ямар нэг байдлаар үхлийг үзэх болно, гэвч Их Эзэнийг эрэлхийлдэг хүмүүс “амьдрах” болно гэж өөрийн боддог арга замуудыг тайлбарла.

Амос 6

Тайван байгчид гаслантай яа

Их Эзэнийг үнэнээсээ хайрлаж, үйлчилдэггүй хэрнээ, зөвхөн Сүмийн гишүүд байгаа учраас аврагдах болно гэж боддог хүмүүс өнөөдөр Сүмд байдаг уу? Их Эзэн тэднийг—тэр ч байтугай тэд зөв шударга биш байлаа ч гэсэн устгагдахыг зөвшөөрөхгүй—учир нь тэд бол Бурханы сонгогдсон хүмүүс (Дэд Хууль 7:6-г үз) гэж боддог байснаас израилчууд олонтаа алдаа гаргадаг байжээ.

Тэд шударга ёс, нигүүлсэл, эсвэл Бурханыхаа тухай бодохоос илүүгээр өөрсдийн эд баялаг, ая тухыг боддог байсан учраас Амос 6-д Их Эзэн тэднийг буруутгажээ (мөн 2 Нисфай 28:21–24-ийг үз). Ийм байдлын улмаас, Израил дайснуудаараа боолчлолд аваачигдах болно гэж Их Эзэн хэлжээ.

Амос 7–9

Амосын таван үзэгдэл

Их Эзэнээс Амосын хүлээн авсан таван үзэгдлийг Амос 7–9 өгүүлдэг. Хэрэв тэд наманчлахгүй бол Израилын хаант улсыг Их Эзэн бүрмөсөн устгах бодолтой байсныг үзэгдэл бүр харуулж байлаа. Эхний хоёр үзэгдэл нь Израил наманчилсан учраас (Амос 7:1–6-г үз) тэдний зайлсхийж чадсан устгалуудын тухай байв. Дараагийн гурван үзэгдэл нь Израил наманчлаагүй замуудыг илчилсэн байв (Амос 7:7–9; 8:1–3; 9:1–4-ийг үз). Эдгээр нүглүүдийн үр дагавар нь Израилын Умард Хаант Улс эзлэгдэж, боолчлолд аваачигдсан явдал байлаа. Гэвч Израил бүрмөсөн устгагдахыг Бурхан зөвшөөрөөгүй юм. Бүлэг 9-д хэдийгээр тэд бүх үндэстнүүдийн дунд тараагдлаа ч гэсэн, эцсийн өдрүүдэд тэд амлалтын нутгуудаа дахин цуглуулахдаг болно гэдгийг Их Эзэн амласан билээ.

Судруудыг судлах нь


А Сонгож хийх үйл ажиллагаа—Энэ юу гэсэн үг вэ?

1. Амос 8:11–12 урвалтыг дүрсэлдэг. Урвалт гэдэг үгийн утгыг мэдэж, эдгээр шүлгүүдэд Амос яагаад дэлхий дээрх нийтийг хамарсан урвалтыг сайнаар дүрсэлснийг хэл.
2. Амос 8:11–12-т Амосын хэрэглэсэн Сайн мэдээний бэлэгдлүүдийг ашиглан, үнэнийг сонирхоход хүмүүсийг урьсан зарлал хий. Уг зарлалд юу гэж хэлэхийг бичих буюу бичмэл үзүүлэн дээр өөрийн тавьж болох зүйлийг зур.

Шударга ёсны захиас

Таныг хүнд хэцүү нөхцөлд байхад чинь хэн нэгэн нь таныг ашиглачихаад, танаас нүүр буруулж байсан тохиолдол бий юу? Иерусалимаас нүүр буруулсных нь төлөө Обадиа Едомын үндэстнийг буруутгасан юм. Иерусалимыг харийн хүчин довтлоход едомчууд иудейчүүдийг ялагдахад туслан, өмч хөрөнгийг нь хулгайлсан ажээ. Сион Уулан дээрх Иуда, Израилын зайлшгүй авралын тухайд тэд харгис бурангуй байсан учраас Обадиа Едомын устгалыг бошигложээ.

Богинохон номны богинохон үндэс суурь



Обадиа гэдэг нэр “Иеховагийн үйлчлэгч (эсвэл шүтэгч)” гэсэн утгатай аж. Түүний ном МЭӨ 586 оны орчимд, Иерусалимын устгалын дараахан бичигдсэн бололтой, мөн энэ нь Хуучин Гэрээний бүх номнуудаас хамгийн богинохон нь юм. Дэлгэрэнгүй суурь мэдээллийг Судруудын Удирдамж, “Обадиа”-гаас үз.

Обадиа

Нас барагсдыг гэтэлгэх нь

Судруудыг ойлгох нь



Обадиа 1:21—“Аврагч нар . . . Сион Уул уруу”

Обадиа 1:21 бол Сайн мэдээг сонсолгүй, үүний ёслолуудыг хүлээн авалгүй нас барсан хүмүүст зориулж гүйцэтгэгдэх хожмын үеийн ариун сүмийн ажлын тухай бошиглол мөн гэдгийг өнөө үеийн бошиглогчид заан тэмдэглэдэг. Бошиглогч Иосеф Смит хэлэхдээ: “Гэвч тэд яаж Сионы Уулан дээрх аврагчид болох вэ? Өөрсдийн ариун сүмүүдийг барьснаар, өөрсдийн баптисмын сангуудыг босгосноор, мөн бүх ёслолууд, баптисмууд, угаалгууд, тослох адислалууд, томилолтууд хийгээд тэдний тэргүүн дээрх лацдалтын хүчнүүдийг нас барсан өвөг дээдсийнхээ нэрийн өмнөөс хүлээн авахаар явдаг болсноор, түүнчлэн тэд эхний амилуулалтад урагш гарч ирэн, алдар суугийн хаан сэнтийд тэдэнтэй хамт өргөмжлөгдөж болохын тулд тэднийг гэтэлгэснээр; мөн Елиагийн үүрэг зорилгыг гүйцэлдүүлэх, эцгүүдийн зүрх сэтгэлийг хүүхдүүд рүү нь, мөн хүүхдүүдийг эцгүүд нь эргүүлэн холбох гинжин хэлхээ энд буй” гэжээ (*Teachings of the Prophet Joseph Smith*, 330).

Ионагийн Ном

Ер бусын бошиглогч ба ер бусын ном

Ионагийн ном бол бошиглогчийн илчлэлтүүд болоод бошиглолуудыг цэдэглэхийн оронд бошиглогчид өөрт нь юу тохиолдсоныг үндсэндээ цэдэглэдэг, Хуучин Гэрээний бошиглогчдын хэсэг дэх цорын ганц ном юм. Иеробоам II Израилын хаан (МЭӨ 793–53 онуудын орчим) байсан үед Иона амьдарч байсан байж болох магадлал хамгийн их юм. Та нар Ионагийн номыг уншихдаа, Бурханы хайрын тухай энэ нь та нарт юу заадгийг авч үз. Хэдийгээр энэ ном богинохон ч гэсэн, Есүс өөрийн мөнх бус тохинууллын үеийн хоёр өөр хэсэгт дурдагддагийг бас ажигла (Матай 12:39–41; Лук 11:29–32-ыг үз). Ионагийн номны тухай дэлгэрэнгүй мэдээллийг Судруудын Удирдамж, “Иона”-гаас үз.

Иона 1–2

Та нар Эзэнээс зугтааж чадах уу?

Хамгийн ёс бус, харгис хэрцгий гэдгийг нь мэдэх нэг хүнтэй Сайн мэдээг хуваалц гэж өөрийг чинь (ганцааранг нь) таны удирдагчид томилбол та юу гэж хэлэх вэ, мөн танд ямар санагдах вэ? Иона Ассирийн нийслэл Ниневе рүү явж, ассиричуудад наманчлалыг сэрэмжлүүлэхээр хэрхэн дуудагдсан тухай Иона 1–2-т өгүүлдэг. Ассиричууд ихэд ёс бус, харгис хэрцгийгээрээ нэрд гарсан байсан бөгөөд Сирийг аль хэдийн эзэлж, Израилыг эзлэхээр заналхийлж байсан аж.

Судруудыг ойлгох нь



Иона 1

Шавга татах (ш. 7)—
Бурханы тааллыг үүгээр
мэдэж болно гэдэгт хүмүү-
сийн итгэдэг нэг арга

Тангараглав (ш. 16)—Амлав

Иона 2

Хий хоосон шүтээнүүдийг
хүндэтгэдэг хүмүүс (ш. 8)—
Хиймэл шүтээнүүдэд ит-

гэж, Их Эзэний тусламжийг
алдсан хүмүүс

Иона 1:2–3—Ниневе ба Таршиш

Ниневе, Таршиш хоёр бол Ойрхи Дорнод болон Газрын
Дундад Тэнгисийн бүсийн хоёр талыг төлөөлдөг. Иона
Таршишийг зорин зугтахаар гарахдаа, Ниневегээс аль болох
хол очихыг хичээж байсан бололтой.

Таршиш уруу хөвөхөөр төлөвлөж байсан нь



Судруудыг судлах нь



А Нарийн тодорхой зүйлүүдийг эрж ол

1. Далайгаар хөвөгчид яагаад Ионаг сэрээсэн бэ?
2. Ионаг далай уруу хаях нь хэний санаа байсан бэ?
3. Ионаг аварга загас залгихаар бэлтгэхэд Их Эзэн юу хийсэн бэ?

Б Та нар юу гэж боддог вэ?

Бурхан түүнээс хийхийг хүссэн зүйлээс хүн зугтаах буюу
Сүм дэх дуудлагуудаас татгалзахыг бодож болдог тухай
бич. Иона 1 дэх Их Эзэнээс зугтаахыг оролдсон Ионагийн
туршлагаас бид юу сурч болох вэ? (Мосе 4:12–16-г үз).

В Аврагчийн хэв шинж

Иона загасны гэдсэнд хэр зэрэг удаан байсан бэ? Матай
12:38–41-ийг уншиж, Ионагийн туршлага Аврагчид то-
хиолдсон зүйлтэй хэрхэн адилхан болохыг бич.

Иона 3–4

Иона Ниневед

Ассирийн нийслэл Ниневе тухайн үедээ маш том хот
байжээ. Энэ нь эргэн тойрноороо 96 километр (60 бээр),
120,000 (Иона 4:11-ийг үз) орчим хүн амтай байсан аж.
Ниневе ихэд ёс бус хот гэдгээрээ нэрд гарсан байж. Ёс бу-
сынхаа улмаас тэд устгагдах болно гэж Иона хүмүүст хэ-
лэхэд, тэд яасан тухай, түүнчлэн тэдний хариултад
Иона хэрхэн хариу үйлдэл үзүүлснийг Иона 3–4 цэдэглэ-
дэг. Тэд юу хийснийг мөн тэрчлэн Иона өөрийн номло-
лоос юу сурсныг ажигла.

Судруудыг ойлгох нь



Иона 3

Таар (ш. 5, 6, 8)—Даруу бай-
дал буюу уй гашууг харуу-
лахын тулд өмсдөг бүдүүн
баараг хувцас

Үнсэн дээр суух (ш. 6)—
Даруу байдал буюу уй га-
шуугийн тэмдэг

Иона 4

Баруун, зүүн гарынхаа
хоорондохыг мэддэггүй
(ш. 11)—Зөвийг буруугаас
ялгаж мэддэггүй

Иона 3:9–10—Бурхан наманчлах хэрэгтэй байдаг уу?

Иона 3:9–10-ын Иосеф Смитийн орчуулга *Судруудын Удирдамжид*
байдаггүй, гэвч Иона 3:9–10-ын Иосеф Смитийн зөв орчуулга
Судруудын Удирдамж дахь “Библийн Иосеф Смитийн Орчуулгаас
авсан түүврүүдэд” Амос 7:3-г байдгийг ажигла.

Судруудыг судлах нь



А Тунхаг бич

Ниневегийн хүмүүст
хандсан тунхаг

Ионагийн захиасыг хаан
сонсоод тэрээр хүмүүст
тунхаг гаргасныг Иона 3:5–8
өгүүлдэг. Иона 3-аас унш-
сан зүйл дээрээ тулгуурлан,
тунхагт юу өгүүлсэн байж
болно хэмээн боддог тухай-
гаа, мөн Ниневегийн хү-
мүүсийн талаар мэддэг
зүйлийнхээ тухай бич.

Б Тэр юу гэж бодож байсан бэ?

Иона 3:10-г Бурханы хийсэн зүйлийн талаар Иона юу гэж бодож байсан байж болохыг, мөн яагаад тэр ингэж бодож байсан байж болно гэж боддоогоо дүрсэл.

В Гол санаа нь юу вэ?

Ионагийн номны захиас юу вэ гэж боддог тухайгаа ярь (та нар нэгээс дээш санааг сонгож болно).

Микагийн Ном

Мессаигийнхтай адил бошиглол

Мика гэдэг нэр “Иеховатай адилхан хүн” гэсэн утгатай аж. Мика бол өмнөд Иудагийн нэгэн жижигхэн хотынх бөгөөд (Мика 1:1-ийг үз) ойролцоогоор МЭӨ 740–697 онуудад, Иудагийн хаад, Иотам, Ахаз, Хезекиа нарын хаанчлалын үед бошиглож байжээ; Мика мөн Исаиатай ойролцоо үед бошиглож байсан аж. Микагийн захиас Израил, Иуда хоёрт хоёуланг нь хандсан бөгөөд аймшигт хувь тавилангийн үгс хийгээд шүүлтийн хажуугаар Их Эзэний хүмүүсийн хожмын, нигүүлсэнгүй сэргээлтийн найдвар болоод амлалтыг агуулдаг. Мессаигийн төрөлтийн (Мика 5:2-ыг үз) тухай түүний гайхамшигт бошиглолоор Мика ихэд алдартай юм.

Мика 1–2

Израил Иуда хоёул унана

Нүглүүдийнх нь улмаас Израил Иуда хоёр дээр Их Эзэн шүүлтэд ирэх болно гэсэн Микагийн бошиглолууд Мика 1–2-т байдаг. Хиймэл шүтээний, баялгийг эгээрэн хүсэхийн хийгээд улмаар хүчирхийлэл, шударга бус замаар эдгээр баялгуудыг олж авахын нүглүүдийг тэрээр онцгойлон дурджээ. Гэвч Мика Израил Иуда хоёрыг бүхэлд нь найдваргүйгээр орхиогүй юм. Шүүлтүүдийн дараа, Израил дахин цуглуулагдах болно хэмээн тэрээр бошигложээ.

Мика 3

Ёс бус удирдагчид шүүмжлэгдсэн нь

Ямар хүмүүсийг Бурхан өөрийн үйлчлэгчид байхаар сонгодог вэ? Израилын удирдагчид бөгөөд Бурханы үйлчлэгчид хэмээн боддог байсан хүмүүсийн юу нь буруу байсан хэмээн Мика хэлснийг Мика 3 өгүүлдэг. Та нар уншихдаа, түүний хэлсэн зүйлүүдийг эрж ол.

Судруудыг ойлгох нь



Мика 3

Тэдний арьсыг нь хуулж, яснаас нь махыг нь салгадаг (ш. 2, 3)—Израил Иуда хоёрын удирдагчдын харгис бурангуйг дүрслэхэд хэрэглэсэн өгүүлбэр. Удирдагчид үнэхээр хүмүүсийг *иддэггүй* байсан нь мэдээж. Тэд хүмүүсийн хоол хүнс, хувцас хунар, өмч хөрөнгийг салган авах замаар баяжихад эрх мэдлээ ашигладаг байжээ.

Шүдээрээ хазах юмтай байхдаа, . . . хүний эсрэг ариун дайн зарладаг (ш. 5)—Хуурамч бошиглогчид өөрсдийг нь тэжээдэг хүмүүст “амар амгалан” гэж хэлэх болно, харин тэгдэггүй хүмүүсийн эсрэг тэмцэх болно

Судруудыг судлах нь



А Үүнийг сайтар бод

1. Ард түмний удирдагчид юуг буруу хийж байсан гэж Мика 3 өгүүлснийг жагсаа.
2. Өөрийнхөө таних Сүмийн нэг удирдагчийн тухай бичих буюу судрын жишээг ашиглаж, Их Эзэнийг дагах болон бусдыг удирдах талаарх түүний шинж чанаруудыг дүрсэл.

Мика 4

Их Эзэн Сионд хаанчлах болно

Микагийн бошиглолуудын загварыг ашиглан, Мика 4 нь Мика 3 дахь зарим “сайн мэдээг” “муу мэдээгээр” цааши үргэлжлүүлдэг. Эхний гурван шүлэг нь уулсын оргил дээрх Их Эзэний уулын тухай Исаиагийн бошиглолтой маш адилхан юм (Исаиа 2:1–4-ийг үз). Бүлэг 4-ийн үлдсэн хэсгийн ихэнх нь бид Их Эзэнийг болон түүний Сионыг эрэлхийлсэн үед Сион ямар болох тухай юм.

Мика 5

Мессиагийн ирэлт

Аврагчийн анхны ирэлт болон эцсийн өдрүүдэд Израилын хүүхдүүд дайснуудаасаа чөлөөлөгдөж, зөв шударга болох тухай Мика угтан хэлснийг Мика 5 цэдэглэдэг.

Судруудыг судлах нь

А Энэ бошиглол хэрхэн гүйцэлдсэн бэ?

Мика 5:2 дахь бошиглол МЭӨ 700 оны орчимд өгөгджээ. Матай 2:1–6; Лук 2:1–7-г унш. Микагийн бошиглолыг хэн гүйцэлдүүлсэн бэ? Мика 5:2 дахь Ефрата хэмээх нэмэлт нэрийг Иуда дахь Бетлехемийг Зебулун дахь Бетлехемээс ялгахын тулд ашигласан бололтой.

Мика 6–7

Израилын нүгэл ба Их Эзэний нигүүлсэл

Их Эзэн Израилыг тэдний шударга бус зан авир, шунахай сэтгэл, тэдний хүчирхийлэл хийгээд хиймэл шүтээн шүтдэгийнх нь улмаас буруутган зэмлэснийг Мика 6 цэдэглэдэг. Эцсийн өдрүүдэд Израил наманчилж, Их Эзэнд эргэж ирсэн үед тэрээр тэдэнд нигүүлсэнгүй байх болно гэсэн Их Эзэний амлалтыг Мика 7 толилуулдаг.

Судруудыг судлах нь

А Юу шаардлагатай вэ?

1. Мика 6:7–8-д өгүүлсэнээр, Их Эзэний мэлмийд “сайн” байхын тулд юу шаардлагатай вэ?
2. Мика 6:7–8 олон жилийн өмнөх хүмүүст зориулан бичигджээ. Хэрэв шүлэг 8-д жагсаасан Христийнхтэй адил шинж чанарууд байхгүй бол, өнөөдөр хүмүүс “сайн” биш ямар үлгэр жишээ үзүүлж болох тухай шүлэг 7-г ашиглан дахин бич.

Нахумын Ном

Тайтгарлын захиас

Нахум гэдэг нь еврей хэлэнд “тайтгарал” гэсэн утгатай ажээ. Нахумын богинохон ном бол Ассирийн нийслэл Ниневе дээр ирэх Бурханы шүүлтүүдийн тухай учраас, ассиричуудын гарт зовж байсан израилчуудыг түүний захиас тайтгаруулсан байх учиртай.

Үндэс суурь

Хуучин Гэрээн дэх зарим нэг бошиглогчдын адил, бид Нахумын тухай бага мэддэг. МЭӨ 663–12 онуудын хоорондох аль нэгэн үед, Ассири Ойрхи Дорнодын ертөнцөд хамгийн хүчирхэг үндэстэн байсан тэр үед тэрээр бошиглогуудаа бичиж байжээ гэдэгт итгэхэд түүний номын агуулга биднийг хөтөлдөг.

Ассирийн устгалын тухай Нахумын бошиглогууд Хоёр дахь Ирэлтийн яг өмнөх болон тэр үеийн дэлхийд бас холбогддог.

Хабаккукийн Ном

Бошиглогчийн асуултууд ба Бурханы хариултууд

Энэ үндэстний сүнслэг байдлыг өөрчлөхийн төлөөх бошиглогчдын хүч чармайлтаас үл хамааран, Иуда ёс бус явдалдаа улам гаарч байсан үед Хабаккук аж төрж байсан бололтой. Хабаккукийн богинохон ном Их Эзэнээс түүний асуусан хоёр асуулт, Их Эзэний хариултууд, түүнчлэн өөрийн хүүхдүүдтэй Их Эзэний харилцдаг арга замын талаарх төгс мэргэн ухааныг хүлээн зөвшөөрөхийн төлөө түүний өргөсөн залбирлыг агуулдаг. Бошиглогч Хабаккукийн тухай болон Хуучин Гэрээн дэх түүний бичээсүүдийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг Судруудын Удирдамж, “Хабаккук”-аас үз.



“Би хэдий болтол дуудаж, Та хэдий болтол сонсохгүй байх юм бэ?”

Хабаккук 1–2

Асуултууд ба хариултууд

Иудейчүүдийн ёс бус явдлын тухай, яагаад тэрбээр өөрийн хүмүүсийн дунд ийм их ёс бус явдлыг хүлээн тэвчиж байгааг Хабаккук Их Эзэнээс асуусныг Хабаккук 1:2–4 цэдэглэдэг. Ёс бусынх нь улмаас иудейчүүдийг вавилончууд удахгүй эзлэн авах болно гэдгийг тайлбарлаж, Их Эзэн түүнд Хабаккук 1:5–11-д хариулжээ. Хабаккук 1:12–17-д, ёс бус болсон өөрийн гэрээт хүмүүсийг устгахын тулд иудейчүүдээс илүү ёс бус хүмүүс—вавилончуудыг Их Эзэн яагаад ашиглах болсныг Хабаккук түүнээс асуужээ. Бүр тэд түр зуур цэцэглэн хөгжиж байгаа мэт боловч, вавилончууд ч ёс бусынхаа улмаас бас устгагдах болно гэж хэлснээр Хабаккук 2:2–20-д Их Эзэн хариулсан байдаг.

Хабаккук 3

Хабаккукийн залбирал

Еврей яруу найргийн хэлээр бичигдсэн бөгөөд Хабаккук үүндээ Бурханы хүч хийгээд нинжин сэтгэлийн тухай, түүнчлэн бүр түүний хүмүүсийн хүнд хэцүү үеүдэд ч гэсэн Их Эзэнийг дагах өөрийнхөө хувийн шийдвэр төгс байдлын тухай гэрчлэлээ хэлсэн залбирлыг Хабаккук 3 агуулдаг.

Судруудыг судлах нь

A Өөрийнхөө үгээр

Их Эзэнийг дагах миний шийдвэр төгс байдал

Бүр хүнд хэцүү цагт ч гэсэн, Хабаккук Их Эзэнийг дагах шийдвэр төгс байдлаа илэрхийлсэн Хабаккук 3:17–18-ыг унш. Их Эзэнийг дагах өөрийнхөө шийдвэр төгс байдлыг илэрхийлсэн өөрийнхөө хувийн богинохон нотолгоог бич.

Зефаниагийн Ном

Их Эзэний өдөр ёс бусчууд дээр аугаа хүчтэйгээр ирэх хэдий ч, Их Эзэнийг эрэлхийлж, зөв шударгаар амьдардаг хүмүүсийн хувьд найдвар агуулсан, гайхамшигтай ирээдүйг хангах болно гэдгийг Зефаниа бошиглодог байлаа.

Хааны бошиглогч

Зефаниагийн нэгдүгээр шүлэгт түүнийг, энэ ном бичигдэхээс ойролцоогоор зуун жилийн өмнө амьдарч асан Иудагийн зөв шударга хаан Хезекиагийн үр удам болохыг заасан байдаг. Зефаниа Иудагийн өөр нэг зөв шударга хаан Иосиагийн үед бошиглож байсан нь, тэрээр Хабаккук, Мика, мөн залуу Иеремиа нартай нэгэн үед ойролцоо амьдарч байжээ гэсэн үг юм.

Зефаниаг судлахад бэлтгэх нь

Зефаниагийн ном хоёр гол санаанаас бүтдэг:

1. *ЭЗЭНий өдөр.* Нүгэл үйлдэж, хоёр нүүр гаргасан хүмүүс дээр Их Эзэн шүүлтэд ирэх болно. Энэ үнэн нь Зефаниагийн үе дэх Иудагийн үндэстэнд мөн түүнчлэн бүх эрин зууны ёс бус хүмүүст, ялангуяа Хоёрдахь Ирэлтийн үед амьдрах хүмүүст бүр ч илүү холбогдолтой юм.
2. *Сэргээлт ба ариусалт.* Бурханы шүүлтүүдийн дунд өөрсдийгөө даруу болгодог хүмүүсийг тэрээр өөртөө ойртуулж, ариусгах болно.

Зефаниа 1–2

Шүүлтийн өдөр

Хиймэл шүтээнүүдийг шүтэх, бие биендээ хилэнцэтийг үйлдэх, үнэн хэрэг дээрээ ёс бус атлаа өөрсдийгөө зөв шударга гэж боддог зэрэг нь нүглүүдийнхээ улмаас Иудагийн хүмүүст юу тохиох тухай Зефаниагийн бошиглолыг Зефаниа 1 цэдэглэдэг.

Вавилончууд зөвхөн иудейчүүдийг төдийгүй, Иудаг тойрон хүрээлсэн бүх ёс бусчуудыг, түүний дотор Иуда, филистчүүд (ш. 4–7-г үз), моабчууд болон аммончууд (ш. 8–11-ийг үз), этиопчууд (ш. 12), ассиричуудыг (ш. 13–15-ыг үз) бас устгах болно хэмээн Зефаниа бошигловсныг Зефаниа 2 өгүүлдэг.

Зефаниа 3

Урам хайрласан үгс

Нүгэл үйлдсэн хүн уруу таталтад буун өгч, түүнд “эргэх нь” ерөөсөө байхгүй болж гэж бодож болох юм. Урам хугаралтын ийм мэдрэмжүүдийн улмаас, нүгэл үйлдэгч чухам ямар буруу зүйл хийснийг тодорхой ярих төдийгүй, бас наманчлах болоод ирээдүйгээ илүү сайнаар харахад нь нүгэл үйлдэгчид урам хайрлахын тулд найдварын үгсийг түүнд ярих нь чухал юм. Зефаниа 3 Иудагийн хүмүүст урам хайрласан Их Эзэний үгсийг агуулдаг.

Судруудыг судлах нь

А Өөрийн чинь сэтгэлийг хөдөлгөсөн зүйлийн тухай ярь

Хожмын өдрүүд болон нүглүүдийнхээ улмаас тараагдаж, боолчлолд аваачигдсаны дараа Их Эзэн өөрийн гэрээт хүмүүсийг өөртөө буцаан авчрах гайхамшигтай арга замыг Зефаниа 3:8–20-д дүрсэлдэг. Та нар эдгээр шүлгүүдийг уншихдаа, Их Эзэнд эргэж очих хэрэгтэй хүмүүс, эсвэл эцсийн өдрүүдийн талаар сэтгэл түгшин, айж байгаа хүмүүст эдгээр нь хэрхэн холбогдох тухай бод. Их Эзэн энэ бүлэгт хэлсэн, өөрт чинь хамгийн гүнзгий сэтгэгдэл төрүүлсэн, наад тал нь хоёр үнэнийг бичиж, яагаад гэдгийг тайлбарла.

Хаггаин Ном

Ариун сүм барихыг урамшуулан дэмжсэн нь

МЭӨ 538 онд Персийн хаан Кореш (Езрагийн Номонд бас дурдагддаг) иудейчүүд Иерусалим уруу буцаж, вавилончуудын устгасан өөрсдийн ариун сүмийг дахин барьж болно гэж тогтоожээ. Энэ боломжийн тухайд иудейчүүд эхлээд сэтгэл ихэд догдолж байжээ. Гэвч уг ажлын бэрхшээл, зардал, дайснуудынх нь эсэргүүцэл, Корешийг залгамжилсан хаадын зүгээс дэмжлэг дутагдаж байсан нь иудейчүүдийг урам хугарахад хүргэжээ. Арванзургаан жилийн туршид ариун сүм дээр ажил бараг хийгдээгүй аж. Хаггаи МЭӨ 520 онд бошиглон, ариун сүмийг тэргүүн зэрэгт тавихыг хүмүүст зааж, эдгээр сорилтуудыг хайхралгүйгээр ариун сүмийг дахин барих ажлаа үргэлжлүүлэхэд нь тэднийг урамшуулан дэмжиж байжээ.

Хаггаиг судлахад бэлтгэх нь


Хаггаи өөрийн богинохон хэсэг бүрийн тодорхой он сар өдрийг заасан байдаг. Сарууд Хуучин Гэрээнд өөр өөрөөр нэрлэгддэг байсан ч гэсэн бидэнд ойлгомжтой болгохын тулд одоогийн нэрээр нь өөрчилсөн ажээ.

Хаггаи 1:1–15 МЭӨ 520 оны наймдугаар сарын 29

Хаггаи 2:1–9 МЭӨ 520 оны аравдугаар сарын 17

Хаггаи 2:20–23 18 МЭӨ 520 оны арванхоёрдугаар сар

Иудейчүүд Иерусалим уруу эргэж ирэн, ариун сүмийг барьсан тухай түүх Езра, Нехемиа нарын номнуудад байдаг. Хаггаин тухай дэлгэрэнгүй мэдээллийг Судруудын Удирдамж, “Хаггаи”-аас үз.



Хаггаи 1

Ариун сүмийг дуусга

Ахлагч Клаудио Р.Коста Бразил дахь өөрийнхөө таньдаг нэг хүний тухай дараах түүхийг ярьсан юм:

“Тэр бүлийнхээ хамт баптисм хүртсэний дараа тэрээр эхнэр, хүүхдүүдээ ариун сүм уруу авч явж болохын тулд Сүм дэх гишүүнчлэлийнхээ нэг жилийг тэсэн ядан хүлээж өнгөрүүлжээ. Бразилын Сан Паулогийн Ариун Сүм Амазоноос маш хол байдаг. Ариун сүмд хүрэхэд далайн хөлөг онгоцоор дөрвөн өдөр, автобусаар мөн дөрвөн өдөр— долоо хоног орчим явна. Энэ хүн шүүгээ хийдэг байлаа. Тэр хүн өөрийнхөө, эхнэрийнхээ, бас хүүхдүүдийнхээ зардлыг төлөхөд хүрэлцэхүйц мөнгийг хэрхэн хэмнэж

чадсан юм бол? Хэдийгээр тэр олон сарын турш шаргуу ажилласан ч гэсэн, тун бага мөнгө хуримтлуулсан аж.

“Ариун сүмд явах цаг болоход тэрээр гэрийнхээ бүх тавилга, цахилгаан хэрэгслүүдээ, тэр ч байтугай өөрийн цахилгаан хөрөө, өөрийнх нь тээврийн цорын ганц хэрэгсэл мотоцикл—ер нь өөртөө байсан юм бүхнийг зарж—тэгээд эхнэр, хүүхдүүдтэйгээ хамт ариун сүмд явжээ. Сан Пауло хүрэхэд найман өдөр явах шаардлагатай байдаг аж. Ариун сүмд Их Эзэний ажлыг хийж, гайхамшигтай сайхан дөрвөн өдрийг өнгөрөөсний дараа, энэ гэр бүл гэртээ харихын тулд дахиад долоо хоног явах хэрэгтэй байв. Гэвч тэдний бэрхшээл, тэмцлүүдийг Их Эзэний өргөөнд тэдний биеэр амссан агуу баяр хөөр, адислалуудтай харьцуулахад юу ч биш юм байна гэдгийг тэд мэдэрсээр, гэртээ баяр хөөртэйгөөр эргэж ирсэн ажээ” (in Conference Report, 1994 оны 10-р сар, 34; Ensign, 1994 оны 11-р сар, 27).

Бразилын энэ гэр бүлийн түүх нь бүлэг 1 дэх Хаггаин захиасны сүнсийг төлөөлдөг. Та нар уншихдаа, Хаггаин ариун сүмийн ач холбогдлын талаар юу хэлснийг, түүнчлэн хүмүүс ариун сүмийг зохих ёсоор үнэлдэггүйгээ харуулдаг юу хийдгийг эрж ол.

Судруудыг судлах нь

А Ариун сүмийн ач холбогдол

1. Ариун сүм барихыг удаашруулсны үр дагаврууд юу байсан гэж Хаггаин хэлсэн бэ? (Хаггаин 1:6, 9–11-ийг үз). Бидний амьдралын хэсэг бүр дэх ариун сүмийн гэрээнууд, ёслолууд болоод адислалуудыг авч үз. Цалингаа “цоорхой түрийвчинд” хийх гэсэн нь юу гэсэн утгатай гэж та нар бодож байна?
2. Хүмүүсийн амьдрал дахь ариун сүмийн тэргүүлэх үүргийн тухай Хаггаин 1:4–6 юу өгүүлдэг вэ?

Б Хүмүүсийн хариулт

1. Хаггаин захиасын улмаас хүмүүс юу хийсэн бэ? (Хаггаин 1:12–15-ыг үз).

2. “Гишүүнчлэлийнхээ агуу бэлгэдэл болгон Их Эзэний ариун сүм өөд харахыг” Ерөнхийлөгч Ховард В.Хантер, Хаггаин нэгэн адил, Сүмийн гишүүдэд хандаж хэлсэн байдаг (in Conference Report, 1994 оны 10-р сар, 8; Ensign, 1994 оны 11-р сар, 8). Та нар ариун сүмийг яаж гишүүнчлэлийнхээ бэлгэдэл болгож байгааг, мөн та нарын өнөөдөр амьдарч байгаа байдалд ариун сүм хэрхэн нөлөөлдгийг тайлбарла.

Хаггаин 2

Барилгыг үргэлжлүүл!

Хүмүүс ариун сүмийг аль хэдийн дахин барьж эхэлсэн үед Хаггаин 2 бичигджээ. Ариун сүмийг баригсдын дотор өмнөх ариун сүмийг үзсэн, энэ ариун сүм хичнээн гоё сайхан, сүр жавхлантай байсныг мэддэг байсан иудейчүүд байжээ. Тэдний дахин барьж байсан ариун сүм хэмжээгээрээ ч, гоё сайхнаараа ч устгагдсан ариун сүмийн хаана нь ч хүрэхгүй байв. Энэ баримт олон иудейчүүдийг урам хугарахад хүргэсэн аж. Хаггаин тэднийг хоёр гол санаагаар урамшуулан дэмжжээ. Нэгдүгээрт, тэрээр барилгыг үргэлжлүүл гэж тэдэнд хэлэн, Их Эзэн эцсийн өдрүүдэд Соломоны барснаас илүү агуу, илүү сүр жавхлантай, тэдний санаж байгаа шиг тийм ариун сүм барих болно гэдгийг тэдэнд амлаж байв. Хоёрдугаарт, тэд ариун сүмийг дахин барьж эхэлсэн цагаас хойш, тэд дэвжин дээшилж эхэлснийг Хаггаин хүмүүст сануулж байв. Иймээс, уг ариун сүм хэдийгээр Соломоны ариун сүм шиг тийм сүр жавхлантай байгаагүй ч гэсэн, Их Эзэнээс мөн адил адислалуудыг авчирсан ажээ.

Зехариагийн Ном

Тэрээр өөрийнхөө үеэс цаашихыг харжээ

Зехариа бол Левийн овгийн санваартны гэр бүлээс гаралтай хүн байв. Тэрээр Вавилонд төрж, МЭӨ 538 оны орчим, Вавилоны боолчлолоос эх нутагтаа буцахыг зөвшөөрсөн иудейчүүдтэй хамт Иерусалимд эргэж иржээ. Тэрээр МЭӨ 520 оны орчим (Зехариа 1:1-ийг үз) бошиглогчоор дуудагдсан болохоор бошиглогч Хаггаин, санваартан Езра нартай хамт ойролцоо нэгэн үед амьдарч байжээ гэсэн үг. Хаггаин нэгэн адил, Зехариа ариун сүмийг дахин барихаа үргэлжлүүлэхийг

хүмүүст урамшуулан дэмжиж байжээ. Гэвч хүмүүс хувийнхаа сүнслэг амьдралыг дахин төлөвшүүлэх сорилттой тэрээр бас тулгарсан аж. Зехариа бас үзмэрч нэгэн байжээ. Түүний үзэгдлүүд Мессиагийн тухай (Аврагчийн Хоёр дахь Ирэлтийн тухай өгүүлдэг) бөгөөд бас урьдаас зөгнөн хэлсэн бошиглогчын (эцсийн өдрүүдийн тухай өгүүлдэг) аль алиных нь шинжтэй юм. Бүлэг 9–14 дэх Есүс Христийн тухай Зехариагийн бошиглогууд Хуучин Гэрээний аль ч бусад бошиглогчдынхоос илүү олон удаа Шинэ Гэрээн дэх дөрвөн Сайн мэдээнд иш татагдсан байдаг.

Зехариа 1–6

Зехариагийн найман үзэгдэл

Израилын угсааны тухай Их Эзэн Зехариад өгсөн найман үзэгдлийг Зехариа 1–6 цэдэглэдэг:

- Иерусалимтай харилцах Их Эзэний нигүүлсэнгүй арга замын тухай заадаг морьдын тухай үзэгдэл (Зехариа 1:7–17-г үз)
- Иудаг тараасан хүчнүүдийн (эврүүд) тухай, мөн эдгээр хүчнүүдэд юу тохиох тухай дөрвөн эвэр ба дөрвөн дархны тухай үзэгдэл (Зехариа 1:18–21-ийг үз)
- Өөрийн хүмүүсийг хамгаалах Их Эзэний хамгаалалтын хүчийг гэрчилдэг хэмжүүр барьсан хүний тухай үзэгдэл (шалгагч; Зехариа 2-ыг үз)
- Иуда Сатаныг хэрхэн даван туулж, Есүс Христийн хүчээр дамжуулан хэрхэн ариусгагдаж (шүлэг 8 дахь “Мөчир”) чадахыг бэлгэдсэн дээд санваартны тухай үзэгдэл (Зехариа 3-ыг үз)
- Их Эзэн өөрийн Ариун Сүнсээр өөрийн хүмүүст хэрхэн хүч өгөхийг бэлгэдсэн дэнлүүний суурь ба чидун моддын (Зехариа 4-ийг үз) тухай үзэгдэл
- Уг нутагт шударга бус байсан хүмүүс буруутгагдсаныг заасан, нисэж буй хуйлмал номны тухай үзэгдэл (Зехариа 5:1–4-ийг үз)
- Ёс бус явдал хүмүүсээс зайлуулагдахыг гэрчилсэн, сагсан дотор суусан эмэгтэйн тухай үзэгдэл (Зехариа 5:5–11-ийг үз)
- Бүх дэлхий дээгүүр Их Эзэний хүч тархахыг бэлгэдсэн дөрвөн тэрэгний тухай үзэгдэл (Зехариа 6:1–8-ыг үз)

Өөрийн хүмүүст тохинуулах Аврагчийн бэлгэдэл болсон Иошуа хэмээх нэртэй хүн дээд санваарт томилогдсоноор Зехариа 6 төгсдөг.

Зехариа 7–8

Тухайн үеийн болон ирээдүйн Иерусалим

Зехариагийн үе дэх Иерусалимын хүмүүс бусдад эелдэг найрсаг, шулуун шударга, энэрэлтэй хандахгүйгээр, мацаг болон бусад гадаад ёслолуудыг гүйцэтгэснээр өөрсдийгөө зөв шударга байгаа гэж боддогийнх нь төлөө Их Эзэн тэднийг буруутган зэмлэснийг Зехариа 7 цэдэглэдэг. Иерусалимын ирээдүйн талаарх Зехариагийн бошиглолуудыг Зехариа 8 агуулдаг. Хүмүүс наманчилж, энэ ариун хотод зөв шударга ёсонд цугларахад Их Эзэн тэдэнтэй хамт байж, өнгөрсөн үед түүнд байсан арга замуудаас илүүгээр тэднийг адислах болно хэмээн тэрээр хэлжээ.

Зехариа 9

Ирж буй Хаан

Эртний бүх бошиглогчид Есүс Христийн тухай (Иаков 7:11-ийг үз) гэрчилдэг байсан гэж Мормоны Номны бошиглогч Иаков хэлжээ. Эдгээр бошиглолуудын зарим нь Библиэс алга болсон байж болох ч гэсэн (1 Нифай 13:24–28-ыг үз), бидний төлөө хадгалагдан үлдсэн зарим бошиглолыг бид Зехариагаас олдог.

Судруудыг судлах нь

А Бошиглол гүйцэлдсэн нь

Зехариа 9:9-ийг Матай 21:1–11-тэй харьцуулж, Зехариа дахь бошиглол хэрхэн гүйцэлдсэн тухай бич.

Зехариа 10

Хожмын үеийн амлалтууд

Их Эзэний зарлигуудад тэд дуулгаваргүй байсны улмаас Израил, Иудагийн хүмүүс тараагдсан юм. Эцсийн өдрүүдэд тэдний төлөө Их Эзэн юу хийхээр амласныг Зехариа 10 өгүүлдэг. Та нар уншихдаа эдгээрийг эрж ол.

Судруудыг ойлгох нь

Зехариа 10

Тэднийг тулаан дахь өөрийн сүр жавхлант морьт мэт болгоно (ш. 3)—
Тэднийг удирдагчийн унадаг морьт шиг (ихэнхдээ шилдэг сайн морьт) болгоно

Дэвслэн гишгэчих (ш. 5)—
Бут ниргэх
Исгэрнэ (ш. 8)—Дуудна
Тэр зовлонгийн тэнгисийг туулан (ш. 11)—Ефраим их зовлон туулан эргэж ирэх болно.

Судруудыг судлах нь

А Израилын цугларалт

Израилын цугларалт бол сүнсний болон тараагдсан хүмүүс эргэж ирэхийн аль аль нь юм. Хүмүүс Сайн мэдээнд хөрвөгдсөн үед тэд дэлхийн шинж чанарыг ардаа орхин, эхлээд сүнслэг байдлын хувьд цуглардаг. Бошиглогч үүнийг тэдэнд хэлсэн үед Гэгээнтнүүд амлалтын

нутгууддаа эргэн ирж бас цугларах болно (Алма 5:57; С ба Г 133:12–15-ыг үз). Зехариа 10:6–12; С ба Г 29:7–11; 101:63–68; 115:5–6-г уншиж, Израилын цугларалтын тухай юу мэдсэнээ, бас энэ нь яагаад чухал болох тухай бич.

Зехариа 11–13

Иудейчүүд ба тэдний Аврагч

Иудейчүүдийн ирээдүйн тухай бошиглолуудыг Зехариа 11–13 цэдэглэдэг. Бүлэг 11-д, Есүс Христийн үе дэх тэднийг ёс бусын улмаас иудейчүүдэд юу тохиохыг Зехариа угтан хэлжээ. Есүс Христийн Хоёр дахь Ирэлтийн тухай, эцсийн өдрүүдэд тэрээр иудейчүүдийн төлөө юу хийх тухай бошиглолуудыг Зехариа 11–13 агуулдаг.

Судруудыг судлах нь

A Бошиглолууд нь хэрхэн гүйцэлдсэн бэ?

1. Зехариа 11:12–13; Матай 26:14–16; 27:1–10-ыг уншиж, Зехариагийн бошиглол хэрхэн гүйцэлдсэнийг ярь.
2. Зехариа 12:10; 13:6; Сургаал ба Гэрээ 45:47–53-ыг унш. Зехариагийн бошиглол хэзээ, хэрхэн гүйцэлдэх вэ?

Зехариа 14

Есүс Христийн Хоёр дахь Ирэлт

Та нар Аврагчийн Хоёр дахь Ирэлтийн тухай бодсон үедээ сэтгэл догдолдог уу, айдаг уу, эсвэл аль аль нь бага зэрэг байдаг уу? Зехариа 14 Хоёр дахь Ирэлтийн үед тохиох зарим үйл явдлуудыг дүрсэлдэг. Та нар уншихдаа, “хэрэв та

нар бэлтгэгдсэн байх аваас, та нар эмээх нь үгүй” (С ба Г 38:30) гэдгийг санан, Есүс Христийн Хоёр дахь Ирэлтийн тухайд сэтгэл түгшихгүй байхад тусалж чадах шүлгүүдийг эрж ол.

Судруудыг ойлгох нь

Зехариа 14

Амин ус (ш. 8)—Шууд утгаараа цэвэр ус, бэлгэдлийн утгаараа бол тэнгэрээс ирэх мэдлэг

Дорнын тэнгис, өрнийн тэнгис (ш. 8)—Сөнөсөн Тэнгис, Газрын Дундад Тэнгис

Иерусалим өндийн (ш. 10)—Иерусалим өргөгдөх бо-

ловч байрнаасаа хөдлөхгүй
Майхан Баяр (ш. 16, 18–19)—Их Эзэн тэднийг Канааны нутагт удирдан авчирсны дараа Израилын хүүхдүүдийг энд хэрхэн хөгжүүлэн дэвжээснийг дурсан тэмдэглэдэг баяр

Зехариа 14:6–7—Үдшийн цагаар гэрэлтэй байх болно
Зехариа 14:6–7-г 3 Нифай 1:8, 15–17-той харьцуул.

Судруудыг судлах нь

A Хоёр дахь Ирэлтийн өмнөх үйл явдлууд

1. Зехариа 14:1–7-д өгүүлснээр, Хоёр дахь Ирэлтийн үеэр иудейчүүдийн төлөө Их Эзэн ямар агуу гайхамшигийг үйлдэх вэ? (С ба Г 45:47–53-ыг үз).
2. Зехариа 14:20–21-д өгүүлснээр, Их Эзэнийг ирэх үед дэлхий дээрх нөхцөл байдал хэрхэн өөр болох вэ?
3. Хоёр дахь Ирэлтийн тухай Зехариагийн бошиглолтой холбоотой ямар үйл явдлууд Аврагч хэзээ дахин ирэхийг хүлээхэд та нарт туслах вэ? Мөн Зехариад бошиглогдсон үйл явдлуудын талаар нарийн тодорхой нэмэлт мэдээллийн төлөө Исаиа 11:4–9; Сургаал ба Гэрээ 29:7–13; 133:17–35-ыг унш.
4. Сургаал ба Гэрээ 106:4–5-ыг уншиж, хэрэв Хоёр дахь Ирэлт та нарын үед ирлээ гэхэд энэ нь та нарын хувьд аймшигт өдөр байхын оронд аугаа алдар суут өдөр байхын төлөө, үүнд бэлтгэгдсэн байхын тулд та нар юу хийж болохыг тогтоо.

Малахийн Ном

Малахийн Ном бол Хуучин Гэрээний, түүхийн хувьд хамгийн сүүлд бичигдсэн ном юм. Малахи (еврей хэлэнд энэ нэр “миний элч” гэсэн утгатай) эдгээр бошиглолуудыг МЭӨ 430 оны орчим, иудейчүүд Вавилоноос Израилын нутагт эргэн ирж эхэлснээс хойш бараг зуун жилийн дараа бичсэн бололтой. Хуучин Гэрээний иудейчүүд Малахийн дараа бошиглогчидгүй байсан хэдий ч, Мормоны Номонд цэдэглэгдсэнээр, Өрнөд тал бөмбөрцөгт Лихай эцгийн үр удам (нифайчууд) бүр Есүс Христийн төрөлтийг хүртэл олон бошиглогчтой байсныг бид мэднэ.

Хуучин Гэрээний сүүлчийн бошиглогчийн захиас

Малахийг бошиглож байх үед, Бурхан Персийн захиргаанаас тэднийг чөлөөлөн, хаант улсаа дахин байгуулах боломжийг олгож, өөрийн хүчийг бүр ч илүү сүр дуулиантайгаар харуулна гэдэгт олон иудейчүүд найдаж байжээ. Иудейчүүд эх нутагтаа эргэж ирснээс хойш зуун жил өнгөрөхөд тэд Персийн хяналтанд хэвээрээ байлаа. Олон иудейчүүд урам хуга

ран цөхөрч, Бурхан тэднийг мартсан, эсвэл орхисон хэрэг, ингэхлээр зөв шударга байх нь үнэхээр хэрэггүй болж гэдэгт итгэн, шашны амьдралаар амьдрахын төлөө шаргуу ажиллахаа больсон байв. Малахийн захиас эдгээр нөхцөл байдлын тухай өгүүлдэг байв. Гэвч бүх насны хүмүүс өөрсдийнхөө шашинд “хайхрамжгүй хандахад” уруу татагддаг учраас Малахийн заадаг зарчмууд түүхэн дэх бараг аль ч үед хамаатай байж чадна.

Малахийн захиас

Түүний үед хүмүүсийн асуудаг байсан асуултуудад хариулахын тулд Малахи дараах асуудлууд, нүгэл болон сорилтуудыг танин мэдэж тогтоосон ажээ:

- Хүмүүс Бурханы нэрийг хэрхэн үзэн ядаж, бузарлаж байсан бэ? (Малахи 1:6-г үз).
- Их Эзэн яагаад хүмүүсийн өргөлүүд, залбирлуудыг хүлээн аваагүй вэ? (Малахи 2:13–14-ийг үз).
- Хүмүүс Их Эзэнийг хэрхэн ядрааж байсан бэ? (Малахи 2:17-г үз).
- Хүмүүс Их Эзэнд хэрхэн эргэж очих ёстой вэ? (Малахи 3:7-г үз).
- Хүн Бурханыг хэрхэн дээрэмддэг вэ? (Малахи 3:8-ыг үз).
- Хүмүүс Их Эзэний талаар хэрхэн ярьдаг байсан бэ? (Малахи 3:14–15-ыг үз).

Малахи бол Хуучин Гэрээний хамгийн олонтаа иш татагддаг бошиглогчдын нэг юм. Шинэ Гэрээний зохиогчид Малахийн бичээсүүдийг иш татсан байдаг, нифайчууд өөрсдийнхөө цэдгүүдэд тэдгээрийг оруулж болохын тулд амилсан Аврагч Малахийн заадаг зүйлүүдээс заримыг нь нифайчуудад иш татсан байдаг. Түүнчлэн тэнгэр элч Моронай Малахийн зарим зүйлийг залуу Бошиглогч Иосеф Смитэд иш татан, Малахийн бошиглолууд хожмын өдрүүдэд гүйцэлдэх болно хэмээн хэлсэн байдаг.

Малахийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг, *Судруудын Удирдамж*, “Малахи”-гаас үз.

Малахи 1

Чин сэтгэлийн бус шүтлэг

Есүс өөрийн мөнх бус байдал дахь тохинууллын үед Иудейн удирдагчдыг зэмлэн буруутгасан юм. Учир нь тэд үнэн хэрэг дээрээ зөв шударга бишээр амьдарч байсан атлаа хэтэрхий зөв шударга мэтээр харагдахыг хичээдэг байв. Энэ асуудал наад тал нь дөрвөн зуун жил оршиж байсныг ойлгоход Малахийн ном бидэнд тусалдаг. Иудейчүүдийн удирдагчид тахил өргөх Их Эзэний зарлигт дуулгавартай байсан хэдий ч, сүргийнхээ хамгийн шилдгийг тахилд өргөхийн оронд, гэмтэж бэртсэн буюу

өвчтэй малаа тахилд өргөдөг байсныг Малахи 1 цэдэглэдэг (Малахи 1:7–8, 12–14-ийг үз). Энэхүү хоёр нүүр гаргах явдал Их Эзэнийг дээдлэн хүндэтгэх нь тэдэнд дутагдаж, мөн тэдний амьдралд шашин доогуур байр эзэлж байсныг харуулж байв.

Малахи 2

Санваартнууд наманчлалд дуудагдав

Ариун сүмд хүмүүсийн төлөө санваартнууд байсан Аароны үр удмынханд Их Эзэний өгсөн чиглэлийг Малахи 2 дүрсэлдэг. Тэд хүмүүст зөв үлгэр жишээ үзүүлээгүйг, бас зөв шударга замуудаар явахад нь ч тэдэнд туслаагүйг Их Эзэн хэлжээ. Үүний оронд, эхнэр, нөхөр хоёрын хоорондох гэрээнүүдтэй Их Эзэний зүйрлэсэн санваарын гэрээнүүдийг санваартнууд зөрчсөн аж. Дуулгаваргүйнхээ төлөө тэд шийтгэгдэх болно хэмээн Их Эзэн хэлжээ.

Малахи 3–4

Эзэний Ирэлт

1823 оны 9-р сарын 21-ний орой Моронай Иосеф Смит дээр ирж, Мормоны Номны тухай түүнд ярихдаа, бас нилээд хэдэн судрыг, түүний дотор, “Малахийн гуравдугаар бүлгийн хэсгийг; мөн . . . тэрхүү бошиглолын дөрөв дэх буюу сүүлчийн бүлгийг” (ИС—Т 1:36) иш татжээ. Малахи 3–4 хожмын өдрүүдэд агуу ач холбогдолтой юм.

Малахи 3–4 “Эзэний аугаа, аймшигт” өдөр буюу (Малахи 4:5), Хоёр дахь Ирэлтэд анхаарал төвлөрүүлдэг. Их Эзэний өдөр ирэх болно гэдгийг Малахи өөрийнхөө үеийн хүмүүст болон бидэнд гэрчилсэн юм. Түүнээс гадна ёс бусчууд дэвжин дээшилж байгаа мэт байж болох ч гэсэн, Их Эзэний өдөр бол зөв шударга хүмүүс шагнагдаж, ёс бусчууд шатаагдах өдөр болно.

Та нар энэ хоёр бүлгийг уншихдаа бид Хоёр дахь Ирэлтэд бэлтгэхийн тулд юу хийх ёстойг, тэрхүү аугаа өдрийг хүртэл итгэлтэйгээр тэвчихэд бидэнд юу тусалж болохыг, мөн Хоёр дахь Ирэлт тохиох болно гэдэгт итгэлтэй байхад юу бидэнд урам хайрлахыг эрж ол.

Судруудыг ойлгох нь



Малахи 3

Цэвэршүүлэгч (ш. 2)—
Металлыг бусад бүх боди-
соос салган цэвэрлэдэг хүн
Мэргэлдэг хүмүүс (ш. 5)—
Бусад нөлөөлөхийн тулд
ид шид, муу ёрын сүнсийг
ашиглахыг эрэлхийлдэг
хүмүүс

Дарлах (ш. 5)—Шударга
бусаар хандах

Цөлмөгч (ш. 11)—Устгагч,
сүйтгэгч зүйлүүд

Бурханыг сорих (ш. 15)—
Бурханы зарлигуудаар амьд-
рахгүй бол үнэхээр шийтгэл
ирдгийг үл тоомсорлон
амьдрах

Судруудыг судлах нь



Малахи 3–4-ийг судлахдаа дараах таван үйл ажиллагаанаас
(А–Д) гурвыг нь хий.

А Нэгээс илүү гүйцэлдэлт

Матай 11:7–11; Сургаал ба Гэрээ 45:9-ийг уншиж, хэний тухай эсвэл ямар элчийн тухай Малахи 3:1-д өгүүлж байгааг хэл. Бошиглогч Иосеф Смит эдгээр хожмын өдрүүдэд Есүс Христийн Сүмийг сэргээснээр Их Эзэний замыг бэлтгэх элч мөн гэж бид хэлэх нь бас зөв юм (*Судруудын Удирдамж*, “Библийн Иосеф Смитийн Орчуулгаас авсан түүврүүд,” Матай 17:10–14; 2 Нифай 3-ыг үз).

Б Нэг гүйцэлдэлт

Малахи 3:1-д бид “миний элч,” “гэрээний элчийн” тухай уншдагийг ажигла. Дээрх А үйл ажиллагаанд та нар “миний элчийг” олж тогтоосон билээ. “Гэрээний элч” гэж хэнийг гэж та нар бодож байна? Яагаад?

В Төгс Эзэмших Судар—Малахи 3:8–10

1. Аравны нэгийн хуулиар амьдардаг хүмүүст зориулагдсан, Малахи 3:8–10-д агуулдаг аадислалуудыг жагсаан бич. Шүлэг -ыг уншин жагсаалтандаа аадислалуудыг нэм.
2. Бид аравны нэг болон өргөлүүдээ төлөхгүй байх нь хэрхэн “Бурханыг дээрэмдсэнд” тооцогдож болох вэ?
3. Сургаал ба Гэрээ 64:23-д аравны нэгийн тухай Их Эзэний хэлсэн зүйлийг унш. Хэрэв та нар Малахи 4:1-ийг хүртэл уншсан бол, Их Эзэний хэлсэн зүйлийг Малахийн захиастай хэрхэн харьцуулж болох вэ?

Г Өөрийнхөө үгээр

1. Малахи 3:14–15-д байдаг хүмүүсийн гомдлын тухай өөрийнхөө үгээр бич.

2. Уг гомдолд хариулт өгсөн бөгөөд зөв шударга байдлынхаа төлөө чи адислагдахгүй байгаа юм шиг атал зарлигуудыг сахьдаггүй хүмүүс өөдрөг сайн байх шиг санагддаг үед та нарт тусалж чадах ямар амлалтуудыг Их Эзэн Малахи 3:16–18-д өгсөн бэ?

Д Төгс Эзэмших Судар—Малахи 4:5–6

1. Малахи 4:5–6 нь Сүмийн дөрвөн жишиг бүтээлд бүгдэд нь иш татагдсан (хэдийгээр яг үгчилсэн биш ч гэсэн) шүлгүүдийг агуулдгийг мэдэх нь та нарт сонирхолтой байж болох юм (3 Нифай 25:5–6; С ба Г 2; 128:17; ИС—Т 1:36–39-ийг үз). 1823 онд бошиглогч хөвгүүнд Моронайн иш татсан олон судраас, Хоёр дахь Ирэлтийн өмнө Елиа эргэж ирэх тухай энэ бошиглол бол Сургаал ба Гэрээнд орсон ганцхан хэсэг юм. Ариун түлхүүрүүдийг сэргээхээр Елиа эргэж ирсэн нь хамгийн чухал юм. Сургаал ба Гэрээ 110:13–16-г уншиж, энэ бошиглол хэзээ, хэрхэн гүйцэлдэснийг тайлбарла.
2. “Елиагийн олгосон энэхүү санваарын хүчээр дамжуулан нөхөр, эхнэр хоёр лацдан холбуулах буюу үүрд мөнхөд гэрлэж болно, хүүхдүүд үүрд мөнхөд эцэг эхчүүдтэйгээ лацдан холбуулж болно; ийнхүү гэр бүл мөнхийн болж, гэр бүлийн гишүүдийг үхэл салгаж чадахгүй. Энэ бол дэлхийг бүрмөсөн устгалаас аврах агуу зарчим мөн” хэмээн Ерөнхийлөгч Жозеф Фиелдинг Смит хэлжээ (*Doctrines of Salvation*, эмхтгэсэн, Брус Р. МкКонки, 3 боть. [1954–56], 2:118). Энэхүү үнэнийг мэдэн, эдгээр үнэнүүдийг мэддэг хэрнээ Елиагийн сэргээсэн адислалууд хийгээд гэрээнүүдийн дагуу амьдардаггүй хувь хүмүүс болон гэр бүлүүд дээр, түүнчлэн дэлхий дээр ямар “зүхлүүд” ирнэ гэж бодогоо тайлбарла. Өөрөөр хэлбэл, Елиагийн сэргээсэн санваарын түлхүүрүүд газар дэлхийг “зүхлүүдээс” хэрхэн хамгаалдаг вэ? Эдгээр зүйлүүдийн тухай гайхамшигт мэдээг хуваалцах нь яагаад бидний хувьд чухал ач холбогдолтой вэ? Тэргүүн Зөвлөл болон Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгаас гаргасан тунхгийн дараах ишлэл дээрх асуултад хариулахад чинь та нарт тусалж болно:
“Ариун явдлын гэрээгээ зөрчин, хань ижил, үр хүүхдтэйгээ зүй бусаар харьцсан, гэр бүлийнхээ өмнө хүлээсэн үүргээ биелүүлээгүй хувь хүн хожмын нэг өдөр Бурханы өмнө өчиг мэдүүлэхийг бид анхааруулж байна. Түүнчлэн гэр бүлээ сарниулбал эрт эдүгээгийн бошиглогчдын зөгнөн хэлснээр хувь хүн, нийгэм, улс үндэстнүүдэд гай гамшиг авчрах болно гэдгийг бид сануулж байна” (“Гэр бүл: Дэлхий Дахинаа Өргөх Тунхаг,” *Ensign*, 1995 оны 11-р сар, 102).
3. Та зүрх сэтгэлээ “эцгүүдэд” (өөрийн өвөг дээдэст) эсвэл хүүхдүүддээ эргүүлж, тэдний амьдралыг үүрд адислахын тулд юу хийж чадна гэж бодогоо тайлбарла.

ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ

